UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS,
MONGOLIA

LAW ENFORCEMENT

THEORETICAL AND METHODOLOGICAL
QUARTERLY JOURNAL

2022
№02 (29)

Ulaanbaatar

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:
Зоригт О. Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Орлогч дарга:
Гантулга С. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Нарийн бичгийн дарга:
Бямбажаргал Б. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хэвлэл редакцын хэлтсийн дарга бөгөөд ахлах редактор, цагдаагийн дэд хурандаа

Гишүүд:

Мөнхзаяа Б. Сургалтын бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа

Азбаяр Ц. Удирдлагын академийн захирал, цагдаагийн хурандаа

Лхагвасүрэн Б. Ахисан шатны боловсролын сургуулийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Хишигтогтох Б. Цагдаагийн сургуулийн захирал, доктор, цагдаагийн хурандаа

Ганбаатар Д. Хилийн албаны сургуулийн захирал бөгөөд хилийн 0345 дугаар ангийн захирагч, бригадын генерал

Уганбаяр П. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, хурандаа

Батсайхан Н. Онцгой байдлын сургуулийн захирал, доктор, дэд профессор, дэд хурандаа

Болдбаатар Ч. Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн захирал, цагдаагийн хурандаа

Ганбаатар Г. Ахлагчийн сургуулийн захирал, доктор, цагдаагийн хурандаа

Гантулга Ц. Шинжлэн магадлахуйн институтын захирал, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Чулуунбат Ш. Гадаад хэлний институтын захирал, доктор, дэд профессор, хурандаа

Мөнхдорж Б. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Сайнтөр Ч. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал, доктор, бригадын генерал

Алтангэрэл Б. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа

JOURNAL EDITORIAL BOARD

Editor of the journal:
Zorigt O, Vice president for Research Affairs, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Colonel.

First Secretary:
Gantulga S, Director, Integrated Research Institute, University of Internal Affairs, Ph.D. Associate professor, Police Lieutenant Colonel.

Secretary:
Byambajargal B, Head of the Press and Editorial Department, Senior Editor, Integrated Research Institute, University of Internal Affairs, Police Lieutenant Colonel

Members:

Munkzaya B, Head of Training Policy and Coordination Department, University of Internal Affairs, Colonel

Azbayar Ts, Director, Executive Management Academy, University of Internal Affairs, Police Colonel

Lkhagvasuren B, Director, Post-Graduate College, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Lieutenant Colonel

Khishigtogtokh B, Director, Police College, University of Internal Affairs, Ph.D., Police Colonel

Ganbaatar D, Director, Border Services College and Commander of the Unit 0345, University of Internal Affairs, Brigadier General

Uuganbayar P, Director, Court Order Decision Enforcement College, University of Internal Affairs, Colonel

Batsaikhan N. Director of Emergency Management School, Ph.D, Associate Professor, Lieutenant Colonel

Boldbaatar Ch, Director, Law and Social Sciences College, University of Internal Affairs, Police Colonel

Ganbaatar G, Director, Non-Commissioned Officer's School, University of Internal Affairs, Ph.D., Police Colonel

Gantulga Ts, Director, Forensic Science Institute, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Colonel

Chuluunbat Sh, Director, Foreign Language Institute, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Colonel

Munkhdorj B, Director, Institute of Criminology and Police Research, Integrated Research Institute, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Lieutenant Colonel

Saintur Ch, Director, Institute of Border Security Research, Integrated Research Institute, University of Internal Affairs, Ph.D., Brigadier General

Altangerel B, Head of Court Order Decision Enforcement Center, Integrated Research Institute, University of Internal Affairs, and Ph.D., associated Professor, Colonel

Одбаатар Б. Удирдлагын академийнЦагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийнпрофессор, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Odbaatar.B. Professor, Professor's Team of Police Strategy Management, Executive Management Academy, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Colonel

Лхагварагчаа Б. Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, цагдаагийн ахмад

Lkhagvaragchaa B, Head of Criminal Investigation Department, University of Internal Affairs, Ph.D., Police Captain

Галбадрах Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, хошууч

Galbadrakh B, Head of Social Work and Psychology Department, Court Order Decision Enforcement College, University of Internal Affairs, Ph.D., Major

Мягмаржав Х. Онцгой байдлын сургуулийн Эдийн засаг нөөцийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа

Myagmarjav Kh, Head of Economics and Resource Management Department, Emergency Management College, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Colonel

Энхтүвшин Б. Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн дэд профессор, доктор, дэд хурандаа

Enkhtuvshin B, Associate Professor in the Department of Emergency Management, University of Internal Affairs, Ph.D., Colonel

Мөнхзул Н. Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Munkhzul N, Head of Public Law Department, Law and Social Science College, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Lieutenant Colonel

Цолмон Б. Шинжлэн магадлахуйн институтын Криминалистикийн шинжилгээний тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Tsolmon B, Head of Forensic Investigation Department, Forensic Science Institute, Ph.D., Associate Professor, Police Colonel

ГАРЧИГ–TITLE

ХУУЛЬ САХИУЛАХУЙН УДИРДЛАГА
LAW ENFORCEMENT MANAGEMENT

БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

THE SOME ISSUES TO CONSIDER FOR IMPLEMENTING IN ORGANIZATIONAL STRATEGIC MANAGEMENT

Б.Одбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа 10
Odbaatar.B
Professor, Professor's Team of Police Strategy Management, Executive Management Academy,University of Internal Affairs, Mongolia, doctor of law (Ph.D), Associate Professor, police colonel

УДИРДЛАГЫН ОНОЛЫН ШИНЭ ХАНДЛАГА

A NEW APPROACH TO MANAGEMENT THEORY

Г.Наранбаяр
Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, докторант, хошууч 18
Г.Наранбаяр
Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, докторант, хошууч

ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ
CRIMINOLOGY

МОНГОЛ УЛС ДАХЬ МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА, АНХААРАХ АСУУДАЛ

CURRENT SITUATION OF ILLICIT TRAFFIC IN NARCOTIC DRUGS AND PSYCHOTROPIC SUBSTANCES IN MONGOLIA, FUTURE TRENDS AND CONSIDERATIONS

Р.Гэрэлбат
Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Эрүүгийн цагдаагийн хэлтсийн ахлах мөрдөгч, магистрант цагдаагийн хошууч 25
Gerelbat. R
Senior Criminal Intelligence officer, Criminal Police Division of Countering Narcotics Department, National Police Agency, Police Major

БАРИВЧЛАХ, ТАСЛАН ЗОГСООХ ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭТРҮҮЛЖ БУСДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД ХОХИРОЛ УЧРУУЛАХ ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

CAUSES, CONDITIONS AND PREVENTION OF THE CRIMES THAT CAUSE HARM TO OTHERS BY EXCEEDING THE LIMITS OF ARREST AND DETENTION BY POLICE OFFICERS IN THE PERFORMANCE OF THEIR LEGAL DUTIES CRIMINAL DAMAGE 33

Ж.Баттулга
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
Battulga.J
Graduate student of the University of Internal Affairs, senior lieutenant of police

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

SITUATION OF LIVESTOCK THEFT

Л.Бат-Очир
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа 40
Bat-Ochir L.
Ph.D, Police Lieutenant Colonel, Associate Professor, Department of Criminal Law and Criminology, Police School, University of Internal Affairs

ГЭМТ ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЖ АВАХ АЖИЛЛАГАА

EXTRADITION PROCEEDING OF CRIMINAL

Х.Сайнжаргал
Дотоод хэргийн их сургуулийн магистрант 48
Kh.Sainjargal
University of internal affairs Master

ГҮЙЦЭТГЭХ АЛБА, АЖИЛТНААС ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГААР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO FIGHT CRIME BY INTELLIGENCE OFFICER AND ANALYSIS

52

Х.Тулга
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
Tulga.Kh
University of Internal Affairs, Post-graduate student, Police senior lieutenant

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

58

Г.Хишигдорж
Магистрант, цагдаагийн дэслэгч
Г.Хишигдорж
Магистрант, цагдаагийн дэслэгч

ХАР ТАМХИНЫ НИЙГМИЙН ХОР АЮУЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

SOCIAL DANGEROUS DRUGS CURRENT SITUATION

73

Ц.Энхманлай
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Ts.Enkhmanlai
University of internal Affairs Post-graduate student, Police major

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНД МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

MONEY LAUNDERING AND SOME ISSUES TO CONSIDER WHEN INVESTIGATING IT

82

Ж.Батсайхан
Дотоод хэргийн их сургуулийн эдийн засгийн ажуулгүй байдлын магистрант
Ж.Батсайхан
Дотоод хэргийн их сургуулийн эдийн засгийн ажуулгүй байдлын магистрант

АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛ
SECURITY STUDIES

ӨНГӨТ ХУВЬСГАЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ШИНЖ

THE CONCEPT OF COLOR REVOLUTION, MAIN FEATURES

93

В.Амарсанаа
Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч
V.Amarsanaa
Ph. D., Lecturer, Department of Criminal Law and criminology, school of police (Ph.D), Police Major
Б.Лхагварагчаа
Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн ахмад
B.Lkhagvaragchaa
Head of the Department of Police School compliance methodology, Dr. (Ph.D), Police captain

ЦАГДАА СУДЛАЛ
POLICE STUDIES

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДРОН АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

USING DRONES IN POLICING, ITS' NECESSITIES, USAGE IMPLEMENTATION, AND FUTURE CONSIDERATIONS

105

Б.Мөнгөнтуяа
БНСУ-ын Үндэсний цагдаагийн их сургуулийн Олон нийтийн аюулгүй байдлын тэнхимийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
B.Munguntuya
Korean National Police University, Department of Public Security Master Student, Police Senior lieutenant

ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТНЫ АЖЛЫН ДҮН МЭДЭЭГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ХАМААРАХ ХҮЧИН ЗҮЙЛ

EXECUTIVE EMPLOYEE RESULTS IMPROVED FACTORS TO BE MADE

111

Л.Энхтуяа
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах ахлагч
L.Enkhtuya
Graduate student of the University of Internal Affairs, senior police chief

ХОРОО ХАРИУЦСАН ЭРҮҮГИЙН МӨРДӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

ХОРОО ХАРИУЦСАН ЭРҮҮГИЙН МӨРДӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

119

Д.Бат-Орших
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахмад
D. Bat-Orshikh
University of Internal Affairs, Post-graduate student, Police capitan

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ НЬ /Улсын чанартай авто зам жишээн дээр/

USE OF INFORMATION TECHNOLOGY FOR THE PREVENTION OF ROAD TRAFFIC ACCIDENTS AND CRIME / On the example of national roads /

126

Х.Мөнх-Эрдэнэ
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
Munkh-Erdene.Kh
Master's student of University of Internal Affairs Mongolia, Senior Lieutenant of Police

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

THE CONCEPT OF RESTRICTIVE MEASURES, PREVENTIVE MEASURES AND THEIR IMPLEMENTATION

М.Энхням 134
Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч /Дотоод хэргийн их сургуулийн магистрант/
M.Enkhnyam
Senior detective of the police department of Khentii province, police major /Master of the University of Internal Affairs/.

ХИЛ СУДЛАЛ
LIMNOLOGY

ХИЛИЙН АЛБАНЫ СУРГАЛТЫН ОНЦЛОГ, АРГА, ХЭЛБЭР

BORDER SERVICES' TRAINING METHOD, TYPE AND SPECIFICATION

Я.Ариунболд 139
ДХИС-ийн УА-ийн хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хурандаа, докторант.
Ariunbold.Ya
Professor, Team of the Border Strategy Studies, University of Internal Affairs

ЕВРОПЫН ХОЛБООНЫ "НЭЭЛТТЭЙ ХИЛ"-ИЙН БОДЛОГО БА ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭЖ БУЙ ТУРШЛАГА

EU POLICY ON OPEN BORDER AND ITS EXPERIENCES FOR COMBATING TERRORISM

147

С.Энхсүх.
ДХИС-ийн Хил судлалын докторант, хурандаа
Enkhsukh.S
Graduate Student at UIA in Border Studies, Colonel

ГАМШИГ СУДЛАЛ
DISASTER STUDIES

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АШИГЛАЛТЫН НОРМ, СТАНДАРТЫН АСУУДАЛД

ON THE ISSUE OF NORMS AND STANDARDS OF PETROLEUM PRODUCTION

Б.Будсүрэн 152
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахлах дэслэгч
B.Budsuren
University of internal affairs, postgraduate master, senior lieutenant

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

FIRE FIGHTING AND RESCUE CLASS CAPACITY WAYS TO INCREASE

Б.Тэгшжаргал 161
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Tegshjargal.B
University of internal affairs master Senior Lieutenant

ХИМИЙН ОСЛООС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME CHEMICAL ACCIDENT PREPAREDNESS ISSUES

А.Бауыржан, Н.Төгсбаяр 166
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Bauirjan.A, Tugsbayar.N
University of internal affairs master Senior Lieutenant

УУЛ УУРХАЙН ОСЛЫН АЖИЛЛАЖ БАЙГАА АВРАГЧИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНД УДИРДЛАГА БОЛГОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION FOR LABOR SAFETY AND SAFETY MANAGEMENT OF MINING ACCIDENTS

У.Хатанзориг 172
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Khatanzorig.U
University of internal affairs master Senior Lieutenant

ӨНДӨР БАРИЛГАД ГАЛ УНТРААХ АВТОМАТ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН АШИГЛАЛТЫН СУДАЛГАА

STUDY ON THE USE OF AUTOMATIC FIRE EXTINGUISHERS IN HIGH-RISE BUILDINGS

А.Бэх-Очир 182
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Bekh-Ocjir.A
University of internal affairs master captain

ОРОН НУТГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF LOCAL DISASTER PREPAREDNESS

Б.Батдорж 189
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Batdorj.B
University of internal affairs master captain

ДАЛД УУРХАЙН АВРАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

FEATURES OF UNDERGROUND MINE RESCUE

Д.Баяржаргал 193
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахмад
D.Bayarjargal
Master of disaster studies of University of internal affairs captain

ОРОН НУТГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ /АРХАНГАЙ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД/

WAYS TO IMPROVE THE PERFORMANCE OF LOCAL DISASTER PROTECTION SERVICES /IN ARKHANGAI AIMAG/ 199

Ш.Эрдэнэбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Erdenebayar.Sh
University of internal affairs master captain

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ЗАРИМ АРГА ЗАМ

SOME METHODS TO DISSIMINATE DISASTER PREVENTION INFORMATION TO PEOPLE WITH DISABILITIES 204

Д.Отгонболд
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, хошууч
Otgonbold.D
University of internal affairs master major

ГАМШГИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF DISASTER HUMANITARIAN ASSISTANCE ACTIVITIES 217

Ш.Мөнгөнтуяа
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Munguntuya.Sh.
University of internal affairs, postgraduate

ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ
LAW ENFORCEMENT EDUCATION STUDIES

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОРОЛЦООГООР ҮНЭЛЭХ НЬ: ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР

TO EVALUATING FOR PARTICIPANTS ON TRAINING ACTIVITIES THE CASE OF UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS, MONGOLIA. 225

Ц.Баясгалан
ДХИС-ийн Удирдлагын Академийн Удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш, доктор, дэд профессор, ахлах дэслэгч
Bayasgalan.Ts
Ph.D, asisstant professor, A senior lecturer at team of management for the Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia.
Л.Булганхангай
Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн ахлах багш, ахмад
Bulgankhangai.L
A senior lecturer of department for fire fighting at Emergency management School at University of Internal
Г.Чулуунбаатар
Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах тэнхимийн багш, хошууч
Chuluunbaatar.G
Lecturer of department for disaster protection at Emergency management School at University of Internal Affairs, Mongolia
Г.Золжавхлан
Ахлагчийн сургуулийн Онцгой байдлын албаны тэнхимийн багш, ахлах дэслэгч
Zoljavkhlan.G
Lecturer of department Emergency management at Non-Commissioned Officer's School at University of Internal Affairs, Mongolia
Н.Одмаа
Онцгой байдлын сургуулийн Эдийн засаг-нөөц ар талын тэнхимийн багш, дэслэгч
Odmaa.N
Lecturer of department for economic and resource rear at Emergency management School at University of Internal Affairs, Mongolia

РОЛЬ РЕЧЕВЫХ МОДЕЛЕЙ В ПРОФЕССИОНАЛЬНО ОРИЕНТИРОВАННОМ ОБУЧЕНИИ РУССКОМУ ЯЗЫКУ КАК ИНОСТРАННОМУ

THE ROLE OF SPEECH MODELS IN PROFESSIONALLY ORIENTED TEACHING OF RUSSIAN AS A FOREIGN LANGUAGE 237

Букина Татьяна Григорьевна
Заведующий кафедрой иностранных языков Уральского юридического института МВД России, кандидат филологических наук, доцент
Bukina Tatyana Grigoryevna
Head of the Department of Foreign Languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation, Candidate of Philological Sciences, Associate Professor

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
LEGAL ISSUES

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛС: ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

SALARIES OF CIVIL SERVANTS, CURRENT STATUS OF LEGAL REGULATION

Э.Чимидлхам
Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн багш, докторант, цагдаагийн ахмад
E.Chimidlkham
Doctoral candidate of Law School of Law and Social Sciences, University of Internal Affairs, Lecturer of the Public Law Department, police captain
Ч.Соёлоо
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Ch.Soyoloo
Graduate student of the University of Internal Affairs
242

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХЭРЭГЖИЛТ

IMPLEMENTATION OF CONSTITUTIONAL LEGAL LIABILITY

Т.Азжаргал
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч
Azjargal.T
Senior lecturer at Common Law department of Law and Social Science School, The University of Internal Affairs, Major
248

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ СУДЛАХ НЬ

EXPLORING POSSIBILITIES TO INCREASE EMPLOYMENT OF PEOPLE WITH DISABILITIES
257

Г.Наранчимэг
ДХИС-ийн магистрант
G.Naranchimeg
Master›s student of UIA

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

LEGAL ENVIRONMENT FOR ENVIRONMENTAL IMPACT STUDY: CURRENT IMPLEMENTATION STATUS
267

Ж.Бат-Эрдэнэ
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Bat-Erdene J
Master student of the University of Internal Affairs, Mongolia

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН МӨНГӨН ХӨРӨНГӨӨС СУУТГАЛ ХИЙХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ХҮНИЙ ЭРХ

Б.Замбага
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахлах дэслэгч
Zambaga.B
Lecturer, Department of Decision execution, the School of Court Decision Execution, University of internal affairs, Master in law, senior lieutenant
281

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
LEGAL ISSUES

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙН САЛБАРЫН НИЙГЭМД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

MEDIA AND PRESS SECTOR'S ROLE IN SOCIATY
293

М.Уянга
ДХИС-ийн магистрант
M.Uyanga
Masters student, University if Internal Affairs

БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

THE SOME ISSUES TO CONSIDER FOR IMPLEMENTING IN ORGANIZATIONAL STRATEGIC MANAGEMENT

Б.Одбаатар
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа
Odbaatar.B
Professor, Professor's Team of Police Strategy Management, Executive Management Academy,University of Internal Affairs, Mongolia, doctor of law (Ph.D), Associate Professor, police colonel

Хураангуй: Энэхүү нийтлэлд байгууллагын стратеги удирдлагын тухай ойлголт, түүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол, стратеги удирдлагад анхаарах асуудлын талаар авч үзэхийг зорилоо.

Abstract: This article aims to discuss the concept of organizational strategic management, its needs and criterias, significance and issues.

Түлхүүр үгс: стратеги удирдлага, байгууллагын удирдлага, байгууллагын стратеги, байгууллагын стратеги удирдлага, стратеги зорилго, зорилт.

Keywords: strategic management, organizational management, organizational strategy, organizational strategic management, strategic goals and objectives.

ОРШИЛ

Аливаа байгууллагын амжилтад хүрэх хамгийн том баталгаа нь сайн стратеги байдаг. Тэгвэл стратеги боловсруулна гэдэг нь товчхондоо "зөв ажлыг сонгож хийх" тухай ойлголт бөгөөд энэ нь байгууллагын удирдлагын түвшинд хийгдэх нэлээд өргөн хүрээтэй, шат дамжлага бүхий цогц үйл ажиллагаа юм. Харин хэрэгжүүлэлт бол "ажлыг зөв хийх" тухай асуудал. Ямар ч агуу стратеги хэрэгжихгүй бол үнэ цэнгүй зүйл болон хувирч болох тул үүнд дээд шатны удирдлага, дунд шатны менежер, алба хаагчид гэхчлэн бүх л оролцогчид онцгой анхаарал хандуулах учиртай.

Удирдахуйн ухааны онолын олон арван бүтээлүүдээс дүгнэхэд стратегийн ач холбогдлыг өргөн хүрээнд авч үздэг хэр нь түүний хэрэгжилтийн асуудлыг тун бага хөндсөн байх нь элбэг. Тэгэхээр стратеги боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх тухай асуудал нь хоорондоо нягт уялдаа холбоотой удирдлагын үйл ажиллагаа бөгөөд эдгээр ойлголтыг нэг нэгнээс нь салгаж авч үзэх боломжгүй юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Байгууллагын стратеги удирдлагын талаар авч үзэхийн тулд эхлээд "стратеги" гэж чухам ямар ойлголт болох, түүний мөн чанар, хэрэгцээ шаардлага байгууллагын удирдлагад ямар ач холбогдолтой вэ? гэдгээс эхлэх нь зүйтэй.

Стратеги – "strategies" гэх грек үгээс үүсэлтэй бөгөөд цэргийн жанжны ур ухаан[1] гэсэн утгатайгаар эх

[1] Анх "генералын ур ухаан" гэсэн утгатай байсан. Генерал хүн ялалтанд хүрэхийн тулд цэргийн хүчээ хаагуур хэрхэн хөдөлгөхөө бодож боловсруулсан төлөвлөгөө юм. *Эх сурвалж.*

сурвалжуудад тэмдэглэгдсэн байдаг. Тухайлбал 2500 жилийн өмнө эртний Хятадад Сүнь Үү хэмээх жанжны туурвисан “Сүнзийн дайтах урлаг” номд цэрэг дайны стратеги, тактикийн талаар бичиж байжээ. Харин XIX зуунд амьдарч байсан дайтах урлагийн судлаач Карл вон Клаусвитц стратегийг “дайны ерөнхий төлөвлөгөө боловсруулах, дайралтад бэлтгэх, зохион байгуулах, тэр дундаа ажиллагаа бүрийг тусгайлан шийдэх үйл явц” хэмээн тодорхойлжээ. Тэгвэл түүхч Эдуарт Мийд Ийрл улс орнууд хоорондоо уралдах болсон орчин цагт тохируулж стратегийг илүү өргөн хүрээнд авч үзэн “нэг улсын эсвэл холбоотон улсуудын ашиг сонирхлыг хамгаалах үүднээс нөөц баялгийг *(цэрэг зэвсгийн хүчийг оролцуулан*) оновчтой удирдах, ашиглах ухаан” гэж тодорхойлсон байдаг.

Бизнесийн салбарынхан “цэргийн стратеги” гэх ойлголтыг хамгийн түрүүн авч хэрэглэсэн ба тэдний хувьд стратеги бол ашиг сонирхлоо хамгаалахын тулд өөрт байгаа бүх нөөц боломжоо (*хүний болон материаллаг, түүнчлэн санхүүгийн нөөц)* зөв хянаж удирдах ухаан юм[2]. Байгууллагын стратеги ямар нөхцөлд байгаа *(гадаад орчны боломж ба аюул),* юу хийж чадах *(бизнесийн давуу болон сул тал)*-аас хамаарна гэсэн загварчлалыг зөвхөн бизнесийн байгууллага гэлтгүй өнөөдөр төрийн байгууллагууд ашиглаж, өөрийн стратеги төлөвлөлтийн суурь судалгаа болгож байна.

Менежментийн шинжлэх ухаанд стратеги гэх ойлголт орж ирсэн нь гадаад орчны тооцоологдоогүй болон гэнэтийн өөрчлөлт хувиралтад байгууллага хэрхэн зохицон орших тухай асуудал чухлаар тавигдаж байсан 1960-аад оны үе гэж үздэг.

Тэгвэл байгууллагын стратеги удирдлага гэдэг нь зорилгодоо хүрэх боломжийг олох чадварыг бий болгох үйл явц юм. Энэ нь асуудлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн холбоосонд авч үзэн хэтийн чиглэлийг хангахын тулд шинжлэх ухааны аргуудад тулгуурладаг.

Байгууллагын стратеги, түүний удирдлагын талаар олон арван эрдэмтэн, судлаачид судлан өөр өөрийн байр сууринаас тайлбарласан. Үүнд:

- Харвардын их сургуулийн профессор Альфред Д.Чандлер “Стратеги нь байгууллагын урт хугацааны үндсэн зорилгыг тодорхойлох, үйл ажиллагааны чиглэлийг батлах, эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг хуваарилах үйл явц[3]”.
- Мемфисийн их сургуулийн профессор Питер Райт[4] “Стратеги нь байгууллагын эрхэм зорилго, зорилгод хүрэхээр боловсруулсан төлөвлөгөө бол стратеги удирдлага нь гадаад, дотоод орчныг шинжлэх, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлох, стратегийн томьёолол, хэрэгжилт гэсэн салшгүй гурван үйл явцын нэгдэл” гэж тодорхойлжээ.

Канадын МакГиллийн их сургуулийн профессор Хенри

Стратегийн удирдлага. *орч.* Б.Өлзийсайхан. 2019. 9 дэх тал.

[2] Кеннет Андрюс. The concept of corporate strategy. 1971.

[3] Эх сурвалж, холбоос: http://ecsocman.hse.ru/data/175/631/1219/Chandler_mem.pdf

[4] *Эх сурвалж*. Стратегийн удирдлага. *орч.* Б.Өлзийсайхан. 2019. 11 дэх тал.

Минцберг[5] 1998 онд стратегийг анх удаа тал бүрээс нь тайлбарласан байна. Тухайлбал стратеги нь:

- зорилгодоо хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөө.
- цаг хугацааны явцад хэрэгжсэн тогтвортой хэв маяг.
- заль мэх, бусдаас илүү гарах зорилготой маневр;
- байгууллагын хэтийн төлөв гэж тайлбарласан нь өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй байна.

Стратеги болон стратеги удирдлагын талаар гадны эрдэмтэн, судлаач нараас гадна манай орны зарим эрдэмтэд ч судлан өөр өөрийн байр суурыа илэрхийлсэн байна. Т.Дорж, Ү.Чимэд нар "Менежмент" бүтээлдээ:

"Стратеги нь зорилго, зорилтуудад чиглэсэн иж бүрдэлт төлөвлөгөө байдаг бол стратеги удирдлага нь байгууллага урт хугацаанд оршин тогтнож зорилгодоо хүрэх боломж өгөхөд чиглэсэн удирдлага" гэж тайлбарлажээ[6].

Д.Лхаашид "Стратеги нь орчны хувьсал, өөрчлөлтөд зохицуулах, байгууллагынхаа холч давуу талыг хадгалах иж бүрэн, цогц зорилго байдаг бол стратеги удирдлага нь онол арга зүйд тулгуурлан байгууллагын үйл ажиллагааг хөгжлийн дээд төвшинд хүргэхэд чиглэсэн зорилтуудыг агуулсан цогц бодлогын хэрэгжилт" гэж тайлбарлажээ[7].

Энэ бүхнээс дүгнэхэд стратеги нь товчхондоо "байгууллагыг амжилттай ажиллах, богино хугацаанд бага зардлаар өмнө тавьсан зорилго, зорилтдоо хүрэх арга зам" буюу "амжилтад хүрэх төлөвлөгөө" юм. Өөрөөр хэлбэл юуг хэрхэн хийх, ямар болгох, хамгийн чухал нь "зорилгодоо яаж хүрэхээ ойлгох"-ын нэр юм.

Зөв стратегийг чадварлаг хэрэгжүүлбэл байгууллагын зорилго, чиглэлийг бүх түвшинд ойлгож, амжилтад хүргэхийн тулд "юу хийх вэ" гэдгээ мэдэж авдаг. Харин эсрэгээрээ тодорхой стратегигүй байгууллага "жолоодлогогүй машин" шиг ажиллан аливаа боломж, саад бэрхшээл гарч ирэх бүрд чиглэлээ өөрчлөн чиг шугамаа алдан, үр бүтээлгүй өдөр хоногийг аргацаалсан хэлбэрт шилжинэ.

Стратеги боловсруулах нь байгууллагын хэтийн төлөв, орчныг илүү тодорхой болгож төлөвлөсөн үр дүндээ хүрэх гол үндэс болдог. Стратегигүй байгууллага чиглэлгүй болох ба төлөвлөсөн үр дүнд хүрэх үйл ажиллагаа урт хугацаандаа алдагддаг.

Тиймээс стратеги нь байгууллагыг бусдаас ялгаруулах замаар давуу тал бүтээх төлөвлөгөө юм.

Аливаа удирдлагын үйл ажиллагаа тодорхой зарчим дээр үндэслэн хэрэгждэг бол стратеги удирдлагад мөн дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлох.
- нэгдмэл цогц, харилцан уялдаатай байх.
- ил тод байх.
- дотоод нөөц боломждоо тулгуурлах.
- судалгаанд суурилсан, биелэгдэх боломжтой байх.

[5] Цахим эх сурвалж, холбоос: https://ru.wikipedia.org/wiki/Минцберг,_Генри

[6] *Т.Дорж, Ү.Чимэд.* Менежмент: сурах бичиг. 2000. 15 дах тал.


[7] *Д.Лхаашид, Р.Бадралмаа*. Стратегийн удирдлага. 1996.

Стратеги нь байгууллагын эрхэм зорилгоос урган гарна. Байгууллагын стратеги боловсруулах, хэрэгжүүлэх нь нэлээд цаг хугацаа шаардсан, өргөн хүрээтэй үйл ажиллагаа бөгөөд үүнийг байгууллагын онолоор орцыг гарц болгон хувиргах нэг төрлийн үйл явц *(процесс)* гэж үзэж болно. Стратеги нь хийсвэр сэтгэлгээ, хоосон мөрөөдөл огт биш бөгөөд биелэгдэхүйц, бодит нөхцөл байдал дээр тулгуурласан хүрч очих ирээдүйн чиг баримжаа байх ёстой.

Стратеги боловсруулах үйл явц өргөн далайцтай, хугацаа шаардсан, судалгаа, дүн шинжилгээн дээр үндэслэх ба байгууллага урт хугацаанд амжилттай ажиллахын тулд нэн тэргүүнд тулгамдсан асуудлуудыг тодорхойлдог. Үүний тулд байгууллагын бүтцийн нэгжийн хэлтэс, тасаг, баг бүр эдгээр асуудалд чиглэсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлагатай бөгөөд түүн дээр үндэслэн стратеги зорилго, чиглэлүүд тодорхойлогдох учиртай. Иймд байгууллага бүрд тохирох “Стратеги боловсруулах нийтлэг загвар”-ыг дараах байдлаар тодорхойлж болно.

Зураг 1.

Байгууллагын стратеги боловсруулах нийтлэг загвар



Байгууллагын стратеги боловсруулалт дамжих үе шат:

1. ***Асуудлаа тодорхойлох*** – тулгамдсан асуудал, түүнийг шийдэж болох эсэх, жинхэнэ асуудал мөн үү, эсвэл асуудлын шинжтэй бэрхшээл үү, яаралтай шийдвэрлэх эсвэл ажиглах, эрсдэлд хүргэх эсэх, цаашид юу хийх ёстой зэргийг тодорхойлох ажиллагаа.

2. ***Мэдээлэл цуглуулах*** – саад бэрхшээлийг олж харахгүй байна уу, юун дээр алдаа гаргав зэрэг асуултын хариуг олох зорилгоор баримт, судалгаа, үйл явдлын талаар мэдээлэл цуглуулж нэгтгэх ажиллагаа.

3. ***Цугласан мэдээллийг үнэлэх*** – цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах сонголт,


шийдлүүдийг тодорхойлох, үнэлэх ажиллагаа.

4. *Шилдэг шийдэл, шийдвэрийг сонгох* – Зорилгод хамгийн сайн нийцсэн шийдвэрийг сонгох ажиллагаа.

5. Шийдвэрийг хэрэгжүүлэх, хянах – Шийдвэрийн явцыг хянах, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ажиллагаа.

Стратеги батлагдан гарсан даруйдаа хэрэгжихгүй бөгөөд цаг хугацаа, төсөв, санхүү, нөөц шаардсан нэлээд өргөн хүрээний үйл ажиллагаа тул хэд хэдэн үе шатыг дамжин хэрэгждэг[8].

Зураг 2.



Эндээс дүгнэхэд байгууллагын эрхэм зорилгоос урган гарсан зорилго, түүнд хүрэх талаар гарсан үйл ажиллагааны төлөвлөлтүүд нь байгууллагын стратегийн эхлэл болж байна. Гэхдээ байгууллагын зорилго бүхнээс тусгаарлагдсан хийсвэр мөрөөдлийн зүйл байж болохгүй. Байгууллага зорилгоо тодорхойлохын тулд гадаад орчин болон дотоод нөөц боломжоо үнэлж дүгнэнэ. Зорилгоос бүх юм эхэлнэ гэж бодох хэдийгээр амархан ч практикт гадаад, дотоод орчны нөхцөл байдлаа урьдчилан харсан, нөөц боломждоо тулгуурласан хэрэгжих боломжтой зорилгыг сонгох учиртай. Үүний тулд гадаад болон дотоод орчны зүгээс нөлөөлөх эерэг болон сөрөг хүчний зүйлийг судлан дүн шинжилгээ хийх замаар стратегийн боломжит сонголтуудыг дэвшүүлэн гаргах ба үүнийг стратеги төлөвлөлтөд SWOT[9] шинжилгээ гэж нэрлэдэг.

Өнөөдөр төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн алба хаагчийн ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэх, байгууллагын хөгжлийг шинэ шатанд гаргах, шинжлэх ухаан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зэрэг цогц бодлогын хүрээнд төрийн байгууллагын стратеги

[8] *Д.Оргилон*. Стратегийн удирдлага. – УБ., 2017. 10 дах тал.

[9] Байгууллагын гадаад, дотоод орчны хүчин зүйлийн нөлөөллийг судлана. SWOT нь:

Strength – давуу тал буюу тулгуур, түшиг болох хүчин зүйл.

Weakness – сул тал буюу саад болоход анхаарах хүчин зүйл.

Opportunity – боломж буюу ашиглаж болох шинэ санаа, бодол.

Threat – аюул занал буюу учирч болох болзошгүй эрсдэл.

хөгжил цаг үеийн шаардлагаар нэлээд өргөн агуулгаар яригдах болж байна. Энэ талаар ч Монгол Улс онцгой анхаарч төрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хэрэгцээ, шаардлагын үүднээс стратеги хөгжил, төлөвлөлтийн талаар үндэсний хэмжээний эрх зүйн зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлж байна. Тухайлбал Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Төрийн албаны тухай хууль[10]-ийн шинэчилсэн найруулгыг батлан хуулиар төрийн байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн. Тухайлбал хуулийн 53 дугаар зүйлд:

- 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.
- 53.2.Хуульд өөрөөр заагаагүй бол стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална гэж заажээ.

Мөн хуулийн 64 дүгээр зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлж, түүний 64.2.6-д “төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулна” гэж тусгажээ.

Түүнчлэн хуулийн 65.1-т “Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны зөвлөл” гэж тодорхойлоод түүний бүрэн эрхийг хуулиар баталгаажуулан 66.1.8-д “төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах, улсын болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг боловсруулах, хянаж батлахад зохих журмын дагуу санал гаргах” эрхтэй гэж заасан байна.

Эндээс дүгнэхэд төрийн байгууллагууд стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бий болсон тэдийгүй хуульд нийцүүлэн Монгол Улсын Засгийн газраас “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам[11]”-ыг 2019 оны 36 дугаар тогтоолоор батлан энэхүү журмаар Төрийн албаны тухай хуулийн 53.2-т заасан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулна. Журмыг Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай уялдуулан төрийн болон нутгийн удирдлагын байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд стратеги төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад мөрдөхөөр тусгасан байна.

[10] Цахим эх сурвалж, холбоос: https://www.legalinfo.mn/law/details/13025

[11] Засгийн газрын 2019 оны 36 дугаар тогтоолын хавсралт. “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” Цахим эх сурвалж, холбоос: https://www.legalinfo.mn/annex/details/9355?lawid=14106

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаас хойш хоёр сарын дотор, дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ба стратеги төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

- үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх.
- нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх.
- төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх.
- судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх.
- нөөц бололцоонд үндэслэсэн байх.
- ил тод, нээлттэй байх.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөхдөө шаардлагатай *нөөц (хүн, санхүү, техник),* түүний эх үүсвэрийг үйл ажиллагаа тус бүрээр тооцсон байх шаардлагатай.

Байгууллагын стратеги төлөвлөгөө хэд хэдэн бүрдэл хэсгээс бүрдэх бөгөөд тэдгээр нь дараах байдлаар тодорхойлогдоно.

Зураг 3.

Стратеги төлөвлөгөөний бүрдэл хэсэг



Байгууллагын стратеги төлөвлөгөөний нэг онцлог нь түүнийг боловсруулаад орхих бус харин хэрэгжилтэд байгууллага бүр онцгой анхаарч удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахад байдаг.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Стратеги боловсруулах, хэрэгжүүлэх нь хоорондоо нягт уялдаа холбоо бүхий цогц үйл ажиллагаа тул нэг нэгнээс нь салгаж үзэх боломжгүй. Иймд төрийн аль ч байгууллага стратеги удирдлагыг хэрэгжүүлэхдээ төрийн бодлогын залгамж чанарыг хадгалан өөрийн дотоод хүч, нөөц бололцоонд тулгуурлан, судалгаа шинжилгээний үндэслэл бүхий цогц үйл ажиллагааг төлөвлөн, нэгдмэл удирдлагыг ханган ил тод, нээлттэй байхад анхаарч ажиллах нь чухал.

1. Стратеги батлагдсан даруйдаа хэрэгжихгүй бөгөөд цаг хугацаа, төсөв, санхүү, нөөц шаардсан нэлээд өргөн хүрээний үйл ажиллагаа тул нэн тэргүүнд байгууллагынхаа алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлж, дотоод, гадаад орчны шинжилгээнд үндэслэн стратегийн зорилтыг тодорхойлон, улмаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулах шаардлагатай.

2. Байгууллагын хөгжлийн бодлого, стратеги зорилго, зорилтыг тодорхойлоход улс орны нийгэм эдийн засаг, хөгжлийн чиг хандлага, хүн амын өсөлт, суурьшил, амьжиргааны төвшин, цаашлаад улс төрийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйл шууд хамааралтай байдаг тул бодит нөхцөл байдалд үндэслэсэн хэрэгжих боломжтой стратеги хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл байгууллагын стратеги хөтөлбөр хоосон мөрөөдөл байх учиргүй.

3. Төрийн байгууллагын стратеги нь технологийн шинэчлэлийг цогц байдлаар хийх, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл хийх замаар мэргэжлийн төвшинд хүргэх, алба хаагчдын чадвар, удирдах ажилтны манлайллыг сайжруулахад чиглэсэн цогц бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд чиглэсэн байдагт анхаарах нь зүйтэй.

4. Байгууллагын стратеги хөтөлбөрт байнгын шинжтэй жил бүр давтагдан явагддаг ажил, үйлчилгээг тусгахаас аль болох татгалзаж хөрөнгө, санхүүгийн томоохон эх үүсвэр шаардсан, зөвхөн стратеги хөтөлбөрийн хүрээнд хийгдэх томоохон төсөвт ажил, үйлчилгээг тусган үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай.

Ашигласан эх сурвалж

1. Төрийн албаны тухай хууль */шинэчилсэн найруулга/*. Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан.

2. Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам. Засгийн газрын 2019 оны 36 дугаар тогтоолын хавсралт.

3. Д.Ганбаатар. Стратегийн удирдлага. УБ., 2017.

4. Д.Лхаашид, Р.Бадралмаа. Стратегийн удирдлага. УБ.,1996.

5. Стратегийн удирдлага. *орч.* Б.Өлзийсайхан. УБ., 2019.

6. Т.Дорж, Ү.Чимэд. Менежмент: сурах бичиг. УБ., 2000.

7. Кеннет Андрюс. The concept of corporate strategy. 1971.

УДИРДЛАГЫН ОНОЛЫН ШИНЭ ХАНДЛАГА

A NEW APPROACH TO MANAGEMENT THEORY

Г.Наранбаяр
Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, докторант, хошууч
Г.Наранбаяр
Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, докторант, хошууч

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Өрнөдийн удирдахуйн онол, шинэ хандлагыг монгол үндэстний сэтгэлгээ, монгол удирдахуйн сургаальтай харьцуульж судлаачийн байр суурыа илэрхийлнэ. Монгол Улс ардчилал, либерал удирдлагын тогтолцоонд шилжсэнээр өрнөдийн удирдлагын онолыг баримтлах, бэхжүүлэхийг зорьж буй ч өмнөх “X” удирдлага /автократ/-ын тогтолцоо болон өрнөдийн удирдлагын онолын шинэ хандлага /Y,Z/-ын аль аль нь бэхжээгүй саармаг, “хайбрид” хэлбэрт шилжээд буй энэ үед уугуул удирдахуйн ухааны ололтыг нэвтрүүлэх талаар та бүхэнтэй санал бодлоо хуваалцахыг зорилоо.

Abstract: This article compares Western management theory and new approaches with Mongolian national thinking and Mongolian leadership teachings, and presents the researcher's position on direct copying or localization. Although Mongolia seeks to adhere to and strengthen Western management theory through the transition to democracy and liberal governance, but previous “X” system of autocracy and the new approach to Western management theory (Y, Z) have shifted to an undeveloped neutral, "hybrid" form. At this time, I would like to share with you my thoughts on introducing the achievements of indigenous management.

Түлхүүр үг: удирдахуйн ухаан, байгууллагын удирдлага, удирдахуйн ухааны онол, уламжлал, манлайлал

Keywords: management science, organizational management, management theory, tradition, leadership

Монгол Улс нийгэм-улс төрийн тогтолцооны шилжилтийн нэн ярвигтай хямралд автаж, өнөөдрийн хүртэл энэхүү нөхцөл байдлаас бүрэн гарч амжаагүй байна. Энэхүү хямрал нийгмийн давхрагад нөлөөлж, бүхий л түвшиндээ удирдлага /менежмент/-ын тодорхойгүй байдлыг үүсгэж байна. Нийгмийн сэтгэл зүй хэдийгээр шилжилтийн энэ нөхцөл байдлаас даруй гарахыг хүсэх ч хувь хүний төлөвшил, ухамсар, ёс суртахууны үнэлэмж доройтож, боловсролын систем онолын аль суурийг баримтлахаа үл олж, иргэний эх оронч сэтгэлгээ, өөрийн үндэстний үнэт зүйлийг дээдлэх үзэл алдагдаж, нийгмийн уур амьсгал бүхэлдээ шилжилтийн үеийн тогтолцооны хямралд автсан хэвээр байна.

Нийгмийг эрүүлжүүлж, тогтолцооны хямралаас гарахын тулд төр засгийн түвшинд менежментийн нэлээд ажил өрнүүлж, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт олонтаа оруулж буй ч амьдралын хөрсөнд буусан хэрэгжилт нэн ядмаг хэвээр байна. Эрх зүйн баримт бичиг болон удирдлагын арга барилд менежментийн шинэ чиг хандлагын элемент дөнгөж илэрч буй ч түүнийг нутагшуулах чиглэлд хийсэн судалгаа, явуулсан үйл ажиллагаа хомс

байна. Өөрөөр хэлбэл ардчилал, либерал удирдлагын тогтолцоонд шилжсэнээр өрнөдийн удирдлагын онолыг баримтлах, бэхжүүлэхийг зорьж буй ч өмнөх Х удирдлага /автократ/-ын тогтолцоо болон өрнөдийн удирдлагын онолын шинэ хандлага /Y,Z/-ын аль аль нь бэхжээгүй саармаг, “хайбрид” хэлбэрт шилжээд байна.

Даян дэлхий даяаршиж, ардчилал хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх нэг үнэт зүйлтэй, нэг тогтолцоот удирдахуйн онолыг өрнөдийн орнууд сурталчилж, энэхүү онолоор ардчилсан улс орон бүрийн удирдлагын тогтолцоог шилжүүлэхийг хүсэх авч үндэстэн бүрийн онцлог, ертөнцийг үзэх үзэл, иргэншил, иргэншинхүйн чанар харьцангуй өөрмөц тул нэгдсэн нэг онолоор удирдах явдал эцэстээ мухардалд хүрч болзошгүйг бид өөрийн амьдралын сүүлийн 30 жилийн түүхээр нотолж байна гэхэд хилсдэхгүй.

Энэхүү өгүүлэлд өрнөдийн удирдахуйн онол, шинэ хандлагыг Монгол үндэстний сэтгэлгээ, монгол удирдахуйн сургаальтай харьцуулж, шууд хуулбарлах эсвэл нутагшуулах асуудлаар судлаачийн байр суурыа илэрхийлэхийг зорилоо.

Байгууллагын удирдлагын онолын шинэ чиг хандлага, түүнийг нутагшуулах үйл явц

Байгууллагын менежментийг гурван үе шатад хуваажүздэг [1] . Тодруулбал, дээд, дунд, анхан шатны менежментийн үйл ажиллагаа байдаг. Үүнээс дээд шатны удирдлага байгууллагын алсын хараа, стратегийн зорилгыг тодорхойлдог, дунд шатны удирдлага дээд шатны удирдлагаас тодорхойлсон зорилгыг хэрхэн үр дүнтэй гүйцэтгэх хариуцлагын тогтолцоо, төлөвлөлтийг хангах үүрэгтэй бол анхан шатны менежерүүд гүйцэтгэлийн нэгж дээр хийх ажлыг хариуцдаг гэж болно. Өөрөөр хэлбэл, дээд шатны удирдлага зорилгоо тодорхойлж, төлөвлөгөө боловсруулж, байгууллагыг бүхэлд нь удирдан чиглүүлдэг. Дунд шатны удирдлага дээд шатны удирдлагаас тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд хийх ёстой ажлыг тодорхойлж, хариуцдаг. Харин анхан шатны менежерүүд өдөр тутмын ажлыг гардан гүйцэтгэгч юм. Энэ гурван шатны менежерийн хийх ажил ерөнхийдөө ижил боловч ур чадвар, давуу тал, туршлага, ур ухаанаас шалтгаалж, үүрэг оролцоо нь өөр өөр байдаг хэдий ч бүгд зорилгодоо хүрэх нэгдмэл үйл ажиллагааны цогц байна. Энэ үйл ажиллагааны цогцыг дээд удирдлага бүхэлд нь удирдан чиглүүлэх үүрэг хариуцлагатай болно. Энэ цогц ажиллагааг удирдан зохион байгуулахад зөвхөн тушаал өгөх биш харин ажилчдынхаа хүчийг нэгтгэн нэг зорилгод чиглүүлэх, авьяас чадвараа нээхэд туслах, шинэ бүтээлч сэтгэгчийг бий болгох таатай орчин бүрдүүлэхэд санаа тавьдаг байх явдал ихээхэн чухал. Удирдлагын ухааны гол зорилго аливаа үйл ажиллагааг зохион байгуулж, удирдах үйл явцдаа хамт олныг нэгтгэн зангидсанаар байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрч чаддагт оршдог. Ийм нэгдмэл байдал бол төгс удирдлагын цогц байна.

[1] Байгууллагын менежментийн түвшин. Өндөр, дунд, бага ба бага холбоосын менежерүүд: Үндсэн чадвар ба өвөрмөц байдал. Цахим эх сурвалж, холбоос: https://chrome-effect.ru/mn/glazing/urovni-upravleniya-organizaciei-menedzhery-vysshego-srednego-i/.

Дээд шатны удирдлагын удирдлага, шийдвэр, тушаал байгууллагад бүхэлд нь нөлөөлдөг. Иймээс байгууллагын дээд шатны удирдлага аливаа шийдвэрийг гаргахдаа стратегийн ач холбогдлыг ямагт тооцох шаардлагатай. Ийм холч ухаан нүүдэлчдийн сэтгэлгээнд тогтсон сэрэл байдаг. Гагцхүү үүнийг сэргээх үүднээс өрнөдийн удирдлагын онолын сууриас өөрийн үндэстний удирдахуйн онолын ялгагдах шинж, нутагшуулах буюу алийг нь авах боломжтойг тодорхойлох нь зөв.

Менежментийн шинжлэх ухаан үүссэн цаг хугацаа, үзэл баримтлал, нөхцөл шалтгаан, үр дагавар, орон зайтай. Захирах, захирагдах ёсны харилцаа бий болсноор удирдлагын шинжлэх ухааны үр хөврөл үүсч бий болсон гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, улс орон бүр өөрийн менежментийн баялаг түүхтэй. Монголчуудын тухайд бидний ахуй соёл, удирдахуйн онцлогийг бүрнээ харуулсан “Монголын нууц товчоо”-нд удирдахуйн ухаан, захирах захирагдах ёсны тухай цөөнгүй удаа өгүүлсэн байдаг. Тухайлбал, *“... Боданчар Буху Хатаги ах юугаан хойноос дагаж хатирч явж өгүүлрүүн: Бие тэргүүт-дээл захт сайн хэмээв …”, “... Боданчар өгүүлрүүн: Тугаарын Түнхлэг горхиноо бүхүн иргэн их өчүүхэн ...” буюу “... Муу сайн, тэргүүн шийр үгүй, сацуун буй. Хялбар иргэн буй бид тэднийг агуулъя...”* [2] хэмээн гардаг нь хүн хооронд харилцаа үүсч, тэдний оюун сэтгэхүй, хүч чадал, авъяас билгийн ялгарал бий болсон явдал менежмент өөрөө төлөвших урьдчилсан нөхцөл болсныг илтгэсэн монгол удирдлагын онолыг суурийг харж болно.

Дээд шатны удирдлага байгууллагын имиж бүрдүүлэх, соёлыг бэхжүүлэхэд ихээхэн чухал нөлөөтэй. Удирдах албан тушаалтан олон талын мэдлэг, чадвартай, мэргэжлийн өндөр боловсролтой, ёс зүйн зөв төлөвшилтэй, хувийн соёл, удирдлагын олон талт арга барилтай, багаар ажиллах чадвартай, түүнчлэн нийгмийн хөгжлийн онцлог, чиг хандлагыг зөв танин мэдэх, дүн шинжилгээ хийх, түүнийг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгтэй уялдуулан холбож цаг үедээ нийцсэн оновчтой шийдвэр гаргах ур чадварыг эзэмшсэн байхыг өнөөгийн цаг үе шаардаж буй талаар удирдахуйн ухааны чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дурддаг. Гэвч сонгуулийн үр дүнд эрх мэдэл улс төрийн нэг хүчнээс нөгөөд шилжиж буй өнөө үед төрийн, төрийн бус, аж ахуйн бүх байгууллагын удирдлагын тогтолцоонд үндсэн өөрчлөлт гарсан. Өөрөөр хэлбэл, мэдлэг, туршлагаар ихээхэн ялгаатай, янз бүрийн түвшний хүмүүс удирдлагын ажлыг хаших болсон. Ингэж удирдахуйн ухааны онолыг үзсэн, үзээгүй олон хүн дээд удирдлагын албыг тодорхой хугацаатай /гол төлөв сонгуульт дөрвөн жилийн хугацаатай/-гаар хаших болсон явдал удирдлагын түвшинд дээр дурдаад буй чадавх, чадварыг бэхжүүлэх боломжийг олгохгүй байна. Хэдийгээр чадахуйн зарчмын эхний элемент хууль эрх зүйн баримт бичигт тусах болсон ч зөвхөн ажилласан жилийн хугацаа, туршлагтай холбож ойлгож байгаа нь харамсалтай.

Мерит буюу чадахуйн зарчим бол зөвхөн он удаан жил ажилласан

[2] Ц.Дамдинсүрэн. Монголын нууц товчоо. Уб., 1990. 30 дахь тал.

хугацаа, туршлагыг үндэслэх төдий бус хамт олондоо хүлээн зөвшөөрөгдөх, манлайлалын асуудлыг агуулдаг болно. Учир нь тухайн албанд 12 жил ямарваа үр бүтээлгүй ажиллаад миний хугацаа болсон би нэгжийн даргаар ажиллах ёстой гэж болохгүй. Энд дурдагдаж буй манлайлал гэдэг ойлголт илэрхий, ойлгомжтой мэт боловч нарийн төвөгтэй асуудал. Тийм ч учраас манлайлал судлалын шинэ урсгал эрчимтэй хөгжиж байна. Энэ чиглэлийн нэрт эрдэмтэн Жэймс Мак Грегор Барнс[3] "... манлайлал бол ертөнц дээрх хамгийн их судлагдсан мөрт хамгийн бага ойлгогдсон ухагдахуун ..." хэмээн дүгнэсэн байдаг. Ийм дүгнэлтэд нэрт судлаач Уоррен Беннис мөн хүрч байж. Тэрээр "манлайллыг асар их судалсан ч манлайллын талаар хэлэх зүйл харьцангуй бага", "нийгмийн ухааны бүхий л салбарт манлайллыг маш их судалсан ч түүнийг маш бага ойлгодог"[4] тухай дурдсан байна. Энэхүү нарийн төвөгтэй асуудлыг судлах, онол, арга зүйн үндсийг тодруулахын тулд тодорхойлолт, онол, менежмент ба манлайллын уялдаа холбоо, төрийн ба хувийн салбар дахь манлайллын ялгаа зэрэгт шинжилгээ хийх нь чухал. Иймд манлайлагч алба хаагчийг бэлдэх боловсон хүчний бодлоготой байх ёстой. Харамсалтай нь өнөө цагт аль ч шатны байгууллагын хүний нөөцийн алба алба хаагчдын хувийн хэргийг хадгалах, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, холбогдох тушаалыг хадгалах, шагнал урамшуулалд тодорхойлох зэрэг бюрократ[5], бичиг хэргийн ажлыг эрхэлж байгаагаас өөрөөр урт хугацаанд удирдах албан тушаалтан бэлдэх ямар ч бодлогогүй, ингэх ч боломжгүй явсаар ирсэн нь Өрнөдийн менежментийн онолын үнэр ханхалах төдий байгаагаас суурших болоогүйг илтгэдэг. Өөрөөр хэлбэл бид *Human resources* буюу хүний нөөцийн явцуу утга болох хүний капитал гэх утгыг барьж буйгаас менежментийн цогц ойлголтоор хөгжүүлж чадахгүй байна.

Удирдлага гэдэг олон талт урсгал хандлага, үйл ажиллагааны нийлбэр цогц учраас менежментийн орчин үеийн урсгалаас удирдлагын практикт ашиглах боломжтой. Үүнийг гэхдээ зөвхөн дээд удирдлагын удирдагчдын оюуны мэлмийд найдаад орхих бус харин ийм түвшний буюу стратегийн түвшний сургалтыг удирдах албан тушаалтанд зориулж явуулахдаа онолын аль урсгалыг авах, алийг нь орхих, алийг нутагшуулж болох тухай тодорхой тайлбарлах нь зөв. Ийм ч учраас Төрийн албаны тухай хуулинд "Мэргэшүүлэх багц" сургалтын асуудлыг хөндсөн байдаг. Гагцхүү төрийн тусгай алба хаагчдын "Мэргэшүүлэх багц сургалт"-ыг ямар байгууллага зохион байгуулах тухай асуудал хуулинд бүрхэг заалттай байгааг олон судлаач илэрхийлж байна.

Дээд шатны удирдлага нь стратегийн түвшний удирдлага учир тухайн түвшний удирдагч болохын тулд аливаа асуудлыг цогцоор харах чадвар, ёс суртахуун, манлайлал, шинжлэх ухаанд суурилсан, амьдралд хэрэгжих боломжтой шийдвэр гаргах зэрэг онол арга зүйн өргөн мэдлэг шаарддаг байна. Иймд түүний шийдвэр бүхий л түвшиндээ обьектив байж, аливаа субьектив хандлагаас ангид байх ёстой.

[3] James MacGregor Burns. АНУ-ын түүхч, улс төр судлаач.

[4] James MacGregor Burns.Leadership. Washington. 1978. Kindle edition 2012.

[5] Захиргаа удирдлага

Үүнийг төр, хувийн хэвшлийн аль ч байгууллагын дээд шатны удирдлага онцгой анхаарах явдал өргөн утгаараа нэгдмэл нэгэн зорилгод тэмүүлэх, эрүүл нийгмийн тогтолцоог бий болгоход ихээхэн чухал болно.

Дунд шатны удирдлага анхан шатны менежерийг дэмжих, туслах, мотивац өгөх, хянах зэрэг үүрэгтэй байдаг. Үүний зэрэгцээ дээд шатны удирдлагад *feedback/ санал, хүсэлт/* гаргах болон зөвлөгөө өгч байх үүрэгтэй. Бүхэлдээ хариуцлагын тогтолцоог зангидаж, холбогчийн үүрэг гүйцэтгэх ёстой байдаг. Учир нь дунд шатны удирдлага байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг тул байгууллгын үйл ажиллагаанд эерэгээр болон сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйлийг мэдэхийн зэрэгцээ хэрхэн сайжруулах арга замыг боловсруулах боломжтой байдаг.

Энэ түвшний удирдлагад харилцааны чадвар ихээхэн шаардлагатай. Өөрөөр хэлбэл тэд холбогчийн үүрэг гүйцэтгэдгийн хувьд удирдлага болон доод түвшний менежерүүдийн сэтгэлзүйн онцлог, хандлагыг сайтар мэдэх шаардлагатай болдог.

Удирдахуйн ухааны онолын хувьд дунд шатны удирдлагад мэдлэгийн менежментийн асуудал нэн чухал. Мэдлэгийн тухайд байгаль, нийгмийн юмс үзэгдэл, тэдгээрийн мөн чанар, хөгжил, хөдөлгөөний талаарх ойлголт хэмээн үздэг уламжлалт ухагдахуун үндсээрээ өөрчлөгдөж байгааг анхаарах хэрэгтэй. Мэдлэг бол зөвхөн юмс үзэгдлийг танин мэдэх процесс бус харин олж авсан мэдлэгээ амьдрал, үйл ажиллагаандаа хүртээмжтэй, оновчтой хэрэглэх тухай асуудал болж байна.

Мэдлэгийн менежментийн үзэл санааг анх дэвшүүлсэн гэгддэг Хитоцубаши Их сургуулийн Бизнесийн судалгааны институтийн захирал, профессор Икюжиро Нонака / Ikujiro Nonaka 野中 郁次郎/-ийн үзсэнээр “Хувь хүн, байгууллагын үр дүнтэй ажиллах чадварыг хэрхэн дээшлүүлж болохыг нотолсон итгэл үнэмшил бол мэдлэг[6]” гэжээ. Энэ шинэ онолын урсгалын өөр нэг гол төлөөлөгч Шведийн судлаач Карл–Ерик Свейби “ Мэдлэг бол ажил хийх чадвар” юм хэмээн тодорхойлсон байна. Нүүдлийн сэтгэлгээнд ажлын ур ухаан, дүйтэй байхыг эрдэм гэж үнэлдэг бөгөөд ийм чадвартай хүнийг эрдэмтэй хүн гэж үнэлж хүндэтгэдэг онцлогтой.

Менежментийн шинэ онолын хандлагын амин сүнс хүний мэдлэг, ур чадвар, авъяас чадвар, урам зориг, бие даасан байдал, оролцоо, хариуцлага санаачлагыг хэрхэн өрнүүлэх, хамт олон болон байгууллагынхаа ажил үйлсэд өөрийн гэсэн сэтгэлээр хандаж хамтдаа өсөж хөгжих, түүнийхээ үр дүнг хамтдаа хүртэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байна. Ийм удирдлагын тогтолцоо бидний хувьд тийм ч шинэ зүйл биш. Учир нь өмнөх нийгмийн хөгжлийн явцад бид хамтрал, нэгдэл, сангийн аж ахуй нэртэй төрийн өмчит компанийн байгууллагатай, Шинэ бүтээл оновчтой санал уралдаантай, мэдлэг чадвар, авьяас, санаачилгыг үнэлдэг хэмжүүртэй, дор бүрнээ хариуцлагын тогтолцоотой явж ирсэн.

Эдүгээ мененжментийн ирээдүй тухайн удирдлага, хувь хүний төдийгүй,

[6] The Knowledge-Creating Company. Цахим эх сурвалж. Холбоос: https://hbr.org/2007/07/the-knowledge-creating-company

нийт хамт олны хөдөлмөрийн үр дүнгээс хамаарч амьдралын чанарын стандартыг хангадаг, хийж бүтээж байгаа зүйлээ илүү үр дүнтэй, илүү боловсронгуй болгох, илүү сайн болгохын төлөө хүн бүр шаргуу ажиллах, тасралтгүй шинэчилж сайжруулах /инноваци/ тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлж чадаж буй тэр байгууллага л амжилтад хүрэх бөгөөд түүнийгээ тогтвортой хадгалах чиглэлд анхаарч хөгжих тухай судлаачид тэмдэглэж байна. Үгтаа хэдийгээр удирдахуйн онолын хувьд X загварын буюу авторитар удирдлагын тогтолцоотой байсан онолын энэ шинэ гээд байгаа хандлага өмнөх нийгмийн үед манай байгууллагын тогтолцоонд үндсэндээ оршиж байсан болно.

Дунд шатны удирдлага нь тактикийн түвшний удирдлага бөгөөд стратегийн түвшинд дэвшүүлсэн зорилго, үйл ажиллагааны тактикийг боловсруулж, мэдлэгийн менежментийг үйл ажиллагаандаа хэвшүүлж, бодлогыг хэрэгжүүлэх матрицийн олон хувилбарыг ашиглах чадвартай байх ёстой.

Анхан шатны менежер байгууллага дахь ажлын нэгж бүрт байх бөгөөд байгууллагын зорилгыг тодорхойлохгүй боловч тэд байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлдэг. Тэдгээр нь өдөр тутмын ажлыг гардан хийдэг ажилтнуудтай байнга харилцдаг тул хэрэв тааруухан манлайлалтай бол ажилтнуудын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх, зохих мотивацыг өгч чадахгүй, улмаар ажилтнуудаа алдах эрсдэлтэй. Ийм эрсдэл төрийн бүх шатны байгууллагад түгээмэл шинжтэй болсон. Үүнд дан ганц анхан шатны менежерийн буруутай үйлдэл бус харин холбогчийн үүргээ зөв гүйцэтгэж чадахгүй байгаа дунд түвшний удирдлагын ур чадвар ч холбоотой. Ийм ч учраас зарим тохиолдолд менежментийг шинжлэх ухаан гэхээсээ хүнтэй харилцах урлаг гэж үзэх хандлагын асуудал гарч ирдэг. Менежментийн онолыг урлаг болгох түвшинд хөгжүүлэх асуудал үнэндээ дээд түвшинд бус гагцхүү доод буюу анхан шатны менежерийн түвшинд шаардагдах ухагдахуун болно. Тийм ч учраас өнөө үед менежментийг нэг талаас мэдлэгийн бие даасан төрөл буюу салбар шинжлэх ухаан, нөгөө талаас хувь хүний авъяас чадварыг илэрхийлэх урлагийн нэгэн төрөл гэсэн нэгдмэл байр сууринаас хандах явдал илүүтэй давамгайлах болсон байна.

Энэ ухагдахуун дорно дахин, түүний дотор Монгол ахуй сэтгэлгээ, соёлын үүднээс авч үзвэл арга билиг, сав шим ертөнцийн зохилдлогоо, хорвоогийн хэрэг явдлын шүтэн барилдлага талаас авч үзвэл тийм ч шинэ зүйл биш. Зөвхөн менежментийг шинжлэх ухааны үүднээс авч үзэж тайлбарлаж ирсэн өрнөдийн судлаач, шинжээчдийн хувьд гарцаагүй шинэ зүйл төдийгүй, сэтгэлгээний томоохон хувьсал, эргэлтийн шинжтэй өөрчлөлтөд тооцогдох юм. Монголчуудын түүхэн сэтгэлгээний тод илрэл болох ардын билиг зүй, аман зохиолд ур ухаан, ов мэхийг урлаг болгож, аз жаргалд хүргэсэн олон үлгэр бий.

Анхан шатны менежерт ажиллаж буй салбар, үйл ажиллагаандаа мэдлэгийн менежментээ оновчтой ашиглах туршлага шаардагддаг. Монголчууд “урмыг хугалахаар ууцыг хугал” гэдэг. Анхан шатны менежерүүд ажилтны бүтээлч ур чадварыг нэмэгдүүлэх, хамт олны уур амьсгал, нэгдмэл байдлыг хангахад ихээхэн нөлөөлтэй. Учир нь тэд гүйцэтгэх

түвшний менежер бөгөөд тактик хувилбарыг оновчтой хэрэгжүүлэгчид байдаг.

Дүгнэлт

Либерал ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, үнэт зүйлийнхээ нэг болгосон улсын хувьд Өрнөдийн удирдахуйн ухааны дэвшилтэт урсгалыг нутагшуулах, тэр дундаа байгууллагын менежментэд нэвтрүүлэх нь зүйн хэрэг. Учир нь удирдлага гэдэг олон талт урсгал хандлага, үйл ажиллагааны нийлбэр цогц тул менежментийн орчин үеийн урсгалаас удирдлагын практикт ашиглах бүрэн боломжтой. Гэхдээ өөрийн үндэстний уугуул удирдахуйн онол сургаалийг сайтар судалж, онол арга зүйн үндсээ бүрэн тодорхойлоогүй учраас бидний оюун сэтгэлгээнд хадгалаатай байдаг сэрлийг цоо шинэ үзэгдэл мэт хүлээж авах, мөн нүүдэлчдийн сэтгэлгээнд суурилж чадаагүй эсвээс огт суурьших боломжгүй онолыг бүх түвшиндээ дагаж мөрдөхийг чармайх явдал удирдлагын шийдвэрийн тодорхойгүй, ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгож, эрхэмлэн дээдлэх, захирагдах, захирагдахуйн ёс аль нэг туйлдаа хүрч байна.

Байгууллагын менежментийн гурван түвшний удирдлага бүхэлдээ нэг зорилгод хүрэх стратеги, тактик болон оператив зорилго, төлөвлөлт, үйл ажиллагааны цогц тул бүх шатны байгууллага мөн удирдлага аливаа шийдвэрийг шинжлэх ухаанд суурилж обьектив гаргаж, субьектив удирдлагын арга барилаас салахын тулд бүх шатны удирдлагад зориулсан сургалт шаардлагатай. Гэвч төрийн тусгай алба хаагчдад энэ сургалтыг аль боловсролын байгууллага явуулах нь эрх зүйн баримт бичигтээ ч тодорхойгүй байна.

Удирдахуйн ухааны чухал асуудал болох хүний нөөцийн удирдлагад хүний капитал гэх утгыг түгээмэл хэлбэрээр ойлгож байгаа нь манлайлагчийг бэлдэх асуудалыг байгууллагын менежментийн цогц ойлголтоор хөгжүүлж чадахгүй байна.

Энэ бүхэн бид удирдахуйн ухааны номлол, даган баримтлах чиг шугамаа эргэж харж өөрийн үндэсний болон өрнөдийн онол урсгалаас бидний хөрсөнд тохирсон холимог удирдлагын онол буюу монгол удирдахуйн дэг журмыг бий болгох шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалж:

1.Ц.Дамдинсүрэн. Монголын нууц товчоо. Уб., 1990

2.Г.Төртогтох, Т.Наранцогт. Байгууллагын менежмент. Уб., 2013

3.Ч.Пүрэвдорж. Байгууллагын менежмент. Уб., 2005.

4.Д.Ганбаатар, Я.Шуурав, Д.Сэржамц Менежмент. Уб., 2017.

5.Я.Шуурав. Менежментийн шинэ прадигма. Уб., 2014.

6.James MacGregor Burns.Leadership. Washington. 1978. Kindle edition 2012.

7.http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634

8.http://www.ubstat.mn/StatTable=3909

9.The Knowledge-Creating Company. https://hbr.org/2007/07/the-knowledge-creating-company

МОНГОЛ УЛС ДАХЬ МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА, АНХААРАХ АСУУДАЛ

CURRENT SITUATION OF ILLICIT TRAFFIC IN NARCOTIC DRUGS AND PSYCHOTROPIC SUBSTANCES IN MONGOLIA, FUTURE TRENDS AND CONSIDERATIONS

Р.Гэрэлбат
Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Эрүүгийн цагдаагийн хэлтсийн ахлах мөрдөгч, магистрант цагдаагийн хошууч
Gerelbat. R
Senior Criminal Intelligence officer, Criminal Police Division of Countering Narcotics Department, National Police Agency, Police Major

Хураангуй: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн олон улсын болон Монгол Улс дахь нөхцөл байдал, энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүн, тулгамдаж буй асуудлууд, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаарх саналыг боловсруулахад оршино.

Түлхүүр үгс: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, хууль бус эргэлтийн нөхцөл байдал.

Abstract: The International and Mongolian context of illicit circulation of Narcotic Drugs and Psychotropic Substances, the results and challenges of the activities implemented to combat this crime, and the proposal for future work and measures.

Keywords: Narcotic Drugs, Psychotropic Substances, conditions of illegal circulation.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (Цаашид - НҮБ) Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албa (UNODC)-ны 2021 оны тайланд COVID-19 цар тахлаас үүдэлтэй дэлхий нийтээр тогтоосон хатуу хязгаарлалт, хөл хорио нь мансууруулах бодисын тариалалт, үйлдвэрлэлт, эрэлт нийлүүлэлт, тээвэрлэлтэд огцом нөлөөлөн улмаар гэмт бүлэглэлүүд нөхцөл байдалд дасан зохицож мансууруулах бодисыг тээвэрлэх, түгээх шинэ арга хэлбэрийг ашиглаж байна. Мөн цар тахлын үеийн хязгаарлалт, хорио цээрийн дэглэм нь мансууруулах бодисын хэрэглээнд тодорхой нөлөөлөл үзүүлж мансууруулах үйлчилгээ үзүүлдэг ургамал болон эмийн хэрэглээ дэлхий нийтээр өссөн тухай дурьджээ.[1]

Дээрх нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор гадаад хамтын ажиллагааг элсэн орсон гэрээ конвенц болон хамтран ажиллах гэрээний дагуу идэвхтэй өрнүүлэх, шинэ мэдээллийг шуурхай харилцан солилцох зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймд Монгол улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, анхаарах асуудлуудыг судлахад оршино.

[1] НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албa (UNODC)-ны 2021 оны тайлан. https://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/wdr2021.html

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэргийн түүхэн уламжлал

Судлаачдын үзэж байгаагаар, хүн төрөлхтөн мансууруулах бодисыг эртнээс таньж, хамгийн анх намуу цэцгийг Месопатамчууд [2] манай тооллын өмнөх 340 жилийн тэртээ хэрэглэж байсан нь эртний булш, бунханаас олдсон эд өлгийн зүйл, хадны сүг зураг зэргээс ажиглагддаг [3] тухай тэмдэглэсэн байна. 1839-1842, 1858 онуудад Манж Чин улс, Англи улстай хийсэн “хар тамхины I, II дайн” -д ялагдсанаар дайны төлбөрт нийт 25 сая доллар төлөх болов. Иймд торго, цай зэрэг дотоодын бүтээгдэхүүнээ гадаадад гаргаж оронд нь хар тамхи оруулж, хэрэглэх явдлыг өөрийн эзэмшлийн орнуудад чөлөөтэй болгожээ. Тухайн үед зөвхөн Хятадад хар тамхийг 1 сая хүн хэрэглэдэг байсан бол XX зууны эхэн үе гэхэд хэрэглэгчийн тоо 100 саяд хүрсэн байна. Энэ байдал нь Манжийн колони байсан Монгол оронд шууд нөлөөлж Манжийн төрийн бодлогын оролцоотойгоор эхэлсэн ба Монголд цагаачлан ирсэн хятад иргэд Манжийн хятадчилагдсан төрөөс явуулсан Шинэ засгийн бодлогоор хятад иргэдийг Ар монголд суурьшуулах шийдвэр гаргаж байсан нь байдлыг улам дэвэргэж, ядуу буурай Монголын нийгэмд бодитой аюул занал учруулж эхэлсэн байна.[4]

Манай улсын хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх төрлийн ургамал “опиум, намуу цэцэг, зэрлэг олс г.м” ургадаг боловч нийгмийн хөгжлийн онцлог хийгээд ард түмний сэтгэхүйтэй холбоотойгоор тэдгээрийг хэрэглэж заншаагүй цөөн тооны улс орны нэг юм[5].

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг нэр томьёоны хувьд авч үзвэл. Хууль зүйн талаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис гэдэгт донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай 1971 оны НҮБ-ын конвенцийн жагсаалтанд заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг хэлнэ [6] гэж тодорхойлсон байдаг.

Зарим сурах бичгүүдэд мансууруулах бодис буюу хар тамхи гэдгийг төв мэдрэлийг тодорхой дарааллаар дарангуйлж нийтэд нь юмуу нэгээхэн хэсэгт нь мэдээ алдуулагч бодисууд гэж бүтцийнх нь талаас тодорхойлдог.

Харин Я.Цэвэлийн монгол хэлний толь тайлбар толь бичигт “намуу цэцгийн төрөл урт бөгөөд том навчтай, шар буюу улаан цэцэгтэй ургамал”, түүнийг гүйцэд боловсроогүй байхад огтолж сүү мэт шүүсийг авч хатаасныг хэлнэ гэж гаднах шинж чанарыг заасан[7] бол англи хэлний толь бичигт грек үгнээс гаралтай бөгөөд хөшөөх, мэдээ алдуулах, мансууруулах чанартай тодорхой зүйлийн ургамлын гаралтай

[2] Азийн баруун урд хэсэгт оршиж байсан омог.
[3] ХЗЯ, УМБГ. Хар тамхитай холбоотой гэмт хэргийг шалгахад анхаарах зарим асуудал. УБ., 2014 он. 5 дахь тал.
[4] Ж.Болдбаатар "Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологи шинж " УБ, 2000 он., 12 дах тал
[5] Д.Адьяабазар "Мафи /Гэмт байгууллага/" УБ, 1999 он. 84 дэх тал
[6] Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай. УБ. 2002 он., №46
[7] Я.Цэвэл "Монгол хэлний тайлбар толь” УБ, 1966 он., 456 дах тал

болоод химийн бодис, хортойгоор хэрэглэвэл хар тамхинд донтох өвчин үүсгэнэ.[14] Энэ бодис нь эмнэлэг анагаах ухаанд мэдээ алдуулах, өвчин намдаах, нойрсуулах зорилгоор хэрэглэгдэж болно гэж тайлбарласан байна. Бидний бодлоор мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис гэдэг нь эмийн найрлагад агуулсан эсхүл байгалийн болоод нийлэгжүүлэх аргаар гаргаж авсан мансууруулах үйлчилгээ үзүүлж, хүний бие, оюун ухааныг түр зуур идэвхжүүлэх боловч түүнийг хэрэглэсэнээр төв мэдрэлийн системд нөлөөлж, сэтгэцийн хүнд өвчнөөр өвчлүүлэх, донтуулах үйлчилгээтэй бодис тэдгээрийн нэгдэлийг хэлнэ.

Гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн:

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн шинжийн хувьд авч үзвэл:

Обьект: Хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих талаар хуулиар тогтоосон журам байна.

Халдлагын зүйл нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, мансууруулах бодисын түүхий эд байна.

Обьектив тал: Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн идэвхтэй үйлдэл байна.[8] Эдгээр үйлдлийн аль нэгийг хийснээр төгсдөг хор уршиг учирсан байхыг шаардахгүй, хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Субьектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгднэ. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах нь хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байдаг.

Субьект: 14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хэн ч байж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг нь Эрүүгийн хуульд зайлшгүй байвал зохих нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, хор уршиг учруулдаг үйлдэл, эс үйлдэхүй байх шинжээрээ гэмт хэргийн шинжийг агуулж байгаа юм.

Олон Улсын болон Монгол Улсын нөхцөл байдал

“COVID-19” цар тахлын нөлөөнөөс хамаарч дэлхий нийтээр мансууруулах бодисын нийлүүлэлт, улс хоорондын тээвэрлэлт доголдож хомсдол үүссэнээс эрэлт ихсэж байна. Эрэлтээс үүдэлтэй мансууруулах бодисын хэрэглээнд өөрчлөлт орж мансууруулах эмийн болон каннабисын хэрэглээ дэлхий нийтээр огцом өсч олсны ургамлын /каннабис/ тариалалт 20-30% хувиар нэмэгдсэн.

Мансууруулах бодисыг тээвэрлэхдээ шуудан илгээмжийг ихэвчлэн ашиглаж, захиалга болон худалдаа цахим орчинд (darknet буюу цахим орчин дахь хар зах зээл) бүрэн шилжин цар тахлын хязгаарлалтанд хамаарахгүй түгээлтүүдийн /дрон ашиглах, хүнсний болон эм эмнэлэгийн хэрэгслийн хүргэлт, түгээлт гэх мэт/ хэлбэрүүдийг өргөн ашиглах болсон нь онцгой анхаарал татах боллоо[9].

[8] С.Гантулга, Б.Энхболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /тусгай анги/. УБ. 2018 он., 313 дах тал

[9] НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны 2021 оны тайлан

Афганистан Улсад үйлдвэрлэгдсэн метафетамин хямд үнээр их хэмжээтэй хар зах зээлд нийлүүлэгдэж Арабын Нэгдсэн Эмират, Кувейт, Шри Ланка, Мальдив, Австрали, Индонези болон Балканы орнууд руу чиглэсэн шинэ маршрут бий болсон байна[10].

Зураг №1



Афганистанд үйлдвэрлэсэн мансууруулах бодисын хууль бус эргэлтийн чиглэл, маршрут[11]

Манай улсын хувьд сүүлийн 4 жилийн байдлаар улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 769 гэмт хэрэгт 968 хүн холбогдон шалгагдаж 2021 оны 8 дугаар сарын байдлаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 107 гэмт хэрэгт 121 хүн холбогдон шалгагдсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүртгэгдсэн гэмт хэрэг 24 буюу 18.3 хувиар, хэрэгт холбогдсон хүн 54 буюу 30.9 хувиар тус тус буурсан.

Хүснэгт №1




Дээрх судалгаанаас үзэхэд, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг 2016 онд 1895, 2017 онд 1069, 2018 онд 314, 2019 онд 333, 2020 онд 291 гэмт хэрэг

[10] “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт” сэдэвт Интерполын 3 дахь удаагийн олон улсын бага хурлын тэмдэглэл. 2021 он

[11] “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт” сэдэвт Интерполын 3 дахь удаагийн олон улсын бага хурлын тэмдэглэл. 2021 он

бүртгэгдсэн[12] бөгөөд энэхүү гэмт хэрэг жил ирэх тусам буурах хандлагатай байгааг харж болно.

Хүснэгт №2



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг улсын хэмжээнд бүртгэгдсэн жилийн эцсийн сарын байдлаар авч үзвэл 2017 оны 12 сард 90, 2018 оны 11 сард 190, 2019 оны 12 сард 257, 2020 оны 12 сард 202, 2021 оны 08 сард 107 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн[13].

“Ковид-19” цар тахлын улмаас тогтоосон хөл хорио, хязгаарлалтаас хамаарч гаднаас нийлүүлэгдэх мансууруулах бодис хомсдоноор тархалт ихтэй аймаг, сумдын нутаг дэвсгэрээс каннабисыг түүж бэлтгэн боловсруулж хэрэглэх, мансууруулах үйлчилгээтэй эм, эмийн түүхий эд бэлдмэлийг зориулалтын бусаар ашиглах, энэ төрлийн эм хэрэглэдэг өвчтөнүүдийн жорыг ашиглах, хуурамч жор үйлдэн олж авч хэрэглэх явдал нэмэгдсэн.

Газарзүйн байршил, бүс нутгийн онцлогоос хамааран Афганистанд үйлдвэрлэсэн үнэ хямд мансууруулах бодис (метафетамин) Монгол Улсад ниилүүлэгдэх магадлалтай байгаа нь зайлшгүй анхаарах асуудлын нэг болж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ

Монгол Улс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх түүхэн уламжлалтай бөгөөд тухайлбал Богд Хаан 1912 оны 6 дугаар сарын 27-нд хар тамхийг тээвэрлэх, худалдах, хэрэглэхийг цаазлан хорих тухай зарлиг гаргаж байжээ.

Манай улс Нэгдсэн үндэстний байгууллагаас гаргасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эсрэг конвенциудад нэгдэн орж, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад

12 https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_036V4

13 https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_036V4

Ард Улс, Бүгд Найрамдах Казахстан Улстай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг байгуулан хамтран ажиллаж байна.

Монгол Улсын төр мансууруулах бодисын талаарх олон улсын санал, санаачилга болон үүрэг зорилтыг хангахын төлөө хүчин чармайлт гарган ирсэн бөгөөд 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хуулийг баталж, 2000-2005 онд "Хар тамхи, мансуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөр" хэрэгжүүлсэний үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн илрүүлэлт өсч гаралт буурсан.

Монгол Улсын Засгийн газраас 2017 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэх "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг дахин батлан хэрэгжүүлж байгаа ба мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгаас урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, иргэдийг соён гэгээрүүлэх гол зорилгыг агуулсан байдаг.

Нэгдсэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас мансууруулах бодис хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн, бусдад худалдаалсан гэмт хэрэг үйлдсэн 1 иргэнийг ОХУ-аас, 1 иргэнийг Испани улсаас тус тус шилжүүлэн авсан.

Монгол Улс Испанийн Хаант Улсын хооронд "Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ" байгуулагдаагүй боловч мансууруулах бодисын эсрэг олон улсын гэрээ, конвенциор хүлээсэн үүргийн хүрээнд 2 талаас өндөр хүчин чармайлт гарган ажилласаны үр дүнд мансууруулах бодис бусдад зарж борлуулах гэмт хэрэг үйлдэн оргон зайлж Испани улсад орогнож байсан Монгол Улсын иргэнийг 2 талын хууль тогтоомжын хүрээнд шилжүүлэн авсан нь өндөр ач холбогдол бүхий практикийг бий болгосон байна.

Уг ажиллагаанд Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага (INTERPOL), Гадаад хэргийн яам, Франц Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Арабын Нэгдсэн Эмират Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсуудын эрх бүхий байгууллагууд өндөр хүчин чармайлт гарган ажилласаныг тэмдэглэх нь зүйтэй.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, тээвэрлэх, худалдах гэмт хэрэгт гадаад улсад 43 иргэн ял эдэлж байгаа нь тухайн улсуудын хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэх шаардлагатайг харуулж байна[14].

Дүгнэлт

"COVID-19" цар тахал дэлхий нийтээр цаашид хэдий хугацаанд үргэлжлэх нь тодорхойгүй байгаа бөгөөд гэмт хэргийн ертөнцөд тодорхой нөлөөлөл, өөрчлөлтийг үзүүлж улмаар гэмт хэрэг үйлдэх уламжлалт арга хэлбэр хувьсан өөрчлөгдөж байна.

[14] ГХЯ-ны Консулын газраас ирүүлсэн мэдээлэл. (2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар)

Үүний тодорхой жишээ нь мансууруулах бодисын хууль бус эргэлт тухайлбал тариалалт, тээвэрлэлт, нийлүүлэлт, түгээлт, хэрэглээнд даркнет болон интернэт цахим орчин ашиглах өөрчлөлт орж байгааг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилго бүхий олон улсын судалгаа, шинжилгээний байгууллагууд дүгнэж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал COVID-19 өвчин гарсантай холбоотойгоор Монгол Улсын хил хаагдаж, хөл хорио тогтоогдсон, цагдаагийн байгууллагаас зохион явуулсан удаа дараагийн идэвхтэй арга хэмжээний үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хомсдол бий болж, хууль бус нийлүүлэлт багассан боловч хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх арга, хэлбэр нарийсаж карго үйлчилгээ, олон улсын шуудан илгээмж, ачаа тээвэр /импортын бараа бүтээгдэхүүнд нуух/, даркнет болон интернэт цахим орчин, харилцаа холбооны далд аргыг ашиглаж байгаа нь цаашид хар тамхи, мансууруулах бодис зарж борлуулдаг этгээдүүд нь зохион байгуулалттай бүлэглэлийн шинжтэй болж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэл үүсч болзошгүй байна.

Олон улсын байгууллагын зөвлөмж, бусад улсын туршлагыг судлахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг хүнийг баривчлах, шийтгэхээс илүү тэднийг аль болох эрт илрүүлэх, хэрэглээнээс татгалзуулах, эмчлэх, нийгэмшүүлэх, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх болон иргэний нийгмийн байгууллагыг ихээр татан оролцуулснаар хэрэглэгч, донтогч нарын тоо буурч үр дүнд хүрч байгаа нь харагдаж байна.

Дэвшүүлсэн санал

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг даркнет болон интернэт цахим орчин, харилцаа холбооны далд аргыг ашиглаж байгаа энэ үед цахим орчинд тавих хяналтыг сайжруулах бусад улс оронтой цахим хэлбэрээр мэдээ мэдээллийг түргэн шуурхай солилцох хамтын ажиллагааг өргөжүүлэх

2. Гэмт хэргийг индекс болон индекс бус гэмт хэрэг гэж 2 ангилан бүртгэж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх стратеги, төсөвөө тодорхойлох. Индекс гэмт хэрэгт нь түгээмэл үйлдэгддэг хүнийг алах, бие махбодид хохирол учруулах, хулгайлах, дээрэмдэх, хүчиндэх, эд хөрөнгө устгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэх мэт гэмт хэргүүдийг хамааруулах. Харин индекс бус гэмт хэрэг гэдэгт түгээмэл биш боловч нийгмийн хор аюул ихтэй бусад төрлийн гэмт хэрэг хэргүүд тухайлбал хүн амын эрүүл мэнд, байгаль орны эсрэг гэмт хэргүүд гэх мэт 2 хувааж гэмт хэрэгтэй тэмцэх стратеги ээ зөв тодорхойлж чадах болно. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж чадна.

3. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэттэй тэмцэхэд зориулж хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, техник технологи, хүний нөөцийг чадавхижуулах, тулгамдаж буй асуудлыг цогцоор шийдвэрлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээ авах. Нөгөөтэйгүүр, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус

эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангахад ихээхэн анхаарах.

4. Үндэсний хөтөлбөрт энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийсэн суурь болон хавсарга судалгааны дүнд суурилан төлөвлөж боловсруулдаг болох нь том дэвшил авчирна гэж хөтөлбөрт тусгасан байх бөгөөд уг судалгаа, шинжилгээний ажлыг мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаар хийлгэх.

5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй, донтолттой этгээдийг тодорхой хугацаанд бүртгэл-хяналтанд авах, эрүүл мэнд, нийгмийн халамжийн тусламж үйлчилгээг үзүүлэх “Дэмжих төв” байгуулан цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эрүүл мэндийн байгууллага зэрэг чиг үүргийн байгууллагууд хамтран ажиллах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. UNODC, Responses to Annual Report Questionnaire and Individual Drug Seizure Database.
2. Гадаад хэргийн яамны Консулын газраас ирүүлсэн мэдээлэл. (2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар)
3. Д.Адьяабазар "Мафи /Гэмт байгууллага/" УБ. 1999 он.
4. Ж.Болдбаатар "Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологи шинж" УБ. 2000 он.
5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль. УБ. 2002 он,
6. С.Гантулга, Б.Энхболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /тусгай анги/. УБ. 2018 он.
7. Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын мөрдөн байцаах газар. Хар тамхитай холбоотой гэмт хэргийг шалгахад анхаарах зарим асуудал. УБ., 2014 он.
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017 он.
9. Я.Цэвэл "Монгол хэлний тайлбар толь” УБ, 1966 он.
Интернет эх сурвалж:
10.https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_036V4.
11.https://www.grandnews.mn/content/read/52415.htm,

БАРИВЧЛАХ, ТАСЛАН ЗОГСООХ ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭТРҮҮЛЖ БУСДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД ХОХИРОЛ УЧРУУЛАХ ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

CAUSES, CONDITIONS AND PREVENTION OF THE CRIMES THAT CAUSE HARM TO OTHERS BY EXCEEDING THE LIMITS OF ARREST AND DETENTION BY POLICE OFFICERS IN THE PERFORMANCE OF THEIR LEGAL DUTIES CRIMINAL DAMAGE

Ж.Баттулга
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
Battulga.J
Graduate student of the University of Internal Affairs, senior lieutenant of police

Хураангуй: Уг судалгааны ажлын үндсэн зорилго нь цагдаагийн алба хаагчид хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхдаа баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж бусдад хохирол учруулах гэмт явдлын шалтгаан нөхцлийг тодорхойлох юм. Монгол улс 1990 онд социалист нийгмээс ардчилсан нийгэмд шилжиж, анхдугаар Үндсэн хуулиа баталснаар хууль, эрх зүйн тогтолцоо мөн адил үндсээрээ өөрчлөгдөх суурь болж өгсөн. Үүнээс хойш Эрүүгийн хуульд олон удаагийн нэмэлт өөрчлөлтүүд хийгдсэн ба 2002 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулахдаа уг хуулийн 42 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон хоригдол шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй”1 гэж анх удаа бие даасан зүйл заалт болгон хуульчилсан нь гэмт этгээдийг баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах үйлдэл нь аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлаас агуулга, мөн чанар, хууль ёсны шинжийн хувьд эрс өөр гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал болсон юм.2 Уг гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тодруулахын тулд шүүхийн шийдвэрийн зүйлчлэл болон тухайн гэмт хэрэгт холбогдсон цагдаагийн алба хаагчийн ажилласан жил, туршлага, боловсрол, онолын мэдлэг, ур чадварыг хүртэл судлан, урьдчилан сэргийлэх ажлын зорилгыг тодорхойлох нь чухал юм.

Abstract: The main purpose of the study was to determine the causes of crimes that cause harm to others by exceeding the limits of arrest and detention by police officers in the performance of their legal duties. Mongolia's transition from a socialist to a democratic society in 1990, with the adoption of its first constitution, also laid the groundwork for a fundamental change in the legal system. Since then, the Criminal Code has been amended several times. In a 2002 revision of the Criminal Code, Article 42 of the Criminal Code stipulates that “a person who has committed a crime or an escaped prisoner shall not be considered a criminal if he or she commits an act specified in a special section of this law during arrest or detention in order to prevent a new crime. For the first time, it was enacted as an independent provision, recognizing that an attack for the purpose of arresting or suppressing a criminal is very different in content, nature, and legal nature from the inevitable protection and inevitability. In order to determine the cause of the crime, it is important to study the classification of the court decision and the

[1] Г.Эрдэнэбат, “Эрүүгийн эрх зүй” гарын авлага” УБ. 113 дахь тал.
[2] Л.Бат-Очир “Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээний онол, эрх зүйн зохицуулалтын асуудал” Докторын диссертацийн ажил, УБ, 2019, 45 дахь тал.

years of service, experience, education, theoretical knowledge and skills of the police officer involved in the crime, and to determine the purpose of prevention.

Түлхүүр үг: Баривчлах, таслан зогсоох, хэр хэмжээ, хохирол учруулах, цагдаагийн алба хаагч

Keywords: Arrest, detention, to cause damage, police officer

Удиртгал

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээний эрүүгийн эрх зүйн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал юм. Эрүүгийн хууль энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тухайн хүн төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтоохын зэрэгцээ ямар үйлдлийг гэмт хэрэг гэж тооцохгүй байх, гэмт хэрэг болохгүй нөхцөл байдлыг хуульчилдаг. Үүнийг эрүүгийн эрх зүйд үгүйсгэх нөхцөл байдлууд гэнэ.

Нэг талаас баривчлах, таслан зогсоох үйлдэл нь бусдад гэм хор учруулдаг санаатай үйлдэл. Нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн, оргосон этгээдийг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоохын тулд хийгддэг учраас нийгэмд ашигтай үйлдэл юм. Өөрөөр хэлбэл ул байдлыг бий болгосон этгээдийн үйл ажиллагаа нь нийгэмд ашигтай байдаг учир бусдад гэм хор учруулсан ч нийгэмд аюултай шинж чанараа алддаг.

Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалт нь эрүүгийн хариуцлагын асуудалд хууль тогтоогч бодитой хандсаны илрэл бөгөөд нийт иргэдэд өөрийн болон бусдын эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, тэдгээрт заналхийлсэн аюулыг зайлуулах, аж ахуйн бизнесийн үйл ажиллагаанд эрсдэл хийх боломжийг олгодог хэдий ч эдгээр эрхээ хэрэгжүүлэхдээ бусдад гэм хор учруулах замаар хийгддэгээр бусад үйлдлээс ялгагдах онцлогтой.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг аюултай шинж, хуульд заасан шинжийг нэг зэрэг үгүйсгэдэг”[3] гэж түүний мөн чанарыг өөр өөр байдлаар тодорхойлжээ.

Дээрх нөхцөл байдлуудын онолын ойлголтыг талаар манай эрдэмтэд, судлаачид өөр өөрөөр тодорхойлсон байна. Доктор Б.Содовсүрэн “БНМАУ-ын эрүүгийн эрхээр гадаад хэлбэрээрээ эрүүгийн хуульд заасан аль нэг гэмт хэрэгтэй тохирох боловч хуульд тусгайлан заасан учир байдал бүхий үйл ажиллагааг нийгэмд аюулгүй, эрхийн эсрэг бус үйлдэл гэж үздэг”[4] гэж эрүүгийн эрх зүйн онолд анх удаа тодорхойлолт өгчээ. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах

[3] А.Н.Берестовой, “Обоснованный риск как общества исключанющее преступность деяние”, 2012, 158 стр.

[4] Б.Содовсүрэн, “БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт”, УБ, 1971, 157 дахь тал.

ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсдэг анхдагч асуудал хэнийг, тухайлбал ямар этгээдийг баривчлах, саатуулах тухай асуудал мөн.

Нэг ёсондоо гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг саатуулах үйл ажиллагаа нь уг этгээдийн үйлдсэн гэмт хэрэг цаазаар авах, хорих, баривчлах ялаар шийтгэгдэх тохиолдолд хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл ямар нэгэн байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах ял заналхийлсэн хэргийн хувьд тийм гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоохын тулд гэм хор учруулж буй нь хууль ёсны гэж үзэх нөхцөл болдог. Түүнээс гадна баривчлах саатуулах үйл ажиллагаа нь зөвхөн гэм хор учруулан баривчлах, саатуулахаас өөр аргагүй болсон нөхцөлд хэрэгжих ёстой. Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтанг баривчлах үед гэм хор учруулах үйл ажиллагаа нь тухайн этгээдийг шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэх зорилгоор, энэ зорилгод хүрэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд гэм хор учруулахаас өөр аргагүй байсан, шаардлагатай хэр хэмжээний хүрээнд хийгдсэн тохиолдолд хууль ёсны гэж үзнэ[5].

Үндсэн хэсэг

Цагдаагийн алба хаагчид баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж бусдад хохируулах гэмт явдлын шалтгаан нөхцлийг судлахын тулд нийт гэмт хэрэг гаралтын хандлага, тоон мэдээлэлэлд дүн шинжилгээ хийх нь үндсэн суурь юм. Гэмт хэргийг хэмжиж, бүртгэх нь үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл, орчин байдал, шинж чанар, цаг хугацааг судлан, үүдэн бий болж байгаа шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлон хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Статистикийн нэгдсэн мэдээллийн сангаас бүртгэгдсэн гэмт хэргийн урт хугацааны хандлагыг харахын тулд 2000-аас 2019 он хүртэлх мэдээллийг харуулав[6].


Бүс	*2000 он*	*2005 он*	*2010 он*	*2015 он*	*2019 он*	*Өөрчлөлт 2000/2019*
Улсын дүн	23,463	17,411	19,825	27,757	31,524	**34%**
Баруун бүс	1,815	1,440	1,530	1,584	1,596	**-12%**
Хангайн бүс	3,438	2,616	2,511	3,031	3,772	**10%**
Төвийн бүс	4,919	3,252	3,234	3,858	3,865	**-21%**
Зүүн бүс	2,322	1,514	1,386	1,306	1,971	**-15%**
Улаанбаатар	10,360	8,208	10,863	17,939	20,261	**96%**

Тухайн мэдээлэлд 2020 оны тоо баримтыг оруулаагүй буюу Ковид-19 цар тахлын нөлөөгөөр тухайн онд гэмт хэргийн тоо огцом буурсан тул энэ нь бодит дүгнэлт өгөхөд дутагдалтай гэж үзсэн учраас хассан.

[5] Г.Эрдэнэбат, “Эрүүгийн эрх зүй” Гарын авлага, УБ, 2007, 114 дэх тал.

[6] ЦЕГ, Мэдээлэл дүн шинжилгээ, аюулгүй байдлыг алба, “Гэмт хэргийн мэдээлэл, статистик” УБ, 2021

Дээрх тоон мэдээллийн хугацааны хандлагыг доорх графикаар харуулав.



	2000	2005	2010	2015	2019
Баруун бүс	1815	1440	1530	1584	1596
Хангайн бүс	3438	2616	2511	3031	3772
Төвийн бүс	4919	3252	3234	3858	3865
Зүүн бүс	2322	1514	1386	1306	1971
Улаанбаатар	10360	8208	10863	17939	20261
Улсын дүн	23463	17411	19825	27757	31524

Дээрх графикаас харахад 2000 оноос 2019 он хүртэлх бүртгэгдсэн гэмт хэргийн хугацааны хандлагаас харахад баруун, төвийн, зүүн 3 бүс буурах хандлагатай байсан бол хангайн бүс 10%, Улаанбаатар хот 96%, улсын дүнгээр 34%-ийн өсөлттэй байна.

Үүний дараагаар бүртгэгдсэн гэмт хэргийн тоог ангилал, жилээр статистикийн нэгдсэн сангаас авч харуулав.[7]

Гэмт хэргийн ангилал	***2003 он***	***2005 он***	***2010 он***	***2015 он***	***2017 он***	***2019 он***	***Өөрчлөлт 2003/2019***
Улсын дүн	19934	17411	19825	27757	32259	31524	58%
Хөнгөн	6504	5537	8151	13487	20120	25156	51%
Хүндэвтэр	10116	8661	9219	12127	5146	0	
Хүнд	2852	2756	2014	1628	6747	6368	92%
Онц хүнд	462	457	441	515	246	0	

[7] ЦЕГ, Мэдээлэл дүн шинжилгээ, аюулгүй байдлыг алба, “Гэмт хэргийн мэдээлэл, статистик” УБ, 2021

Статистикийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээлэл 2000 онд төрлөөр ангилагдан гараагүй байсан учраас 2003 оны мэдээллийг ашигласан. Мөн гэмт хэргийн хөнгөн хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж 4 ангилдаг байсан бол 2017 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар дараах 2 төрөлд тухайн байдлаар ангилахаар зааж өгсөн. Үүнд:

1. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.

2. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ.

Ийм учраас 2018 оноос хойш гэмт хэргийг зөвхөн 2 төрөлд ангилан авч үзсэн учраас 2003 онд бүртгэгдсэн хөнгөн, хүндэвтэр гэмт хэргүүдийн нийлбэрийг 2019 оны хөнгөн гэмт хэргийн тоонд, хүнд онц хүнд гэмт хэргүүдийн нийлбэрийг хүнд гэмт хэргийн тоонд харьцуулан өсөлт бууралтыг тодорхойлов. Үүнээс харахад 2003 онтой харьцуулахад улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2019 онд 58%, хөнгөн гэмт хэргийн тоо 51%, хүнд гэмт хэргийн тоо 92% тус тус өссөн байна.

Дээрх мэдээллүүдээс харахад сүүлийн жилүүдэд гэмт хэрэг зарим бүсүүдэд буурсан байгаа ч Улаанбаатар хотод хамгийн өндөр өссөн, мөн бүртгэгдсэн хүнд гэмт хэргийн тоо бараг 2 дахин нэмэгдсэн байна. Үүнээс бид цагдаагийн алба хаагчдад тавигдах шаардлага, өгөх сургалт, ур чадвар аль бүсэд харъяалагдаж байгаагаас хамааран ялгагдах, тухайн сургалт, хөгжүүлэх хөтөлбөрүүд ямар төрлийн ур чадварыг нэмэгдүүлэх, гэмт хэргийн гаралтаас урьдчилан сэргийлэх ямар үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох боломжийг олж авах юм. Мэдээж дээрх цагдаагийн алба хаагчдад чиглэсэн бодлого нь тэднийг баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж бусдад хохирол учруулах гэмт явдалд холбогдохоос урьдчилан сэргийлэх чухал нөлөөтэй.

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж бусдад хохирол учруулсан гэмт явдлын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхдээ тухайн хэргийг хэрхэн зүйлчилж байгаа, мөн хэргийн нөхцөл байдал, цагдаагийн алба хаагч тухайн үйлдлийг яагаад хийх болсон зэргийг үнэлэх нь чухал юм. Цагдаагийн алба хаагч баривчлах, таслан зогсоох ажиллагааны үеэр эрүүгийн хуулийн тусгай ангид[8] заасан 84 хэсэг бүхий 43 гэмт хэрэгт холбогдож болох ба үүнээс 17 хэсэг нь хүнд, 67 хэсэг нь хөнгөн гэмт хэрэгт ангилагдаж байна. Шүүхийн шийтгэх нийт 40 тогтоолд дүн шижилгээ хийхэд баривчлах, таслан зогсоохтой холбогдох нийт 13 тохиолдолд байсан. Үүнээс орон нутагт 8, Улаанбаатар хотод 5 үйлдэгдсэн. Дээрх хэргүүдийг шийдвэрлэсэн байдлыг харахад тэнссэн 4, хэрэгсэхгүй болсон 2, цагаатгагдсан 2, ял шийтгэгдсэн 3, торгуульсан 1 хэрэг байна. Мөн алба үүргээ гүйцэтгэж байгаад холбогдсон

[8] Төрийн мэдээлэл эмхэтгэл, “Эрүүгийн хууль”, УБ, 2015

байтал зүйлчлэлийн хувьд хувийн сэдэлтэй гэж үзсэн 4, хэдий гэмт хэргийн шинжгүй гэж үзсэн ч х "гэмт хэрэг үйлдэж оргосон хүнийг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор энэ хуульд заасан үйлдлийг аргагүй байдалд хийж тухайн хүнд халдсан нь баривчлах, таслан зогсоох хэр хэмжээнээс хэтрээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй" гэх эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийг хэрэглээгүй тогтоол байв.

Дүгнэлт

1. Манай улс тухайн үеийн нийгмийн зохион байгуулал, харилцаа, хөгжлийн онцлогоос хамааран баривчлах, таслан зогсоох хэр хэмжээний талаарх ойлголтыг тухай бүр хуульчилж ирсэн.

2. Гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг саатуулах үйл ажиллагаа нь уг этгээдийн үйлдсэн гэмт хэрэг цаазаар авах, хорих, баривчлах ялаар шийтгэгдэх тохиолдолд хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл ямар нэг заналхийлсэн хэргийн хувьд гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоохын тулд гэм хор учруулж буй нь хууль ёсны гэж үзэх нөхцөл болдог.

3. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээний эрүүгийн эрх зүйн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал юм.

4. Цагдаагийн албан хаагчид нь эрүүгийн тухай хуулийн дагуу баривчлах, таслан зогсоох ажиллагааны үеэр нийт 43 гэмт хэрэгт холбогдох боломжтой байгаа юм. Дээрх эсрдлээс урьдчилан сэргийлэхийн тулд цагдаагийн алба хаагчдын холбогдсон гэмт хэргүүдийн нөхцөл байдлыг нарийвчлан судлах, шүүхийн тогтоолд дүн шинжилгээг хийсэн.

5. Цагдаагийн алба хаагчдын холбогдсон нийт 40 шүүхийн тогтоолд дүн шинжилгээ хийхэд 13 тохиолдод нь баривчлах, таслан зогсоох хэр хэмжээтэй холбогдож байв.

6. Дээрх 13 тохиолдлоос 3 нь хэр хэмжээг хэтрүүлсэнд тогтоогдож ял болон торгуулиар шийтгэгдсэн.

7. Үүнээс гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болсон цагаатгагдсан тогтоол байсан ч эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлээр зүйлчлээгүй.

8. Мөн "Хувийн сэдлээр" гэж зүйлчилж байсан нь учир дутагдалтай байгаа юм.

9. Дээрх нөхцөл байдлыг нарийвчлан шинжлэхийн тул зохицуулагдаж байгаа хууль эрх зүйн орчиноос гадна тухайн нөхцөл үүсэх болсон шалтгааныг тодруулах нь зүйтэй.

Санал

Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж, бусдад хохирол учруулах явдлыг багасгахын тулд шалтгаан, нөхцлийн суурь судалгааны ажлыг сайжруулах шаардлагатай байна. Энэ талаар судалгааны ажил бичих явцад тоон хэмжээнд хийгдсэн судалгаа байхгүй, тогтсон статистик гардаггүй, алба хаагчдад зохион

байгуулагдаж байгаа сургалт, мэдээлэл учир дутагдалтай байна. Иймд дараах саналыг уг судалгааны ажлын хүрээнд гаргаж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчдын хувь хүний судалгааг нарийн түвшинд хөгжүүлэх. Үүнд тухайн хүний сэтгэл зүй, уг гарал, хүүхэд насандаа өнгөрүүлсэн орчин зэргийг тодорхойлох.

2. Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны манлайлал, алба хаагч нарт тавих хяналтыг сайжруулахад шат шатны дарга нар анхаарч ажиллах.

3. Алба хаагчдад тулгарсан асуудал, гэмт хэргийг шуурхай шийдвэрлэж үр дүнг хамт олонд мэдээлэх ажиллагааг зохион байгуулах.

4. Шинээр томилогдож буй албан хаагчдад хүний эрх, эрх чөлөө, ёс зүй, мэргэжлийн ур чадвар, харилцааны соёл төлөвшүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг түлхүү оруулах.

5. Монгол Улсын хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр болон аймаг, сумдад гэмт хэргийн талаарх дуудлаганд судалгаа явуулж нийтлэг тулгардаг асуудлийг олж тогтоон түүнд тохирох сургалтыг түлхүү явуулах.

Эх сурвалжийн жагсаалт

1. Г.Эрдэнэбат, “Эрүүгийн эрх зүй” гарын авлага, УБ, 2013.

2. .Бат-Очир “Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээний онол, эрх зүйн зохицуулалтын асуудал” Докторын диссертацийн ажил, УБ, 2019.

3. А.Н.Берестовой, “Обоснованный риск как общества исключающее преступность деяние”, 2012.

4. Б.Содовсүрэн, “БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт”, УБ, 1971,

5. ЦЕГ, Мэдээлэл дүн шинжилгээ, аюулгүй байдлыг алба, “Гэмт хэргийн мэдээлэл, статистик” УБ.

6. Төрийн мэдээлэл эмхэтгэл, “Эрүүгийн хууль”, УБ.

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

SITUATION OF LIVESTOCK THEFT

Л.Бат-Очир
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Bat-Ochir L.
(Ph.D), Police Lieutenant Colonel, Associate Professor, Department of Criminal Law and Criminology, Police School, University of Internal Affairs

Хураангуй: Манай улсад мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал буюу бүтэц, төвшин, энэ гэмт хэрэг үйлдсэн хүний нийгмийн байдал, нутаг дэвсгэрийн онцлогийн талаар сүүлийн 3 жилийн статистикийг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсэн.

Abstract: We have compared and analyzed the statistics of the last 3 years on the situation or structure and level of livestock theft in Mongolia, the social status of the perpetrators and the specifics of the territory.

Түлхүүр үгс: Мал сүрэг, нүүдэлчин өв соёл, мал хулгайлах, нөхцөл байдал.
Keywords: livestock, nomadic heritage and culture, livestock theft, situation.

Монгол Улсын Үндсэн хуульд[1] “:Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заажээ. Энэ нь Монгол орны цаг уурын онцлог нөхцөл байдал, бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн уламжлалт нүүдлийн соёл иргэншил, түүнтэй дасан зохицсон өвөрмөц ашиг шим бүхий малын удмын санг хамгаалах зэрэг олон асуудлын хүрээнд, малчдад төрөөс үзүүлэх нийгэм, эдийн засаг, эрх зүйн болон шинжлэх ухааны туслалцаа, дэмжлэг үзүүлж байхыг төрийн үүрэг болгосон заалт ажээ. Манай улсын дийлэнх иргэдийн хувьд мал сүрэг нь амьжиргааны эх үүсвэр, тэдний үнэт зүйлс бөгөөд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн эртний уламжлалтай орон юм.

2015 оны Эрүүгийн хууль нь Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг хамгаалах, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн томьёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн. Үүний дагуу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлэгт[2] мал хулгайлах гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

Бусдын малыг хулгайлсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх,

Энэ гэмт хэргийг,

- олон тооны мал хулгайлж;
- бүлэглэж;
- улсын хилээр нэвтрүүлж;
- машин механизм ашиглаж;
- ноцтой хохирол, хор уршиг учруулж;
- гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн бол хүндрүүлэн үзэж хоёр

[1] Монгол Улсын Үндсэн хууль.Уб.,1992. Төрийн мэдээлэл эмхтгэл №1. 5 дугаар зүйлийн 5.

[2] Эрүүгийн хууль.Уб.,2015. Төрийн мэдээлэл эмхтгэл № 2. 17.12 дугаар зүйл.

жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

- байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

- зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн онц хүндрүүлэн үзэж таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус заасан.

Урдны эрүүгийн хуульд мал хулгайлах үйлдлийг “Хулгайлах” гэмт хэргийн бүтэцэд хамааруулдаг байсан бол шинэ эрүүгийн хуульд бие даасан гэмт хэрэг болгож хуульчилснаар энэ гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд оногдуулах ялын үр нөлөө, хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь судлах шаардлага тулгарч байна. Ийм учраас мал хулгайлах гэмт хэргийн сүүлийн **3** жилийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

2021 оны эцэст мал тооллогын дүнгээр[3] 67.3 сая толгой мал тоологдож өмнөх оноос 268.4 мянгаар буюу 0.4 хувиар өсчээ. Тэгвэл улсын хэмжээнд[4] сүүлийн 3 жилд нийт 3586 мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдсэнээс 34746 мал хулгайд алдагдсан. 2019 онд өмнөх оныхоос 65.1%-иар өссөн нь (орон нутагт 67.6%, нийслэлд 36.6 %-иар) цар тахлын үеийн хөл хорионы өмнөх үед гадаад улсад малын мах экспортлох үйл явц эрчимжиж байсантай холбоотой ба 2020, 2021 онд мал хулгайлах гэмт хэргийн гаралт буурсан боловч хулгайд алдагдсан малын тоо тогтмол өссөнийг доорх хүснэгтээс харж болно.

Хулгайлагдсан малын төрөл, тоог харьцуулан үзвэл:

№	Малын төрөл	2019 он	2020 он	2021 он
1.	Адуу	5105	2960	2399
2.	Үхэр	1032	1991	1718
3.	Тэмээ	8	72	77
4.	Ямаа	923	2229	2135
5.	Хонь	1605	5683	6809
	Нийт	**8673**	**12935**	**13138**

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотой Улсын онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосноор сүүлийн 2 жилд буюу 2020 онд 42.5%, 2021 онд 29.3%-иар тус тус буурсан. Сүүлийн 3 жилийн хугацаанд мал хулгайлах гэмт хэргийн улмаас 14097 буюу 40.5 хувь нь хонь, 5287 буюу 15.2 хувь нь ямаа, 157 буюу 0.45 хувь нь тэмээ, 4741 буюу 13.6 хувь нь үхэр, 10464 буюу 30.1 хувь нь адуу алдагджээ. Тэмээ хамгийн бага хувийг эзэлж байгаа нь цар тахлын хөл хорио, жижиг дунд бизнес эрхлэгчдийн алдагдал, эдийн засгийн нөлөөлөл гол хүчин зүйл болсон. Тухайлбал цайны, зоогийн газрын махны хэрэгцээний тодорхой хувийг тэмээний мах эзэлдэг бөгөөд үйл ажиллагаа нь жигдрээгүйтэй холбоотой нийлүүлэлт багассан учир тэмээ хулгайлах нь бага байна.

Мөн 2019 онд үйлдэгдсэн мал хулгайлах гэмт хэрэг нь 8673 буюу нийт гэмт хэргийн 24.9 хувь, 2020 онд 12935 буюу нийт гэмт хэргийн 37.2 хувь, 2021 онд 13138 буюу нийт гэмт хэргийн 37.9 хувийг эзэлсэн нь сүүлийн 2 жилд тогтвортой өсөлттэй.

Сүүлийн 2 жилд хулгайд алдагдсан хонины тоо огцом өссөн нь

[3] www.ikon.mn.

[4] ЦЕГ.Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба.Уб.,2022.

тээвэрлэх, бэлтгэх, борлуулхад амар хялбар, үхрийн махны үнийн өсөлт тогтвортой байгаатай холбоотой хонины махны хэрэгцээ нэмэгдсэн. Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт энэ гэмт хэргийн гаралт их байгаа нь нутаг дэвсгэр, ургамал, бэлчээрийн онцлог, малын ашиг шим, махны гарц, амт, чанар нөлөөлсөн гэж үзэх үндэстэй.


Баруун аймгуудын гол зам Архангай аймгийн нутгаар дамжин өнгөрдөг, 24 цагийн турш хөдөлгөөн их, Төв аймаг нь Нийслэлд ойрхон малын мах борлуулах цэг, хүн амын нягтаршил их байдагтай холбоотой энэ гэмт хэргийн гаралт их байна. Малын тоогоор Хөвсгөл аймаг 5.9 сая, Архангай аймаг 5.6 сая, Хэнтий аймаг 5 сая, Төв аймаг 4.7 сая, Сүхбаатар аймаг 4.2 сая мал тус тус тоолуулж улсын хэмжээнд тэргүүлжээ. Ялангуяа Архангай аймаг адуу, үхэр, хонины тоогоор, нийт малын тоогоор Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 662 мянга, Хэнтий аймгийн Хэрлэн сум 529.3 мянга, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум 523.1 мянга, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул 494.1 мянга, Архангай аймгийн Эрдэнэмандал сум 485.5 мянган мал тоолуулж малын тоогоор тэргүүлсэн бөгөөд тус аймаг, сумын нутаг дэвсгэрт мал хулгайлах гэмт хэргийн гаралт тогтмол их байгаа нь малын толгойн өсөлттэй холбоотой байх магадлалтай.

№	Аймаг	2019 он	2020 он
1	Баян-Өлгий	13	27
2	Ховд	54	28
3	Увс	53	22
4	Завхан	42	34
5	Говь-Алтай	24	9
6	Хөвсгөл	101	74
7	Архангай	162	109
8	Баянхонгор	101	66
9	Орхон	8	7
10	Булган	117	52
11	Өвөрхангай	57	50
12	Сэлэнгэ	66	49
13	Дархан-уул	35	15
14	Төв	199	100
15	Дундговь	29	18
16	Өмнөговь	13	22
17	Хэнтий	287	124
18	Говьсүмбэр	12	10
19	Дорноговь	26	19
20	Дорнод	133	64
21	Сүхбаатар	149	86
Нийслэлд			
1	Баянзүрх	15	10
2	Найлайх	19	8
3	Сүхбаатар	1	0
4	Баянгол	0	0
5	Сонгинохайрхан	66	27
6	Багануур	11	5
7	Чингэлтэй	1	0
8	Хан-уул	15	13
9	Багахангай	0	0

Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүх, Налайх дүүрэгт мал хулгайлах гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа нь малтай иргэд, малын мах худалдаалах цэгүүд төвлөрсөн зэрэг нөхцөл байдлууд нөлөөлжээ.

Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-уул, Найлах дүүргийн газар нутгийн онцлог нь нийслэлийг орон нутагтай холбосон гол замууд дамжин өнгөрдөг, мал, мах тээвэрлэх явцад зам дагуу мал хулгайлах үйлдэл

Бүртгэгдсэн гэмт хэргийн түвшин /2012-2021 оны байдлаар/




Статистикаас үзэхэд сүүлийн 10 жилийн дунджаар жилд 1181, сард 98, хоногт 3 гэмт хэрэг үйлдэгдсэн үзүүлэлттэй байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн гарагын хувьд ажлын 5 өдөр жигд үйлдэгдэж, амралтын өдрүүдэд багассан дүн байна. Энэ нь амралтын өдөр илүү хараа хяналт тавих боломжтой байдаг холбоотой. Урд нь пүрэв, баасан, ням гарагт ихэвчлэн үйлдэгддэг байсан бол сүүлийн 3 жилийн статистикаас үзэхэд мал хулгайлах гэмт хэргийн төлөв байдал өөрчлөгдөж буйг илтгэнэ. 2019 онд бүх гарагуудад өссөн дүнтэй байсан бол 2021-2022 онд бүх гарагуудад буурсан үзүүлэлттэй байна.



Мал хулгайлах гэмт хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 528 буюу 14.7 хувь нь, 14-19 цагийн хооронд 581 буюу 16.2 хувь нь, 19-22 цагийн хооронд 496 буюу 13.8 хувь нь, 22-06 цагийн хооронд 1981 буюу 55.2 хувийг эзэлж байгаагаас үзэхэд шөнийн цагаар дийлэнхдээ энэ төрлийн гэмт хэргийг үйлджээ.



Нийт бүртгэгдсэн хэргийн 91 буюу 2.5 хувь нь согтуугаар, 67 буюу 1.8 хувь нь хүүхэд оролцож, 47 буюу 1.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 759 буюу 21.1 хувь нь бүлэглэн, 2084 буюу 58.1 хувь нь тээврийн хэрэгсэл ашиглаж тус тус үйлдсэн байна.

№	Согтуугаар	Хүүхэд оролцсон	Эмэгтэй хүн оролцсон	Тээврийн хэрэгсэл ашигласан	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
2019 он	38	38	21	1003	356	13
2020 он	33	10	17	659	252	4
2021 он	27	19	9	422	151	1
Нийт	**91**	**67**	**47**	**2084**	**759**	**18**

Мал хулгайлах гэмт хэргийг тээврийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн тохиолдолд хүндрүүлэн үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа ч тогтмол хэрэглэсээр байна. Цаашид тээврийн хэрэгслийн ангилал, төрөл, зориулалт, техникийн үзүүлэлтийн судалгааг нарийвчлан судалж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих шаардлага үүсч байна.

Энэ гэмт хэрэгт нийт 2825 хүн холбогдсоноос 47 эмэгтэй оролцжээ. Энэ гэмт хэрэгт 67 хүүхэд оролцсон нь анхаарал татав. Хүүхдийг энэ гэмт хэрэгт татан оролцуулж буй үйлдэл нь хүүхдийн зөв хүмүүжил, төлөвшил, зан төлөв, эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж буй нь харамсалтай. Нүүдлийн соёл иргэншлийн өв соёлын нэг буянт малыг

галт зэвсэг хэрэглэж хулгайлж буй явдал Монгол хүний ёс суртахуун доройтсоны илрэл.

Гэмт хэрэг үйлдсэн хүний нийгмийн байдлаар авч үзвэл:


- Төрийн албан хаагч 17
- Хувийн хэвшилд 33
- Сурагч 22
- Ажилгүй 1274
- Малчин 1376
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч 87 байна.

Төрийн албан хаагчид энэ төрлийн гэмт хэрэгт багагүй холбогдож байгаагаас үзэхэд албан хаагчийн ёс зүйг төлөвшүүлэх, төрийн албаны тухай хуулийг нь анхаарал татаж байна.

2011 онд Засгийн газар, ЦЕГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааг эрчимжүүлэхээр 2011 онд[5] энэ гэмт хэргийн сүүлийн 2001-2011 оны төлөв хандлага, нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч шийдвэрлэвэл зохих зарим арга хэмжээний саналыг дэвшүүлсэн боловч мал хулгайлах гэмт хэрэгт хүүхэд, эмэгтэйчүүдийн оролцоог багасгах, бууруулах, тэдэнд чиглэсэн тодорхой арга хэмжээний талаар нэг ч дурдаагүй.

Гэмт хэрэг үйлдсэн хүний дийлэнх нь тодорхой эрхэлсэн ажилгүй, малчид үйлджээ. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн улмаас 3631 хүн хохирсон ба 2021 онд хохирсон хүний тоо өмнөх оныхоос 1067 буюу 137 хувиар өссөн үзүүлэлт байна[6].

Мал хулгайлах гэмт хэргийн улмаас 2019 онд 7543.5 сая төгрөгийн хохирол учирсны 36.1 хувийг, 2020 онд 4390.9 сая төгрөгийн хохирол учирсны 45.5 хувийг, 2021 онд 3766.4 сая төгрөгийн хохирлын учирсны 51.3 хувийг нөхөн төлүүлжээ.



Нийт гэмт хэрэг үйлдсэн хүний дийлэнх нь 25-29, 30-34 насны хүн байгаа нь эдгээр иргэдэд чиглэсэн нийгмийн, ёс суртахууны болон эрх зүйн боловсрол олгох төрийн бодлого, хөтөлбөр, төсөл шаардлагатай. Эдгээр иргэдийн дунд цөөнгүй ахмад настан байгаа нь харамсалтай. Нүүдлийн мал аж ахуй, малын ашиг шим, өв соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх учиртай

[5] ЦЕГ.Мэдээлэл судалгааны төв. Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал. Судалгааны тайлан.Уб.,2011. 4 дахь тал.

[6] www.police.gov.mn.

ахмад настангууд мал хулгайлах гэмт хэрэгт оролцож, буруу үйлдэлд үлгэрлэх, турхирах, өөгшүүлэх явдал гарсаар байна.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа эрх зүйн орчинг сайжруулах, түүний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хамтын ажилагааг сайжруулах гэхээс илүүтэй гэмт хэрэг үйлдсэн хүмүүст чиглэсэн соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагтай.

2004 онд батлагдсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай” хуульд энэ гэмт хэргийн талаарх мэдээлэл өгсөн, урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон, мэдээлэл нь шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогдсон, энэ хуулийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагтай оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, мэдээлэл худалдаж авах талаар 7 заалт[7] байна. Үүнийг хэрэгжүүлэх үүднээс, урамшууллын тогтолцоог бодитой бий болгох, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй хөтөлбөр, аян, судалгаа, төслийн ажил нь “тасралтгүй явагдах зарчим”-д тулгуурлан, онолд суурилсан шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой хэрэгжихүйц байх учиртай.

Дүгнэлт.

1.Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндэсний өв соёл, үнэт зүйлсийн нэг болох мал сүргийг төрийн бодлогын хүрээнд тусгайлан хамгаалах эрх зүйн орчинд ахиц дэвшил гарсан.

2.Энэ гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрөөс баримтлах бодлогын түвшинд олон талт арга хэмжээг хэрэгжүүлсээр байгаа боловч ахицтай үр дүнд хүрэхгүй байна.

3.2011 онд Засгийн газар, ЦЕГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааг эрчимжүүлэхээр 2011 онд[8] энэ гэмт хэргийн сүүлийн 2001-2011 оны төлөв хандлага, нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч шийдвэрлэвэл зохих зарим арга хэмжээний саналыг дэвшүүлсэн боловч мал хулгайлах гэмт хэрэгт хүүхэд, эмэгтэйчүүдийн оролцоог багасгах, бууруулах, тэдэнд чиглэсэн тодорхой арга хэмжээний талаар нэг ч дурдаагүйн судалгааны үр дүн учир дутагдалтай байгааг илтгэнэ.

4.2004 онд батлагдсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай” хуульд энэ гэмт хэргийн талаарх мэдээлэл өгсөн, урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон, мэдээлэл нь шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогдсон, энэ хуулийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагтай оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, мэдээлэл худалдаж авах талаар 7 заалт[9] байна.

5.Сүүлийн 2 жилд хулгайд алдагдсан хонины тоо огцом өссөн нь тээвэрлэх, бэлтгэх, борлуулхад амар хялбар, үхрийн махны үнийн өсөлт

[7] Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль. Уб.,2004.11.3, 14.1, 15.1, 15.2, 16.5.2, 16.5.3, 16.5.4 дүгээр зүйл.

[8] ЦЕГ.Мэдээлэл судалгааны төв. Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал. Судалгааны тайлан.Уб.,2011. 4 дахь тал.

[9] Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль. Уб.,2004.11.3, 14.1, 15.1, 15.2, 16.5.2, 16.5.3, 16.5.4 дүгээр зүйл.

тогтвортой байгаатай холбоотой хонины махны хэрэгцээ нэмэгдсэн. Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт энэ гэмт хэргийн гаралт их байгаа нь нутаг дэвсгэр, ургамал, бэлчээрийн онцлог, малын ашиг шим, махны гарц, амт, чанар нөлөөлсөн гэж үзэх үндэстэй.

Санал.

Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах, хохирлыг багасгах, цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дараах саналыг дэвшүүлсэн. Үүнд:

1.Мал хулгайлах гэмт хэргийг тээврийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн тохиолдолд хүндрүүлэн үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа ч тогтмол хэрэглэсээр байна. Цаашид тээврийн хэрэгслийн ангилал, төрөл, зориулалт, техникийн үзүүлэлтийн судалгааг нарийвчлан судалж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих шаардлага үүсч байна.

2.Нийт гэмт хэрэг үйлдсэн хүний дийлэнх нь 25-29, 30-34 насны хүн байгаа нь эдгээр иргэдэд чиглэсэн нийгмийн, ёс суртахууны болон эрх зүйн боловсрол олгох төрийн бодлого, хөтөлбөр, төсөл шаардлагатай

3.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, Мал хулгайлах гэмт хэргтэй тэмцэх, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг энэ гэмт хэргийн нөхцөл байдалтай уялдуулан бодитой хэрэгжүүлэх ажил шаардлагтай.

4. Сүүлийн 2 жилд хулгайд алдагдсан хонины тоо огцом өссөн нь тээвэрлэх, бэлтгэх, борлуулхад амар хялбар, үхрийн махны үнийн өсөлт тогтвортой байгаатай холбоотой хонины махны хэрэгцээ нэмэгдсэн. Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт энэ гэмт хэргийн гаралт их байгаа нь нутаг дэвсгэр, ургамал, бэлчээрийн онцлог, малын ашиг шим, махны гарц, амт, чанар нөлөөлсөн гэж үзэх үндэстэй. Тийм учраас эдгээрт тохирсон урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх.

ГЭМТ ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЖ АВАХ АЖИЛЛАГАА

EXTRADITION PROCEEDING OF CRIMINAL

Х.Сайнжаргал
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Kh.Sainjargal
University of internal affairs Master

Хураангуй: Энэхүү өгүүлэлээр гэмт хэрэг үйлдэж гадаад улс руу оргон зугтсан этгээдийг Олон Улсын Эрүүгийн Цагдаагийн Байгууллага (Organisation internationale de police criminelle) Интерполын шугмаар шилжүүлэн авах ажиллагааны талаар авч үзнэ.

Abstract: This article about extradition criminal of a fugitive from the international Crime Police Organization (ICPO) thought to the Interpol.

Түлхүүр үг: Эрэн сурвалжлах, гэмт этгээд шилжүүлэн авах ажиллагаа, Интерпол, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ.

Keywords: To search, extradition proceeding of criminal, Interpol mutual agreement on legal relation contract.

Сүүлийн үед манай иргэд болон гадаадын иргэд манай улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдээд гадаад улс руу оргон зугтах болсоноор гэмт хэргийг мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэх ажиллагаа зогсонги байдалд орж, гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүсээд багагүй хугацаа өнгөрлөө. Хууль хэрэгжүүлэх байгууллагын чадамжийг шалгах сорилт болж буй гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гадаадын улс орноос шилжүүлэн авах асуудал өнөөгийн нөхцөлд зайлшгүй ажиллагааны нэгэн төрөл болж байна.

Гэмт этгээдийг шилжүүлэн авах нь хүнд ноцтой гэмт хэрэг үйлдсэний улмаас эрүүгийн хариуцлагад татахаар эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор аль нэг улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин сууж байгаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэрэг үйлдэгдсэн улсын эрх бүхий байгууллагын зохих ёсны хүсэлтийн дагуу шилжүүлэн өгөх ажиллагаа юм.

Гэмт хэрэг үйлдээд оргон зугтсан этгээдийг, эрэн сурвалжлах, хаана байгааг тогтоох, шилжүүлэн авах ажиллагаа явуулахад манай улсын нэгдэн орсон эрүүгийн эрх зүйн салбарт хамаарах олон улсын эрх зүйн баримт бичиг, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх болон гэмт этгээдийг шилжүүлэн өгөх гэрээ, Олон Улсын Эрүүгийн Цагдаагийн Байгууллага (Organisation internationale de police criminelle) Интерполын үүрэг оролцоо, дэмжлэг ихээхэн чухал.

Манай улс ОХУ, БНХАУ, БНГУ, БНПольш, БНУнгар, БНБолгар, БНЧех, БН Югослав, Ардчилсан Солонгос, БН Солонгос, БН Казакстан улс, Украйн улс, БН Киргиз улс, БН Турк улс, БНС Вьетнам улс, БН Энэтхэг улсуудтай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулсан бол, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, гэмт хэрэг үйлдэгсдийг хариуцлагад татах, таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай гэрээ БН Казакстан улс (1993), БН Солонгос улс (1999), БН

Энэтхэг улс (2001), БНХАУ-тай (1997) тус тус байгуулсан байна.[1]

Олон Улсын Эрүүгийн Цагдаагийн Байгууллага (Organisation internationale de police criminelle) Интерпол[2] нь олон улсын хэмжээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, зохих улсад шилжүүлэх, дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улс дамнан зугтсан гэмт этгээдүүдийн эсрэг хамтран ажиллах шаардлагатай гэж үзэн 1914 онд үүсгэн байгуулжээ. Интерпол нь дэлхийн 194 орныг эгнээндээ нэгтгэсэн, гишүүнчлэлийнхээ цар хүрээгээр НҮБ-ын дараа орох хамгийн том олон улсын байгууллага бөгөөд төв оффис нь Францын Лион хотод байрладаг. Энэ байгуулага анх Олон Улсын Эрүүгийн Цагдаагийн Комисс нэртэй байсан ч 1956 оноос цахилгаан мэдээний код болох **“ИНТЕРПОЛ”** гэсэн нэршлийг албан ёсоор ашиглахаар тогтжээ.

Интерпол нь гишүүн улс орнуудад өөрийн удирдан зохион байгуулах төвөөрөө дамжуулан улс дамнасан оргодолыг эрэн сурвалжилж шилжүүлэх, терроризм, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, цахим гэмт хэрэг, хүний наймаа, мөнгө угаах, урлагын бүтээлийн хулгайн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд 24 цагийн турш дэмжлэг туслалцаа үзүүлдэг.

Интерпол нь гишүүн орнуудынхаа хэмжээнд оргодол этгээдүүдийг эрэн сурвалжлах, мэдээлэл солилцох ажиллагааг зохион байгуулахдаа өнгөөр кодлон ялгасан 8 төрлийн зар мэдээг үйл ажиллагаандаа ашигладаг.



Улаан өнгийн зар мэдээ: гишүүн орнуудаас ирүүлсэн оргодол этгээдийг шилжүүлэн авах зорилгоор гадаад улсын нутаг дэвсгэрт баривчлуулах хүсэлтийг үндэслэн гаргадаг бөгөөд оргодол этгээдийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүхийн хүчин төгөлдөр тогтоол үйлдэгдсэн байхыг заавал шаарддаг.

Хөх өнгийн зар мэдээ: гишүүн орнуудаас ирүүлсэн оргодол этгээдийг байршлын талаар мэдээлэл солилцох хүсэлт дээр үндэслэдэг.

Ногоон өнгийн зар мэдээ: гишүүн орнуудаас ирүүлсэн давтан гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдэж

[1] Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. ЭЭЗ, ЭБШЭЗ. 2012. 599-602 дахь тал

[2] https://www.interpol.int/en/Who-we-are/General-Secretariat

болзошгүй этгээдүүдийн талаарх мэдээлэл дээр үндэслэн тухайн этгээдийн талаар бусад гишүүн орнуудад сэрэмжлүүлэг өгөх зорилгоор гаргадаг.

Шар өнгийн зар мэдээ: сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах чиглэлээр гишүүн орнуудаас ирүүлсэн хүсэлт дээр үндэслэн гаргадаг.

Улбар шар өнгийн зар мэдээ: нийтийн аюулгүй байдалд аюул заналхийлэл учруулж болзошгүй хүн, эд зүйл, үйл явдлын талаарх мэдээллийг бусад гишүүн орнуудтай хуваалцах, сэрэмжлүүлэх чиглэлээр аль нэг гишүүн орноос ирүүлсэн мэдээлэл дээр үндэслэн гаргадаг. Тухайлбал олон тооны хоригдол шоронгоос оргосон тохиолдолд хөрш зэргэлдээ улс орнууддаа сэрэмжлүүлэг өгөх зорилгоор энэ төрлийн зар мэдээг гаргуулах хүсэлтээ Интерполд хүргүүлдэг.

Хөх ягаан өнгийн зар мэдээ: гэмт этгээдүүд гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж байгаа онцлог үйлдлийн арга, багаж хэрэгсэл, гэмт хэргийн халдлагын зүйлс, нуун далдлах аргын талаар бусад гишүүн орнуудад мэдээлэл өгөх гаргадаг. Тухайлбал: хар тамхийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт ашиглагдсан хар тамхийг нуун далдалсан үйлдлийн аргыг нийт гишүүн орнуудад мэдээлж сэрэмжлүүлэх зорилгоор энэ төрлийн зар мэдээг тогтмол ашигладаг.

Хар өнгийн зар мэдээ: хэн болох нь тогтоогдоогүй цогцсын танин олуулах зорилгоор гаргадаг

Тусгай зар мэдээ: Интерпол, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хамтарсан НҮБ-ын хориг арга хэмжээнд хамрагдсан хүн болон байгууллагуудад холбогдуулж гаргадаг байна.

Манай улс 1991 оны тавдугаар сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Интерполд элсэн орох тухай шийдвэрлэж, 1991 оны арван нэгдүгээр сард Интерполын Ерөнхий ассамблейн 60 дугаар чуулганаар Интерполын 155 дахь гишүүн орноор элссэн. Интерполийн гишүүн улс бүр үндэсний хууль сахиуулах байгууллагын ажилтнуудаас бүрдсэн Үндэсний товчоотой байна гэсэн заалтын дагуу манай улсын Интерполын үндэсний төв товчооны Ажлын алба ЦЕГ-ын даргын шууд удирдлага дор ажилладаг.

Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь хэсэгт: “Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн байгууллагыг хангах нь Цагдаагийн төв байгууллагын үндсэн үүрэг” болох талаар хуульчилжээ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь гадаад улс орон руу оргон зугтсан нь Хил хамгаалах албанаас авсан албан ёсны мэдээллээр батлагдсан тохиолдолд гэмт этгээдийг эрэн сурвалжлах, мэдээлэл солилцох, шилжүүлэн авах шаардлагатай болохыг Интерполын Үндэсний төв товчооны Ажлын албанд батлагдсан хүснэгтийн дагуу хүргэж, Ажлын алба хүсэлтийг Интерполын удирдан зохион байгуулах төвд хүргэх замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, шилжүүлэн авах ажиллагаа хийгдэнэ. Тухайлбал, манай улс 2019 онд гэмт хэрэг үйлдэн гадаад улс оронд оргон зугтсан 8 иргэнийг

шилжүүлэн авах зорилгоор Интерполын улаан зар мэдээгээр, 31 иргэний байгаа газрыг тогтоолгох зорилгоор хөх зар мэдээгээр, сураггүй алга болсон 1 иргэнийг шар зар мэдээгээр эрэн сурвалжлуулахаар Интеполд хандсан ба тэдгээр эрэн сурвалжлагдаж буй этгээдүүдийн 7 нь гадаад улсын иргэн байна.

2020 онд 8 иргэнийг улаан зар мэдээгээр, 53 иргэнийг хөх зар мэдээгээр, 2021 онд 2 иргэнийг улаан зар мэдээгээр, 24 иргэнийг хөх зар мэдээгээр, 1 иргэнийг шар зар мэдээгээр олон улсын хэмжээнд шинээр эрэн сурвалжлуулсан. 2022 оны 03 дугаар сарын байдлаар шинээр нийт 21 иргэнийг (үүнээс гадаадын иргэн 1) шилжүүлэн авах зорилгоор гадаад улсын нутаг дэвсгэрт баривчлуулах хүсэлтийг улаан зар мэдээгээр, байршил тогтоох чиглэлээр мэдээлэл солилцох хөх зар мэдээгээр 66 иргэнийг (үүнээс гадаадын иргэн 15) идэвхтэй төлөвт эрэн сурвалжилж байгаа бол, сураггүй алга болсон 11 иргэнийг шар зар мэдээгээр нийт 87 оргодол этгээдийг эрэн сурвалжилж байна.[3]

Ийнхүү Интерполын шугмаар эрэн сурвалжлуулах ажиллагаа зохих үр дүнгээ өгч байна. Тухайлбал, Интерполын улаан зараар олон улсын хэмжээнд эрэн сурвалжилж байсан манай улсын иргэн “Z”-г Испаний Хаант Улсад саатуулан шилжүүлэн авсан нь Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэнд гэмт этгээдийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан шилжүүлэн авсан анхны тохиолдол байлаа. Мөн онд Интерполын улаан зараар эрэн сурвалжлагдаж байх үедээ ОХУ-д саатуулагдсан Монгол Улсын иргэн “W”-г ОХУ-аас, мөн иргэн “S”- АНУ-аас тус тус шилжүүлэн авсан.

Манай улсын цагдаагийн байгууллага ч Интерполын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж Интерполын шугамаар олон улсын хэмжээнд эрэн сурвалжлалт зарлагдсан этгээдүүдийн бүртгэлийг шинэчлэн сайжруулж, үнэлэлт дүгнэлт өгөх, эрэн сурвалжлах ажлыг шуурхай зохион байгуулах зэрэг цогц арга хэмжээ авсны дүнд оргодол этгээдүүдийн байршлыг тогтоон баривчлах, шилжүүлэн өгөх ажиллагааг амжилттай зохион байгуулж байна. Тухайлбал, 2019 онд ОХУ-д залилан мэхлэх гэмт хэрэг үйлдээд оргон зайлсны учир ОХУ-ын Интерполын Үндэсний төв товчооны хүсэлтийн дагуу Интерполын шугамаар эрэн сурвалжилж байсан ОХУ-ын иргэн “C”-ийг Монгол Улсад байгаа байршилийг нь тогтоон баривчилж, ОХУ-ын талд шилжүүлэн өгсөн.

Дээрх тоо баримтаас үзэхэд манай улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд гадаад улс орон руу оргон зугтах нь жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг илтгэнэ.

Ашигласан материалын жагсаалт

1. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, ЭБШЭЗ. 2012

2. https://www.interpol.int/en/Who-we-are/General-Secretariat

3. Цагдаагийн ерөнхий газрын Интерполын үндэсний төв товчооны ажлын албаны сүүлийн 3 жилийн мэдээ.

[3] ЦЕГ-ын Интерполын үндэсний төв товчооны Ажлын албаны мэдээ. 2020-2022

ГҮЙЦЭТГЭХ АЛБА, АЖИЛТНААС ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГААР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO FIGHT CRIME BY INTELLIGENCE OFFICER AND ANALYSIS

Х.Тулга
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
Tulga.Kh
University of Internal Affairs, Post-graduate student, Police senior lieutenant

Хураангуй: Гүйцэтгэх алба, ажилтны гол зорилго нь цуглуулсан мэдээ, мэдээллээ боловсруулж онилсон байндаа зөв оновчтой байдлаар хүрэх бодлого гэж үзвэл дүн шинжилгээ нь өөрөө гүйцэтгэх ажил гэсэн утга нэг ойлготонд хүрэх юм. Энэхүү өгүүлэлд гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий цагдаагийн байгууллагын гүйцэтгэх алба, ажилтнаас дүн шинжилгээний арга, аргачлал ашиглан гэмт хэрэгтэй тэмцэх зарим асуудлын талаар дурдсан болно.

Abstract: Assuming that the main goal of an intelligence agency is to process the information it collects and to achieve it in the right way, the analysis itself will be understood as intelligence work. This article discusses some of the issues in the fight against crime using analytical methods and techniques from the police intelligence service responsible for combating crime.

Түлхүүр үгс: Гүйцэтгэх алба, гүйцэтгэх ажилтан, дүн шинжилгээ, дүн шинжилгээний арга, гэмт хэрэг.

Key words: Intelligence Agency, Intellingence Agent, analysis, analytical methods, crime.

Гүйцэтгэх алба, ажилтны гол зорилго нь цуглуулсан мэдээ, мэдээллээ боловсруулж онилсон байндаа зөв оновчтой байдлаар хүрэх бодлого гэж үзвэл дүн шинжилгээ нь өөрөө гүйцэтгэх ажил гэсэн утга нэг ойлготонд хүрэх юм.

Дэлхий нийтэд өрнөж буй дижитал шилжилт буюу аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал, нийгмийн хөгжилтэй зэрэгцэн гарч буй гэмт хэргийн өөрчлөлт, чиг хандлага, үйл явцын шинж тэмдгийг урьдаас олж харж мэдэрч түүний хор уршгаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх, ГА-ын хяналт тогтооход хариуцсан чиглэл, нутаг дэвсгэрийнхээ нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж зорилт, хэрэгцээ шаардлагаа зөв тодорхойлох нь цагдаагийн гүйцэтгэх алба, харьяа нэгж, гүйцэтгэх ажилтан бүрийн хамгийн түрүүнд хийх ажлын нэг юм.

“Дүн шинжилгээ” гэсэн хоршоо үг Монгол хэлний их тайлбар толиос олдоогүй тул хоршоо үгийн утга санааг тус тусад нь эрэлхийллээ. Тухайлбал “Дүн” гэдэг үгийг үр дүн, үйл хэргийн дуусгал, үр тус гэж тодорхойлсон. “Шинжилгээ” гэдэг үгийг дангаар нь судалж үзвэл шинжлэн судлах арга, аливаа юмны бүтцийг тодорхойлох судалгаа гэж тайлбарласан байна.[1]

Иймд энэ хоёр үгийн утгыг нийлүүлж ойлговол аливаа судалж байгаа зүйлийг нэгтгэх, шинжлэн судлах, боловсруулах буюу эцсийн үр

[1] Монгол хэлний их тайлбар толь, https://mongoltoli.mn/

дүн гэж ойлгогдоно. Тиймээс дүн шинжилгээ гэдгийг эх сурвалжуудаас цуглуулсан мэдээг нэгтгэх, үнэлэх, өөр хооронд нь харьцуулах, таамаглал дэвшүүлэх, дүгнэлт гаргах, өөрөөр хэлбэл түүхийг мэдээг боловсруулж мэдээлэл болгох үйл ажиллагаа гэж ойлгож болох юм.

Нөгөөтэйгүүр "Гүйцэтгэх ажил-Тагнуулын ажил" гэдэг хоршоо үгийг судалж үзвэл www.dictionary.com[2] толь бичигт "Мэдээ, мэдээлэл цуглуулах, харилцан солилцох түгээх", "Мэдлэг, ур чадвараа ашиглах", АНУ-ын Холбооны мөрдөх товчооны тодорхойлсноор "Мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулах, шинжлэх процесс"[3] гэж тайлбарласан байна

Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагын гүйцэтгэх алба, ажилтны цуглуулсан түүхий мэдээнд дүн шинжилгээ хийснээр үүсч болзошгүй аюулыг урьдчилан харж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чухал ач холбогдол үзүүлж үүсч болзошгүй аюулаас сэргийлэх талаар шийдвэр гаргагчид нөхцөл байдлыг бодитоор харах боломжийг бүрдүүлж өгөх явдал юм.

Дүн шинжилгээний ажлын зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гэмт хэргийн улмаас учрах хор уршиг, аюулыг урьдчилан тооцоолж, цаашдын хэтийн төлөв, чиг хандлагыг тодорхойлох зөв шийдвэр, шийдэл гаргах гэж ойлгож болох юм.

Дүн шинжилгээний ажлын ач холбогдол нь зөв бодлого боловсруулж сайн зохион байгуулалтыг хийдэг болох, тухайлбал гэмт хэргийн шинжтэй шаардлага хангасан мэдээ, мэдээллийг сонгож цуглуулах, сан үүсгэж бүртгэлжүүлэх талаар нарийн ойголттой болно гэж ойлгож болно.

Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх алба, ажилтан дүн шинжилгээ хийхийн тулд бүх төрлийн эх сурвалжаас авсан мэдээг зөв зохион байгуулалтад оруулан нэгтгэж, урьдчилсан таамаглал, зураглал гаргах нь зүйтэй юм.

Өнөөдөр дэлхийн улс орнуудын гүйцэтгэх тусгай албад дүн шинжилгээний арга, аргачлалд суурилсан тагнуулын үйл ажиллагаа явуулж байна.

Ингэхдээ тагнуулын байгууллагууд нь дүн шинжилгээний олон улсын жишиг аргачлалд тулгуурлан дүн шинжилгээг хийж байна.

Төлөвлөх ба чиглүүлэх

Гүйцэтгэх алба нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг хандлагаа тодорхойлоход сайн боловсруулсан төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Сайн төлөвлөгөө бол Гүйцэтгэх ажлын эргэх холбооны чухал хэсэг юм. Төлөвлөгөөнд:

- Хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох
- Удирдлагаас ямар зүйл хүсэж байгааг тогтоох
- Гүйцэтгэх ажлын зорилгод хүрэх арга замыг тодорхойлох
- Хүн, хүч төсөв бусад хэрэгцээтэй нөөц боломжийг тодорхойлох
- Хийх ажлуудыг цаг хугацаагаар нь жагсаах

Хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлохын тулд тухайн нөхцөл байдлаа сайтар судлах хэрэгтэй. Мөн хүрч болох зорилгоо тодорхойлж, зорилгодоо хэрхэн яаж хүрэх, ямар эх сурвалжуудыг ашиглах /ГА-ын хүч,

[2] https://www.dictionary.com/browse/intelligence

[3] Мэдээллийн дүн шинжилгээ. УБ. 2016 он

хэрэгсэл, арга/ гэх зэргээр төлөвлөгөөний дагуу ажиллана.

Анхаарах зүйл: Бэлтгэл ажлыг сайн хангаж төлөвлөгөөг маш нарийн хийх ёстой. Хийх ажлын ач холбогдол, зорилгыг сайн ойлгож удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, цаг хугацааг анхаарах ёстой байдаг. Хэрэв төлөвлөгөөг алдаатай, хайнга, учир дутагдалтай хийсэн тохиолдолд буцаад эхэлсэн цэг дээрээ ирж цаг хугацаа, төсөв мөнгө ихээр алдсан байдаг тул дээрх зүйлсийг анхаарах нь чухал юм.

Зарим өндөр хөгжилтэй орны тусгай албад гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг доод тал нь 3 сарын хугацаанд хийж гүйцэтгэдэг байна.

Мэдээлэл цуглуулах

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор боломжтой бүх мэдээллүүдийг нээлттэй, хаалттай, нууц эх сурвалжаас цуглуулах нэгтгэх үнэлэх үйл ажиллагаа юм. *Мэдээлэл бол их хүч бололцоо юм. Түүнийг үр дүнтэй ашиглах арга нь дүн шинжилгээ юм.*

Мэдээлэл цуглуулах эх сурвалжийн төрлүүд. Тухайлбал:

- *Нээлттэй эх сурвалж* гэж /Open Source/ Хүссэн хүн бүхэн олж авах боломжтой нийтэд зориулсан бүх төрлийн эх сурвалжийг хэлнэ. Тухайлбал:

/Сонин хэвлэл, сэтгүүл, телевиз, радио, интернэт сошиал орчин/ гэх мэт

- *Хаалттай эх сурвалж* гэж /Restricted/Closed Source/ Төрийн болон төрийн бус байгууллагуудад үүсэж хөтлөгдөн баяжилт хийгддэг албан хэрэгцээнд ашиглагддаг мэдээлэл, өгөгдөл юм. Тухайлбал:

/Иргэний бүртгэл, хил гааль, татвар, нийгмийн даатгал гэх мэт тусгай эрхтэй алба хаагчийн нэвтрэн орж мэдээллээ авдаг өгөгдлийн сангууд байна/

- *Нууц эх сурвалж* нь /Sensitive/Confidential Source/ Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл, арга хувилбар, тоо бүртгэл, туслагч, туслах ажилтан, НГА-с авсан маш нууц зэрэглэлд хамаарах мэдээллүүд орно.

Боловсруулагдаагүй мэдээлэл гэж /Raw information/ Нээлттэй, хаалттай, нууц эх сурвалжаас авагдсан дүн шинжилгээ хийгдээгүй мэдээллийг хэлнэ.

Гүйцэтгэх ажлын мэдээлэл нь /Intelligence information/ Нээлттэй, хаалттай, нууц эх сурвалжаас авагдсан бүх төрлийн өгөгдөлд дүн шинжилгээ хийж үнэлэгдсэн ашиглагдахаар түвшинд боловсруулсан мэдээлэл юм.

*Мэдээлэл цуглуулахад анхаарах зүйлс.*Үүнд:

- Мэдээлэл цуглуулахаас өмнө хэн юу хүсэж байгааг сайн тодорхойлох ёстой
- Бид нар юу мэдэж байна?
- Бид нар юу мэдэхгүй байна?
- Ийм зүйл өмнө болж байсан уу?
- Хэрхэн болсон?
- Ямар шинж тэмдгүүд илрэн гарч байсан эсэх? гэх мэт хэрэгтэй бүх асуултуудыг жагсааж бичнэ. Дараа нь багаараа буюу хамт олноороо хурлаа хийж жагсааж бичсэн асуултуудаа ач холбогдлоор нь эрэмбэлж, мөн чанарыг тодорхойлж асуултуудыг хооронд нь групп болгоно.

Дээрх асуултуудын хариултыг гаргаж ирснээр бидний мэдээлэл цуглуулах ажлын ерөнхий зураглал нь гарч ирнэ. Энэ бол дүн шинжилгээний нэг арга хувилбар юм. Гүйцэтгэх ажил бол багийн тоглолт.

Дэлхийн хөгжилтэй орнууд нь тагнуулын ажлын мэдээллүүдийн ихэнх хувийг нээлттэй эх сурвалжаас авч

байна. Өөрөөр хэлбэл тагнуулын ажил нь маш нууц мэдээллийн сангуудтай харьцаж, нууц мэдээлэл авч ашигладаг гэсэн ойлголтоос орчин үед татгалзаж байна.

Гэхдээ гэмт хэрэг, гэмт бүлэглэлийн талаарх чухал мэдээллийг өгөх эх сурвалж бол туслах хүч гэдгийг мартаж болохгүй.

Аливаа ерөнхий мэдээллийг хүн бүр олж авч чаддаг. Харин ГА-ын сонирхол татсан үнэ цэнтэй мэдээллийг хүч хөдөлмөр, төсөв хөрөнгө, цаг хугацаа зарцуулан байж олж авдаг гэдгийг байнга санах хэрэгтэй.

Жишээ нь: ГА-ын арга хэмжээний үр дүнгээр, гэмт этгээдүүдийн хувийн байдлыг тодорхойлох үед, гэмт бүлэглэл, гэмт этгээдүүдийн хоорондын харилцааг судлах үе гэх мэт.

Мэдээллийг ангилах

Цугларсан мэдээллийг ашиглахад илүү хялбар болгох зорилгоор төрөлжүүлэн зохион байгуулалтад оруулахыг мэдээллийг ангилах гэдэг. Ингэснээр өөр өөр эх сурвалжуудаас цугларсан мэдээлэл, өгөгдлүүдийн ижил төсөөтэй болон тэдгээрийн хоорондын харилцаа холбоог тогтоож, бусад лавлагаа, мэдээллийг хугацаа алдахгүйгээр олох боломжтой болдог.

Мэдээллийг боловсруулж, ангилж үнэлэх нь дүн шинжилгээ хийх боломж нөхцлийг бүрдүүлднэ. Мэдээлэл, өгөгдлийг ангилах үйл ажиллагааг гар болон автомат дүн шинжилгээний программ хангамжууд гэж хоёр хуваадаг. Мэдээж олон мянган өгөгдөл мэдээллийг ангилан системчлэхэд тусгай программ хангамж, техник хэрэгслийг ашигладаг. Жишээ нь: /excel, access, i2 гэх мэт/

*Өгөгдөл мэдээллийг боловсруулах ангилах арга.*Үүнд:

- Цаг хугацааны шугам /Time Line/
- Холбоосын дүн шинжилгээ /Link analysis/
- Бүлгийн схем /group scheme/
- Хүснэгт үүсгэх /Table matrix/ гэх мэт аргуудыг ашиглан мэдээллийг боловсруулж ангилдаг байна.

Мэдээлэл өгөгдлийг ангилахын ач холбогдол:

- Аль мэдээллийг ашиглаж болох, ашиглаж болохгүй бэ, гэдгийг тодорхойлдог.
- Ашиглах болон хэрэгцээтэй өгөгдлүүдийг олж авахад хялбар болох бөгөөд дараагийн алхмыг автоматаар хийх нөхцөл бололцоог бүрдүүлж дүн шинжилгээний үр дүн сайжрахад нөлөөлнө.
- Мэдээлэл өгөгдлүүдийн холбоосууд болон түүнд анхаарах дохио, шинж тэмдгүүд илэрч ингэснээр урьдчилсан үнэлэлт хийх боломж олгож судалгаан дахь дутуу, хоосон орон зайг олж тогтоох боломжоор хангадаг.

Дүн шинжилгээ хийх

Дүн шинжилгээ гэдэг нь нээлттэй, хаалттай, нууц эх сурвалжаас авагдсан бүх төрлийн мэдээллийг цуглуулан судалж, ангилж үнэлсэн мэдээллүүдэд тулгуурлан оновчтой таамаглал дэвшүүлж, дүн шинжилгээ хийж бодлого боловсруулагч, удирдах албан тушаалтнуудыг мэдээллээр хангаж шийдвэр гаргахад нөлөөлөх үйл ажиллагаа юм.

Өөрөөр хэлбэл *Анализ* гэж боловсруулагдаагүй мэдээлэл болон өгөгдлийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх үйл ажиллагааг хэлнэ.

Дүн шинжилгээ нь үнэ цэнэгүй мэт мэдээллүүдийг тагнуулын ажлын мэдээлэлд хувиргах талбар болдог

бөгөөд өмнөх үе шатанд цугларч нэгтгэгдсэн өгөгдлүүдийг дүн шинжилгээний аргачлалаар боловсруулж гүйцэтгэх ажлын мэдээлэл болгон хувиргадаг.

Дүн шинжилгээ хийхэд сэтгэн бодох болон гаргалгаа хийх чадвар, жижиг деталиудыг том зураг байрлуулах арга зүй чухал байдаг. Нөгөө талаас цугларсан өгөгдлүүдийг дүн шинжилгээний программ хангамж, техник хэрэгслийн тусламжтайгаар тайлбарлах нь илүү ашигтай байдаг.

Түгээх, эргэлтэд оруулах

Боловсруулагдсан гүйцэтгэх ажлын өгөгдлүүдийн хамгийн сүүлийн шат бол түгээлтийн хэсэг юм. Түгээлт нь хэрэгцээнээсээ хамааран зөвхөн шийдвэр гаргах эрх бүхий удирдах албан тушаалтнуудад зориулагдан бэлтгэлдэж болох боловч албан бичиг, танилцуулга хэлбэрээр өөр байгууллагуудад /УАБЗ, ТЕГ, АТГ, ШШГЕГ гэх мэт/ өгч болно. Танилцуулгын агуулга дотор дүн шинжилгээний ажлын тактикийн төрлүүд ойлгомжтой байдлаар тусгагдсан байх ёстой.

Жишээ нь: “*Тактикийн дүн шинжилгээ, Арга хэмжээ, дайчилгааны дүн шинжилгээ, Стратегийн дүн шинжилгээ”*-ний аргуудын аль төрөлд нь тус тус тулгуурлан уг дүн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэснийг бичиж тайлбарласан байх хэрэгтэй.

Гүйцэтгэх ажлын дүн шинжилгээг тухайн хийгдэх гэж буй ажлын цар хүрээ, нийгмийн хэрэгцээ шаардлага, зорилгоос хамаарч *Тактикийн, Арга хэмжээ, дайчилгааны, Стратегийн* гэж 3 хуваадаг.

Тухайлбал:

Тактикийн дүн шинжилгээ /Tactical Intelligence/ тодорхой төрлийн гэмт хэрэг, түүнтэй холбоотой аюул заналыг хор аюулыг маш богино хугацаанд шийдвэрлэх зорилгоор арга хувилбар зохиоход хэрэглэж буй шууд ашиглаж болох дүн шинжилгээ,

Арга хэмжээ, дайчилгааны дүн шинжилгээ /Operations Intelligence/ Тодорхой цаг хугацаанд гэмт хэрэг, бүлэглэл бүлгийн гишүүдэд чиглэсэн тагнуулын арга хэмжээний үр дүнд объектыг тодорхойлох, дайчлах, тодорхой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, харилцаа холбооны арга замыг олж тогтоох дүн шинжилгээ,

Стратегийн дүн шинжилгээ /Strategic Intelligence/ Гэмт хэрэг, гэмт явдал болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой урт хугацааны бодлого тодорхойлох зорилго бүхий дүн шинжилгээ. /Ирээдүй рүү чиглэсэн байдаг/

Дүгнэлт

Манай улсын хувьд үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, шинэ төрлийн гэмт хэргүүд бүртгэгдэж, цаашид түгээмэл гарч болзошгүй энэ цаг үед бодлогын хэмжээнд гэмт явдалтай тэмцэх түүний үр дүнг тооцон ажиллах нь нэн чухал сэдэв болж байна.

Үүний тулд гэмт хэргийн чиг хандлага, хувьсан өөрчлөлт, нөхцөл байдлыг дүн шинжилгээний аргаар үндэслэл, судалгаатайгаар үнэлж, эргэлтэд оруулж түгээлт хийн түүнтэй тэмцэх нь үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан харах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход тэргүүний ач холбогдолтой юм.

Улсын орны болон бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитой тодорхойлж түүнтэй тэмцэхийн тулд

“*Стратегийн дүн шинжилгээ*” хийж одоогийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч ирээдүйд гэмт явдалтай тэмцэх бодлогыг тодорхойлж гэмт этгээдүүдийн үйл ажиллагааг саармагжуулах, гэмт хэргийн хар зах зээл, зам сувгийг тодорхойлж нөлөөллийн арга хэмжээг авч байнгын хяналтдаа авах ГА-ын хэрэгцээ шаардлага бидний өмнө тавигдаж байна.

Иймд алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн хэлтэс, тасгаас гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж буй бодлого, төлөвлөлт, хүч хэрэгслийн зохион байгуулалт, арга тактикийг хариуцсан нэгж, нутаг дэвсгэрийн нөхцөл байдалтай уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй, дүн шинжилгээний арга, дэвшилтэт техник хэрэгслийг ашиглан үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай.

Гэвч өнөөгийн бодит байдал дээр цагдаагийн байгууллагын гүйцэтгэх албаны алба хаагчд өөрсдийн хариуцсан нэгж, нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг бодитойгоор тэр болгон зөв мэдэрч тодорхойлж чадахгүй байна.

Санал:

Дэлхий нийт дижитал шилжилтийн үе буюу аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын эрэн зуунд амьдарч байгаа өнөө үед цагдаагийн байгууллагын гүйцэтгэх алба зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэгтэй тэмцэхдээ хөгжингүй орны гүйцэтгэх байгууллагын дүн шинжилгээний арга аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ашигласнаар тухайн гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгааныг үнэн бодит, зөвөөр тодорхойлж хариу арга хэмжээг авах, гэмт хэргийн нөхцөл байдлын цаашдын чиг хандлага, учирч болзошгүй аюул заналхийллийг тодорхойлж түүнтэй тэмцэх оновчтой арга хэмжээг цаг алдалгүй авах давуу талууд үүсэх юм.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Г.Хишигдорж
Магистрант, цагдаагийн дэслэгч
Г.Хишигдорж
Магистрант, цагдаагийн дэслэгч

Хураангуй: Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Abstract: An analysis of the situation in which the crime of rape of a minor has been enshrined in the Criminal Code of Mongolia

Түлхүүр үг: Бага насны хүүхэд, хүүхэд хүчиндэх гэмт хэрэг, бэлгийн харьцаа, хууль тогтоомж,

Key words: Juvenile and child rape, sexual intercourse and legislation.

Ёс бус үйлдэл буюу гэмт хэрэг бол эрх зүйн сөрөг үзэгдэл болохын зэрэгцээ түүхийн, нийгмийн үзэгдэл бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдээ гэмт халдлагаас хамгаалах асуудал нь төрийн дотоод чиг үүргийн хүрээнд хамаарагдаж ирсэн байна.

Монголын эртний улсуудын үед Монгол газар нутагт Монгол угсааны Хүннү, Сүмбэ, Их Нирун, Түрэг, Уйгур, Кидан зэрэг улсууд оршин тогтнож, өөрөөр хэлбэл Монгол нутагт эртний нийгэм бүхий монгол болон монгол бус угсааны улсууд оршин тогтнож, төр ёс ихэд хэлбэржин, хэв хуулиас бичмэл хууль руу шилжиж эхэлж болох нь түүхийн олон баримтаар нотлогддог.

МЭӨ 209 - МЭӨ 93 онд оршин тогтнож байсан Монголын анхны төрт улс болох Хүннү гүрний эрх зүйн эх сурвалж бидний үед хадгалагдан үлдээгүй ч гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлүүлэд тодорхой хэмжээгээр тусгагдаж ирсэн нь биднийг эх түүхээ судалж суралцах боломжийг олгож байна. Тухайлбал, ял шийтгэлийн бэрээдэх, хөрөнгийг хураах, хүнд хөдөлмөрт зүтгүүлэх, цаазаар авах шийтгэлийн 4 төрөл[1] байсан тухай дурьдсан боловч тэдгээрт насны хязгаар байсан эсэх талаар тодорхой бичээгүй байна. Харин хүүхдийг эрх зүйн субъект байсан гэж үзэх 2 баттай тохиолдолыг харж болохоор байна. Үүнд:

1-рт: Татвар авахдаа хүн малын тооллого явуулдаг, ингэхдээ насанд хүрээгүй этгээдийг оролцуулан тоолдог байсан,

2-рт: Хятад сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэнээр 14-15 насны хүүхдүүд морь унах, нум сум харвах зэргээр цэргийн бэлтгэлд гаргах үүрэгтэй, цэрэг иргэний гол систем болох аравтын тогтолцоонд тэднийг оруулан тооцдог байсан зэрэг болно.

Хүннү гүрний дараагаар Монгол газар нутаг дээр оршин тогтнож байсан

[1] Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980.

түүхэн төрт улс бол Сүмбэ улс юм. Тус улс эхэндээ хэв хуультай байснаа сүүлдээ бичмэл хуультай байсан гэж эрдэмтэд үздэг боловч гэмт хэрэг, ял шийтгэлийн талаархи ямар нэгэн мэдээ тэр бүр бичигдэн үлдээгүй басхүү судлагдаагүй байна.

Хүннү болон Сүмбэ улсын төрийн аюулгүй байдлаа сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого нь хатуу чанд ял шийтгэлийн бодлогоор дамжин илэрч хэрэгжиж байсан гэж эрдэмтэд үзсэн байдаг. Тухайлбал, доктор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар “...улс орон даяар хоригдол хүн хэдхэнээс хэтрэхгүй...”, “...Хүннүгийн хууль хатуу чанд байсан тул зүрхлэн зөрчигчид тун цөөхөн байсныг илтгэнэ[2]”, “Сүмбэ улс нилээд хатуу эрх зүйн хэм хэмжээ тогтоон, түүнийгээ нарийн чанд биелүүлэхийг шаардаж байсан байна[3]” хэмээн тус тус бичсэн бол доктор Г.Сүхбаатар өөрийн бүтээлдээ: “Сурвалж бичгийн мэдээгээр цааз тогтоон зөв бурууг шийдэж байсан бөгөөд зүрхлэн зөрчигчид байгаагүй[4]” хэмээн бичсэн зэрэг нь дээр дурьдсанчилан гэмт хэрэгтэй тэмцэх бодлого хатуу чанд ял шийтгэл оногдуулах байдлаар илэрч байсанг нотолж байна.

Сүмбэ улсын дараагаар Монгол газар нутаг дээр оршин тогтнож байсан дараагийн Улс бол Их Нирун /МЭ 330-550 он / улс юм. Нирунчуудын төрт ёсонд өмнөх улсаас онцлогтой нь бурханы шашны нөлөө нэвтэрсэн байсан гэдгийг түүхчид тэмдэглэн үлдээжээ. Тиймээс төр ёсны үзэл нь гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд Хүннү, Сүмбэ улстай харьцуулахад харьцангуй зөөлөрч ирсэн байх магадлалтай гэж бид үзэж байна.

Гэвч түүх эрх зүйн тулгар бичгүүдэд цэрэг захиргааны цаазтай байсан гэснээс өөрөөр Нируны хуулийн талаар тун хомс баримт сэлт үлдсэн учраас тэдний гэмт хэрэг, түүн дотор насанд хүрээгүй этгээд, хүүхдийн эрх ашиг сонирхолыг хэрхэн хамгаалж ирсэн талаар тодорхой дүгнэлт хийх боломжгүй байна. Их Нирун улс мөхсөний дараа Монгол газар нутаг дээр Түрэгийн хаант улс /552-745 он/, дараа нь Уйгарын хаант улс /745-840/ түүнчлэн Кидан /907-1125 он/ зэрэг улс оршин тогтнож байжээ. Тэдгээр нь хэл, гарлын хувьд харь угсааны улсууд байсан боловч нэг үе Монгол угсааны улсуудын бүрэлдэхүүнд багтаж, зарим үед Монгол угсааны аймгуудыг өөрийн бүрэлдэхүүнд багтааж явсаны хувьд өмнөх үеийн Монгол угсааны улсуудын төрт ёс, эрх зүйн уламжлалыг тодорхой хэмжээгээр хадгалж улмаар цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлж байсан гэж үзэж болох учраас эдгээр улсуудын хууль цаазны байдлыг цухас төдий боловч хөндөн үзэх нь зүйтэй юм. Түрэгийн тухайд заншлийн хэм хэмжээ үйлчлэн хааны зарлигаар тогтоосон хатуу хуулийг мөрдөж байсан тухай бичжээ. Хүүхдийн эрх ашиг сонирхлын эсрэг халдлагыг шийтгэх талаарх хэм хэмжээ бидний үед үлдээгүй ч “бусдын гэргийтэй нөгцөгсдөд алах ял заадаг” байсан нь шашин зан үйлийн гэхээсээ илүүтэй гэр бүлийн тогтвортой байдлыг хангах байдлаар хүүхэд, гэр бүлийн эрх ашиг сонирхолыг хамгаалахад тухайн үедээ дөхөмтэй заалт байжээ гэж үзэж болохоор байна.

[2] Ж.Болдбаатар, Л.Лүндээжанцан. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997. 19 дэх тал

[3] Мөн тэнд 24 дэх тал

[4] Г.Сүхбаатар. Сянби. 1971. 155 дахь тал

Эндээс тухайн түүхэн цаг хугацааны үед хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах талаар нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ тэр бүр байгаагүй эсхүл сайтар судлагдаагүй гэж үзэж болох бөгөөд харин хүүхдийг алах, алахаар завдах, хаях, хулгайлах зэрэг гэмт үйлдэл нийгмийн үзэгдэлийн түвшинд байсан зэргийг төр, эрх зүйн түүхийн эх сурвалжуудад үндэслэн тус тус дурьдаж болохоор байна.

Дундад зууны буюу XIII-XX зууны эхэн хүртлэх үе нь Их Монгол Улс байгуулагдахаас эхэлж 1921 оны Ардын хувьсгал ялах хүртэлх нийт найман зууны Монголын төр ёс, эрх зүйн түүхийн урт хугацааг хамардаг. Их Монгол улсын хууль цаазын гол сурвалж бичиг **Их засаг** хуульд эрүүгийн эрх зүй, ял шийтгэлд хамаарах хэд орчим зүйл байсан талаар эрдэмтэд мөн л янз бүрийн байрь суурь баримталдаг. Ямартай ч уг хууль нь ял шийтгэлийн бодлогоор улс орны аюулгүй байдал, дотоод дэг журмыг хангах, хамгаалах талаар тухайн түүхэн цаг үедээ нилээд дэвшилттэй хууль байсан гэж үздэг.

Уг хуулийн эрүүгийн эрх зүйд хамаарах түүн дотроо хүүхдийн эрх ашиг сонирхолыг гэмт халдлагаас хамгаалсан шинжтэй дараах зүйл заалтууд хуульчлагдан мөрдөгдөж байжээ. Тухайлбал, хүүхдийн хүмүүжилд эцэг эх багаас хэрхэн нөлөөлөх талаарх өвөрмөц заалт уг хуульд байсныг “Хүүхэд багачууд бусдыг гомдоовол томчууд нь өмөөрч хаацайлах нь үгүй, харин хатуу чангаар залхаан шавхуурдах бөлгөө” хэмээн Плано Карпини[5] өөрийн бүтээлд дурьдан үлдээснийг нилээдгүй эрдэмтэд иш татан бичсэн байдаг. Энэ нь буруу зан үйлд багаас нь сургахгүй байх төдийгүй гэмт зан үйл гаргахаас урьдчилан сэргийлсэн заалт байсан гэж үзэж болохоор байна.

“**Их Юаны нэвтэрхий хууль**”-д хүүхэд хохирсон бол хэрхэх тухай хэм хэмжээ хэр түвшинд байсан талаар тэр бүр нарийвчлан судлагдаагүй байна. Зарим мэдээ баримтаас харвал хүүхдийн эрх ашгийг хамгаалсан эрүүгийн эрх зүйн дараах хэм хэмжээ үйлчилж байжээ. Тухайлбал, “Монгол хүний үр хүүхдийг уйгар, хятад хүн худалдан авч шивэгчин болгохыг хориглоно[6]” хэмээн зааснаас үзэхэд тухайн үеийн нийгэм төрийн бодлого, эрх зүйн хөгжлийн онцлог хэдийгээр ялгамжтай хандаж буй боловч хүүхдийн эрх ашгийг хамгаалсан хэм хэмжээ байсныг нотлон харуулж байна. Мөн В.А.Рязановскийн бичсэнээр: “Эцэг эхийн үгийг үл сонсох дээд үеийн садан төрлөө үл хүндэтгэх” үйлдлийг хориглосон хэм хэмжээ байсан нь хүмүүжлийн чухал ач холбогдолтой байж хэмээн тодорхойлжээ.

Харин 1271 онд боловсруулж баталсан 88 бүлэг 2539 зүйл бүхий “**Их Юань улсын хууль цаазын бичиг**” хуульд насанд хүрээгүй хүнтэй холбоотой хэд хэдэн зүйл байжээ. Жишээ нь: “Бага насны хүүхдийг хүчирхийлбэл цаазаар авах ял онооно”[7] хэмээн зааснаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэгтэй хатуу тэмцэж байсан байдал ажиглагдаж байна. Харин “Бага насны охиноо алсан бол 57 удаа занчина”[8], “Охин төрүүлсэн хүн

[5] И.Дашням. Эзэн богд Чингис хааны Их засаг хууль. УБ., 2002.
[6] Ч.Далай. Монголын түүх. /1260-1388 он /. УБ., 1992. 74 дэх тал,
[7] Юань Дянь Чжан судар. 1320. В.А.Рязановский. Чингис хааны Их засаг хууль. УБ., 2002. 74 дэх тал
[8] Мөн тэнд

түүнийгээ хүмүүжүүлэх ёстой агаад сая мэндэлсэн охиныг егүүтгэвэл өөрийг нь боол болгож, өмч хөрөнгөний нь талыг хураана”[9] гэсэн хэм хэмжээ байгаа нь ял шийтгэлийн бодлогын хувьд хөнгөн байсан нь сонирхол татаж байна. Энэ талаар доктор, С.Бадарчи өөрийн бүтээлд: “Аливаа бяцхан охид хэмээсэн нь арван наснаас доошхийг болой, Гурван эр нэг эмэгтэй хүчирхийлэн явалдваас цөмийг ална” гэсэн хатуу алах ял оноох хэм хэмжээ мөн байсан хэмээн үзжээ. Мөн хуулинд хүүхдийн эрх ашиг сонирхол түүн дотроо хүүхдийн хүсэл зоригийн эсрэг гэмт үйлдлүүдийг цаазлан хориглож байсан хэд хэдэн хэм хэмжээ хуульчлагдсан байжээ. Эдгээрт “Үр хүүхдүүдээ барьцаалж буюу худалдаж болохгүй[10]”, “Барьцааны этгээд барьцаанд өгөгчийн охинтой гэрлэх ёсгүй.”[11] гэсэн хэм хэмжээ хамаарах бөгөөд дундад зууны үеийн хууль гэхэд хүүхдийн хүсэл сонирхол, өссөн төрсөн гэр бүлдээ байх заяагдмал эрх, өрийн болон бусад дарамтын улмаас бусадтай гэрлэх байдлаас урьдчилан сэргийлэх зэрэг олон талт байдлыг харгалзсан хууль байжээ.

Үүний дараагийн төр хууль цаазын түүхэн эх сурвалж бол “**Алтан ханы цаазын бичиг**” юм. Энэхүү цаазын бичигт насанд хүрээгүй этгээдтэй холбоотой гэмт хэрэг, ял шийтгэлийн дараах зохицуулалтыг агуулсан байна.

“Эр эм. гэр бүлийн хэрэг” гэсэн зүйл ангид хүүхдийн эсрэг гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох агуулга бүхий заалтууд байна. Жишээ нь: Цааз бичгийн 53 дугаар зүйлд “жирсэмсэн эмийн ургийг унагаваас сараар тоолон ес ав”[12] гэсэн нь нэг талаас эмэгтэйчүүдийг хамгаалах тухай боловч нөгөө талаас хүүхдийн амьд явах, эсэн мэнд өсөн бойжих эрхийг эхийн хэвлийд байхаас нь хуулиар хамгаалж байсан байна. Эмс охидыг эрд гаргахад тэдний санал бодлыг хүндэтгэх, эрх ашиг сонирхлыг нь харгалзах талаархи агуулга бүхий “эцэг эх нь охиноо элдэв аргаар эрд өгвөөс есөн есөөр торго, охин буцаж ирвээс цаазгүй”, “цэвэр бага охиныг гутааж эцэг эх нь хүргэнд барьж өгвөөс эцэг эх нь цаазтай”, “хүүхэн босговоос есөн есөөр торгож, нэг хэсэг жанч” гэсэн хэм хэмжээ цаазын бичигт тусгагдан үйлчилж байжээ. Эдгээрээс гадна эмэгтэй хүн түүн дотроо охидыг бие махбодийн болон бэлгийн түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлээс хамгаалах агуулга бүхий “эр нь эмийн үсийг тасдваас нэг таваар торго”, “хувцсийг нь урваас нэг таваар торго”, “ор дэвгэрээс нь татваас гурван есөөр торго”[13] гэсэн зүйлүүд мөн үйлчилж байжээ.

Дээрхи цаазын хэм хэмжээнээс харахад зарим зүйлд нь “эр нь эмийн”, заримд нь “эр нь эхнэрээ” хэмээн тусган зохицуулснаас харахад дээр дурьдсан гурван зүйлийн гэмт хэргийн хохирогч нь эмэгтэйчүүд төдийгүй насанд хүрээгүй охидууд хамрагдаж байсныг илтгэнэ.

XVI зууны II хагасаас XVII зууны эхний хагаст үйлчилж байсан Монголын хууль цаазын түүхэн эх сурвалж бол “**Халхын цааз эрхэмжийн 18 хууль**” юм.

Энэ цаазад “гэрчгүй хуримыг үрье, Гэрчтэй болтугай, хорь насалсан

[9] Юань ши судар. В.А.Рязановский Чингис хааны Их засаг хууль. УБ., 2002. 76 дахь тал
[10] В.А.Рязановский. Чингис хааны Их засаг хууль. УБ., 2002. 75 дахь тал
[11] Мөн тэнд
[12] Мөн тэнд
[13] Мөн тэнд

охиныг өөрийн ноён хүргэний ноёнд хүрч өг”[14], “Хорь насалсан охиныг өг, өөрийн ноёноосоо асууж өг. Ноён хүн өөрийн хорь насалсан охиноо ойрхи ноёнд сонгож өг. Хан ба харц малыг нь хариулж өг. Хуримтай ч болов өг” гэсэн төсөөтэй хоёр зүйлийг цаг хугацааны хувьд 2 өөр хугацаанд батлаж гаргасан нь гэрлэх насыг 20 насаар тогтоож уг насанд хүрээгүй эмэгтэй хүний эрх ашиг сонирхол зөрчигдөж, бага залуу охидыг элдэв аргаар бусдад худалдагдах, богтлогдохоос урьдчилан сэргийлж, үүний тулд өөрийн болон хүргэний талын ноёнд мэдэгдэх ёс тогтоосон нь иргэн гэр бүлийн байдлыг бүртгэх, хяналт тавих өвөрмөц хэлбэр байсан гэж үзэж болохуйц байна.

Мөн өнөөгийн үүднээс авч үзвэл эмэгтэй хүн түүн дотроо насанд хүрээгүй охидын бие махбод, оюун санааны хийгээд хүчирхийллээс ангид байх эрх, эрх чөлөөг хамгаалсан “Эс богтолсон охин хүний үсийг авч ичээн, эм хүний сэтгэл айлгасан эд хүн алсан хэвд оров”[15], “эм хүний үс гурван ест, эм хүний залаа гурван ест”[16], “эм татсан хүн гурван ест”[17] гэх зүйл заалтууд үйлчилж байжээ.

Эдгээр заалтын агуулгаас харахад насанд хүрээгүй охидыг айлгаж ичээсэн, сэтгэл санааг цочирдуулан айлгасан этгээдийг хүн алсантай адилтган үзэж ял шийтгэлийн хэв тогтоож байсан нь өмнөх хууль цаазаас онцлог бүхий байна.

Эдгээрээс авч үзвэл Арван найман цааз эрхэмийн бичиг нь хүүхдийг гэмт халдлагаас түүн дотроо бэлэгсийн гэмт хэргээс хамгаалах тодорхой хэм хэмжээг түүхэн тодорхой цаг хугацаанд тогтоон мөрдүүлж зөрчигсдөд оногдуулах хариуцлагын хэр хэмжээг тогтоож байсан байна.

Бидний явуулсан судалгаагаар Монгол-Ойрадын их цаазад насанд хүрээгүй этгээдээс үйлдсэн болон тэдний эсрэг үйлдсэн гэмт хэрэг, тэдгээрт оногдуулах ял шийтгэлийн асуудлыг зохицуулсан 10 гаруй хэм хэмжээ, түүнчлэн гэрлэлт, гэр бүлийн харилцааг хамгаалах, хүүхдийн боловсрол, хүмүүжлийн талаарх харилцааг зохицуулсан агуулга бүхий хэд хэдэн хэм хэмжээ тусгагдан хэрэгжиж байжээ. Тухайлбал, Их цаазын гучин наймдугаар зүйлд: “Арван дөрвөн наснаас дээш авах болов /эмэгтэйн гэрлэх нас 14-өөс дээш/ доошхийг дэмч шүүлэнгэд хэлээд байтугай /бүү гэрлүүл/. Энэ цаазаас хэн хүн давбал хүүхнийг нь малгүй /сүй бэлэггүй/ авч өгөх болов” гэж заасан бол дөчин зургаадугаар зүйлд: “...Гоёсон сүйт гэрийн /охиноо хүнд өгөхөөр сүй тавьсан айлын/ эцэг эх, охиноо зохицон гаргаж өгвөл /сүй тавьснаас өөр хүнд оргуулж өгвөл/ сайн хүнээс таван ес тэмээ тэргүүтэй, дундаас тэмээ тэргүүтэй гурван ес, адаг нь тэмээ тэргүүтэй ес, өгсөн малтай эмээ авах болов. Эцэг эх үгүй бол /эцэг эх оролцолгүйгээр охин өөрөө өөр хүнд оргож очсон бол/ гурван цаазын хэвээр болов. Эцэг эхийн ариуныг шахаж мэдье. Энэ цаазыг хүргэнээс авах болов. Өгсөнийг охины эцэг идтүгэй”[18] хэмээн хуульчилжээ. Түүнчлэн мөн цаазын далдугаар зүйлд: “Эм хүн эр хүнтэй сэтгэл нийлвэл, хоёул дуртай бол эмээс дөрөв, эрээс тав ав. Эм дургүй бол хүчээр гээд эрээс ес ав.

[14] “Хүрч” гэдэг нь дуулгаж, мэдэгдэж, сонсгож гэсэн утга агуулж байсан бололтой.
[15] Т.Алтангэрэл. XVI-XVII зууны Монгол цаазын бичгүүд. УБ., 1999. 85 дахь тал
[16] Мөн тэнд 86 дахь талд
[17] Мөн тэнд 88 дахь талд
[18] Мөн тэнд 58 дахь тал

Боол эмээс нэг морь ав. Дуртай бол ялгүй. Охин нь дургүй болвоос унтвал хоёр ес ав. Дуртай бол нэг ес ав...” хэмээн гэрлэлтээс гадуурх эр эмийн харилцааны талаархи харилцааг хориглож зөрчсөн тохиолдолд ял шийтгэл оногдуулахаар тогтоосон байсан бөгөөд уг зүйлийн үйлчлэл нь насанд хүрээгүй эмэгтэй хүний эрх ашгийг хамгаалсан шинжтэй болохыг “...Охин нь дургүй болвоос унтвал хоёр ес ав. Дуртай бол нэг ес ав хүн...” гэсэн хэсэг нотолж байна. Энэ зүйлийг эдүгээчлэн авч үзвэл Эрүүгийн хуулийн “Арван зургаан насанд хүрээгүй этгээдтэй хурьцал үйлдэх ” гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй төстэй зохицуулалт болох нь ажиглагдаж байна.

Их цаазын бичигт эмэгтэй хүний биеийн болон бэлгийн халдашгүй байдал, эрүүл мэндийн эсрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулах агуулга бүхий зохицуулалт мөн байсныг уг цаазын далан тавдугаар зүйл “Эм хүний үс, залаа таславал ес, ураг унагаавал, хэдэн сартай бол төдий ес ав. Хөх хатгах, үнэсэх, нууц орноос нэг инж ав. Арван наснаас дээш хүүхэн цаазтай, доош цаазгүй” гэсэн хэм хэмжээний агуулгаас харж болохоор байна.

Их цаазын дээрхи хэм хэмжээг урьд өмнөх Монгол хууль, цаазын зохицуулалттай харьцуулахад эцэг эх, ах захаа хүндэтгэх, худ ураг болох, гэрлэлт, гэр бүлийн хоорондын харилцаанаас үүдсэн зөрчлийг шийдвэрлэхэд чиглэсэн нилээд өвөрмөц заалтуудыг агуулсаны дээр насанд хүрээгүй этгээдийн эрх ашиг сонирхолыг хамгаалах талаар илүү нарийвчилсан зохицуулалт бүхий дэвшилтэт шинж чанартай хууль байжээ.

1709 оны **Халх Журам** хуульд өмнөх Монгол хууль цаазад тусгагдаж байсантай агуулгын хувьд ойролцоо эмэгтэйчүүд, охидын бэлгийн халдашгүй байдлын хамгаалсан шинж бүхий “Босуул хүн эм ба охиныг босгож хүчиндвээс (ичээвээс) мөнхүү босуул хүн алсан лугаа адил[19]” хэм хэмжээ болон эх нялхасын амь бие эрүүл мэндийг хамгаалсан агуулга бүхий “Эм хүнийг жанчиж (зодож) хүүхдээ унагааваас (хүүхдээ дутуу гаргаваас) хэдэн сартай бол төдий есөөр торгох[20]” гэсэн хэм хэмжээ уламжлагдан хуульчлагдаж үйлчилж байсан байна.

1789 онд батлагдсан “**Монгол цаазын бичиг”-**ийн хэд хэдэн зүйлд: хүүхэд, эх нялхсийн эрх ашиг сонирхолыг зохицуулсан заалт байжээ. Цаазын бичгийн 7 дугаар дэвтрийн 10 дугаар зүйлд зааснаар “...шалтгаантай эм ураг унагавал нэгэн ес торгож шийтгэх, гээгэ залаа тасалбал таван мал авах[21] - аар тус тус заасан нь эхийн бие махбодийн халдашгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ “хэвлийд буй хүүхдийг нэгэн амь” гэж үздэг монгол хийгээд дорны сэтгэлгээтэй шууд холбоотой зохицуулалт байсан гэж үзэж байна.

Орчин үед дэлхийн нийтийн өмнө тулгамдсан асуудал болоод байгаа хүүхэд, хүн худалдаалах үйлдлийг тухайн үед гэмт хэрэгт тооцож, ял оногдуулах заалт тус цаазад мөн тусгагдаж хэрэгжиж байжээ. Тухайлбал, Цаазын бичгийн 10 дугаар дэвтрийн 12 дугаар зүйлд: “Аливаа монголчууд дотроон аргадаж зүгээр хүнийг боол, шивэгчин эм, бага эм, хөвгүүн, ач

[19] Халх журам. Зуун арван тавдугаар зүйл. 30 дах тал

[20] Мөн тэнд

[21] Мөн тэнд

болгон худалдвал худалдсан ба эс худалдсаныг ялгалгүй зуу ташуурдаж, гурван есөөр торго. Аргадагдсан хүнийг зуу ташуурд" хэмээн заасан бол мөн дэвтрийн 13 дугаар зүйлд: "Гадаад монголчууд дотоод газрын эр, эм ба нуган охиныг аргадаж авч одоод худалдах эсхүл эм, бага эм, боол шивэгчин болговол зүгээр хүн боол, шивэгчин худалдсан ба эс худалдсаныг ялгалгүй ер аргадаж авч одоход аргадагдсан хүн учрыг үл мэдэх бол тэргүүлсэн хүнийг хөвчдөж алах ял торгож, гянданд хорьж хүлээ. Дэд хүнийг зуу ташуурдаж, гурван есөөр торго. Аргадагдсан хүнийг үл торгоно. Ганц нэг боловч мөн хөвчдөж алах ялаар торго. Хэрэв үгсэж аргадан боол, шивэгчин эм, бага эм, хөвгүүн ач болгон худалдахад аргадагдсан хүн учрыг мэдвэл худалдсан ба эс худалдсаныг ялгалгүй зуу ташуурдаж гурван есөөр торго. Аргадагдсан хүнийг зуу ташуурд"[22] хэмээн тус тус заасан бөгөөд үүнтэй адил зохицуулалт Гадаад Монголын хууль зүйлийн бичгийн 1185 дугаар зүйлд мөн байжээ. Үүнээс харвал хүн худалдах түүн дотроо эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалах гэмт хэргийн талаарх зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгаж нийгмийн байдлын ялгаа бүхий ханддаг байдалтай ямартай ч эрс ширүүн хатуу ялын бодлогоор тэмцэж байсныг харж болохоор байна.

Дүгнэн үзэхэд Монгол цаазын бичиг, Гадаад Монголын хууль зүйлийн бичиг зэрэг манжийн хууль цаазууд нь эзэнт гүрний дээрэнгүй, чанд хатуу дэглэмийг агуулсан хэдий ч Монгол хууль цаазын уламжлалыг зарим талаар тусгаж хүүхдийн эрх ашиг сонирхолыг хамгаалах талаарх тодорхой бодлогын илэрхийлэл болсон хууль зүйн баримт бичиг байжээ.

1926 оны Шүүх цаазын бичигт: Монгол Улсын анхны Эрүүгийн хууль нь «**Шүүх цаазны бичиг**» гэдэг нэртэйгээр ерөнхий ангийг нь Засгийн газрын 1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1-р хурлаар, тусгай ангийг нь 1926 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн улсын 3-р их хурлаар тус тус батлан гаргаж мөрдүүлж байжээ. Бүтцийн хувьд 31 бүлэг 227 зүйлтэй бөгөөд уг хуулийг доктор Г.Совд "эрүүгийн эрхийн эх сурвалжийн салбарт зонхилох байр эзлэх нэгдсэн хуультай болсон" хэмээн дүгнэсэн байдаг.

Уг цаазны бичгийн ерөнхий ангид гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдийн эрх зүйн байдлыг хөнгөтгөн үзсэн, түүнчлэн хүүхдийн эрх ашиг сонирхолын үүднээс эмэгтэйчүүдэд оногдуулсан ялыг хөнгөтгөн үзэх, эд хөрөнгө хураах ялыг оногдуулахдаа гэр бүлийн гишүүдийн байдлыг харгалзах зэрэг хэд хэдэн зохицуулалтыг хуульчилсан байна. Шүүх цаазны бичгийн тусгай ангид насанд хүрээгүй этгээд, хүүхдийн эрх ашиг, сонирхолын эсрэг гэмт халдлагыг гэмт хэрэгт тооцож ял шийтгэх талаар нилээд системтэйгээр хуульчлан тогтоосон Монголын эрүүгийн эрх зүйн түүхэнд анхны тохиолдол байлаа.

Шүүх цаазны бичгийн[23] агуулгад хийсэн бидний судалгаагаар уг цаазын бичигт хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол шууд объект нь байхаар 8 гэмт хэрэг хуульчлагдсан байна.

Шүүх цаазны бичгийн "Самуун садарт холбогдох гэмт хэрэг үйлдэх" нь

[22] Б.Баярсайхан. Монгол цаазын бичиг /харьцуулсан судалгаа/. УБ., 2001. 318 дахь тал

[23] Д.Адъяабазар. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил /1921 оноос хойш/.

хэмээх 29-р бүлэгт хуульчилж тусгаж өгснөөс дурьдвал:

197-р зүйлд: Аливаа хүн 15 наснаас дорогш насны охидтой явалдваас 6 сараас 2 жил хүртэл гяндан хорино.

198-р зүйлд: Аливаа хүн 16 наснаас дээш насны эмс охид лүгээ албадан хүчирхэн явалдваас 1-3 жил гяндан хорино.

199-р зүйлд: 199-р зүйл: Аливаа хүн энэхүү цааз бичгийн 197-р зүйлд дурьдсан насны охидтой хүчирхэн явалдваас 1-5 жил хүртэл гянданд хорино.

200-р зүйлд: Аливаа хүн өөр бусдын эм буюу охидыг ашгийг хичээж бусадтай явалдуулбаас 6 сараас 2 жил хүртэл гяндан хорих буюу 300 төгрөгөөс 1200 төгрөг хүртэл торговол зохино.

201-р зүйлд: Алив эмс охидыг явалдуулахаар гэр орон бэлтгэж ашгийг хичээгсдийг 1 жилээс 3 жил хүртэл гяндан хорихоос гадна хөрөнгө хогшлынх нь заримыг буюу бүрмөсөн албанд хураана.

202-р зүйлд: Алив хүн, өөрийн биеэс дээш, доош тус бүр 3 үеийн доторх төрөл ургийн хүмүүстай явалдваас 1-3 жил гяндан хорих буюу 600-1800 төгрөг хүртэл торговол зохино.

203-р зүйлд: Алив хүн эм хүний ухаан мэдрэл алдагдаж эсэргүүцэх чадалгүй цагт зоргоор явалдваас 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар гяндан хорих буюу 300-1200 төгрөг хүртэл торговол зохино,

204-р зүйлд: Хулгайлах, булаах, айлгах, мэхлэх зэргээр эр бололцсоныг 3 сараас 1 жил хүртэл гяндан хорих буюу 150-600 төгрөг хүртэл торговол зохино[24] хэмээн тус тус заасан нь ял шийтгэлийн хувьд нилээд хөнгөн байгаа юм.

Мөн бүлгийн 204-р зүйлд: “Хулгайлах, булаах, айлгах, мэхлэх зэргээр эр бололцсоныг (болцгоосныг) 3 сараас 1 жил хүртэл гяндан хорих буюу 150-600 тогрог хүртэл торговол зохино” хэмээсэн нь хэдийгээр хүчээр гэр бүл болохоос урьдчилсан сэргийлсэн шинжийг агуулсан боловч тухайн түүхэн цаг үеийн үндэстний зан заншил, онцлог зэргээс шалтгаалан насанд хүрээгүй эмэгтэйг богтлох байдлаар нөхөрт гаргах хуучны заншилтай тэмцэж байсан учраас уг зохицуулалтад насанд хүрсэн болон хүрээгүй эмэгтэйчүүдийн эрх ашиг сонирхолыг хамгаалах асуудлууд нэг адил хамаарч байсан гэж үзэж болох талтай.

1929 оны Эрүүгийн хууль: 1929 оны 9 дүгээр сарын 23-нд Улсын XIV бага хурлаас БНМАУ-ын Шүүх цаазны бичгийг шинэчлэн баталжээ. 1929 оны Шүүх цаазын бичиг нь анх батлагдахдаа 30 бүлэг 227 зүйлээс бүрдэж байсан бөгөөд дотоод зохион байгуулалт бүтцийн хувьд 1926 оны Шүүх цаазны бичгээс үндсэн өөрчлөлтгүй байсныг монголын эрүүгийн эрх зүй судлаач эрдэмтэд болох Г.Совд[25], Б.Содовсүрэн[26], С.Нарангэрэл,[27] С.Жанцан[28], Д.Адъяабазар[29] тэмдэглэсэн байдаг. Насанд хүрээгүй

[24] Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил УБ., 1998 он. 31 дэх тал.
[25] Г.Совд. Дурдсан бүтээл. 61 дэх тал
[26] БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ. 1971 он., 48 дахь тал
[27] С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. Сурах бичиг. УБ., 1999. 54 дэх тал
[28] С.Жанцан. Эрүүгийн эрх зүйн онол. I боть. УБ., 2009. 81 дэх тал
[29] Д.Адъяабазар.Дурдсан бүтээл. 35 дахь тал

этгээдтэй хүнтэй хурьцал үйлдэх, хүчиндэх гэмт хэргийн талаархи 1926 оны Шүүх цаазны бичгийн зохицуулалт зарим ялын төрөл хэмжээнд өөрчлөлт орсныг эс тооцвол хэвээр уламжлагдан хуульчлагдсан байна. Үүнээс дурьдвал:

201-р зүйлд: Аливаа хүмүүн бие, боловсроогүй охид лүгээ анхан явалдах буюу мөн насанд хүрээгүй эрэгтэйчүүд лугаа явалдагсдыг 6 сар хүртэл хорих буюу 300 төгрөг хүртэл торгомой.

202-р зүйлд: Хүчирхэн түрэмгийлэх ба айлган сүрдүүлэх хийгээд өөрийн биеийг хамгаалж үл чадахыг далимдуулан хуурч хүчирхэн явалдагчдыг нэгэн жи хүртэл хоримой.

203-р зүйлд: Аливаа хүмүүн өөр бусдыг ашгийг хичээж бусад лугаа явалдуулбаас нэгэн жил хүртэл хорих буюу 600 төгрөг хүртэл торговоос зохимой.

204-р зүйлд: Аливаа хүмүүсийг явалдуулахаар гэр орон бэлтгэж ашгийг хичээгсдийг нэгэн жил хүртэл хорихоос гадна хөрөнгө хогшлийг нь заримыг нь буу бүрмөсөн албан дор хураамой.

205-р зүйлд: Аливаа хүмүүн эм хүмүүнийг ухаан мэдрэл алдагдуулж эсэргүүцэх чадалгүй үгүй цаг дор зоригоор явалдваас 1 жил хорих хүртэл буюу 600 төгрөг хүртэл торговоос зохимой.

206-р зүйлд: Айлгах мэхлэх зэргээр эр эм бололцогсдыг 1 жил хүртэл хорих буюу 600 төгрөг хүртэл торговоос зохимой[30] гэсэн нь урьд мөрдөгдөж байсан 1926 оны шүүх цаазын бичгээс ялын бодлого хөнгөрсөн нь харагдаж байна.

1934 оны Шүүх цаазын бичигт: 1934 онд БНМАУ-ын Шүүх цаазны бичгийн ерөнхий ангийг 6 бүлэг 41 зүйлтэйгээр, тусгай ангийг 8 бүлэг 113 зүйлтэйгээр батлан гаргасан байна. 1929 оны Шүүх цаазны бичгийг өөрчлөх болсон тухайд "…элдэв гэмт хэргүүдийг бүлэг бүрийн зохих зүйлүүдэд хутгалдуулан бичсэн, хувьсгалд тэрсэлсэн гэмт хэргүүдийг хэдэн бүлэг болгон бичсэнээс гадна аж ахуй ба албан тушаал, ялангуяа хурьцлын гэмт хэргүүдийн ялыг хөнгөн заасан зэрэг дутагдлууд гарсан учир 1934 онд шинэчлэн зохиож өөрчилсөн байна…[31]" хэмээн тэмдэглэсэн байдаг.

Үүнээс дурьдвал:

131-р зүйлд: Алив хүн бие, бэлэг боловсроогүй эмэгтэйчүүд насанд хүрээгүй эрэгтэйчүүдтэй явалдсаныг заасан хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино,

132-р зүйлд: Алив нэг этгээдээс төрөлхийн ёс бусаар эр хүн эм хүнтэй харилцан явалдах буюу мал адгуусны зэрэг бусад төрлийн амьтан лугаа хурьцал үйлдвэл 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино,

133-р зүйлд: Бие махбодийг хүчирхэн барьж явалдах хийгээд биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан явалдах буюу түүнчлэн эд амьдрал, албаны хувиар эрхэнд буй ашиглан албадах замаар хүчирхэж явалдсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорьж ял шийтгэвэл зохино,

-Хэрэв хүчирхэн явалдах явдлыг хэдэн хүн хамтран үйлдсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

1942 оны Эрүүгийн хуульд: Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс

[30] Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил УБ., 1998 он. 64 дэх тал.

[31] Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхэн сэдвийн дэвтэр. УБ., 1936. 135 дахь тал

төрийн амьдралд гарсан өөрчлөлт шинэчлэлтэй холбоотойгоор 1940 онд БНМАУ-н Үндсэн хуулийг шинээр баталсан бөгөөд уг Үндсэн хуульд нийцүүлэн хууль тогтоомжийг шинэчлэх ажил явагдаж 1942 оны 1 дүгээр сарын 17-нд Улсын 25 дугаар бага хурлаа БНМАУ-ын Эрүүгийн хуулийг ерөнхий ангийг 54 зүйлтэйгээр, тусгай ангийн 10 бүлэг 165 зүйлтэйгээр батлан гаргажээ. Уг хуульд нийгмийн хөгжлийн шаардагаар хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орж байжээ. Хүүхдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахтай холбоотой өмнөх шүүх цаазны бичгүүдийн ерөнхий ангид заагаагүй дараах зохицуулалтыг шинээр хуульчилжээ.

Үүнээс дурьдвал:

162-р зүйлд: Төрсөн өдрөөс хойш 14 насанд хүрээгүй багачууд буюу мөн түүнчлэн 14 насанд хүрсэн боловч бэлгийн бойжилт олоогүй хүмүүстэй садар самууны явдлыг үйлдвэл 5 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

-Эдгээр явдлыг ёс бус маягийг хэрэглэж ямар нэгэн хурьцлыг үйлдсэн байвал 5 жилээс доошгүй хугацаагаар хорьж шийтгэнэ.

163-р зүйлд: Бага насны ба насанд хүрээгүй хүмүүсийг садар самуунд татаж завхруулах бол 5 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

164-р зүйлд: Хүчирхэн явалдах нь бие махбодыг хүчирхэн барьж явалдах буюу сүрдүүлэн айлгах, залилан мэхлэж явалдах хийгээд нөгөө этгээдийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан явалдах бол 8 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

-Хэрэв хүчирхэн явалдах явдлыг хэд хэдэн хүмүүсээс үйлдсэн буюу тийнхүү үйлдсэнээс нөгөө этгээд нь өөрийн амийг хорлосон буюу бие бэлэг боловсроогүй эмэгтэйчүүдийг ийнхүү хүчирхсэн байвал 5 жилээс доош хугацаагаар хорьж шийтгэх бөгөөд хэрэв хүндэтгэх шалтгаан байвал буудан алж хөрөнгийг хураавал зохино[32] хэмээн заасан нь өмнөх хууль тогтоомжид байсан насанд хүрээгүй буюу бэлгийн бойжил олоогүй хүмүүстэй бэлгийн харьцаанд орох, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бага насны хүүхэд, насанд хүрээгүй этгээдийг садар самуунд уруу татах, хүчиндэх гэмт хэргүүдэд оногдуулах ялыг чангатгаж хорих болон зарим тохиолдолд буудан алах ял хүртэл шийтгэхээр тусгасан байна.

1961 оны Эрүүгийн хуульд: 1942 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай болсон бөгөөд уг хуулиар гэмт хэрэгт тооцогдож байсан зарим нийгмийн үзэгдлийг нийгэмд аюултай шинжээ алдсан гэсэн үндэслэлээр Эрүүгийн хуулиас хас ч нийгэмд аюултай зарим нэг үзэгдлийг шинээр гэмт хэрэгт тооцож 1942 оны Эрүүгийн хуулийг хүчингүй болгож 1691 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн БНМАУ-ын Ардын их хурлын 2 дугаар чуулганаар шинэ Эрүүгийн хуулийг баталжээ.

Энэ хууль нь 2 анги 11 бүлэг 221 зүйл заалттай. 1961 оны Эрүүгийн хуульд бэлгэсийн гэмт хэргийг тусгайлан зааж гэмт хэргийг тус тусад нь нарийвчлан тусгаж өгсөн байна. Гэхдээ иргэдийн амь, эрүүл мэнд, эрх

[32] Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил УБ., 1998 он. 136 дахь тал.

чөлөө нэр алдарт холбогдох гэмт хэрэгт хамааруулан тусгаж өгсөн байна.

Үүнээс дурьдвал:

88-р зүйл. Хүчиндэх:

А. Хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, түүнчлэн нөгөө этгээдийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдвэл 2-6 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

Б. Хэрэв гэмт хэргийг хэд хэдэн хүн буюу хүчингийн хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд үйлдсэн, нөгөө этгээдэд хүн хор хохирол учруулсан, эсхүл насанд хүрээгүй хүнийг хүчирхийлж хурьцал үйлдвэл 5-12 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

В. Бага насны хүүхдийг хүчирхийлж хурьцал үйлдвэл 8-15 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ[33].

1987 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд: (1993 онд, нэмэлт, өөрчлөлт орсон) 1961 оны эрүүгийн хууль 25 жилийн турш үйлчилж нийгмийн амин чухал харилцааг гэмт халдлагаас хамгаалах зорилтыг хэрэгжүүлж байсан эрүүгийн хуулийн олон хэм хэмжээг өөрчилж боловсронгуй болгохыг нийгмийн зүгээс шаардсан тул БНМАУ-н ардын их хурлын тэргүүлэгчид 1986 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 213 дугаар зарлигаар эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргасан. Улмаар 1992 онд шинэ Үндсэн хуулийг батлан гаргаснаар эрүүгийн хуулийг түүнд нийцүүлэх зорилгоор 1993 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсан нь 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл үйлчилж нийгмийн амин чухал харилцааг гэмт халдлагаас хамгаалах зорилтыг хэрэгжүүлж байсан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн (2002) 126 дугаар зүйлд Хүчиндэх гэмт хэргийг дараах гурван зүйл ангиар тодорхойлсон байна[34]. Үүнд:

126.1. Хохирогчийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

126.2. Энэ гэмт хэргийг хохирогчийг тохуурхан даажигнасан, зовоон тарчлааж, хүнд буюу хүндэвтэр гэмтэл учруулж, давтан, насанд хүрээгүй хүнийг, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол 5-аас дээш жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

126.3. Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүн хор уршиг учирсан эсвэл бага насны өөрөөр хэлбэл, 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол 15-25 жил хүртэл хугацаагаар хорьж эсвэл цаазаар авах ял шийтгэнэ хэмээн заасан байна.

Эрх зүйн шинэтгэлийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд орчин цагийн шаардлага, нөхцөл байдалд уялдуулан шинжлэх ухааны ололт амжилтад тулгуурлан судалгааны шинжилгээний аргаар боловсруулан шинэ Эрүүгийн хуулийн төслийг Монгол Улсын хууль тогтоох байгууллага болох УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр ерөнхий ба тусгай анги, 30

[33] Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгий хууль тогтоомжийн хөгжил УБ., 1998 он. 177 дахь тал.

[34] Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 1993 он. 49 дэх тал.

бүлэг, 286 зүйлтэйгээр батлан гаргасан нь 2017 оны 07 дүгээр 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн (2015) 12 бүлгийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт Хүчиндэх гэмт хэргийг дараах зүйл ангиар тайлбарласан байна[35]. Үүнд:

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх

1. Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1 Арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;

2.2 Бүлэглэж;

2.3 Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;

2.4 Хохирогчийг жирэмсэн болгож;

2.5 Хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;

2.6 Хоёр, буюу түүнээс олон хүнийг хүчиндэж;

2.7 Урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

2.8 Харгис хэрцгий аргаар;

2.10 Хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

-Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.

-“Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно[36] хэмээн тус тус заасан нь тухайн гэмт хэрэг нь хүнд, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болж хуульчлагдсан байна.

Мөн 2015 оны Эрүүгийн хуульд бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцсон. Ингэснээр зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог олон улсын жишигт нийцүүлсэн[37] байна.

[35] Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016 он. №7

[36] Монгол Улсын Эрүүгий хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016 он. №7 38 дах тал.

[37] Хууль зүй, дотоод хэргийн яамнаас эрхлэн гаргасан “Сургагч багш нарт зориулсан гарын авлага” УБ., 2017 он. 114-117 дахь тал.

Дүгнэлт:

Дээрх судалгаанаас дүгнэхэд 1271 онд боловсруулж баталсан 88 бүлэг 2539 зүйл бүхий “Их Юань улсын бичиг” хуулинд “Бага насны хүүхдийг хүчирхийлбэл цаазаар авах ял онооно” заалттайгаар бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг, бэлгийн халдашгүй дархан байдлыг гэмт үйлдлээс хамгаалах эрүүгийн эрх зүйн суурь тавигдаж дараа дараачийн хаад, төр нийгмийн бүхий л цаг хугацаанд хадгалагдан уламжлагдаж ирсэн болох нь түүхэн эх сурвалжуудаар харагдаж байна. Мөн өнөөгийн үүднээс авч үзвэл эмэгтэй хүн түүн дотроо насанд хүрээгүй охидын бие махбод, оюун санааны хийгээд хүчирхийллээс ангид байх эрх, эрх чөлөөг хамгаалсан заалт нь XVI зууны II хагасаас XVII зууны эхний хагаст үйлчилж байсан “Халхын цааз эрхэмийн 18 хууль”-д “Эс богтолсон охин хүний үсийг авч ичээн, эм хүний сэтгэл айлгасан эд хүн алсан хэвд оров” хэмээн хуулийн хэм хэмжээ тогтоон хуульчилж өгсөн бага насны эмэгтэй хүний сэтгэл санаа болоод бие махбодид халдах элдэв гэмт хэргээс хамгаалах эрх зүйн орчин болж байсан гэж үзэж болохоор байна. Түүхийн олон жилийн цаг хугацаа, нийгмийн байдал, хүмүүсийн бололвсрол хийгээд, ахуй амьдрал нь өөрчлөгдөхийн хэрээр гэмт хэрэг нь хувьсаж зарим гэмт хэргийн нийгмийн хор аюул нь арилж, зарим гэмт хэрэгт тооцогддоггүй байсан үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжийг агуулж эхэлсэн учраас төрийн эрх баригчид Эрүүгийн хуулийг тухайн цаг үед нийцүүлэн хуульчилж ирсэн байдал нь тус хуулийн нийгмийн ххэрэгцээ шаардлагыг харуулж байна. 1926,1929,1934 оны Шүүх цаазны бичгүүд, 1942 оны Эрүүгийн хууль нь Монгол улс феодолизмаас социализмд шилжих, дорнын хэв шинж бүхий эрх зүйн тогтолцооноос үндэсний онцлогийг тусгасан өрнийн эрх зүйн тогтолцоонд шилжих түүхэн цаг үеийн тусгал орчин үеийн Эрүүгийн хуулийн бүтэц, агуулга, хууль зүйн техникийг ашигласан харьцангуй сайн боловруулагдсан нэгдмэл эрх зүйн актууд байжээ. Харин 42 оноос хойш буюу социализмийн үеийн гэмт хэрэгтэй тэмцэх, нэн ялангуяа насанд хүрээгүй хүн, хүүхдийн эсрэг гэмт халдлагаас урьчдилан сэргийлэх төрийн бодлого нь Эрүүгийн хууль байсан бөгөөд тэдгээрт ял шийтгэлийн бодлогоос гадна тухайн хуулийн ерөнхий, тусгай ангийн зарим хэм хэмжээнд гэр бүл, захиргааны эрх зүйн шинжтэй үүрэг болгосон хэм хэмжээг тусган хэрэгжүүлж байснаар илэрч байна. Ардчилал чөлөөт зэх зээл, хувь хүний эрх, ашиг, нэр алдар, халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөө зэрэг нөхцөл байдал хурцаар тавигдах болон 1990 оноос хойш буюу 1993, 2002, 2015 оны Монгол улсын Эрүүгийн хуулийн шинэчлэл, нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга зэрэг нь нэгдмэл байдлаар системчлэгдэж нэг бүлэгт тусгагддаггүй байсан шүүх цаазын бичиг, Эрүүгийн хуулиудын дутагдал, хийдлийг арилгаж боловсруулагдсаар ирсэн байдал нь тусгай ангийн ихэнх хэм хэмжээ нь насанд хүрээгүй хүн, тэдний хууль ёсны эрх ашиг сонирхлыг нийгмийн бусад гишүүд, харилцааны адил гэмт халдлагаас хамгаалахад чиглэгдсэн, насанд хүрээгүй хүн буюу хүүхдийг нийгмийн онцгой анхаарал халамж татсан гишүүнийхээ хувьд эдлэх ёстой хамгаалуулах, хүчирхийлэлээс ангид байх, хөгжих зэрэг олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичигт заасан эрхээ эдлэхэд нь төрийн хуулийн хамгаалалт тогтоох, хэн

нэгнээс тэдний энэхүү эрхэд халдсан тохиолдолд зөрчигдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэхийн тулд тусгайлан системчлэгдэж хуульчлагдаж байсан нь Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны томоохон ололт байсан гэж үзэж байна.

Санал:

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нь түүхийн ямар ч цаг үед гарч байсан бөгөөд тухайн гэмт хэргийг тухайн үеийн шүүх цаазын бичиг, эрүүгийн хууль зэргээр зохицуулж ирсэн нь хамгийн зөв бөгөөд оновчтой шийдвэр гэж үзэж болохоор байна. Харин тухайн хуулиудад болох “Их Юаны нэвтэрхий хууль”, “Их Юаны хууль цаазын бичиг”, “Халхын цааз эрхэмийн 18 хууль”, “Халх журам”, “Монгол цаазын бичиг”, “Шүүх цаазын бичиг” хохирогчийг айлган ичээж сэтгэл санааг зовоон хүчирхийлсэн, онгон цэвэр охиныг бузарлан хүчирхийлж сэтгэл санааг гутаасан бол цаазаар авах ял онооно эхсүл мөнга, эд материал, мал гэх мэт байдлаар торгууль ноогдуулахаар заасныг онцолж үзэхэд бага насны хүүхдийн сэтгэл зүй, түүний дотор хохирогчийн эдийн бус хохирол амссан тохиолдолд хэрхэн талаар тухайн цаг үед эрүүгийн хуульдаа зааж хамгаалсан байгаа нь ихээхэн сонирхол татаж байна. Харин манай Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хуульд хохирогч сэтгэл зүй, нэр алдар, эдийн бус хохирол амссан тохиолдолд хэрхэх талаар заагаагүй байдал яаж хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байдал нь хуульд хийсэн дүн шинжилгээгээр харагдаж байгаа тул хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд:

Хохирогч сэтгэл санаа, нэр алдар болон бусад эдийн бус хохирол амссан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тусгаж хуулийн хийдлийг арилгах нь хамгийн зөв зохицуулалт болно хэмээн үзэж санал дэвшүүлж байна.

Мөн дээрх цааз бичиг болон Эрүүгийх хуулиуд нь нийгминй цаг үеэ дагаад шинчлэгдэж байсан тул бага насч хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс интернэт орчинд бага насны хүүхдийг хууран мэхлэх, айлгаж дарамтлах, заналхийлэх аргаар түүний бэлгийн халдашгүй дархан байдал, хүсэл зоригийн эсрэг гэмт хэрэг үйлдсэнд тооцож хуульчилж өгөх нь энэ ач холбогдол чухал заалт болн гэж үзээд санал дэвшүүлж байна.

Ном зүй

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016. № 7

2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966

3. Эзэн богд Чингис хааны Их засаг хууль. УБ ., 2002

4. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992. № 1

5. Хүүхдийн эрхийн конвенци. Олон улсын гэрээ хэлэлцээрийн эхмтгэл. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2012.

Ном, сурах бичиг

6. Философийн толь. УБ., 1990. 303 дахь тал

7. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966. 750 дахь тал

8. С.Энхтуяа. Хүүхэд хамгааллын үндэс. Гарын авлага.

9. Хүүхэд хамгааллын асуудал ба хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь. Сургалтын гарын авлага.

НХХЯ, БСШУЯ, Нийгмийн ажлын багш сурагчдын холбоо, НҮБ-ын Хүүхдийн сан, ОУ-ын шилжин суурьшилийн байгууллага. УБ., 2009. 6 дахь тал

10. Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 244 дэх тал

11. Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980

12. Г.Сүхбаатар. Сянби. 1971

13. Ж.Болдбаатар, Л.Лүндээжанцан. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997

14. Ч.Далай. Монголын түүх. /1260-1388 он /. УБ., 1992

15.О. А. Омельченко. Римское право. Учебник. М., 2000

16. Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973. 198 дахь тал

17. С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. Сурах бичиг. УБ., 1999

18.С.Л.Феодоров. К вопросу о понятии охранительной функции права. //Вектор науки ТГУ. № 2(5). 2009

19.В.А.Рязановский. Чингис хааны Их засаг хууль. УБ., 2002

20. Халх журам.

21. Улаан хацарт.

22. Б.Баярсайхан. Монгол цаазын бичиг /харьцуулсан судалгаа/. УБ., 2001

23. С.Бадарчи. Эмэгтэйчүүд хүүхдээ хамгаалж ирсэн Монголын эртний хууль цаазын уламжлал

24.Д.Адъяабазар. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил /1921 оноос хойш/

25. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ. 1971

26. С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. Сурах бичиг. УБ., 1999

27. С.Жанцан. Эрүүгийн эрх зүйн онол. I боть. УБ., 2009. 81 дэх тал

28. Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхэн сэдвийн дэвтэр. УБ., 1936

29.Эмэгтэйчүүд хүүхдийг худалдах гэмт хэргийн байдал Монгол Улсад. УБ., 2002 он

30.Хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хохирогчтой харилцах цагдаагийн алба хаагчийн гарын авлага. УБ., 2008 он

31.С.Гантулга, Б.Энхболд Эрүүгийн эрх зүй Тусгай анги сурах бичиг. УБ., 2018 он

ХАР ТАМХИНЫ НИЙГМИЙН ХОР АЮУЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

SOCIAL DANGEROUS DRUGS CURRENT SITUATION

Ц.Энхманлай
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Ts.Enkhmanlai
University of internal Affairs Post-graduate student, Police major

Хураангуй: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис гэдэгт донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, Мансууруулах эмийн тухай 1961 оны НҮБ-ын конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай 1971 оны НҮБ-ын конвенцийн жагсаалтанд заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг хэлнэ.

Abstract: Narcotic drugs and psychotropic substances are addictive and other psychotropic substances listed in the 1961 United Nations Convention on Narcotic Drugs and the 1971 United Nations Convention on Psychotropic Substances. preparation.

Түлхүүр үг: Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, хор аюул, гэмт хэрэгтэй тэмцэх, конвенц.

Keywords: Convention on Narcotic Drugs, Psychotropic Substances, Harm, Crime.

Хар тамхины гэмт хэргийн тухай ойлголт, мөн чанар:

Манай улсын хувьд хар тамхины төрлийн ургамал “опиум, намуу цэцэг, зэрлэг олс г.м” ургадаг боловч нийгмийн хөгжлийн онцлог хийгээд ард түмний сэтгэхүйтэй холбоотойгоор тэдгээрийг хэрэглэж заншаагүй цөөн тооны улс орны нэг юм.[1]

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг нэр томьёоны хувьд авч үзвэл. Хууль зүйн талаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис гэдэгт донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, Мансууруулах эмийн тухай 1961 оны НҮБ-ын конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай 1971 оны НҮБ-ын конвенцийн жагсаалтанд заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг хэлнэ[2] гэж тодорхойлсон байдаг.

Зарим сурах бичгүүдэд мансууруулах бодис буюу хар тамхи гэдгийг төв мэдрэлийг тодорхой дарааллаар дарангуйлж нийтэд нь юмуу нэгээхэн хэсэгт нь мэдээ алдуулагч бодисууд гэж бүтцийнх нь талаас тодорхойлдог.

Хар тамхины гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал:

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт Монгол Улсын иргэд холбогдож буй нөхцөл байдал, шалтгаан:

Эхэн үедээ зөвхөн цөөн тооны иргэд хар тамхи, мансууруулах бодисыг хэрэглээний журмаар /хагас нийлэгжүүлэх аргаар гаргаж авсан мансууруулах бодис/ бага хэмжээгээр


[1] Д.Адьяабазар. Мафи /Гэмт байгууллага/.Уб., 1999 он. 84 дэх тал

[2] Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2002 он. №46

хууль бусаар нэвтрүүлэх байдлаар үйлдэгдэж байсан бол өнөөдөр уг гэмт хэрэг үйлдэгчид нь ашиг орлогын үндсэн эх үүсвэр бий болгох зорилгоор тээвэрлэж, зарж борлуулах гэмт хэргийг үйлдэх болсон.

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэрэг, сэжигтэнийг харуулбал:

График:1



Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой 939 гэмт хэрэгт 1173 этгээд холбогдон шалгагдсан байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг, холбогдогч 2017, 2018, 2019 онуудад тогтмол өссөн хэдий ч 2020, 2021 онуудад цар тахалын нөхцөл байдал, хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор буурсан үзүүлэлттэй байна[3].

Өнгөрсөн онд бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 8.3 хувиар, сэжигтэн 22.8 хувиар тус тус буурсан хэдий ч, эд мөрийн баримтаар хурааж авсан бодисын хүн/тун хэмжээ 26.8 хувиар өссөн нь хүн ам цөөн манай улсын хувьд яах аргагүй Үндэсний аюулгүй байдалд нэгэнт нөлөөлснийг илтгэж байна.

Дээрх тоо баримт нь хэдийгээр цөөн мэт харагдаж, сонсогдож буй ч манай улсын хүн амын тоотой харьцуульж үзвэл аюул нэгэнт буй болсныг тоо баримт нотлон харуулсаар байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, холбогдогч нарыг насны байдлаар ангилан харуулбал[4]:

График:2






[3] Police.gov.mn

[4] Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцах газар албан ёсны эх сурвалж. Уб., 2022 он.

“Цагаан тахал” хэмээх мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг Монголын залуу үеийг эзэмдэж байгаа баримтаас цухасхан дурдвал, сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн нийт 1173 сэжигтний 1069 буюу 91.1 хувийг эрэгтэй, 104 буюу 8.9 хувийг эмэгтэй, 35 хүртэлх насны хүүхэд, залуус нийт холбогдогчдын 92.2 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргүүдийг газар нутгийн харьяаллаар нь авч үзвэл:

График:3



Нийслэлд 80, орон нутагт 20 хувь нь бүртгэгдсэний 86.1 хувь нь дараах 4 аймагт бүртгэгдсэн ба Орхон аймагт 81, Дархан-Уул аймагт 36, Төв аймагт 35, Сэлэнгэ аймагт 22 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн бол нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 33.8 хувийг гадаад улсад лабораторийн болон гар аргаар боловсруулсан мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг эзэлжээ[5].

Мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгаагаар өсвөр насны 130 гаруй мянган хүүхэд ямар нэгэн байдлаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж үзсэн гэсэн судалгаа байгаа нь ирээдүйн улс орны хөгжилд ямар аюул занал учруулахыг төсөөлж болно. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлж байгаа залуусын насны ангиллыг харвал, өмнө нь жил тутамд 18-20 насны 20 гаруй хүн эмчлүүлдэг байсан бол сүүлийн жилүүдэд энэ тоо хэд дахин нэмэгдсэнийг дурьдаад байвал маш олон тоо баримт гарч байна. Эндээс харвал манай улс хар тамхитай өнгөрсөн хугацаанд хийсэн тэмцэл тэдийлөн үр дүнгүй болсноос гадна, хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагаа шаардлагын хэмжээнд хүрээгүйг нотлож байна.

Харин дэлхийн хэмжээнд хар тамхи хэрэглэж буй хүмүүстэй харьцуулан авч үзвэл. НҮБ-ын

[5] Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцах газар албан ёсны эх сурвалж. Уб., 2022 он.

мансууруулах бодистой тэмцэх албанаас гаргасан 2020 оны тайланд дурдсанаар дэлхийн хэмжээнд 15-64 насны 250 сая хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж байгаагаас 37 сая орчим нь тогтмол хэрэглэдэг. Үүнээс 200 орчим сая хүн каннабис, 15 орчим сая хүн амфетамин, 15,9 сая хүн опиум /героин/, 13,7 сая хүн кокаин хэрэглэдэг гэсэн судалгаа гарсан байна.[6] Үүнээс үзвэл дэлхийн улс орнууд болон манай оронд хар тамхи хэрэглэж байгаа хүмүүсийн насны хувьд авч үзвэл 18-35 насны залуучууд хар тамхи хэрэглэж байгаа харагдаж байна. Тиймээс мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бодисын хэрэглээ өсвөр үе, хүүхэд залуучуудын дунд өсөн нэмэгдэж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байгаа төдийгүй улмаар улс үндэстний аюулгүй байдалд үнэлж баршгүй хор уршиг учруулж болзошгүй болоод байна. Учир нь ажиллаж хөдөлмөрлөх насны залуучууд хар тамхинд донтосноор амь нас, эрүүл мэндээрээ хохирох цаашлаад нийгэм, эдийн засагт хүртэл хор уршиг учруулж болзошгүй юм.

Манай иргэд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож буй байдлыг авч үзэхэд дийлэнх хувь нь БНХАУ-д үйлдэгдэж байна. Хил залгаа ӨМӨЗО-ны Эрээн хотод дээрх төрлийн мансууруулах бодисын хэрэглээ газар авсан, манай иргэд байнга зорчдог, биеэ үнэлэгч, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэд энэ төрлийн гэмт хэрэгт хэрэглэгч гэсэн ангилалд байсан бол сүүлийн 2-3 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэргийн тээвэрлэгч гэсэн ангилалд хамаарах болоод байна. Энэ төрлийн хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн зүгээс манай иргэдийн Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих боломжтой байдал, гэнэн итгэмтгий зан, амар хялбар аргаар мөнгө олох зэрэг сул талуудыг нь ашиглан хууль бус эргэлтэнд татан оруулж байгаад анхаарах шаардлагатай юм.

Хүмүүс мансууруулах эм, бодисыг хууль бусаар хэрэглэх нь ихсэж, түүний нөлөөгөөр гэмт хэрэг, хараат байдал, хүчирхийлэл улам ихээр гарах болж түүний хор уршгаар жилд олон мянган хүн амь насаа алдаж байна.

Өнөөдөр мансууруулах эм, бодисыг буруу зорилгоор хэрэглэхийн эсрэг дэлхий нийтээр тэмцэж, их хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч хэрэглэгчдийн тоо буурахгүй, харин ч өсөх хандлагатай байна. Хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын эдийн засаг, хууль эрх зүй болон бусад сул талуудыг ашиглан зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэлүүд мансууруулах бодисын үйлдвэрлэлээ эдгээр улсууд руу шилжүүлж байна. НҮБ-ын судалгаагаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын үйлдвэрлэл сүүлийн 15 жилд 3 дахин нэмэгджээ.

Мөн түүнчлэн олон улсын баримт бичгүүдэд “наркотерроризм” гэсэн шинэ нэр томьёо бий болж, үндэстэн дамжсан энэ гэмт хэрэгтэй тэмцэх асуудал нэг улс орон, бүс нутгаар үл

6 https://www.grandnews.mn/content/read/52415.htm хандалт 2021.10.08

хязгаарлан даяаршлын үзэгдэл болон хувирч байна.

Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх асуудал:

Энэ төрлийн гэмт хэргийн онцлогоос шалтгаалж хойшлуулшгүй ажиллагааг шуурхай, үр дүнтэй хийж гүйцэтгэн хэрэгт ач холбогдолтой эд мөрийн баримтуудыг илрүүлэн бэхжүүлж авах нь хэргийн шийдвэрлэлтэд чухал нөлөө үзүүлдэг тул хойшлуулшгүй ажиллагааг явуулахдаа дараах зүйлсийг анхаарах шаардлагатай.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн тохиолдолд хүний биеийн онцлогоос шалтгаалж, анх удаа хэрэглэсэн хүнд 3 хоног, удаа дараа хэрэглэсэн хүнд 10 хоног, уг бодисуудад донтох буюу хамааралтай болсон хүнд 20 хоногийн дараа шээснээс илрэх боломжтой. Гэхдээ хүний биеийн онцлогоос хамааран хэт таргалалттай, бие эрхтэний өвчлөлтэй хүнд сар хүртэлх хугацааны дараа шээснээс илрэх тохиолдол байдаг. Иймд шээсэнд нь тест ашиглаж хэрэглэсэн хугацааг тогтоож байх,шаардлагатай тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.10 дугаар зүйлийн 1, 2[7] дахь хэсэгт зааснаар шинжилгээнд зориулж биологийн дээж авах.

Хар тамхи, мансууруулах бодис нь овор хэмжээ багатай бөгөөд орон байр, тээврийн хэрэгсэл, биедээ нуухдаа гар хүрэхгүй далд, хүний анзаарахгүй байж болох газар нуудаг тул үзлэг, нэгжлэг, хэргийн газрын үзлэг хийхэд албаны нохой оролцуулж нуугдмал бодисыг бүрэн илрүүлж байх.

Улсын хэмжээнд эд мөрийн баримтаар хураагдсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис :

График:4



Огноо	Каннабис /гр/	Гашиш /гр/	Мөс /гр/	Кокайн /гр/	Героин /гр/	Экстази /ширхэг/	LSD /ширхэг/	Сэтгэцэд нөлөөт эм /ширхэг/	Ми мм /гр/
2017	21,053.70	8.1	588.17	-	-	4	303	871	234
2018	30,831	415.1	562.5	0.2	-	67	125	556	7
2019	92,244	5798.9	903.76	-	3	116	17	642	759
2020	54,807.98	893.95	1,651.59	-	-	-	1	117	10,300
2021	81,387.2	237.3	1,514.8	-	-	-	80	26,139 DXM – 122.3 гр	-
Өсөлт, бууралт	+48.5%	-65.8%	-8.3%	-	-	-	+79 нэгж	223 дахин +DXM – 122.3 гр	-
Нийт	280,324	7,153	5,221	0	3	187	526	28,325 +DXM – 122.3 гр	11,300

2021 онд хураан авсан бодисыг өмнөх онтой харьцуулахад каннабис 48.5 хувиар, морфин 26039 ширхэг, DXM 122.3 граммаар тус тус өссөн бол метамфетамин 8.3 хувиар, гашиш 65.8 хувиар хувиар тус тус буурчээ.

[7] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2017 он.№23

Өнгөрсөн онд хураан авсан мансууруулах бодисыг хүний нэг удаагийн хэрэглээний дундажтай харьцуулбал 52300 хүн/тунг хураан авч хууль бус хэрэглээг таслан зогсоожээ[8].

Энэ төрлийн гэмт хэрэг нь эд мөрийн баримт буюу тухайн бодис, түүний хэрэглүүргүйгээр гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээ алддаг учир хойшлуулшгүй ажиллагааг шуурхай хийж гүйцэтгэн, хэрэгт ач холбогдолтой эд мөрийн баримтуудыг илрүүлэн бэхжүүлж авдаг болох шаардлагатай. Жишээ нь: Эвдэрхий асаагуур, хүнсний зориулалттай тугалган цаас, бонго, хуйлсан мөнгөн дэвсгэрт, гуурс, зип лок түгжээ бүхий уутнууд, жижиг гар жин хэргийн газраас ихэвчлэн илэрдэг. Энэ нь маш бага дөлөөр “ice” гэх бодисийг шатааж хэрэглэдэг тул асаагуурыг эвдэж галын дөлийг нь багасгадагтай холбоотой юм.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд шинжээчийн дүгнэлт гол нотлох баримт болно. Гэхдээ хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын бүхий л эх сурвалжийг мөрдөгч, прокурор сайтар шалгаж, үнэлэх ёстойг энд тэмдэглэх нь зүйтэй.

Харин гадаад орнуудын хувьд хэрхэн тэмцдэг талаар авч үзвэл:

Хятад улсын мансууруулах бодисын шинжилгээний төв олон газраас ирүүлсэн дээжнээс сэтгэцэд нөлөөлөх шинэ төрлийн 1529 ширхэг бодис илрүүлсэн. Гэмт этгээдүүд химийн бодисын бүтцийг өөрчлөх, тасралтгүй шинжлэх аргаар сэтгэцэд нөлөөлөх шинэ төрлийн бодис үйлдвэрлэсээр байна.

Өнгөрсөн онд Хятадын Мансууруулах бодистой тэмцэх хороо хиймэл дагуул, нисгэгчгүй онгоц ашиглан “Тянь Му-16” хэмээх хорыг устгах ажиллагаа явуулж, мансууруулах ургамал тариалсан 5578 гэмт хэргийг илрүүлж, 5345 сэжигтнийг баривчилж, намуу цэцгийн 84 га тариалангийн талбай, 1 сая 160 мянган үрслэг устгасан.[9] Монгол Улсын хувьд хиймэл дагуул, нисгэгчгүй онгоц ашиглан мансууруулах бодисыг хууль бусаар тариалж байгаа газруудыг илрүүлэхэд ашиглаж болохоор байна. Тиймээс гэмт хэрэгтэй тэмцэхэд техник технологийн ололтыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дөрөв.Хар тамхи, мансууруулах бодисын олон улсын нөхцөл байдал:

Дэлхийд хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн сүлжээ үүсгэн идэвхтэй ажиллаж байгаа Алтан гурвалжин /Тайланд, Лаос, Мьянмарын хилийн бүс/, Алтан хавирган сар /Афганистан, Пакистан, Ираны хилийн бүс/, Мөнгөн гурвалжин /Колумб, Болив, Перу, Мексикийн хилийн бүс нутаг/, Хар гурвалжин /Нигер, Гана, Кени, Судан, Өмнөд африк/ гэгдэх Африкийн орнуудын гэмт бүлэглэлүүд Төв болон Зүүн өмнөд Азийн орнуудын иргэдийг хар тамхины хууль бус наймаанд элсүүлэх, татан оролцуулах, тээвэрлүүлэх явдал газар авч байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт гол төлөв Зүүн өмнөд Азийн орнуудад сурч буй манай оюутан залуус, биеэ

[8] Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцах газар албан ёсны эх сурвалж. Уб., 2022 он.

[9] UNODC, Responses to Annual Report Questionnaire and Individual Drug Seizure Database.

үнэлэгчид, хулгай хийх зорилгоор маршрутаар зорчигч иргэд тээвэрлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт монгол залуучууд өртөж байгаа шалтгаан нь манай иргэдийн амьжиргааны түвшин доогуур, энэ талын мэдлэг, мэдээлэл дутмаг, амар хялбар аргаар мөнгө олох хүсэлтэйгээс гадна Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих давуу тал байдаг нь гол хүчин зүйл болж байна.

Цаашид авах арга хэмжээ, анхаарах зүйл:

1.Хүн бүр энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг, учирч болох эрсдэлийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй болох нь чухал байна. Тухайлбал:

•Монгол Улсын эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэсэн зүйл заалтын дагуу энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд 12 жил хүртэл хорих ялаар шийтгэх,

•БНХАУ-д 50 граммаас дээш хэмжээгээр хар тамхи, мансууруулах бодисыг тус улсын хилээр ашиг олох зорилгоор нэвтрүүлсэн бол цаазаар авах хүртэл ял оногдуулдаг,

•ОХУ-д энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд 20 хүртэлх жилийн хорих ял оноож, 1 сая рублиэр торгодог байна.

2.Дунд, ахлах, их дээд сургуулийн оюутан сурагч нарт хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийн талаарх ойлголтыг сурган хүмүүжүүлэгч, эцэг, эхчүүд болон асран харгалзагч нараас өгөх нь манай улсын ирээдүйн эрүүл нийгмийн баталгаа болно.

3.Энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг, ялангуяа Зүүн өмнөд Азийн зарим улс орон руу зорчиж буй манай иргэд бусдын дайвар ачаа тээш авахгүй, өөрийн ачаа тээшийг хяналтгүй орхихгүй, мөн сонор сэрэмжтэй байх нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх юм.

Дүгнэлт: Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийн тулд холбогдох албадаас мэргэжлийн ур чадвар, байгууллага хоорондын төдийгүй бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх шаардлага тулгамдаж байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ухуулга сурталчилгаа явуулах, тодорхой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Жишээ нь, БНХАУ өсвөр насны хүүхэд залуусыг мансууруулах бодис хэрэглэх явдлаас урьдчилан сэргийлэх “6.27” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2020 онд мансууруулах бодис хэрэглэгчдийн дотор 35-аас доош насны залуусын эзлэх хувь 2.6 хувиар буурчээ. Мөн 2020 оны сүүлээр Хятад, Лаос, Бирм, Тайланд, Камбож, Вьетнам улсууд “Аюулгүй гарц” томъёолсон нэртэй хамтарсан ажиллагаа явуулснаар энэ төрлийн 6476 гэмт хэргийг илрүүлж, 9927 сэжигтэнг баривчлан, 12.7 тонн мансууруулах бодис хураан авсан бөгөөд манай улсад энэ төрлийн ажиллагаа явуулах хэрэгтэй байна.

Цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд хэрхэн үр дүнтэй тэмцэх, гадаад улс дахь ДТГ-аас энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон өөрийн иргэдэд эрх зүйн туслалцаа хэрхэн үзүүлэх

талаар гарын авлага бэлтгэж түгээх нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн далд аргаар, зохион байгуулалттай үйлдэгддэг бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ил мөрдөн шалгах ажиллагаагаар илрүүлэх боломжгүй, харин мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд илрэх боломжтой тохиолдол практикт нэлээд гарч байна. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээдүүд дахин мөн төрлийн гэмт хэрэг үйлдэх, ингэхдээ илүү зохион байгуулалтай, нуугдмал шинжтэй болж байна.

Тухайлбал: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг Монгол улсаас захиалагч этгээдийн хүсэлтийн дагуу нийлүүлэгч этгээд Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас карго, ачаа, тээш, дайвар зэрэг бусад байдлаар, мөн гүйцэтгэгч этгээдээр Монгол улсын хилээр нэвтрүүлж захиалагч, зохион байгуулагч нар Монгол улсад хүлээн авдаг. Захиалагчаас борлуулагч этгээдэд шилжин зуучлагчаар дамжуулан хэрэглэгч этгээдүүдэд хүргэхдээ төлбөр тооцоог урьдчилан болон дараа төлбөрт байдлаар, бэлэн болон бэлэн бусаар, мөн дансаар болон данс хоорондын гүйлгээгээр авч бодисыг гараас гарт, хүнээс хүнд дамжуулахгүйгээр нууц далд хэлбэрээр хүргэж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэн, таслан зогсооход хуудь сахиулах байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас мэргэжлийн ур чадвар шаардаж байна.

Дэвшүүлсэн санал:

1.Цагдаагийн Ерөнхий газраас гэмт хэрэг үйлдсэн этгээд, хохирогч, гэрч зэрэг тухайн гэмт хэрэгт холбогдол бүхий хүмүүс болон хэргийн газраас олдсон, эд мөрийн баримтаар хураагдсан, нууц үзлэгээр илэрсэн гэх мэт баримт мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийхэд чиглэгдсэн аргачлалыг шинээр нэвтрүүлэх. Учир нь Цагдаагийн Албаны тухай хуулийн 14-р зүйл “Цагдаагийн төв байгууллагын үүрэг”-ийн 14.2.2 дахь хэсэгт “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах аргачлал, бодлого боловсруулж хэрэгжүүлэх”... үүрэгтэй хэмээн заасан байдаг. Тиймээс энэхүү үүрэг ээ хэрэгжүүлж нэгдсэн аргачлалтай болох шаардлагатай байна. Гэрч, хохирогчийн мэдүүлэг, үзлэгийн тэмдэглэл, дүрс, дууны бичлэг зэрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан эд мөрийн баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр тухайн хэргийг үйлдсэн хүний талаарх төсөөллийг бий болгож, энэ талаарх мэдээллийг алба хаагчид харилцан солилцох зарчмаар явагддаг. Сэжигтний талаарх тодорхойлолтонд дараах зүйлсийг тусгах

- Сэтгэл зүйн байдал, нас, хүйс,
- Зан байдал, оршин суугаа газар орны болон гэмт хэргийг үйлдэхдээ урьдчилан бэлтгэсэн эсэх зэрэг нөхцөл байдлуудыг тусгах хэрэгтэй. Энэхүү аргачлалыг манай улсын цагдаагийн мөрдөн шалгах ажиллагааны практикт нэвтрүүлснээр бүлэг, олон үйлдэлтэй хэргүүдийг үйлдлийн арга, бусад мэдээллээр илрүүлэх ажилд ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

2.Хар тамхины гэмт хэргийг сүлжээгээр нь илрүүлэхийн тулд шалгалтын худалдан авалт, хяналттай хүргэлт зэрэг мөрдөн шалгах бусад

/нууц/ ажиллагаануудыг идэвхитэй явуулах.

3.Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг боловсруулан, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, нэгтгэн зохион байгуулах, хяналт тавьж, үнэлгээ хийдэг бие даасан бүтцийн байгууллагыг Улсын Их Хурал, Засгийн газрын дэргэд байгуулан ажиллуулах нь энэ төрлийн гэмт хэрэгтэй амжилттай тэмцэх гол хүчин зүйл болно гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай. Уб. 2002,

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017,

3. Ж.Болдбаатар "Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологи шинж " УБ, 2000,

4. Д.Адьяабазар "Мафи /Гэмт байгууллага/" УБ, 1999,

5. Цагдаагийн Ерөнхий газрын албан ёсны эх сурвалж. 2022,

6. https://www.grandnews.mn/content/read/52415.htm

7. UNODC, Responses to Annual Report Questionnaire and Individual Drug Seizure Database.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНД МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

MONEY LAUNDERING AND SOME ISSUES TO CONSIDER WHEN INVESTIGATING IT

Ж.Батсайхан
Дотоод хэргийн их сургуулийн эдийн засгийн аюулгүй байдлын магистрант

Хураангуй: Мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гэмт хэргийн улмаас олж авсан хөрөнгө, орлогыг хураан авах, битүүмжлэх, хохирол барагдуулах ажлыг олон улсын хэмжээнд явуулах асуудлыг дэвшүүлсэн болно.

Abstract: It is proposed to improve the legal environment for investigating money laundering, and to conduct international seizure and seizure of assets or proceeds of crime.

Түлхүүр үгс: Мөнгө угаах, Авлигатай тэмцэх, (Financial Action Task Force буюу ФАТФ), Угаахын Эсрэг Олон Улсын Ажлын Хэсэг (GTF-AML).

Key words: Money laundering, Fight against corruption, (Financial Action Task Force буюу ФАТФ), International Working Group Anti-Money Laundering (GTF-AML).

Оршил

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ) нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, дэлхийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм. ФАТФ-ын зөвлөмж нь дэлхий нийтийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрөгддөг. ФАТФ нь Их долоогийн уулзалтаар 1989 онд байгуулагдсан бөгөөд өнөөдрийн байдлаар 37 гишүүн улс, 3 ажиглагч улс, 9 бүс нутгийн холбоо байгууллага, 23 ажиглагч олон улсын байгууллагаас бүрддэг ба бүс нутгийн байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна.

1997 онд байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн байгууллага (The Asia/Pacific Group on Money Laundering буюу АНДББ) нь ФАТФ-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагааг зохицуулах байгууллага билээ.

Монгол Улс 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”-д[1] нэгдэн орж, 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог Олон улсын санхүүгийн арга хэмжээ авах бүлэг /Financial Action Task Force буюу ФАТФ/-ийн салбар байгууллага болох Ази Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага /APG/-д элсэн орсон.

[1] АТГ. Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2016

Улмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартуудыг мөрдөн ажиллах үүрэг хүлээж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулах холбогдох үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актууд, олон улсын гэрээ, конвенц, стандартуудад нийцүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж эхэлсэн.

ФАТФ-аас гишүүн орнуудын хийж хэрэгжүүлж байгаа ажлын хүрээнд манай улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог хянахаар болж, үүний дагуу 2007 оны 07 дугаар сард Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүс нутаг хариуцсан Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгээс шалгаж үнэлэн “Харилцан үнэлгээний тайлан” гаргасан юм.

Дээрх харилцан үнэлгээгээр Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлж байгаа улс орон гэж үзэн 2 үе шаттай нарийвчилсан хяналт шалгалтад оруулсан бөгөөд ФАТФ-ын зөвлөмжийг бүрэн гүйцэд хэрэгжүүлж амжаагүй, стратегийн томоохон дутагдлууд байгааг онцолсон байна. Тухайлбал: мөнгө угаах гэмт хэргээр хөрөнгө хураасан, битүүмжилсэн, улс орнуудад харилцан туслалцаа үзүүлсэн тохиолдол байхгүй, мөнгө угаах хэргээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж, шүүхээр эцэслэн шийдвэрлээгүй, гэм буруутай нь тогтоогдож ял авсан нэг ч тохиолдол байхгүй зэрэг дутагдлуудыг дурдаж, манай улсын энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо дутагдалтай байгааг илэрхийлж байна гэж үзсэн байна. Мөн хар тамхи, хүний наймаа, авлига, хээл хахууль гэх мэт хууль бус орлого олдог гэмт хэргийн тоо, хэмжээгээр бусад орнуудтай харьцуулахад өндөр эрсдэлтэй орнуудын тоонд багтаж байна гэж ФАТФ үзэж[2] “өндөр эрсдэлтэй болон хамтран ажилладаггүй улс” гэсэн ангилал буюу “хар саарал жагсаалтад” оруулж байсан байна.

Манай улс ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тодорхой ажлуудыг хийж, хууль эрх зүйн орчноо шинэчилж байгаа боловч өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх өнөөгийн нөхцөл байдал нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн нэг зорилт бүхий бүтэц байгуулаагүй, мөрдөгч, прокурор, шүүгч тус бүр өөр өөрийн дотоод итгэлийн хүрээнд дээрх гэмт хэргийг ойлгож, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг, хянадаг, шүүхийн системд шийдвэрлэгдэж буй хэргийн практик дутмаг, мөрдөгч, прокурор, өмгөөлөгч нь энэ төрлийн гэмт хэргээр дагнан мэргэшсэн байдал байхгүй байгаа учраас мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах ажлын үр нөлөөг сайжруулж, олон улсын эрх зүйн харилцан туслалцааны нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, улс орнуудтай харилцах хамтын ажиллагааг сайжруулах, техник технологийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан боловсронгуй болгох, хууль сахиулах

[2] АТГ. “Мөнгө угаах гэмт хэрэг” гарын авлага. УБ., 2020 он 10 дахь тал

байгууллагын албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлж мэргэшүүлэх, шүүхийн шатанд энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх дагнасан боловсон хүчнийг /шүүгч/ бэлтгэх зэрэг зайлшгүй шинэчлэл, өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д3 “мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг” хэлнэ гэж томьёолсон байдаг. Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг юм.

Гэмт хэрэгтнүүд их хэмжээний бэлэн мөнгийг дараах хууль бус үйл ажиллагаанаас олдог бөгөөд тэр нь мөнгө угаах гэмт хэргийн үндэс болдог. Үүнд:

- Хууль бус галт зэвсгийн наймаа
- Хүний, эд эрхтний наймаа
- Хар тамхины худалдаа
- Бусдын биеийг үнэлүүлэх
- Мөнгөн тэмдэгт хуурамчаар боловсруулах
- Авлига, хээл хахууль
- Татвараас зайлсхийх
- Байгаль орчны эсрэг, гэмт хэрэг
- Хулгай, дээрэм
- Цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр, далд веб дэх хууль бус үйл ажиллагааны төлбөр болгож биткойн, этериум зэрэг криптовалютаар олсон орлого гэх мэт

Иймд гэмт хэрэгтнүүд хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоо мэдээлэх үүрэгтэй этгээд эсвэл, хууль хяналтын байгууллагын анхаарлыг татахгүй, тэдний харанд өртөлгүйгээр зарцуулах боломжтой болохын тулд санхүүгийн системд нэвтрүүлж, жинхэнэ эх үүсвэрийг нь нуун дарагдуулж, төөрөгдүүлэх замаар хууль ёсны орлого мэт харагдуулахыг зорьдог.

Мөнгө угаах нь гэмт хэрэгтнүүдийн хувьд хууль бус орлогын эх үүсвэрээ аливаа эрсдэлд оруулалгүйгээр түүнээс олсон ашиг, орлогоо тааваараа ашиглахад туслах, санхүүгийн аюулгүй байдлаа хамгаалахад чиглэгдсэн маш чухал үйл явц юм. Мөнгө угаах гэмт хэрэг нь байршуулах, тараах буюу гүйлгээнд оруулах, буцааж төвлөрүүлэх гэсэн 3 үе шаттайгаар хийгддэг. Эхний үе шат буюу байршуулах үе шатанд хууль бусаар олсон мөнгөө хаа нэгтээ байршуулах шаардлагатай байдаг. Тухайлбал, гэмт этгээд өөр хүний нэр дээр банканд нээлгэсэн дансанд хууль бусаар олсон мөнгөө анхаарал татахааргүй хэмжээтэйгээр таслан хийх, үнэт цаас, чек, хувьцаа худалдан авах, эсхүл байр, байшин ч худалдан авах замаар байршуулж болно.

[3] https://legalinfo.mn/mn/detail?lawId=9242. Хандалт 2022.03.28

Хоёр дахь үе шатанд гарал үүслийг нь нуун далдлах, хууль ёсны орлого мэт харагдуулах зорилготойгоор нэгэнт байршуулсан мөнгөө эргэлтэд оруулдаг. Жишээлбэл, худалдан авсан үнэт цаас, аяллын чекээ эргүүлэн зарах эсвэл гадаад худалдаа эрхэлж буй мэт харагдуулах зорилгоор мөнгө угаахтай тэмцэх хяналтын механизм бүрдүүлээгүй орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэдэг.

Үүний дараа гурав дахь үе шат нь нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны юм шиг харагдах болсон мөнгөө эргүүлэн өөрийн нэр дээр төвлөрүүлдэг ажээ.

Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбодог. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор хууль бус үйл ажиллагаанд зарцуулахыг зорьдог.

Мөнгө угаах нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай. Хууль бус мөнгө гаднаас орж ирсэн бол зорилгодоо хүрээд гэнэт орж ирсэн шигээ гэнэт буцаад гарна. Их хэмжээний мөнгө гэнэтийн шилжилт нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй хямралд ч хүргэж болох юм. Үүний зэрэгцээ олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээг гаднын орнууд авч болох юм.

Хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авлигыг гааруулах, шударга өрсөлдөөнийг хавчих, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монополь байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо дутуу хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах эрсдэл өндөр юм. Манай улс шиг жижиг эдийн засагтай улс оронд хөрөнгө оруулалт, мөнгөний хэрэгцээ их байгаа нь ойлгомжтой. Тэр ч хэмжээгээр банкнуудад хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалтыг дэмжих сонирхол их байгаагийн зэрэгцээ банкаар дамжиж байгаа орлого, хөрөнгийн цаад эх үүсвэр, бизнесийн мөн чанарын талаар сонирхох, судлах хэрэгцээ байхгүй мэт ойлгосоор ирсэн билээ.

Гэтэл энэ байдал нь эргээд санхүүгийн системийн найдвартай, тогтвортой байдалд заналхийлж болзошгүй байна. Монгол Улсад 2006 оны 7 дугаар сард “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль батлагдаж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны үндэс суурь тавигдсан. Энэ хуулийн дагуу 2006 оны 11 дүгээр сарын 29-нд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба (СМА) Монгол банкны харьяанд үйл ажиллагаа явуулж байна4.

Дэлхийн улс орнууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар санхүүгийн үйл ажиллагааны чиг үүрэг (FATF),

[4] Санхүүгийн мэдээллийн алба. “ФАТФ-н хяналт шалгалт”. 2017 он

Дэлхийн банк, Олон улсын валютын сан (ОУВС), НҮБ-ын газар зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг. Хар тамхи, гэмт хэргийн талаар (UNODC), Интерпол, Эгмонт групп, Транспэрэнси Интернэшнл. GTF-AML нь мөнгө угаах, ялангуяа авлигын мөнгө угаахтай тэмцэх нэмэлт аргыг боловсруулж, ийм үйл ажиллагааг хязгаарлах, баривчлах практик арга хэрэгсэл, арга техникийг ашиглахыг сурталчилсан бөгөөд Мөнгө Угаахын Эсрэг Олон Улсын Ажлын Хэсэг (GTF-AML)-ээс дараах шийдвэрийг гарган ажиллаж байна[5]. Үүнд:

- Анхаарал татаж буй орнуудын дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлэх, мөн тухайн орны парламентчдийг мөнгө угаахын эсрэг хууль журмыг бэхжүүлэхэд мэдээлэл, арга хэрэгсэл болон удирдамжаар хангах;
- Авлигын замаар хулгайлагдсан өмч хөрөнгийг буцаан авах парламентчдийг хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх үүднээс дотоодын хууль тогтоомж боловсруулах болон санаачилгуудад тусгах боломжийг олгох тухайн салбарынхны дэмжлэг, зөвлөгөө, удирдамж, техникийн мэдээлэл авах боломж болон сайн туршлагуудаар хангах;
- Латин Америк болон Арабын бүс нутгийн орнуудын парламентчдад Авлигын Эсрэг Парламентчдийн Дэлхийн Байгууллагын Мөнгө угаахын эсрэг Үйл ажиллагааны удирдамжаар үргэлжлүүлэн хангах, ингэхдээ Мөнгө угаахын эсрэг болон хулгайлагдсан хөрөнгийг буцаахтай холбоотой үндэсний хууль тогтоомжийг чангатгахад парламентчдийн чадамжийг нэмэгдүүлэхийн тулд үндэсний болон бүс нутгийн чанартай хурал, семинар зохион байгуулах замаар хэрэгжүүлэх;
- Бүх санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн зуучлагч нар нь хүлээн авагчаас тэдгээрийн хадгаламж болон санхүүгийн гүйлгээний талаарх мэдээллийг хуулийн дагуу мэдэгдэх, эс бөгөөс шийтгэл оногдуулах шаардлага тавих явдлыг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсад Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай анхны хууль 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан. Тус хуулийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Мөн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын стандартын дагуу “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг 2002 онд, 2013 онд, Авлигын эсрэг хуулийг 2006 онд тус тус баталж, мөрдөж байна. Үүнээс гадна, Эрүүгийн хуульд “мөнгө угаах”, “мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах”, “хээл хахууль авах”, “хээл хахууль өгөх”, “хээл хахууль зуучлах”, “хууль бусаар хөрөнгөжих” гэмт хэргийг тус тус хуульчилсан[6].

Мөнгө угаах гэмт хэргийн хувьд Монгол Улсад харьцангуй шинэ төрлийн гэмт хэрэг юм. Тодруулбал,

[5] Олон улсын мөнгө угаах мэдээллийн товчооны сайт. http://www.imlib.org/page14_conclusions.html. Хандалт 2022.03.28

[6] Монгол Улсын Эрүүгийн хууль. 2008. УБ., https://old.legalinfo.mn/law/details/

[7] Монгол Улсын Эрүүгийн хууль 2015. УБ, https://old.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634

- 2006.07.08-ны өдөр, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль” батлагдаж,
- 2008.02.01-ний өдрийн баталсан Эрүүгийн хуульд 268[1] дугаар зүйл буюу “Мөнгө угаах” гэмт хэрэг болон, 178[2] дугаар зүйл буюу “Терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэргийн зохицуулалтыг нэмсэн.
- 2009.12.24-ний өдрийн баталсан Эрүүгийн хуулийн 268[1] дугаар зүйл буюу “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтыг хүчингүй болгож, Эрүүгийн хуулийн 166[1] дугаар зүйлд “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтыг шинээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- 2014.01.16-ны өдрийн хуулиар, Эрүүгийн хуульд 166[1] дугаар зүйл буюу “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтыг өөрчлөн найруулсан.
- 2015.12.03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 18.6 дугаар зүйлд “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтыг тусгасан[7].
- 2017.05.11-ний өдрийн хуулиар,Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийн холбогдох хэсэг, заалтад өөрчлөлтийг тус тус оруулж хуульчилсан байна.

“Мөнгө угаах” гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуульд дараах байдлаар хуульчилжээ. Үүнд:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6 /Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт,

6.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6 /Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт Авлигатай тэмцэх газар,

6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна” гэж заажээ. Энэ заалт нь Тагнуулын байгууллагын өөрсдөө илрүүлээгүй, Авлигатай тэмцэх байгууллагын авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлээгүй “Мөнгө угаах” гэмт хэргийг Цагдаагийн байгууллага шалгахаар тусгасан заалт юм.

Мөн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно” гэж заасан[7].

Монгол Улсын ерөнхий прокурорын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/67 дугаартай “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг хянан шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” тушаалын 2-д “Энэ тушаалын хавсралтад заагдсан байгууллагуудын шалгах нууцын зэрэглэлд хамаарах эрүүгийн хэрэгт Нийслэлийн прокурорын газраас хяналт тавихаар тогтоосугай” гэж,

Мөн тушаалын 1 дэх хэсэгт Авлигатай тэмцэх газрын шалгах

[7] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017. УБ., https://old.legalinfo.mn/law/details/

Цагдаагийн байгууллагын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргээс бусад хэрэгт Нийслэлийн прокурорын газар,

2 дахь хэсэгт Тагнуулын ерөнхий газрын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан хэрэгт Нийслэлийн прокурорын газар, тухайн нутаг дэвсгэрийн прокурорын газар,

3 дахь хэсэгт Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албанаас шалгаж буй 3.9 /Шүүгч, прокурор, Авлигатай тэмцэх газрын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэгт Нийслэлийн прокурорын газар,

4 дэх хэсэгт Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанаас шалгаж буй 4.7 “Мөнгө угаах” /Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл/ гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэгт Нийслэлийн прокурорын газар хяналт тавихаар шийдвэрлэсэн байна.

Үүнээс дүгнэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/ заасан гэмт хэрэгт Тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллага мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэрэгт тавих хяналтыг Нийслэлийн прокурорын газар, тухайн орон нутгийн прокурорын газар хяналт тавихаар, хэргийг шийдвэрлэх шүүхийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх шийдвэрлэхээр тусгасан байна.

Мөн Монгол банкны ерөнхийлөгчийн А/116 дугаарын тушаалын 1 дүгээр хавсралтын 2-д “Хамтын ажиллагааны зөвлөлийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтад “Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүйн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Санхүү мэдээллийн алба, Авлигатай тэмцэх газрын төлөөлөл оролцохоор тусгасан байна.

Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, түүнд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд /Мөнгө угаах/ заасан гэмт хэргийн шинжийг зайлшгүй тогтоож шалгах шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих зүйлийг бүрэн дүүрэн тогтоож улмаар мөнгө угаах гэмт хэргийн үндсэн шинж болох суурь гэмт хэргийг нотолсон байх шаардлагатай. Мөнгө угаах гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргүүдээс онцлох зүйл нь нууц далд аргаар үйлдэгддэг бөгөөд үүний сацуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага, алба хаагчаас их хэмжээний мэдлэг, мэдээлэл, цаг хугацааг шаарддаг юм.

Авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэн мөрдөн шалгах ажиллаа явуулахад мэдээ, мэдээллийн эх сурвалжийг олж тогтоох,түүнд дүн шинжилгээ хийх, мөрдөн шалгах ажиллагааны хүрээг тогтоох, гэмт хэрэгт холбогдсон хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой шаардлагатай бүх мэдээлэл болон хөрөнгийг боломжит эх сурвалжийг ашиглаж, зохион байгуулалттайгаар олж тогтоон нотлох баримтын хэмжээнд цуглуулж, бэхжүүлэх, түүнийг хамгаалах, битүүмжлэх, санхүүгийн болон бусад нотлох баримтуудыг олж тогтоох зорилгоор гэмт этгээдийн орон

байр, ажлын байр гэх мэт газруудад үзлэг, нэгжлэг хийх, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах, сэжигтэй этгээдэд чиглэсэн албадлагын арга хэмжээ авах, бусдын эрхийг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээ авах, сэжигтэй этгээд болон түүний хамтрагч бусад гэрчээс мэдүүлэг авах, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг шаардлагатай гадаад улс орнуудад илгээх, мэдээ, мэдээлэл солилцох бусад төрлийн мөрдөн шалгах ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд хойшлуулшгүй явуулах шаардлагатай юм.

Мөн олон улс оронд хэрэгжиж буй чиг хандлагаас харахад авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхдээ санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг оновчтой хэрэгжүүлж, гэм бурууг хөдөлбөргүй тогтоох, олон талт хамтын ажиллагааг ашиглан гэмт хэрэгтэнд дан ганц хорих ял шийтгэхээс илүү хууль бусаар олсон хөрөнгийг хураан авч улсын орлого болгох, алдагдсан хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг явуулах нь туйлын чухалд тооцогдож байна. Энэхүү ажиллагаа нь эрүүгийн эрх зүйн шинэлэг зүйл бөгөөд гэмт этгээдэд дан ганц ял шийтгэл ногдуулахаас илүү хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах, гадаад улс орон руу алдагдсан хөрөнгийг эргүүлэн авахад манай улсын хууль сахиулах байгууллагууд мөн анхаарч байна.

Манай улсад мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага буюу тэр дундаа хуулиар харьяалуулсан Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэрэг, гомдол мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг Авлигатай тэмцэх газарт сүүлийн 8 жилийн хугацаанд шалгасан албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийн статистик тоо мэдээнээс үзэхэд дараах нөхцөлтэй байна.

График 1. Авлигатай тэмцэх газарт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан албан тушаалын гэмт хэргийн тоон үзүүлэлт, 2013-2020[8]





График 2. ЭХ-ийн 18.6-д заасан мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн тоон үзүүлэлт, 2013-2020[9]



[8] АТГ-ын мэдээлэл, судалгаа

[9] АТГ-ын мэдээлэл, судалгаа

Авлигатай тэмцэх газарт сүүлийн 8 жилийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн албан тушаалын гэмт хэргийн тоон үзүүлэлтээс үзэхэд сүүлийн жилүүдэд иргэдээс Төрийн байгууллагад итгэх итгэл суларсан, төрийн байгууллагын албан тушаалтан болон хууль сахиулах байгууллагын ажилтны сонгон шалгаруулалт, хүний нөөц, боловсон хүчний бодлого алдагдсан,

Улс төр, эдийн засаг нөхцөл байдал хүнд, нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалт, хуулийн хийдэл ихтэй, нийгэмд шударга бус явдал газар авсан, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал дутуу, худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулах, тендер шалгаруулалт, төрийн болон төрийн захиргааны байгууллагаас гаргаж байгаа захиргааны шийдвэр нь хууль бус, эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтны цалин, хангамж бага, ажилтан, алба хаагчдын хүнд суртал, байгалийн баялгийн шударга бус хуваарилалт зэрэг олон шалтгаан нөхцөл нь албан тушаалын гэмт хэрэг өссөнтэй шалтгаант холбоотой байна.

Үүнд мөнгө угаах гэмт хэргийн тоон үзүүлэлт харьцангуй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт дээр хэлсэнчлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчин нөлөөлж байгаа бөгөөд мөнгө угаах гэмт хэргээр шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэрэг бага байгаагийн тод илрэл юм.

Авлигатай тэмцэх газраас 2020 онд хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 236 хэргийг шүүхэд шилжүүлсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлт юм. Энэ онд авлига, албан тушаалын 114 эрүүгийн хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн нь өмнөх оноос 67.6 хувиар өссөн сайн үзүүлэлт байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах эрх бүхий байгууллага (ФАТФ)-ын газар дээрх хяналт шалгалт хийх ажлын хүрээнд 2017-2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийн тоон мэдээнээс мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн төрлийг авч үзвэл:

1. Хулгайлах гэмт хэрэг 32.5 хувь,
2. Мал хулгайлах гэмт хэрэг 18.9 хувь,
3. Залилах гэмт хэрэг 2.7 хувь,
4. Авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг 8.4 хувь,
5. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 0.7 хувийг тус тус эзэлж байгаа нь нийт шийдвэрлэсэн хэргийн 63.2 хувь нь өндөр эрсдэлтэй гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт

Монгол Улсад авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа эрчимтэй өрнөж байгаа ч өнөөгийн даяарчлагдсан нийгэмд хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгийг гадаадын улс орон, засаг захиргааны бүс, цаашилбал оффшор бүсэд байршуулах, нуун далдлах асуудал нэмэгдсээр байна. Энэ нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэйгээр ашиглаж, мөнгөн урсгалыг тогтоосноор гадаадын улс орон руу шилжүүлсэн, нуун дарагдуулсан хөрөнгийг илрүүлэх боломж бүрдүүлж байна. Учир нь орчин цагийн гэмт хэрэг,

ялангуяа өндөр зохион байгуулалт, олон шатлалт, нарийн төлөвлөсөн том хэмжээний авлигын хэрэг нь уламжлалт мөрдөн шалгах ажиллагаанаас гадна санхүүгийн мөрдөн шалгах, гүйцэтгэх ажиллагаа, олон улсын олон хэлбэрийн хамтын ажиллагаа, ялангуяа эрх зүйн харилцан туслалцааг үр дүнтэйгээр гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай байна.

Манай улс тус чиглэлээр ихээхэн ахиц дэвшил гаргаж байгаа ч цаашдаа хууль сахиулах болон санхүүгийн салбарын хооронд хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж, асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай. Энэ нь гэмт хэргийн гаралтай хөрөнгө мөнгө, гүйлгээг цаг алдалгүй царцаах, зогсоох, битүүмжлэх, хураах, хураасан хөрөнгийн менежмент хийх, улсад учруулсан хохирлыг барагдуулах, хууль бус хөрөнгийг хураан авах, эргүүлэн татах зэрэг олон асуудлын шийдэл болох боломжтой юм.

Мөн өндөр төвшний авлига, албан тушаалын гэмт хэрэгт олон улсын байгууллага, банк, гаднын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй сан, буяны байгууллага, татвар төлөхөөс зайлсхийх, хар зах зээл дэх бэлэн мөнгөний эргэлтийг зогсоох, хууль бус эсхүл халхавчилсан үнэт цаасны арилжаа зэрэг зохион байгуулалттай үйлдэлтэй үр дүнтэй тэмцэх арга нь дээрх гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлэх бөгөөд энэ бүх нөхцөлийг харгалзаж Монгол Улс эрх зүйн орчиндоо мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоо оновчтой тодорхойлох, авлигын гэмт хэрэг шалгах тохиолдол бүрд мөнгө угаах гэмт хэргээр давхар шалгадаг практик тогтоох, мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг нэрлэж өгөх шаардлагатай байна.

Санал

1. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, бусад салбар хуулийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

Үүнтэй уялдуулан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох, гэмт этгээдэд холбогдох ял шийтгэлийн бодлогыг уг гэмт хэргийн ноцтой шинж чанарт нь тохирохуйц хэмжээнд тогтоон хэрэгжүүлэх, шүүхээр энэ төрлийн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх асуудалд ахиц, дэвшил гаргах;

2. Гэмт хэргийн улмаас олж авсан хөрөнгө, орлогыг хураан авах, гадаадын улс орнуудад байршуулсан хөрөнгө, оффшор бүсэд байршуулсан орлого зэргийг буцаан татах чиглэлээр улс орнуудын хоёр талын болон олон талт эрүүгийн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, гүйцэтгэлд нь хяналт тавих төрийн механизмыг сайжруулах;

3. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж буй хууль сахиулах байгууллага, санхүүгийн байгууллага /Санхүү мэдээллийн алба, Арилжааны банкнууд, Хөрөнгийн зах зээл г.м /, бусад төрийн чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, тэдгээр байгууллагуудын ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг төрийн бодлогоор авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Ашигласан ном зүй

1. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ. 1986, 2002, 2015

2. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ, 2020 он

3. Авлигатай тэмцэх газар. Мөнгө угаах гэмт хэрэг. УБ, 2020 он

4. М.Гантулга (УЕПГ-ын ахлах прокурор). Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа. УБ, 2020 он

5. Авлигатай тэмцэх газар. Авлига албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал. УБ, 2019

6. Монгол банкны Санхүү мэдээллийн алба. ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилтийг үнэлэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг дүгнэхэд ашиглагдах аргачлал. УБ. 2013 он

7. Ж.Болдбаатар нар. “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2012. 36 дахь тал

8. Авлигатай тэмцэх газар. Гэмт хэрэг, гомдол мэдээлэл шийдвэрлэлтийн судалгаа. 2013-2020 он

9. ШЕЗ. “Шүүх эрх мэдэл” сэтгүүл. 2020 он №4 дугаар

10. Авлигатай тэмцэх газар. https://www.iaac.mn

11.Санхүүгийн мэдээллийн алба. Мөнгө угаах гэмт хэрэг гэж юу вэ? /www.mongolbank.mn/

12.Олон улсын мөнгө угаах мэдээллийн товчооны сайт http://www.imlib.org/page14_conclusions.html

13.Мөнгө угаах гэмт хэрэг. https://ru.wikipedia.org/

14.Мөнгө угаахтай тэмцэх толь бичиг. https://www.acams.org/zh-hans/

ӨНГӨТ ХУВЬСГАЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ШИНЖ

THE CONCEPT OF COLOR REVOLUTION, MAIN FEATURES

В.Амарсанаа
Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч
V.Amarsanaa
Ph. D., Lecturer, Department of Criminal Law and criminology, school of police (Ph.D), Police Major
Б.Лхагварагчаа
Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн ахмад
B.Lkhagvaragchaa
Head of the Department of Police School compliance methodology, Dr. (Ph.D), Police captain

Хураангуй: Улс төрийн бодлогын шинжтэйгээр зөөлөн хүчний технологи, арга хэрэгсэл ашиглаж, олныг хамарсан эсэргүүцлийн замаар, хүчирхийллийн бус аргаар засгийг нураан унагаадаг төрийн эргэлтийн ойлголт, үндсэн шинжийн талаар авч үзэхийг зорилоо.

Abstract: in the nature of political policy, we aim to consider the concept and basic features of a coup that involves the use of certain soft power technologies, and tools, mass street protests, and the non-violent overthrow of the government.

Түлхүүр үг: Жагсаал, хүчирхийллийн бус тэмцэл, хүч үл хэрэглэх зарчим, цуглаан, эмх замбараагүй байдал.

Keywords: Demonstration, non-violent struggle, principle of non-use of force, Assembly, disorder.

Иргэдийн эмх замбараагүй байдал бий болох шалтгаан нь нийгэм, эдийн засаг, улс төрийн шинжтэй стресс, бухимдал удаанаар хуримтлагдсаны улмаас нийгмийн давлагаагаар илрэн гарах явдал юм. Түүхийн бүхий л мөчлөгт эмх замбараагүй байдал нь нийгэм, соёлын том өөрчлөлтийг бий болгодог. Жишээлбэл, 1848 онд Францын иргэдийн засаглалд сэтгэл ханамжгүй байдлаас үүссэн эмх замбараагүй байдал даамжирсаар Европ болон Латин Америкийн ихэнх хэсгийг хамарсан бол 1960 онд АНУ-ын хотуудад арьс өнгөөр ялгаварлахын эсрэг хөдөлгөөн ихээхэн газар авсан. Мөн 1989 онд Төв ба Зүүн Европын орнуудад коммунизмын эсрэг тэмцэл нь “Берлины хананы уналт” бэлэг тэмдэг дор өрнөсөн байна. Харин сүүлийн үед Арабын ертөнцөд нийгмийн тогтвортой бус байдал ихсэж буй явдал нь Тунис болон Египетэд хүч үл хэрэглэх замаар өрнөж, засгийн дарангуйллыг түлхэн унагаасан тэмцлийн хөдөлгөөнөөс эхлээд, Ливи улсад өргөн хүрээг хамарсан иргэний дайн болон өөрчлөгдсөн эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийг нэрлэж болох юм .

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд “өнгөт хувьсгал” хэмээх нийгэм, улс төрийн шинэ үзэгдлийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ихээхэн ярьж, энэхүү ажиллагааны гарал үүсэл, шалтгаан нөхцөл, зорилгын талаар хэлэлцэх болжээ. Өнгөт хувьсгал гэх нэр томьёонд албан ёсны тодорхойлолт одоог хүртэл хараахан гараагүй бөгөөд, түүний шалтгаан, зорилго болон зохион байгуулах арга, хэлбэрийг судлаачид өөр өөрөөр тайлбарлаж ирсэн. Зарим судлаачид “Өнгөт хувьсгал” гэдэг нь хэдий

шинэвтэр ойлголт хэдий ч, түүний эхлэлийг өнгөрсөн үеэс улбаатайгаар тайлбарладаг. Тиймээс уг нэр томьёоны суурь ойлголтыг тодорхойлохын тулд өнгөрсөн үеийн үзэл баримтлалын асуудлыг судлах шаардлагатай байна.

Өнгөт хувьсгалын хам шинж

XIX, XX зууны үед хүч хэрэглэх болон хүч үл хэрэглэх эсэргүүцлийн талаарх ойлголт, тулгамдсан асуудлын талаар М.А.Бакунин, Л.Д.Бронштейн Троцкий, К.Маркс, В.И.Ленин, Мао Зедун, Ф.Энгельс, Г.Д.Торо, Л.Н.Толстой, М.Ганди, М.Л.Кинг болон бусад эрдэмтэн, судлаач бүтээл туурвиж ирсэн түүхтэй. Тэр дундаа нийгмийн шударга бус үзэгдэл, төрийн удирдлагын алдаатай бодлого үйл ажиллагааг хүчирхийллийн бус аргаар ард нийтээр эсэргүүцэх үзэл санааг Г.Д.Торо, Л.Н.Толстой, М.Ганди, М.Л.Кинг нар түлхүү дэмжиж, үр дүнтэй тэмцэл өрнүүлж байжээ. Жишээлбэл, Америкийн иргэдийн эрхийг хамгаалахад чиглэсэн эсэргүүцлийн хөдөлгөөн институцийн өөрчлөлт хийхэд хүчтэй нөлөөлсөн бөгөөд М.Л.Кинг АНУ-ын үндэсний цөөнхийг арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг тэмцэл өрнүүлж, үр дүнд нь 1964 оны Иргэний эрхийн тухай хуульд арьс өнгөөр ялгаварлахын эсрэг дэвшилттэй заалт орсон байдаг[1]. Хүчирхийллийн бус аргаар тэмцэх үзэл санааны талаар Г.Д.Торо (1817-1862) “Нийгмийн ба иргэдийн амьдралын нөхцөлд үл нийцсэн шударга бус бодлого хэрэгжүүлж байгаа төр засгийг хүлээн зөвшөөрөхгүй байх, тийм төртэй хамтран ажиллахаас нийгэм даяараа татгалзах ёстой” гэж үзсэн байна.

Америкийн судлаач Ж.Шарп (Gene Sharp 1928-2018) зарим тохиолдолд хүчирхийллийн бус тэмцлийг хүчирхийлэл хэлбэрээр явуулж болох мэтээр дэлгэрэнгүй ухуулсан байдгийн дотор, ихэвчлэн төр засгаас явуулж буй улс төрийн ба эдийн засгийн ажиллагааг таслан боогдуулах талаар зааварчилсан бөгөөд төрийн эрх мэдлийг булаан авах улс төрийн хүчирхийллийн бус тэмцлийн шинэлэг арга зүйг өнгөт хувьсгал байдлаар явуулах тухай тайлбарлаж, түүний мөн чанар, арга технологийг харуулсан байна[2]. Хүчирхийллийн бус аргаар тэмцэх тухай үзэл санааны томоохон төлөөлөгчдөөс ялгаатай нь Ж.Шарп өөрийн боловсруулсан арга зүйг “...бодь сэтгэлд үндэслээгүй, хүчирхийллийн арга хэрэглэхийг ёс суртахуун, шашны үүднээс татгалзаагүй бөгөөд, ёс зүйг хэрэгжүүлэхэд бус, харин аливаа хүмүүст нийтлэг байдаг “зөрүүдлэх” зан авирт суурилсан, төрийн эрхийг авах арга зүй ...” гэж тайлбарлажээ. Ж.Шарп нэгэн удаа BBC NEWS-т өгсөн ярилцлагадаа: “... Би төрийн дэглэмийг хэрхэн түлхэн унагаах талаар судалж байсан. Надад олон тооны баримт бичиг, захидал, нооргууд, мөнгө дэмжлэг болон туслахуудыг гарган өгсөн. Бид дөрвөн сарын хугацаанд эдгээрийг нэгтгэж ном гаргасан. Уг номыг АНУ-д бус Бангкогт хэвлүүлэн гаргаж, дөрвөн хэл дээр орчуулсан ...”[3] гэж ярьжээ.

Ж.Шарпын зохиосон өнгөт хувьсгалын талаарх арга зүйд суурилж

[1] Juan Pablo Mendez Campos. Violent versus Non-Violent Political Protests. A Case Study from the American Civil Rights Movement. 2017. P.2.

[2] Аббасов Р.Г. Джин Шарп: политологический плагиат или классика цветных революций. Научные ведомости. Серия философия. Социология. Право. 2016. №3.

[3] Ж.Шарпын BBC NEWS-т өгсөн ярилцлагаас: https://www.youtube.com/watch?v=h_BA7dmU7R4

өрнөсөн нэгэн жишээг дурдахад 2005 онд Кыргызстан улсад алтан зул цэцгийн хувьсгал өрнөсөн бөгөөд, Ж.Шарпын өнгөт хувьсгал хийх технологийн дагуу тухайн үед засгийн эрхийг атгаж байсан ерөнхийлөгч Аскар Акаевыг эрх мэдлээс нь огцруулсан байна[4].

Жагсаал, цуглааныг судлах талаарх эртний үзэл санааг Францын сэтгэл судлаач Гюстав Лебон дэвшүүлсэн боловч үнэн хэрэгтээ хүлээн зөвшөөрөгдөх байдал маргаантай хэвээр. Түүний үзэл санааг Италийн эрдэмтэн Ч.Ломброзын сурагч С.Сигеле эрс эсэргүүцэж, далайн дээрэмчин гэж буруутгасан юм. Энэхүү цаг үе нийгмийн эмх журмын эмзэг байдалд буюу жагсаал, цуглааны хүч ба ач холбогдолд чухал анхаарал хандуулж байсан үе юм. Г.Лебон энэ үед өрнөж байсан явдалд түүхэн ач холбогдол өгч, "... Бидний эртний итгэл үнэмшил ганхаж, нийгмийн хуучин багануд ар араасаа нуран унаж буй цагт, бөөгнөрсөн олны засаглал хэний ч заналхийлэлд өртөлгүй, цорын ганц хүч болсон бөгөөд, алдар нэр нь байнга нэмэгдэж байна. Шинээр алхан орж буй эрин зуун маань үнэн хэрэгтээ бөөгнөрсөн олны эрин зуун болно ..."[5] гэж тэмдэглэн үлдээжээ. Энэ ч хоосон таамаг байсангүй. Хүйтэн дайн дууссанаас хойших хугацаанд дэлхийн улс орнууд ихээр ардчилсан тогтолцоонд шилжих болсон, үүнийг дагаад жагсаал, цуглаан, бослого, үймээн газар авах болсон юм. Аливаа төрийн дэглэмийг түлхэн унагаахад ихэвчлэн ашигладаг байсан хүч хэрэглэх аргаас улам нарийн аргад шилжсэнийг эдүгээ дэлхий дахинд "өнгөт хувьсгал" гэж нэрлэж заншсан байна.

Өнгөт хувьсгал гэх нэр томьёо Гүрж улсад сарнай цэцэг, Кыргызстанд алтан зул цэцэг, Украинд улбар шар өнгийн цэцэг барьсан эсэргүүцлийн хөдөлгөөнөөс үүдэлтэй, хүч үл хэрэглэх замаар өрнөж, XXI зууны эхний арван жилийн хугацаанд авторитар дэглэмийг нурааж, өөрчилсөн нийтлэг үзэгдлийг тайлбарлахад ашиглагддаг нэр томъёо юм[6]. Бүгд Найрамдах Тунис улсад 2011 онд өрнөсөн мэлрэг цэцгийн нэрээр нэрлэсэн "жасмин" хувьсгалыг эс тооцвол, Ойрхи Дорнодод энэ нэршил тийм ч түгээмэл биш.

Гүрж улсад 2003 онд өрнөсөн сарнайн хувьсгалыг анх "өнгөт хувьсгал" гэж нэрлэж ирсэн байна. Жагсагчид парламентын бүрэлдэхүүнийг шинээр сонгох сонгуулийн үр дүнд дургүйцэж, гартаа өөрийн улсын төрийн далбаа болон сарнай цэцэг барьж, парламентын танхим руу дайрч орсон байдаг. Гэхдээ жагсагчид хүч үл хэрэглэх замаар эсэргүүцлээ илэрхийлж байснаас үүдээд, зарим судлаач тухайн үеийн улс төрийн өөрчлөлтийн төлөөх тэмцлийг хилэн (бархатный) хувьсгал гэж нэрлэдэг байна. "Гүрж, Кыргызстан, Украин болон бусад улсад өрнөсөн өнгөт хувьсгалын гол шалтгаан ажилгүйдэл, ядуурал, нийгмийн

[4] Воронин С.А., Бакина Е.А. Клановая иерархия как основа «тюльпановой революции» в Кыргызстане. Вестник РУДН. Серия: Всеобщая история. (RUDN journal of World History) 2019. №2. С. 161.

[5] Tim Newburn. Annual Review of Criminology. The Causes and Consequences of Urban Riot and Unrest. Department of Social Policy, London School of Economics and Political Science. London. 2020. P. 55

[6] Оросын холбооны улсын эрдэмтэд Дж. Савино, Новодержкин Н.А. нар "Революция vs «цветная революция»" өгүүлэлдээ өнгөт хувьсгалын нэр томъёонд өөрсдийн тодорхойлолтыг дээрх байдлаар тайлбарласан байна.

халамжийн асуудал, авлига, хэвлэл хахууль, отог омгийн зэрэг хүчин зүйлээс улбаатай" гэж зарим судлаач[7] дүгнэсэн байна.

ОХУ-ын эрдэмтэн А.О.Наумов "Өнгөт хувьсгал гэдэг зөөлөн хүчний тодорхой технологи, механизм болон багаж зэвсэг ашиглаж, олныг хамарсан гудамжны эсэргүүцлийн замаар өрнөж, хүч үл хэрэглэн засгийг нураан унагаадаг төрийн эргэлт" гэж тодорхойлсон бол А.Э.Гапич, Д.А.Лушников нар "төрийн засаглалыг түлхэн унагаах арга зүйн нийцэл, тодорхой улсын дотоод хэрэгт гадаадаас оролцсоны үр дүн, улс төрийн эргэлт болон тогтворгүй байдлыг үүсгэж, өөрт ашигтай, хялбараар удирдах, нэг үгээр утсан хүүхэлдэйн дэглэм тогтоох ажиллагаа"[8] гэж дүгнэсэн байна.

Керимов А.А, Вербицкая Т.В. нар "Сонгодог буюу хүч хэрэглэх замаар өрнөдөг хувьсгалаас өнгөт хувьсгалын ялгаатай тал бол улс төрийн процессын удирдлага болон технологийг агуулсан гадаадын болон олон улсын захиалагчтай, улс төрийн дэглэмийг өөрчлөхөд чиглэсэн эсэргүүцлийн хөдөлгөөн бөгөөд зорилго нь захиалагчаас өөрийн талд ашигтай байдлыг олж авахад чиглэдэг"[9] гэж тодорхойлжээ. АНУ, Их Британи, БНХАУ зэрэг хөгжилтэй орнууд дэлхий нийтэд өөрсдийн тогтоосон нөлөөг өргөжүүлэх, хөгжиж буй болон ядуу буурай орнуудын төрийн тогтворгүй байдлыг ашиглаж, урьдаас төлөвлөсөн технологийн дагуу элдэв аргаар ард иргэдийг засаглалын эсрэг хүч үл хэрэглэх тэмцэлд турхирч, үр дүнд нь тухайн улсын төрийн дэглэмийг "ардчилал" нэрийн дор өөрт ашигтайгаар өөрчлөх явдлыг ерөнхий байдлаар өнгөт хувьсгал гэж тодорхойлж байна. Өнгөт хувьсгал өрнөсөн оронд, улс төрийн систем нуран унаж, захиалагч улсын гадаад удирдлагад бүрэн болон хэсэгчилсэн байдлаар орсноор захиалагч улсын геополитикийн ашиг сонирхол үндсэндээ зорилгодоо хүрдэг аж[10].

ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин "Өнгөт хувьсгал эмгэнэлт хор уршигт хүргэдэг, экстремизмын хэлбэртэй үзэгдэл" гэж тодорхойлсон явдал анхаарал татаж байна. Мөн тэрээр 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр тус улсын Аюулгүй байдлын зөвлөлийн хурал дээр өнгөт хувьсгалын шинжтэй үйл ажиллагааг Оросод үгүй болгох санаатай болохоо илэрхийлжээ[11].

Судлаачдын үзэл санааг багцлан нэгтгэвэл өнгөт хувьсгал гэдэг аливаа улс орны засгийн эрхийг авах зорилгоор гадаад улсаас хөндлөнгөөс оролцож, хүчирхийллийн бус тэмцэл өрнүүлэх замаар зориуд хатган үймүүлж, зөрчилдөөнт байдлыг үүсгэж, дагаж мөрдөж ирсэн хууль (Үндсэн Хууль), эрх зүйн үндэс, засаглал, геополитик, геоэдийн засгийн бодлогыг өөрсдийн эрх ашигт нийцүүлэн, ул сууриар

[7] Хабриева Т.Я., Чиркин В.Е. "Цветные революции" и "арабская весна" в конституционном измерении. Монография. М. 2019. С. 12-13.

[8] Гапич А.Э., Лушников Д.А. Технологии «цветных революций» М, 2014.

[9] Керимов А.А., Вербицкая Т.В. Концепция цветной революции в политической науке. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн нэгдсэн сайт cyberleninka.ru. интернет холбоос: https://cyberleninka.ru/article/n/kontseptsiya-tsvetnoy-revolyutsii-v-politicheskoy-nauke/viewer

[10] Мөн тэнд.

[11] https://ru.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B2%D0%B5%D1%82%D0%BD%D0%B0%D1%8F_%D1%80%D0%B5%D0%B2%D0%BE%D0%BB%D1%8E%D1%86%D0%B8%D1%8F.

өөрчлөхөд чиглэсэн тусгай хэлбэрийн тэмцэл юм.

Өнгөт хувьсгал гарсан улс орнуудын алинд ч сонгодог хувьсгалын тохироо бүрдээгүй байдгаараа онцлогтой. Хувьсгалын тохироо гэдэг “Доодчуул өмнөх шигээ амьдрахыг хүсэхгүй, Дээдчүүл нь өмнөх шигээ захирч чадахгүй болохыг хэлнэ” гэж В.И.Ленин тэмдэглэж байсан удаатай.

Өнгөт хувьсгалын үндсэн шинжүүдийн нэг бол тухайн улсын төрийн засаглалыг өөрчлөх болон төрийн эргэлт хийхэд чиглэсэн гадаад улсын шууд болон шууд бус хэлбэрийн оролцоо, дэмжлэг болно. Ихэнх улс орны шинжээчид “АНУ ардчиллыг дэмжих, энх тайвныг сахин хамгаалах нэрийн дор, өөрийн эрх ашгийн үүднээс аливаа хөгжиж буй орнуудын төрийн үйл ажиллагаанд оролцохыг эрмэлздэг, энэ чиглэлээр нэлээд хэдэн улсад нөлөөлсөн гэж үздэг юм.

Америкийн улс төр судлаач Ж.Шарп өөрийн бүтээлдээ өнгөт хувьсгалыг зохион байгуулах талаар тусгай боловсруулсан арга зүйг нэвтрүүлсэн байна. Үүнд:

- Хүч үл хэрэглэх замаар явагдах өргөн хүрээний үйл ажиллагаа;
- Эмх замбараагүй байдлын удирдлага, зохион байгуулалтын үзэл санаа;
- Төрийн засаглалын эсрэг мэдээллийн дайн (засаглалыг илчлэх);
- Төрийн хууль ёсны байдлыг үгүйсгэх олныг хамарсан кампанит ажил;
- Арми, хүчний бүтцийг задлах ажиллагаа;
- Эсэргүүцлийн хүчээр тээвэр, харилцаа холбоо, хангамж, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өөрийн хяналтад оруулах[12] зэрэг багтжээ.

XX зууны 70, 80-аад онуудад дэлхийн 30 гаруй орон улс төрийн авторитари дэглэмийг халж, ардчилсан тогтолцоонд шилжсэн. АНУ болон Өрнөд Европын нөлөө бүхий орнууд олон улсын институцүүдийн бодлого болон үйл ажиллагаанууд Испани, Португал, Латин Америкийн олон орон Филиппин, Өмнөд Солонгос, Зүүн Европт ардчилал тогтооход нөлөөлсөн юм. Ингээд 1990 оны үе гэхэд өрнийн христийн үзлийг дээдэлдэг, христийн нөлөөнд ихээр автсан бүх улсад ардчилсан өөрчлөлт өрнөжээ. Ийнхүү ардчиллын түгэн дэлгэрэлтийг дэмжих явдал өрнийн оршин суугчдын тэргүүн зэргийн зорилт болсон байна. Энэ зорилтыг Ж.Бушийн засаг захиргаа дэмжиж, 1990 оны 4 дүгээр сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкер: “... Тогтоон барих бодлого бол ардчиллын төлөө юм ...” хэмээн мэдэгдэж, “... хүйтэн дайны дараах ертөнц дэх манай шинэ зорилтыг ерөнхийлөгч Ж.Буш “ардчиллыг дэмжиж нэгтгэх явдал гэж тодорхойлсон ...” гэжээ.

Бүгд Найрамдах Ирак Улсад тогтсон дэглэмийг өөрчлөхөд АНУ цэргийн үйл ажиллагаа болон Нэгдсэн улсын үзэл суртлын бүхий л албанаас явуулсан мэдээллийн хүчирхэг дэмжлэг нөлөө үзүүлсэн байдаг. Америкийн ашиг сонирхлын бай болсон бусад оронд улс төрийн дэглэм болон ерөнхийлөгчдийг өөрчлөх ажиллагаа “хилэн (бархатная), улбар шар (оранжевая), сарнайн (революция роз)”

[12] Кузьмин В. Роль США в осуществлении цветных революций в зарубежных странах //Зарубежное военное обозрение. 2008. №9. С. 9-18.

ардчилсан замаар өрнөсөн байна[13]. “Арабын хавар” хэмээх өнгөт хувьсгал хамгийн их хохирол дагуулж арабын хүрээний 20 гаруй улсыг засаглалын доройтолд оруулж Ирак, Ливи зэрэг 10 орчим улс төр засаггүй, хуваагдмал иргэний дайны нөхцөл байдалд шилжсэн юм. Энэхүү хувьсгалыг АНУ-ын тусгай албад зохион байгуулсан гэх мэдээлэл ч түгээмэл байдаг. Тухайлбал, Нэгдсэн улс бусад улс орны дотоод хэрэгт хэрхэн түрэмгийлж оролцсон тухай судлаач Уильям Блум төр засгийн тэргүүн нь ардчилсан сонгуулиар сонгогдсон гадаад улсын засгийн эрх мэдлийг унагах 50 гаруй оролдлого хийж, 30 гаруй улсын ардчилсан сонгуульд хөндлөнгөөс оролцсон, төр засгийн удирдагчийн амь насанд 50 гаруй удаа халдсан, 20 гаруй улсын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нухчин дарахад хөндлөнгөөс оролцсон байна[14].

Өнгөт хувьсгалын үндсэн шинж гадаад улс, тэр дундаа хөгжиж буй зарим оронд шууд болон бусаар нөлөөлсөн АНУ-ын оролцоо их болохыг үүнээс харж болно. Энэхүү шууд болон бус байдлын нөлөөллийн зорилгыг тодорхойлоход тийм ч хүнд биш бөгөөд АНУ-ын зүгээс НАТО-гийн бусад улсын оролцоотойгоор “ардчилал” нэрийн дор өөрийн улсын бодлого, үзэл суртал, ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулж буй жижиг орнуудын улс төрийн дэглэмийг өөрчлөх замаар тухайн улсад өөрийн эрх мэдэл, оролцоо, нөлөөллийг өмнөхөөс харьцангуй ихээр нэмэгдүүлж, улмаар тухайн орныг өөрийн эрх ашигт нийцүүлэн удирдахад чиглэдэг байна.

Гадаад улсын оролцоо, нөлөөлөл заавал байх шинжээс гадна, өнгөт хувьсгал хүч үл хэрэглэх замаар өрнөдгөөрөө бусад төрлийн бослого, үймээнээс илт ялгаатай. Өөрөөр хэлбэл, өнгөт хувьсгал бол юуны өмнө улс төр, нийгмийн тогтолцоог өөрчлөх зорилготой байдаг ч сонгодог утгаар авч үзвэл хувьсгал биш. Энэ төрлийн эсэргүүцлийн хөдөлгөөн эхэндээ тайван замаар явагдах боловч, цаг тухайд зогсоогоогүй тохиолдолд цуст мөргөлдөөн, зэвсэгт төрийн эргэлт болдог байна.

АНУ-ын 40 дэх ерөнхийлөгч Рональд Рейгены үед **хүчирхийллийн бус тэмцлийн үзэл санааг** “... аливаа нийгэмд иргэдийн эрх ашигт үл нийцсэн улс төрийн дэглэмийг өөрчлөхдөө ашиглаж болох арга зүйн гол үндэс ...” гэж үзэж, америкийн төрийн гадаад бодлогын хэмжээнд хэрэгжүүлэх улс төр, санхүү, зохион байгуулалтын дэмжлэгтэй, зарчмын чанартай арга хэмжээ болгосон байна. Тухайлбал, 1983 онд АНУ-ын Ардчилсан нам, Бүгд найрамдах намаас хамтарсан ажлын хэсэг байгуулж, боловсруулсан “Ардчиллыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг ерөнхийлөгч Р.Рейген баталснаар дор дурдсан хэд хэдэн төрийн бус байгууллагыг үүсгэсэн байдаг.

- Ардчиллыг дэмжих үндэсний сан (NED – National Endowment for Democracy);
- Ардчиллын олон улсын хүрээлэн (NDI – National Democratic Institute);
- Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI – International Republican Institute);

[13] Макаревич Э.Ф., Карпухин О.И. Технологии цветных революций. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн нэгдсэн сайт cyberleninka.ru. интернет холбоос: https://cyberleninka.ru/article/n/tehnologii-tsvetnyh-revolyutsiy/viewer.

[14] Аюулгүй байдал судлалын хүрээлэн. Интернет холбоос: https://niss.gov.mn/archives/1221.

- Олон улсын хувийн үйлдвэрлэгчдийн төв (Center for International Private Enterprise);

- Олон улсын хөдөлмөрчдийн эв нэгдлийн америкийн төв (American Center for International Labor Solidarity);

- Нээлттэй нийгэм хүрээлэн, Соросын сан – ажиллагааг санхүүжүүлэх, төрөл бүрийн төсөл хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах;

- Хүчирхийллийн бус тэмцлийн асуудлаар судалгаа, сургалт хийх зорилготой Альберт Эйнштейний Хүрээлэн[15]. Эдгээр байгууллагаар дамжуулан дэлхийн олон оронд "хүмүүнлэг, ардчилсан үйл хэргийг түгээх" нэрийн дор хүч үл хэрэглэх замаар өнгөт хувьсгал өрнүүлж байна гэж үзэхэд үгүй гэх газаргүй юм. Ингэснээр урьд өмнө АНУ-ын хувьд улс төрийн дэглэмийг өөрчлөх шаардлагатай гэж үзсэн аливаа гадаад улсын дотоод хэрэгт оролцохоор Тагнуулын төв газраас нууцаар зохион байгуулж, хэрэгжүүлдэг байсан "төрийн эргэлт" хийхийн оронд ардчиллыг хөгжүүлэх "буянт үйлс" нэрийдлээр явуулах тусгай ажиллагааны гол ачааллыг дээр дурдсан төрийн бус байгууллагууд хууль ёсны дагуу болж буй мэт ил хэлбэрт шилжсэн гэж үзэхээр байна. Энэхүү шинэ аргачлал, механизмын хүрээнд дээр дурдсан зарим байгууллагын хариуцах чиг үүргийг дараах байдлаар тодруулсан байна. Үүнд:

- АНУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (US Agency for international - USAID) – өнгөт хувьсгалын ажиллагааг санхүүжүүлэх, улс төрийн дэмжлэг үзүүлэх;

- Тагнуулын төв газар – өнгөт хувьсгал гаргахад мэргэжлийн удирдлага, дэмжлэг болон шаардлагатай мэдээллээр хангах;

- Ардчиллыг дэмжих үндэсний сан – өнгөт хувьсгалын ажиллагааг тэмцэгчид болон дэмжигчдийн хооронд уялдуулж зохицуулах, санхүүжилтийг хуваарилах;

- Ардчиллын олон улсын хүрээлэн, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн – өнгөт хувьсгалын ажиллагааг газар дээр нь зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

- Олон улсын хувийн үйлдвэрлэгчдийн төв, Олон улсын хөдөлмөрчдийн эв нэгдлийн Америкийн төв – өнгөт хувьсгалд шаардлагатай санхүүжилтэд зориулж, төрөл бүрийн сангаас хөрөнгө босгож өгөх;

- А.Эйнштейний хүрээлэн – гадаад орнуудын сөрөг хүчнийг сургаж, бэлтгэх, онол, арга зүйн гарын авлага боловсруулах;

- Тухайн улсад суугаа америкийн элчин сайдын яам нь өрнөж буй өнгөт хувьсгалын ажиллагаанд дэргэдээс нь хяналт тавьж, холбогдох дэмжлэг үзүүлдэг байна[16].


Эдгээр байгууллагын үйл ажиллагаа өнгөц байдлаар хөгжиж буй болон ядуу буурай улс оронд аливаа төрлийн нийгмийн хангамж үзүүлэх, олон нийтийг гэгээрүүлэх, ардчилсан ёсыг хөгжүүлж, бэхжүүлэх гэх мэт энх тайвныг тогтоох болон дэмжлэг, тусламж үзүүлэхэд чиглэсэн мэт харагдах ч үнэн хэрэгтээ тухайн улсад хүч үл хэрэглэх замаар өнгөт хувьсгал өрнүүлэх зорилготойгоор оршдог байна. Үүний нэг жишээ: АНУ-ын Бүгд

[15] А.Батсайхан, Б.Эрдэнэбат. "Хүчирхийллийн бус тэмцэл" гэдгийг яаж ойлгох вэ? Улаанбаатар. 2019. 36-37 дахь тал.

[16] А.Батсайхан, Б.Эрдэнэбат. "Хүчирхийллийн бус тэмцэл" гэдгийг яаж ойлгох вэ? Улаанбаатар. 2019. 38 дахь тал.

найрамдахчуудын намаас үүсгэн байгуулж, сенатор Ж.Маккейны удирдаж байсан Олон улсын Бүгд найрамдахчуудын институц (Международный республиканский институт), АНУ-ын Ардчилсан намаас үүсгэн байгуулсан, Үндэсний ардчилсан институц (Национальный демократический институт) зэрэг юм. Эдгээр институц АНУ-ын засгийн газрын дэмжлэгтэйгээр 1983 онд байгуулагдсан бөгөөд Оросын нутаг дэвсгэрт хэдэн жилийн хугацаатай үйл ажиллагаа явуулж байгаад 2012 оны сүүлчээр Оросын нутаг дэвсгэрт эдгээр байгууллагын үйл ажиллагааг зогсоосноор Олон улсын Бүгд найрамдахчуудын институцыг Польш улсад, Үндэсний ардчилсан институцыг Литв улсад шилжүүлсэн байна[17]. Өөр нэгэн жишээг дурдахад, АНУ-ын саятан Ж.Соросын нэрэмжит сан бусад улсын нутагт хүмүүнлэгийн шинжтэй үйл ажиллагаа явуулсаар байгаа бөгөөд, манай улсад ч энэ сан үйл ажиллагаа явуулдаг билээ. Тэгвэл Гүрж улсад өрнөсөн хувьсгалаас өмнөхөн Соросын сангаас тухайн улсад "Шинэтгэлийг хөгжүүлэх фонд" гэгчийг үүсгэн байгуулсан бөгөөд 2004 онд Гүрж улсад өрнөж, ерөнхийлөгч Э.Шеварднадзег засгийн эрхээс түлхэн унагаах ажиллагааг санхүүжүүлсэн гол байгууллага бол Соросын сан байжээ[18].

Зураг 1. Ерөнхийлөгч Р.Рейганд 1983 оны 7 дугаар сарын 27-ны өдөр танилцуулсан "Ардчиллыг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн тухай албан бичгийн хуулбар.



THE
DEMOCRACY PROGRAM

27 July 1983

The President
The White House
Washington, D.C.

Dear Mr. President:

In the spring of 1982, I wrote to you as Chairman of the bipartisan American Political Foundation, joined by the Chairmen of the Democratic and Republican National Committees. We proposed a research study to determine how the United States, through private sector initiatives, could help strengthen democratic values and institutions in other countries. That study has been completed, and its recommendations have been forwarded to Congress. We know of your keen and continued interest in our work, which represents the cooperative effort of the two major political parties, labor, business, and other American institutions.

It is with special pleasure, therefore, that I present you with a copy of our basic report on behalf of the Executive Board of The Democracy Program. This report, "The Commitment to Democracy: A Bipartisan Approach," recommends creation of a private non-profit corporation, The National Endowment for Democracy, to assist our friends abroad in making democracy work. The Endowment's authorizing legislation has passed the House and comes up for Senate action in the very near future. We hope, with Senate approval and a successful resolution of House and Senate bills in conference, that the Endowment can begin its work sometime this fall.

Both the leaders of The Democracy Program and a bipartisan group of congressional leaders look forward to discussing our proposals with you today at the White House. For now, we wish simply to thank you for your strong support of these efforts.

Very truly yours,

William E. Brock, III

2100 Pennsylvania Ave., N.W.
Suite 818
Washington, D.C. 20037
(202) 293-0072

Ерөнхийлөгч Р.Рейганд 1983 оны 7 дугаар сарын 27-ны өдөр танилцуулсан "Ардчиллыг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн тухай албан бичгийн орчуулга.

[17] Макаревич Э.Ф., Карпухин О.И. Технологии цветных революций. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн нэгдсэн сайт cyberleninka.ru. интернет холбоос: https://cyberleninka.ru/article/n/tehnologii-tsvetnyh-revolyutsiy/viewer.

[18] Мөн тэнд.

АРДЧИЛЛЫН ХӨТӨЛБӨР

1983 оны 7-р сарын 27

Ерөнхийлөгч
Цагаан Ордон
Вашингтон хот, Колумб Дүүрэг

Эрхэм хүндэт ноён Ерөнхийлөгч өө,

1982 оны хавар миний бие танд Ардчилсан Нам болон Бүгд Найрамдах Намын Үндэсний Хорооны дарга нарын хамт нэгдэн орсон хоёр намын Америкийн улс төрийн сангийн даргын хувьд захидал илгээж байсан билээ. АНУ-ын зүгээс хувийн хэвшлийн санаачилгаар дамжуулан бусад улсуудын ардчиллын үнэт чанар болон институцийг чадавхтай болгоход хэрхэн туслах боломжтойг тодорхойлох судалгааны ажлыг бид санал болгож байв. Уг судалгааг хийж дуусгаад түүний талаарх зөвлөмжийг Конгресст хүргүүлсэн билээ. Улс төрийн хоёр үндсэн нам, хөдөлмөр эрхлэлт, бизнес болон Америкийн өөр бусад институцийн хамтарсан хүчин чармайлтыг төлөөлж байдаг бидний үйл ажиллагаанд та бүхэн ихээхэн анхаарал хандуулж, байнга сонирхож байдаг болохыг бид мэднэ.

Энэхүү шалтгааны улмаас би “Ардчиллын Хөтөлбөрийн Гүйцэтгэх Зөвлөл”-ийн нэрийн өмнөөс манай үндсэн тайлангийн хуулбарыг танд гардуулж байгаадаа туйлын сэтгэл хангалуун байна. “Ардчиллын төлөө хүлээх үүрэг хариуцлага: Хоёр намын хандлага” хэмээх энэхүү илтгэлээр ардчиллыг хөгжүүлэхэд хилийн чанад дахь нөхдөдөө дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ардчиллын төлөө Үндэсний сан” ашгийн бус хувийн корпораци байгуулахыг зөвлөмж болгож байна. Уг сангийн зөвшөөрөл олгох хууль нь Танхимаар батлагдаж, тун удахгүй Сенатаар шийдвэрлэгдэхээр боллоо. Сенат үүнийг баталж, Сенатын хуулийн төслийн Конференцээс баталсан шийдвэр гарснаар Сангийн ажлыг энэ намартаа эхлүүлнэ гэж найдаж байна.

Ардчиллын Хөтөлбөрийн тэргүүлэгчид болон хоёр намын бүлгийн Конгресс дахь удирдагчид өнөөдөр Цагаан Ордонд бидний саналуудын талаар яриа хэлэлцээр хийхийг хүлээж байна. Энэ цаг мөчид бид эдгээр хүчин чармайлтуудыг тууштай дэмжиж байгаад тань талархаж байна

Таныг гүнээ хүндэтгэсэн,

/Гарын үсэг/
Уиллиам И.Брок, III

Хүч үл хэрэглэх гэдгийг тайлбарлахын тулд хүч хэрэглэх (насилие) гэдэг үгний утгыг авч үзье. Хууль зүйн тайлбар тольд “Хүч хэрэглэх гэдэг нь биеийн болон сэтгэхүйн хүчирхийлэл хийсэн идэвхтэй үйлдлээр илэрнэ”[19] гэжээ. Тэгвэл академич С.Нарангэрэл хүч хэрэглэх гэдгийг “Эрх

[19] Ж.Амарсанаа., Ж.Бямбаа нар. Хууль зүйн тайлбар толь. Legal dictionary. Улаанбаатар. 2003 он.

зүйд Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэдийн хувийн халдашгүй байдлын эрхийг зөрчиж, нэг хүн нөгөөдөө үзүүлж буй бие махбодын ба сэтгэл санааны нөлөөлөл" гэж тайлбарласан. Бие махбодын хүч хэрэглэх – хүний бие организмд шууд нөлөөлөл үзүүлэх, зодох, гэмтэл учруулах, янз бүрийн аргаар (түүний дотор ямар нэгэн эд зүйлс ба бодис хэрэглэж) тарчлаах утгыг илэрхийлдэг байна. Сэтгэл санааны хүч хэрэглэх – хохирогчийн эсэргүүцэл үзүүлэх хүсэл зориг, өөрийн эрх ба ашиг сонирхлыг хамгаалах явдлыг няцаан дарахын тулд айлгах, заналхийлэх (ялангуяа бие махбодын хүч хэрэглэхээр заналхийлэх) замаар хүний сэтгэхүйд нөлөөлөх утгыг илэрхийлдэг байна[20].

ОХУ-ын эрдэмтэн С.И.Ожеговын тайлбар тольд хүч хэрэглэх (насилие) гэдгийг "хэн нэгэнд биеийн хүч хэрэглэх", "Бие дээр хүчний үйлчлэлийн улмаас мөр үлдээх", "хэн нэгэнд албадан нөлөөлөх", "хувийн халдашгүй байдлыг зөрчих", "хувь хүнд халдах", "хавчих", "хяхах", "дарлах", "хүчирхийлэх"[21] гэсэн утгуудыг агуулдаг байна. Хүч хэрэглэх гэдэг утга бие махбод болон сэтгэл санаанд хүч хэрэглэх гэсэн хоёр төрөлд хуваагддаг. Бусдыг элдэв байдлаар заналхийлэх, сэтгэл санааны хүч хэрэглэх явдал бөгөөд энэ тохиолдолд хүч хэрэглэсэн гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Монгол хэлний тайлбар тольд "үл" гэдэг "үйл үгийн өмнө тохиолдож, тухайн үйл үгээр илрэх утгыг үгүйсгэнэ" (үл дарагдам - дарагдахгүй)[22] гэж тайлбарласан бол бусад толь бичигт[23] "үл" гэдэг нь "үгүйсгэх утга" гэж тайлбарласан байна. Тэгвэл академич С.Нарангэрэл "хүч үл хэрэглэх" нэр томьёог "Улс хоорондын харилцаанд хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхийг хориглосон олон улсын эрх зүйн үндсэн (нийтээр хүлээн зөвшөөрсөн) зарчмын нэг" гэж тайлбарлажээ. Тэгэхээр "хүч үл хэрэглэх" гэдэг "хүч хэрэглэхгүй байх" гэсэн утгатай дүйцэж байна.

Өнгөт хувьсгалын гол шинжүүдийн нэг болох "хүч үл хэрэглэх" нь бусдын бие организмд шууд нөлөөлөл үзүүлэхгүй, зодохгүй, гэмтэл учруулахгүй, янз бүрийн аргаар тарчлаахгүй байхыг шаардах боловч, элдэв төрлийн эсэргүүцэл (ажил хаялт зохион байгуулах, өлсгөлөн зарлах, төрийн эрх баригчдыг түлхэн унагаах зорилготой үйл ажиллагаа гэх мэт) илэрхийлэх замаар нийгмийн болон засгийн эрх баригчдын сэтгэхүйд нөлөөлж, сэтгэл санааны хүч хэрэглэж байгаа болох нь илт байна. Иймээс өнгөт хувьсгалын "хүч үл хэрэглэх" гэдгийг "сэтгэл санааны хүч хэрэглэх" гэж өөрчлөх явдал уг үзэгдлийн талаарх ойлголтыг нарийвчлан тодруулахад дөхөмтэй гэж үзэж байна.

Дүгнэлт

Өнгөт хувьсгал гэдэг аливаа улс орны засгийн эрхийг авах зорилгоор их гүрнүүдийн хөндлөнгийн оролцоотой явагддаг, хүчирхийллийн бус тэмцэл өрнүүлэх замаар зориуд хатган үймүүлж, зөрчилдөөнт байдлыг үүсгэн, тухайн улсын хууль, эрх зүй, засаглал,

[20] С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. Англи, орос, латин, хадмал. Дөрөв дэх хэвлэлт. Улаанбаатар. 2015. 580 дахь тал.
[21] Ожегов С.И., Шведова Н.Ю. Толковый словарь русского языка. 4-е издание., Доп. М. 2006. С. 972.
[22] Н.Даш., А.Янжиндолгор нар. Монгол хэлний тайлбар толь. 4 дэх хэвлэл. Улаанбаатар. 2016. 413 дахь тал.
[23] Ё Бён Мү., Ж.Санжаа нар. Монгол хэлний толь. 2014. 568 дахь тал.

геополитик, геоэдийн засгийн бодлогыг өөрсдийн эрх ашигт нийцүүлэн, өөрчлөхөд чиглэсэн онцгой хэлбэрийн тэмцэл юм. Тодруулбал өөрийн улсын бодлого, үзэл суртал, ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулж буй бусад (ядуу, буурай) орнуудын улс төрийн дэглэмийг өөрчлөх замаар тухайн улсад өөрийн эрх мэдэл, хөндлөнгийн оролцоо, нөлөөллийг урьд байснаас харьцангуй ихээр нэмэгдүүлж, улмаар тухайн орныг өөрийн эрх ашигт нийцүүлэн удирдахад чиглэдэг байна.

Өнгөт хувьсгалын гол шинжийн нэг болох "хүч үл хэрэглэх" явдал бусдын бие организмд шууд нөлөөлөл үзүүлэхгүй, зодохгүй, гэмтэл учруулахгүй, янз бүрийн аргаар тарчлаахгүй байхыг шаардах боловч, элдэв төрлийн эсэргүүцэл (ажил хаялт зохион байгуулах, өлсгөлөн зарлах, төрийн эрх баригчдыг түлхэн унагаах зорилготой үйл ажиллагаа гэх мэт) илэрхийлэх замаар нийгмийн болон засгийн эрх баригчдын сэтгэхүйд нөлөөлж, сэтгэл санааны хүч хэрэглэдэг болох нь харагдаж байна. Иймд өнгөт хувьсгалын "хүч үл хэрэглэх" гэх шинж "сэтгэл санааны хүч хэрэглэх" гэсэн ойлголтыг өөртөө агуулдаг байна.

Өнгөт хувьсгал бол юуны өмнө улс төр, нийгмийн тогтолцоог өөрчлөх зорилготой байдаг ч сонгодог утгаар авч үзвэл хувьсгал биш. Энэ төрлийн эсэргүүцлийн хөдөлгөөн эхэндээ тайван замаар явагдах боловч, цаг тухайд зогсоогоогүй тохиолдолд цуст мөргөлдөөн, зэвсэгт төрийн эргэлт болдог байна.

Эх сурвалжийн жагсаалт:

1. Juan Pablo Mendez Campos. Violent versus Non-Violent Political Protests. A Case Study from the American Civil Rights Movement. 2017.

2. Tim Newburn. Annual Review of Criminology. The Causes and Consequences of Urban Riot and Unrest. Department of Social Policy, London School of Economics and Political Science. London. 2020.

3. А.Батсайхан, Б.Эрдэнэбат. "Хүчирхийллийн бус тэмцэл" гэдгийг яаж ойлгох вэ? Улаанбаатар. 2019.

4. Аббасов Р.Г. Джин Шарп: политологический плагиат или классика цветных революций. Научные ведомости. Серия философия. Социология. Право. 2016. №3.

5. Аюулгүй байдал судлалын хүрээлэн. Интернет холбоос: https://niss.gov.mn/archives/1221.

6. Воронин С.А., Бакина Е.А. Клановая иерархия как основа «тюльпановой революции» в Кыргызстане. Вестник РУДН. Серия: Всеобщая история. (RUDN journal of World History) 2019. №2.

7. Гапич А.Э., Лушников Д.А. Технологии «цветных революций» М, 2014.

8. Ё Бён Мү., Ж.Санжаа нар. Монгол хэлний толь. 2014.

9. Ж.Амарсанаа., Ж.Бямбаа нар. Хууль зүйн тайлбар толь. Legal dictionary. Улаанбаатар. 2003 он.

10.Ж.Шарпын BBC NEWS-т өгсөн ярилцлагаас: https://www.youtube.com/watch?v=h_BA7dmU7R4

11.Керимов А.А., Вербицкая Т.В. Концепция цветной революции в политической науке. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн нэгдсэн сайт cyberleninka.ru. интернет холбоос: https://cyberleninka.ru/article/n/kontseptsi

ya-tsvetnoy-revolyutsii-v-politicheskoy-nauke/viewer

12.Кузьмин В. Роль США в осуществлении цветных революций в зарубежных странах //Зарубежное военное обозрение. 2008. №9.

13.Макаревич Э.Ф., Карпухин О.И. Технологии цветных революций. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн нэгдсэн сайт cyberleninka.ru. интернет холбоос: https://cyberleninka.ru/article/n/tehnologii-tsvetnyh-revolyutsiy/viewer.

14.Макаревич Э.Ф., Карпухин О.И. Технологии цветных революций. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн нэгдсэн сайт cyberleninka.ru. интернет холбоос: https://cyberleninka.ru/article/n/tehnologii-tsvetnyh-revolyutsiy/viewer.

15.Н.Даш., А.Янжиндолгор нар. Монгол хэлний тайлбар толь. 4 дэх хэвлэл. Улаанбаатар. 2016.

16.Ожегов С.И., Шведова Н.Ю. Толковый словарь русского языка. 4-е издание., Доп. М. 2006.

17.С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. Англи, орос, латин, хадмал. Дөрөв дэх хэвлэлт. Улаанбаатар. 2015.

18.Хабриева Т.Я., Чиркин В.Е. “Цветные революции” и “арабская весна” в конституционном измерении. Монография. М. 2019.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДРОН АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

USING DRONES IN POLICING, ITS' NECESSITIES, USAGE IMPLEMENTATION, AND FUTURE CONSIDERATIONS

Б.Мөнгөнтуяа
БНСУ-ын Үндэсний цагдаагийн их сургуулийн Олон нийтийн аюулгүй байдлын тэнхимийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
B.Munguntuya
Korean National Police University, Department of Public Security Master Student, Police Senior lieutenant

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Дроны тухай ойлголт, аюул заналхийлэл, монгол улсын дрон ашиглалтын нөхцөл байдал, хэтийн төлөв, хууль эрх зүйн зохицуулалтын тухай мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дрон ашиглах хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх арга замын талаар авч үзсэн ба цаашид анхаарах асуудал, саналыг дэвшүүлсэн болно.

Abstract: This article discusses the concept of drones, threats, conditions and prospects of drone use in Mongolia, legal regulations, the need for drones in police operations, and ways to implement them, as well as issues to be addressed in the future.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, Дрон, Алба хаагчийн аюулгүй байдал, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, аюул заналхийлэл.

Key word: Police, Drones, Officer Security, Crime Control, Public Safety, Threats.

Дроны тухай ойлголт, үүсэл хөгжил:

Сүүлийн үед аж үйлдвэрийн 3-р хувьсгалаас хойших аж үйлдвэрийн 4-р хувьсгал (Аж үйлдвэр 4.0)-ын тухай хэлэлцүүлэг идэвхжихийн хэрээр нисгэгчгүй онгоцыг сонирхох сонирхол нэмэгдэж байна.

Британийн Оксфордын толь бичигт дрон гэдэг нь "алсын удирдлагатай нисгэгчтэй нисэх онгоц эсвэл пуужин[1]" гэж тодорхойлогддог. Энэхүү үзэл баримтлалд ойртож үзвэл дроныг "алсын удирдлагатай нисэх онгоц ба пуужин" гэсэн утгатай гэж үзэж болно. Оксфордын толь бичгийн тодорхойлолтод үндэслэн ихэнх шинжээчдийн үзэж буйгаар нисгэгчгүй онгоцонд пуужингаас гадна нисгэгчгүй нисдэг тэрэг багтдаг гэж хэлж болно. НҮБ-ын дэргэдэх Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) нь нисгэгчгүй онгоцыг RPAS буюу "Алсын удирдлагатай нисэх онгоцны систем" гэж тодорхойлдог[2]. RPAS нь алсын удирдлагатай агаарын хөлгийн систем бөгөөд үүнд алсын удирдлагатай нисэх онгоц болон түүнтэй холбоотой алсын нисгэгч станц орно.

АНУ-ын Холбооны Нисэхийн Захиргаа (FAA) нь нисгэгчгүй онгоцыг "Зорчигч болон багийн гишүүдийг тээвэрлэхгүй, алсын удирдлагатай, бие даасан удирдлагаар хараанаас гарах чадвартай арилжааны онгоц[3]" гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, "зорчигч" болон "нисгэгч"-ийн аль аль нь нисгэгчгүй боловсон хүчний шалгуурт багтдаг.

Солонгосын Doosan нэвтэрхий толь бичигт дрон гэдэг нь "онгоц эсвэл нисдэг тэрэг хэлбэртэй, хүнгүй, радио

[1] https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/english/

[2] https://www.un.org/en/

[3] https://www.faa.gov/

долгионоор нисдэг нисдэг тэрэг[4]"-ийг хэлдэг. Doosan нэвтэрхий толь нь дронуудын хэлбэрт анхаарлаа хандуулдаг. Дрон нь онгоц, нисдэг тэрэгний хэлбэртэй байх ёстой гэдгийг онцолсон. Толь бичгийн тодорхойлолтоор дрон гэдэг нь зөгий дуугарах эсвэл бага дуугарах гэсэн утгатай. Үүнийг мөн Нисгэгчгүй Агаарын тээврийн хэрэгсэл (UAV) гэж нэрлэдэг.

Нисгэгчгүй онгоц буюу UAV (Unmanned Aerial Vehicles) гэдэг нь нисгэгчгүйгээр радио долгионы удирдамжаар нисэж, удирдаж болох нисэх онгоц эсвэл нисдэг тэрэг хэлбэртэй нисэх онгоцны нэг төрөл[5] юм.

Дроны үүсэл хөгжлийг авч үзвэл XVII зууны үеэс эхлэлтэй гэдэг. Дайны тулалдаанд нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийг ашигласан тухай хамгийн анхны бүртгэгдсэн нь 1849 оны 7-р сарын 24-нд бөмбөлөг тээвэрлэгчтэй нисэх төхөөрөмж байдаг. Германы эрдэмтэн Отто Лилиентал 1891 онд анхны нисгэгчтэй планерыг төхөөрөмжийг бүтээсэн[6] гэж үздэг. Түүний дараагаас 1900-аад оны эхээр Никола Тесла, Уильям Крозиер нар анхны нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийг бүтээжээ. Сүүлийн жилүүдэд дрон технологи үнэхээр өөрийн гэсэн онцлогтой болж, сонирхогчдын дронууд урьд өмнөхөөсөө илүү дэвшилтэт болж, дэлхийд алдартай болсон[7].

Дроныг анх цэрэг, тагнуулын чиглэлээр ашиглах зориулалтаар бүтээсэн ба захидал, илгээмж хүргэх, зураг дарах зэргээр ашигладаг байсан бол өнөөдөр барилгын 3D зураг боловсруулах, бичлэг хийх, гал унтраах, хөрсний бүтэц тодорхойлох, кино үйлдвэрлэл, ашигт малтмалын хайгуул хийх зэрэг бүхий л салбарт ашиглах болжээ.

Дрон гэдэг ойлголтыг хэрэглэх үед нисгэгчгүй онгоцонд зөвхөн тэнгэрт нисдэг биетүүд төдийгүй далайд болон усан дор ажилладаг нисгэгчгүй хөлөг онгоц, нисгэгчгүй шумбагч онгоц, газар дээр ажилладаг нисгэгчгүй машинууд багтах төлөвтэй байна. Хэдийгээр нисгэгчгүй нисэх онгоцны тухай ойлголт өргөжин тэлж магадгүй байгаа ч зарим мэргэжилтнүүд дроныг зөвхөн “газар, усан, усан доогуур тэнгэрт нисдэг нисдэг тээврийн хэрэгслээр хязгаарлах ёстой” хэмээн үзэж байна.

Техник, технологийн хурдацтай хөгжил дэвшлийн өнөө үед дэлхий нийтээрээ “дрон” буюу нисгэгчгүй онгоцыг үйл ажиллагаандаа өргөнөөр хэрэглэх болжээ. Төрийн болон хувийн хэвшлийн бүхий л салбарт дрон буюу зайнаас удирдах нисгэгчгүй онгоцны хэрэглээ улам бүр нэмэгдэж, өргөн хүрээг хамарч байна.

Дэлхийд дроны зах зээлийн дүн 2020 онд 22.5 тэрбум ам.доллар байсан бөгөөд жилийн дундаж өсөлт 9.4 хувь гэж тооцоход 2026 онд хоёр дахин буюу 41.3 тэрбум ам.долларт хүрнэ гэж үздэг.[8]

Түүнийг энгийн хэрэглээнд ашиглагдахаас гадна тусгай зориулалтын байдлаар өргөн

[4] https://www.urbandictionary.com/define.php?term=Dron

[5] Tice, Brian P. (Spring 1991). "Unmanned Aerial Vehicles – The Force Multiplier of the 1990s". Airpower Journal. Archived from the original on 24 July 2009. Retrieved 6 June 2013.

[6] Anderson, John D. A History of Aerodynamics and Its Impact on Flying Machines. Cambridge, UK: Cambridge University Press, 2001, First edition 1999.

[7] https://www.propelrc.com/history-of-drones/

[8] Дэлхийн дроны зэх зээлийн судалгаа эрхэлдэг DRONII (Drone Industry Insights)-ийн дүгнэлт https://droneii.com/product/drone-market-report

хэрэглэгдэж, хүний үйл ажиллагаагаар тодорхойлох боломжгүй нөхцөл байдал, эрсдэлийг өндөр нарийвчлалтай тогтоохын зэрэгцээ энтертайнмент, хөдөө аж ахуй, боловсрол, батлан хамгаалах, цэрэг, цагдаа, онцгой байдлын байгууллага, уул уурхай, үйлчилгээ, байгаль орчин хамгаалал, барилга, хот байгуулалт, зам тээврийн салбар гэх мэт олон салбарт илүү өргөнөөр ашиглагдаж байна.

Зарим орнууд дрон ашиглаж гадаад орнуудын хилийн аюулгүй байдал, төрийн захиргааны байр, улсын онц чухал дэд бүтцэд хамаарах барилга байгууламж, цэргийн стратеги, барилга, техникийн аюулгүй байдал, атомын цахилгаан станц, хорих анги зэрэг онц чухал объектын зураг, бичлэгийг хийх зэргээр тагнуулын салбарт дроныг ашиглаж, улс орны үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй аюул заналыг учруулж байна.

Дрон үйлдвэрлэлийн олон компани байгаа хэдий ч дэлхийн дроны зах зээлийн худалдааны 75 хувийг "DJI[9]" компани хангаж байна. Уг үйлдвэр нь иргэний болон цэргийн техникийг үйлдвэрлэдэг байна.

Иймээс улс орны хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллагуудад энэхүү төрлийн нисэгчгүй онгоц/дрон гол эмзэг газруудад нэвтэрч орохоос хамгаалах, хариу арга хэмжээ авах шаардлага бий болж байна. Улс орнууд эдгээр нисгэгчгүй онгоцыг олж тогтоох, саармагжуулах дроны эсрэг технологи буюу Anti-Drone системийг[10] ашиглаж байна. Тиймээс улс орнуудын антидроны тухай нэгдсэн ойлголтыг бий болгох, үр дүнтэй хариу арга хэмжээ авах тогтолцоог бий болгох судалгааг олон улсын түвшинд судалж байна[11].

Үндэсний аюулгүй байдлын хангах ажлын хүрээнд бид өөрсдийн орны төрийн нууцтай холбоотой болон онц чухал объектын хил хязгаарыг тогтоож түүний дээгүүр нисгэгчгүй төхөөрөмж ажиллуулахгүй байх хоригийг тавих нь юу юунаас илүү чухал билээ. Иймд Anti-Drone системийг төрийн эрх бүхий байгууллагаас ажиллуулах шаардлага тулгарч байна.

Эрх зүйн орчин:

Дрон ашиглах, газар нутгийн хязгаар, хориглолт, зөвшөөрөл авах, хяналт тавих, зөрчсөн үйлдэлд хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулах журам өнөөдрийн байдлаар манай улсад хараахан батлагдаагүй байна. Энэхүү зохицуулалтыг тусгасан журмыг батлахын тулд юуны түрүүнд Агаарын аюулгүй байдлын тухай хуулийг шинээр батлах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Яагаад гэвэл захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуулийн 59.1 дэх хэсэгт "Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно" гэж, мөн зүйлийн 59.2 дахь хэсэгт " Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхээ бусад

[9] https://www.dji.com/

[10] Нисгэгчгүй онгоцыг хянах, таслан зогсооход зориулагдсан систем буюу UAV эсрэг технологи.

[11] Kang Wook. A Study on the Establishment of Anti-Drone Concept and Effective Response System. 2019.

этгээдэд шилжүүлэхийг хориглоно[12]" гэж тус тус заажээ.

Харин захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлагыг Захиргааны ерөнхий хуулийн 60.1.3 хэсэгт "тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх" гэж заасан.

Иймээс дээрх журмыг батлахын хууль хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл шинээр батлах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Хүлээлгэх хариуцлагын хувьд Зөрчлийн тухай хуулийн 6.22 дугаар зүйлд "Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх"[13] зөрчил, Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйлд "Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах"[14] гэмт хэргийг тус тус хуульчилж өгчээ.

Цагдаагийн байгууллага ба дрон:

Монгол улсын цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд шинжлэх ухаан технологийн хөгжил дэвшлийг үйл ажиллагаандаа зайлшгүй нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Бид өөрсдийн үйл ажиллагаанд нисгэгчгүй онгоцны хэрэглээг нэвтрүүлснээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, терроризмыг таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлж, нотлох баримт цуглуулах, цаг хугацаа хэмнэх, ажиллах хүн хүчний хөдөлмөрийг хөнгөвчлөх ач холбогдолтой билээ.

Тиймээс бид цаг үетэйгээ хөл нийлүүлж цагдаа, дотоодын цэргийн үйл ажиллагаанд түлхүү ашиглах хэрэгцээ шаардлага нэмэгдэж байна. Одоогийн байдлаар цагдаагийн байгууллагын хэмжээнд 24 дрон ашиглагдаж байна. Үүнээс 8 нь орон нутгийн цагдаагийн байгууллагуудад, үлдсэн 16 нь нийслэл хотод ашиглагдаж байна.[15]

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд дрон ашиглах нь ихээхэн үр дүнд хүргэх аргуудын нэг юм. Тухайлбал хүн барьцаалсан гэмт хэрэг, терроризмтой тэмцэхэд гэмт этгээдийн байрлал, газар орны нөхцөл байдлыг тодруулахад ашиглагдаж болох юм.

Мөн хэргийн газрын үзлэгийг хийхэд гарч байсан алдаа дутагдлаас харахад дарга албан тушаалтай хүмүүс хэргийн газарт нэвтэрч гэмт хэргийн ул мөрийг устгаж тухайн хэргийг илрэхэд саад болж байсан тохиолдол бий. Тиймээс хэргийн газрын нөхцөл байдлыг дрон ашиглан удирдах бүрэлдэхүүнд харуулж, чиглэл авч

12 Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016 он №1.

13 Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авсан, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14 Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

15 Цагдаагийн ерөнхий газрын тайлан. 2021 он. https://police.gov.mn/

ажиллах нь цэвэрхэн бөгөөд зөв шийдэл юм.

Хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, аливаа жагсаал, цуглааны хамгаалалтын үед цагдаагийн байгууллагаас дрон ашиглаж болсон үйл явдал, гэм буруутай этгээдийн үйлдлийг баримтжуулж авахад дөхөм болох юм.

Цаашид цагдаагийн байгууллагаас өөрийн үйл ажиллагааг хурдан шуурхай, тасралтгүй, явуулж зөв төлөвлөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд дроны ашиглалтыг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Хүний эрх:

Цагдаагийн байгууллага нь хуульд заасан чиг үүргээ биелүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж бусдын орон байранд нэвтрэх, халдашгүй байдлыг хангаж ажиллах ёстой.

Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд иргэн хуулийн этгээдэд нисэгчгүй нисэх төхөөрөмж буюу дрон ашиглах зөвшөөрөл өгөх зохицуулалт хуулиар олгогдоогүй байгаа нь ихээхэн хүндрэл учруулж байна.

Дээрх хуулийн заалтаас үзвэл нисэгчгүй нисэх төхөөрөмж буюу дрон ашиглан иргэдийн орон байрны дүрс бичлэгийг хийхдээ аль нэг субъектээс зөвшөөрөл авах зохицуулалт байхгүй байна. Энэ Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон орон байрны халдашгүй чөлөөтэй байх эрхийг нь хангахгүй байгаагийн илрэл юм.

Энэхүү өгүүллэгийн хүрээнд доорх дүгнэлтийг хийж байна.

1. Агаарын аюулгүй байдлын тухай хуулийг батлах. Түүнтэй уялдуулан дроны ашиглах, газар нутгийн хязгаар, хориглолт, зөвшөөрөл авах, хяналт тавих, зөрчсөн үйлдэлд хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулах журмыг баталж эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

2. Гэмт хэрэг илрүүлэх, нотлох баримтыг бэхжүүлж авах, хэргийн газрын үзлэг хийх, терроризмыг таслан зогсоох, хүн барьцаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, жагсаал цуглаан зохион байгуулах, экологийн эсрэг гэмт хэргийг шалгах, нийтийн хэв журам хамгаалах зэрэг цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дроныг ашиглах нь цаг хугацаа, хүн хүчний хуваарилалт, ачаалал зэргийг хөнгөвчлөх ач холбогдолтой билээ.

3. Нисэгчгүй нисэх төхөөрөмж буюу дрон ашиглахдаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн иргэдийн орон байрны зураг, дүрс бичлэгийг хийхдээ аль нэг субъектээс зөвшөөрөл авах зохицуулалт байхгүй байна. Энэ Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон орон байрны халдашгүй чөлөөтэй байх эрхийг нь хангахгүй байна.

4. Үндэсний аюулгүй байдлын хангахдаа төрийн нууцтай холбоотой захиргааны болон онц чухал объектын хил хязгаарыг тогтоож түүний дээгүүр нисгэгчгүй төхөөрөмж ажиллуулахгүй байх хоригийг тавьж Anti-Drone системийг төрийн эрх бүхий

байгууллагаас ажиллуулах шаардлага тулгарч байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Монгол Улсын агаарын аюулгүй байдлын тухай хууль”-ийг батлах, түүнтэй уялдуулж “дроны ашиглах, түүнд хяналт тавих журам”-ыг батлах;

2. Цагдаагийн байгууллагаас өөрийн үйл ажиллагаандаа дроныг түлхүү ашиглаж цаг хугацаа, хүн хүчний хуваарилалт, ажлын ачаалал зэргийг хөнгөвчлөх;

3. Дроныг иргэн хуулийн этгээд, төрийн байгууллагаас хэрэглэх, ашиглахдаа хүний эрх эрх чөлөөг хүндэтгэж, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангаж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах;

4. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон орон байрны халдашгүй чөлөөтэй байх эрхийг нь хангахын тулд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хүлээлгэх хариуцлагыг тусгаж өгөх;

5. Үндэсний аюулгүй байдлын хангахад Anti-Drone системийг ашиглах.

Ашигласан ном зүй

1. Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016 он №1.

2. Anderson, John D. A History of Aerodynamics and Its Impact on Flying Machines. Cambridge, UK: Cambridge University Press, 2001, First edition 1999.

3. Kang Wook. A Study on the Establishment of Anti-Drone Concept and Effective Response System. 2019.

4. Tice, Brian P. (Spring 1991). "Unmanned Aerial Vehicles – The Force Multiplier of the 1990s". Airpower Journal. Archived from the original on 24 July 2009. Retrieved 6 June 2013.

5. Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны сайт.https://police.gov.mn/

6. Дэлхийн дроны зэх зээлийн судалгаа эрхэлдэг DRONII (Drone Industry Insights)-ийн дүгнэлт https://droneii.com/product/drone-market-report

7. https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/english/

8. https://www.un.org/en/

9. https://www.faa.gov/

10.https://www.urbandictionary.com/define.php?term=Dron

11.https://www.propelrc.com/history-of-drones/

12.https://www.dji.com/

ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТНЫ АЖЛЫН ДҮН МЭДЭЭГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ХАМААРАХ ХҮЧИН ЗҮЙЛ

EXECUTIVE EMPLOYEE RESULTS IMPROVED FACTORS TO BE MADE

Л.Энхтуяа
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах ахлагч
L.Enkhtuya
Graduate student of the University of Internal Affairs, senior police chief

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Эрүүгийн цагдаагийн албаны алба хаагчийн ажлын дүн мэдээг дүгнэсэн байдалд судалгаа явуулж, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, үйлдэгдсэн гэмт хэрэг, түүний дотор хүнд хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, ажлын дүн мэдээг боловсронгуй болгох талаар тусгасан болно.

Abstract: This article examines the activities of criminal police officers, analyzes the size of the territory, the number of people, the situation of crimes committed, including the most serious cases, and further improves the work.

Түлхүүр үг: Эрүүгийн цагдаагийн алба, гүйцэтгэх ажилтан, гэмт хэрэг, хүнд гэмт хэрэг, нутаг дэвсгэр, хүн ам, ажлын дүн мэдээ.

Keywords: Criminal police department, criminal detective, crime, serious crime, territory, population, job results.

Удиртгал

Аливаа төрт улсын дотоод аюулгүй байдлыг хангах, иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүргийг үе үеийн цагдаагийн алба хүлээж ирсэн. Цагдаагийн байгууллага нь үүсэн байгуулагдсан цагаасаа хойш улс орны нийгэм, төрийн байгууламжийн хөгжлийн бүхий л үе шатуудад хөгжиж, бэхжиж ирсэн Монгол төрийн ууган байгууллагын нэг юм.[1]

Ард түмний амь бие, эд хөрөнгөд халдагсадтай тэмцэх, хэв журам, энх амгалан байдлыг сахиулах үүрэг бүхий “Сэргийлэх цэргийн салаа”[2] -г 1921 онд байгуулсан нь шинэ үеийн цагдаагийн байгууллагын үүсэл болжээ.

Өнөөдөр Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн[3] бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үндэс нь Эрүүгийн цагдаагийн алба юм.

Эрүүгийн цагдаагийн алба нь Цагдаагийн ерөнхий газрын шууд удирдлагын дор Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан далд аргаар үйлдэгдсэн эсхүл тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүний үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч шүүгдэгч, яллагдагч, прокурор шүүхээс даалгасан буюу хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум, хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансуурууллах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт

[1] Zasag.Mn. Цагдаагийн Байгууллагын Түүхэн Замнал
[2] Ардын Засгийн газрын 1921 оны 6 дугаар хурлын тогтоол
[3] Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

болон бусад үнэт зүйлийг эрж олох зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажиллагааг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байгаа эрүүгийн тагнуулын байгууллага юм.[4]

Үндсэн хэсэг

Улсын хэмжээнд 2017 онд 32259, 2018 онд 36220, 2019 онд 31524, 2020 онд 23064, 2021 онд 25429 гэмт хэрэг тус тус бүртгэгдэж[5], сүүлийн 5 жил гэмт хэргийн гаралт тогтмол өсөлттэй байсан боловч нийгэм, эдийн засаг, цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2020 оноос буурсан үзүүлэлт байгаа ч Цагдаагийн байгууллага, тэр дундаа Эрүүгийн цагдаагийн албаны ачаалал байнга өсч байна.

Тодруулбал: Монгол Улсад явагдаж байгаа хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаас хойш Гүйцэтгэх ажилтнууд Мөрдөн шалгах ажиллагааг явуулах болсон.

Энэ өөрчлөлттэй холбогдуулан Эрүүгийн цагдаагийн албаны “гүйцэтгэх ажилтан-эрүүгийн мөрдөгч” нарын ажлын ачаалал эрс ихэсч, ажлын дүн мэдээг гаргах, алба хаагчийн хийсэн ажлыг дүгнэх үзүүлэлтийг боловсронгуй болгон шинэчлэн, ашиглаж байна.

Судлаачийн хувьд өнөөдөр цагдаагийн алба хаагчийн, тэр дундаа гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг шууд утгаар нь хэрэгжүүлж байгаа эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгчийн ажлын дүн мэдээг улсын хэмжээнд дүгнэж, жагсааж байгаа арга, хэлбэр нь тус албаны алба хаагчдын ажлын үзүүлэлтийг бодитой дүгнэхгүй, хэтэрхий хуучинсаг байна гэж үзэж байна.

Байгууллагын зүгээс алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэсэн бол түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, алба хаагчдын ажлыг үнэлсэн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, цалин хөлс олгох, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, сургалтад хамруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Ингэснээр алба хаагчдын ажлын идэвх сайжирч, ажлын бүтээмж нэмэгдэх ач холбогдолтой.

Хүний нөөцийн нэг томоохон функц бол яах аргагүй алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт буюу ажлын гүйцэтгэлийг үнэлэх асуудал байдаг. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг нь байгууллагын зүгээс ажилтан бүрд өөрт ногдсон үүрэг даалгавраа хэрхэн биелүүлж, ямар үр дүнд хүрч байгаа түүний ур чадвар, мэргэшлийн бэлтгэл, ажлын ачаалал ямар байгааг дүгнэх үйл явц юм.[6]

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний гол зорилго нь:

[4] С.Жанцан. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо. Уб.2005. 162 дахь тал

[5] Үндэсний статистикийн газрын мэдээлэл. Уб., 2021. 18 дахь тал

[6] hrconsulting.mn. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний тухай

- Ажил үүргээ ямар түвшинд гүйцэтгэж байгаа талаар удирдлага ба алба хаагчид бодитой мэдээлэлтэй болох;
- Сургах хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- Цалин хөлс болон нэмэлт шагнал урамшуулал олгох, шийтгэл ногдуулах бодит үндэслэлийг тогтоох;
- Гүйцэтгэлийг сайжруулах;
- Алба хаагчдыг илүү ололт, амжилт гаргахад нь идэвхжүүлэлт болдог.

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ гэж товчоор хэлбэл ажилтны ажил үүргийн биелэлтийг дүгнэх албан ёсны үнэлгээ байдаг.[7]

Одоогийн цагдаагийн алба хаагчдын ажлыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-ын дагуу хагас, бүтэн жилээр үнэлж байгаа. Эрүүгийн цагдаагийн албанд ажилладаг алба хаагчдын ажлыг үнэлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ гэж “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-д заажээ. Тодруулбал:

- Мэдээлэл цуглуулах гүйцэтгэх ажилтны ажил дүгнэх үзүүлэлт /маягт ЦБҮАЖ №111.4181.д/;
- Мөрдөн сурвалжлах гүйцэтгэх ажилтны ажил дүгнэх үзүүлэлт /маягт ЦБҮАЖ №111.4181.е/;
- Мөрдөн тагнах гүйцэтгэх ажилтны ажил дүгнэх үзүүлэлт /маягт ЦБҮАЖ №111.4181.ж/[8].

Гэсэн хэдий ч манай улсын онцлог, нутаг дэвсгэр, хүн ам сийрэг, дэд бүтэц муу, оршин суугчдын дийлэнх нь уламжлалт нүүдлийн хэв маягаар амьдарч байгаа газар ажиллаж байгаа алба хаагчийн ажлын үзүүлэлтийг төв, суурин газарт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчидтай харьцуулан үнэлэх нь алба хаагчдын ажлын үр дүнг тооцоход бэрхшээл учруулж байгааг анхаарахгүй орхигдуулж болохгүй юм.

Уг ажлын ачааллын талаар шинжлэх ухааны доктор Ж.Болдбаатар “Улсын хэмжээнд эрүүгийн мөрдөгч (чиглэлийн ахлах, эрүүгийн ахлах мөрдөгчийн тоо ороогүй) 800 орчим алба хаагч ажиллаж байна. 2015 оны Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө нийслэлд нэг эрүүгийн мөрдөгч сард дунджаар 5 хэрэг, орон нутгийн эрүүгийн мөрдөгч сард 2 хэрэг шийдвэрлэж гүйцэтгэх ажлын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулах, бусад арга хэмжээг зохион байгуулж байсан бол 2017 оны 07 дугаар сарын 01-нээс хойш нийслэлд ажиллаж байгаа нэг эрүүгийн мөрдөгч сард дунджаар 7-8 хэрэг, орон нутагт ажиллаж байгаа эрүүгийн мөрдөгч сард 3 хэрэг шийдвэрлэж мөн давхар хэрэг бүртгэлтийн 60-180 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна”[9] гэж ажлын ачаалал харилцан адилгүй байгаа талаар дурджээ.

Гэсэн ч Улсын хэмжээнд эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нарыг нэг үнэлгээгээр үнэлж байгаа нь харьцангуй байна гэдгийг дараах судалгаа харуулж байна.

Зөвхөн 2021 онд үйлдэгдсэн гэмт хэрэг, хүнд хэрэг, тухайн газар, хэлтэст ажиллаж байгаа гүйцэтгэх ажилтан нарын ажлын ачааллыг харьцуулахад

[7] Нямсүрэн Д. “Хүний нөөцийн менежментийн функц”. Уб. 2015. 118 дахь тал

[8] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб.2018. 86 дахь тал

[9] Ж.Болдбаатар: Мөрдөгчдийн ажлын ачаалал ихсэж байна - Eguur.MN

/хавсралт 1, 2/ дараах нөхцөл байдалтай байна.

Хавсралт №1.

Улаанбаатар хотын цагдаагийн газар хэлтэс, албад болон чиглэл хариуцсан газар, хэлтсийн 2021 оны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ

№	Нутаг дэвсгэр	Нутаг дэвсгэрийн хэмжээ /км^2/	Хүн ам	Нийт гэмт хэрэг	Хүнд гэмт хэрэг	Хамаарлыг харуулсан байдал
				2021 он		
1	Багахангай	140000	4100	20	2	**1441.2**
2	Багануур	620200	28600	163	16	**1298.0**
3	СХД 3 хэлтэс	1200600	257556	624	83	**1215.7**
4	Налайх	687600	37600	279	38	**1036.5**
5	СХД 2 хэлтэс	1200600	257556	810	150	**911.9**
6	СХД 1 хэлтэс	1200600	257556	1469	259	**695.2**
7	ХУД 1 хэлтэс	484700	119843	1244	100	**504.9**
8	ХУД 2 хэлтэс	484700	119843	801	84	**432.4**
9	БЗД 3 хэлтэс	124400	336932	1120	156	**308.4**
10	БЗД 2 хэлтэс	124400	336932	1684	196	**257.3**
11	БЗД 1 хэлтэс	124400	336932	1413	128	**243.6**
12	СБД 1 хэлтэс	208400	144400	1513	108	**208.5**
13	СБД 2 хэлтэс	208400	144400	772	119	**186.2**
14	ЧД 2 хэлтэс	89300	153117	989	107	**152.2**
15	ЧД 1 хэлтэс	89300	153117	875	75	**143.2**
16	БГД 2 хэлтэс	29500	192614	1436	67	**139.8**
17	БГД 1 хэлтэс	29500	192614	1322	83	**124.2**

Хавсралт №2.

Хөдөө орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 2021 оны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ

№	Нутаг дэвсгэр	Нутаг дэвсгэрийн хэмжээ /км^2/	Хүн ам	Нийт гэмт хэрэг	Хүнд гэмт хэрэг	Хамаарлыг харуулсан байдал
				2021 он		
1	Өмнөговь	165400	71248	453	71	**91.2**
2	Баян-Өлгий	45700	105853	187	52	**84.3**
3	Говь-Алтай	141400	58343	231	45	**83.3**
4	Сүхбаатар	82300	64307	344	55	**77.4**

5	Дорнод	123600	83473	536	117	**76.9**
6	Орхон	844	105361	504	81	**71.2**
7	Дорноговь	109500	71233	490	88	**64.8**
8	Увс	69600	84294	239	54	**64.2**
9	Ховд	76100	88974	416	61	**63.7**
10	Өвөрхангай	62900	116785	458	112	**62.2**
11	Дундговь	74700	47274	245	55	**61.1**
12	Ховд аймгийн Булган	8104	9266	65	6	**58.1**
13	Архангай	55300	95067	412	94	**58.0**
14	Дархан-Уул	3300	103580	543	67	**56.6**
15	Булган	48700	61516	388	76	**55.3**
16	Хэнтий	80300	78507	540	125	**55.0**
17	Дорноговь аймгийн Замын-үүд	486.8	14473	160	24	**50.5**
18	Завхан	82500	73231	367	59	**50.4**
19	Сэлэнгэ	41200	108370	637	78	**45.5**
20	Завхан аймгийн Тосонцэнгэл	5300	7881	113	13	**44.4**
21	Баянхонгор	11600	89329	428	76	**42.3**
22	Сэлэнгэ аймгийн Мандал	484.3	25562	204	26	**37.5**
23	Говьсүмбэр	5500	18008	135	19	**33.8**
24	Хөвсгөл	100600	136058	716	94	**32.4**
25	Төв	7400	93332	611	87	**31.7**
26	Төв аймгийн Заамар	2900	5280	139	22	**27.8**
27	Өмнөговь аймгийн Цогтцэций	7246	4042	201	17	**23.0**
28	Өвөрхангай аймгийн Хархорин	2241	13613	129	21	**22.9**
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр	144	8883	97	14	**22.8**

Судалгаанаас үзэхэд:

- Нийт хэргийн гаралт, хүнд хэрэг алба хаагчдын орон тоо, илтэд харьцангуй буюу ажлын ачаалал эрс зөрүүтэй,
- Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, алба хаагчийн орон тоо

- Хөдөө орон нутагт амьдарч байгаа иргэд, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг нөлөөлөх хүчин зүйл илэрхий

- Тодорхой чиглэл дагнасан алба, нэгжийн үйл ажиллагаа бусад цагдаагийн газар, хэлтэстэй харьцуулах боломжгүй зэрэг нөхцөл байдлыг судалгааны үр дүн харуулж байна.

Тодруулбал хөдөө орон нутагт нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн ам, 2021 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг, үүнээс хүнд гэмт хэрэг, алба хаагчийн батлагдсан орон тооны хамаарлаар нөхцөл байдлыг харуулахад:

- Өмнөговь, Баян-Өлгий, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод, Орхон аймаг дахь цагдаагийн газрууд нь 71,2-91,2 хүртэл оноогоор ягаан буюу дээгүүр түвшинд,

- Дорноговь, Увс, Ховд, Өвөрхангай, Дундговь, Ховд аймгийн Булган сум, Архангай, Дархан-Уул, Булган, Хэнтий, Дорноговь аймгийн Замын-Үүд, Завхан аймаг дахь цагдаагийн газрууд нь 50,4-64,8 хүртэл оноогоор цэнхэр буюу дунд түвшинд

- Сэлэнгэ, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Говьсүмбэр, Хөвсгөл, Төв, Төв аймгийн Заамар сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум зэрэг голцуу сум дундын цагдаагийн хэлтсүүд нь 22,8-45,5 хүртэл оноогоор ногоон буюу доогуур түвшинд бусад аймгуудын цагдаагийн газар, хэлтсүүдээс эрс ялгаатай байна.

Нийслэлд Багахангай, Багануур, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 3 дугаар хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийг дээр дурдсан хамаарлаар үзэхэд 1036,5-1441,2 хүртэл оноотой, хөдөө орон нутагтай харьцуулагдахгүй, эрс ялгаатай байна.

Мөн Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Хан-уул дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Хан-уул дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3 дугаар хэлтэс нь 308,4-911,9 хүртэл оноотой, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Баянгол дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс нь 124,2-257,3 хүртэл оноотой байна.


Нутаг дэвсгэр хариуцдаггүй мэргэшсэн цагдаагийн албад буюу Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Хар тамхитай тэмцэх газар, Тээврийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газруудыг дүүрэг, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдийн ажилтай харьцуулах боломжгүй байна.

Тодруулбал, Нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалан аль нэг суманд хэрэг, төвөг гардаггүй тайван газарт хэсгийн төлөөлөгчийн ажил дүгнэх үзүүлэлтийг, төв суурин газар ажиллаж байгаа алба хаагчийн нэгэн адил дүгнэх нь харьцангуй ойлголт юм. Тухайн хэрэг гардаггүй сум нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайн явуулж байна гэж дүгнэгдэж байгаа ч үндсэн ажлыг гэмт хэргийн илрүүлэлтээр дүгнэхэд гэмт хэрэг, зөрчил бараг гардаггүйгээс болж илрүүлсэн хэргээр нь улсын хэмжээнд

жагсаахад сүүлийн байранд орж, сануулах, цалингийн хувь хасуулах зэрэг сахилгын шийтгэл хүлээхэд хүрч байгаа тул эрүүгийн мөрдөгчийн ажлыг дүгнэх аргыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Судалгааны ажлын хүрээнд тодорхой эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нартай ажлын дүн мэдээг тайлагнаж байгаа, албан дээр нэгтгэн дүгнэж байгаа байдлын талаар ярилцлага явуулахад 70 хувь нь ажил дүгнэх үзүүлэлтийг сайжруулж, боловсронгуй болгох шаардлагатай, уг ажиллагааг хийхдээ заавал нутаг дэвсгэр, гэмт хэргийн гаралт зэргийг харгалзан үзэж хийх ёстой гэж хариулж байсан бол 20 хувь нь тийм шаардлага байхгүй гэж хариулж байсан бол 10 хувь нь буюу шинээр томилогдсон алба хаагчид тухайн асуудлыг сайн мэдэхгүй тул, хариулах боломжгүй байна гэж хариулж байсан.

График 1. Эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нартай хийсэн ярилцлагын үр дүнг харьцуулсан судалгаа.



Дүгнэлт. Энэ нь цагдаагийн байгууллагын тодорхой алба, нэгжийн онцлог, гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалан эрхэлж буй албан тушаалтай холбоотой нэмэлт үүргийг харгалзан алба хаагчид, тэр дундаа эрх бүхий алба хаагчдын ажлын дүн мэдээг гаргаж байгаа нь хангалтгүй, харьцуулалт буруу хийгдэж байна гэж судлаачийн үүднээс үзэж байна.

Эрүүгийн мөрдөгчийн ажлын дүн мэдээг дүгнэх арга нь нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын тоо, гэмт хэргийн гаралт, байршил зэргээс шалтгаалан өөр, өөр байгаа нь цаашид энэхүү асуудлыг авч үзэх шаардлага байна гэж үзэх үндэс байна.

Санал. Эрүүгийн эрх бүхий алба хаагчдын ажлын дүн мэдээг дүгнэх аргыг боловсронгуй болгох дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Ажил дүгнэх үзүүлэлтийг алба, Улаанбаатар хот, хөдөө орон нутаг гэсэн 3 өөр шалгуур үзүүлэлтээр гаргадаг болох;

2. Хөдөө орон нутаг, тэр дундаа сум дундын цагдаагийн хэлтсүүд, хэсгүүдийг хооронд нь харьцуулан дүгнэдэг болох;

3. Бүсчилсэн байдлаар газар нутаг, хүн амын тоо, үйлдэгддэг гэмт хэрэг, тэр дундаа хүнд гэмт хэрэг, орон тооны нөхцөл байдлыг харгалзан үзэж, хамаарлыг тогтоон, адил төсөөтэй байдлыг харгалзан дүгнэх шинэ арга хэлбэрийг нэвтрүүлэх.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он, УБ

2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб.2018. 86 дахь тал

3. Ардын Засгийн газрын 1921 оны 6 дугаар хурлын тогтоол

4. Үндэсний статистикийн газрын мэдээлэл. УБ., 2021. 18 дахь тал

5. С.Жанцан. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо. 2005 он, УБ.

6. Нямсүрэн Д. “Хүний нөөцийн менежментийн функц”. УБ. 2015.

7. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний тухай (hrconsulting.mn)

8. Цагдаагийн Байгууллагын Түүхэн Замнал (Zasag.Mn)

9. Ж.Болдбаатар: Мөрдөгчдийн ажлын ачаалал ихсэж байна - Eguur.MN

ХОРОО ХАРИУЦСАН ЭРҮҮГИЙН МӨРДӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

ХОРОО ХАРИУЦСАН ЭРҮҮГИЙН МӨРДӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

Д.Бат-Орших
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахмад
D. Bat-Orshikh
University of Internal Affairs, Post-graduate student, Police capitan

Хураангуй: Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн үйл ажиллагаа нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын харьяалах нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг олж тогтоох, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр ажилладаг.Энэхүү өгүүлэлд хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, ажлын ачаалал, тулгамдаж буй асуудал, ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох талаар тусгасан.

Abstract: The activities of the criminal investigator in charge of the Commission are aimed at detecting, detecting and suppressing crimes committed in secret in the territory of the police in charge of the territory. and job descriptions.

Түлхүүр үгс: Эрүүгийн мөрдөгч, хороо, ажил, хууль, тодорхойлолт, ажлын ачаалал

Key words: Criminal detective, committee, job, law, definition, workload

Эрх зүйн зохицуулалтын асуудал

Хууль, тогтоомжийг нийгмийн хөгжилтэй уялдуулан боловсронгуй болгох асуудал нь тасралтгүй байнгын шинжтэй, цагийн зүүний хүрд мэт эргэлдэн хэрэгжих үйл явц бөгөөд хууль тогтоомжийг шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах зэргээр төгөлдөржүүлэн нийгмийн харилцааг зохицуулан, хэрэгцээ шаардлагыг хангаж байх зүй тогтолтой. 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль нь тухайн нийгмийн харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх, амьдралд хэрхэн нийцэн хэрэгжиж байгаа байдал, Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчдийн ажилд яаж нөлөөлж байгаа зэрэгт зарим судалгаа явуулж санал бодлоо хуваалцахыг зорилоо.

Нийслэл Улаанбаатар хотод Монгол Улсын нийт хүн амын 50 хувиас дээш хувь нь ажиллаж амьдарч байгаа боловч жилд бүртгэгдэж байгаа нийт гэмт хэргийн 60 хувь нь Нийслэл хотын дүүргүүдэд үйлдэгддэг. Засаг захиргааны анхан шат болох хорооны нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдсэн, зохион байгуулалттай, захиалгаар үйлдэгдсэн гэмт хэргүүд гарч түүнтэй тэмцэх асуудалд тодорхой хүндрэлүүд үүсдэг. Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн нэг нь гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох явдал юм. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн гаралт тоо корона вирустэй холбоотой жилээс жилд буурч байгаа хэдий ч хүнд, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн тоо өсч түүнийг мэргэжлийн

өндөр ур чадвараар илрүүлэх гэмт этгээдийг олж тогтоох нь цагдаагийн байгууллагын нэн тэргүүний чухал зорилт болоод байгаа билээ.

Өмнө нь мөрдөгдөж байсан Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар Эрүүгийн цагдаагийн алба, ажилтан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заагдсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрхгүй. Харин 2017 онд хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, албан тушаалын нэршил өөрчлөгдсөнөөр Эрүүгийн төлөөлөгч гэх нэршлийг Эрүүгийн мөрдөгч болгон өөрчилж хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн нөхцөл үүссэн бөгөөд практикт хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, харъяалалын дагуу шилжүүлэх ажиллагаануудыг хийж хэрэгжүүлж ажиллаж байгаа нь Гүйцэтгэх ажлын чиглэлийн ажил, арга хэмжээ сүүлийн 3 жилийн хугацаанд буурч гэмт хэрэг илрүүлэх нууц далд аргаар үйлдэгдэж байгаа хэргийг Гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлэх, туслах хүчний сүлжээ зохион байгуулах ажил чанаргүйдсэн үзүүлэлттэй байгаа нь Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн хувьд тулгамдаж буй асуудлуудын нэг болоод байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар бүлэгт заасан Хэрэг бүртгэлтийн ажиллагааг Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч явуулж байна. Өнөөдрийн байдлаар эрүүгийн мөрдөгч нь зөвхөн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гомдол мэдээлэл, хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бөгөөд хуульд хэрэг бүртгэлтийн хэргийг түдгэлзүүлэх үндэслэл байхгүй мөн эзэнгүй хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл хугацааг сунган мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа нь гар дээрх хэрэг бүртгэлтийн хэрэг нэмэгдэх шалтгаан нөхцөл болж байна.

Хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоосон эрүүгийн мөрдөгч нь ЭХХШТХ-ийн 30.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагчаар татах хүн хуулийн этгээд хаана байгаа тодорхой бол Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг прокурорт гаргаж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31, 32 дугаар бүлэгт заасан Мөрдөн байцаалтын ажиллагааг Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааг цааш явуулж байна.

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн эрх зүйн зохицуулалт, ажил үүргийн онцлогийг болон хариуцсан нутаг дэвсгэртээ гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохион явуулах үндсэн суурь болох гүйцэтгэх ажлын нөхцөл байдлын ойлголт, шинж бүрдлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, үнэлэн дүгнэснээр Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчөөс хариуцсан хороо, харьяа дүүрэгтээ гүйцэтгэх ажлын сүлжээг зөв зохион байгуулах, хүч хэрэгслийг оновчтой байршуулах, нууц далд, зохион байгуулалттайгаар үйлдэгдсэн гэмт хэргийг хариуцсан нутаг дэвсгэртээ илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон үйлдсэн байж болох сэжигтэй этгээдүүдийн талаарх мэдээ, мэдээллийг олж авах зэргээр эрүүгийн тагнуулын арга хэмжээг зохион явуулах асуудлыг боловсронгуй болгоход хувь

нэмрээ оруулах зорилгоор уг сэдвийг сонгон авсан нь энэхүү өгүүллийн гол ач холбогдол билээ.

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн үйл ажиллагааны асуудал

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нь Нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн тасагт харяалагдадгаараа бусад алба нэгжийн эрүүгийн мөрдөгчидөөс онцлогтой байдаг жишээ нь Хар тамхитай тэмцэх газрын эрүүгийн мөрдөгч зөвхөн хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр ажилладаг бол Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эзэнгүй хэрэг шалгахаас гадна сэжигтэй этгээдүүд, сэжигтэй объектын судалгааг хийж мөн өөрийн нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдэж байгаа болон үйлдхээр бэлтгэж байгаа бүхий гэмт хэргийг Эрүүгийн цагдаагийн албаны чиглэл хариуцсан хэлтэс тасагтай хамтарч илрүүлэх таслан зогсоох чиглэлийн ажлыг хийдэг учир албан тушаалын хувьд маш их туршлага хуримтлуулах боломжтой хамгийн их ачаалал авч ажилладаг нэгж юм.

2017 оны 07-р сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотойгоор Цагдаагийн байгууллагаас албан тушаалын нэршил, бүтэц орон тоог өөрчилж Нутаг дэвсгэрт хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн тасгуудын орон тоог 4-5 хүнээр нэмж Мөрдөн байцаах тасагт ажиллаж байсан мөрдөгч нарыг Эрүүгийн цагдаагийн тасагт шилжүүлэн томилсоноор нэг тасагт дунджаар хариуцсан хороо нутаг дэвсгэрээс шалтгаалж 15-20 эрүүгийн мөрдөгчтэй, хэрэг бүртгэлтийн 1700-1800 хэрэгтэй тухайн цаг хугацаанд ажиллаж байсан бөгөөд эрүүгийн мөрдөгчдийн Гүйцэтгэх ажил явуулах, мэдээ мэдээлэл цуглуулах ажил орхигдож зөвхөн хэрэг бүртгэлтийн хэрэгт процессийн зөрчил гаргахгүй, хэргийн хугацаа алдахгүй, прокурорын шаардлага авахгүй гэсэн бодолтой байсан үе энүүхэнд санагдаж байна. Хуулийн өөрчлөлтөөр хэрэг бүртгэлтийн хэрэг шалгаж, ачаалалтай байх үед Цагдаагийн байгууллагаас 2017-2020 оны хооронд өөрийн хүсэлтээр ажлаас гарсан болон бусад албанд шилжин томилогдсон алба хаагчдын 70 хувь нь Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчид хамгийн их байсан нь цалин хөлс, цаг наргүй ажилтай холбоотой бөгөөд Цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн хэргийг шийдвэрлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулсаны үр дүнд нэг тасагт одоогоор 500-800 хэрэг бүртгэлтийн хэрэгтэй байгаа нь ачаалал өмнөх онуудаас 2-3 дахин буурсан байгаа нь эерэг үзүүлэлт боловч Гүйцэтгэх ажлын чиглэл мөн л орхигдсон хэвээр байгаа нь эрүүгийн мөрдөгч нарт тулгамдаад байгаа гол асуудлуудын нэг болоод байна. Хэдийгээр хэрэг бүртгэлтийн хэрэг шалгахын хажуугаар Эрүүгийн тагнуулын ажлыг хариуцсан хороо, дүүргийн нутаг дэвсгэртээ явуулж үндсэн ажлаа хийж байгаа боловч нэг эрүүгийн мөрдөгчийн ажлын зураг авалт хийж үзэхэд цаг хугацааны хувьд 70/30 буюу сарын нийт ажлын 70 хувь нь хэрэг бүртгэлт үлдсэн 30 хувь нь Гүйцэтгэх ажлын чиглэлийн ажил хийж байгаа нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хувьд

хариуцсан нутаг дэвсгэртээ Эрүүгийн тагнуулын ажил арга хэмжээ явуулахад ихээхэн хүндрэлтэй байгаагын нэг шалтгаан болоод байна.

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн ажлын байрны тодорхойлолтонд хэрэг бүртгэлтийн хэрэг шалгах гэсэн асуудлыг хассанаар хариуцсан хорооны нутаг дэвсгэрт Эрүүгийн тагнуулын ажлыг идвэхтэй зохион байгуулж нууц далд аргаар үйлдэгдэж байгаа болон эзэнгүй хэргүүд дээр ажиллах цаг хугацаа ихсэснээр хэргийн илрүүлэлт алба хаагчдын ажлын ачаалал тэнцвэржиж эрүүгийн мөрдөгчийн албан тушаалд тогтвортой ажиллах нөхцөл болно гэж үзэж байна.

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн ажлын ачааллын талаар

Хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачааллыг дүүргийн хэмжээнд судлах зорилгоор Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нарын ажлын ачааллыг дүн шинжилгээний аргыг ашиглаж дараах судалгааг гаргалаа:

Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэр нь **9** хороо **305.3** га газар нутагтай, **51810** хүн амтай, **15243** өрх, **312** орон сууц, барилга, байгууламжтай, **4720** аж ахуйн нэгж, байгууллага, **13** худалдаа үйлчилгээний төв, их дээд сургууль, оюутны байр болон хүн ам ихээр төвлөрдөг дэд бүтэц эрчимтэй хөгжсөн нийслэлийн төвийн дүүрэг юм. Тус дүүрэг нь зүүн талаараа Баянзүрх дүүрэг, баруун талаараа Чингэлтэй дүүрэг, урд талаараа Хан-Уул дүүрэг, хойд талаараа Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан газар нутагтай хил залган оршдог нийслэлийн хүн амын нийт **7.6** хувь нь тус цагдаагийн хэлтсийн хариуцсан дүүргийн нутаг дэвсгэрт оршин сууж байна. Хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалж Сүхбаатарын талбай дээрх жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлж мэдээ мэдээлэл цуглуулан ажилладаг.

Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасаг нь ЦЕГ-ын даргын 2017 оны 06 дугаарын 25-ны өдрийн тушаалаар Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга 1, эрүүгийн ахлах мөрдөгч 2, эрүүгийн мөрдөгч 15 нийт 18 алба хаагчтайгаар ажиллахаар орон тоо батлагдсан байна.

Тус тасгийн алба хаагчид нь 2021 оны эхний 9 сарын байдлаар иргэд, байгууллагаас гаргасан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл нийт 1797 хүлээн авч шалгаснаас 378-д хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, харъяаллын дагуу 46 гомдлыг шилжүүлж, 762 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Шалгасан гомдол, мэдээллийг нэг алба хаагчид хуваж дунджаар тооцвол эхний 9 сарын байдлаар 1 эрүүгийн мөрдөгч 120-130 гомдол мэдээлэл, 1 сард 15-20 гомдлын материал шалгаж ачаалал ихтэй ажилласныг харуулж байна.

Эхний 9 сарын байдлаар Эрүүгийн цагдаагийн тасаг нь нийт 1875 хэрэг бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулсанаас 788 хэргийг илрүүлж, мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн, 46 хэргийг харъяаллын дагуу шилжүүлсэн, 1308 хэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хааж шийдвэрлэсэн ба одоо 1489 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн тоог 1 алба хаагчид хувааж дундажаар тооцвол 9 сарын хугацаанд 1 эрүүгийн мөрдөгч 100-120 хэрэг бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулж ачаалал ихтэй ажилласан байна.

Одоо гар дээр шалгагдаж байгаа хэрэг бүртгэлтийн хэрэгт ачааллыг хувааж тооцвол нэг алба хаагч дундажаар 110-120 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Эрүүгийн цагдаагийн тасаг нь хэлтсийн илрүүлэлтийг хариуцахаас гадна эрүүгийн мөрдөгч бүрт урьд хөтлөгдөж хэвшисэн бүртгэл, судалгаанууд хөтлөгдөж байгаа ба улирал, хагас, бүтэн жилээр биелэлтийг гаргадаг Эрүүгийн цагдаагийн албанд хүргүүлэх албан даалгаврууд биелэлт, сар бүр Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах газраас болон Эрүүгийн цагдаагийн албаны харъяа хэлтсүүд, бусад албадаас зохион явуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний явц, үр дүнг хариуцан ажилладаг.

Эрүүгийн цагдаагийн тасгийн хэмжээнд нийт 1489 хэрэг бүртгэлтийн хэрэг шалгагдаж байгаа бөгөөд тухайн хэргүүдийг хорооны зохион байгуулалтын дагуу шалгаж ажиллах явцад ачаалал тэнцвэржүүлэх зорилгоор ачаалал ихтэй 1, 8 дугаар хороонд хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулах тус бүр 3 алба хаагчийг ажиллуулж байна.

Хэдийгээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч эзэн холбогдогч тодорхой залилан мэхлэх гэмт хэргүүдэд хийгдэх процессийн ажиллагаа, прокурорын байгууллагаас ирүүлж байгаа даалгавар, тогтоол, өдөр тутамд бүртгэгдэх өргөдөл гомдлуудад хийгдэж буй ажиллагаа их байгаа зэрэгтэй холбоотойгоор эзэн холбогдогч тодорхой боловч эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн байгаа газрыг тогтоох чиглэлээр мэдээ, мэдээлэл цуглуулан ажиллах ажиллагаа хангалтгүй, үндсэн ажил болох Мөрдөн шалгах нууц ажиллагаа чанар үр дүн хангалтгүй зэрэг сөрөг нөлөөтэй байна.

Тасгийн хэмжээнд нийт шалгагдаж буй хэрэг бүртгэлтийн 1489 хэргийн 422 буюу 28.6% нь шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэг Бусдын эд хөрөнгийн залилан мэхэлж авах гэмт хэрэгт зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээгдсэн хэргүүд эзэлж байгаа ба нийт хэрэг бүртгэлтийн хэргийн 162 буюу 9.07%-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гээгдэл эд хөрөнгөтэй холбоотой гэмт хэргүүд эзэлж байна.

Эрүүгийн мөрдөгч нар нь ажлын цаг ашиглалтыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд эрүүгийн мөрдөгчийн хариуцсан хороон дээр эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд эрүүгийн цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүн бүгд буюу багаар ажиллаж байна. Мөн хэлтсийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт бага түвшинд байгаа энэ үед зохион байгуулагдаж байгаа арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлэх, явц байдлыг чанаржуулах зорилгоор өдөр тутам 23 цаг хүртэл уртасгасан цагаар ажиллаж байна.

7 хоног бүрийн Бямба, Ням гарагуудад 1-5 дугаар хороо, 6-9 дүгээр хороод хариуцсан эрүүгийн мөрдөгч нараар хуваарилж хуваарьт өдрөө цуглаж, хариуцсан баримт бичгүүдийг цэгцлэх, бүртгэл судалгаагаа бүртгэх ажлыг зохион байгуулж, хариуцсан

хороонд үйлдэгдсэн гэмт хэргийн материал цохогдсон үед хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчдөд албан үүргээ гүйцэтгэхэд учирч буй бэрхшээлийн талаар:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг түдгэлзэх боломжгүй тул эзэнгүй болон цаашид шалгах чиглэлгүй болсон хэрэг бүртгэлтийн хэрэг эрүүгийн мөрдөгчийн гар дээр нэмэгдэж ажлын ачаалал эрс нэмэгдсэн.

2. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй 48 цаг баривчлах ажиллагаа нь хэрэг бүртгэлтийн шатанд долоо хоногийн Баасан гаригт баривчилсан тохиолдолд ням гаригт сэжигтнийг гаргаж дахин даваа гаригт дуудан яллагдагчаар татах тогтоол танилцуулан шүүхээр таслан сэргийлэх арга хэмжээ авхуулж байгаа нь сэжигтнийг оргон зайлах шалтгаан нөхцөл болж байна.

3. Алба хаагч нар ажлын ачаалал их байгаа учир өглөө 08:30-аас орой 22:00 цаг хүртэл ажиллаж байна. Зарим тохиолдолд хагас, бүтэн сайн өдөр ажиллаж байгаа нь хэрэг бүртгэлтийн хэрэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг бүртгэлтийн хэрэг түдгэлзэх боломжгүй болсонтой холбоотой байна.

4. Хэрэг бүртгэлтийн шатанд гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдэд хилийн хориг тавьж болохгүй байгаа нь гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд нь хилээр гарч оргон зайлах тохиолдол ихэссэн.

Дүгнэлт

1. Гүйцэтгэх ажлын чиглэлээр хийгдэх ажиллагаа хангалттай түвшинд хүрэхгүй байгаа нь шалгагдаж буй хэрэг бүртгэлтийн хэргийн тоо, тэдгээрт хийгдэж байгаа ажиллагаа болон өдөр тутам бүртгэгдэж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо мэдээнээс хамаарч байна.

2. Гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээллийн чанарыг ахиулах, шалгагдаж буй хохирол ихтэй буюу хүнд хэргүүдэд гүйцтгэх ажлын идэвхитэй арга хэмжээ, мөрдөн шалгах нууц ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвших чиглэлд анхаарахгүй бол хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа хэргүүдийн өнгө жилээс жилд өөрчлөгдөж түүнийг илрүүлэх эрх бүхий албан тушаалтнуудын ажлын ачаалал өдөр ирэх тусам ихэсч байгаа нь хууль эрх зүйн зохицуулалт болон Цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, ажлын байрны тодорхойлолтыг өөрчлөх шаардлагатай байгааг харуулж байна.

3. Эрх зүйн зохицуулалт, бүтэц зохиун байгуулалтанд өөрчлөлт оруулснаар хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн ажлын байрны ачаалал, ажилдаа хандах хандлага дээшилж, алба хаагчид албандаа тогтвор сууршилтай ажиллах шалтгаан нөхцөл болох юм.

Дэвшүүлсэн санал

1. Гүйцэтгэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, ачааллыг тэнцвэржүүлж, хороо хариуцсан эрүүгийн мөрдөгчийн гүйцэтгэх ажлын идвэхитэй арга хэмжээ болон МШНА-нд чиглүүлж, энэ чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хэвшил болгох, хэргийн илрүүлэлтийг ахиулах, оргодол этгээдийг эрэн сурвалжлах ажилд дэвшил гаргах, үр дүнг дээшлүүлэх чиглэлээр хэрэг

бүртгэлтийн ажиллагааг эрүүгийн мөрдөгч нараар хийлгэхгүй байх.

2. ЭХХШТХ-д хэрэг бүртгэлтийн эзэнгүй, шалгах чиглэлгүй болсон хэргийг 2 сарын хугацаанд шалгалтын ажиллагаа явуулаад түдгэлзүүлэх, эрх зүйн зохицуулалт нэмэх саналтай байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль.УБ.2002 он

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017 он

3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ. 2018 он

4. Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн тоон мэдээ. УБ. 2021 он

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ НЬ
/Улсын чанартай авто зам жишээн дээр/

USE OF INFORMATION TECHNOLOGY FOR THE PREVENTION OF ROAD TRAFFIC ACCIDENTS AND CRIME
/ On the example of national roads /

Х.Мөнх-Эрдэнэ
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
Munkh-Erdene.Kh
Master's student of University of Internal Affairs Mongolia, Senior Lieutenant of Police

Хураангуй: Манай улсад гарч байгаа зам тээврийн осол хэргийн шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд нийт зам тээврийн ослын 98 хувийг жолоочийн буруутай үйлдэл эзэлдэг. Зам тээврийн ослын улмаас хамгийн их хохирол үүсдэг, хүний амь нас хохирдог зам бол олон улсын болон улсын чанартай авто замууд буюу манай улсын төв суурин газрыг холбосон хатуу хучилттай нэг зорчих хэсэг буюу эсрэг хөдөлгөөнтэй хөвөө бүхий замууд юм.

Замын хөдөлгөөнд оролцогч иргэд ялангуяа жолооч нь дээрх замын талын мэдээлэл талаарх мэдээлэл буюу тухайн замын аюул бүхий хэсэг, мал ихээр гардаг гарам, замын энхэл донхол хэсгийн мэдээлэл байхгүй тогтмол зорчдоггүйгээс шалтгаалан зам тээврийн осолд холбогддог гэж ойлгож болох юм.

Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын чанартай авто замд байнга буюу давтамжтай зам тээврийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг газар, орчны судалгааг гаргаж гар утасны GPS Navigation" аппликэйшнд мэдээллийг оруулж, жолооч нарт уг газрын талаарх мэдээллийг өгснөөр зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэхийг зорьсон.

Abstract: Driver misconduct accounts for 98 percent of all traffic crimes. Roads that cause the most damage and loss of life due to traffic crimes are national roads. Due to the lack of knowledge about these roads, every driver is involved in traffic crimes when traveling to the countryside. Over the past five years, we have conducted a survey of frequent or frequent traffic crimes and violations on national roads, entered information into the GPS Navigation mobile application, and provided drivers with information on the area to prevent traffic crimes.

Түлхүүр үгс: Зам тээврийн осол, зөрчил, улсын чанартай авто зам, хар цэг, Зам тээврийн ослын шалтгаан, Зам тээврийн ослын хэлбэр, Замын нөхцөл, Урьдчилан сэргийлэх ажил, замын мэдээлэл, гар утасны аппликэйшн, GPS Navigation координат

Keywords: Traffic crime and violations, national road, black zone, causes of traffic accidents, types of traffic accidents, road conditions, prevention, traffic information, mobile application, GPS Navigation coordinates

УДИРТГАЛ

Зам тээврийн осол, хэрэг түүний шалтгаан нөхцөлийн талаар судалсан магистр, докторуудын судалгаа ажил тайлангуудыг уншиж судлахад энэ төрлийн осол хэргээс мэдээллийн технологийг ашиглаж урьдчилан сэргийлэх арга замын талаар өмнө огт судлагдаж байгаагүй нь бидний хувьд шинэлэг судалгааны ажил болж байна. Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанаас сүүлийн жилүүдэд

зуны улиралд олон улсын болон улсын чанартай авто замд үйлдэгдэх зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээнүүдийг идэвхтэй зохион байгуулж үр дүнгээ өгч байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахдаа зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам орчин-Ослын дараах тусламж” гэсэн харилцан уялдаа бүхий цогц системийг бүрдүүлэх зорилго тавьсан бидний судалгаа ажлын хүрээнд дэвшүүлж буй саналтай уялдаж байгаа билээ. Олон улсын болон улсын чанартай авто замуудын тодорхой хэсэг газар, байршилд тогтмол давтамжтай зам тээврийн осол, зөрчил үйлдэгддэг газрыг “Хар цэг” гэж албаны хүмүүс, дийлэнх судлаачид нэрлэж заншжээ. Эдгээр “Хар цэг”-т үйлдэгдэж буй зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн аюултай хэсгийн GPS координатыг сүүлийн 5 жилийн судалгаагаар тогтоож, гар утасны GPS Navigation аппликэйшнд нарийвчлан суулгаж, жолооч нарт ашиглахад амар хялбараар бүтээж, гар утсанд үнэгүй суулгах нөхцөл боломжоор хангах ажлыг хийлгэх явдал юм.

Энэ аппликэйшныг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр улсын чанартай авто замаар орон нутгийн замд зорчиж буй шинэ туршлага муутай, авто замын мэдээлэл дутмаг жолооч нарт замын нөхцөл байдлын мэдээллийг гар утсаар нь дамжуулан өгөх нь гол зорилго юм.

Мөн замын тээврийн ослын дараах хохирлыг бууруулах ослын дараах хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор эмнэлгийн анхны тусламжийг цаг хугацаа алдахгүй хүргэх яаралтай тусламжийн цэсийг гар утасны аппликэйшнд суулган ашиглах арга замыг тодорхойлоход оршино.

НЭГ. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ШАЛТГААН

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.6 “Зам тээврийн осол” гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг[1]; гэж заасан байдаг. Зам тээврийн ослыг хохирлоор ангилаад зам тээврийн гэмт хэрэг, зам тээврийн зөрчил гэж ойлгож болох юм. Зам тээврийн гэмт хэрэг нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 “Автотээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”[2] буюу түүнээс дээш хохирол учирсан зам тээврийн ослыг ойлгоно. Зам тээврийн зөрчил гэдэг ослын улмаас учирсан хохирол нь

[1] Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлын тухай хууль //Төрийн мэдээлэл. Уб.,2015.№28

[2] Монгол Улсын Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл. Уб., 2016.№7

эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээргүй Зөрчлийн тухай хуулийн 14.7.51 дэх хэсэгт зааснаар арга хэмжээ тооцогдох ослыг ойлгоно.

Монгол Улсын хувьд 2021 он дэлхий дахиныг хамарсан цар тахалтай тэмцсэн, засгийн газрын шийдвэрээр өвчний тархалтын хумих зорилгоор хэд хэдэн удаагийн тэг зогсолтыг улсын хэмжээнд зохион байгуулсан.

Үүнтэй холбоотойгоор хөдөө орон нутгийн зорих, орон нутгаас Улаанбаатар хот руу орох хөдөлгөөний хагас жил гаруй хугацаанд хязгаарласан жил болж өнгөрсөн. Гэвч орон нутгийн замд хөдөлгөөнд оролцож буй иргэд зам тээврийн осол, хэрэгт өртөж хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд учрах хохирол буурсангүй. 2021 оны статистик мэдээнээс товч дурдвал.

Улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй 79260 дуудлага мэдээлэл хүлээн авч, 22482 осол бүртгэн шалгалтын ажиллагаа явуулсны 3264 буюу 14.5 хувь орон нутагт бүртгэгдсэн байна. Зөвхөн орон нутгийн замд бүртгэгдсэн эдгээр 3264 ослын улмаас 267 хүн амь насаа алдаж, 974 хүн гэмтэж бэртсэн харамсалтай тоо үзүүлэлт гарч ирж байна.

Улсын хэмжээнд зам тээврийн осолд холбогдсон 22482 жолооч нарын ур чадварын талаар судалгааг авч үзвэл: Тээврийн хэрэгсэл жолоодох эрх аваад 0-4 жил болсон жолооч 52.2%, 5-9 жил болсон жолооч 34.5%, 10-14 жил болсон жолооч 7.2%, бусад 6.1%-ийг эзэлж байна[3].

Дээрх тоо мэдээллүүдэд дүгнэлт хийж дараах ажил арга хэмжээг хэрэгжүүлэх санал дэвшүүлж байна.

Орон нутгийн замд сүүлийн 5 жилд 17684[4] зам тээврийн ослын тоо мэдээнд үндэслэн зам тээврийн осол давтамжтай болон гарах магадлал бүхий аюул эрсдэл бүхий 232 байршил /хар цэг/-үүдэд мэдээллийг тээврийн цагдаагийн албан дээр нэгтгэгдэж байна. Мөн сүүлийн 5 жилд осолд холбогдсон жолооч нарын туршлага, замын хөдөлгөөнд оролцсон болон зорчиж буй замын мэдээллийг хүлээн авсан байдлыг судалж үзэхэд:

Судалгаагаар дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

Шалтгаан нөхцөл: Жолооч нар орон нутгийн замд хурд хэтрүүлэх, замын нөхцөл байдалд хурдаа тохируулахгүй байх, хэт ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалж байгаа нь статистикаар тогтоогдсон.

Олон улсын болон улсын чанартай автозамд зам тээврийн осолд холбогдсон жолооч нарын 65% нь тухайн орон нутгийн замыг сайн мэдэхгүй буюу тухайн авто замаар анх удаа зорчиж байгаа, өөр орон нутгийн харьяалалтай байгаагаас гадна тээврийн хэрэгсэл жолоодсон хугацаа, туршлагыг авч үзэхэд 0-4 жилийн хугацаанд жолоо барьсан нь нийт жолооч нарын 52.2% хувийг эзэлж байлаа.

Иймд дээрх нөхцөл байдалтай уялдуулан тус гар утасны “GPS navigation”-нд тулгуурласан аппликэйшныг ашиглаж шинэ туршлага муутай, замын нөхцөл байдлын

[3] Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл цуврал. Уб., 2022. №11. 99 дэх тал

[4] Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл цуврал. Уб., №11. №10. №09. №08. №07

мэдээлэл дутмаг жолооч нарт мэдээлэл өгснөөр зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзлээ.

ХОЁР: ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ АСУУДАЛ

Цагдаагийн байгууллагаас орон нутгийн замд үйлдэгддэг зам тээврийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр маш олон төрлийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, хяналтын үйл ажиллагаанд техник технологийн дэвшлийг ашиглах, нэвтрүүлэхээр ажиллаж байгаа боловч зам тээврийн осол түүнээс үүдэлтэй нас баралт гэмтлийг бууруулж тодорхой дүнд хүрэхгүй байна. Учир нь Монгол Улсын газар нутаг өргөн уудам тэр дундаа хяналт шалгалт хийхэд цагдаагийн алба хаагчдын тоо хүрэлцээ хангалтгүй байгаатай холбоотой гэдгийг нэг талаас нь дүгнэн үзэж болно. Дан ганц техникийн дэвшлийг ашиглаж хяналт шалгалтыг сайжруулахаас гадна мэдээллийн технологийг ашиглаж жолооч нарт зам орчны мэдээллийг илүү амар хялбар аргаар ойлгомжтой өгч байх нь учирч болох зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажил болох юм.

Иймд жолооч бүрийн автомашинд нь цагдаагийн өмнөөс анхааруулж, сануулж, мэдээлэл өгч байхын тулд мэдээллийн технологи дундаас гар утасны аппликэйшныг сонгох болсон юм.

Гар утасны аппликэйшн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор 4 үндсэн чиглэлээр мэдээллийг жолоочид өгөх бөгөөд цаашид олон төрлөөр хөгжүүлэх боломжтой юм.


1. Зам тээврийн осол ихээр бүртгэгдсэн аюул бүхий хэсгийг жолооч нарт мэдээлэх чиглэл:



Зураг №1 Улаанбаатар хотоос Увс аймаг явах орон нутгийн авто замд байх “Хар цэг”-“Аюултай хэсэг”-ийн тоо мэдээлэл. /*Жишээ*/


Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын чанартай автозамд зам тээврийн осол хэрэг ихээр бүртгэгдсэн 232 “Хар цэг буюу аюултай хэсэг”-ийн мэдээллийг тухайн замаар явж буй жолоочид 500-300 метр ойртох үед гар утсанд анхааруулах дууд дохио хэлбэрээр өгнө.

Аюултай хэсгийн талаар мэдээлэлгүй жолооч нар тухайн хэсэгт ихэвчлэн хурд хэтрүүлэх, нойрмоглох, хэрэгт холбогддог. 2021 онд орон нутгийн замд хурд хэтрүүлсэн үйлдэл 302, анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд



анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцоноос болж зам тээврийн гэмт оролцоноос 590 зам тээврийн осол бүртгэгдсэн байна.

Эдгээр осолд холбогдсон жолооч нарын дийлэнх хувь тухайн зорчиж явсан замын нөхцөл байдлын талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байснаас осолд холбогдсон байна. Иймд замын аюултай хэсгийг жолоочид мэдээлж, анхааруулж өгснөөр жолоочийн анхаарал сайжирч, тээврийн хэрэгслийн хурдыг багасгаж аюул осолгүйгээр тухайн хэсгийн дайран өнгөрөх боломжтой болно. Уг аппликэйшн нь аюултай хэсгийг өнгөрсний дараа дахин дуут дохио өгч хурдаа хэвийн нөхцөл үргэлжлүүлэх талаар мэдээлэл болно.



2.Хурд хэтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх:

Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 12.4. Тээврийн хэрэгслийн хурдыг суурин газарт цагт 60 км, суурин газрын гадна цагт 80 км, тууш замд цагт 100 км-ээс хэтрүүлэхийг хориглоно[5] гэж заасан байдаг. Улаанбаатар хотоос орон нутгийг зорин замд гарсан жолооч замын хөдөлгөөний дүрэмд заасан 80 км/цагийн хурдтай хөдөлгөөнд оролцож, зорчих цагаа мөн энэ хурдтай хамааруулан төлөвлөж байгаа хэдий ч бодит байдал дээр замын нөхцөл байдал, замд тохиолдох олон хүчин зүйлсээс хамаарч А цэгээс Б цэг хүртэлх зайг төлөвлөсөн цагт туулдаггүй, цагт дунджаар 55-60 км явдаг. Жишээ нь: Улаанбаатар хотоос Дархан-Уул аймаг хүртэл 220км газрын хурдны хязгаарыг 80км/ц-аас хэтрүүлэхгүйгээр явахад 2 цаг 45 минут туулах ёстой. Гэтэл бодит байдал дээр орон нутгийн замын хөдөлгөөний ачаалал, даваа нугачаа, замын эвдрэл бусад хүчин зүйлээс шалтгаалан таны

[5] Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм //Төрийн мэдээлэл. Уб.,2018. №42

туулах зам цагт дунджаар 55-60 км буюу Дархан-Уул аймагт 3 цаг 40 минутаас 4 цагийн хугацаанд явж очих болно. Хэрэв та ийм хугацаанд уг замын туулж замын хөдөлгөөнд оролцсон хурд хэтрүүлэх зөрчил гаргалгүй хөдөлгөөнд оролцсон байна гэсэн үг. Үүнээс богино хугацаанд замаа туулах юм бол та замын аль нэг хэсэгт замын хөдөлгөөний дүрэм зөрчиж хурд хэтрүүлсэн гэж ойлгож болох юм. Орон нутгийн замд хурд хэтрүүлэх зөрчилд хяналт тавьж ажиллахад зөрчил гаргасан жолооч нарын гаргадаг тайлбар нь "*очих цагаасаа хоцрох гээд яараад хурд хэтрүүлчихлээ*" гэж хэлдэг.

Энэ нь очих газрынхаа замын нөхцөл байдлыг мэдэхгүй, цагаа зөв тооцоолж орон нутгийн замд хөдөлгөөнд оролцдоггүй учраас заавал хурд хэтрүүлэх шаардлага үүсэж байгааг харуулж байна.


Иймд энэхүү аппликэйшн нь жолооч нарт хаанаас хаана хүртэл хэдэн цаг явна гэдгээ тооцох боломжийг бодитоор олгож, хурдыг хэтрүүлэх шаардлага үүсэхгүй, ялангуяа эрсдэл бүхий цэг дээр хурд хэтрүүлсэн тохиолдолд анхааруулга өгөхөөр төлөвлөгдсөн.

3.Ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодохоос урьдчилан сэргийлэх:

Жолооч орон нутгийн замд тасралтгүй 2-оос дээш цагаар тээврийн хэрэгсэл жолоодох үед анхаарал буурч, самбаачлах хугацаа уртсаж, нойрмоглох байдалд ордог. Тээврийн хэрэгсэл жолоодох үед нойр хүрхэд авах хамгийн сайн арга бол замын зорчих хэсгийг чөлөөлж зогсоод 20-30 минут унтах амрах юм.

Жолооч тамхи татаад, шингэн юм уух, цонхоо онгойлгох, хөгжмөө чангалах зэргээр олон янзаар нойроо сэргээх үйлдэл хийж болох боловч эдгээр нь 3-5 минутын туршид үр дүнтэй байдаг.

Жолоо барьж явах үедээ нойрмоглох нь зам тээврийн ноцтой осол, гэмт хэрэг гарах шалтгаан болдог. 80км/ц цагийн хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэл 1 секундэд 22.2 м газрын туулдаг. Энэ нь жолооч 5 секунд нойрмоглох үед 111м замыг ямар ч хяналтгүйгээр туулах бөгөөд энэ үед эсрэг урсгалд явж байгаа тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, зам дээр байгаа биет мөргөх, замын хажуу руу унах зэргээр зам тээврийн осолд өртөх магадлал маш өндөр бөгөөд 2021 онд орон нутгийн замд онхолдох хэлбэрээр 898 зам тээврийн осол бүртгэгдсэн байна[6].



Иймд улсын чанартай авто замд 2-оос дээш цаг тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд аппликэйшн нь анхааруулах дохио өгөх, ойролцоо байгаа амрах боломж бүхий зогсоол талбайн мэдээллийг өгөх, ингэснээр жолооч түр зогсох, биеийн чилээгээ гаргах, нойроо сэргээх, богино хугацаанд унтаж амрах, анхаарлаа өндөржүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөгдсөн.

4.Зам тээврийн ослын дараах анхны тусламжийг сайжруулах чиглэлээр:

[6] Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл цуврал. Уб., 2022. №11. 56 дэх тал

Олон улсын туршлага, өгч байгаа зөвлөмжөөс үзэхэд ослын үед эмнэлгийн анхны тусламжийг яаралтай үзүүлэх, ингэснээрээ хүний амь насыг аврахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Манай улсад зам тээврийн осолд өртсөн жолооч, зорчигч нарт яаралтай тусламж авах зорилгоор 102, 103 дугаарт холбогддог боловч осол болсон газрын нэршил, байрлалыг мэдэхгүй, аль аймгийн аль суманд байгаагаа мэдэхгүй, эмнэлгийн байгууллагууд харьяаллын дагуу очдог зэргээс маш их хугацаа алддаг. Өнгөрсөн онд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 383 хүний 59 буюу 14.5 хувь осолд өртсөн даруйд эмнэлгийн анхны тусламж авсан, 324 буюу 84.6 хувь нь эмнэлгийн анхны тусламж авч чадаагүй[7] гэсэн харамсалтай мэдээлэл байна.

Уг аппликэйшн нь улсын чанартай авто зам дайрч өнгөрдөг аймаг, сумын хилийн цэсийг GPS-ээр тогтоож, осол хэрэгт бүртгэгдсэн аймаг сумын нэршил шууд гарч ирэх, тухайн сумын эрүүл мэндийн төвийн жижүүр, эрхлэгчийн утас, хэсгийн төлөөлөгч, сумын цагдаа, замын цагдаагийн хяналтын цэгийн мэдээлэл утасны дугаар шууд гарч ирдэг байхаар төлөвлөгдсөн. Энэ нь ослын дараах анхны тусламж үзүүлэх цагийг 5-аас 20 минутаар хэмнэж, нас баралт гэмтэл, хохирлыг бууруулах зорилготой юм. Эрүүл мэндийн анхны тусламжийг хамгийн богино хугацаанд үзүүлж чаддаг гэх Израйл улсын эмнэлгийн анхны тусламж үзүүлдэг сайн дурын иргэд “Ambucycle” нэртэй мотоциклыг түргэний машин болгож тоноглосон тээврийн хэрэгслээрээ “Зүрх судалсны асуудал тулгарсан өвчтөн дээр 2 минутын дотор хүрч очиж чадвал аврагдах магадлал 90 хувь байдаг”[8] гэсэн тооцооллыг гаргажээ. Мөн тэдгээр сайн дурынханд гар утасны аппликэйшнаар яаралтай эмнэлгийн тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийн байршил ирдэг байна. Анхны тусламж хугацаа алдаж ирэх тусам зам тээврийн осолд өртсөн хүмүүсийн амь насаа магадлал ихсэх болно. Иймд хугацаа алдахгүй яаралтай тусламж дуудах бүх нөхцөл байдлаар уг аппликэйшныг мэдээллээр хангах болно.

ДҮГНЭЛТ

Зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цаг үетэйгээ нийцүүлж, мэдээллийн технологийг нэвтрүүлэх цаг ирсэн тодийгүй иргэд олон нийт бүгд л өдөр тутамдаа ухаалаг гар утасны тусламжтай мэдээлэл авч нийгмийн харилцаанд орж, ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагад 10000 гаруй албан хаагч үүрэг гүйцэтгэж байгаагаас Тээврийн цагдаагийн албанд 1090 албан хаагч гудамж замын хөдөлгөөнд хяналт тавьж байгаагаас орон нутаг 450 албан хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын хэмжээнд ашиглаж байгаа орон нутгийн гэж нэрлэгддэг аймаг, сумдыг Улаанбаатар хоттой холбосон 14918 км замыг орон нутагт ажиллаж буй нэг албан хаагчид хуваах

[7] Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхтгэл цуврал. Уб., 2022.№11.36 дахь тал

[8] Израйл инновацийн нууцууд. Уб., 2021. 43 дахь тал

үзэхэд дунджаар 33.1 км зам ноогдож байна. Улаанбаатар хот руу орох гарах хөдөлгөөний хянадаг байнгын хяналтын 7 цэг /товчоо/-ээр өдөрт дунджаар 4900-5600 тээврийн хэрэгсэл бүртгүүлдэг, бүх нийтийн баяр амралтын өдрүүдэд уг тоо нь 10200 болж өсдөг зэрэгт дүгнэлт хийж үзэхэд орон нутгийн замд хяналт шалгалт сул тавигдаж жолооч нарт хурд хэтрүүлэх, өөр бусад хэлбэрээр замын хөдөлгөөний дүрэм зөрчих нөхцөл боломж үүсэж байна.

Иймд орон нутгийн замд хөдөлгөөнд оролцож байгаа жолооч бүрд, эсвэл түүний хажууд сууж яваа зорчигч бүр тухай замын аюултай хэсгийн мэдээллийн маш сайн мэддэг, очих цагаа зөв тооцоолж орон нутгийг зорьдог, ядарсан үедээ амрах зогсоол талбайн байршлыг мэддэг, зам тээврийн осолд холбогдсон үед цаг алдалгүй хамгийн ойр байгаа эмнэлэг цагдаагийн албан хаагч нартай холбогдож өөрсдийн мэдээллийг үнэн зөвөөр дамжуулдаг болгохын тул мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж гар утасны аппликэйшныг бүтээж зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах шаардлагатай байна дүгнэж байна.

Мэдээллийн технологийг ашиглаж “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам орчин-Ослын дараах тусламж” гэсэн харилцан уялдаа бүхий цогц системийг бүрдүүлсэн гар утасны аппликэйшныг бүтээснээр зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх шинэлэг ажил болж гэдэгт итгэлтэй байна.

Ашигласан материал.

- Монгол Улсын Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл. Уб., 2016.№7
- Монгол Улсын Замын Хөдөлгөөний Аюулгүй Байдлын тухай хууль //Төрийн мэдээлэл. Уб.,2015.№28
- Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм //Төрийн мэдээлэл. Уб.,2018. №42
- “Алсын хараа 2050” Монгол улсыг хөгжүүлэх урт хугацааны хөгжлийн бодлого.
- Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл цуврал. Уб., №11. №10. №09. №08. №07
- Магистр докторын судалгааны ажил.
- Израйл инновацын нууцууд Avi Jorisch. Уб., 2021. //орчуулагч Б.Буянт

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

THE CONCEPT OF RESTRICTIVE MEASURES, PREVENTIVE MEASURES AND THEIR IMPLEMENTATION

М.Энхням
Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч /Дотоод хэргийн их сургуулийн магистрант/
M.Enkhnyam
Senior detective of the police department of Khentii province, police major /Master of the University of Internal Affairs/.

Хураангуй: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлд: **"**Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ**"-г таслан сэргийлэх арга хэмжээний төрөл болгон хуульчилсан нь** өмнө хэрэглэж байсан оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээний агуулга, хэлбэрийг шинэчлэн найруулж тогтоосон зохицуулалт гэж үзэж болно. Уг таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдалд судалгаа хийн үр дүнг танилцуулж байна.

Abstract: Article 14.5 of the Criminal Procedure Code, enshrined and legitimized as a means of restriction in "Restrictive measures and preventive measures", can be considered as a revised provision on the content and form of a preventive measure to obtain a guarantee of the impossibility to leave the place of residence. The results of a study of the status of execution of this preventive measure are presented.

Түлхүүр үгс: Хүний чөлөөтэй зорчих эрх, эрүүгийн процесс ажиллагаа, албадлага, таслан сэргийлэх арга хэмжээ, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ.

Key words: the right to freedom of movement, criminal proceedings, coercion, preventive measures, restrictive and preventive measures.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дэх хэсэгт: "Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно", мөн 18 дахь хэсэгт: "Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно" гэж тус тус заажээ[1].

Хязгаарлах гэдэг үг нь Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд юмыг хасах буюу хэмжээ тогтоож зогсоох, зарим эрхийг хязгаарлах гэх утгаар тодорхойлогджээ[2]. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ гэж таслан сэргийлэх арга

[1] Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл. УБ., 1992

[2] Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1964

хэмжээний нэг төрөл болгон хуульчилсан[3].

Таслан сэргийлэх арга хэмжээний нэг төрөл болох хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ нь Монгол Улсын хувьд 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд анх орж ирсэн шинэлэг ойлголт бөгөөд уг хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш дагаж мөрдсөнөөр хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт мөн даган хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын саналыг үндэслэн шүүхээс авч байна.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг яллагдагчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгах зэрэг зургаан хэлбэрээр хэрэгжүүлж байна[4].

Харин энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ нь гадаадын зарим орнуудын хувьд бол шинэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ биш бөгөөд жишээ нь: Оросын холбооны улсад 1. Оршин суугаа газраасаа зөвшөөрөлгүйгээр гадагш явахгүй тухай үүрэг авахуулах, 2. Гэр хорионд байлгах зэргээр энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Мөн АНУ-д гэр хорионд цагдан харгалзах гэх нэр томъёогоор энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж байна[5].

2017-2020 онд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байдлыг үзвэл:

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг 2017 онд нийтдээ 196 хүнд авсан байх бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээг доорх төрлөөр авчээ. Үүнд:



[3] Лхагварагчаа.Б нар, Эрүүгийн процессын эрх зүй /ерөнхий, тусгай анги/, УБ., 2021


[4] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2015

[5] Баярсайхан.Д. Гадаад орнуудын эрүүгийн процесс. УБ., 2015

2018 онд нийтдээ 399 хүнд авсан байх бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээг доорх төрлөөр авчээ. Үүнд: [6]



2019 онд нийтдээ 680 хүнд авсан байх бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээг доорх төрлөөр авчээ. Үүнд: [7]



2020 онд нийтдээ 451 хүнд авсан байх бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээг доорх төрлөөр авчээ. Үүнд: [8]



[6] http://admincourt2.gov.mn
[7] http://admincourt2.gov.mn
[8] https://www.court.za.gov.mn

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг 2017-2020 оны хооронд нийтдээ 1726 хүнд авсан байх ба уг хүмүүст таслан сэргийлэх арга хэмжээг доорх төрлөөр авчээ. Үүнд:[9]



Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг харахад Монгол улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээг хамгийн ихээр сонгон хэрэглэж байх ба тогтоосон замаар зорчихыг даалгах арга хэмжээг хамгийн бага буюу практикт 2 удаа л сонгон хэрэглэсэн байна.

Практикт энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авлига, албан тушаалын гэмт хэргүүд, залилах, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт авах нь түгээмэл бөгөөд мөн Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах /хилийн хориг/ гэх ойлголтоор л түлхүү сонгон хэрэглэж байна.

Харин тогтоосон газраас гарч явахыг хязгаарлах, тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явахыг хязгаарлах, тодорхой газар очихыг хязгаарлах, тодорхой хүнтэй уулзахыг хориглох зэрэг арга хэмжээнүүдийг практикт тодорхой хэмжээгээр тохируулан хэрэглэж байгаа нь сайшаалтай боловч хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээнд хэн хяналт тавих нь тодорхойгүй байгаа нь энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээний тулгамдсан асуудал болоод байна.

Дүгнэлт: Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ нь бусад таслан сэргийлэх арга хэмжээнүүдээ бодвол шинэлэг, онцлогтой таслан сэргийлэх арга хэмжээ юм. Гэтэл энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдалд хяналт тавих байгууллага, хүн тодорхойгүй, шүүхээс тухайн яллагдагчид үүрэг болгох, даалгах байдлаар л энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авч байна.

Практикт энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг зорчих эрхийг хязгаарлах ялтай андуурах нь ч байна.

Сүүлийн жилүүдэд шүүхээс энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг сонгон хэрэглэх нь нэмэгдэж байгаа боловч нэр төдий авсаны улмаас яллагдагч нар сул чөлөөтэй гадуур явж,

[9] http://www.judinstitute.mn/

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, дахин гэмт хэрэг үйлдэх зэрэг эрсдэл бүхий нөхцөл байдлыг үүсгэж байна. Практикаас харахад зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангаж эхлэн ялтанд хяналтын төхөөрөмжүүдийг зүүлгэж, түүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хяналт тавин ажиллаж байна. Гэтэл хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний тухайд энэ нь хэрэгжихгүй, хэн хяналт тавих нь тодорхойгүй байна.

Иймд энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ бүрэн утгаараа хэрэгжих нөхцөл байдлыг бүрдүүлэх зорилгоор энэ талаарх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хяналт тавих хүн, байгууллагыг тодорхой болгох шаардлагатай байна.

Санал: 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Шүүхийн шийдвэрт заасан бол хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага нь яллагдагчид хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавина гэж заасан. Гэтэл энд заасан хяналт тавих байгууллага гэж ямар байгууллага болохыг хуульд тусгайлан зааж өгөөгүй учир хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагч нарт хяналт тавих ажилд огт хэрэгждэггүй, хаягдсаар иржээ. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам гэж тусдаа бүлэг оруулж өгөх.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ гэж заасан. Иймээс прокурор хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний тухай саналыг шүүхэд гаргахдаа хэргийг мөрдөж буй мөрдөгч нараас саналыг нь асуулгүй, өөрөө бие даан шийдвэр гаргаж байгаа нь учир дутагдалтай байна. Иймд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг мөрдөгчийн саналыг үндэслэн, хэрэв үндэслэлтэй бол прокурор уг саналыг хүлээн авч үргэлжлүүлэн өөрийн саналаа шүүхэд гаргаж шийдвэрлүүлэх гэж өөрчлөн найруулах саналтай байна.

ХИЛИЙН АЛБАНЫ СУРГАЛТЫН ОНЦЛОГ, АРГА, ХЭЛБЭР

BORDER SERVICES' TRAINING METHOD, TYPE AND SPECIFICATION

Я.Ариунболд
ДХИС-ийн УА-ийн хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хурандаа, докторант.
Ariunbold.Ya
Professor, Team of the Border Strategy Studies, University of Internal Affairs

Хураангуй: Хилийн албаны сургалтын онцлог, арга хэлбэр, онол, арга зүйн ойлголтуудыг тусгасан.

Abstract: This study explains understanding of the theories of border services training method, type and specification.

Түлхүүр үг: Хилийн алба, сургалтын зарчим, арга, хэлбэр
Keywords: Border services, concept of the training, method, type

Оршил: Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академи нь Цагдаа, Хил, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалын нөөцөд авагдсан офицеруудыг захиалгаар сургаж, бэлтгэдэг.

Монгол Улсын батлан хамгаалах хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт цэргийн байгууллын удирдлагыг улс төрийн, төрийн захиргааны, цэргийн мэрэгжлийн удирдлагаас бүрдэнэ гэж заасны дагуу хилийн цэргийн мэрэгжлийн удирдлагын байгууллалд ажиллах, хил хамгаалах байгууллагаас захиалгаар суралцаж буй офицеруудыг хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хилийн албаны мэдлэг, ур чадвар олгох мэргэжлийн сургалтыг зохион байгуулж байна.

7.5.3Зэвсэгт хүчин нь үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чиг үүрэг бүхий цэргийн байгууллагын тогтолцоо мөн бөгөөд Монгол Улс мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бүрдүүлж, бэхжүүлнэ.

Зэвсэгт хүчний тухай хууль 3.1.5."цэргийн мэргэжлийн удирдлага" гэж зэвсэгт хүчний стратегийн бодлого, төлөвлөлтийг боловсруулахад оролцож, цэргийн бодлогыг тодорхойлох, командлагч, захирагчид дэмжлэг үзүүлэх, төрөл мэргэжлийн цэргийн анги, байгууллага, салбарыг удирдлагаар хангах үйл ажиллагааг;

9.5.Цэргийн мэргэжлийн удирдлагыг төрөл мэргэжлийн цэргийн дарга хэрэгжүүлнэ.

Мэргэжлийн сургалтыг, мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 4.1.4-т "мэргэжлийн сургалт" гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагаа хэмээн томъёолжээ.

Монгол улсын хилийн тухай хуулийн 34.1 дүгээр заалтад улсын хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байх бөгөөд хилийн цэрэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб, анги, салбар,

зэвсэглэл, техник, ар тал, хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна гэж хуульчилсан байна.

Иймээс хилийн албаны сургалтын уламжлал нь цэргийн сургалтад тулгуурлагддаг бөгөөд цэргийн сургалт гэдэг нь офицер цэрэг хоёрын сурах, сургах гэсэн олон талт үйл ажиллагааны нэгдэл гол зорилго нь цэргийн хэргийн тодорхой хэмжээний мэдлэг, дадлага, ур чадварыг эзэмшүүлэхэд оршдог.

Хилийн алба гэдэг нь[1] 1. Монгол Улсын хил хамгаалалтын нэг төрөл.

2.Монгол Улсын хилийн тодорхой хэсгийг /зорилт, газар орон, цаг хугацаагаар/ тасралтгүй хамгаалахад чиглэгдсэн хилийн анги, салбаруудын үйл ажиллагааны үндсэн хэлбэр.

3.Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах зорилгоор цэргийн болон тагнуул, инженерийн арга хэмжээтэй хослуулан хилийн анги, салбаруудаас зорилго, үүрэг, чиглэл, газар орон, цаг хугацааг тохируулан тасралтгүй явуулж байгаа үйл ажиллагаа.

Агуулга нь: Хилийн тусгай анги, салбаруудаас хил манах зорилтоо биелүүлэхэд бэлтгэх, түүнийг гүйцэтгэхээр цэргийн болон тагнуулын ажиллагааг зохион байгуулж явуулах, хилийн дэглэм, хил орчмын дэглэм /хилийн бүс, зурвас, хилийн боомт газарт тогтоосон журам/ -ийн биелэлтэд хяналт тавих зэрэг ажиллагаанаас бүрдэнэ.

4.Тайван цагт улсын хил манах, хилийн болон хил орчмын дэглэм сахиулахын тулд орон тооны хүч хэрэгсэл, иргэд, хил хамгаалахад туслах хүчний идэвхтэй оролцоотой нутгийн засаг захиргааны нэгж, цагдаа, тагнуулын байгууллагатай нягт харилцан ажиллаж хэрэгжүүлдэг цэргийн болон инженер- техник, тагнуул, захиргаа, хууль хяналтын цогц үйл ажиллагаа гэж тайлбарласан бол “Хилийн нэр томъёоны тайлбар толь”-д 1. Улсын хил хамгаалах зориулалт бүхий хилийн анги, салбар байгууллагад Монгол улсын иргэд алба хаах төрийн албаны онцгой төрөл.

2. Улсын хил хамгаалах алба-байлдааны ажиллагааны хэлбэр бөгөөд улсын хилийн зөрчил болон Монгол улсын хил хязгаарын орон зайд хуулиар тогтоосон эрх зүйн бусад дэглэмд халдсан халдлагыг илрүүлэх, таслан зогсооход чиглэгдсэн ХХБ-аас үүрэг, зорилго, орон зай, цаг хугацаагаар нь зохицуулан тасралтгүй явуулж буй оперативын, дэглэмийн, хяналт шалгалтын болон бусад арга хэмжээ гэж тус тус тайлбарласан байна.

Дээрх тайлбаруудаас хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах үндсэн арга нь хилийн алба гэж ойлгож болохоор байна.

Хилийн албаны сургалт нь улсын хил хамгаалах алба-байлдааны ажиллагаанд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, дадлагыг эзэмшүүлж, хилийн анги салбаруудыг бие даан болон харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтран хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдан явуулах арга ажиллагаанд сургах үндсэн сургалт юм.

1.Хилийн албаны сургалтын онцлог

Хилийн албаны сургалт нь суралцагч албан тушаалтан бүрд

1 Сүндэв.П. (2003). Монгол улсын хилчний тайлбар толь.УБ.,246-р тал

тохирсон агуулгатай, төлөвлөлтийн тодорхой зохион байгуулалт, сургалтын хэлбэр, арга ажиллагаа, хэрэгсэл, тактикийн бэлтгэл сургалтын төвшинг илэрхийлсэн тоон болон чанарын үзүүлэлт, нормативыг өөртөө багтааж бие бүрэлдэхүүнд үүссэн цагийн байдалд үүрэг гүйцэтгэх ур чадвар олгоход чиглэгдсэн олон төрлийн хичээл, хээрийн сургуулийг багтаасан зохион байгуулалттай, төлөвлөгөөт үйл ажиллагаа, хилчдийн алба хаах бүхий л хугацаанд хилийн албаны сургалт тасралтгүй явагдана.

Хилийн албаны сургалтыг цэргийн болон хил судлалын шинжлэх ухааны онолд суурилж, хил хамгаалах урлагийн хүрээнд тактик, оператив, стратегийн түвшинд зохион байгуулж явуулдаг.

Хилийн албаны хичээлүүд нь өөрийн судлах зүйл, заах аргаар өөр өөр байх боловч, эцсийн зорилго нь хил хамгаалалтыг бэлтгэж, явуулах ажиллагаанд сургаж, улсын хилийг найдвартай хамгаалахад чиглэгдэнэ.

Хилчид тайван цагт байлдааны үүрэг гүйцэтгэж байдаг онцлогт тохируулан хилчдийг сургахад хилийн албаны хичээл гол үүрэг гүйцэтгэнэ.

Хилийн алба нь улсын хил хамгаалах үүргийг биелүүлэхэд хилийн манаа, харуул, застав, отрядын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдан явуулах, хил дамнасан гэмт хэрэг, хууль бусаар хилээр эд зүйл нэвтрүүлэх, хил зөрчигчтэй тэмцэх, олон улсын гэрээ, хэлэлцээрийг сахиулах, шалган нэвтрүүлэх арга ажиллагаанд сургадаг цэргийн тусгай бэлтгэлийн нэг юм.

Хилийн албаны сургалтыг зөвхөн хууль тогтоомж дүрэм, зааврыг танилцуулж, болсон үйл явдлыг мэдээлснээр хязгаарлан, онол арга зүйн үндэслэл муутай явуулбал тавьсан зорилгоо хангахгүй.

Хилийн албаны хичээл нь өөрийн гэсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, цэргийн сургалтын зарчим, заах арга, хэлбэрүүдээр явагддаг.

Хилийн албаны хичээл заах багш нь хичээл заах арга зүйгээс гадна албаны болон цэргийн сургалтын ерөнхий онолыг зайлшгүй судалсан, албан үүрэг гүйцэтгэх үед үүсч болох тодорхой цагийн байдалд ажиллах туршлагатай байж хилийн албаны мэдлэг, дадлага, ур чадварыг олгоно.

Хилийн албаны мэдлэг нь олон улсын гэрээ хэлэлцээр болон Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиг, хилийн албаны дүрэм, заавар, удирдлагын тушаал шийдвэр, улсын хил хамгаалалтын мөн чанар, зорчигч тээврийн хэрэгслийг хилээр шалган нэвтрүүлэх, хууль бусаар хилээр эд зүйл нэвтрүүлэх, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, хилийн тусгай дэглэм, журам, манааны албан үүрэг гүйцэтгэх, хил зөрчигчийг эрж саатуулах, онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах зэрэг мэргэжлийн ур чадвараар илэрхийлэгдэнэ.

Хилийн албаны сургалт нь хүн нэг бүрийн бэлтгэл, салаа салбарын бэлтгэл, удирдлагын бэлтгэл гэж ангилагдан цэргийн сургалтын үндсэн зарчмуудад тулгуурлан явагддаг.

Цэргийн сургалтын үндсэн зарчмууд:

1. Сургалт шинжлэх ухааны үндэслэлтэй байх.

2. Эсрэг талаа ялан дийлэхэд хэрэгтэй бүхэнд сургах.

3.Сургалтыг байлдааны бэлэн байдлыг хангахад чиглүүлэх.

4.Дайчдыг ухамсарлуулан идэвхжүүлэх.

5.Үзүүлж, таниулах.

6.Сургалт систем дэс дараалалтай явагдах.

7.Мэдлэг, дадлага, чадварыг эзэмшүүлэх.

8.Хялбар дөхөм байх.

9.Бүлгээр болон ганцаарчлан ажиллаж сургах зэрэг зарчмууд багтана.

Цэргийн сургалтын 25 хувь нь онол, 75 хувь нь дадлага байдаг.

Сургалтын зарчим нь сургалтын процессын удирдамжийг тодорхойлдог бол үйл ажиллагааны дүрэм, заавар журам нь тусгай нэгж, салбар юу хийхийг тусгасан байдаг.

Хилийн албаны сургалтыг сургалтын зарчмуудад тулгуурлан тусгай арга, хэлбэрээр явуулдаг. Сургалтын зарчим арга, хэлбэрүүд нь хоорондоо нягт холбоотой, нэг нь нөгөөгөө баяжуулж байдаг.

Хилийн сургуулийн 2,3,4-р дамжааны сонсогчдоос

1.Хилийн албаны талаарх таны ойлголт?

2.Хилийн алба нь ямар салбар шинжлэх ухаанд багтах вэ?

3.Хилийн албаны хичээл ямар сургалтын аргаар явагдаж байна вэ?

Гэсэн асуулт бүхий судалгааг авахад

1.Хилийн албан талаарх таны ойлголт гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 35 сонсогчийн 32 нь буюу 91,4 хувь нь сайн хариулсан байна.

2.Хилийн алба нь ямар салбар шинжлэх ухаанд багтах вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 35 сонсогчийн 16 нь буюу 45 хувь нь цэргийн шинжлэх ухаан, 19 нь буюу 55 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

3.Хилийн албаны хичээл ямар сургалтын ямар хэлбэр, аргаар явагдаж байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 35 сонсогчийн 31 нь буюу 88,5 хувь нь лекц, семинар, дадлага, хээрийн гаралт гэсэн хариулт өгсөн байна.

Судалгаанаас харахад хилийн албаны сургалтыг багш нар үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг судлуулж, хил хамгаалалтын дүрэм, заавар, журмыг удирдлага болгон лекц, семинар, дасгал үйлдүүлэн хээрийн гаралтаар тактик ажиллагаанд сургах байдлаар явуулж байна.

Хилийн сургуулийн хилийн албаны сургалтын дараагийн шатны үргэжлэл нь Удирдлагын академийн хилийн стратеги тактикийн сургалт бөгөөд сургалт шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчмын дагуу хилийн албаны суурь шинжлэх ухааны талаар гүнзгийрүүлсэн хичээлийн хөтөлбөрийн цаг сэдвийн задланд тусган тодорхой ойлголт өгч онол практикийн нэгдлийг туршлага болгон цэргийн сургалтын удирдах бүрэлдэхүүний үндсэн зарчим, арга, хэлбэрийг эзэмшүүлж байгаагаар онцлогтой.

Удирдлагын академи төгсөөд хилийн анги салбарт болон харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтарсан шат шатны сургалт, хээрийн сургуулиудыг зохион байгуулах офицерууд цэргийн сургалтын зарчим, арга, хэлбэрийн талаар тодорхой мэдлэгтэй, нэгдсэн болон хэсэгчилсэн дадлага, команд штабын сургууль зохион байгуулах чадвартай байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Цэргийн сургалтын хэлбэр

Хэлбэр гэдэг үг нь бүтэц гэсэн утга бүхий латин үгнээс гаралтай. Сургалтын хэлбэр нь сурах үйл явцыг хэрэгжүүлж суралцагсдад системтэй ур

чадвар олгох шат дараалсан ажилбарууд юм.

Хилийн албаны сургалт нь хил хамгаалалтын зохион байгуулалтын талыг харуулсан сургалтын ба албаны үйл ажиллагааны тодорхой хэлбэрээр явагдана.

Суралцагсдын тоо хэмжээ, хичээллэх хугацаа, газар, журам, сурагч сургагчийн хоорондын холбоо, нэг бүрийн болон салаа салбарын гүйцэтгэх үүргээс шалтгаалан тухайн сургалтын хэлбэр тодорхойлогдоно.

Цэргийн сургалтын хэлбэрүүдэд: Лекц, семинар, Бие даалт, Бүлгийн дасгал, Шуурхай дадлага, Тактик-жагсаалын хичээл, Тактикийн хичээл, Хээрийн нэгдсэн хичээл, Сурган зааварлах хичээл, Штабын хэсэгчилсэн дадлага, Штабын нэгдсэн дадлага, Команд штабын цэргийн тоглоом, Команд штабын сургууль, Команд штабын хээрийн сургууль, Тактикийн хээрийн сургууль, Байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль зэрэг хэлбэрүүдээр цэргийн сургалт явагддаг.

Эдгээр хэлбэрүүдийн бүтэц нь өөр өөр байх ба ямар аргаар яаж явуулахыг ойлгохгүйгээр хилийн албаны сургалтыг явуулахад хүдрэлтэй юм.

Эдгээр хэлбэрүүдийг нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй бөгөөд зайлшгүй хилийн албанд хэрэглэгддэг онол, дадлага, дасгал, бие даалт, практик ажиллагаа буюу хээрийн хичээл, тактик-жагсаалын хэлбэрийг товч авч үзье.

Хилийн албаны хичээл заах арга зүй 1,2 /Ч.Дашдэлэг 1986 он/, Офицер, штаб, нэгтгэл, ангид тактикийн бэлтгэл заах арга зүй /1974он/ зэрэг номонд дэлгэрэнгүй тусгасан байдаг.

Эдгээр хэлбэрүүд нь цэргийн сургалтын хялбар дөхөм байх зарчмын дагуу хөнгөнөөс хүндрүү чиглэсэн өөр хоорондоо нягт холбоотой, нэг нь нөгөөгөө баяжуулж байдаг.

Хилийн албаны тактикийн бэлтгэлийн сургалтын процессын өөр нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь дайчдад хилийн албаны дадлага чадвар суулгах явдал юм.

Хилийн албаны хичээл нь сургалтын зорилго агуулгаас шалтгаалж зөвхөн ангид төдийгүй төрөл бүрийн газар орон, цагийн байдлын хүндэрсэн нөхцөлд хээр явагдах бөгөөд түүнийг зохион байгуулалтын талаас:

1.Онол

2.Дадлага

3.Дасгал

4.Бие даалт

5.Практик ажиллагаа буюу хээрийн хичээл гэсэн үндсэн хэлбэрүүдэд хуваана.

Онолын хичээл: Хилийн албаны онолын хичээлээр орчин үеийн улсын хил хамгаалалт, арга тактикийн онолын үндсүүдийг судална. Онолын хичээл нь гол төлөв танхимд явагдана.

Онолын хичээл нь зохион байгуулалтын хэсэг шинэ мэдлэг олгох хэсэг, сонсогчдод олсон мэдлэгийг бататгах хэсэг, дүгнэх, даалгавар өгөх хэсэг гэсэн бүтэцтэй байна.

Дадлагын хичээл нь: тактик-жагсаалын ба тактикийн хичээл, зэвсэг техник дээр хийгдэх дадлагын хичээлийн хэлбэрүүдээр явагдана.

Дадлагын хичээл нь зохион байгуулалтын хэсэг, мэдлэг шалгах хэсэг, хийж гүйцэтгэх ажлыг үзүүлж тайлбарлах хэсэг, дайчдаар бие даалган дадлага сургууль хийлгэх хэсэг, дүгнэж даалгавар өгөх хэсэг гэсэн бүтэцтэй байна.

Дасгалын хичээл нь сургуульд оролцогсдыг чадвар дадлагатай болгож, түүнийг улам боловсронгуй болгох зорилгоор ямар нэг үйлдэл, арга барилыг олон давтан үйлдэнэ.

Дасгал, дадлага хоёр бол нэг аргын хоёр тал юм.

Дадлагаар олж авсан чадварыг улам боловсронгуй болгох зорилгоор хүндрүүлсэн цагийн байдал дээр дасгалыг явуулдаг.

Дасгал (дадлага)-ын арга нь тактикийн бэлтгэлийн явцад тактик-жагсаалын сургууль, тактикийн шуурхай дадлага болон бүлгийн дасгал хийхэд өргөн хэрэглэгдэнэ.

Хилийн албаны тактик-жагсаалын хичээл нь албаны бэлтгэлийг заах хичээлийн үндсэн хэлбэр, хилийн манаанды албаны талаар анхны мэдэгдэхүүн олгох болох гэж байгаа хээрийн сургууль, тактикийн хичээлийн гол чухал асуудлыг боловсруулах, өмнөх хичээлүүдэд заагдсан алдаа дутагдлыг засах, хилийн манаанды тактик үйл ажиллагааны үйлдлийг элемент элементээр үзүүлж дасгал хийлгэдэг.

Хилийн албаны тактик-жагсаалын хичээлийн онцлог нь хичээлээр боловсруулж байгаа асуудлын үйлдлийг элемент элементээр үзүүлж, дасгал хийлгэн норматив хугацаанд багттал нэг бүрчлэн давтуулж элементийг зөв хийдэг болгосны дараа асуудлыг эхнээс нь дуустал бүхэлд нь бие даалган хийлгэдэг. Тактик-жагсаалын хичээлийг заах үндсэн арга нь дасгал, дадлага байна.

Тактик жагсаалын хичээл нь зохион байгуулалтын хэсэг, мэдлэг шалгах хэсэг, хичээлийн зорилтыг танилцуулж, манаанды үлгэр жишээ ажиллагааг үзүүлэх хэсэг, түүний дагуу дайчдыг бие даалган сургуулилах хэсэг, дүгнэж даалгавар өгөх хэсэг гэсэн бүтэцтэй байна.

Бие даалтын хичээл нь сургалтад голлох үүрэг гүйцэтгэнэ. Бие даан эх сурвалж, хичээлийн холбогдолтой материал судлах нь сонсогчдоос бие даан асуудлыг боловсруулах чөлөөтэй сэтгэдэг, дүгнэдэг, мэдэж байгаа зүйлээ нэвтрүүлж чаддаг дадлагыг олж авдаг.

Бие даалтын хичээл нь зохион байгуулалтын хэсэг мэдлэгийг бататган давтах чиглэлээр даалгаврыг шалгах хэсэг, даалгавар өгөх хэсэг, хичээлийн төгсгөл гэсэн бүтэцтэй байна.

Практик ажиллагааны хичээл нь: Сонсогчдоос, байлдааны цагийн байдалд ойртсон тийм нөхцөлд, тодорхой хугацаанд өөрийн үүрэгт ажлаа хийж гүйцэтгэхийг хэлнэ.

Практик ажиллагаа нь сонсогчдоос тодорхой хэмжээний бэлтгэл, бие даан ажиллах өндөр чадварыг шаарддаг тул суралцагчдаас дадлагын зохих хэмжээний мэдлэг чадвар эзэмшсэний дараа энэ ажилд шилжин орно.

Практик хээрийн ажиллагааны сургалт нь сонсогчдоос өмнөх сургалтын явцад олж авсан мэдлэг, чадвар, дадлага нь зайлшгүй хэрэгцээтэй зүйл болохыг зөвшөөрч өөрийн бэлтгэлийн төвшинг шалгах бололцоог олгодог.

МЭДЛЭГ: Бодит байдлыг танин мэдсэн, практикаар шалгарсан үр дүн, тэр нь хүний сэтгэхүйд буусан зөв тусгал. Ердийн болон шинжлэх ухааны гэж ангилна.

ДАДЛАГА: Хувь хүн аливаа үйлдлийг ухамсарлаж ойлгосны үндсэн дээр зөв хийж сурахыг дадлага гэнэ. Тодорхой хэмжээний дадлага хийхгүйгээр чадвар эзэмшиж чадахгүй.

ЧАДВАР: Аливаа үйлдлийг ухамсартай, бүтээлч, тооцоотой, түргэн шуурхай хийж чаддаг болтлоо эзэмшихийг чадвар гэнэ. Чадвар нь онол, практикийн мэдлэгт түшиглэсэн үйл ажиллагаа бөгөөд харин дадлага нь зөвхөн түүний эхний шат болно.

Цэргийн сургалтын арга

Арга бол зорилгод хүрэх зам мөн. Өөрөөр хэлбэл тавьсан зорилгодоо хүрэхийн тулд ашигладаг арга барил, үйлдлүүдийн цогцолбор юм.

Хичээлийнхээ агуулгыг суралцагчдад эзэмшүүлэхийн тулд багшийн хэрэглэж байгаа сургалтын аргаас сургалтын чанар ихээхэн шалтгаална.

Суралцагчдад хилийн албаны тухай тодорхой мэдлэг, дадлага, чадвар эзэмшүүлэх, жигдрэлтийг хангахад

1. Шинэ мэдлэг олгох, олсон мэдлэгийг бэхжүүлэх
2. Дадлага чадвар суулгах
3. Тактикийн сэтгэлгээг хөгжүүлэх гэсэн үндсэн зорилго тавигдана.

Хилийн албаны мэдлэг, дадлага, чадвар эзэмшүүлэх, жигдрэлтийг хангах сургалтыг тухайн багш ярих, тайлбарлах, ярилцах, үзүүлэх, дасгах, бие даалгах, асуух, шалгах, үйлдүүлэх, зуруулах, бичүүлэх, дасгал хийлгэх, бүлэглэх болон ганцаарчлан заах гэх мэт аргыг ашиглана.

Дүгнэлт: Удирдлагын академийн Хилийн албаны сургалтыг суралцагч нарт тохирсон агуулгатай, төлөвлөлтийн тодорхой зохион байгуулалт, сургалтын хэлбэр, арга ажиллагаа, хэрэгсэл, тактикийн бэлтгэл сургалтын түвшинд онолоос илүүтэй дадлага, дасгал, чадвар олгоход чиглэгдсэн байдлаар явуулах нь үр дүнтэй бөгөөд цэргийн болон хил судлалын шинжлэх ухааны онолын суурь ойлголтыг өгч хил хамгаалах урлагийн тактик, оператив, стратегийн түвшинд хил хамгаалалтыг бэлтгэж, явуулах ажиллагаанд сургаж, улсын хилийг найдвартай хамгаалахад хэрэгцээтэй бүхэнд сургахад албаны сургалтыг хандуулах нь зүйтэй.

Хилчид тайван цагт байлдааны үүрэг гүйцэтгэж байдаг албаны онцлогт тохируулан хилчдийг сургахад хилийн албаны хичээл гол үүрэг гүйцэтгэнэ.

Хилийн алба нь улсын хил хамгаалах үүргийг биелүүлэхэд хилийн манаа, харуул, застав, отрядын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдан явуулах, хил зөрчигчтэй тэмцэх арга ажиллагаанд сургахдаа зөвхөн хууль тогтоомж дүрэм, зааврын хүрээнд кейс жишээ болсон үйл явдалд дүгнэлт хийн бодлого бодуулах уламжлалт хил хамгаалалт, хилийн манааны ажиллагааг эзэмшүүлэхээс гадна өнөөдөр дэлхийн бусад улс оронд хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилийн манааны арга тактик, өрнөж буй цагийн байдал, ашиглагдаж буй техник хэрэгслийг талаар тодорхой ойлголт өгч мэдлэг, дадлага, чадварыг хөгжүүлэх ирээдүйд үүсч болох цагийн байдалд ажиллахад бэлтгэгдсэн офицеруудыг бэлдэх нь өнөөгийн эрэлт байж болох юм.

Сургалтын зарчим нь сургалтын процессын удирдамжийг тодорхойлдог бол үйл ажиллагааны дүрэм, заавар журам нь тусгай нэгж, салбар юу хийхийг тусгасан байдаг.

Хилийн албаны сургалтыг хилийн албаны мэдлэг, дадлага, туршлага мөн сургалтын аргаар хослуулан явуулах бөгөөд цэргийн

сургалтын зарчим, хэлбэр, арга зүйг эзэмших, суралцагч нарт эзэмшүүлэх нь зүйтэй гэж дүгнэж болохоор байна.

Дараагийн дугаараар цэргийн сургалтын бусад хэлбэр аргын талаар ялангуяа удирдах бүрэлдэхүүнтэй явагддаг бүлгийн дасгал, штабын нэгдсэн болон хэсэгчилсэн дадлага, команд штабын сургуулийн талаарх мэдээллийг та бүхэнтэйгээ хуваалцах болно.

Ашигласан материал

1. “Офицер штаб нэгтгэл ангид тактикийн бэлтгэл заах арга зүй” 1976 он
2. Мотобуудлага танкийн салбаруудын тактикийн бэлтгэл
3. Хилийн албаны хичээл заах арга зүй 1,2
4. Монгол улсын хилчний тайлбар толь 2003
5. Хилийн нэр томьёоны тайлбар толь 2010
6. Цэргийн нэр томьёоны тайлбар толь
7. Штабын сургалт бэлтгэл 2013

ЕВРОПЫН ХОЛБООНЫ “НЭЭЛТТЭЙ ХИЛ”-ИЙН БОДЛОГО БА ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭЖ БУЙ ТУРШЛАГА

EU POLICY ON OPEN BORDER AND ITS EXPERIENCES FOR COMBATING TERRORISM

С.Энхсүх.
ДХИС-ийн Хил судлалын докторант, хурандаа
Enkhsukh.S
Graduate Student at UIA in Border Studies, Colonel

Хураангуй: Европын холбооны улс орнууд нь НҮБ-ын дүрмийн шаардлага, олон улсын эрх зүйн зарчимд тулгуурлан холбооны улсын гадаад хилийн аюулгүй байдлыг хангахад баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийг хүлээдэг. Энэхүү судалгааны ажилд Европын холбооны нээлттэй хилийн бодлого, терроризмтой тэмцэж буй арга туршлагын талаар судлан үзсэн болно.

Abstract: EU member states are responsible to develop and implement its state policy on border based on requirements of the Charter of the United Nations and principals of the international legislation. In this study, we aimed to investigate the main objectives and particularity of the state policies on the external border of EU and experiences of combating terrorism.

Түлхүүр үгс: НҮБ-ын дүрэм, олон улсын эрх зүйн зарчим, хилийн талаар баримтлах бодлого, терроризм

Keywords: Charter of the UN, principals of the international legislation, border policy, combating terrorism

Европын Холбоо (ЕХ) нь улс төр, эдийн засгийн нягт хамтын ажиллагаа бүхий “нээлттэй хил”-ийн бодлогыг 1985[1] оноос эхлэн нэвтрүүлж эдүгээ 27 орныг гишүүнчлэлдээ нэгтгээд байна. ЕХ нь 4.233.255.3 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, 447 сая хүн амтай, зах зээлийн болон эрх зүйн хэм хэмжээний нэгдсэн зохицуулалттайгаар хөгжиж байна.

Түүхэн эх сурвалжаас үзэхэд ЕХ-ны үүслийг 1951 онд Белги, Герман, Франц, Итали, Люксенбург, Голланд зэрэг улсууд эдийн засгийн хамтын ажиллагааны “Европын нүүрс, төмрийн нийгэмлэг”-ийг байгуулснаар тавигдсан гэж үздэг[2].

Түүнчлэн Шенгений хэлэлцээр (1985)-ийн хүрээнд тусгай бүс нутгийг бий болгож, гишүүн орны иргэдийг улсын хилээр харилцан визгүйгээр нэвтрэх хөдөлгөөнийг зөвшөөрсөн нь олон улсын хэмжээнд хилийн нээлттэй бодлогын томоохон эргэлтийг бий болгосон явдал болсон. Улмаар уг хэлэлцээрээр гишүүн орнуудын дотоод хилийн хяналтыг цуцалж, нийтлэг визийн бодлогыг бий болгосон бөгөөд гишүүн улсуудын гадаад хилийн хамгаалалтад үндсэн чиглэлийг хандуулах болсон.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Сайд нарын зөвлөлөөс 2005 онд

[1] James, R.P., Jeffrey, D., Monica, K., (2018). *“Border Security”*, Carolina Academic Press, Durham, 373

[2]Declaration of 9 May 1950, European Commission. Retrieved 5 September 2007

баталсан “Хилийн аюулгүй байдал, менежментийн үзэл баримтлал” нь гишүүн орнуудын хилийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг зохицуулах бодлогын баримт бичиг бөгөөд олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд харилцан итгэлцэх, түншлэх, эрх тэгш, нээлттэй, байх зарчмуудыг баримтлан ажиллахыг тунхаглажээ.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Сайд нарын зөвлөлөөс баталсан “Хилийн аюулгүй байдал, менежментийн үзэл баримтлал” нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд гишүүн орнуудын хүлээх үүргийг дэлхий, тив, бүс нутгийн болон хоёр талын хэмжээнд хэрхэн уялдуулан зохицуулах талаар нарийвчлан тусгасан байдаг. Тухайлбал:

- Дэлхийн хэмжээнд: гишүүн орнууд нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа олон улсын хууль, хүний эрх, дүрвэгсэд, хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж Дэлхийн гаалийн байгууллага, Шилжилт хөдөлгөөний олон улсын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын дүрвэгсдийн дээд хороо болон бусад олон улсын байгууллагуудаас гаргасан үйл ажиллагааны зөвлөмж, стандартыг мөрдлөгө болгоно;

- ЕАБХАБ-ын хэмжээнд: гишүүн орнууд нь Хельсинкийн эцсийн тайланд тусгагдсан эрх тэгш, нээлттэй байх зарчим, нийтлэг хэм хэмжээг баримтална. Ингэхдээ Копенгагены баримт бичиг (1990), Хельсинкийн баримт бичиг (1992), Европын аюулгүй байдлын тунхаг бичиг (1999) болон ЕАБХАБ-аас хүлээн зөвшөөрсөн хилийн аюулгүй байдлыг хангах талаар гаргасан бусад эрх зүйн баримт бичгийг удирдлага болгоно;

- Бүсийн болон дэд бүсийн хэмжээнд: гишүүн орнууд нь бүсийн болон дэд бүсийн хэмжээнд хүлээсэн үүрэг, хариуцлагаа бүрэн ухамсарлаж хилийн аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, стандартыг мөрдөн ажиллах бөгөөд үйл ажиллагааны хэрэгжилтэд аливаа давхардал үүсгэхээс татгалзана;

- Хоёр талын хэмжээнд: гишүүн орнууд нь сайн хөршийн харилцааг эрхэмлэх, хилийн асуудлаар байгуулсан хоёр талын гэрээ, хэлэлцээрийг хүндэтгэх, харилцан туршлага хуваалцаж ажиллахыг эрмэлзэнэ гэж тусгажээ.

Энэхүү үзэл баримтлалын хүрээнд хил дамнасан зохион байгууллаттай гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Хилийн нэгдсэн менежментийн загвар (Integrated Border Management Model)-ыг Европын холбооны гишүүн орнуудын гадаад хил хариуцсан агентлаг Фронтекс (FRONTEX)-ээс нэвтрүүлж гишүүн орнуудын хилийн албадын харилцаа, хамтын ажиллагааг уялдуулах, туслалцаа үзүүлэх, хамтарсан операци, сургалт, судалгаа, мэдээлэл солилцох систем бүрдүүлэх зэрэг олон арга хэмжээг зохион байгуулдаг байна. Түүнчлэн ЕХ-ны гадаад хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг эрх зүйн хэм хэмжээний хүрээнд буюу хуулийн дагуу зохион байгуулах, иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, гадаад хилийн аюулгүй байдлыг хангах замаар дотоодын болон нийтийн

аюулгүй байдлыг хангах гэсэн үндсэн зарчимд тулгуурлаж байна[3].

Одоогоор Европын холбооны гишүүн орнуудын гадаад хил хариуцсан агентлагт мэргэшсэн 6500 (2021) орчим албаа хаагчид үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид гадаад хил хамгаалалтын үйл ажиллагааг бэхжүүлэх, албаа хаагчдыг чадавхжуулах бодлогыг баримтлан ажиллах, албаа хаагчдын тоог 2027 он гэхэд 10000-д хүргэхээр төлөвлөж байна[4].

Фронтекс нь Европын хилийн хяналт, шалгалтын систем (EUROSUR)-ийг байгуулж гишүүн болон гуравдагч орнуудын хил хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллан 2020 оны байдлаар 13170 хүний ам нас, эрүүл мэндийг хил, хил орчмын нутаг дэвсгэрт хамгаалж, хүн худалдаалах гэмт хэргийг зохион байгуулагч 742, хар тамхи мансууруулах бодисын хууль бус эргэлтийг зохион байгуулагч 453 этгээдийг илрүүлэн 147 тонн хар тамхи, мансууруулах бодисийг хураан авсан байна[5].

ЕХ-ны “нээлттэй хил”-ийн бодлогын нэг онцлог нь гадаад хил хамгаалалтын үйл ажиллагаанд жил бүр эрсдлийн үнэлгээг хийх явдал юм. Жишээлбэл, Эрсдлийн үнэлгээ-2020[6] баримт бичгийн аргачлалыг дараах үндсэн чиглэлээр хийсэн байна. Үүнд:

- Хилийн зөрчлийн илрүүлэлт;
- ЕХ-ны хилээр нэвтрэхийг түтгэлзүүлсэн байдал;
- Зөвшөөрөлгүй оршин суугчдыг илрүүлсэн байдал;
- Нутаг буцаах шийдвэрийн хэрэгжилт;
- Баримт бичгийн хуурмаглал зэрэг болно.

Фронтекс нь ЕХ-ны гадаад хилийн 141846 зөрчлийг 2019 онд илрүүлэн шийдвэрлэсэн байна[7]. Хилийн зөрчил гарч буй чиглэлийг Баруун Африкийн, Баруун газар дундын, Төв газар дундын, Зүүн газар дундын, Албани-Грекийн тойрог, Хар тэнгисийн, Дорнод хилийн зам хэмээн тогтоож эдгээр чиглэлүүдэд хүч хэрэгслийг төвлөрүүлэн ажиллаж байна (Зураг 1). Хилийн зөрчлийн зонхилох хэлбэрийг нь хууль бусаар улсын хил нэвтрэх, баримт бичгийн хуурмаглал үйлдэх, хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг, сум, галт хэрэгсэлийн хууль бус наймаа, хууль бус шилжилт хөдөлгөөн, цагаачлал зэрэг эзэлж байна. Хамгийн их хилийн зөрчил гаргасан буюу цагаачлах хөдөлгөөн үйлдсэн орноор Афганистан (34154), Сири (24390), Морокко (8020) зэрэг улсууд бүртгэгджээ (2019).

Зураг 1. Европын Холбооны гадаад хилийн зөрчлийн нөхцөл байдал (2019 оны байдлаар)


[3] https://ec.europa.eu/home-affairs/what-we-do/policies/securing-eu-borders_en

[4] https://www.consilium.europa.eu/en/ policies /strengthening- external-borders/

[5] European Border and Coast Guard Agency, (2021). In Brief 2020, Luxembourg, Publications Office of the European Union

[6] Risk Analysis for 2020, European Border and Coast Guard Agency (Frontex), 2020

[7] 2018 онд 149117 хилийн зөрчлийг илрүүлэн шийдвэрлэсэн.



Эх сурвалж: Risk Analysis for 2020, European Border and Coast Guard Agency (Frontex), 2020

Фронтекс нь холбооны гишүүн орнуудтай хамтран хэт даврагсад,, салан тусгаарлагчид, терроризмтой тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Ялангуяа хилийн шалган нэвтрүүлэх боомтод зорчигч, ачаа бараа, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх явцад аливаа зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, сэжигтэй этгээдийн мэдээллийг холбогдох байгууллага, гишүүн орнуудад шуурхай дамжуулах чиглэлд түлхүү анхаарч ажилладаг байна.

Хүснэгт 1. Терроризтой тэмцэх харилцан ажиллагааны зарчим

Болзошгүй аюул, заналын талаарх мэдээллийг харилцан солилцох зарчим	Мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх хүрээ	Харилцан мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх байгууллагууд	Европын холбооны бодлогод тусгах санал, зөвлөмжийг боловсруулах байгууллагууд
Европын холбооны гишүүн орнуудын төрөлх хэлээр мэдээллийг шуурхай хүргэх	Хилчид; Хилийн хяналтын байгууллагын албан хаагчид; Хууль сахиулагчид; Төрийн тусгай байгууллагын албан хаагчид	INTERPOL[8] CEPOL[9] EUROPOL[10] EU CTC[11] INTCEN[12]	CCWP[13] COSI[14] COTER[15] TWP[16]

Эх сурвалж: Risk Analysis for 2021, European Border and Coast Guard Agency (Frontex), 2021

[8] Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага
[9] Европын холбооны Хууль сахиулагчдын сургалт, бэлтгэлийн агентлаг
[10] Европын холбооны Хууль сахиулах агентлаг
[11] Европын холбооны Терроризмтой тэмцэх координатор
[12] Европын холбооны Тагнуулын мэдээлэл, дүн шинжилгээний алба
[13] Европын холбооны Гаалийн хамтын ажиллагааны алба
[14] Европын холбооны Дотоод аюулгүй байдлын байнгын хороо
[15] Европын холбооны Газар нутгийн хамаарлын хороо
[16] Европын холбооны Терроризмтой тэмцэх алба

Түүнчлэн Европын холбооны гэмт хэрэгтэй тэмцэх олон талт хамтын ажиллагааны алба (EMPACT)-наас терроризмтой тэмцэх үйл ажиллагааг нь олон улсын байгууллага, гишүүн орнуудын үндэсний хууль сахиулах байгууллага болон Европын холбооны бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг байна.

Энэхүү судалгаанд Европын Холбооны Улсын гадаад хил хамгаалалтын талаар баримталж буй бодлогын үндсэн чиглэл, терроризмтой тэмцэж буй онцлогийн талаар судалсан бөгөөд судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

Нэгдүгээрт: Европын Холбооны Улс нь гадаад хилийн талаар баримталж буй бодлогын баримт бичгийн агуулга, үзэл баримтлал, үндсэн чиглэл нь НҮБ-ын дүрэм, олон улсын эрх зүйн хэм хэмжээний зарчимд нийцэж байна.

Хоёрдугаарт: Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Сайд нарын зөвлөлөөс 2005 онд баталсан “Хилийн аюулгүй байдал, менежментийн үзэл баримтлал”-д олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд харилцан итгэлцэх, түншлэх, эрх тэгш, нээлттэй байх зарчмуудыг баримтлан ажиллахыг үндэслэл болгон тунхаглажээ.

Гуравдугаарт: Хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналд хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хэт даврагсад, салан тусгаарлагчид, зэвсэгт бүлэглэл, терроризм, улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан болон хориглосон бараа бүтээгдэхүүний хууль бус эргэлт, хууль бус шилжилт хөдөлгөөн, үй олноор хөнөөх зэвсэг түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, маргалдаан, зөрчилтэй хилийн орон зай гэх мэт хүчин зүйлсийг нийтлэгээр багтаасан байна.

Дөрөвдүгээрт: Европын Холбооны Улсын хилийн талаар баримтлах бодлогын баримт бичиг нь НҮБ-ын дүрэм болон хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх; улс орны тэгш бүрэн эрхийг хангах; дотоодын хэрэгт үл оролцох; нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх; улсын хил халдашгүй дархан байх; маргааныг эв зүйгээр шийдвэрлэх; хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх; ард түмнүүд тэгш эрхээр өөртөө засан тогтнох; олон улсын үүргээ шударгаар биелүүлэх тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээний зарчимд тулгуурласан байх бөгөөд терроризмтэй тэмцэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь мэдээллийг шуурхай солилцох, харилцан ажиллагааг өндөр түвшинд нягт зохион байгуулах, алба хаагчдын чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

Тавдугаарт: Манай орны хувьд терроризмын бодит аюул сүүлийн 20 жилд[17] бүртгэгдээгүй байх боловч урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэл, ажил, арга хэмжээг тухайлан тодорхойлох нийгмийн бодит хэрэгцээ шаардлага бий болоод хэмээн судлаачийн зүгээс үзэж байна.

[17] Дэлхийн терроризмын индекс GTI

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АШИГЛАЛТЫН НОРМ, СТАНДАРТЫН АСУУДАЛД

ON THE ISSUE OF NORMS AND STANDARDS OF PETROLEUM PRODUCTION

Б.Будсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахлах дэслэгч
B.Budsuren
University of internal affairs, postgraduate master, senior lieutenant

Хураангуй: Газрын тосны бүтээгдэхүүний галын аюулгүй байдал, норм, стандарт, зарим орны туршлагын судалгаанд тулгуурлан газрын тосны бүтээгдэхүүний өнөөгийн байдлыг шинжилж, түүний сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Abstract: Based on a study of fire safety, norms, standards, and some years of experience in petroleum products, it aims to analyze the current state of petroleum products and identify ways to improve it.

Түлхүүр үг: Газрын тосны бүтээгдэхүүн, галын аюулгүй байдал, хадгалалт
Key words: Petroleum products, fire safety and storage

Монгол Улсын эдийн засгийн салбарт газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил тутам өсч түүнийг үйлдвэрлэх, хадгалах, боловсруулах, тээвэрлэх, худалдаалах үйлчилгээний хүрээ улам өргөжиж байна. Манай улсын одоогийн нөхцөлд хүн амын эрүүл мэнд, аюулгүй орчинд нөхцөлийг зохих ёсоор хангаж баталгаажуулахад газрын тосны аж ахуй, нэгжид холбогдох норм, стандартын дагуу байгуулж ашиглах нь түүнд үүсэж болзошгүй гал түймрээс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааг боловсронгуй болгох асуудлыг онол арга зүйн талаас судлах нь тулгамдсан асуудал болж байна.

Манай Улс нь газрын тосны хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж 2020 онд 1,6 сая тонн хүрч, 2022 онд 1,9 сая тонн болох төлөвтэй байгаа боловч газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг орнуудаас 100 хувь импортоор хангаж, газрын тосны зохих нөөцтэй, ойрын үед газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байгаа хэдий ч одоогийн нөхцөл байдалд аюулгүй байдлаа хангах стандарт, норм ба дүрэм хангалтгүй байна.

“Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ийн 3.2.4.3-д Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөхөөс сэргийлж улсын нөөцийг түүхий нефтиэр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана гэж заасан байдаг.

Газрын тосны салбарын обьект нь эрсдэл өндөртэй, гамшиг, аюулт үзэгдэлд өртөх магадлал өндөртэй байдаг. Учир нь газрын тосны бүтээгдэхүүн нь шатамхай чанараараа онцгой аюултай бодисуудын ангилалд хамаардаг. Газрын тосны бүтээгдэхүүн нь шатамхай тэсрэмтгий, очноос шатах, температур ихсэхэд өөрөө шатах, шатахууны уур, агаарын холимог тэсрэлтийн аюултай болон өндөр температур ялгаруулан шатах, гал хурдан тархах, хортой учир байгаль орчинд сөрөг нөлөөлөхөөс гадна хүний

биед хортой, стратегийн чухал бүтээгдэхүүн зэрэг онцлог шинж чанартай.

Олон улсын туршлагаас үзэхэд орчин үед аливаа байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгийг урьдчилан харж, сэрэмжлүүлэх нь түүний хор хохирлыг арилгах үйл ажиллагаанаас 15-20 дахин бага зардал гардаг гэдгийг тогтоосон байдаг.

Газрын тосны бүтээгдэхүүний норм, стандартад хийсэн шинжилгээ

Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савыг өмчлөгч савыг улсын бүртгэлд бүртгүүлнэ. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалтын савыг улсын бүртгэлд бүртгэх журмыг газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.[1]

“Газрын тос**”** гэж газрын хэвлийд болон агаарын хэвлийн даралт, хэмд хатуу, шингэн, хий төлөвт орших нүүрс-устөрөгчийн нэгдэл /түүхий тос, байгалийн хий/-ийг хэлнэ гэж заажээ.

“Газрын тосны бүтээгдэхүүн” гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг хэлнэ гэж заасан байна.

Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалахад дараах зүйлийг анхаарах шаардлагатай байдаг. Газрын тосны бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, саванд хадгална.

Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах агуулах эзэмшигч хуулийн этгээд дор дурдсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй байдаг. Үүнд:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх;

2. Газрын хөрсний геологийн дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар хийлгэх;

3. Эрх бүхий мэргэжлийн байгууллагаар боловсруулж, улсын экспертизийн хяналт хийлгэсэн зураг, төслийн дагуу барьсан байх, газар эзэмших зөвшөөрөлтэй байх;

4. Мэргэжлийн хяналтын байгууллагаар ариун цэвэр, эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах;

5. Галын аюулгүй байдлын /А/ дүгнэлт гаргуулах;

6. Агуулах, шатахуун түгээх станцын барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын акт, барилга байгууламжийн үндсэн бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөв байдлыг тодорхойлсон техникийн дүгнэлттэй байх.

Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалахад дараах зүйлийг хориглодог байна. Үүнд:

1. Зориулалтын бус барилга байгууламжид, мөн улсын комисс хүлээн аваагүй барилга байгууламжид газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах;

2. Стандартын шаардлага хангаагүй саванд хадгалах;

3. Нэвчилт, шүүрэлттэй дамжуулах хоолой ашиглах;

4. Аянга зайлуулагч, газардуулгын байгууламжгүй, уг байгууламжийн эсэргүүцлийг нь

[1] Монгол Улсын Газрын тосын тухай хууль, УБ, 2014 3-р зүйл

мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулаагүй сав, тоног төхөөрөмж ашиглах;

5. Газрын тосны бүтээгдэхүүнийг автоцистернээс газардуулгагүй буулгах;

6. Газрын тосны бүтээгдэхүүнийг зориулалтын буулгах байгууламжгүй саванд буулгах заалтыг тус хуульд зааж өгснөөр газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, агуулахын асуудлыг дээрх хуулиудаар зохицуулж байдаг бол галын аюулгүй байдлын асуудлыг Галын аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулж байдаг.

Галын аюулгүй байдал гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон төр, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг хэлнэ гэж заасан.

Галын аюултай болон тэсэрч дэлбэрэх бодис, материал хадгалж /шатахуун түгээх станц, шатах хий хадгалах зэрэг/, ашиглахад гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагаас гал түймрийн улсын хяналтын зөвшөөрлийг авсан байх ёстой.

Галын аюултай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах иргэн болон хуулийн этгээд нь энэ тухайгаа гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авах үүрэгтэй болно.

Барилга, хот байгуулалтын сайдын тушаал 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 57 дугаар тушаалаар Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний галын аюулгүйн норм БНбД 21-07-14-ыг хавсралтаар батлсан байна.

Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Дэд бүтцийн хөгжлийн сайдын “Норматив-техникийн баримт бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 1996 оны 2 дугаар тушаалаар мөрдөгдөж байсан “Склады нефты, и нефтепродуктов, противопожарные нормы” СНиП 2.11.03-93-ыг төслийг ажилд мөрдөхийг зогсоожээ.

Тус нормыг ОХУ-ын СП 155.13130.2014СКЛАДЫ НЕФТИ И НЕФТЕПРОДУКТОВ Требования пожарной безопасности, БНХАУ-ын GB-50074-2002 Газрын тосны агуулахын загвар түүний загвар, АНУ-ын NFPA-30 Flammable and Combustible Liquids Code / Шатамхай шингэн болон шингэрүүлсэн хийн дүрэм /эрх зүйн баримт бичгүүдтэй галын аюулгүйн зай хэмжээг харьцууллаа.[2]

Хүснэгт 1. Монгол Улс, ОХУ, АНУ, БНХАУ-ын газрын тосны бүтээгдэхүүний стандартыг харьцуулсан судалгаа

д/д	Зүйл, заалтын асуулт	БНбД 21-03-04 Монгол	СП 155.13130.2014 ОХУ	GB 50074-2002 БНХАУ	NFPA 30 АНУ
1	Ангилал	I II IIIа IIIб IIIв	I II IIIа IIIб IIIв	I II III IV V	IA IB IC
2	Зэргэлдээх барилга байгууламж	100-30	100-30	100-50	Савны багтаам-

[2] А.Алтанбагана “Газрын тосны агуулахад галын аюулгүй байдлыг хангах асуудал” 2015, УБ

					жаас хамаарч-116 м
3	Авто зам (зорчих хэсгийн зах хүртэл); Гол замаас Туслах замаас	75-45 40-15	75-45 40-15	25-15	-
4	Орон сууц, олон нийтийн барилга, гэр хороолол, хатуу түлш хэрэглэдэг зуух бүхий барилга	200-100	200-100	100-50	116
5	Нийтийн үйлчилгээний ШТС	50-30	50-30	-	-
6	Автомашины гараж, задгай зогсоол 100	100-40	100-40	-	-
7	Агуулахад үл хамаарах бохир усны цэвэрлэгээний байгууламж	100-40	100-40	-	-
8	Агуулахад хамаарах ус дамжуулах байгууламж	200-70	200-70	-	-
9	Галын болон тэсрэлтийн аюултай үйл ажиллагаа бүхий технологийн төхөөрөмжүүд, илүүдэл хийг шатаах төхөөрөмжүүд (яндан)	100	100	33-30	-
10	Ачиж буулгах төхөөрөмж: Төмөр замын болон автоцистерн	30-20	30-20	47-26,5	-
11	Насос станц (насосны цех), насос станцын хаалтуудын зангилааны барилга буюу талбай, хэмжилт, тооцоололтын зангилаанууд, жижиглэн савлагааны байр, газрын тосны хольц бүхий хаягдал усны насос станц	20-10	20-10	19-9	-
12	Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнтэй үйлдвэрлэлийн хаягдал усыг цэвэрлэх байгууламж:	-	-	-	11
13	Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнтэй үйлдвэрлэлийн хаягдал усыг цэвэрлэх байгууламж: а/ тунгаах талбай, лагийн талбай, хаалттай газрын тос ялгагч, барилгын гадна байрлах флотацийн төхөөрөмж (400 м2 болон илүү шингэний талбайтай), 700м3 болон илүү багтаамжийн хүлээн авах болон тунгаах резервуар; б/ барилга доторх флотацийн төхөөрөмж, шүүр, хаалттай газрын тос ялгагч (400- м4аас бага шингэний талбайтай) 700 м3-аас бага багтаамжийн хүлээн авах резервуар болон тунгаах резервуарууд, лагийн сав,	30-20 15-10 24-15	30-20 15-10 24-15	28-15	-

	озонатор бүхий тунадас угаах төхөөрөмж; в/ ууршуулах талбай				
14	Ил гал хэрэглэх үйл ажиллагаа бүхий барилгууд (газрын тос халаах зуух, халаалтын зуух, гагнуурын ажил г.м), автомашины гараж болон техник үйлчилгээний байр; -хялбар асах газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнтэй резервуараас; -шатамхай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнтэй резервуараас;	60-30 60-24	60-30 60-24	33-26,5	-
15	Галын техникийн хэрэгслийн барилга (хүн амьдрах байргүй), захиргаа аж ахуйн зориулалтын барилгууд	40-30	40-30	33-19	-

Эх сурвалж: СП 155.13130.2014 /ОХУ/, GB 50074-2002 /БНХАУ/, NFPA 30 /АНУ/, БНбД 21-03-04 /Монгол/-ын стандартууд

Газрын тосны бүтээгдэхүүний зааснаар үзүүлэлтийг холбогдох агуулахын гал түймрийн аюулд дүн шинжилгээ хийхэд 2 дугаар хүснэгтэд стандарт норм дүрмийн тусламжтай хянан үзэж дүгнэнэ.

Хүснэгт 2. Галын аюулгүйн дүн шинжилгээ

№	Үзүүлэлт	Дагаж мөрдөх стандарт		
		ГОСТ 12.1.004-91 “Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага”	НПБ107-97 Гадна тоног төхөөрөмжийн гал түймрийн аюулын ангилалыг тодорхойлох нь	НБП 105-95 Барилга байгууламж, өрөө тасалгааны гал түймэр, дэлбэрэлтийн аюулын ангилалыг тодорхойлох нь
1	Гал түймрийн аюулын зөвшөөрөгдөх түвшин	1.2-р зүйл	-	-
2	Гал түймрийн аюулгүй байдлын шаардагдах түвшин	1.2-р зүйл	-	-
3	Дэлбэрэх аюултай хамгийн бага түвшин	-	-	-
4	Дэлбэрэх аюултай хамгийн их зөвшөөрөгдсөн түвшин	-	-	-
5	Нэгж тоног төхөөрөмжид дэлбэрэлт үүсэх магадлал	1.7-р зүйл	-	-
6	Эрсдэлийн утга (магадлал)	-	4-р зүйл	-
7	Осол үүсэх магадлал	-	3.1.1-р зүйл	-
8	Тооцооны илүүдэл даралт болон үйлдвэрлэлийн осол үүсэх магадлал	-	3.1.1-р зүйл	
9	Дэлбэрэлтийн илүүдэл даралт	-	-	2.1-р зүйл

10	Шатлагын үеийн тооцооны илүүдэл даралт	-	3.1.1-р зүйл	-
11	Шатлагын үеийн даралтын долгион	-	3.1.1-р зүйл	-
12	Гал түймрийн шатлагын ачаалал	-	-	3.19-р зүйл
13	Материалын шатах зөвшөөрөгдсөн жингийн хэмжээ	-	3.1.2-р зүйл	3.1-р зүйл
14	Цацрагийн уналтын утга	-	3.3-р зүйл	3.20-р зүйл
15	Дэлбэрэх аюултай бүсийн хэмжээ	-	3.1.9-р зүйл	-

Эх сурвалж: ГОСТ 12.1.004-91 "Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага", НПБ107-97 Гадна тоног төхөөрөмжийн гал түймрийн аюулын ангилалыг тодорхойлох нь, НБП 105-95 Барилга байгууламж, Өрөө тасалгааны гал түймэр, дэлбэрэлтийн аюулын ангилалыг тодорхойлох нь"

Газрын тосны бүтээгдэхүүний тухай

Газрын тосноос олон төрлийн бүтээгдэхүүн гарган авдаг бөгөөд тэдгээрийг зориулалтаас нь хамааруулан

1. Шатахуун, түлш
2. Тос, тосолгооны материал
3. Бусад бүтээгдэхүүн
4. Химийн үйлдвэрийн түүхий эд гэж ангилдаг.

Газрын тосны физик шинж чанар тодорхой утгад хязгаартай байдаг. Шаардлагатай утгын үзүүлэлтэд: нягтрал, зуурамтгай чанар, гэрэл нэвтрүүлэлт, өнгө, үнэр болон бусад үзүүлэлт багтана. Газрын тосны нягтрал нь бусад төрлийн биесүүдтэй адил нэгж эзэлхүүн дахь жингээр илэрхийлэгдэх ба дундаж нягтрал нь 20^0С-ын температурт 0.75-1.00 байх ба энэ нь орцоос шалтгаална. Газрын тос (нефть) нь 7000 төрлийн нефтийн химийн бүтээгдэхүүний түүхий эд болдог болохоор нефтийг "үлгэр жишээ их дэлгүүр" гэж эрдэмтэд нэрлэсэн байдаг.[3]

Түлш нь дулаан ялгаруулан шатдаг бөгөөд уг дулааныг янз бүрийн зориулалтын хөдөлгүүрт механик энерги болгон хувиргах эсвэл уурын зууханд усны уур бэлтгэхэд мөн ус халаахад ашигладаг байна. Нефтийн түлшийг хэрэглэгдэх хүрээ, зориулалтаас хамааруулан ангилдаг.

Нефтийн бүтээгдэхүүний физик, хими шинж чанарын үзүүлэлтүүдэд нягт молекул жин, зууралдлага, дулааны шинж чанар, дөл үүсэх, ноцох, өөрөө ноцох, царцах, хайлах хэмүүд гэрлийн ба цахилгааны шинж чанар зэрэг ордог.

Хүснэгт 3. Түлшний химийн найрлагын ангилал

Түлшний гарал	Түлшний химийн найрлага	Түлшний төрөл	
Байгалийн (naturial)	Цэвэр нүүрстөрөгчөөс бүрдсэн (С)	Антрацит	
	Нүүрстөрөгч, устөрөгчөөс бүрдсэн (С+Н)	Газрын тосны байгалийн хий	

[3] Д.Баян-Эрдэнэ, Газрын тосны бүтээгдэхүүний гал түймрийн аюулгүй байдал, унтраах арга зүй, эрсдэлийн үнэлгээний аргачлал, УБ Соёмбо принтинг ХХК, х-6

	Нүүрстөрөгч, устөрөгч, хүчилтөрөгчөөс бүрдсэн (C+H+O)	Чулууннүүрс, аргал г.м	
Хиймэл (artificial)	Цэвэр нүүрстөрөгчөөс бүрдсэн (C)	Кокс, модны нүүрс	
	Нүүрстөрөгч, устөрөгчөөс бүрдсэн (C+H)	Бензин, дизель түлш, керосин	
	Нүүрстөрөгч, устөрөгч, хүчилтөрөгчөөс бүрдсэн (C+H+O)	Спирт, чийгтэй холимог хий	

Нефтийн бүтээгдэхүүний галын аюулгүй байдал, түүний найрлага дахь хөнгөн нүүрсустөрөгчдийн агууламжийг тодорхойлохын тулд дүрс хийн асах, ноцох, өөрөө ноцох хэмийн үзүүлэлтээр илэрхийлдэг.

Нефть бүтээгдэхүүний өөрөө ноцох хэм нь химийн найрлагаасаа хамаарна.

Бензин - Карбюраторт хөдөлгүүртэй машин техникт хэрэглэгдэх янз бүрийн бүтэцтэй C_4-C_{12} нүүрстөрөгчийн атом бүхий нүүрсустөрөгчдийн холимгийг бензин гэнэ.

Бүх төрлийн түлшний олон улсын стандартаар нь ГОСТ 28577.0-90 (ISO 8216/0-86) авч үзвэл 5 бүлэгт хуваадаг.

Хүснэгт 4. Бүх төрлийн түлшний олон улсын стандарт (ГОСТ 28577.0-90) (ISO 8216/0-86)

Түлшний бүлэг	Шинж чанар, түлшний төрөл
G	Хийн түлш- метан, этаны найрлага ихтэй түлш
L	Шингэрүүлсэн хийн түлш- пентан, пропан, бутен, бутан агуулсан
D	Нэрдсийн түлш- газрын тосний нэрлэгийн процессоор гарган авах ба хөнгөн түлшнүүд орно.
R	Үлдэгдлийн түлш- газрын тосны үлдэгдэл фракцаас гарган авсан түлш. Дунд болон дулаан эргэлттэй дизель хөдөлгүүрт хэрэглэх хөдөлгүүрийн түлш, тогооны түлш ба флотын буюу түлшний мазут зэргийг хамааруулна.
C	Газрын тосны гарал үүсэлтэй ихэвчлэн нүүрсустөрөгчөөс тогтсон гидрокрекинг, коксжуулалт, пиролиз зэрэг процессоор гарган авсан хатуу түлш, газрын тосны кокс

Эх сурвалж: Бүх төрлийн түлшний олон улсын стандарт (ГОСТ 28577.0-90) (ISO 8216/0-86

Бүх төрлийн бензинд дараах үндсэн шаардлагууд тавигддаг. Үүнд:

- Аль болох гүйцэт шаталтыг бий болгохоор бүрэн гүйцэт ууршх чанартай байх;
- Хөдөлгүүрийн ашиглалтын үед детонац үүсгэхгүй байхаар детонац сэргүүцэх чадвартай байх;
- Хөдөлгүүрийн тэжээлийн системд болон шаталтын камерт хурдас үүсгэхгүй байх;
- Химийн тогтворжилттой байх;
- Зэврүүлэх нөлөө бага, резинен эдлэлийг хөөлгөдөггүй байх;
- Хөдөлгүүрт бензин тасралтгүй дамжин ирж байхаар дамжуулагдах ба бага хэмийн шинж чанартай байх зэрэг юм.

Автобензин нь нефть боловсруулах технологийн янз бүрийн процессуудаар гаргаж авсан олон бүрдүүлэгчүүдийн холимог юм. Тэдгээр

нь хоорондоо нүүрс устөрөгчийн болон фракцын бүтцээрээ ялгаатай. Автобензинд фракцын янз бүрийн бүтэцтэй шууд нэрлэгийн болон бага октант бензинийг катализаторт риформингоор боловсруулсан бүтээгдэхүүн мөн катализаторт крекинг, дулааны крекинг, удаашруулсан коксжуулалтын бүтээгдэхүүн, пиролизын, гидрокрекингийн бензин, хийн бензин, үнэрт нүүрсустөрөгч гарган авах процессын, рафинат техникийн бутан, пентан, гексан мөн өндөр октант бүрдүүлэгч алкилат ба үнэрт нүүрс устөрөгчүүд зэргээс гаргаж авна.

ОХУ-ын ГОСТ 2084-77- дагуу А-76, АИ-92, АИ-93, АИ-98 маркийн бензинүүд үйлдвэрлэж байгаа болно.

А-76, А-80 маркийн бензинүүдийг Газ-66, Зил-130, Уаз-469 зэрэг автомашинуудад хэрэглэдэг. А 92, АИ-93 марзийн бензинүүдийг ВАЗ, АЗЛК ба ГАЗ заводын суудлын автомашинууд мөн барууны гэж нэрлэгддэг Хьюндай маркийн Ексел, Сонато загвар, Бенз, Форд зэрэг маркийн хөнгөн суудлын авто машинуудад хэрэглэгддэг байна. АИ-98 маркийн бензин нь ОХУ-ын хувьд Чайка, Зил зэрэг дээд ангилалын суудлын автомашины хүч нэмэгдүүлсэн хөдөлгүүрүүдэд ашиглагддаг.

Дизелийн түлшийг 200-350°дахь хэмд нефтийн шууд нэрэлтийн фракц болох керосины фракцаас гарган авна. Дизелийн түлш нь гадаад байдлаараа бензинийг бодвол арай зуурамтгай, тунгалаг, шар эсвэл улбар шар өнгөтэй шингэн.

Нефтийн хүчлийг тунгалаг болон тосны нэрдсийг цэвэрлэж гаргаж авдаг ба эмульгатор, присадка, янз бүрийн даирхайт болон анилины будгийн уусгагч болгож хэрэглэдэг. Түүхий эд болон бэлтгэх технологиос хамаараад 4 маркийн нефтийн хүчлийг үйлдвэрлэдэг.

Дүгнэлт

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний агуулахын ихэнхи сав, тоног төхөөрөмж хуучнаар ЗХУ-д үйлдвэрлэгдсэн сав, шугам хоолой бөгөөд 2000 оноос хойш шинээр баригдсан газрын тосны бүтээгдэхүүний агуулах болон шугам хоолой, шахуурга зэргийг шинэчлэхэд БНХАУ, БНСУ, Европ, АНУ-аас импортлон авчирж угсарч байна.

Цаашид Австралийн NFPA-ын стандартууд болон БНХАУ-ын GB (Ghunggua Byajing) болон Европын зарим дүрэм, стандартыг судалж зарим тоног төхөөрөмжтэй холбоотой заалтыг өөрийн улсад мөрдөгдөж байгаа норм, дүрэмд тусгаагүй зөвхөн ОХУ-ын нормоор зохицуулж байна.

Сүүлийн жилүүдийн судалгаанаас үзэхэд шатахуун тээвэрлэлт, жижиглэн болон бөөнөөр худалдаалах явцад гарсан аваар осол, түүнээс үүсэх гал түймрийн аюулгүй байдлыг хангах хууль, норм, стандарт шаардлага хангах тал дээр хангалтгүй байна.

Газрын тосны бүтээгдэхүүний нэг гол үйл ажиллагаа болох ачиж буулгах ажлыг хийдэг автоцистерний галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт, норм одоогоор манай улсад байхгүй байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Газрын тосны тухай хууль. Улаанбаатар хот, 2014 он, 4-р зүйл
2. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль. Улаанбаатар хот, 2005 он, 4-р зүйл
3. Газрын тосны тухай хууль, /Шинэчлэсэн найруулга/, 2014.07.01
4. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
5. Д.Баян-Эрдэнэ, Газрын тосны бүтээгдэхүүний гал түймрийн аюулгүй байдал, унтраах арга зүй, эрсдэлийн үнэлгээний аргачлал, Улаанбаатар хот, 2013 он
6. Ч.Юмбүүхүү “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн галын аюулгүй байдалд анхаарах зарим асуудлууд” Улаанбаатар хот, 2020 он
7. Ж.Цэвээнжав, В.Алимаа, Ц.Алтанцэцэг нар “Нефть хийн аж үйлдвэрийн үндэс” Улаанбаатар хот,
8. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм БНбД 21-03-04, Улаанбаатар хот, 2004 он
9. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

FIRE FIGHTING AND RESCUE CLASS CAPACITY WAYS TO INCREASE

Б.Тэгшжаргал
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Tegshjargal.B
University of internal affairs master Senior Lieutenant

ТҮЛХҮҮР ҮГС: Гал түймэр унтраах, анхны тусламж, ангийн байрлалаас гарч аврах, аврах ангийн бэлэн байдал, тоног төхөөрөмж, техник

KEY WORDS: Firefighting, first aid, rescue from the scene, rescue team readiness, equipment and techniques

Хураангуй

Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдал гэж болзошгүй гал түймрийн үед түүний сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах хүн хүч, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдан үүргийг гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байдлаар илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл томилгоот ээлжийн хүч хэрэгсэл ангийн байрлалаас гарч аврах, гал түймэр унтраах, анхны тусламж үзүүлэх үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байдлыг хэлнэ. Гал түймэр унтраах, аврах ангийн үүргээ гүйцэтгэх бэлэн байдал нь томилгоот бүрэлдэхүүн болон техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлаас шууд хамаарах хэсгийг дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Abstract: Firefighting and rescue team readiness shall be expressed in the form of personnel, machinery, tools and equipment prepared to perform their duties in order to take appropriate measures to eliminate the negative impact of a potential fire. In other words, the task force is prepared for rescue, firefighting and first aid.

The readiness of fire and rescue teams to perform their duties is directly related to the readiness of the assigned personnel and equipment.

УДИРТГАЛ

Гал түймэр унтраах, аврах анги нь тухайн төв, орон нутгийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, аж ахуй, нэгж байгууллагын өмч хөрөнгө, байгалийн баялгийг объектын, ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан үед хохирол багатай аврах, хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах нь чухал үүрэгтэй бие даасан нэгж юм.

21-р зууны нийгэм дэд бүтэц, техник технологийн хөгжил байгаль, экологийн өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагаа зэргээс шалтгаалан Монгол Улсын гамшгийн сүүлийн 13 жилийн статистик мэдээнээс үзэхэд нийт аюулт үзэгдэл, техникийн холбоотой ослын дийлэнх буюу 91 орчим хувийн объектын болон ой хээрийн гал түймэр эзэлж байна.

Мөн төрөл бүрийн барилгын хийц бүтэц, шатамхай эд материалын ашиглалтаас шалтгаалан галын ачаалал буюу шатах материалын масс

нэмэгдэж, хохирлын хэмжээ ч нэмэгдэх эрсдэлтэй нөхцөл байдал үүсч байна.

Иргэн хуулийн этгээд байгаль орчинд учирч болзошгүй гал түймрийн эрсдэлийг бууруулах зорилгоор төв, орон нутаг, гал түймэр унтраах, аврах анги, нэгжүүдийг шинээр байгуулж байгаа нь сайшаалтай хэдий ч түүний бэлэн байдлыг хангах асуудлыг дээрх нөхцөл байдалтай уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй хангах асуудал нь маш чухал юм.

Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг хангах арга зүйн үндсийг судалж, гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын өнөөгийн түвшинд хийсэн шинжилгээнд тулгуурлан дээшлүүлэх арга тодорхойлоход судалгааны ажлын зорилго оршино.

ҮНДСЭН ХЭСЭГ

Ажил гүйцэтгэх чадвар, мэдлэг, зөв хандлагыг нийлүүлээд цогцоор нь чадамж гэдэг. Хандлага гэдэг нь хүний зан чанар, дотоод сэтгэлийн гадагш гаргаж буй илрэл юм. Хүний хандлага нь маш чухал бөгөөд байгууллага хамт олны ажилдаа хандах хандлагаас их зүйл хамаардаг.

Ур чадвар “мастерство” бол тухайн хүний аливаа үйлдлийг өөрийн гэсэн арга барилаар гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байдаг юм. Мэдлэг ур, чадвар, хандлага гурвын цогц нийлэмжийг чадамж гэж хэлж болно.

Мэдлэг + ур чадвар + хандлага = чадамж

Чадавх гэдэг үгийн утгыг авч үзвэл хүч чадал нөөц бололцоо юм гэжээ. Энэ нь субъектив зүйлд гол төлөв ашигладаг нэр томьёо юм. Гамшгаас хамгаалах салбарт чадавх гэж гамшгийн үр дагавар эрсдэлийн түвшинг тодорхой хэрэгслийн бүрдэл боломжийн талаар илүү дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Танхимын сургалт

Гал түймэр унтраах, аврах ангийн танхимын сургалт нь алба хаагчдад мэдлэг олгоно.

Аливаа сургалтыг эхлүүлэхээс өмнө тухайн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг урьдчилан боловсруулсан байх ёстой.

Сургалтын төлөвлөгөө

Сургалтын хөтөлбөр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж

Хөтөлбөрийг боловсруулахад ашигласан материал

Өдөр тутмын дасгал сургууль

Өдөр тутмын дасгал сургуулийг харуул эзлжинд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, үүрэг гүйцэтгэхэд сэтгэл зүй болон бие бялдрыг бэлтгэх, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгсэлтэй ажиллах дадлага эзэмшүүлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор өдөр тутам хийж гүйцэтгэдэг.

Гал түймэр унтраах дадлага сургууль

Гал түймэр унтраах үед “гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын үндсэн хэсэг нь дадлага сургалт, соён гэгээрүүлэх ажил мөн” юм.

Техникийн үйлчилгээ

ТҮ нь график төлөвлөгөөний дагуу тодорхой гүйлт /хэсэг хугацаа/ явсны дараа албадан хийгддэг. Энэ үед тосолгоо, угаах, цэвэрлэх, чангалах ажлууд заавал хийгдэх ба цэнэглэх,

тохируулах ажлуудыг шаардлагын үүднээс хийнэ.

Засвар

Засварын ажил нь тохиолдсон эвдрэл гэмтлийн дараа шаардлагын дагуу хийгдэхээс гадна осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөтэйгөөр /урьдчилан сэргийлэх засвар/ хийгдэнэ. Урьдчилан сэргийлэх засварт галын галын автомашины хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах системүүд, мөн эвдрэл гэмтэл тохиолдсон үед автомашиныг бүхэлд нь буюу гал түймэр унтраах ажиллагааны үед үндсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүргэх агрегат / түүний дотор бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагаанд нөлөөлөх/ болно.

Радио холбооны техник хэрэгсэл

Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хоорондын харилцан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана.

Хангалт

Ар тал хангалт гэдэг нь зөв хангалтыг зөв тоо, хэмжээгээр, оновчтой захиалгаар, сайн чанар байдалтайгаар, зөв газар зохих цаг хугацаанд худалдан авч нийлүүлэх, хуваарилан хүргэх үйл ажиллагаа юм.

Хөнөөл уршгийг арилгах арга хэмжээний тодорхой үүрэг гүйцэтгэх үед газар, агаар, усан замаар хөдөлгөөн ихээхэн үйлдэх шаардлагатай байдгаас гадна аврах бүлэг хэсэг бэлтгэл ажлаа хангахын тулд үндсэн үйл ажиллагаан дээрээ нэмэлтээр хэд дхэн үйл ажиллагаа явуулдаг. Аврах, хөнөөл уршгийг арилгах ажилгаанд төрөл бүрийн тээврийн хэрэгсэл, завь, нисэх онгоц шаардагддаг бөгөөд тэдгээрт төрөл бүрийн хангалт хэрэгтэй болдог. Энэхүү хангамжид доорх зүйлүүд орно. Үүнд:

шатах тослох материал;

техникийн сэлбэг, тоног төхөөрөмж;

хүнсний зүйл , эм эмнэлгийн хэрэгсэл, майхан сав гэх мэт хүн нэг бүрийн эд хэрэгсэл;

захиргаа аж ахуй, бичиг хэргийн эд гэж тодорхойлсон байна

Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг хангах асуудлын нэгэн чухал хэсэг бол гал түймэр унтраах бодисын нөөцийн асуудал юм. Гал унтраах бодисыг ус, хөөс, нунтаг зэргээр ангилдаг. Гал унтраах бодисоос түгээмэл хэрэглэгдэж байгаа бодис нь ус юм. Тиймээс усан хангамжийн асуудал нь нэн чухал юм. Ангийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт байгаа усан хангамжийн судалгааг гаргаж тодотгон бэлэн байдлыг ханган ажиллах байдал чухал юм.

Аврах, гал түймэр унтраах үйл ажиллагааны үед зохион байгуулагдах ар талын хангалтад амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварын хэсэг зэрэг олон төрлийн үйл ажиллагаа тус арга хэмжээнд хамаарна.

Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын хангалтад дараах асуудлыг авч үздэг. Үүнд:

томилгоот бүрэлдэхүүний хувцас, хэрэглэл

автомашин техник, хэрэгсэл түүний сэлбэг

холбооны хэрэгсэл

хүнсний зүйл

шатахуун

эм бэлдмэл, анхны тусламжийн хэрэгсэл

гал түймэр унтраах бодис

захиргаа аж ахуй, бичиг хэргийн эд зүйлс хамаарна.

Томилгоот бүрэлдэхүүний хувцас, хэрэглэл буюу эрүүл мэнд, амь нас, хөдөлмөр хамгаалын хувцасны техник хэрэгсэл, томилгоот бие бүрэлдэхүүн, хангалт гэж 4 ангилан үзэж болохоор байна.

ДҮГНЭЛТ

Гал түймэр унтраах, аврах ангиуд гал түймрийн үед хүний амь нас, аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг авран хамгаалах эрхэм үүрэгтэй байна. Энэхүү эрхэм үүргээ биелүүлэхэд түүний бэлэн байдал маш чухал бөгөөд бэлэн байдлын хангах арга зүйн асуудлыг тодруулан авч үзлээ. Арга зүйн үндэс болон бэлэн байдлын түвшинг тодорхойлох арга зүйг, судалж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдал нь болзошгүй гал түймрийн үед түүний сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах хүн хүч, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлаар илэрхийлэгдэнэ.

2. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын хүрээнд хамаарагдах арга хэмжээнд гал түймэр унтраах төлөвлөгөө, шуурхай карт, гал түймэр унтраах дадлага сургууль, танхимын сургалт, гал унтраах хүч хэрэгсэл, гал түймэр унтраах, аврах ангийн үйл ажиллагааны эрх зүйн орчин, нөөц гэсэн 6 хэсэгт хуваагдана гэж үзлээ.

3. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг хангах хүчин зүйлийг барилга байгууламж (галын депо), эзэмшлийн талбай, хангалт, түүнд тавигдах шаардлагын талаар дараах эрх зүйн баримт бичиг мөрдөгдөж байна

4. Бэлэн байдлыг хангахтай холбоотой хууль, эрх зүйн орчны шинжилгээнээс үзэхэд дээрх хүчин зүйлийн бэлэн байдлыг хангахтай холбоотой үндсэн шаардлага, үзүүлэлтийг зохих хэмжээнд тодорхойлсон байна гэж үзлээ. тоног төхөөрөмж, Тухайлбал хууль 1, MNS стандарт 10, Монгол Улсын Засгийн газрын тогтоол 1 дүрэм, дэд бүтцийн сайдын тушаалаар батлагдсан 3 норм дүрэм боловсруулагдан батлагдаж, үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.

Харин хангалтын хүчин зүйлд хамаарах холбооны хэрэгслийн бэлэн байдлыг хангах, түүнд тавигдах шаардлагын талаар эрх зүйн баримт бичиг дутагдалтай байгаа нь ажиглагдлаа.

5.Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх

асуудлыг тодорхойлохын тулд түүнийг дээрх үзүүлэлтүүдийн цогцоор, стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхээр нь үнэлж болохоор байна.

6.Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын түвшинг тодорхойлох арга зүйн судалгаанаас Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын түвшин тогтоох шалгуур үзүүлэлтийн аргыг санал болгон дэвшүүллээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол улсын үндсэн хууль

2. Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он

3. Галын аюулгүй байдлыг хангах эрх зүйн бичиг баримтын эмхтгэл, 2019

4. Гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал 2017 он

5. MNS 5566:2005 “Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм”

ХИМИЙН ОСЛООС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME CHEMICAL ACCIDENT PREPAREDNESS ISSUES

А.Бауыржан, Н.Төгсбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Bauirjan.A, Tugsbayar.N
University of internal affairs master Senior Lieutenant

Хураангуй: Энэхүү өгүүлэлд гамшгаас хамгаалах бэлэн байдлын ойлголт, бүрэлдэхүүн хэсэг, бэлэн байдлыг хангахад анхаарах асуудалд тулгуурлан химийн ослын үед ажиллах химийн бүлгийн бэлэн байдлыг хангахад анхаарах зарим асуудлыг авч үзлээ.

Abstract: This article discusses the concept, components, and focus of disaster preparedness. In connection with this, some issues to be considered in ensuring the readiness of the chemical group have been considered.

Түлхүүр үгс: Химийн бүлэг, бэлэн байдал, гамшиг судлал.
Key words: Chemical group, preparedness, disaster research

Удиртгал

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах нь гамшгаас хамгаалах менежментэд онцгой чухал асуудал юм. Гамшиг тохиолдсон үед удирдлагаар хангах, ур чадвар эзэмших, шаардлагатай нөөцийг бий болгох арга хэмжээг авч, хэрэгжүүлэх хугацаа маш бага буюу бараг байхгүй. Ийм учраас бэлэн байдлыг сайтар хангах шаардлагатай байдаг. Бэлэн байдлыг хангах нь урьдчилж үр дүнтэй арга хэмжээ авснаар аюулаас учрах хор уршгийг аль болох багасгах, зарлан мэдээллийг үр дүнтэй дамжуулах, яаралтай тусламжийг хүргэх ажиллагааг шуурхай, оновчтой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх учраас гамшгийн аюулаас учрах сөрөг нөлөөллийг хязгаарлаж чадна.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээний зорилго нь гамшгийн аюулыг урьдчилан мэдэж, түүний болзошгүй сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах, гамшгийн үед болон дараа юу хийх ёстой, хэрхэн үүнийг хийхийг мэдэх болон эдгээр шуурхай арга хэмжээг үр дүнтэй явуулах хүн хүч, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байхад оршино.

Үндсэн хэсэг

Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ нь “хамгаалалтын хоёр дахь зурвас” гэж гадаадын судлаачид үздэг. Энэ арга хэмжээний үндсэн зорилго нь гамшиг гарсан үед аврах ажиллагаа явуулах, хор уршгийг хэрхэн шуурхай бөгөөд үр дүнтэй арилгах, гамшгийн үед гарч болзошгүй бэрхшээлийг урьдчилан төсөөлсний үндсэн дээр тэдгээрийг хэрхэн оновчтой шийдвэрлэх талаар зохих бэлтгэлийг хангахад оршино. Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээг хийх, бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах, гамшигтай тэмцдэг байгууллага ба хүн амын дунд холбогдох сургалтыг зохион байгуулах, гамшгаас сэрэмжлүүлэх ажлыг тогтмол явуулах, зохих нөөц, хүч хэрэгслийг бүрдүүлэх, зарлан

мэдээллийг шуурхай дамжуулах зэрэг ажлууд орно.

АНУ-ын гамшгийн удирдлагын судлаач Фрэдэрик Кьюнигийн хэлснээр “Гамшгаас хамгаалах удирдлагын салбарт хамгийн их боломж, бололцоо олгодог үе нь бэлэн байдлыг хангах үе” гэжээ.[1] Бэлэн байдлыг цаг тухайн нь хангах явдал маш их ач холбогдолтой байдаг юм.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг гэж тухайн гамшгийн цагийн байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний түвшинг хэлнэ. Гамшгийн бэлэн байдлын зэрэг гэж тухайн гамшгийн цагийн байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний үе шатыг хэлнэ. Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, засаг захиргаа, дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар өдөр тутмын, өндөржүүлсэн, бүх нийтийн гэсэн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдтэй байдаг.

Бэлэн байдлыг хангах арга хэмжээ гэдэг нь гамшиг тохиолдсон үед Засгийн газар, яам, агентлаг, байгууллага, орон нутаг, хувь хүмүүсээс хор уршгийг арилгах арга хэмжээг яаралтай зохион байгуулах бэлтгэлийг хангахад чиглэгдсэн арга хэмжээг хэлнэ.[2]

Бэлэн байдлыг хангах арга хэмжээнд гамшигтай тэмцэх төлөвлөгөө боловсруулах, хүч хэрэгсэл, материал, техникийн бэлтгэлийг хангах, бие бүрэлдэхүүнийг сургах арга хэмжээнүүд хамрагдана.

Бэлэн байдлыг хангах арга хэмжээний мөн чанар.

Гамшгийн менежментийн аливаа асуудал бэлэн байдлын асуудалтай холбогдож, түүнээс ямар нэгэн хэмжээгээр шалтгаална. Бэлэн байдлыг хангах арга хэмжээг урьдчилсан сэргийлэх болон хохирлыг бууруулах арга хэмжээтэй харьцуулахад чанарын эрс ялгаатай.

Урьдчилан сэргийлэх болон хохирлыг бууруулах арга хэмжээг Засгийн газрын хэмжээнд боловсруулсан томоохон хөтөлбөрийн хүрээнд гамшигтай тэмцэх удирдах дээд байгууллагын төвшинд ихэвчлэн хэрэгжүүлнэ. Гэтэл бэлэн байдлыг хангах арга хэмжээ ихэвчлэн байгууллага тус бүрт чиглэгдэнэ. Бэлэн байдлыг хангах арга хэмжээнд олон байгууллага хамрагдах учраас тэдгээрийн үйл ажиллагааг харилцан зохицуулахад нэлээд бэрхшээлтэй байдаг.

Бэлэн байдлыг хангах арга хэмжээнд ажил үүргийн хувьд харилцан адилгүй олон байгууллага хамрагддаг учраас түүнийг хэрэгжүүлэх явцад олон янзын тулгамдсан асуудлууд үүсч гарна. Үүнд:

А.Зохион байгуулалт, төлөвлөлтийн талаар

Гамшигтай тэмцэх ажлын талаар цэгцтэй зөв бодлого баримталж ажиллаагүйгээс бэлэн байдлыг хангах арга хэмжээг тогтоосон стандарт журмын дагуу явуулахад муугаар нөлөөлнө.

Гамшигтай тэмцэх зохих шаардлага хангах төлөвлөгөөгүйгээс бэлэн байдлыг хангах арга хэмжээг

[1] Болдбаатар.Ш “Гамшгийн менежмент” Уб., 2005, х-215

[2] Болдбаатар.Ш “Гамшгийн менежмент” Уб., 2005, х-215

зохих төвшинд хэрэгжүүлж чадахгүйд хүрэх.

Б.Гамшигтай тэмцэх ажлын удирдлага. Зохион байгуулалт зөв зохистой бусаас бэлэн байдлыг хангах арга хэмжээ бүхэлдээ үр дүнтэй явагдаж чадахгүйд хүрэх;

Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд хүчээ хэт их төвлөрүүлснээс бэлэн байдлыг хангах арга хэмжээний түвшин буурч, гамшигтай тэмцэх ажил бүхэлдээ суларч болох талтай.

Бэлэн байдлын түвшинг зохих шаардлагын хэмжээнд байлгах асуудал нь нийлээд бэрхшээлтэй асуудлын нэг юм. Бэлэн байдлыг байнга дээшлүүлэхгүйгээр зөнгөөр нь хаях юм бол түүний түвшин амархан буурна.

Жишээ нь: томоохон гамшиг тохиолдсоны дараа гамшгийн бэлэн байдлыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах, ялангуяа гамшигтай тэмцэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тодотгох шаардлагатай болдог.

Бэлэн байдлыг зохих төвшинд байлгах нэг гол нөхцөл нь төлөвлөгөөг аль болох бодитой байлгах явдал бөгөөд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Үүнд:

Сургалт явуулах

Дадлага үзлэг, шалгалт, тодотгол хийх

Үүрэг гүйцэтгэх чадвар, бэлэн байдлыг шалгах

Гамшгийн дараа дүн шинжилгээ, үнэлэлт дүгнэлт хийх

Хууль дүрэм ашиглаж зохицуулах

Олон улсын тусламжийн байгууллагатай холбоо тогтоох

Сургуулийн сурагчдад сургалт явуулах

Хүн амын дунд ухуулга сурталчилгаа явуулах

Хэвлэн нийтлэх зэрэг болно.

Бэлэн байдлын төвшинд нөлөөлөх гол 2 хүчин зүйл бий. Үүнд:

Гамшгийн менежментийн асуудал эрхэлсэн үндэсний байгууллагад гол удирдлагыг төвлөрүүлэх

Гамшигтай тэмцэх ажилд оролцож, үүрэг гүйцэтгэх чадвартай засгийн газрын бус байгууллагуудын нөөц хүч, бололцоог бүрэн оновчтой ашиглах.

Гамшгаас хамгаалах төлөвлөлт: Төрийн бэлэн байдлыг хангахад гамшгаас хамгаалах төлөвлөлтийн ач холбогдол маш өндөр. Учир нь гамшиг нь гэнэт тохиолдож эмх замбараагүй байдлыг бий болгодог үйл явц тул энэ цаг үед хэрхэн ажиллах төлөвлөлтийг урьдчилж хийх шаардлагатай. Энэхүү төлөвлөлтөд ямар техник хэрэгсэл ашиглах, бусад ямар талууд туслах зэргийн тодорхой тусгасан байна. Гамшгаас хамгаалах төлөвлөлтийг хийх хамгийн оновчтой арга арга хэлбэр бол бүх түвшин Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах явдал юм. Эдгээр төлөвлөгөөнүүдийн цар хүрээ хүн амын хэрэгцээ болон тухайн гамшгийн төрлөөс хамааран олон янз байхын зэрэгцээ болон тухайн гамшгийн төрлөөс хамааран олон янз байхын зэрэгцээ эрэн хайх аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааны үед үүсэх маш олон төрлийн хэрэгцээг хангахуйцаар хийгдэх шаардлагатай.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго нь гамшигтай холбоотой аливаа нөхцөл байдал, шаардлага хэрэгцээг урьдчилан харж, тооцоолох замаар гамшгаас хамгаалах арга хэмжээг амжилттай

зохион байгуулж, зохицуулахад оршино.[1] Төлөвлөгөөнд зөвхөн бэлэн байдлыг хангах, арга хор уршгийг арилгах арга хэмжээг тусгаад зогсохгүй аливаа аюулт үзэгдэл, ослын үед хор уршгийг арилгах ажиллагаанд оролцох хүмүүс, байгууллагын гамшгийн үед хаана, хэзээ ямар үүрэг гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нь хүмүүс, болон байгууллага тус бүрээр нарийвчлан тодорхойлсон байна. Энд мөн иргэд болон барилга, байгууламжууд гамшгийн үед хэрхэн хамгаалагдсан байхыг тодорхойлж өгөхийн зэрэгцээ тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл болон нөөцийн бэлэн байдлыг хамруулан авч үздэг. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө, ослын үеийн төлөвлөгөө, шуурхай ажиллагааны төлөвлөгөө, онцгой байдлын хор уршгийг арилгах төлөвлөгөө, гамшигтай тэмцэх төлөвлөгөө гэсэн нэртэй байж болно. Эдгээрт авч үзэг асуудлууд нь адилхан. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг засаг захиргааны бүх түвшин хийх шаардлагатай. Түүнээс гадна бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд ийм төлөвлөгөөтэй байна.

Гамшгаас хамгаалах дадлага, сургуулилт явуулах: Улс орон эсвэл иргэдийн гамшгийн хор уршгийг арилгах чадавхын бэлэн байдлыг хангах арга хэмжээний нэг чухал зүйл нь байнгын дадлага, сургуулилт хийх юм. Дадлага, сургуулилтаар гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд онцгой байдал үүссэн үед болон гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд оролцохоор тусгагдсан бүх талууд ямар нэгэн гамшгийн аюул тохиолдохоос өмнө төлөвлөгөөний дагуу үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэх ажиллагааг явуулна. Дадлага, сургуулилт талуудын үүргээ гүйцэтгэх бэлэн байдлыг ханган төдийгүй гамшиг болоогүй үед төлөвлөгөөнд байгаа тодорхойгүй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх боломжийг олгоно. Гамшгаас хамгаалах сургалт нь өртөг өндөртэй, урт хугацаанд үр дүн гардаг, цогц арга хэмжээ учраас түүнийг гол төлөв олон улсын байгууллагын болон гадаад орны тусламжтайгаар явуулах нь түгээмэл байдаг. Гамшгаас хамгаалах сургалт нь өртөг өндөртэй, урт хугацаанд үр дүн гардаг, цогц арга хэмжээ учраас түүнийг гол төлөв олон улсын байгууллагын болон гадаад орны тусламжтайгаар явуулах нь түгээмэл байдаг. Гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах ажиллагааг явуулах хүн хүч, нөөц хүрэлцэхгүй байх, тэдний чадавхаас хэтрэх нөхцөл байдал үүсч болно. Ийм нөхцөл байдал үүсэх үед хүн амыг өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан хор уршгийг арилгах ажиллагааг явуулах шаардлага үүсэх учраас хүн амын бэлэн байдлыг хангах нь чухал асуудал байдаг.

Хүн амын бэлэн байдлыг хангах арга хэмжээнд:

Гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох;

Зан үйлийг хэвшүүлэх, хандлагыг өөрчлөх;

Зарлан мэдээлэх дохиогоор ажиллахад сургах зэрэг ажиллагаанууд хамаарна.

Хүн амын бэлэн байдал нь жирийн иргэн нэг нэгэндээ, гэр бүлгийнхэн, хөршдөө туслах чадавхтай болохоор тодорхойлогдоно. Энэхүү үйл ажиллагаа амжилттай байхын тулд хүн амд гамшгийн талаар мэдлэг олгохоор хязгаарлагдаж болохгүй. Хүн амыг бэлэн байлгах гэдэгт тэдгээрийг эрэн хайх аврах, анхны тусламж үзүүлэх, гал түймрийг унтраах

зэрэг тусгай ажиллагааг гүйцэтгэх чадвартай болгох төдийгүй гамшгийн дараа өөрсдөө бие дааж хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг явуулах чадавхтай байх явдал юм.

Химийн ослоос хамгаалах бэлэн байдал:

Химийн ослоос хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээний зорилго нь химийн аюулыг урьдчилан мэдэж, түүний болзошгүй сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах, химийн ослын үед болон дараа юу хийх, хэрхэн хийхийг мэдэх болон эдгээр шуурхай арга хэмжээг үр дүнтэй явуулах хүн хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслээр хангагдсан байхад оршино. Бэлэн байдлыг хангах арга хэмжээ нь 2 түвшинд хийгдсэн байх шаардлагатай. Үүнд: нэгдүгээрт төрийн бэлэн байдал, хоёрдугаарт хүн амын бэлэн байдал гэж ангилж авч үзэж болно. Үүнийг тайлбарлая.

Төрийн бэлэн байдалд:

Химийн хорт болон аюултай бодисын гамшгаас хамгаалах төлөвлөлт хийх;

Химийн хорт болон аюултай бодисын гамшгаас хамгаалах дадлага, сургуулилт явуулах;

Химийн хорт болон аюултай бодисын гамшгаас хамгаалах сургалт хийх;

Химийн хорт болон аюултай бодисын гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл бэлтгэх;

Химийн хорт болон аюултай бодисын гамшгаас хамгаалах бодлого, үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдүүлэх;[3]

Хүн амын бэлэн байдалд:

Химийн хорт болон аюултай бодисын гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох;

Зан үйлийг хэвшүүлэх, хандлагыг өөрчлөх;

Зарлан мэдээлэх дохиогоор ажиллахад сургах;

Бэлэн байдлыг хангахад дараах арга хэмжээг авсан байвал зохино. Үүнд:

Химийн аюул, ослоос хамгаалах бодлого үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлсэн байх.

Химийн аюул, ослоос хамгаалах төлөвлөлт хийсэн байх.

Химийн аюул, ослоос хамгаалах сургалт, дадлага сургуулилт хийх.

Химийн аюул, ослоос хамгаалах хүч хэрэгслийг бэлэн болгосон байх.

Химийн ослын өмнөх бэлэн байдал хэрхэн хангах асуудал:

Хүн ам, хүрээлэн буй орчны гамшигт өртөх байдал, туршлага сургамж зэрэг нь гамшгийн эрсдэлийн тодорхой өсөлтийг харуулж байгаа ба цаашид хор уршгийг арилгах, бэлэн байдлыг хангах, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах улмаар гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хор уршгийг арилгах, бэлэн байдлыг хангах арга хэмжээтэй уялдуулах шаардлагатай байгааг харуулж байгаа бөгөөд хор уршгийг арилгах ажиллагааг бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхыг бий болгоно. Энэ химийн хорт бодисын ослын үүсэх эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, шинэ дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

[3] Сэржмядаг Д. ”Гамшгаас хамгаалах менежментийн үндэс” Уб., 2017 он. 78 дахь тал

Үүний тулд:

Химийн хорт бодисын аюулын хувьд, бүх салбар холбогдох талуудын оролцоог хангаж, бэлэн байдал, онцгой байдлын үеийн бодлого төлөвлөгөө, хөдөлбөрийг боловсруулах, нягтлах, тогтмол шинэчлэх шаардлагатай. Энэ нь гамшгийн бэлэн байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг нь байна.

Болзошгүй химийн осол, аюул тохиолдсон үед авах арга хэмжээг нарийн зохион байгуулах нь эрсдэл, ирээдүйд учирч болох хохирлыг бууруулах томоохон арга хэмжээнүүдийн нэг юм. Аливаа гамшгийн үеийн үйл ажиллагаа нь гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах, голомтын бүсийг тогтоох, эрэн хайх аврах, хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгах гэсэн үндсэн 5 хэсгээс бүрддэгийн дагуу химийн хорт бодисын ослын үеийн удирдлага зохион байгуулах юм.

Химийн ослын үеийн бэлэн байдлын асуудал:

Химийн хорт бодисын ослын эх үүсвэрийг олж, асгарлыг зогсоож, битүүмжлэх, саармагжуулах, хоргүйжүүлэх үйл ажиллагаа нь химийн бодис, химийн ослын улмаас үүсэх хохирлыг бууруулах, хоёрдогч аюулын эрсдэлийг бууруулах гол үйл явц юм.

Асгарал гэдэг нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин эсвэл эд хөрөнгөнд эрсдэл үүсэх аюултай материал хүрээлэн буй орчинд тархахыг хэлнэ. Химийн бодисын асгарлын явцад дараах 2 арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Асгарсан эх үүсвэрийг хаах, таглах, бөглөх;

Асгарсан бодисыг саармагжуулах, хоргүйжүүлэх.

Тухайн химийн бодисын асгарлаас хамааранд тархалтыг зогсоох хэд хэдэн арга байдаг. Модон шаантаг, хаймран, соронзон наалт, агаар битүүмжлэх уут, холболтын төхөөрөмж гэх мэт материал хэрэгслийг ашиглаж болно.

Дүгнэлт

Бэлэн байдлын төвшинг зохих төвшинд байлгана гэдэг нь нэлээд идэвхтэй үйл ажиллагаа шаардагдана гэсэн үг юм. Хэрэв түүнийг зөнгөөр нь орхих юм бол маш хурдан бэлэн байдлын төвшин байхгүй болно. Түүнчлэн гамшгийн аюул, давтамж бага байх үед бэлэн байдлын төвшинг зохих төвшинд байлгана гэдэг нь маш хүнд асуудал юм. Иймд бэлэн байдалд нөлөөлөх олон талын асуудлуудыг авч үзэж товч дүгнэлт хийх бөгөөд түүнийг гамшгийн менежментийн ажилтнаас бэлэн байдлын төвшинг шалгах, бэлэн байдлыг зохих төвшинд байлгах тухай зөвлөмжийг гаргаж байх шаардлагатай.

Ашигласан материал

1. П.Цэдэв, Гамшгаас хамгаалах төлөвлөлт., Уб. 2018 он

2. Ш.Болдбаатар, Гамшгийн менежмент., Уб. 2005 он

3. Чимэдцэрэн.П, Химийн хорт бодисын эрсдэл., Уб. 2020 он

4. Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс., Уб. 2017 он

УУЛ УУРХАЙН ОСЛЫН АЖИЛЛАЖ БАЙГАА АВРАГЧИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНД УДИРДЛАГА БОЛГОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION FOR LABOR SAFETY AND SAFETY MANAGEMENT OF MINING ACCIDENTS

У.Хатанзориг
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Khatanzorig.U
University of internal affairs master Senior Lieutenant

Хураангуй: Уул уурхайн ослын үед эрэн хайх, аврах ажиллагаа явуулж байгаа аврагчийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд тулгуурлан өнөөгийн байдлыг шинжилж, сайжруулах арга замыг тодорхойлсонд оршино.

Abstract: The purpose is to analyze the current situation and identify ways to improve it based on the safety and security of rescuers conducting search and rescue operations in the event of a mining accident.

Түлхүүр үг: Уул уурхайн осол, эрэн хайх, аврах ажиллагаа, аврагчийн хөдөлмөр хамгаалал, \аврагчийн аюулгүй ажиллагаа – ийм үг алга\, \хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажилтны аюулгүй байдал

Keywords: Mining Accidents, Search and Rescue, Occupational Safety and Health, (Rescue Safety - No Words), Occupational Safety, Occupational Safety, and Occupational Safety

Удиртгал

Монгол Улсад орчин үеийн дэлхийн жишигт нийцсэн Онцгой байдлын алба хурдацтай хөгжиж, шинэ ажлын байр олноор бий болж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж байгаа нь алба хаагчдын ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, ажлын байранд гарч болох аюул ослоос урьдчилан сэргийлж чаддаг удирдлагын тогтолцоо болон арга замын асуудал хөндөгдөж байгаа юм.

Манай улс 1997 онд ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155 дугаар конвенцод нэгдэн орж, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг 1997 оноос эхлэн хэрэгжүүлж, 2008 онд ХАБЭА-н тухай бие даасан хуультай болж, холбогдох дүрэм, журам гарснаар ХАБЭА-н хууль, эрх зүйн орчин бүрэлдэн бий болсон.

Аливаа гамшиг ослын үед түүний хор уршгийг арилгах явцад эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдын гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний эрсдэл, эрсдэл өндөртэй өвөрмөц онцлог нь өөрөө хүний эрүүл мэнд, амь насанд заналхийлсэн аюултай, хортой хүчин зүйлсийн нөлөөлөл юм. Иймд гамшиг ослын үед ажиллаж буй аврагчдын хөдөлмөр хамгаалал нь чухал ач холбогдолтой асуудал болж байна.

“Аюулгүй ажиллагаа” гэдэг нь аюулгүй ажиллагааны талаар баримталж байгаа зарчмуудын нэг чухал хэсэг бөгөөд бүх төрлийн ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэлнэ.

Эрэн хайх аврах ажиллагаанд оролцогчдын гүйцэтгэж буй ажил, үйлчилгээ нь аливаа гамшиг ослын хор

уршгийг арилгах үед тэдний амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн аюултай, хортой нөлөөллийн доор явагддагаараа эрсдэл өндөр өвөрмөц онцлогтой байдаг.

Сүүлийн үеийн уул уурхайд гарч байгаа осол, аваарын дуудлага, мэдээллийг үзэхэд ихэвчлэн хүний буруутай үйлдлээс гарч байна. Энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллаагүйтэй холбоотой. Тухайн нөхцөл байдалд ажиллаж байгаа аврагч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал, түүнд тулгамдаж байгаа асуудал өнөөгийн нийгэмд хангагдахгүй байгаа талаар хөндөгдөж байна.

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд Эрэн хайх, аврах анги, салбар бүлэгт нийт аврагчийн 10 төрлийн ажлын байран дээр алба хаагч нар үүрэг гүйцэтгэж байна

Аврагч- тэсэлгээчин

Аврагч-химичин

Аврагч- усчин

Аврагч- нохой хөтлөгч

Аврагч- тэсэлгээчин, нохой хөтлөгч

Аврагч

Холбоочин-аврагч

Эмнэлгийн зааварлагч

Аврагч - жолооч, холбоочин

Жолооч-холбоочин

Өнөөдрийн аврагчийн ажлын байрны тодорхойлолтын үндэс зөвхөн аврагч гэсэн томьёоллоор тодорхойлогдохгүй бөгөөд аврагч гэсэн нэрний ард давхар мэргэжлийн нэршил нэмэгдэж байгаа тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллах үндсэн суурь болох давхар сургалтуудыг боловсронгуй болгох хүний нөөцийн бодлогод тулгуурлах нь зүйтэй юм.

Аливаа гамшиг ослын үед түүний хор уршгийг арилгах явцад эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдын гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний эрсдэл өндөртэй өвөрмөц онцлог нь өөрөө хүний эрүүл мэнд, амь насанд заналхийлсэн аюултай, хортой хүчин зүйлсийн нөлөөлөл юм. Иймд гамшиг ослын үед ажиллаж буй аврагчдын хөдөлмөр хамгаалал нь чухал ач холбогдолтой асуудал болж байна.[1]

Эрэн хайх, аврах алба /ЭХАА/ нь гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, мөн үйлчилж буй объект, түүний ойр орчмын нутаг дэвсгэрт гамшгийн хор уршгийг арилгах зорилгоор хойшлуулшгүй арга хэмжээг зохин байгуулах бүтэц юм.

Эрэн хайх аврах ажиллагаанд оролцогчдын гүйцэтгэж буй ажил, үйлчилгээ нь аливаа гамшиг ослын хор уршгийг арилгах үед тэдний амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн аюултай, хортой нөлөөллийн доор явагддагаараа эрсдэл өндөр өвөрмөц онцлогтой байдаг.

Аливаа гамшиг ослын үед түүний хор уршгийг арилгах явцад эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдын гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний эрсдэл өндөртэй өвөрмөц онцлог нь өөрөө хүний эрүүл мэнд, амь насанд заналхийлсэн аюултай, хортой хүчин зүйлсийн нөлөөлөл юм. Иймд гамшиг ослын үед ажиллаж буй аврагчдын хөдөлмөр хамгаалал нь чухал ач холбогдолтой асуудал болж байна. Хөдөлмөр хамгаалал гэж хөдөлмөрлөх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хүний эрүүл мэнд, ажиллах чадварыг хамгаалахад чиглэсэн эрх зүйн болон нийгэм эдийн засаг, зохион байгуулалт, техник, ариун цэвэр, эрүүл

[1] Магистр Д.Мөнх-Эрдэнэ “Уул уурхай ослыг бууруулах нь” судалгааны ажил, УБ, 2021 он

ахуй, эмчлэн сэргийлэх арга хэмжээ, арга хэрэгслийг төрөөс урьдчилан харж зохицуулсан төрийн тогтолцоог хэлсэн байдаг.

Гамшиг, ослын үеийн аюулгүй байдал гэж гамшиг, ослын үед ард иргэд, улс ардын аж ахуйн объект, хүрээлэн буй орчныг хамгаалагдсан байдлыг хэлнэ. Аюулгүй байдлыг төрлөөр нь /үйлдвэр, цацраг, хими, газар хөдлөлт, гал, биологи, экологи/, объектоор нь /хүн ам, улс ардын аж ахуйн объектууд, хүрээлэн буй орчин/ болон гамшиг ослын үндсэн эх үүсвэрээр нь ялгадаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал гэж ажилчдыг үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлсийн нөлөөллөөс хамгаалсан хөдөлмөрийн нөхцөлийг хэлнэ.

Аврагч гэж эрэн хайх аврах үүрэг гүйцэтгэх зохих бэлтгэлийг хангасан, холбогдох мэргэжлийг эзэмшсэн үнэмлэхтэй гамшиг ослын хор уршгийг арилгах, салбар, нэгжид ажилладаг мэргэжилтэн, албан хаагчийг хэлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага гэж ажилчдын аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай хууль тогтоомж, техникийн баримт бичиг, дүрэм, журмаар тогтоогдсон шаардлагыг хэлнэ.[2]

Гамшиг осол гэж объект, тодорхой нутаг дэвсгэр болон эрэг орчмын гадаргууд гамшиг ослын эх үүсвэр бий болсны улмаас хүний амьдрал, үйл ажиллагааны хэвийн нөхцөл алдагдаж, тэдний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, улс ардын аж ахуй, хүрээлэн буй орчинд хохирол учруулсан нөхцөл байдлыг хэлнэ.

Гамшиг ослыг эх үүсвэрийн шинж чанараар нь /байгалийн, хүний үйл ажиллагаатай холбоотой гамшиг, биологи-нийгмийн, цэргийн/, хэмжээгээр нь /олон улс хамарсан, үндэсний хэмжээний, бүсийн, орон нутгийн, хувийн/ гэж ангилдаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартуудын систем нь хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг бий болгох талаарх хийх ажлуудын үндсэн чиглэлүүдийг багтаадаг. Эдгээр чиглэлүүд зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээ, аюултай, хортой үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн байж болох төвшний хэмжээг тогтоох, үйлдвэрлэлийн аюулгүй тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн процесс, байшин барилга, байгууламж, хамгаалалтын найдвартай, үр дүнтэй хэрэгслийг бий болгох асуудлыг тусгана. Эдгээр үндсэн чиглэлтэй уялдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал стандартуудын систем /ХАБСС/ нь дараах үндсэн таван стандартаас бүрэлддэг.

Мэргэжлийн эрэн хайх, аврах алба, мэргэжлийн болон орон тооны бус эрэн хайх, аврах бүлэглэлийн аврагчид онолын мэдлэг, мэргэжлийн ур чадвараа ажлын цагаар тогтоосон журмын дагуу дээшлүүлэх эрхтэй.

Мэргэжлийн эрэн хайх аврах, алба, бүлэглэлийн аврагчид жижүүрийн үүрэг гүйцэтгэж байхдаа тухайн байгууллагад хуваарилагдсан зардлаас хүнсээр хангагдах эрхтэй.

Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад нэрвэгдсэн мэргэжлийн эрэн хайх аврах алба, бүлэглэлийн аврагчид болон гамшиг ослын хор уршгийг арилгах явцад нэрвэгдсэн бусад аврагчид үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах, үндсэн цалингийн сарын

[2]П.Даш “Аврагчийн хөдөлмөр хамгаалал” УБ., 2018 он

дундажтай тэнцэх нөхөн төлбөр авах эрхтэй.

Аврагчдад дүрэм, журмаар тогтоосноос гадна хуулиар дараах үүргийг ногдуулсан байдаг. Үүнд:

Гамшиг ослын хор уршгийг арилгах ажилд оролцоход байнга бэлэн байх, бие бялдрын, тусгай, эмнэлгийн, сэтгэл зүйн бэлтгэлээ тогтмол дээшлүүлэх;

Эрэн хайх аврах бүлгийн бүрэлдэхүүнд ажиллах дадлага, чадвараа дээшлүүлэх;

Эрэн хайх аврах ажлын технологийг хэлбэрлэлтгүй мөрдөх;

Нэрвэгдэгсдийг эрэн хайх ажлыг идэвхтэй явуулах, тэднийг аврах арга хэмжээ авах, эмнэлгийн анхны болон бусад төрлийн тусламжийг үзүүлэх;

Мэргэжлийн эрэн хайх, аврах алба, бүлэглэлүүдийг удирдлагаас эрэн хайх, аврах ажиллагааны явцад өгсөн үүрэг даалгаврыг хатуу чанд биелүүлэх

Гамшиг осол гаргахгүй байх зорилгоор иргэдэд аюулгүйгээр биеэ авч явах дүрмийг тайлбарлах, гамшиг осол болсон нөхцөлд хийх үйлдлийн дэс дарааллыг зааж өгөх;

Хуулинд заасан эрэн хайх, аврах алба, бүлэг, аврагчдын үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь:

Хүмүүнлэг, энэрэнгүй байх, гамшиг ослын үед хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах зарчим

Нэгдмэл удирдлагатай байх зарчим

Ослоос аврах ажиллагаа явуулах, хойшлуулшгүй арга хэмжээ авахдаа эрсдэл гаргахгүй байх, аюулгүй ажиллагааг хангах зарчим

Гамшиг ослын үед ба түүний хор уршгийг арилгахад шуурхай зохицож ажиллах бэлэн байдлыг байнга хангах зарчим

Хөдөлмөр хамгааллын заавар гэдэг нь төрөл бүрийн нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэх эсвэл хөдөлмөрийг аюулгүй зохион байгуулах талаар хэм хэмжээг тогтоож өгсөн хэм хэмжээний акт юм. Хөдөлмөр хамгааллын заавар нь тодорхой мэргэжилд зориулагдсан байна. Тухайлбал: аврагч-жолооч, аврагч-шумбагч, аврагч-угсрагч, аврагч- хийн хоолой гагнагч гэх мэт. Мөн ажлын төрлүүдэд зориулагдсан заавар байна. Тухайлбал: өндөрт хийх ажил, ачих, буулгах ажил, хийн болон цахилгаан гагнуурын ажил гэх мэт. Зааврын шаардлагыг тухайн ажилтан заавал биелүүлэх ёстой бөгөөд биелүүлээгүй тохиолдолд хөдөлмөрийн сахилга зөрчсөн гэж үзнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал стандартуудын системийн стандартад үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлсийн тодорхой төрлүүдэд энэ ангиллыг улам дэлгэрэнгүй болгосон. Тухайлбал Дуу шуугианд тавих аюулгүй байдлын ерөнхий шаардлагын / ГОСТ12.1.003-83 стандартаар/ дуу шуугианы ангиллын тогтоосон байна.

ГОСТ 12.1.007-76 стандартаар хүний биед үзүүлж буй нөлөөллөөр нь хортой бодисыг ангилдаг. Тэдгээр нь аюулын дөрвөн ангилалд хуваагдана.

1-р ангилал-онц аюултай бодис

2-р ангилал-өндөр аюултай бодис

3-р ангилал дунд зэргийн аюултай бодис

4-р ангилал бага зэргийн аюултай бодис

ГОСТ 12.4.011-89 стандартаар нь ажилчдын хамгаалах хэрэгслийн ангиллыг тогтоож өгсөн.

Хөдөлмөр хамгааллын хууль эрх зүйн үндэс болсон суурь баримт бичиг

нь ОХУ-ын Үндсэн хууль юм. Үндсэн хуулинд "ОХУ-д хүний хөдөлмөр, эрүүл мэндийг хамгаалагдана". /7 дугаар зүйлийн 2-р заалт/, "Хүн бүр аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд ажиллах эрхтэй" /37 дугаар зүйлийн 3-р заалт/, "Хүн өвчилсөн, хөгжлийн бэрхшээлтэй болсон нөхцөлд нийгмийн халамж хүртэх эрхтэй" /39 дүгээр зүйлийн 1-р заалт/ гэж заасан байдаг.

Үүний зэрэгцээ хөдөлмөр хамгааллын асуудлыг ОХУ-ын Иргэний хууль, Хөдөлмөр хамгааллын тухай ОХУ-ын хууль тогтоомжийн үндэс, эрэн хайх, аврах алба болон аврагчийн эрх зүйн байдлын тухай хууль, бусад хэм хэмжээ, техникийн бичиг баримтад тусгасан. Дотоод зөвлөлийн 1993 оны 08-р сарын 13-ны өдрийн 5601 тогтоолоор батлагдсан. ОХУ-н "Хөдөлмөр хамгааллын тухай ОХУ-ын хууль тогтоомжийн үндэс" /хууль нь/ хөдөлмөрчид хөдөлмөр хамгааллын эрхийн баталгаа, аж ахуйн үйл ажиллагааны хүрээ, харъяаллыг үл харгалзан өмчийн бүхий л хэлбэрийн /үйлдвэр, албан газар, байгууллага/ ажил олгогч болон ажилтнуудын хөдөлмөр хамгааллын харилцааг зохицуулах нэгдсэн журмыг тогтоож, хөдөлмөрлөх явцад эсвэл түүнтэй холбоотойгоор ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлийг бий болгоход чиглэсэн байна.

Хуулинд ажил хийж буй хүн бүр хөдөлмөрөө хамгаалуулах дараах эрхтэй, Үүнд:

Үйлдвэрлэлийн гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчин болон хөдөлмөрийн чадвар буруулахад хүргэх хортой болон аюултай үйлдвэрлэлийн хүчин зүйлээс хамгаалагдсан ажлын байртай байх;

Үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад тахир дутуу болох, мэргэжлээс шалтгаалах өвчин, эрүүл мэндийн бусад гэмтлээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;

Ажил олгогч эсвэл төрийн болон олон нийтийн байгууллагаас хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэл, үйлдвэрийн аюултай болон хортой хүчин зүйлээс хамгаалах зорилгоор авсан арга хэмжээний талаар бодитой мэдээлэл авах;

Амь нас, эрүүл мэндэд нь шууд аюул заналхийлсэн тохиолдолд энэ байдлыг арилгатал үүсч болох хор уршгийг харгалзахгүйгээр ажил хийхээс татгалзах;

Хууль тогтоомж бусад эрх зүйн актыг үндэслэн ажил олгогчийн зардлаар нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгслээр хангагдах;

Ажил олгогчийн зардлаар хөдөлмөр эрхлэх аюулгүй арга барилд суралцах;

Хөдөлмөрийн нөхцөл шаардлага хангахгүйн улмаас үйл ажиллагаа түр зогсох, эсвэл үйлдвэр, цех хаагдах эсвэл ажлын байр байхгүй болох мөн үйлдвэрийн осол, мэргэжлээс өвчний болон үйлдвэрлэл дээр гарсан золгүй явдлын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд ажил олгогчийн зардлаар мэргэжлийн давтан сургалтанд хамрагдах;

Төрийн хяналт шалгалтын байгууллага болон олон нийтийн хяналтын байгууллагаас хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцөлийг шалгах, түүнчлэн ажилтны хүсэлтээр түүний ажлын байранд шалгалт хийх;

Хөдөлмөрлөх нөхцөл, хөдөлмөр хамгаалал хангалтгүй байгаа тохиолдолд төрийн зохих байгууллага,

үйлдвэрчний холбоод болон ажилтныг төлөөлөх эрх мэдэл бүхий бусад байгууллагад гомдол гаргах;

Хөдөлмөрлөх нөхцөл, хөдөлмөр хамгааллыг сайжруулахтай холбоотой асуудлыг шалгах, хэлэлцэхэд оролцох;

Ажилтан хуулиар дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

Хөдөлмөр хамгааллын норм, дүрэм, зааврыг мөрдөх;

Нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэх;

Үйлдвэр дээр гарсан аливаа золгүй явдал, учрал, мэргэжлээс шалтгаалах өвчний шинж тэмдэг, хүний амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлэл бий болгож буй нөхцөлийн талаар өөрийн шууд удирдлагад нэн даруй мэдэгдэж байх;

Хөдөлмөр хамгааллын хэм хэмжээний улсын нэгдсэн шаардлагыг нэвтрүүлэх зорилгоор ОХУ-ын Засгийн газар "ОХУ-д хөдөлмөр хамгаалалд тавигдах шаардлагын тухай" 937 тоот тогтоолыг /1994 оноос 08 дугаар сарын 12 өдөр/ засгийн газраас батлан гаргасан. Энэ баримт бичигт өмчийн бүхий л хэлбэрийн гүйцэтгэх засаглалын байгууллагууд, үйлдвэр, аж ахуйн нэгжийн баримтлах ёстой хөдөлмөр хамгааллын нэгдмэл шаардлагыг тусгасан хэм хэмжээний болон эрх зүйн актуудын системийг тогтоож өгсөн.

Хөдөлмөр хамгааллын хууль тогтоомжийг зөрчсөн, нийтийн гэрээ эсвэл хөдөлмөр хамгааллын тухай хэлэлцээрт заасан үүргийг биелүүлээгүй, эсвэл төрийн хяналт шалгалтын болон олон нийтийн хяналтын байгууллагын төлөөлөгчдийн үйл ажиллагаанд саад тотгор учруулсан ажил олгогч, албан тушаалтныг хууль тогтоомжийн дагуу захиргааны, сахилгын эсвэл эрүүгийн хариуцлагад татна. Хөдөлмөр хамгааллын хууль тогтоомж болон бусад эрх зүйн актыг зөрчсөн ажилтанд сахилгын хариуцлага оногдуулах ба тодорхой тохиолдолд хууль тогтоомжинд заасан материалын болон эрүүгийн хариуцлага оногдуулна.

Эрэн хайх, аврах ажлын онцлогийг харгалзан Төрийн ДУМ-д 1995 оны 7-р сарын 14-ний өдөр 998-1 тогтоол "Эрэн хайх аврах алба, аврагчийн эрх зүйн байдлын тухай ОХУ-ын хуулийг" баталсан. Уг хуулинд эрэн хайх аврах алба байгуулах, үйл ажиллагаа явуулах, тус улс орны нутаг дэвсгэр дээр эрэн хайх аврах албаны бүтцүүдийг байгуулах ерөнхий зохион байгуулалт эрх зүй, эдийн засгийн үндсийг тодорхойлох, төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, үйлдвэр, албан байгууллага, аж ахуйн нэгж болон хуулийн бусад этгээд, олон нийтийн байгууллага, албан тушаалтан, иргэдийн хоорондын энэ салбар дахь харилцааг зохион байгуулалт эрх зүйн хэлбэрт, өмчийн хэлбэрээс үл шалтгаалан зохицуулдаг.

Хөдөлмөр хамгаалал, ажилтны аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжинд хяналт тавихын тулд дотроо хөдөлмөрийн хяналт, уул уурхайн болон аж үйлдвэрийн хяналт, эрчим хүчний хяналт, эрүүл ахуй ариун цэврийн хяналт, гал түймэртэй тэмцэх алба, авто тээврийн хяналт, Оросын онцгой байдлын яамыг багтаасан төрийн тогтолцоог бүрдүүлсэн юм.

Хөдөлмөрийн хяналт. Хөдөлмөрийн яамны дэргэдэх холбооны хөдөлмөрийн хяналтын /Оросын хөдөлмөрийн хяналтын алба/ алба түүний харъяа орон нутгийн байгууллагууд нь /хөдөлмөрийн улсын

хяналтын алба/ өмчийн бүхий л хэлбэрийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүд дээр /цаашид байгууллага гэх/ хөдөлмөрийн болон хөдөлмөр хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийх нэгдмэл тогтолцоог бүрдүүлдэг.

Оросын хөдөлмөрийн хяналтын алба болон түүний харъяа хөдөлмөрийн улсын хяналтын албадуудын үндсэн зорилт нь:

Хөдөлмөр болон хөдөлмөр хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ажилтны эрүүл мэндэд учруулсан хохирлыг барагдуулах, нийгмийн даатгал, ажил эрхлэлт, дампуурал, хувьчлал, хамтын гэрээ, хэлэлцээрийн тухай хууль тогтоомж болон эрх зүйн актуудын хэрэгжилтэнд төрөөс хяналт тавих, шалгалт хийх

Ажилтны хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх мөн эдгээр эрхийг зөрчсөн ажил олгогч, албан тушаалтан болон бусад хариуцлагатай ажилтнуудын /хөдөлмөрийн болон хөдөлмөр хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тушаал, заавар болон бусад бичиг баримтанд зөвшөөрөл өгөх эрх мэдэл бүхий ажилтнууд/ хууль бус үйлдлээс хамгаалах

Хөдөлмөрийн болон хөдөлмөр хамгааллын тухай хууль тогтоомж, мөрдөгдөж байгаа норм, нормативын талаар мэдлэгээ дээшлүүлэхэд нь ажил олгогч болон ажилтнуудад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Уул уурхай бол дэлхийн хамгийн хэцүү, эрсдэлтэй мэргэжил; ялангуяа, энэ нь ямар нэг зүйл буруу болсон тохиолдолд гинжин урвалд орж болзошгүй харилцан уялдаатай эрсдэлүүдийг агуулдаг. Эрсдэлийг багасгахын тулд мэдлэг, туршлага, туршлага, байнгын хяналт шаарддаг. Бүх төрлийн уурхайнуудаас нүүрс олборлолт нь нэг ажилчинд ногдох осол, нас баралтын тоогоор хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Уурхайн судалгаа, аврах ажиллагаа нь маш чухал салбар бөгөөд тусгай боловсрол, техник хэрэгсэл, туршлагатай хүмүүс гүйцэтгэх ёстой.

Уул уурхай нь ашигт малтмал ашиглах, олборлох боломжийг олгодог хөрс, газрын хэвлийд орд хэлбэрээр хуримтлагдсан газар юм.

Уул уурхай бол дэлхийн хамгийн хэцүү, эрсдэлтэй мэргэжил; ялангуяа, энэ нь ямар нэг зүйл буруу болсон тохиолдолд гинжин урвалд орж болзошгүй харилцан уялдаатай эрсдэлүүдийг агуулдаг. Эрсдэлийг багасгахын тулд мэдлэг, туршлага, туршлага, байнгын хяналт шаарддаг. Бүх төрлийн уурхайнуудаас нүүрс олборлолт нь нэг ажилчинд ногдох осол, нас баралтын тоогоор хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Уурхайн судалгаа, аврах ажиллагаа нь маш чухал салбар бөгөөд тусгай боловсрол, техник хэрэгсэл, туршлагатай хүмүүс гүйцэтгэх ёстой.

Уурхай бүр онцгой байдлын үр дүнтэй удирдлагын тогтолцоотой байх ёстой. Ажилчдаас эхлээд менежер хүртэл хүн бүр ямар ч нөхцөлд юу хийхээ мэддэг байх ёстой.

Уул уурхай нь анхдагч салбарын эдийн засгийн үйл ажиллагааны нэг хэсэг тул түүнийг хөгжүүлэх нь тухайн улс, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн салбарт чухал ач холбогдолтой юм.

Уул уурхай бол хүн төрөлхтний хамгийн эртний үйл ажиллагаа бөгөөд үүнээс олон тооны нөөцийг олж авсан бөгөөд хувь хүмүүст шаардлагатай

эсвэл зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнийг олж авахад үйлдвэрлэлийн янз бүрийн салбарт ашиглаж байжээ.

Зарчмын хувьд хүн уул уурхайгаар багаж хэрэгсэл, зэвсэг хийж болох нөөцийг олж, ерөнхийдөө ан агнах, өдөр тутмын бусад ажилд ашигладаг байв.

Аливаа улс уул уурхайн үйл ажиллагааг хөгжүүлж, сурталчлах тусам түүний эдийн засгийн үр ашиг, өөрөөр хэлбэл ажлын байр нэмэгдэж, эрдэм шинжилгээний ажлыг сурталчилж, экспорт, олон улсын худалдааг дэмжиж байдаг.

Уул уурхайг эдийн засгийн нөлөөллөөр нь:

том уул уурхай

дунд уул уурхай

жижиг уул уурхай

Уул уурхай гэж ангилж болно.

Уурхай бүр онцгой байдлын үр дүнтэй удирдлагын тогтолцоотой байх ёстой. Ажилчдаас эхлээд менежер хүртэл хүн бүр ямар ч нөхцөлд юу хийхээ мэддэг байх ёстой.

Уул уурхай тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт манай улсад 1990 оны сүүлч 2000-д оны эхээр улс орон зах зээлийн нийгэмд шилжихэд улсын үйлдвэрүүд хаалгаа барьж, үйлдвэрийн олон мянган ажилчин ажилгүй, орлогогүй болж хоцорсон байдаг. Энэ үеэс эхлэн ажилгүйдлийн тоо огцом нэмэгдэж 2000-д оны эхээр жил дараалан зуд турхан болж олон малчид амьдралын амьжиргааны эх үүсвэр болсон малаа алдаж хорогдуулсан байдаг. Эдгээр шалтгаануудын улмаас гэр бүл, үр хүүхдээ тэжээх амьжиргаагаа залгуулах гэсэн иргэд хувиараа ашигт малтмал олборлож эхэлсэн байдаг. Тэрээр иргэд хүмүүсийн хэлж заншсанаар "нинжа" нар олноор хувиараа ашигт малтмал олборлож эхэлсэн байдаг. Уул уурхай хөгжөөд 20 орчим гаруй жил болж байгаа бөгөөд хувиараа ашигт малтмал олборлогч буюу Уул уурхайчидтай танилцаад 20 жил болжээ. 2020 оны байдлаар 19 аймаг, 1 дүүрэг, 71 суманд, 1181 нөхөрлөл, хоршоонд хариуцлагатай 12000 гаруй мянган Уул уурхайчин, гишүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хугацаанд Уул уурхай зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан талбайн хэмжээ 1831,97 га га, байгаль орчны нөхөн сэргээлтийг 562 га талбайд хийж, Монгол банканд 10,3 тонн алт тушааж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 1,2 тэр бум төгрөгийг улсад төвлөрүүлж ажилласан байна.

Улсын хэмжээнд "Уул уурхайд ажиллаж байгаа нийт иргэдийн 60 гаруй хувь нь малчин буюу мал бүхий иргэд бөгөөд "150 хүртэл толгой малтай, өрхийн 3-6 хүний өрхийн хэрэгцээг хангах өдөр тутмын орлого нь хангалтгүй тул гар аргаар алт, жонш, байгалийн чулууг олборлохоор гэр бүлийн 2-3 хүн нь хамтран ажиллаж байна" гэсэн мэдээлэл байна.

Уул уурхай нэгдсэн дээвэр холбоо нь 2013 оны 5 сарын 02-нд байгуулагдаж өнөөг хүртэл гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалах, дуу хоолойгоо бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэх, тэдгээрийг тогтвортой ажлын байртай, орлоготой, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай Уул уурхайчин, бизнес эрхлэгч болгон төлөвшүүлэх, улмаар амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршдог. Энэхүү зорилгынхоо хүрээнд гишүүн байгууллагуудаа чадавхижуулах, эрдэс

баялаг уул уурхайн бодлого үзэл баримтлалыг иргэний нийгмийн байр сууринаас боловсруулан төрийн байгууллагад нөлөөлөх, гишүүдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжих, гишүүдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлж гадаад дотоодын төсөл хөтөлбөрт хамруулах, чиглэлээр зорилго тавин ажиллажээ.

Уул уурхай бол зөвхөн Монголд байгаа цоо шинэ үзэгдэл, үйл явц биш 100, 200 жилээр тоологдох уул уурхай Уул уурхай түүхтэй орнууд ч бий. Тэд ч өнөөдрийн манайд байгаатай адил нөхцөл байдлыг ухаалгаар, албажуулах, зөөлөн бодлого барих замаар зохицуулсан нь амжилт олсон байдаг. Харин эсрэгээрээ шууд хааж боох алхмуудыг хийснээр хүний эрхийн болон байгаль орчны нөхцөл байдлыг улам сөрөг, их эрсдэлд оруулсан харамсалтай жишээнүүд ч бий. Энэ холбоо нь оновчгүй, сөрөг үр дагавартай шийдвэр гарахаас сэргийлэх, Уул уурхай эрх зүйн орчныг тогтвортой байлгах, шинэчлэн сайжруулахад анхааран ажилладаг ба Уул уурхайчдын эрхийг хамгаалахаас гадна тэднийг өөрсдөө эрхээ хамгаалахчадавхитай болгоход онцгой анхаарч ажилладаг байна.

Уул уурхай эрхлэгч нь олборлолтын талбайд 3, 2, 1 -д заасан баримт бичгийг байлгах, ашигт малтмал олборлох гэрээнд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хийсэн байх, гэрээгээр олгосон талбайг бусдад шилжүүлэхгүй, барьцаалахгүй, худалдахгүй түрээслэхгүй байх, Уул уурхай ашуулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөх, тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргаас тогтоож өгсөн талбайд амьдрах суурьшлын талбай, хог хаягдлын цэг байгуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлөх, тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, олборлолтын талбайд 18 нас хүрээгүй иргэнийг ажиллуулахгүй байх, үйл ажиллагаанаас олсон орлогоосоо хуульд заасны дагуу татвар төлөх, нөхөн сэргээлтийг Уул уурхай нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж сум дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгөх, тухайн жилийн үйл ажиллагааны тайланг сум дүүргийн Засаг даргад дараа оны нэг сард багтаан хүргүүлэх үүргүүдийг тус тус хүлээн ажилладаг байна.

Аврагчийн ажлын үүрэг хариуцлага.

Эрэн хайх, аврах, нэн тэргүүний яаралтай тусламжийн ажиллагааг гүйцэтгэдэг. Хүмүүсийг аврахад шаардлагатай бэлтгэлийн цогц ажлыг гүйцэтгэдэг. Гамшгийн бүс эсвэл сүйрлийн голомтод байгаа мэргэжилтнүүд эсвэл мэргэжилтнүүдийг дагалддаг. Тэрээр бүрэн эрхийнхээ хүрээнд онцгой байдлын үр дагаврыг арилгахад дайчлагдсан цэргийн албан хаагчид, иргэний мэргэжилтнүүдийг удирддаг. Томилогдсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийн засвар үйлчилгээ, байнгын бэлэн байдлыг хангана. Осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, үр дагаврыг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Аврах ажиллагаа гэдэг нь онцгой байдлын бүсэд хүн ам, материаллаг болон соёлын үнэт зүйлсийг аврах, байгаль орчныг хамгаалах, онцгой байдлын нөхцөл байдлыг нутагшуулах, тэдгээрийн онцлог ауултай хүчин зүйлийн нөлөөллийг дарах буюу хамгийн бага хэмжээнд хүргэх үйл

ажиллагаа юм. Аврах ажиллагааны онцлог нь эдгээр ажлыг гүйцэтгэж буй хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд заналхийлж буй хүчин зүйл, тусгай сургалт, тоног төхөөрөмж, тоног төхөөрөмж шаарддаг.

Монголд үйлдвэрлэлийн осол буурахгүй байгаа нь ажил олгогчдын хяналт сул, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах мэргэжлийн боловсон хүчин дутагдаж байна. Уул уурхайн удирдлагууд ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах асуудлаар сургалт явуулж,ослоос урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааны ажлыг олон нийтэд түгээх чиглэлд анхаарлаа хандуулж ажилладаг ч ажлын байран дахь осол буурахгүй байна.

Дүгнэлт

ААН, байгууллага ХАБЭА-н хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодоггүй, энэ талын дотоод хяналт байдаггүй нь өнөөгийн нийгэмд ажиллах хөдөлмөрийн аюулгүй байдалтай шууд холбоотой байна.

Ажлын байранд эрсдлийн үнэлгээ хийдэггүй, ажилчин ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг эрсдэлд суурилсан боловч одоог хүртэл болзошгүй уул уурхайн ослыг дагуулсаар л байна.

Аж ахуй нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдадаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах, үзлэгийн мөрөөр тодорхой үйл ажиллагаа авч явуулдаггүй, сувилуулах, эмчлүүлэх ажлыг зохион байгуулдаггүйгээс ихэвчилэн осол, аваар гарч байгаа нь өнөөгийн нийгэмд шууд харуулж байна.

Сүүлийн 10 жилд манай улсад жилд дунджаар 369 осол гарч, мөн дунджаар 404 хүн үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд өртөж, 70 орчим хүн нас барж байсан тоо мэдээлэл байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн жилүүдэд өдөрт нэг осол гарч, 1-2 хүн өртөж, 5 хоногт 1 хүн ХАБЭА-н байдлаас болж эндэж байгаа нь тодорхой байна.

Тодруулбал, 2016 онд улсын хэмжээнд үйлдвэрийн осол, хурц хэлбэрийн нийт 332 тохиолдол бүртгэж байснаас уул уурхай, олборлох салбарт нийт ослын 18 хувь буюу 61 тохиолдол гарч байжээ. 2017 онд мөн 330 гаруй тохиолдол бүртгэгдсэнээс уул уурхай, олборлох салбарт 55 бүртгэгджээ. Эдгээр тохиолдлын 288 буюу 86.7 хувь нь үйлдвэрлэлийн осол, 44 буюу 13.3 хувь нь хурц хордлого болж байжээ

Ашигласан материал

1. П.Даш “Аврагчийн хөдөлмөр хамгаалал” УБ, 2018 он
2. А.Адъяасүрэн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” /хууль тогтоомжийн эмхэтгэл/ УБ., 2019 он
3. В.Батсайхан “Гамшгийн нэр томъёоны тайлбар толь” УБ, 2012
4. Цахим эх сурвалж
5. https://nema.gov.mn
6. https://legalinfo.mn
7. https://hss.mn хууль-дүрэм-журам
8. Хууль, дүрэм, журам
9. “Аврах ажиллагааны үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”
10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм

ӨНДӨР БАРИЛГАД ГАЛ УНТРААХ АВТОМАТ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН АШИГЛАЛТЫН СУДАЛГАА

STUDY ON THE USE OF AUTOMATIC FIRE EXTINGUISHERS IN HIGH-RISE BUILDINGS

А.Бэх-Очир
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Bekh-Ocjir.A
University of internal affairs master captain

Хураангуй: Өндөр барилгын галын аюулгүй байдал ь барилгын зураг төсөл дээр галын тоноглол нь автоматжуулсан дохиолол мэдээллийн систем, гал унтраах төхөөрөмж бүхий хосолсон системээр төлөвлөгдсөн байх шаардлагатай. Эдгээр автоматжуулсан систем нь барилга байгууламжийн галын аюулаас хамгаалах өнөөгийн арга хэмжээ нь галын аюулын бүх асуудлыг тусгаагүй байгаа нь галын аюулгүй байдлын асуудал улам бүр нэмэгдэж байна. Иймд энэхүү баримт бичиг нь гал түймрээс хамгаалах одоогийн арга хэмжээ, тэдгээрийг барилга байгууламж дахь галын аюултай холбоотой өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ашиглах боломжтой байдлыг танилцуулахыг зорьж байна.

Түлхүүр үгс: Гал унтраах автомат төхөөрөмж, галын дохиолол, өндөр барилгын галын аюулгүй байдал

Key words: Automatic fire extinguishers, fire alarms, fire safety in high-rise buildings

Сүүлийн жилүүдэд Манай улсын барилгын салбарын эрчимтэй хөгжлийг энэ салбарт оруулж байгаа гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээгээр тодорхойлж болно. Дээрхи хурдацтай хөгжлийг дагаад хүн амын нягтрал ихсэж, хот төлөвлөлтийн зарчим алдагдан Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хязгаарлагдаж байгаа нь зөвхөн Нийслэлийн хэмжээнд 570 мянган га талбайд 10 түүнээс дээш давхар бүхий орон сууц болон олон нийтийн барилга байгууламж 300 гаруй баригдаж үйл ажиллагаа явуулж байна.

Манай улсын эдийн засгийн өсөлт, дэд бүтцийг дагаж бизнес эрхлэгчид Улаанбаатар хотод өндөр барилга барих сонирхол эрс нэмэгдэж байгаа боловч нөхцөл шаардлага хангаагүй зай талбайд хот төлөвлөлтийн болон /Галын аюулгүйн норм, дүрэм, стандарт/ техникийн шаардлага хангахгүй өндөр барилга барих явдал цөөнгүй байна.

Нийслэлд өндөр барилга их хэмжээгээр баригдаж ашиглалтад орж байгаатай уялдан барилга байгууламжийн галын аюулгүй байдлын шаардлагыг хангах эрх зүйн бичиг баримтын төрөл, тэдгээрт тусгагдсан ерөнхий төлөвлөлт, хийц бүтээцийн онцлог,материалын шинж чанар, зам гарц, усан хангамж, автомат тоног төхөөрөмж зэрэг нь авралтын үйл ажиллагаа явуулах, оршин суугч болон үйлчилгээ эрхлэгчдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт норм дүрмийг хэрэгжүүлэх, нэгэнт гарсан гал түймрийг хохирол багатай унтраахад чухал ач холбогдолтой.

Мөн сүүлийн жилүүдэд баригдаж байгаа барилгууд нь чанарын шаардлага хангахгүй барилгын материал их хэмжээгээр үр ашиггүй хэрэглэх, батлагдсан дүрэм журам, норм стандарт, зураг төслийн дагуу

баригдахгүй байгаа нь тэдгээрээс учирч болзошгүй аюулын эрсдэлийг нэмэгдүүлсээр байна

- Өндөр барилга - 30 м -ээс доош барилга;
- I, II, III зэрэглэлийн өндөр барилгууд - 50, 75, 100 м хүртэл;
- Өндөр өндөр - 100 м -ээс дээш.
- Сүүлчийн бүлэг нь 100 м -ийн алхмаар өндөрт хуваагддаг.

Орчин үед дэлхий даяар янз бүрийн өндөрт тэнгэр баганадсан барилгуудын барилгын хурд хурдацтай нэмэгдэж байна. Тэдгээрийн дотроос 100-200 м өндөртэй тэнгэр баганадсан барилгууд илүү хийцлэлтэй байдаг. Бусад өндөр барилгуудыг мөн барьж байгаа бөгөөд тэдгээрийн тоо дараах байдалтай байна.

- Дэлхий дээр 400 м -ээс дээш 10 орчим;
- 300 -аас 400 м хүртэл - 20 -оос арай илүү;
- 200 -аас 300 м хүртэл - 100 орчим байна.

Сүүлийн 15 жилд Орон сууцны болон үйлдвэр, үйлчилгээний объектууд, албан байгууллага шинэчлэгдэн 9 ба түүнээс дээш давхар бүхий барилгуудаас гадна, үйлдвэрлэлийн нарийн технологи бүхий олон арван объектууд нь гал түймэр гарсан тохиолдол нэлээдгүй бүртгэгдсэн ба гал унтраах үйл ажиллагаа зохион байгуулахад хүндрэл учирч цаг хугацаа их зарцуулдаг тул гал унтраах автомат төхөөрөмжийг суурилуулах нь өндөр ач холбогдолтой. Гал унтраах байгууламжийг ашиглах нь бусад хэсэгт гал түймэр тархахаас урьдчилан сэргийлж учирч болзошгүй хохирлыг таслан зогсоодог.

Галыг унтраах автомат төхөөрөмж зохион бүтээхтэй холбоотой шинэ бүтээлүүд 17 -р зууны сүүл - 18 -р зууны эхэн үед анх үүссэн. Дараа нь уг байгууламжийг тэсэрч дэлбэрэх төхөөрөмжөөр тоноглож эхэлсэн бөгөөд тэдгээрийг цаг тухайд нь асааж, галыг унтраах тусгай хөлөг онгоцноос бодис цацдаг байжээ. Эдгээр нь баррель хэлбэртэй хөлөг онгоцнууд байсан бөгөөд тэдний гадаад төрх нь Петр I-ийн засаглалтай холбоотой байв. Орчин үеийн загвар болсон усан гал унтраах төхөөрөмж гарч ирсэн нь Оросын офицер судлаач К.Д. Фролов -ийн ажилтай холбоотой юм. Ийм систем дэх хөдөлгүүр нь ус дүүргэх дугуй байсан бөгөөд түгээлтийн хоолойд ус нийлүүлдэг насосны поршенуудтай холбогдсон бүлүүрт механизм байв. Гэсэн хэдий ч энэ суурилуулалтыг практикт ашиглаагүй болно. Ус цацагч шиг ус цацагч суурилуулах ажлыг 1864 онд Английн эрдэмтэн Стюарт Харрисон хийсэн юм. Дараагийн 15 жилийн хугацаанд ус цацах төхөөрөмжийн загвар нь анхны хувилбарыг сайжруулсан хэд хэдэн өөрчлөлтийг хийсэн бөгөөд гал унтраах системийг суллах нь конвейр дээр байрлуулж байв.

Орон сууц болон албан байгууллагуудад зориулсан стандартын ес ба түүнээс дээш давхар бүхий барилгыг өндөр барилгад тооцно зохион байгуулалтын хувь эдгээр барилга нь нэг буюу олон секц хэсэг болгон тусгаарлагдсан байдаг.

Өндөр барилгыг зориулалт болон хэв загварыг харгалзан ердийн болон цахилгаан шатны зангилааны төлөвлөлт, хийц бүтээцийн шийдэхдээ тогтоодог байна. Ердийн болон цахилгаан шатны зангилааны асуудлыг ингэж шийдэхдээ гал гарсан үед авралтын замыг утаанаас хамгаалах, шатны хонгил, гадны хүн аврах болон унтраах хэрэгсэл ажиллах боломжтой,

нэвтрүүлэн гаргах чадвар сайтай байлгахыг бодолцсон байх ёстой. Шатны хонгил утаажихгүй байх явдлыг тагт буюу нэг талаас хаалтгүй өрөө дамжин барилгын гадна задгай бүс ашиглан давхар тус бүрт орох орцтой болгосноороо хангадаг.

Олон секц хэсэг болгон тусгаарлагдсан өндөр барилгын хувьд дээрх асуудлыг барилгын аль нэг өнцөгт угсарсан авралтын зориулалттай гадна талын шат буюу тагт дамжин нэг байшингаас нөгөөд орох хүзүүвчийн тусламжтай шийднэ.

Дээрх шийдлээс гадна өндөр барилгаас хүмүүс аврах, гарсан галыг унтраах нөхцөлийг хангах зорилгоор инженерийн тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг.

Тухайлбал утаа гаргах нүх, хоолой, агаар соруулах төхөөрөмжийг нэрлэж болно. Орон сууцны өндөр барилгуудад давхар бүрийн гудамд байгаа утааг соруулах хавхлага, цахилгаан шатны хөндийд илүүдэл агаар соруулах төхөөрөмж угсардаг. илүүдэл агаар соруулах төхөөрөмж ердийн шатны хонгилд байрлуулж болно.

Ийм төхөөрөмж бүхий шатны хонгил нь агаар орохгүй нарийн чигжээстэй өрөө хаагддаг хаалгатай байх ёстой Утаанаас хамгаалах төхөөрөмж нь гал гарсан үед тусгай мэдрэмтгий хэрэгслийн тусламжтай өөрөө автоматаар ажиллана Ийм хэрэгслийг байруудын дундах гудам, агуулах, хөлийн өрөөнд тавина. Утаа соруулах төхөөрөмжийг галын дотуур краны хайрцагт байдаг алсын удирдлагын товчлуур дарж ажиллуулна.

Өндөр барилгууд нь дотроо гал унтраах усны шугамтай. Энэ давхрын тоо, барилгын өндрөөс болж хэд хэдэн бүсэд хуваагдана. Барилгын доторх гал унтраах усны энэ шугамын ус гаргах хүчин чадал нь зориулалт, эзлэхүүн, өндрөөс хамааран 5-40 л/с байхаар тооцоолдог.

Өндөр барилгын салхины урсгалын хүчтэй нөлөөлөл, цаг агаарын хэлбэлзэл, барилга доторх болон гаднах даралтын ихээхэн ялгавар, түүнчлэн гал гарсан үед унтраах арга хэрэгслийг сонгон авах, түүнийгээ бодит байдалд хэрэгжүүлэх, мөн авралтын ажлыг явуулах энэ бүхэн нь онцгой байдлын байгууллагыг хэд хэдэн төвөгтэй асуудал шийдвэрлэхийг зүй ёсоор шаардана ийм учраас өндөр барилгад гарсан бага хэмжээний ч галыг унтраахад ихээхэн хүч хэрэгсэл шаардаж, аврах, унтраах ажлын янз бүрийн арга, тактик хэрэглэх ёстой.

Өндөр барилгад гарсан галын гол онцлог нь гэвэл маш богино хугацаанд хонгил, дээд давхруудад галын утаа их хурдтай тархдагаас шалтгаалан ихэнх тохиолдолд авралтын ажиллагааг заавал явуулах шаардлагатайд оршино. Өндөр барилгад хийсэн туршилтаас үзвэл барилгын нэгээс гуравдугаар давхарт гарсан галын утаа нь гал гарснаас хойш 5-6 минутын дараа бүх давхрын шатны хонгилоор тархаж, утаажилтын түвшин нь хамгаалалтын тусгай баггүйгээр хүн амьсгалах аргагүй болгодог байна. Утаажилтын улмаас хүмүүсийг хордуулах үзэгдэлээс гадна харагдах орчингүй болсноос үймээн сандралд орох явдал гарна. Шатлагын улмаас үүссэн их халуун агаар нь шатны хонгилоор тархаж, энэ нь хүн тэсч байхын аргагүй хэмжээнд хүрнэ.

Галын автомат хэрэгслүүд ажиллагааны онол, арга зүй

Гал түймэр унтраах автомат төхөөрөмжүүдийн технологийн


ажиллагааг автоматжуулахад галын аюул гарсан тухай хүний туслалцаагүйгээр илрүүлж, унтраах чадвартай хэрэгсэл чухал байр суурь эзэлж байна. Дэлгүүр агуулах, театр, музей бусад өндөр барилга байгууламжид гарсан галын аюулыг илрүүлж, унтраах хамгийн үр ашигтай арга бол галын автомат хэрэгслээр төхөөрөмжлөх явдал юм.Олон давхар өндөр барилгын гал эсэргүүцэх хамгаалалтын системд үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь галыг унтраах, утаа зайлуулах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл болж байна. Онцгой байдлын албаны гал түймрийн улсын хяналтын байцаагчид, галын автомат хэрэгслийн зураг төсөл зохиох, угсрах, ашиглалтын найдвартай ажиллагааг хангах асуудлыг шууд хариуцдаггүй. Гэвч компани, аж ахуйн нэгж байгууллагууд галын автомат төхөөрөмж нэвтрүүлэх ажилд тус дэмжлэг үзүүлж, тэдгээрийн бүрэн бүтэн байдалд, зөв ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих ёстой. Барилга байгууламжийн зураг төсөл хянаж, галын аюулгүйн шалгалт хийхдээ гал түймрийн хяналтын байгууллагын ажилтнууд компани аж ахуйн нэгж газрын удирдлагад энэ чухал асуудлыг тавьж, ажил хэрэг болгон хэрэгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлбэл зохино. Галын автомат тоног төхөөрөмжийн талаар, гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгслийн ашиглалтыг хариуцсан хүмүүсийн мэргэжил чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулахад оролцож туслах.

Гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгслүүдийн судалгааны арга зүй

Галын автомат хэрэгсэлд хийсэн судалгаа

ГАЛ УНТРААХ АВТОМАТ СИСТЕМ / AUTOMATIC FIRE-EXTINGUISHING SYSTEM-Галыг автоматаар илрүүлж зөвшөөрөгдсөн гал унтраах бодисыг гал руу, эсвэл гал гарсан талбар руу шүрших тоноглол, төхөөрөмжөөс бүрдсэн зөвшөөрөгдсөн иж бүрдэл систем галын үүсэл голомтыг богино хугацаанд мэдээлэлж, унтраахад чиглэгдсэн агааргүйжүүлэх, хөөс, болон усан систем


Зураг 1 Гал унтраах автомат систем



ГАЛЫН БОРООЖУУЛАГЧ АВТОМАТ СИСТЕМ / AUTOMATIC SPRINKLER SYSTEM. Галаас урьдчилан сэргийлэх инженерийн стандартын дагуу зураг төслийг нь боловсруулж газар доор ба дээр суурилуулсан хоолой бүхий усыг цацруулан шүршиж гал унтраах

нэгдмэл систем. Энэ систем нь шаардлага хангасан усан хангамжтай байна. Бороожуулагч системийн газар дээрх хэсэг нь ихэвчлэн барилга, байгууламжийн таазаар суурилуулсан тусгай хэмжээсээр,эсвэл гидравлик тооцоогоор зохион бүтээгдсэн усны хоолой бүхий сүлжээ байх бөгөөд эдгээрт автоматаар бороожуулах хошууг системтэйгээр холбож өгдөг. Систем нь галаас үүдсэн дулаанаар идэвхжиж усыг галын бүс рүү шүршинэ.

Зураг 2 Галын мэдээлэх систем



Галын автомат тоног төхөөрөмжид тавих хяналт, шалгалт, ашиглалтад хүлээн авах техникийн шаардлага

Галын автомат хэрэгслийн үр ашигтай, найдвартай ажиллахад тэдгээрийн ажиллагааг байнга шалгах асуудал чухал шаардлагатай. Ийм шалгалтыг улиралд 1-ээс доошгүй удаа уг төхөөрөмжийн үйлчилгээг хариуцсан байгууллагын мэргэжилтнүүд хийнэ. Галын автомат дохиоллын ихэнх хүлээн авах самбарууд шугам сүлжээний гэмтэл /тасрах, богино холбоо болох/-ийг автоматаар мэдэрдэг. Харин мэдээлэгчүүдийн хэвийн ажиллагаатай эсэхийг хүлээн авах хэрэгсэл гүйцэтгэдэггүй. Ийм учраас мэдээлэгчүүдийн утаа, дулаан, гэрлийн үйлчлэлийг мэдрэх чадварыг байнга шалгах нь чухал. Галын байцаагч шалгалт хийхдээ хэд хэдэн мэдээлэгчийг утаа, дулаан, гэрлийн үйлчлэлээр шалгаж үзэх хэрэгтэй. Шалгалтын хамгийн энгийн арга бол “дулаан-утаа-мэдээлэгч-хүлээн авах станцад дохио өгөх” гэсэн системээр шалгах явдал юм.

Галын автомат дохиоллын хэрэгсэлтэй объектод шалгалт хийхдээ эрх бүхий албан тушаалтан дараах зүйлүүдийг онцлон анхаарах хэрэгтэй. Үүнд:

1.Дохиоллын хэрэгсэл нь үндсэн ба бэлтгэл тэжээлийн эх үүсвэртэй байх хэрэгтэй. Ердийн нөхцөлд тэжээлийн утас нь үндсэн шугамд холбоотой байх бөгөөд үндсэн шугам ажиллахаа болиход станц бэлтгэл оруулгад автоматаар холбогдох ёстой.

2.Мэдээлэгч, хүлээн авах хэрэгсэл болон бусад тоноглол эд анги нь тосноос цэвэрлэгдсэн, зэврэлтийн ул мөргүй байвал зохино. Өрөө тасалгааны таазанд тулгаж юм хурааж, шүүгээ тавиур байрлуулан утаа, дулаан, гэрэл тархахад саад учруулж мэдээлэгчийг хааж болохгүй.

3.Хүлээн авах самбарын жижүүр нь өөрийн гүйцэтгэх үүрэг гал гарсан авах арга хэмжээг сайн мэддэг байх хэрэгтэй.

4.Дохио хүлээн авах самбарын өрөөнд нүдэнд ил харагдахуйц газар мэдээлэгчийн байршилд, автомат хэрэгслийн ашиглалтын заавар, гал гарсан болон тэжээлийн шугам гэмтсэн

үед авах арга хэмжээг бичиж хадсан байвал зохино.

5.Цахилгаан шугамыг гэмтлээс хамгаалахын тулд хана, хамар хана нэвтлэн гарсан хэсэгт нь хамгаалалт хийх шаардлагатай.

Нэг спринклерийн хамгаалах шалны талбай 12 м2, дренчерийнх 9 м2-аас илүүгүй байх ёстой. Спринклер.гол хавхлага, дренчер.хялбар хайлагч бөглөөнүүд нь дээврийн хучилтаас доош 0,4 м-ээс ихгүй зайд байрлах бөгөөд спринклерийн толгойд, хялбар хайлагчийн хайлах температурыг нь тэмдэглэсэн бичигтэй байдаг. Мөн спринклерийн их биеийн өнгөөр хайлах хэмжээг тодорхойлж болно.

Спринклер нь дараах халуунд хайлахаар хийгдэнэ. Үүнд:

+72°С. Агаарын халуун 55°С хүрэх үед

+93°С агаарын халуун 56-70°С-т

+141°С агаарын халуун 71-100°С-т

+П182°С агаарын халуун 101-140°С-т

Тоног төхөөрөмжийг хариуцагч ажилтанд нөөц спринклерийн толгой, тэдгээрийг солиход шаардагдах түлхүүр, шат, түүнчлэн тоосыг цэвэрлэх алчуур байх хэрэгтэй. Бух шугам хоолой, дохиолол-хяналтын хэрэгслийг будсан байна. /усны системийг цэнхэр өнгөөр, агаар-усны системийг цагаан өнгөөр, шахагдсан агаарын тусламжтайгаар ажилладаг системийг улаан өнгөөр будна./ Хяналтын хавхлага, группээр ажилладаг хавхлага, хөөрөг, нөөцийн савны бүрэн бүтэн байдалд онцгой анхаарвал зохино. Хөөрөг хаалтууд дээр тэдний зориулалт, ажиллуулах журмыг бичиж байрлуулсан байхын дээр хавхлагуудыг дугаарласан байна. Дохиолол-хяналтын хэрэгслийг шалгахдаа шугамын даралтын манометрийн заалтаар заавал үзнэ. Усаар гал унтраах системд хавхлага хүртэлэх, түүнээс цааших хэсэгт даралт адилхан байвал систем ажиллагаанд бэлэн гэж үзнэ.

Галын автомат хэрэгслийг ашиглалтад хүлээн авах нь

Гал унтраах төхөөрөмж, дохиоллын хэрэгслийг ашиглалтад хүлээн авахад Онцгой байдлын байгууллага оролцоно. Ашиглалтад хүлээн авахдаа тэдгээрийг туршсан тухай бичиг баримтууд, мэдээлэгч төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, мэдрэх чадвар, түүнчлэн автомат хэрэгслийн ашиглалтыг хариуцагч хүмүүсийн мэдлэгийг шалгана. Нарийн хийцтэй зарим автомат хэрэгслийн ашиглалтад хүлээн авахад холбогдох бусад салбарын мэргэжилтнийг оролцуулах хэрэгтэй. Ашиглалтад хүлээн авахад заавал туршилт хийж шалгана. Хэрэв туршилт, шалгалтын явцад зураг төсөлд тусгагдсанаас өөрөөр угсарсан, автомат хэрэгслийн техникийн нөхцөлийн шаардлага хангаагүй зэрэг зөрчил илэрвэл энэ тухай акт тогтоож засч арилгуулах арга хэмжээ авна. Угсралтын ажлыг гүйцэтгэгч байгууллага энэхүү актад дурдсан зөрчлийг бүрэн засч арилгасны дараа, ашиглалтад хүлээлгэн өгнө.

Гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгслийг ашиглалтад хүлээн авахад ажлын зураг, далд ажлын акт, угсарч тавигдсан тоног төхөөрөмж, хэрэгслийн нэрс, тэдгээрийн паспорт болон техникийн бусад баримт бичигтэй танилцана.

Дүгнэлт

Судлаачид Өндөр барилга байгууламжуудад гал түймрийн хэтийн төлөвийг үнэлж байгаагаас харахад

түймэр гарах магадлал ихсэж байгаатай холбоотойгоор технологийн дэвшилд тулгуурласан Гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгслийн ашиглалтыг нэмэгдүүлэх боломжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь чухал байна.

Өнөө үед усан гал унтраах автомат систем нь хамгийн өргөн тархсан байна. Ус бол хамгийн хямд, аюулгүй гал унтраах хэрэгсэл бөгөөд олон хүн цуглардаг объектуудыг үр дүнтэй хамгаалах боломжийг олгодог: худалдааны төв, оффис, зочид буудал зориулалт бүхий байгууламжид илүү тохиромжтой байна.

Зөвлөмж

Галын автомат тоног төхөөрөмж суурилуулж хэрэглэх хэтийн төлөвлөгөө боловсруулахад нь албан байгууллага, үйлдвэр. аж ахуйн нэгжийн удирдлагад туслалцаа үзүүлэх,

Гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгслийн ашиглалтыг хариуцсан хүмүүсийн мэргэжил чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулахад оролцож туслах.

Галын автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгслийн сүүлийн үеийн хэв загварыг сурталчлах ажлыг зохион байгуулах.

Сонирхогч байгууллагуудтай хамтран галын автомат тоног төхөөрөмжийн талаар семинар, бага хурал зохион байгуулах.

Автомат төхөөрөмжийг хариуцагч нь системийг шалгах, урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ хийх жилийн хуваарьтай байхын дээр төхөөрөмжийн байдалд хяналт тавих тусгай бүртгэл хөтөлж хавхлага, нөөцийн сав дахь усны даралт, илэрсэн зөрчил дутагдал, спринклер ажилласан тухай өдөр бүр тэмдэглэж байна.

Жилд 1 удаа байгууллагын захиргаа, тоног төхөөрөмжид нарийн шалгалт хийж тэдгээрийн найдвартай ажиллагаа. манометрүүдийн заалт зөв эсэхийг үзэж хяналтын хавхлагуудыг цэвэрлэнэ.

5-10 жил тутамд байнга устай байдаг шугам хоолой, бусад хэрэгслийг сайтар угааж, хуримталсан тундасаас цэвэрлэнэ. Дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тухай бичиг баримтыг галын байцаагч шалгаж танилцах

Ашигласан материал

1.Пожарная тактика Я.С Повзика 1984 г Москва

2.Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааны үндэс Г Даваадорж УБ 2009.

3.Гал түймрээс сэргийлэх ажлын зохион байгуулалт Б Амгаабазар УБ.1989он.

4.Пожарные шкафы стандартные модели новый дизайн 2010 г

5.https://prezi.com/nwoohjwic7wy/presentation/

ОРОН НУТГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF LOCAL DISASTER PREPAREDNESS

Б.Батдорж
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Batdorj.B
University of internal affairs master captain

Хураангуй: Сүүлийн жилүүдэд аюул, ослын тоо давтамж нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан байгалийн онц аюулт үзэгдлийн тохиолдол ихсэж, учрах хохирол жилээс жилд нэмэгдэж, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, чадавхыг бэхжүүлэх талаар судалгаа хийх шаардлага тулгарч байна.

Abstract: In recent years, the number of hazards and accidents has increased, the number of natural disasters due to climate change has increased, and the number of damages has increased year by year. need to do.

Түлхүүр үгс: Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, бэлэн байдал.
Keybords: Disaster protection service, professional unit, readiness.

Монгол Улсын Үндсэн Хуулинд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, хүн амыг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийг мөрдлөг болгон үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.


Сүүлийн жилүүдэд өмнө гарч байгаагүй шинэ төрлийн өвчин үүсэн бий болж, гамшиг, аюулт үзэгдэл шинэ төрөл, хэлбэрээр үүсч байна.


Тухайлбал, Короновируст халдвар /Ковид-19/ цар тахал өвчин дэлхийн 223 оронд тархаж, 130 гаруй сая гаруй хүн өвчилж, 2.9 сая гаруй хүн нас барж, үлэмж хэмжээний хохирол учруулж байна. Монгол улсад тус өвчнөөр нийт 682284 хүн өвчилж, 2108 хүн нас барсан байна.

Манай улсын хэмжээнд 2021 оны 12 сарын байдлаар 4075 удаагийн аюулт үзэгдэл, ослын тохиолдол бүртгэгдэж, 2282 хүн нас барж, нийт 25.5 тэрбум төгрөгний хохирол учиржээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гамшиг, аюулт үзэгдэл, ослын тоо 56.5 хувиар өсчээ. Улсын хэмжээнд жилд дунджаар 4100 орчим аюулт үзэгдэл, осол тохиолдож, 210 гаруй хүн амь насаа алдан, 89 тэрбум төгрөгийн хохирол учирч байна.

Говь-Алтай аймгийн хэмжээнд 2016-2021 онд нийт 471 удаагийн аюулт үзэгдэл осол бүртгэгдэж, түүний улмаас 26 хүн амь насаа алдаж, 487 хүн бэртэж гэмтэж, 535.1 тэрбум төгрөгийн хохирол учирч нийт аюулт үзэгдэл, ослын 57 хувийг гал түймэр, 43 хувийг бусад аюулт үзэгдэл, осол эзэлж байна

Зураг 1. Монгол Улсын хэмжээнд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын судалгаа (2016-2021)





Эх сурвалж: ОБЕГ, Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нэгдсэн мэдээ

Зураг 2. Аюулт үзэгдэл, ослын дуудлагын тоо

Говь-Алтай аймаг /2016-2021 он/



Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын гамшиг, аюулт үзэгдэл, ослын нэгдсэн мэдээ

Дээрх судалгаанаас авч үзэхэд гамшгийн тоо, давтамж, 56.7 хувиар нэмэгдсэн байна.

Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос хүний амь нас, эд хөрөнгөд хохирол учрах магадлал өндөр байгаа тул гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх арга замыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай байгаа нь энэхүү сэдвийг сонгох үндэслэл болж байна.

Иймд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасан “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах нь чухал байна.

Гамшгаас хамгаалах “Бэлэн байдал”-ын талаарх нэр томьёоны тодорхойлолтыг авч үзвэл:

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.24-т "Бэлэн байдал" гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг” гэж тодорхойлсон.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын талаар Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд өргөн хэрэглэж байна. “Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна: Үүнд:

10.1.1.өдөр тутмын бэлэн байдал;

10.1.2.өндөржүүлсэн бэлэн байдал;

10.1.3.бүх нийтийн бэлэн байдал гэж 3 ангилсан бөгөөд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой заасан байна.

Гамшгаас хамгаалар бэлэн байдлыг хангах нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлснээр учрах хохирлыг бууруулах, зарлан мэдээллийг шуурхай дамжуулах, анхны

тусламжийг яаралтай хүргэх ажиллагааг шуурхай зохион байгуулах боломжийг бүрдүүлэх учраас гамшгийн аюулаас учрах сөрөг нөлөөллийг бууруулж чадна[1].

1.Төрийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ

Төрийн зүгээс хүн амыг гамшгаас хамгаалах арга хэмжээг түргэн шуурхай, үр дүнтэй удирдаж байгаа нь гамшгийн үед бодитоор харагдах юм.

Төрийн бэлэн байдлын хүрээнд хамаарах арга хэмжээг дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

-Гамшгаас хамгаалах төлөвлөлт

-Гамшгаас хамгаалах дадлага, сургуулилт

-Гамшгаас хамгаалах сургалт

-Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл гэх мэт...

2.Хүн амын бэлэн байдлыг хангах арга хэмжээ

Гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулахад өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан аврах, хор уршгийг арилгах шаардлага үүсэх учраас хүн амын бэлэн байдлыг хангах нь их чухал асуудал байдаг. Хүн амын бэлэн байдлыг хангах арга хэмжээнд дараах арга хэмжээ хамааруулж болно. Үүнд:

Гамшгаас хамгаалах мэдлэг чадвар олгох

Аюулгүй амьдрах зан үйлийг хэвшүүлэх, хандлагыг өөрчлөх

Зарлан мэдээллийн дохиогоор ажиллахад сургах

Хүн амыг бэлэн байдлыг хангах гэдэгт гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, анхны тусламж үзүүлэх арга хэмжээг бие дааж явуулах чадавхтай байх явдал байдаг.

Хүн амын бэлэн байдлыг хангах гол арга зам бол иргэдэд гамшгаас хамгаалах боловсрол олгох юм.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд бэлэн байдлыг тодорхой зааж өгсөн байдаг. Дээрх үе шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэгтэй холбогдуулан төлөвлөж хэрэгжүүлэх нь чухал юм.

Дүгнэлт

Гамшгаас хамгаалах бэлэн байдал гэдгийг нэр томьёоны толь, стандарт, судлаачид өөрийн судалгааны өнцгөөс харж тодорхойлсон хэд хэдэн янзын тодорхойлолт байна. Тэдгээрийг нэгтгэн үзэж гамшгаас хамгаалах бэлэн байдал гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой байдлын газар, хэлтэс, байгууллагын удирдлага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн нь болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд дээд удирдлага (дарга) захирагчаас өгсөн үүргийг цаг хугацаанд нь биелүүлэх жинхэнэ чадварыг хэлнэ” гэж тодорхойлж болох юм гэж үзлээ.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үндсэн хүчин зүйл нь хүн хүч, техник хэрэгсэл, хүний нөөц, материал хэрэгслийн /багаж

[1] Д.Сэржмядаг Гамшгаас хамгаалах менежментийн үндэс.УБ.,2017

зэвсэглэмж, шатахуун, тос, тослох материал, хүнсний/ болж байна гэж дүгнэлээ.

Эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль
2. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого
3. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр
4. Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр
5. Д.Сэржмядаг “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс”, 2017
6. Цэргийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2014,
7. ОБЕГ Гамшиг судлалын хүрээлэн, Гамшгийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2012,
8. ОБЕГ, Гамшиг судлалын эрдэм шинжилгээний хүрээлэн, Гамшгаас хамгаалах асуудалтай холбогдол бүхий товчилсон үг, нэр томьёоны тайлбар, УБ., 2007
9. Дотоод хэргийн их сургуулийн “Хууль сахиулахуй” онол арга зүйн улирал тутмын сэтгүүл-2020 №01 (23)
10. Онцгой байдлын ерөнхий газрын 2016-2021 оны гамшиг, аюулт үзэгдлийн нэгдсэн мэдээ

ДАЛД УУРХАЙН АВРАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

FEATURES OF UNDERGROUND MINE RESCUE

Д.Баяржаргал
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, ахмад
D.Bayarjargal
Master of disaster studies of University of internal affairs captain

Хураангуй: Монгол Улсын нутаг дэвсгэр дээр уурхай, эрдэс баялгийн түүхий эдийн эрэлт, хэрэгцээ өсч, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрүүдэд нэмэгдэж байгаа нь өнөөгийн нөхцөлд ашигт малтмалын нөөцийг ашиглах шаардлага тулгарч байна.

Иймээс далд уурхайд гарч болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, гарсан ослыг бууруулах шаардлагатай гэж үзэж байгаа тул энэхүү сэдвийг сонгон авч судлахаар шийдвэрлэсэн болно.

Abstract: Demand and demand for mining and mineral raw materials in Mongolia is increasing, and the number of mining and processing industries is increasing, so there is a need to use mineral resources in the current situation.

Therefore, it was decided to study this topic as it is necessary to prevent and reduce the number of accidents that may occur in underground mines.

Түлхүүр үгс: Далд уурхайн аюулгүй байдал, тавигдах шаардлага, гадаад орны туршлага

Keywords: Underground mine safety, requirements, foreign experience

Улс орны ойрын ирээдүйн хөгжил уул уурхайгаас бүрэн хамаарах болоод байгаа энэ үед хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг өөрийн оронд нутагшуулах, тус салбарт учирч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг зохистой шийдэхэд манай эрдэмтэд, инженерүүдийн хичээл зүтгэл, хүчин чармайлт онцгой үүрэгтэй билээ. Цаашид эрдэмтэн, судлаачдын өмнө уул уурхайн салбар дахь судлагдаагүй хариугаа хүлээж байгаа олон асуудал байгааг анхааралдаа авч, эрдэм чадал, хичээл зүтгэлээ зориулна гэдэгт итгэж байна.

Уул уурхайн салбарт орчин үеийн шинэ дэвшилтэд технологийн нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн удирдлага менежментийг боловсронгуй болгох мэргэжлийн удирдлагаар хангах, уул уурхайн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг өндөр төвшин бэлтгэх, үйлдвэрийн дадлага, туршилт судалгааны лабораторийг шинэчлэн шинээр байгуулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг үр ашигтай ашиглах тэдний үйл ажиллагааны тогтвортой орчинг бүрдүүлэх, салбарын үйл ажиллагааны уялдаа холбоо, эрх зүйн орчинг сайжруулах, шаардлагатай стандартуудыг нэн яаралтай гаргах нь тус салбараас Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Далд уурхай дээр тулгамдаж байгаа нэг асуудал бол осол гарах явдлыг багасгах, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сахиулах явдал юм.

Иргэд уул уурхайг гамшгийн эрсдэл, амь дүйцсэн гэж ярьдаг ч амьдрал дээр гамшгийн эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хангах тал дээр хангалтгүй байна.

Гамшгийн эрсдэл үүсэх гол шалтгаан нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаагүйгээс үүсдэг. Иймээс далд уурхайд гарч болзошгүй гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нэн тулгамдаж байна.

Далд уурхай /цаашид уурхай гэх/ уулын нуралт, даралтыг эсэргүүцэх бэхэлгээ, агааржуулах систем гэж газрын гадаргаас дооших агааржуулалтын нэгдсэн системд орших уулын малталтуудын нэгдлийг хэлнэ.[1]

Аврах ажиллагааг шуурхай удирдахын тулд уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объект, үзэгдэх орчингүй, агааргүй, хорт хийтэй, хязгаарлагдмал орчинд аврах ажиллагааг зохион байгуулахад Гамшгаас хамгаалах тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм, Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Баяжуулах үйлдвэрийн дүрэм, Уул уурхайн аврах ангийн дүрэм, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм” Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам болон холбогдох бусад эрх зүйн баримтыг удирдлага болгоно.

Ослын үеийн удирдагчаар тухайн уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн ерөнхий инженер ажиллах бөгөөд түүний эзгүйд диспетчер уг үүргийг түр гүйцэтгэнэ. Ослын үеийн удирдагчийн гаргасан шийдвэрийг тухайн обьектийн ажилтнууд болон аврах ажиллагаанд оролцож буй албан хаагчид заавал биелүүлнэ.

Аврах ажиллагааны ерөнхий удирдагчаар төв, орон нутгийн Онцгой байдлын газар, Аврах тусгай салбар, болон Уул уурхайн аврах ангиас шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй томилогдсон албан хаагч ажиллана.

Аюул, ослын үед уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг, ажиллагсдын аюулгүй газарт очих зам, үйл ажиллагааг “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-өөр тодорхойлно.

Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулж даалгаврыг Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагчид бичгээр өгнө. Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч, Ослын үеийн удирдагч нарын санал зөрсөн тохиолдолд Ослын үеийн удирдагчийн шийдвэрийг баримтална. Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч “Шуурхай ажиллагааны дэвтэр”-т өөрийн саналаа бичнэ.

Ослын үеийн удирдагч аврах ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

Эхний ээлжинд уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ;

Аюул ослыг арилгах үр дүнтэй аргыг тодорхойлох;

[1] Жанчив Ц., Батсэрээ С., “Аврагчдад зориулсан гарын авлага”, Уб., 2011 он,

Аюул ослын голомт дээр шаардлагатай хүч хэрэгслийг төвлөрүүлэх, зөв хуваарилах

Аврах ажиллагаа явуулж байгаа газартай тасралтгүй холбоотой байж, нөхцөл байдлыг тодруулж, шуурхай удирдлагаар хангах;

Шуурхай ажиллагааны биелэлтийг хангах.

Аюул, ослын үед уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг, ажиллагсдын аюулгүй газарт очих зам, үйл ажиллагааг “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-өөр тодорхойлно.

Газрын дор болон үзэгдэх орчингүй, хязгаарлагдмал, агааргүй, хорт хийтэй орчинд аврах ажиллагаа явуулахдаа тусгаарлагч шүүгч багтай 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй бүлгийг ажиллуулна. Аврагчид нь зөвхөн нэг бүлгийн аврагчид байна.

Тусгаарлагч шүүгч багтай ажиллах албан хаагч нь эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан, сургалтад хамрагдаж баг эзэмших эрх авсан байна. Багтай ажиллах эрхгүй албан хаагчийг агааргүй орчинд ажиллуулахыг хориглоно.

Тусгаарлагч шүүгч багтай аврагчдын ээлжинд ажиллах хугацаа нь багны хүчин чадлаас шалтгаалах ба цэвэр агааргүй орчинд 4 цагаас хэтэрч болохгүй.

Ослын үеийн удирдагч эхний ээлжинд “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ба үүнтэй хамт уурхайгаас гараагүй хүний тоо, агааргүй орчинд байж болох хүний байрлал, нөхцөл байдал, агааржуулалтын горим, аюулын бүс зэргийг тодорхойлно.

Ослын үеийн удирдагч аврах ажиллагааны удирдагчид үүрэг өгөхдөө дараах мэдээллээр хангасан байна:

- Аюул ослын төрөл, болсон газар, үүссэн цаг хугацаа, өртсөн бүс
- Өртсөн хүний тоо, тэдний байж болох байрлал
- Агаарын урсгалын чиглэл, аюулын бүсэд өгч буй агаарын хэмжээ;
- Уул уурхайн аврах ангийг ирэхээс өмнө авсан арга хэмжээ, хүрсэн үр дүн
- Аврах бүлгийн явах чиглэл, замын малталтын нөхцөл байдал;
- Уурхайн малталтад байгаа аюул осол арилгах зориулалттай тоног төхөөрөмжийн байршил
- Аюул ослын төрөл, хаана үүссэн талаар бодит мэдээлэл байхгүй тохиолдолд зөвхөн нэрвэгдэгсдийг аврах ажлыг гүйцэтгэх ба зэрэгцэн нөхцөл байдлыг тодруулах хайгуулын ажиллагааг зохион байгуулна.

Ослын үеийн удирдагч Уул уурхайн аврах ангийн бие бүрэлдэхүүнд аврах ажиллагааны удирдагчаар дамжуулан үүрэг даалгаврыг өгнө. Уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн ажилтнуудыг аюул ослын бүсэд ажиллуулахдаа аврах ажиллагааны ерөнхий удирдагчтай зөвшилцөнө.

Ослын газарт очсон удирдах албан тушаалтан аюул ослын нөхцөл байдалтай танилцаж, аврах ажиллагааны удирдлагыг албан ѐсоор аваагүй тохиолдолд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар зөвхөн санал гаргаж Шуурхай ажиллагааны дэвтэрт бичнэ.

Хэрвээ “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж дууссан, хэрэгжүүлэх явцад үр дүн гарахгүй нь тодорхой болсон, аюулын нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд Ослын үеийн удирдагч,

аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан “Шуурхай ажиллагааны төлөвлөгөө” боловсруулна. Уг төлөвлөгөөг Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар батална.

“Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө” ба “Шуурхай ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй гэнэтийн шийдвэрийг Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар зөвшилцөн гаргаж энэ тухай шуурхай ажиллагааны дэвтэрт бичиж, хэрэгжүүлнэ.

Аврах ажиллагаа явуулж байгаа бүх тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

Аврах ажиллагааны үр дүнг тодорхойлох, аврагчдын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар ажиллагаа явуулж байгаа газарт байнга орж танилцах үүрэгтэй.

Аюул ослын голомт дээр нөхцөл байдал гэнэт өөрчлөгдсөн тохиолдолд (тэсрэмтгий хий их хэмжээгээр ялгарсан г.м) аврах бүлгийн дарга шийдвэр гаргах ба энэ тухай газрын гүний удирдлагын төвд яаралтай мэдэгдэнэ.

Аврах ажиллагааны удирдагч нэрвэгдэгсдийн амь насыг аврахтай холбоотой хойшлуулшгүй ажлын үед аврагчдад тохиолдож болзошгүй эрсдэлийг зөв тооцож, ажиллагааг шуурхай удирдана.

Далд уурхайд аврах ажиллагааны үед хязгаарлагдмал орчин хамаарах ажил үйлчилгээнд далд уурхайн объектуудын судалгаа, зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, өргөтгөл, өөрчлөн байгуулалт, техникийн шинэчлэл, түр зогсолт, хаалт зэрэг ажлууд багтана.

Далд уурхайн гүнд хязгаарлагдмал, давчуу орон зайд аврах ажиллагаа явуулахад оршино. Уурхай нь байнгын хиймэл агааараар агааржиж байдаг аврах ажиллагаа явуулахад хүний нүдэнд харагддаггүй хязгаарлагдмал, давчуу, утаатай, хорт хийтэй, нуралт үүссэн орчинд аврах ажиллагаа явуулдаг.

Уул уурхайн аврагчийн хөдөлмөрийн онцлог нь бүрэн тусгаарлах амьсгалын аппараттай ажиллах, хэвийн нөхцлөөс өндөр температуртай орчинд сэтгэл санаанд онцгой таагүй орчинд биеийн хүчний нэн хүнд ажил хийдэгтэй холбоотой. Уул уурхайн аврах ангид бие сэтгэлийн, зан төлөвийн тодорхой үзүүлэлттэй хүмүүс тэнцэх ёстой байдаг.

Хэрвээ ямар нэгэн байдлаар уурхайн гүнд осол гарах, нуралт үүсэх зэрэг эрсдэл үүссэн тохиолдолд уурхайн гүнд голомтод ажиллаж буй аврагчид өөрсдөө нурангид даруулах, амьсгалын бие даасан төхөөрөмж ажиллахгүй болж агааргүйдэх зэрэг эрсдэлтэй нөхцөлд ажилладаг.

Уул уурхай үйлдвэрийн олборлох салбарт осол үүсэх объектууд нь янз бүр байна. Хүний үйл ажиллагааны болон хүрээлэн байгаа орчны нөлөөллийн түвшин зөвшөөрөгдөх эрсдэлийн төвшингээс давж, аюул болохоор хэмжээнд хүрснээс ослын нөхцөл байдал үүснэ. Онцгой нөхцөл байдал нь, хүний үйл ажиллагааны болон хүрээлэн байгаа орчны хурдан хугацааны өөрчлөлтөнд хэсэг бүлэг хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюултай, нийгэм материаллаг болон

эдийн засгийн боломж муутай байх үед үүсдэг.[2]

Зураг 1. Ослын онцгой нөхцөл байдал



Далд уурхайд аврах ажиллагааны үед хязгаарлагдмал орчин хамаарах ажил үйлчилгээнд далд уурхайн объектуудын судалгаа, зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, өргөтгөл, өөрчлөн байгуулалт, техникийн шинэчлэл, түр зогсолт, хаалт зэрэг ажлууд багтана.

Далд уурхайн гүнд хязгаарлагдмал, давчуу орон зайд аврах ажиллагаа явуулахад оршино. Уурхай нь байнгын хиймэл агааараар агааржиж байдаг аврах ажиллагаа явуулахад хүний нүдэнд харагддаггүй хязгаарлагдмал, давчуу, утаатай, хорт хийтэй, нуралт үүссэн орчинд аврах ажиллагаа явуулдаг.

Уул уурхайн аврагчийн хөдөлмөрийн онцлог нь бүрэн тусгаарлах амьсгалын аппараттай ажиллах, хэвийн нөхцлөөс өндөр температуртай орчинд сэтгэл санаанд онцгой таагүй орчинд биеийн хүчний нэн хүнд ажил хийдэгтэй холбоотой. Уул уурхайн аврах ангид бие сэтгэлийн, зан төлөвийн тодорхой үзүүлэлттэй хүмүүс тэнцэх ёстой байдаг.

Хэрвээ ямар нэгэн байдлаар уурхайн гүнд осол гарах, нуралт үүсэх зэрэг эрсдэл үүссэн тохиолдолд уурхайн гүнд голомтод ажиллаж буй аврагчид өөрсдөө нурангид даруулах, амьсгалын бие даасан төхөөрөмж ажиллахгүй болж агааргүйдэх зэрэг эрсдэлтэй нөхцөлд ажилладаг.

Дүгнэлт

Далд уурхайн осолд орж буй шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд салбарын мэдээллээс харж байхад хүний өөрийн санамсаргүй, буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй болох нь тогтоогдож байна.

Далд уурхай дээр гарч буй ослыг авч үзвэл инженер техникийн ажилчдын оролцоотой, ажлын байрны болон гамшгийн эрсдлийн үнэлгээг хийлгэж,

[2]Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай обьектод аврах ажиллагааг зохион байгуулах журам

тодорхой эрсдэлд тулгуурлан өөрийн уурхайн онцлогт тохирсон хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгааг тогтмол өгч хэвшээгүй.

Мөн ашигт малтмал олборлох үйлдвэрийн газар болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх, ашиглах, геологи хайгуулын болон газрын хэвлийг ашиглахтай холбогдсон бусад ажил гүйцэтгэхдээ хүн амын аюулгүй байдлыг хангах, ажиллагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах шаардлагыг хангах шаардлагатай.

Иргэд уул уурхайг өндөр эрсдэлтэй гэдэг ч амьдрал дээр гамшиг осол гарахаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангахгүй байсаар байна.

Иймээс далд уурхайд гарч болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, гарсан ослыг бууруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Ашигласан материалын жагсаалт

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Улаанбаатар хот, 2017 он

2. Ц.Жанчив, С.Батсэрээ “Аврагчдад зориулсан гарын авлага”, Улаанбаатар хот, 2011 он

3. Ц.Жанчив, С.Батсэрээ “Уурхайн ерөнхий мэдлэгийн сэдэвчилсэн гарын авлага”, Улаанбаатар хот, 2011 он

4. Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын шинэчилсэн дүрэм, Улаанбаатар хот, 2019 он

5. Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай обьектод аврах ажиллагааг зохион байгуулах журам.,Улаанбаатар хот, 2015 он

ОРОН НУТГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ /АРХАНГАЙ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД/

WAYS TO IMPROVE THE PERFORMANCE OF LOCAL DISASTER PROTECTION SERVICES /IN ARKHANGAI AIMAG/

Ш.Эрдэнэбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Erdenebayar.Sh
University of internal affairs master captain

Хураангуй: Анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1967 оны 42 дугаар тогтоолоор “Иргэний хамгаалалтын албад буюу Улсын албадыг байгуулах” анхны шийдвэр гарч байжээ. Мөн 1990 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор “Иргэний хамгаалалтын дүрэм”-ийг баталсан байна. Улмаар 1994 онд “Иргэний хамгаалалтын тухай шинэ хууль”-аар гамшгаас хамгаалах албадыг шинэчилж байсан түүхтэй бөгөөд 1996, 1997 онуудад нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж байжээ.

2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 33 дугаар зүйлд[1] Гамшгаас хамгаалах албаны ажиллах чиг үүргийг тусгаж өгсөн байна.

Түлхүүр үг: Гамшгаас хамгаалах албад, хөдөө аж ахуй, химийн аюул.
Key word: Features, functions and structure of local disaster protection services

Удиртгал: Дэлхийн нийтэд гамшгийг нийгмийн үйл явц гэж үзэж, түүний улс орны тогтвортой хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөг арилгахын үндэс нь гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал гэдэгт санал нэгдээд байгаа билээ. Гамшгийн эрсдэлийг бууруулах нь маш нарийн зохицуулалт бүхий хөгжлийн хандлагатай олон талт асуудал бөгөөд түүнийг дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч үүнийг бүх талуудын орлцоо, түншлэлийн замаар хэрэгжүүлэхийг чухалчлах болсон[2]. Олон улсын санал санаачлагаас гадна манай улсын өнөөгийн нөхцөл байдал ч мөн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг бүх түвшинд дэвшүүлэн тавьж олон талын түншлэл хамтын ажиллагааны үр дүнд шийдвэрлэх шаардлага бодитой байгааг илтгэж байна.

Дэлхийн улс орнууд гамшигтай тэмцэх, түүнийг даван туулах талаар олон аюулт үзэгдлээс туршлага хуримтлуулж, сургамж авч байгаа хэдий ч гамшигтай тэмцэх ажлыг удирдан зохион байгуулахын тулд гамшгаас үүсэх үр дагаварт тухайн орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан дүн шинжилгээ хийж, үүнд үндэслэн гамшгаас хамгаалах арга хэмжээг улс, орон нутагтаа хэрхэн зохион байгуулах нь чухал ач холбогдолтой асуудал юм.

Манай улс эх газрын эрс тэс уур амьсгалтай орон бөгөөд сүүлийн жилүүдэд байгалийн араншин

[1] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйл
[2] Д.Сэржмядаг “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо: хөгжил хандлага”, Улаанбаатар,2013,х.128

өөрчлөгдөж аюулт үзэгдэл, ослын тоо, давтамж ихсэж учруулах хохирол жилээс жилд нэмэгдэж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эмзэг байдлыг бууруулах, бэлэн байдлыг хангах, чадавхийг бэхжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Гамшигтай тэмцэх үйл ажиллагаа нь зөвхөн Онцгой байдлын байгууллагын үүрэг биш, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний байгууллага, олон нийт, иргэдийн оролцоотойгоор үр дүнд хүрэх асуудал зайлшгүй юм.

Орон нутагт гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулахын тулд аймаг, сумын нутгийн захиргааны байгууллага, гамшгаас алба, мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдийн оролцоотойгоор сүүлийн үеийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэн боловсронгуй болгож, үүрэг хариуцлагыг ухамсарлуулж, гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед практик дээр хамтран ажиллаж, мэдлэг, ур чадварыг сайжруулах нь чухал ач холбогдолтой болсон байна.

Иймд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг орчин үеийн гамшгаас хамгаалах менежментийн дээрх үзэл баримтлалд нийцүүлэн, үр дүнтэй, оновчтой явуулахын тулд гамшгаас хамгаалах албадын үйл ажиллагааг сайжруулах арга замыг боловсруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсч байна.

Үндсэн хэсэг: Анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1967 оны 42 дугаар тогтоолоор “Иргэний хамгаалалтын албад буюу Улсын албадыг байгуулах” анхны шийдвэр гарч байжээ. Мөн 1990 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор “Иргэний хамгаалалтын дүрэм”-ийг баталсан байна. Улмаар 1994 онд “Иргэний хамгаалалтын тухай шинэ хууль”-аар гамшгаас хамгаалах албадыг шинэчилж байсан түүхтэй бөгөөд 1996, 1997 онуудад нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж байжээ.

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны холбогдох байгууллагыг түшиглүүлэн гамшгаас хамгаалах орон тооны бус улсын албыг 2005 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 158 дугаар тогтоолоор дор дурдсанаар байгуулсан байна. Үүнд:

Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба

Эрүүл мэндийн алба

Хүнс, хөдөө аж ахуйн алба

Түлш, эрчим хүчний алба

Цацрагийн аюулаас хамгаалах алба

Зам, тээврийн алба

Барилга, хот байгуулалтын алба

Мэргэжлийн хяналтын алба

Мэдээлэл, харилцаа холбооны алба

Хэв журам сахиулах алба

Сурталчилгааны алба

Засгийн газрын 2005 оны 158 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах орон тооны бус 11 улсын алба ажиллаж байсан бол 2012 онд батлагдсан Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиар зарим яам, агентлагийн бүтэц өөрчлөгдсөн, шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан “Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 186 дугаар тогтоолоор

гамшгаас хамгаалах орон тооны бус 13 улсын алба байгуулагдаж гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран хэрэгжүүлж иржээ.

Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хөгжлийн хэтийн төлөв, хандлагыг харгалзан “Уул уурхайн улсын алба”-ыг, хүний хөгжил, онцгой байдлын үе дэх хүүхэд, хүн ам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн бодлого, аюулгүй байдал, тэдгээрт үзүүлэх нийгмийн хамгаалал, тусламж, дэмжлэг зэргийг харгалзан “Хүн ам нийгмийн хамгааллын улсын алба”-ыг тус тус нэмж байгуулсан байна.

Улсын алба байгуулах эрхзүйн үндэс нь Гамшгаас хамгаалах тухай хууль байсан бөгөөд 16.2-т “Гамшгаас хамгаалах улсын албыг төрийн захиргааны холбогдох байгууллагыг түшиглэн Засгийн газар байгуулна”, 16.3-т “Гамшгаас хамгаалах улсын албаны дарга нь тухайн төрийн захиргааны байгууллагын дарга” байна гэсэн бол 17.2-т “Шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын шийдвэрээр гамшгаас хамгаалах улсын албыг шинээр байгуулж, татан буулгаж болно” гэж тус тус заасныг үндэслэн гамшгаас хамгаалах улсын албадыг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор байгуулдаг байна[3].

Гамшгаас хамгаалах албадын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэг:

2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 33 дугаар зүйлд[4] Гамшгаас хамгаалах албаны ажиллах чиг үүргийг тусгаж өгсөн байна. Үүнд:

Салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

Салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх;

Хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;

Салбарын онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах;

Гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах;

Салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах;

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх;

Орон нутгийн гамшгаас хамгаалах албыг мэргэжлийн удирдлагаар хангах;

Гамшиг болон аюулын нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах;

Голомтын бүсэд ажиллах мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт оролцуулах;

Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;

[3] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16.2 дахь заалт

[4] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйл

Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх аргахэмжээний санал боловсруулах;

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх мэдээ, тайлан гаргах.

Хариуцсан салбарын хүрээнд холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартыг боловсруулж, батлуулах.

Гамшгаас хамгаалах улсын албань гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагчтай байна.

Орон нутгийн гамшгаас хамгаалах алба энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Орон нутгийн гамшгаас хамгаалах албадын бүтэц

д/д	Аймгийн гамшгаас хамгаалах албаны нэр	Түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага
1	Байгаль орчны алба	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
2	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн газар
3	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуйн газар
4	Түлш, эрчим хүчний алба	ЭБЦТСТӨК-ХКомпани
5	Зам, тээврийн алба	Авто тээврийн төв
6	Барилга, хот байгуулалтын алба	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
7	Мэргэжлийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын газар
8	Хэв журам сахиулах алба	Цагдаагийн газар
9	Сурталчилгааны алба	Боловсрол соёл урлагын газар
10	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК
11	Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
		Нийгмийн даатгалын хэлтэс
12	Цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх алба	Ус цаг уур, орчны шинжилгээний төв
13	Мал эмнэлгийн алба	Мал эмнэлгийн газар

Орон нутгийн гамшгаас хамгаалах удирдлагын менежментийг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх.

Орон нутгийн гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах

Орон нутгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийнхний гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох мэдлэг дадлагыг дээшлүүлэх.

Орон нутгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүү болон бусад нөөцийг нэмэгдүүлэх, бичил зээл, дундын сан, давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх.

Орон нутагт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бий болгох.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

Дүгнэлт:

Монгол оронд тохиолдох байгалийн аюулт үзэгдэл, технологийн болон үйлдвэрлэлийн ослын төрөл, тэдгээрийн давтамж, учруулж байгаа хохирлын хэмжээ өсөн нэмэгдэж байгаа өнөө үед гамшгийн суурь ойлголт, нэр томьёог олон улсын жишигт нийцүүлэн зөв тодорхойлох, салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын үндэсний механизмыг бүрдүүлэх, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудалд олон нийт, иргэдийн оролцоог хангах, эрсдэлийг үнэлэх, гамшгаас хамгаалах тогтолцоог шинэчлэх, хүмүүнлэгийн тусламж, зохицуулалтыг хангах зэргээр зохион байгуулалтын арга хэмжээг боловсронгуй болгох шаардлага чухал ач холбогдолтой байна.

Монгол Улс гамшгаас хамгаалах бодлогыг байгаль цаг уур, газар орны нөхцөл байдалд уялдуулан бүсийн системд хуваан хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнтэй холбоотой гамшгаас хамгаалах албадын үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах, эрхзүйн баримт бичигт судалгаа хийж, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход төрийн зарим байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар дундын удирдлага, зохицуулалт, хэрэгцээ, шаардлагыг боловсронгуй болгож хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги нэг бүрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг гамшиг, аюулт үзэгдэл, осол тус бүр дээр нь нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс” 2017 он

2. “Гамшгаас хамгаалах орон нутгийн албаны нийтлэг журам” 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн А/865 дугаар тушаал

3. “Гамшгаас хамгаалах тухай хууль” шинэчилсэн найруулга 2017.02.02

4. “Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 186 дугаар тогтоол

5. Гамшгаас хамгаалах улсын албаны нийтлэг журам” Монгол улсын Шадар сайдын 2013 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 52 дугаар тушаал

6. “Гамшгаас хамгаалах үндэс” Шинжлэх ухааны доктор, профессор О.Үржин, П.Цэдэв.

7. “Гамшгийн менежмент” 2020 он

8. Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал 2020 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ЗАРИМ АРГА ЗАМ

SOME METHODS TO DISSIMINATE DISASTER PREVENTION INFORMATION TO PEOPLE WITH DISABILITIES

Д.Отгонболд
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, хошууч
Otgonbold.D
University of internal affairs master major

Хураангуй: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшгаас хамгаалах эрхзүйн зохицуулалт, баримт бичгүүдэд шинжилгээ хийлээ. Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл хэрхэн хүрч байгаа талаар судлан цаашид хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь ангилан энэ талын мэдлэг, мэдээллийг хүргэх зарим арга замуудыг тодорхойллоо.

Abstract: Legal regulations and documents on disaster protection of people with disabilities were analyzed. Studied how disaster prevention knowledge and information is available to people with disabilities, and identified ways to further disseminate knowledge and information in this area by classifying people with disabilities.

Түлхүүр үгс: Хөгжлийн бэрхшээл, гамшгаас хамгаалах, цахим мэдлэг олгох
Key words: Disability, disaster protection, provide knowledge online

Удиртгал: Дэлхий нийтэд тулгараад буй цаг уурын өөрчлөлт, байгалийн хүчин зүйл, гамшиг, аюулт үзэгдэл, осол аваар зэргээс үүдсэн хохирлын үр нөлөө жил бүр нэмэгдэж, дэлхий дахинд сөргөөр нөлөөлсөөр байна.

Үүнийг дагаад дэлхийн хүн төрөлхтөн хөгжлийн явцдаа байгалийн болон хүнээс үүдэлтэй төрөл бүрийн гамшиг, аюулт үзэгдлийн эсрэг тэмцэн тодорхой хэмжээний дадлага, туршлага чадвараа хөгжүүлсээр байна.

Манай ард түмэн ч байгаль цаг уурын үзэгдэлд дасан зохицож эх дэлхийтэйгээ уялдаа холбоотой амьдарсаар ирсэн. Гэвч байгалийн давагдашгүй аюулт үзэгдэл, гамшиг ослын хор хохирлын хэмжээ жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь биднийг гамшгийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй байж түүнтэй хэрхэн тэмцэх арга барилд суралцахыг шаардсаар байна. Гамшиг, ослын талаар зөв мэдээ, мэдээлэлтэй байснаар хэрхэн урьдчилан сэргийлэх, хор хохирол багатайгаар даван туулах чадварыг эзэмших боломжтой болно.

Хүнд хэцүү байдлаас өөрийнхөө болон бусдын амь нас, эрүүл мэндийг авран хамгаалахын тулд арга барил, мэдлэг, мэдээллийг олж авах шаардлагатай. Анхны тусламж шаардлагатай болсон үед шарх боох, цус алдалтыг зогсоох, түлэгдсэн болон хөлдсөн, осгосон үед авах арга хэмжээ, хиймэл амьсгал хийх, усанд живсэн хүнд үзүүлэх тусламж зэрэг зааж сургах болон суралцах зүйлс маш олон байдаг.

Хүн төрөлхтөн бид нас, хүйс, гарал угсаа, яс үндэс, нийгмийн гарал, оршин суугаа улс зэргээсээ үл хамааран хүний эрхээ эдлэх ёстой байдгаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамгаалуулах эрх нь нэн чухалд тооцогддог.

Гамшиг осол, аюулт үзэгдлийн үед хамгийн их хохирол амсдаг

нийгмийн бүлэг нь хүүхэд болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хөгжлийн бэрхшээлийн онцлог шинж тус бүрээр ангилан сургах нь чухал юм. Харааны бэрхшээлтэй хүнд сонсголоор нь, сонсголын бэрхшээлтэй хүнд хараа болон дохиогоор нь, тулгуур эрхтний буюу тэргэнцэртэй иргэдэд зориулсан тусгай арга барилаар, оюуны бэрхшээлтэй иргэдэд ямар зүйлийг илүү хүлээж авах тэр чадвараар нь тухайн онцлог бүрт нь тохируулан мэдлэг, мэдээллийг хүргэх нь хамгийн чухал.

Энэхүү илтгэлийг боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын төлөөллүүдтэй фокус бүлгийн ярилцлага хийх судалгааны арга хэрэглэлээ.

Үндсэн хэсэг: Хөгжлийн бэрхшээлийн тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг хэлэх талаар бидний ойлголт цаг хугацааны явцад нэлээд хувьсан өөрчлөгджээ.

Үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээл, Эрүүл мэндийн олон улсын ангилалд:

Хүүхэд залуучуудын хувилбар (англиар International Classification of Functioning, Disability and Health: Children and Youth Version буюу ICF-CY) нэртэй баримт бичигт хөгжлийн бэрхшээлийг цэвэр биологийн юм уу нийгмийн талаас нь харах хандлагаас татгалзаж, харин эрүүл мэндийн байдал, орчин, хувь хүний хүчин зүйлсийн харилцан үйлчлэл юм гэж үзжээ. Хөгжлийн бэрхшээл нь дараах гурван түвшинд илэрч болох ба үүнд:

- Бие мах бодийн үйл ажиллагаа юм уу бүтцийн согог (жишээлбэл, гэрэл нэвтрэх, эд зүйлсийн хэлбэр дүрс, хэмжээг мэдрэхэд саад болдог нүдний болор цайх өөрчлөлт)
- Үйл хөдлөлийн хязгаарлалт (жишээлбэл, юм унших, бие дааж явах чадваргүй байх);
- Оролцооны хязгаарлалт (жишээлбэл, сургууль завсардах) зэрэг багтана.

1975 онд НҮБ-аас батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал”-д хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн ойлголтыг анх боловсруулжээ. Тунхаглалын нэгдүгээр зүйлд “Бие бялдрын буюу сэтгэл санааны чадавх нь төрөлхийн буюу олдмол шалтгаанаар дутмаг болсны улмаас хувийн болон нийгмийн амьдралын шаардлагыг бие даан хангаж чадахгүй байгаа аливаа этгээдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж хэлнэ.” гэж заасан бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулинд “Бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж ойлгоно” гэж заасан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухайн конвенцод “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие мах бодь, сэтгэл мэдрэл, оюун санаа, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь янз бүрийн саад тотгортой нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй

оролцоход нь саад учруулахуйц болсон хүнийг багтааж ойлгоно” гэжээ.[1]

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-д зааснаар "хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдэгт бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг” хэлнэ гэсэн байна.[2]

Зураг 1. Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ? /МХБИБҮХолбоо/




Хөгжлийн бэрхшээлийн статистик нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд хүрээлэн буй орчны зүгээс тулгарч буй саад тотгор, тэдгээрийн аж амьдралын байдал, зорилтот үйл ажиллагаан дахь оролцооны хязгаарлалт, ялгаварлан гадуурхалт зэргийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зэрэг нийгэм, эдийн засаг болон хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдийг тусгасан өргөн агуулгатай юм.

Монгол Улсад 2021 оны байдлаар эрэгтэй 60,247, эмэгтэй 45,922 нийт 106,169 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Зураг 2. Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо /Статистикийн мэдээллийн нэгдсэн сан/

[1] Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл Асуудал дэвшүүлсэн тайлан 2012 он

[2] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо www.1212.mn

Үүнээс харааны хөгжлийн бэрхшээлтэй хүн 11,695, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн 20,414, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн 4,074, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүн 21,011, сонсголын хөгжлийн бэрхшээлтэй хүн 8,430, хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн 7,430, бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн 33,115 амьдарч байна.[3]

Эдгээр тоон үзүүлэлтүүдийг харвал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох шаардлагатай байгааг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин, баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ.

Дэлхийн хүн ам өсөхийн хэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо ч улам бүр нэмэгдэж байна. Нөгөө талаас ядуурал, байгалийн гамшиг, осол гэмтэл, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдлаас хүн хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өссөөр байна. Ялангуяа ийм байдал хөгжлөөр буурай болон хөгжиж буй улс орнуудад харьцангуй өндөр хувьтай байдаг. Хөгжлийн бэрхшээл нь хэнд ч хэдийд ч тохиолдож болох учраас хүн бүрт хамаарах асуудал юм.

[3]Үндэсний статистикийн хороо www.1212.mn

2013 онд Дэлхий нийтэд анх удаа НҮБ-аас Женевийн судалгаа буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд гамшигт нэрвэгдсэн, өртсөн талаарх томоохон судалгааг дэлхийн 126 улс орны 5450 хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс авч дүн шинжилгээ хийсэн байна.[4]

Ерөнхий Ассамблейн 1982 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 37/52 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх дэлхийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бүх салбар дахь хөгжлийн агент болон ашиг хүртэгч хүмүүс гэж хүлээн зөвшөөрсөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломж бололцоог тэгшитгэх стандарт дүрмийг Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/96 тоот тушаалаар баталсан.

Хүний эрхийн Комиссын 1992 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 48/3 тоот тушаалаар Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 1993-2002 оны 10 жилийн хөтөлбөрийг баталсан бөгөөд комисс бүс нутгийн хэмжээнд хийгдэх анхны 10 жилийн хөтөлбөрийг дэлхий дахинд тунхаглав.

Хүний эрхийн комиссын 2002 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 58/4 тоот тушаалаар 21 дүгээр зуунд Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан оролцоотой, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг хөхүүлэн дэмжих бөгөөд үүнд Комиссоос 2003-2012 онд хэрэгжүүлэх Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дараагийн 10 жилийн хөтөлбөрийн үргэлжлэлийг тунхаглав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хугацаанд Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан оролцоотой, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг чиг болгосон Бивакогийн мянганы хүрээн дэх үйл ажиллагааны бүс нутаг дахь хэрэгжилтийн талаарх комиссын 2003 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 59/3 тоот тушаал болон үүнд Комиссоос Бивакогийн мянганы хүрээн дэх үйл ажиллагааны хэрэгжилтийг гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудаас дэмжихийг уриалав.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2006 онд 61-р чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” түүний нэмэлт протоколд Монгол улс нэгдэн орсныг УИХ 2008 онд соёрхон баталсан.

НҮБ-ын бүсийн хөгжлийн байгууллага Ази, номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орнууд 2012 онд Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодитой болгоё” Инчеоны стратегийг баталсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай “Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчеоны Стратегийг Ази болон Номхон Далайн бүс нутагт орших хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан 1993-2002 он болон 2003-2012 онуудад дараалан хэрэгжүүлсэн 10 жилийн 2 хөтөлбөрийн туршлага

[4] https://www.undrr.org/news/un-global-survey-explains-why-so-many-people-living-disabilities-die-disasters

болон 2006 онд Ерөнхий Ассамблейн батлалсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцод суурилж боловсруулсан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал Японы Мияаги мужийн Сендай хотноо 2015 оны 3 дугаар сард зохион байгуулагдаж гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос хойш баримтлах үйл ажиллагааны хүрээг батлан дэлхийн хэмжээний долоон зорилт дэвшүүлсэн.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны 4 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

1.Гамшгийн эрсдэлийг ойлгох;

2.Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх;

3.Гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах;

4.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд "Сайжруулан барих" үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Мөн гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр ангилсан мэдээлэл, уламжлалт мэдлэгээр баяжуулсан хүртээмжтэй, шинэчлэгдсэн, өргөн хүрээтэй, шинжлэх ухаанд суурилсан, нийтэд зориулсан эрсдэлийн мэдээллийг нээлттэй солилцох, түгээх талаар олон төрлийн аюул, эрсдэлийг тооцсон шийдвэр гаргах шаардлагатай байдаг гэж тус баримт бичигт заагдсан байна.

Монгол улс нь АНДБЭЗНК-ын гишүүн орны нэг бөгөөд Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн "Эрхийг бодит болгоё" Инчеоны Стратегийн 10 зорилгын "Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах, менежментийг баталгаажуулах" гэсэн 7 дахь зорилт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд хамаарсан томоохон эрх зүйн баримт бичиг болно.[5]

Монгол Улсад Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, гамшгаас хамгаалах тухай хуулиуд болон бусад 28 хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 278 орчим зүйл заалт байдаг.

НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах байгууллагаас жил бүрийн 10 дугаар сарын 13-ны өдрийг Олон улсын гамшгийн эрсдэлийг бууруулах өдөр болгон зарлаж гишүүн улс, орон бүр тодорхой уриан дор дараа жилийн 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл тодорхой ажлыг зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлдэг.

2013-2014 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрсдэлийг бууруулах" уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 3 төрлийн судалгаа байдаг. Үүнд:

Үндэсний статистикийн хорооны тоон судалгаа

[5]Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал, 2015 он

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын судалгаа /Эрүүл мэндийн шалтгаанаар тодорхойлох/

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын судалгаа.

Судалгаанаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшигт өртсөн байдлаар тоон судалгаа огт хийгдээгүй байна.

2015 онд Монгол Улсын засгийн газар болон НҮБ-ын конвенцийн тайланд Гамшгаас хамгаалах болон гамшигт нэрвэгдсэн хүний тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэд өртсөн эсэхийг судлах боломж байхгүй байгааг тусган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Сүүдэр” тайланд хамгаалах механизм бий болгох талаар дурдсан байна.

Мөн оны 5 дугаар сард Монгол Улсын засгийн газарт НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос энэ чиглэлээр зөвлөмж ирүүлсэн боловч одоог хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.[6]

Гамшиг, ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдлууд Монгол Улсад цөөнгүй тохиолддог. Жишээ нь: Нэгэн малчин малдаа явж байгаад аянганд цохиулаад амьд гарсан боловч сонсгол нь гэмтэж сонсголын бэрхшээлтэй болсон байна. Дорнод аймагт гарсан ой хээрийн гал түймрийн улмаас онцгой байдлын газарт ажиллаж байсан аврагч, гал сөнөөгч залуу хүндээр түлэгдэн хөгжлийн бэрхшээлтэй болсон байдаг.

Мөн сонсголын бэрхшээлтэй иргэн голын дэргэд хүүхдүүдтэйгээ амарч яваад голын усанд унасан хүүхдээ сонсохгүйгээр амь насыг нь алдсан, объектын гал түймрийн улмаас гал гарч байгааг мэдэлгүйгээр угаартаж амь насаа алдсан тохиолдлууд гарсан байдаг.7

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж буй байдал, бусад орны туршлага:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2018-2022)-ийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газраас 2021 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлтийн үр дүнд -Гамшгаас хамгаалах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт улсын хэмжээнд 2016 онд 20 удаа 40 цаг нийт 529 хүн, 2017 онд 18 удаа 36 цаг, 482 хүн, 482, 2018 онд 22 удаа 408, 2019 онд 21 удаа 42 цаг, 504 хүн, 2020 онд 9 удаа 9 цаг, 98 хүн, 2021 онд нийт 26 удаа, 42 цагийн сургалтыг зохион байгуулж 463 хүнийг хамруулсан байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлгийг дохионы хэлний орчуулгатайгаар бэлтгэн хүргэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээ, мэдээлэл шуурхай хүргэдэг болсон.

2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас бэлтгэн хүргэдэг “Онцгой байдлын цаг” нийт 118 нэвтрүүлэг дохионы хэлтэйгээр 14 хоног тутамд Монголын Үндэсний телевиз, UBS, Өлзий, Royal телевизүүдээр хүрч байна.

Мөн болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөгөө, мэдээ, мэдээллийг тогтмол хүргэдэг www.nema.gov.mn цахим хуудас, гамшгаас урьдчилан сэргийлэх

[6] МХБИБҮХ болон МХБИБШүхэр НБЕЗөвлөлийн ерөнхийлөгч Ц.Оюунбаатар, 2022 он

[7] Сонсголгүй иргэдийн үндэсний холбооны тэргүүн А.Энхбаатар, 2022 он

сургалтын www.ontsgoisur.gov.mn цахим хуудаснуудыг ажиллуулан иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэж байна.

14 хоног тутамд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх “Онцгой мэдээ” сонинг эрхлэн гаргадаг.[8]

Зураг 3. Онцгой байдлын ерөнхий газрын Олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагаа



2012 онд Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан Ази болон Номхон далайн бүс нутаг дахь Инчеоны стратегийн хурлын үеэр тулгуур эрхтний бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй иргэн гэрт нь хийн газ дэлбэрсний улмаас гарч чадалгүй амь алдсан тохиолдол байдаг. Үүнээс үүдэн бослого гарч байсан.

Энэ үйл явдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн "эрхийг нь бодитой болгох" Инчеоны стратегийн уриа болсон байдаг.Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Засгийн газар 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авсан.

2015 онд Бүгд Найрамдах Солонгос Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ зориулсан гамшгаас хамгаалах болон урьдчилан сэргийлэх зориулалтаар өөрсдөө автоматаар дуугардаг, анивчдаг тусгай дугаарууд руу залгадаг төхөөрөмжүүдийг системтэйгээр хөгжүүлсэн байна.

Америкийн Нэгдсэн Улсад 35.000 орчим суралцагчидтай сургууль 1.700 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байдаг. Тухайн сургууль нь тэдгээр суралцагчиддаа зориулан хөгжлийн бэрхшээл тус бүрээр нь ангилан өөрийн хийх гэж байгаа үйлдлээ илэрхийлэхээс гадна аюул тохиолдоход тусгай дугаар руу залгаж тусламж авах зориулалтын дардаг төхөөрөмжүүдийг суурилуулсан байна.

Мөн Япон, Малайз, Тайланд зэрэг улсуудад эмнэлгийн барилга, байгууламж дотор гал гарах, газар хөдлөх зэрэг аюул тохиолдоход анхааруулах гэрлэн дохиоллыг бүх

[8]ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын тайлан, 2022 он


газарт байршуулсан байдаг байна.[9] Энэ нь сонсголын бэрхшээлтэй болон оюуны бэрхшээлтэй иргэдэд чухал шаардлагатай байдаг байна.

Бусад орны туршлагаас харахад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүргэх үйл ажиллагаа нь янз бүрээр илэрч байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж буй өнөөгийн байдалд хийсэн бодит судалгаанд тулгуурласан сайжруулах зарим арга зам


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл хэрхэн хүрч байгаа талаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, мэдээлэл хүргэж буй судалгаа” асуулгыг боловсруулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагын “Шүхэр” нэгдсэн бодлогын ерөнхий зөвлөл, Сонсголын бэрхшээлтэй иргэдийн холбоо болон бусад иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудын харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, тулгуур эрхтний бэрхшээлтэй зэрэг хэлбэр тус бүрээс төлөөлөл болгон одоогийн байдлаар нийт 120 орчим иргэдээс энэхүү судалгааг хийлээ.

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс авсан асуулгын үр дүн




Судалгаанд оролцсон иргэдийн 50% нь эрэгтэй, 50% нь эмэгтэй байсан бөгөөд нийт 82.8% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 12.1% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагч, 5.2% нь хамтдаа оролцсон байна.

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн согогийн онцлог, төрлөөр авсан асуулгын үр дүн



[9]МХБИБҮХ болон МХБИБШүхэр НББЕзөвлөлийн ерөнхийлөгч Ц.Оюунбаатар, 2022 он

Зураг 5. Гамшгаас урьдчилан сэргийлэх цахим мэдээллийн сан байгаа эсэх талаар авсан асуулгын үр дүн



Дээрх асуулга судалгаанаас харахад дэвшүүлсэн гол санаа, мэдээлэл хүргэх арга зам хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл хүргэх нэгдсэн мэдээллийн сан, цахим хуудас зэрэг байдаг талаар нийт оролцсон хүмүүсийн 92.4% огт байхгүй гэсэн санал өгсөн байна.

Дэлхий нийт цаашид хийсвэр оюун ухаан, олон нийтийн сүлжээ, дижитал хөгжүүлэлтийн ертөнцөд хөтлөгдөн орж байна. Түүнийгээ дагаад техник, технологийн шинэ дэвшлүүд урган гарсаар байна.

Орчин цагт мэдээ, мэдээллийг сошиал болон интернетийн цахим хуудсуудын тусламжтайгаар цаг алдалгүй хурдтай авч байгаа нь гар утас болон таблет хэрэглэж байгаа хүмүүсийг харахад ойлгогдож байна.

Тиймээс цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн онцлог тус бүрээр нь ангилан /харааны хөгжлийн бэрхшээлтэй хүн, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн , хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүн, сонсголын хөгжлийн бэрхшээлтэй хүн, хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн/ харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай мэдрэгч бүхий ном, гарын авлагыг бэлдэх, сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан үйл хөдлөл бүхий дохионы хэлтэй видео, контентууд, гамшиг, ослын чиглэлээрх сургалтуудыг гамшгийн төрөл бүрээр нь ангилан хувааж сургалтын тусгай модулиудыг боловсруулах нь илүү үр дүнтэй.

Тусгай модулиудыг боловсруулахдаа зурган хэлбэрт оруулж, дараалан ангилж, сонирхолтой хэлбэрээр боловсруулах хэрэгтэй.

Мөн гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэхдээ мөн адил аврагчдад тухайн иргэний хөгжлийн бэрхшээлийн онцлогт таарсан сургалтыг заадаг байх хэрэгтэй байна. Газар хөдлөлтийн үед харааны бэрхшээлтэй хүнтэй хэрхэн ойлголцох, сонсголын бэрхшээлтэй хүнтэй хэрхэн дохионы хэлээр харилцан ойлголцох гэсэн асуудлаар сургалтуудыг тэдгээрийн иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдтэй хамтран зохион байгуулах нь зүйтэй.

Одоог хүртэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгдсэн мэдээллийн систем байхгүй байгааг дээрх судалгааны үр дүнгээс харж болно. Гамшгаас хамгаалах,

урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийн нэгдсэн систем, платформыг бий болгож хөгжлийн бэрхшээлтэй иргэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг бие даан өөрөө суралцах том боломж бүрдэх томоохон арга зам юм.

Дүгнэлт

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, мэдээлэл хүргэж буй судалгаа”-ны одоогийн /цаашид энэ тоо нэмэгдэнэ/ үр дүнг харахад ихэнх хөгжлийн бэрхшээлтэй иргэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг зурагтаар 83%, facebook сошиал сувгуудаар 38.3%, гар утсаар 16.5%, амьдарч байгаа газрынх нь хувь гал түймэр гарах эрсдэл 33.1%, үер усны аюул 28%, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтад огт оролцож байгаагүй 63.8%-тай гарч байгаа нь судалгааны бодит үр дүнг харуулж байна.

Энэ нь цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн согогийн онцлог, хэлбэр тус бүрээр нь ангилсан /харааны хөгжлийн бэрхшээлтэй хүн, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн , хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүн, сонсголын хөгжлийн бэрхшээлтэй хүн, хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн/ харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай мэдрэгч бүхий ном, гарын авлагыг бэлдэх, сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан үйл хөдлөл бүхий дохионы хэлтэй видео, контентууд, гамшиг, ослын чиглэлээрх сургалтуудыг гамшгийн төрөл бүрээр нь ангилан хуваж сургалтын тусгай модулиудыг боловсруулах шаардлагатай байгааг бодитоор харуулж байгаа нь дээрх төрөл, хэлбэрээр ангилсан бүтцүүдийг агуулсан, тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүн нэвтрээд өөрийн хэрэгцээт бүх мэдээллээ нэг дооройс төвөггүй авдаг байхаар нэгдсэн цахим мэдээллийн сантай болгох шаардлагатай байгааг харуулсан үр дүн гарлаа.

2021 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик тоо өмнөх оныхоос багассан эерэг үзүүлэлттэй боловч түүнээс өмнөх жилүүдийг харахад улам өссөн нь харагдаж байна. Тэгэхээр хөгжлийн бэрхшээл нь ямар нэгэн байдлаар үүсч байдаг нь магадгүй гамшиг, ослын тоо нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Монгол Улсын Засгийн Газарт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийг эргэн харах, гамшгаас хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшигт өртөж буй тоон судалгааг гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд багтаан үндэсний статистикийн хороонд уламжлан жил бүр гаргадаг болгох нь зүйтэй.

Инчеоны стратеги нь уялдаа холбоо бүхий 10 зорилго, 27 зорилт болон 62 шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ. Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөрийн зорилго болон зорилтод хүрэх цаг хугацааны хүрээ нь 2013-2022 оныг хамарч байгаа нь энэхүү хөтөлбөрийн зорилго, зорилтод анхаарах боломж буйг харуулж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ

баримт бичигт тодорхойлсон дараах шаардлага, заалтуудын хэрэгжилтэд анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүн төвтэй үйл ажиллагааг өргөн хүрээнд хэрэгжүүлэх.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй, үр нөлөөтэй болгохын тулд олон салбарын олон төрлийн аюулыг тооцсон, хүртээмжтэй болгох хэрэгтэй.

Удирдан зохицуулах үүрэг, хариуцлага бүхий Засгийн газрууд бодлого, төлөвлөгөө, стандарт боловсруулах, хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүд, хүүхэд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуу иргэд, шилжин суурьшигчдад, нутгийн уугуул иргэд, сайн дурынхан болон ахмадууд, холбогдох бусад талуудын оролцоог хангах хэрэгтэй.

Төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, бизнесийн үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна.10 Эдгээрийн хэрэгжилт үр дүнг шалган сайжруулах, дүн шинжилгээ хийх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнд хийгдээгүй орхигдсон ажлуудыг төлөвлөх шаардлагатай байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтууд хийгдэж байгаа ч гэсэн илүү эрчимжүүлэх шаардлагатай байгааг сонсголын бэрхшээлтэй иргэдийн байгууллагын төлөөлөлтэй фокус бүлгийн ярилцлага хийх үеэр ажиглагдаж байсан.

2011 оны 3 дугаар сард Япон улсад болсон 9 баллын газар хөдлөлтийн улмаас маш олон хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэрвэгдсэн бодит мэдээллүүд байдаг. Үүнээс үүдэн Япон улсын засгийн газраас гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтууд болон мэдээ, мэдээллийг хүргэх үе шаттай ажлуудыг зохион байгуулж байгаа.

Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдардаг өрх болон ажлын байранд гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө хийгдэх шаардлагатай байгааг 2015 онд хийсэн Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах судалгаа харуулж байна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд уламжлалт аргууд болох танхимын болон цахим сургалтаар олгохдоо онцлог шинжүүдээр нь илүү дэлгэрэнгүй арга барилыг нягтлан судлах, мэдээллийн нэгдсэн системийг бий болгож техник, технологийн эрин үетэй зэрэгцэн мэдээллийг хүргэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Ашигласан материал

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он

2. Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 он

3. Хөдөлмөрийн тухай хууль 2021 он

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, 2006 он

[10]Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр 2006 он,

6. Үндэсний статистикийн хороо www.1212.mn, 2022 он

7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын цахим хуудас http://www.gadpwd.gov.mn/

8. Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн асуудал: бодлого, Үйл ажиллагаа 2020 он,

9. Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага /Дэлхийн Банк, Хөгжлийн бэрхшээлийн тухай дэлхийн тайлан 2011 он,

10.Ази, Номхон Далайн бүс нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги. ХАХНХЯ, 2014 он

11.Гамшгийн эрсдэлийг бууруулах “Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичиг 2015-2030

12.Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн байдал, учирч буй бэрхшээл, даван туулах арга зам, МХБИБҮХ болон МХБИБШүхэр НБЕЗөвлөлийн ерөнхийлөгч Ц. Оюунбаатар

13.Гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах олон улсын туршлага ЭШӨ. ОБЕГ-ын БТХАГ-ын мэргэжилтэн ОБ-ын ахлах дэслэгч Д.Базаррагчаа. УБ 2014 он

14.Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал, ГСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан хошууч, докторант Ч.Мэндэлмаа, 2015 он,

15.Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох нь, М.Батмөнх, 2017 он,

16.Дэлхийн судалгаа-https://www.undrr.org/news/un-global-survey-explains-why-so-many-people-living-disabilities-die-disasters

17.Five actions for disability-inclusive disaster risk management https://blogs.worldbank.org/

18.https://www.dinf.ne.jp/doc/english/twg/escap_121031/fujii.html

ГАМШГИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF DISASTER HUMANITARIAN ASSISTANCE ACTIVITIES

Ш.Мөнгөнтуяа
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Munguntuya.Sh.
University of internal affairs, postgraduate

Хураангуй: Хүмүүнлэгийн тусламж болон гамшгийн үеийн хүмүүнлэгийн тусламжийн талаарх ойлголт, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа, тогтолцоо, оролцогч талууд болон хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтад шинжилгээ хийхэд оршино.

Abstract: The purpose of study is to analyze the understanding of humanitarian assistance and disaster relief, international humanitarian aid activities, systems, stakeholders, and humanitarian aid coordination.

Түлхүүр үгс: Хүмүүнлэгийн тусламж, гамшиг, оролцогч талууд, зохион байгуулалт

Key words: Humanitarian aid, disasters, stakeholders, organization

Удиртгал: Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн тоо, давтамж, хор уршиг нэмэгдэж байгаатай зэрэгцэж дэлхий улс орнууд нэгдсэн санал санаачлага гаргаж ирсэний нэг нь “Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн бага хурал”-ыг зохион байгуулж ирсэн явдал бөгөөд уг хурлаас гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааныг хүрээг баталж, тодорхой цаг хугацааны хүрээнд хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлж, улс орнууд эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах болсон.

2015 оны “Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн III бага хурал”-аас “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг баталж, уг баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх дэлхийн хэмжээний 4 тэргүүлэх чиглэл (гамшгийн эрсдэлийг ойлгох, гамшгийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх, даван туулах чадварыг нэмэгдүүлэх болон гамшгийн эрсдлийг бууруулахад хөрөнгө оруулалт хийх, гамшгийг даван туулах бэлэн байдлыг хангах)-ийг тодорхойлсон. Энэ баримт бичигт хүмүүнлэгийн тусламж, тэр тусмаа гамшгийн эрсдэлийг сааруулах чиглэлээр хэрэгжиж буй тусламжийн хөтөлбөрүүд нь эрт анхааруулга, эрт арга хэмжээний арга хэлбэрүүдэд ихээхэн төвлөрч байна.

Энэхүү Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй зэрэгцээд Монгол Улсын гамшгаас хамгаалах салбарт олон шинэчлэлт бий болсоны нэг нь “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 2017 оны шинэчлэл юм. Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчлэснээр урьд өмнө нь тэр бүр анхаарлаа хандуулж чаддаггүй байсан хэд хэдэн асуудлуудыг нэмж оруулах боломж олдсон байна. Үүнээс дурьдвал гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхныг дайчлах, урамшуулах, дотоодын болон гадаадын

хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг зохицуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн асуудал зэргийг илүү тодотгож өгсөн юм.

Монгол Улсад гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн зохицуулалт нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам (МУ-ын ЗГ-ын 133 дугаар тогтоол) зэргээр зохицуулагдаж байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийн тоо, давтамж нэмэгдэж, гамшигт өртсөн иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байгаа ч манай улсын хувьд хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн зохицуулалт, ялангуяа олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, зарцуулах тал дээр зохицуулалт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Иймд гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох сайжруулах шаардлага тулгарч байна.

Үндсэн хэсэг: "Хүмүүнлэгийн тусламж" гэж иргэн, байгууллага, хуулийн этгээдээс гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж сайн дурын үндсэн дээр өгч байгаа мөнгөн хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материал, ажил, үйлчилгээг"[1] хэлнэ гэж тусгасан байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн үе шатуудаар тасралтгүй үргэлжлэх, нэгээс нөгөөд шилжих 4 үндсэн үйл ажиллагаа, 40 гаруй арга хэмжээнүүдийн цогц юм .

Зураг 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, үе шат



[1] Гамшгаас хамгаалах тухай. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №07. 2017

Тохиолдсон гамшгийн төрөл, хамрах хүрээ, учирсан хохиролоос хамаарч хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа нь дотоодын болон гадаадын гэсэн хоёр ангилалтай байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээнд гамшгийн төрөл, хамрах хүрээг тодорхойлсон дараах нэр томъёог ашиглаж байна . Үүнд:

Small-scale disaster буюу хэсэг орон нутгийг хамарсан, гамшигт өртсөн орон нутгийн хүчин чадлаас давсан гамшигт үзэгдэл.

Large-scale disaster буюу улс орныг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хамарсан зайлшгүй олон улсын хүмүүнлэгийн тусламж шаардагдах гамшигт үзэгдэл.

A slow-onset disaster буюу удаан өрнөлтэй гамшигт үзэгдэл. Үүнд ихэвчлэн ган гачиг, цөлжилт, халдварт өвчин зэрэг орно.

A sudden-onset disaster буюу хурдан өрнөлтэй, гэнэтийн гамшигт үзэгдэл. Газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, химийн осол, барилга байгууламж, техинкийн ослууд энэ төрөлд багтана.

Дээрх нэр томъёоноос харвал large scale, a sudden-onset disaster буюу улс орныг бүхэлд нь хамарсан, хурдан өрнөлтэй, гэнэтийн гамшиг тохиолдсон үед тухайн улсын өөрийн хүчин чадлаас давсан нөхцөл байдал үүсч зайлшгүй олон улсын хүмүүнлэгийн тусламж хүсэх хэрэгцээтэй болдог.

Гамшгийн үед олон улсын байгууллагуудаас үзүүлж буй хүмүүнлэгийн тусламж, хөтөлбөрүүд гамшгийн эрсдэлийг бууруулах буюу гамшиг тохиолдохоос өмнөх ба гамшгийн хор хохирлыг бууруулах буюу гамшгийн дараах хариу арга хэмжээ гэсэн хоёр үндсэн хэлбэрээр хүргэдэг.

Сүүлийн жилүүдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг байгууллагууд аливаа нэг гамшиг тохиолдохоос өмнө учирж болзошгүй хохиролыг бууруулах зорилгоор “Early warning, Early Action” буюу эрт зарлан мэдээлэл, эрт хариу арга хэмжээний үйл ажиллагааг авах болсон. Үүнийг нэг жишээ бол “Цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилт” хөтөлбөр бөгөөд Монгол улсын хувьд Монголын улаан загалмай нийгэмлэг болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага 2017 оноос хойш Ус, цаг уур, орчны шинжилгээний газраас гаргадаг “Зудын эрсдэлийн зураглал” дээр үндэслэж зудын нэн өндөр эрсдэлтэй аймаг, сумдын малчдад хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг. Ингэснээр өвөлжилт хүндрэх болон зуд болж, амьжиргааны эх үүсвэрээ алдахаас нь өмнө тусламжийг үзүүлж, гарч болзошгүй хохиролыг бууруулдаг.

Гамшгийн дараах хариу арга хэмжээний үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн онцлогийн хувьд хохирол, хэрэгцээний үнэлгээнд тулгуурлаж хүний амь нас, амьжиргааг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа орно.

Гамшгийн үеийн тусламж гэдэг нь үер, хар салхи, газар хөдлөлт, ган гачиг, хар салхи, үймээн самуун зэрэг гамшгийн улмаас хохирол амссан хувь хүн, олон нийтэд үзүүлэх мөнгөн болон мөнгөн бус үйлчилгээ юм. Тусламжийг янз бүрийн байгалийн гамшиг, осол, дайны хохирлыг арилгах, хохирогчдод туслах зорилгоор өгдөг.

Хүмүүнлэгийн тусламж нь хүний амь насыг аврах, эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьжиргааны наад захын хэрэгцээг

хангах зорилгоор гамшгийн өмнө, гамшгийн үеэр эсвэл дараа нэн даруй авсан арга хэмжээ юм. (UNDRR)

Олон улсын жишгээр хүмүүнлэгийн тусламж нь

- хүсэлт гаргах,
- бүртгэх,
- байршуулах,
- хадгалах,
- тээвэрлэх,
- хуваарилах зэрэг үйл ажиллагааны хэсгүүдээс бүрдэнэ[2].

Хүмүүнлэгийн тусламж бол яаралтай болон богино хугацааны хэрэгцээнд голчлон чиглэдэг бөгөөд үр дүнтэй, үр ашигтай, цаг тухайд нь хариу арга хэмжээ авах нь гамшгийн эрсдэлд суурилсан бэлэн байдлын арга хэмжээ, тэр дундаа хувь хүн, олон нийт, байгууллага, улс орон, олон улсын хамтын нийгэмлэгийн хариу арга хэмжээний чадавхийн хөгжилд тулгуурладаг.

Хариу арга хэмжээний институцийн элементүүдэд ихэвчлэн төрийн болон хувийн хэвшил, олон нийтийн салбараас яаралтай тусламж үзүүлэх, олон нийтийн тусламж үзүүлэх, түүнчлэн олон нийт, сайн дурынхны оролцоо багтдаг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний платформ нь улс орны хэмжээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотой, олон салбар, салбар дундын шинж чанартай гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зохицуулалт, бодлогын удирдамжийн механизм юм.

Үр дүнтэй засгийн газрын зохицуулалт нь үндэсний болон орон нутгийн түвшинд холбогдох орологч талуудаас бүрдэх бөгөөд үндэсний төвлөрсөн төвтэй байдаг. Ийм механизмыг үндэсний институцийн тогтолцоонд бат бөх суурь болгохын тулд хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, журмаар дамжуулан цаашдын үндсэн элементүүд, хариуцлагыг бий болгох шаардлагатай бөгөөд үүнд: тодорхой үүрэг хариуцлага, эрх мэдэл; гамшгийн эрсдэлийн мэдрэмжгүй мэдээлэл, өгөгдлийг хуваалцах, түгээх замаар гамшгийн эрсдэлийн талаарх мэдлэгийг бий болгох; орон нутгийн болон улсын гамшгийн эрсдэлийн тайланд хувь нэмэр оруулах, зохицуулах; гамшгийн эрсдэлийн талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохицуулах; орон нутгийн олон салбарын хамтын ажиллагааг хөнгөвчлөх, дэмжих (жишээлбэл, орон нутгийн засаг захиргаа хоорондын); үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, гамшгийн эрсдэлийн удирдлагатай холбоотой бүх бодлогыг тодорхойлох, тайлагнахад хувь нэмэр оруулах зэрэг хамаарна.

Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах баг (Humanitarian Country Team (HCT) нь хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг

Хүмүүнлэгийн тусламжийг ерөнхийдөө 11 гол салбар буюу 11 кластераар чиглэн хүргэдэг. Эдгээр нь :


- хүнсний хангамж
- орогнох хуаран
- эрт нөхөн сэргэлт
- боловсрол
- орон байр

[2] IFRC, Introduction to the Guidelines for domestic facilitation and regulation of international disaster and initial recovery assistance

- эрүүл мэнд
- шим тэжээл
- хамгаалалт
- ус, ариун цэвэр
- яаралтай харилцаа холбоо
- тээвэр

Хүмүүнлэгийн тусламжийн тогтолцоо гэдэг нь нийтлэг зорилго, зарчим, хэм хэмжээг дагадаг хоорондоо уялдаа холбоотой олон улсын байгууллага, хандив, төрийн байгууллагын удирдлага гэх мэтийг багтаасан сүлжээ юм. Энэхүү системд цэргийн хүчин болон хувийн байгууллагууд ордог ба хүмүүнлэгийн үйл ажиллагаанд голчлон төвлөрдөггүй ч, шаардлагатай үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд гол хүчин болдог.

Зураг 2. Хүмүүнлэгийн тусламжийн оролцогч талууд[3]



Хүмүүнлэгийн тусламжийн оролцогч талууд гол үүрэг болон оролцогч талуудад хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд гол нөлөөтэй хувь хүн, бүлэг, байгууллагууд юм. Үүнийг тайлбарлая.

1.Орон нутгийн иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд

Аливаа нэгэн байгалийн гамшгаас сэргийлэхэд нийгмийн бүлэг гүйцэтгэдэг. Тэд гамшигт өртсөн хүн ам болон тусламж хүртэгчдийг төлөөлөхөөс гадна гамшгийн үед хамгийн түрүүнд хариу арга хэмжээ авч, бусад оролцогч талуудад шийдвэрлэх шаардлагатай зүйлсийн талаар мэдээлэл өгдөг. Олон улсын байгууллагууд зарим тохиолдолд хүмүүнлэгийн тусламжийн үйл

[3] Сэржмядаг Д. “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс” УБ 2017 он, х 175

ажиллагаанд оролцох боломжгүй байдаг бөгөөд энэ үед орон нутгийн иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг өндөр бөгөөд чухал ач холбогдолтой байдаг. Аюулд өртсөн нийгмийн бүлэг нь тусламжийн үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлдэг ба заримдаа олон улсын байгууллагууд арга хэмжээ авах боломжгүй байдаг.

2.Төр, захиргааны байгууллагууд

Гамшгийн хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг (өөрийн улс орны хүн амаа хамгаалах) хамгийн түрүүнд тухайн улсын төрийн байгууллагууд (засгийн газар, яам, орон нутгийн болон дотоод байгууллагууд) хийдэг билээ. Тиймээс энэ нь хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааны зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжүүлэлт, эхлэлийг хариуцах гол үүрэгтэй. НҮБ-ын 46/182 тогтоолын дагуу гамшигт нэрвэгдсэн улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал ба үндэсний эв нэгдлийг хүндэтгэх ёстой бөгөөд тухайн улсын зөвшөөрлөөр хүмүүнлэгийн тусламжийг үзүүлнэ. Тухайн улсын Засгийн газар, төр захиргааны байгууллага нь гамшигт өртсөн иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хандлагагүй эсвэл тусламж үзүүлэх боломжгүй болсон үед олон улсын байгууллага үйл ажиллагаагаа эхлэх ёстой. Их Британий ALNAP ТББ-н мэдээлснээр “бүс нутгуудын хүмүүнлэгийн тусламжийн хамтын ажиллагааны нөөц бололцоо болон ач холбогдол сайжирсан” гэжээ. Латин Америк болон Карибын тэнгисийн орчмын улсууд Төв Америкийн байгалийн гамшгаас сэргийлэх, зохицуулах төв (CEPREDENAC) ба Пан Америкийн Эрүүл мэндийн байгууллага (PAN) зэрэг байгууллагууд нь гамшгийн үеэр хамтран ажиллаж эрсдэлийг бууруулах, гамшигт бэлэн байх гэх мэт механизмыг агуулсан байдаг.

3.Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)

Нэгдсэн үндэстний байгууллага нь олон улсын гамшгийн хариу арга хэмжээ, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах гол үүрэгтэй ба түүний төрөлжсөн байгууллагууд нь:

- Хүмүүнлэгийн Асуудлыг Зохицуулах Газар (OCHA)
- Дэлхийн Хүнсний Хөтөлбөр (WFP)
- Дүрвэгсдийн Асуудал Хариуцсан Дээд Комиссарын Газар (UNHCR)
- Хүүхдийн сан (UNICEF)
- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (WHO)
- Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO) гэх мэт.

4.Хандивлагч байгууллага

Энэхүү байгууллагууд нь эрсдэлд орсон хүн амд хоёр талт, олон талт хандив болон техникийн тусламж үзүүлдэг (бодит болон мөнгөн хэлбэрээр). Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд голчлон оролцдог оролцогч тал нь Европын холбоо, АНУ болон Япон зэрэг улс юм.

5.Хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага

Хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь төр болон бусад оролцогч талуудаас хараат бус, бие даасан бөгөөд тухайн орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг сайн мэддэг.

6.Цэргийн хүчин

Аливаа үйл ажиллагаанд оролцоход хамгийн тохиромжтой хүний нөөц, техник хэрэгслийн чадамжтай байдаг тул хүмүүнлэгийн тусламжийн

үйл ажиллагаанд сүүлийн жилүүдэд цэргийн хүчин орж ажиллах болсон.

Гол үүрэг:

- тусламж хүргэх
- аюулгүй байдлыг хангах

7.Хувийн хэвшил

Үүнд хувийн салбарууд болох сайн дурын байгууллагууд, хувь хүмүүсийн хандив ордог. Тусламж үзүүлэх арга:

- гамшгийн хариу арга хэмжээ, мөнгөн болон эд материалын тусламж
- гэрээт байгууллага болон засгийн газрын хүмүүнлэгийн тусламжид үйлчилгээ үзүүлэх

Хүснэгт 1. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах нь

Төрөл	Үүрэг	Засгийн газар	ОУ-ын байгууллагууд
Зохицуулалт	Хариу арга хэмжээний үүрэг хариуцлага	Засгийн газар гамшигт өртсөн хүн амд үйлчлэх	НҮБ ба ХАЗГ нь Засгийн газрын олон улсын тусламжийн зохицуулалт хийх ажилд дэмжлэг үзүүлэх
	Хариуцлагатай байдал	Хүн ам болон байгуулагуудад	ОУ-ын хамтын нийгэмлэг, гамшигт өртсөн улсын Засгийн газар, хандивлагч нар, гамшигт өртсөн иргэд
	Удирдлага	Стратегийн ба үйл ажиллагааны	Олон улсын оролцогч талуудын зохицуулалт
	Зохион байгуулалт	Салбарууд	Кластерууд
Санхүүгийн нөөц болон техникийн баг бүрэлдэхүүний нөөцөө дайчлах	Санхүүжилт	Улсын төсөв Улсын нөөц хөрөнгө 2 талт хамтын ажиллагааны дэмжлэг, зээл, Иргэний нийгмийн байгууллагын хандив, зээл	Онцгой байдлын төсөв Гамшгийн яаралтай тусламжийн сан 2 талт хандив Олон улсын хүмүүний нийгэмлэгийн тусламж
Мэдээллийн менежмент	Харилцаа холбоо	Мэдээ мэдээлэл	SITREPS, ХАЗГ болон бусад хамтрагчид

Засгийн газар болон Олон улсын байгууллагууд нь үүрэг, хариуцлагын хувьд хамтарсан, харилцан биенээ дэмжсэн байна. Ингэснээр хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг илүү оновчтой, үр дүнтэй зохион байгуулах ач холбогдолтой.

Дүгнэлт

Байгалийн гамшгаас гадна сүүлийн жилүүдэд зэвсэгт мөргөлдөөн, дотоодын үймээн самуун их гарах болсон нь complex emergency буюу илүү төвөгтэй онцгой байдал бий болж байгаа хүмүүнлэгийн тусламжийн хэрэгцээ, шаардлагыг улам бүр нэмж, илүү ухаалаг зохицуулалтыг шаардаж байна.

Хүмүүнлэгийн тусламжийг дотоодын ба олон улсын хэмээн хоёр ангилах ба аль ч тусламжийн үйл ажиллагаанд:

1) хүсэлт гаргах,
2) хүлээн авч, бүртгэх,
3) байршуулах,
4) хадгалах,
5) тээвэрлэх,

6) хуваарилах зэрэг үе шат зайлшгүй байна.

Дээрх хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа нь олон тооны оролцогч талуудтай учраас энэ харилцааг зохицуулахын тулд төрөөс уг харилцаанд оролцогчдын дагаж баримтлах зан үйл, хэм хэмжээг нарийвчлан журамлаж тодорхойлсон байх шаардлагатай гэж үзэж байна.

Судалгааны ажлын хүрээнд авч үзсэн улс орнуудын ихэнх ямар нэг байдлаар гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж байгаа боловч хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалттай холбоотой заалтууд нь харилцан адилгүй байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааны зохицуулалт нь зөвхөн хэрэгцээ шаардлага тулгарсан үед л арга хэмжээ авах байдлаар явж байна.

Хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт сул байгаа үед нэн шаардлагатай тусламжийг хэрэгцээтэй газар нь түргэн шуурхай хүргэхэд нөлөөлж, энэ нь эргээд хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах эрсдэлтэй.

Ашигласан материал

1. https://mn.wikipedia.org)
2. “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2017 он.
3. “Монголын Улаан Загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай” хууль 2016 он
4. http://mercycorps.org.mn
5. http://nema.gov.mn/?p=34131/
6. http://www.legalinfo.mn/
7. https://en.wikipedia.org/wiki/Humanitarian_aid/
8. https://www.adb.org/mn/news/adb-approves-2-million-herders-hit-mongolian-climate-disaster
9. Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response, 2011
10. Humanitarian Country team meeting minutes. 2018.02.22
11. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. 2017 он, Д.Сэржмядаг
12. Гамшгаас хамгаалах талаарх бодлогын баримт бичгүүд. 2016 он
13. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал. 2017 он
14. Гамшгийн нэр томьёоны тайлбар толь. 2012 он
15. Гамшиг Судлалын Хүрээлэн. Судалгааны ажлын эмхэтгэл. 2015-2021 он.
16. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Я.Цэвэл.
17. МУЗН. Үйл ажиллагааны тайлан. – 2016-2021 он

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОРОЛЦООГООР ҮНЭЛЭХ НЬ: ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР

TO EVALUATING FOR PARTICIPANTS ON TRAINING ACTIVITIES THE CASE OF UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS, MONGOLIA.

Ц.Баясгалан
ДХИС-ийн Удирдлагын Академийн Удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш, доктор, дэд профессор, ахлах дэслэгч
Bayasgalan.Ts
Ph.D, asisstant professor, A senior lecturer at team of management for the Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia.
Л.Булганханган
Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн ахлах багш, ахмад
Bulgankhangai.L
A senior lecturer of department for fire fighting at Emergency management School at University of Internal
Г.Чулуунбаатар
Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах тэнхимийн багш, хошууч
Chuluunbaatar.G
Lecturer of department for disaster protection at Emergency management School at University of Internal Affairs, Mongolia
Г.Золжавхлан
Ахлагчийн сургуулийн Онцгой байдлын албаны тэнхимийн багш, ахлах дэслэгч
Zoljavkhlan.G
Lecturer of department Emergency management at Non-Commissioned Officer's School at University of Internal Affairs, Mongolia
Н.Одмаа
Онцгой байдлын сургуулийн Эдийн засаг-нөөц ар талын тэнхимийн багш, дэслэгч
Odmaa.N
Lecturer of department for economic and resource rear at Emergency management School at University of Internal Affairs, Mongolia

Хураангуй: Бидний судалгааны ажил нь сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа сургалтын идэвхтэй аргуудыг хэрхэн дэмжих, түүнийг хэрэгжүүлэх тухай өгүүлнэ. Судалгааны ажлаараа, суралцагчдад мэргэжлийн суурь, мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлүүдийн талаар үндсэн ойлголт, төсөөллийг олгохдоо багш нар уламжлалт заах аргыг хэрэглэхээс илүүтэйгээр харилцан ярилцах, бодит жишээнээс суралцах, асуудал дэвшүүлэх, асуудлыг шийдвэрлэх, дүрд тоглох, оролцоог дэмжих зэрэг аргыг хэрэглэснээр сургалтын үйл ажиллагаа үр дүнтэй, бүтээлч байх боломжийг сургалтын арга зүйд хэрэглэх нь илүүтэй байгаа эсэхийг судлахыг хичээсэн. Бидний судалгаанд ДХИС-ийн 438 сонсогч хамрагдсан. Судалгааны боловсруулалтыг SPSS-25.0, SMART PLS-3.3.4 программ хангамж ашигласан.

Түлхүүр үг: сургалт, сургалтын үйл ажиллагаа, идэвхтэй сургалт, оролцоо

Abstract: Our article focuses on how to support and implement activity learning methods in using for training. We tried to find out the opportunity to be creative is better used in teaching methods such as lecturers are more effective in using basic methods, dialogue, learning from real-life examples, problem-solving, problem-solving, and participation, to provide students with a basic understanding of basic, professional, and specialized subjects. There were 438 students participated in our survey and developed using SPSS-25.0 and SMART PLS-3.3.4 software.

Keywords: training, training activities, active training and participation

Судалгааны ажлын үндэслэл Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 2 дугаар зүйлд “Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино” гэж заасан байдаг[1].

ДХИС-ийн суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны багц болох албан хэрэгцээний гарын авлагад оролцогч талуудын хэрэгцээ хүлээлтийг тодорхойлж, үнэлэмж тогтоон төгсөгчдийг ажил олгогчоор үнэлүүлэх, төгсөгчөөс авсан сэтгэл ханамжийн багц, цуврал судалгаанууд байдаг хэдий ч сургалтын үйл ажиллагааны талаар бүрэлдэхүүн сургуулийн оролцоотой авсан судалгаанууд манай судалгааны ажилтай хувьсагчийн хувьд, нөлөөлөх хүчин зүйлийн хувьд өөр байна.

Дээд боловсролын салбарт нийгмийн болон улс төрийн дэмжлэг, оролцогч талуудын хүлээлт, дээд боловсролын хэрэгцээний нийлүүлэлтэд суурилсан хяналт, сургалтын хөтөлбөрүүд боловсруулахад тавигдах шаардлагууд, сургахуй, сурахуй үйл явцын гүйцэтгэлийн үнэлгээг багтааж өгөх хэрэгцээ одоо хэрэгжүүлж буй чанарын баталгаажуулалт, чанартай баримт бичиг, үнэлгээний шинэ хэлбэрүүдийн үр дүнд бий болдог.

Сэдвийн судлагдсан байдал: Олон улсын эрдэмтэд сургалтын байгууллага, их дээд сургуулийн оюутнуудыг идэвхтэй суралцах боломжоор хангахын тулд олон хүчин зүйлсийн нөлөөллийг сонгон авч судлахдаа идэвхжүүлэлтийн аргыг судалсан эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, судалгааны ажлууд их байдаг. Үүнд:

Сицилиа Христерсон, Патрика Стафи (2019), Идэвхтэй суралцах аргыг хэрэглэх нь оюутныг идэвхжүүлж, сурах сонирхол, сурах ач холбогдлыг өөрт нь бий болгох үйл явцаас бүрддэг (Christerson, 2019).

Мехмет Бхзат Туран, Кенан Коц (2018) нар Уильям Х Бертон (1958) үр дүнтэй заах дараах алхам болох “багш нь өөрөө суралцагч байх ёстой”, “үр дүнтэй, идэвхтэй суралцахын тулд суралцагч өөрөө зохих нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой” зэрэг үзэл санааг дэмжин, заах үйл ажиллагаа нь таныг ямар нэг зүйлд суралцахад хүргэдэг хэмээн багш нарт зөвлөмж өгсөн байдаг (Turan, 2018).

Сүүлийн 80 гаруй жилд суралцахуй, ой тогтоолтын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудыг хамтран шинжилсэн Вашингтоны их сургуулийн сэтгэл судлаач Хенри Ридигер, Марк Мак Даниел нарын дүгнэлт юм. Харин флаш карт хөтлөх, бүдүүвч зохиох, өөрөөсөө асуулт асуух гэх мэт идэвхтэй сургалтын аргууд нь илүү үр дүнтэй байдгийг судлаачид хэлж байна (Brown, 2014).

Бидний хувьд, сургалтын байгууллага бол бизнесийн байгууллагын нэг хэлбэр бөгөөд, суралцагч оюутнуудыг идэвхжүүлснээр тэдний суралцах болон сургалтын үр дүнд ахиц гаргах боломжтой гэж үзэн “Сургалтын үйл ажиллагааг оролцоогоор үнэлэх нь: Дотоод хэргийн их сургуулийн жишээн дээр” гэж сонгон сэдвээ томьёолсон. Энэхүү сэдвийг сонгосноор, бусад судлаачдын ажлаас

[1] Дээд боловсорлын тухай хууль, УБ.,2002.

ялгагдах байдлыг чанарын судалгаагаар шинжилгээ хийхийн тулд онолд үндэслэн загвар гаргасан, тухайн загварын таамаглалыг батлах оролдлого хийсэн, санал болгож буй загварт SMART PLS-3.0 програмаар боловсруулалт хийж эх олонлогийн өгөгдөлд хүчин зүйлийн шинжилгээ, хувьсагчийн хамаарлын шинжилгээ, замын шинжилгээг нэг зэрэг хийн таамаглалыг олон талаас нь шинжилж үр дүнг нэгтгэн гаргасан.

Идэвхжүүлэлт, идэвхтэй сургалтын онол арга зүй

Монгол Улсын төрөөс “Боловсролын талаар баримтлах бодлого” хэмээх баримт бичигт боловсролын нийгмийн үнэлэмжийг тодорхойлохдоо Боловсрол бол Монгол Улсын тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдлын баталгаа, хөгжил дэвшлийн эх сурвалж мөн. Иймд боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ гэсэн байдаг.

Дээд боловсролын агуулга гэж: Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээ. Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалтыг хөтөлбөрт үндэслэн мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.[2]

Бүдүүвч 01. Сургалтын үйл ажиллагааны үечлэл[3]



Эх үүсвэр: Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоос

“*Сургалт гэж юу вэ*? Сургалт хэмээх ухагдахууны утга нийгмийн өөрчлөлтийг даган их өөрчлөгдөж байна. 1980-аад оны сурах бичигт сургалт бол багшаас сурагчдад шинжлэх ухааны үндэстэй мэдлэг олгох, тэднийг коммунист хүмүүжилтэй болгох явдал хэмээн бичиж байсан.

Орчин үеийн сургалтын үндсэн зорилго бол зах зээлийн өрсөлдөөнт нийгэмд ажиллаж амьдрах чадвар бүхий бие хүн төлөвшүүлэх явдал юм. Сургалт нь суралцагчдад мэдлэг, чадвар, дадал олгох, зөв хандлага төлөвшүүлэх зорилго бүхий сурган хүмүүжүүлэх үйлүүдийн нэгдэл. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь зохион байгуулах, судлах, харилцаа, танин мэдэхүй, төлөвлөх гэсэн зүй тогтолтой. Сургалтын зорилго нь суралцагчдыг бие даан суралцах, ажиллах амьдрах арга барил, чадвар эзэмшүүлэх, мэдлэг, чадвар олгох, суралцагч өөрийгөө бүх талаар хөгжүүлэх,

[2] Дээд боловсорлын тухай хууль 3.1, 2002 он

[3] Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого

хурдацтай өөрчлөгдөж буй орчиндоо дасан зохицох, шинийг хүлээн авах, хийж бүтээх, өрсөлдөх чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Идэвхжүүлэлт гэдэг ойлголтыг бүх талаар нээн тодорхойлоход түүний гурван талыг зайлшгүй авч үзэх шаардлагатай юм.

- Хүний үйл ажиллагаанд идэвхжүүлэлтийн нөлөөллөөс шалтгаалж байдаг тэр зүйл нь юу болох;
- Зан үйлийг тодорхойлогч дотоод, гадаад хүчин зүйлийн харьцаа ямар болох;
- Идэвхжүүлэлт нь хүний үйл ажиллагааны үр дүнтэй яаж холбогддог зэрэг болно.

Идэвхжүүлэлтийн талаар олон судалгаа байдаг. Судлаачдын судалгааг дараах байдлаар тоймлон авч судалгааныхаа ажилд оруулаа.

Менежментийн шинжлэх ухаан, хүний нөөцийн менежмент болон сэтгэлзүйн чиглэлийн эрдэмтэн судлаачид идэвхжүүлэлтийн асуудалд онцгой ач холбогдол өгөн судалгаа явуулж ирсэн байна.

Английн эрдэмтэн С. Л.Карлан “Бизнес стратегид нөлөөлөх шагналын систем” 2007 он, Ф.Х.Лайонс болон Д.Бен-Ора нарын хамтын бүтээл “Шагналын стратеги” 2002 он зэрэг бүтээлүүдэд компани өсөн дэвжихэд нөлөөлөх үндсэн хөшүүрэг нь шагнал, урамшууллын системийг сайн хэрэгжүүлэх үйл явцаар илэрнэ. Байгууллагын хөгжил ажилтан бүрийн ур чадвар, идэвх чармайлт, ажлын гүйцэтгэлээс ихээхэн шалтгаална иймээс илүү чадамжийг илүү шагнах хэрэгтэй гэж үзсэн байна. Идэвхжүүлэлтийн онолын талаар АНУ-ын эрдэмтэн, сэтгэл судлаач Абрахам Маслоу Хэрэгцээний шатлалын онол, АНУ-ын эрдэмтэн, сэтгэл судлаач Дэвид Кларенс Макклелландын Дээд шатны хэрэгцээнд тулгуурлсан мотивацийн онол, Канадын эрдэмтэн, сэтгэл судлаач Виктор Врум Хүлээлтийн онол, Лайман Портер, Эдвард Лоулер нарын эрдэмтэд мотивацийн процессын иж бүрдэл шинжтэй загварыг боловсруулсан, АНУ-ын эрдэмтэн, сэтгэл судлаач Герцберг Ирвин Фредерик өөрийн багийнхантай хамтран Хоёр хүчин зүйлийн онол гэсэн загварыг, Клейтон Альдерферийн хэрэгцээний бас нэгэн онол (эмпирик судалгаануудаар батлагдсан хүний хэрэгцээний ангиллын загвар) боловсруулсан. Фредерик У.Тейлор Ажилчдын хүч чармайлтыг төдий л их шахалгүйгээр хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж болно гэж тэр өөрийн судалгаагаар нотолсон.

Хүснэгт 01. Идэвхжүүлэлтийн онолын харьцуулалт

Хэмжүүр	Маслоугийн онол	Макклеландын онол	Герцбергийн онол
Хоёрдогч буюу дээд түвшний хэрэгцээ	Өөрийгөө илэрхийлэх	Эрхийн	Урамшууллын хүчин зүйл
	Хүндэтгэх	Амжилтын	Урамшууллын хүчин зүйл
	Нийгмийн	Байгууллагатай холбогдох	Урамшууллын хүчин зүйл
Анхдагч буюу доод түвшний хэрэгцээ	Аюулгүй байдлын хүчин зүйл		Ахуйн хүчин зүйл
	Биеийн хүчний хүчин зүйл		Ахуйн хүчин зүйл

Эх үүсвэр: П.Наранцэцэг ”Хүний нөөцийн менежмент” сурах бичиг, 2013 он.


Бодит байдалд суралцах аргыг хэдийгээр хууль, бизнес, анагаахын боловсролд анх хэрэглэж байсан. Бодит нөхцөл байдлыг хэлэлцэн ярилцсанаар оюутнууд бодит орчны үйл ажиллагаанд шууд бус байдлаар дадлага хийж, асуудал, бэрхшээлийг шийдэхэд оролцоно. Бодит байдалд суралцах аргын зорилго нь бодит орчинд практик дадлага хийлгэж оюутнуудын бие даан шийдвэр гаргах болон сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд оршино. Багш болгон сургалтын үр дүнтэй болгох зорилгоор мэдлэг туршлагатай байхыг хүсдэг билээ. Учир нь ажил мэргэжилдээ амжилттай байхын эхлэл юм. Хичээл заах арга барилын талаар ерөнхий ойлголт байдаг ч хичээлийг илүү идэвхтэй, сонирхолтой болгохын тулд зарим нэг онцгой арга бас бий.

Хүснэгт 02. Идэвхтэй болон туршилттай сургалтын аргуудын ялгаа

Идэвхтэй сургалтын арга	Туршилттай сургалт
• Оюутнууд сэтгэн бодох • Асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох • Багаар ажиллах • Дүрд орлон тоглох • Өөрийн үүрэгт ажлын гүйцэтгэлийг илтгэх • Тодорхой хугацаагаар даалгаврыг ахин гүйцэтгэн ахиц дэвшил гаргах • Хайгуул хийх, шинэ санаа гаргах	• Мэргэжлийн зарим практик ажлыг дуурайлган гүйцэтгүүлэх • Тодорхой хугацаанд даалгавар гүйцэтгэн уралдах • Тусгай багаж хэрэгсэлтэй ажиллах • Үзүүлэн макет ашиглах, биеэр хүрч мэдрэх • Багийн үйл ажиллагаагаар нэгдсэн даалгавар гүйцэтгүүлэх
СУДАЛГААНД АШИГЛАСАН АРГА	
• Оюутнууд сэтгэн бодох • Асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох • Багаар ажиллах • Дүрд тоглох • Өөрийн үүрэгт ажлын гүйцэтгэлийг илтгэх • Тодорхой хугацаагаар даалгаврыг ахин гүйцэтгэн ахиц дэвшил гаргах • Хайгуул хийх, шинэ санаа гаргах • Мэргэжлийн зарим практик ажлыг дуурайлган гүйцэтгүүлэх • Тодорхой хугацаанд даалгавар гүйцэтгэн уралдах • Үзүүлэн макет ашиглах, биеэр хүрч мэдрэх.....	

Эх үүсвэр: П.Аюурзана, бусад, /2017, ШУТИС, МТС/ CDIO гарын авлага, 2017 он.

Загвар 01. Сургалтын оролцоонд нөлөөлөх хүчин зүйл



Таамаглал-1: *Сургалтын үйл ажиллагаа идэвх оролцооны үнэлгээнд эерэгээр нөлөөлнө.*

Таамаглал-2: *Ур чадвар идэвх оролцооны үнэлгээнд эерэгээр нөлөөлнө.*

Таамаглал-3: *Багшийн хандлага, харилцаа идэвх оролцооны үнэлгээнд эерэгээр нөлөөлнө.*

Хамаарах хувьсагч: *Сургалтын үйл ажиллагаа, Ур чадвар, Багшийн хандлага, харилцаа*

Үл хамаарах хувьсагч: *Идэвх оролцооны үнэлгээ*

Судалгааны үр дүн, боловсруулалт


ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн анхны суурь НАХЯ-ны сайдын 1990 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/49 дүгээр тушаалаар НАХЯ-ны Цагдаагийн дээд сургуулийн бүтцэд нэг жилийн сургалттай мэргэжлийн гал сөнөөгч бэлтгэх дамжааны сургалтыг явуулж эхэлснээр тавигдаж, Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2012 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 19/А/39 дүгээр тушаалаар Их сургуулийн бүтцэд Онцгой байдлын сургуулийг байгуулснаар үйл ажиллагаа нь өргөжин ажиллаж байна.

Онцгой байдлын сургуулийн сургалтын үйл ажиллагаа Дээд боловсролын тухай хууль, Боловсролын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичигт үндэслэн өдөр, эчнээ ангийн сургалтыг явуулж байна. Монгол Улсын гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах замаар улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, үндэсний эх оронч, албаны ёс зүй, цэргийн хэрэг, бие бялдар, сэтгэл зүйн өндөр төлөвшилтэй, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх, онцгой байдлын байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангасан, тактикийн түвшний албан хаагчийг бэлтгэдэг.

Чанарын судалгааны арга зүй

Сургалтын үйл ажиллагааг оролцоогоор үнэлэх судалгааг гарааны судалгааны адил дөрвөн үйл ажиллагааг хамааруулан чанарын судалгаагаар судалсан.

Загвар 02. Сургалтын идэвхтэй, оролцоог үнэлэх үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээний үр дүн



Тайлбар: tra-сургалтын үйл ажиллагаа, skills-ур чадвар, attit-багшийн харилцаа, хандлага, enga- идэвх оролцооны үнэлгээ

Судалгааны үр дүнг танилцуулбал, Сургалтын үйл ажиллагааг 6 асуултаар судалсан. Асуултын утга 0.515-0.823 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал 0.824, дундаж утга 0.443үр дүнтэй байна. Ур чадварыг 6 асуултаар судалсан. Асуултын утга 0.532-0.793 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал 0.847, дундаж утга 0.483 үр дүнтэй байна. Багшийн харилцаа, хандлагыг 6 асуултаар судалсан. Асуултын утга 0.5383-0.836 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал 0.890, дундаж утга 0.576 үр дүнтэй байна. Идэвх оролцооны үнэлгээг 10 асуултаар судалсан. Асуултын утга 0.564-0.808 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал 0.907, дундаж утга 0.497 үр дүнтэй байна.

Хүснэгт 03. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн

Үйл ажиллагаа	Асуултууд	Асуултын үр дүн	Найдвартай байдал	Дундаж утга
Сургалтын үйл ажиллагаа	Мэргэжлийн мэдлэг эзэмшсэн байдал	0.542	0.881	0.562
	Мэргэжлийн мэдлэгт загвар ашиглаж сурсан байдал	0.552		
	Шинжлэх ухааны шинэ арга зүй эзэмшсэн байдал	0.798		
	Дадлагаар шаардлагатай зүйлээ бататган сурсан.	0.773		
	Онол дадлага хосолсон сургалт явагддаг.	0.858		
	Ажлын байранд дадлагажих сургалт явагдсан эсэх.	0.897		
Ур чадвар	Ерөнхий гадаад хэлний мэдлэгээ сайжруулсан.	0.713	0.847	0.483
	Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгээ сайжруулсан.	0.675		
	Олон улсын судалгааны ажлаас судлах хичээл орж гадаад хэлний мэдлэгт нөлөөлдөг.	0.532		
	Илтгэх ур чадвараа сайжруулж хөгжүүлж чадсан эсэх.	0.771		
	Харилцааны ур чадвар эзэмшсэн байдал	0.793		
	Шийдвэр гаргах ур чадварт суралцаж буй байдал.	0.655		
Багшийн харилцаа, хандлага	Багшийн хандлага нь үр дүнд суурилсан сургалтанд чиглэдэг.	0.811	0.890	0.576
	Багшийн зөвлөгөө мэргэжлийн өндөр түвшинд байдаг.	0.811		
	Багш мэргэжлийн хувьд нийгэм, салбартаа нэр хүнд бүхий судлаач мөн.	0.727		
	Багш хичээлд шинэ арга зүй ашиглан сургалтыг бүтээлч үйл ажиллагаа болгодог.	0.583		
	Багш мэргэжлийн гадаад хэлний ур чадвартай, судалгаанд гадаад эх үүсвэр ашигладаг.	0.836		

	Багш мэргэжлийн чадвар, хандлага, заах аргаараа манлайлагч байдаг.	0.758		
Идэвх оролцооны үнэлгээ	Сургалтын явц, хандлага, үр дүн шударга байдаг.	0.699	0.907	0.497
	Суралцагчдын оролцоог шударга үнэлдэг байдал	0.650		
	Суралцагчдыг идэвхжүүлдэг байдал	0.654		
	Оролцоогоор урамшуулан үнэлгээ өгдөг байдал	0.771		
	Судалгааны ажил, диплом бичихэд багш нар нэмэлт тайлбар зөвлөгөө өгдөг эсэх	0.808		
	Суралцагчдыг ойлгох байдал	0.779		
	Сургалтын үйл ажиллагаанд оролцоо, санал, хүсэлтийг харгалзах байдал	0.742		
	Багш нараас гадна зочин профессор хичээл заадаг эсэх	0.564		
	Сургалтын алба суралцагчдыг хүндэлж харьцдаг эсэх	0.695		
	Хичээлийн бус цагаар багш нар зөвлөгч байдаг эсэх.	0.653		

Тайлбар: Судалгааны үр дүн

Хүснэгт 04. Хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

№	Үйл ажиллагаа	Сургалтын үйл ажиллагаа	Ур чадвар	Багшийн харилцаа, хандлага	Идэвх оролцооны үнэлгээ
1	Сургалтын үйл ажиллагаа	**1.000**			
2	Ур чадвар	0.699	**1.000**		
3	Багшийн харилцаа, хандлага	0.450	0.785	**1.000**	
4	Идэвх оролцооны үнэлгээ	0.580	0.590	0.758	**1.000**

Тайлбар: Судалгааны үр дүн

Сургалтын үйл ажиллагаа хувьсагчид хоорондоо хамгийн их хамаарал ба 1.000, сургалтын үйл ажиллагаа ба ур чадвар 0.699, сургалтын үйл ажиллагаа ба багшийн харилцаа хандлага 0.450, сургалтын үйл ажиллагаа ба идэвх оролцооны үнэлгээ 0.580 тус тус хамааралтай байна. Харин ур чадвар нь хоорондоо 1.000, ур чадвар ба багшийн харилцаа хандлага 0.785, ур чадвар ба идэвх оролцооны үнэлгээ 0.590 тус тус хамааралтай байна. Багшийн харилцаа, хандлага нь хоорондоо 1.000, багшийн харилцаа хандлага ба идэвх оролцооны үнэлгээ 0.758 тус тус хамааралтай байна. Идэвх оролцооны үнэлгээ хоорондоо 1.000 хамааралтай байна.

Энэхүү асуултын хамаарлын шинжилгээнээс, хамгийн их хамааралтай хувьсагчид болох идэвх оролцоо үнэлгээ, багшийн харилцаа

хандлага байгааг хамаарлын шинжилгээгээр тогтоолоо.

Хүснэгт 05. Замын шинжилгээний үр дүн

ТААМАГЛАЛУУД	Дундаж утга	Стандарт хэлбэлзэл	Т статистик утга	Р үнэ цэнэ	ҮР ДҮН
Таамаглал 1. Сургалтын үйл ажиллагаа нь оролцоонд эерэг нөлөөлнө.	0.562	0.106	5.406	**0.000**	**Дэмжигдсэн.**
Таамаглал 2. Ур чадвар оролцоонд эерэг нөлөөлнө.	0.060	0.118	0.279	**0.780**	**Дэмжигдсэнгүй.**
Таамаглал 3. Багшийн харилцаа, хандлага нь оролцоонд эерэг нөлөөлнө.	0.165	0.125	1.988	**0.002**	**Дэмжигдсэн.**

Тайлбар: Судалгааны багийн үр дүн

Замын шинжилгээний үр дүнгээс харахад, сургалтын үйл ажиллагаа нь оролцоонд Т статистик утга 5.406, П үнэ цэнэ 0.000 үр дүнтэйгээр таамаглал батлагдсан. Ур чадвар оролцоонд Т статистик утга 0.279, П үнэ цэнэ 0.780 үр дүнтэйгээр таамаглал батлагдсангүй. Багшийн харилцаа хандлага оролцоонд Т статистик утга 1.988, П үнэ цэнэ 0.002 үр дүнтэйгээр таамаглал батлагдсан. Замын шинжилгээний үр дүнгээс бидний таамагласан гурван таамаглалаас сургалтын үйл ажиллагаа, багшийн харилцаа хандлага хувьсагчид суралцагчдын оролцоонд эерэг нөлөөлж, багшийн ур чадвар суралцагчдын оролцоонд нөлөөлж чадсангүй гэсэн үр дүн гарсан.

Дүгнэлт

Бидний судалгаа 2021-2022 оны хичээлийн жилийн эхний улиралд танхимаар явагдаж буй сургалтын үйл явцыг үнэлүүлэн чанарын судалгааг цахимаар авч боловсруулалт хийсэн нь онцлог байлаа. Энэхүү судалгаанд ДХИС-ийн **438** сонсогч нь олон оролцогчдыг нэг дор хамруулж, төлөөлөх чадварыг бүрэн хангах боломж бүрэн хангагдсан гэж дүгнэж байна. Энэхүү судалгааг идэвхтэй сургалтын явцад суралцагчдад ямар хүчин зүйл хэрэгцээтэй байгааг тодруулах, ямар хүчин зүйл нь шаардлагатай байгааг илрүүлэхийн тулд хувьсагч бүрийг илэрхийлсэн асуултыг давхцалгүйгээр, тухайн хувьсагчаа үнэлүүлэх боломжийг ханган авч судалгааны загварт нарийвчлан тусгасан.

Сургалтын үйл ажиллагааны эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгааны эх сурвалжийг энэхүү ажилдаа хураангуйлан оруулсан. Мөн судалгааны арга зүйн талаарх тайлбар, хоорондын уялдааг нэр томъёо, тодорхойлолтыг илүү тусгаж өгсөн.

Сургалтын үйл ажиллагаанд суралцагчдыг идэвх оролцоог үнэлэх шинжилгээ сэдэвт энэхүү дипломыг ажлыг бичихийн тулд сургалтын үйл ажиллагаа, идэвхтэй сургалтын онол арга зүйг боловсрол судлалын чиглэлээр дэлгэрэнгүй судаллаа. Мөн нийгмийн шинжлэх ухаан, менежментийн үндсэн чиг үүргийн нэг болох идэвхжүүлэлтийг үндсэн суурь онол болгон судалсан ба агуулгын онол, процессын онолын хувьд эрдэмтдийн гаргасан онолын үзэл баримтлалыг харьцуулан судалсан. Сургалтын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх хэд хэдэн хувьсагчийг санал

болгон таамаглал болгон дэвшүүлж, загвараа боловсруулсан. Үүнд:

Сургалтын үйл ажиллагаа, ур чадвар, багшийн харилцаа, хандлага сургалтын идэвх оролцоонд эерэг нөлөө үзүүлэх гурван таамаглал тус тус дэвшүүлэн онолд суурилсан загварыг баталсан.

Судалгааны үр дүнгээс харахад, нийт гурван таамаглалаас хоёр таамаглал батлагдсан. Эндээс манай судалгааны ажлын хувьд таамагласан ажлын үр дүн сайн гэж дүгнэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Чанарын судалгааны хувьд, таамаглал батлагдахгүй байгаа тохиолдолд тухайн хувьсагчийн хасах, хувьсагч дотор байгаа асуултаас хасалт хийн үр дүнг гаргаж батлах тохиолдол их байдаг. Бид судалгааны ажлаа заавал батлахын тулд бус, ямар хувьсагч, асуултууд анхаарал татаж байгааг нээн илрүүлэхийг чухалд үзсэн.

Судалгааны хязгаарлагдмал байдал


Судалгааны ажлын хувьд, дараах хэд хэдэн үзүүлэлтийг судалгааны ажлын хязгаарлагдмал тал гэж үзэж байна. Үүнд:


- Судалгааны ажлын боловсруулалтад 2020-2021, 2021-2022 хичээлийн жилд суралцаж байгаа суралцагчдыг судалгаанд хамруулсан.
- Сургалтын үйл ажиллагааг бүрэн илэрхийлэх олон хүчийн зүйлсийг төлөөлөл болгон загварт таамаглал болгон оруулах боломж бий болгоогүй.


Судалгааны ажлын санал зөвлөмж

Судалгааны ажлын үр дүнгээс дараах зөвлөмж саналыг бий болгосон. Үүнд:

- Гамшгийн үеийн цагийн байдлыг тайлбарлахдаа, бүх суралцагчдад ойлгоомжтой байдлаар мэдлэг бататгах дасгал орох
- Багийн хуваарилалтын тэгш байдлаг ханган нэг багт оногдох суралцагчдын тоог багаар ажиллаж байгаа суралцагчдаас санал асуун шийдьэрлэж байх
- Гамшгийн цагийн байдал дээр ажиллах бэлтгэлийг хангахдаа, баг бүрт оногдсон даалгаварт шаардлагатай байгаа бичиг хэрэг, баримтжуулсан мэдээллээр бүрэн хангах
- Сургалтын үйл ажиллагааны орчинг бүрдүүлэхдээ, өрсөлдөгч баг гэхээс илүү багууд хоорондоо мэдлэг түгээж, туршлага солилцох боломж олгон анги танхимын хуваарилалтыг анхаарч ажиллах
- Хээрийн гаралтын үйл ажиллагаа болон полигон дээр хийсэн сургалтын үйл ажиллагааны орчин бүрдүүлэхдээ зааварчилгаа сайн өгөх
- Хичээлийн бус цагаар багш нар зөвлөгч байх нь суралцагчдад хэрэгцээ шаардлагатай байгааг анхаарч ажиллах, бие даан гүйцэтгэх ажлын цагийг үр бүтээлтэй байлгах зэрэгт анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.







Эх сурвалжийн жагсаалт

Эрх зүйн актууд

Боловсорлын тухай хууль, УБ.,2002.

Дээд боловсролын тухай хууль, УБ.,2002.

Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого

Монгол хэл дээр:

Амаржаргал, Б. (2013). *Менежмент.* Улаанбаатар хот, Мөнхийн үсэг.

Амартогтох, Г. (2016) “*Хүний нөөцийн онол практик*”, Улаанбаатар хот,

Галбадрах. Б, *Боловсролын байгуулагын хөгжил*. УБ. 2019 он

Жавзан Б., Б.Энхбаяр. *Боловсролын сэтгэл судлал*. УБ.2009 он

Ш.Ичинхорлоо. (2002). *Сурган хүмүүжүүлэх арга, онол ба хэрэглээ.* Улаанбаатар хот.

Пүрэвдорж. Ч, “*Менежментийн Удирдлага*”, Улаанбаатар хот, 2002 он 291-р хуудас

Оюун. Ц. *Их, дээд сургуулийн үйл ажиллагааны онол, арга зүй*. УБ.2015 он

Цэнд Н, Г.Батхүрэл Н, ..Ц. Цэцэгмаа нар “Менежмент” 2013 он, УБ

Судалгааны ажил:

Blanton, W. E. (1973). Ausubel's theory of meaningful verbal learning: Implications for reading research. *Reading Research and Instruction*, 202–211.

Brown, P. C. (2014). *Make It Stick: The Science of Successful Learning.* New York: 2016.

Christerson, C. (2019). Promoting active learning in universities. *LEARNING and TEACHING PAPER, European universities association,*, 58-63.

Creswell. J. (2003). *Research Design: qualitative, quantitative and mixed methods approach.* Oaks, : SAGE Publications Ltd.

Gibbs, G. (2020). Training to Teach in Higher Education: A Research Agenda. *Teacher Development* , 31-44.

Henseler.J, . (2014). A new criterion for assessing discriminant validity in variance-based structural equation modeling. *Journal of the Academy of Marketing Science*, 115–135.

Netemeyer, R. G., Bearden, W. O., & Sharma, S. (2003). Scaling Procedures: Issues and Applications. . *Scientific Research*, 233-235.

Turan, M. B. (2018). Review of quality teaching in higher education. *International Management in Higher education*, 23-29.

Mehmet Behzat Turan, Kenan Koz (2019), The Analysis of the Relationship Between Teaching/Learning

Conceptions and Reflective Thinking in Physical Education Teacher Candidates. *International Education Studies;* Vol. 12, No. 3; 2019, ISSN 1913-9020 E-ISSN 1913-9039, Published by Canadian Center of Science and Education

Боловсролын магадлан итгэмжлэл (2014), Европын дээд боловсролын чанарын баталгаажуулалын стандартууд ба зөвлөмжүүд

Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, (2016), “Хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах” зөвлөх үйлчилгээ, “Сургалтын үйл ажиллагаа ба хөдөлмөрийн зах зээлийн судалгаа

РОЛЬ РЕЧЕВЫХ МОДЕЛЕЙ В ПРОФЕССИОНАЛЬНО ОРИЕНТИРОВАННОМ ОБУЧЕНИИ РУССКОМУ ЯЗЫКУ КАК ИНОСТРАННОМУ

THE ROLE OF SPEECH MODELS IN PROFESSIONALLY ORIENTED TEACHING OF RUSSIAN AS A FOREIGN LANGUAGE

Букина Татьяна Григорьевна
Заведующий кафедрой иностранных языков Уральского юридического института МВД России, кандидат филологических наук, доцент
Bukina Tatyana Grigoryevna
Head of the Department of Foreign Languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation, Candidate of Philological Sciences, Associate Professor

Аннотация: В статье рассматривается опыт изучения иностранными обучающимися темы «Служебные документы» в курсе дисциплины «Русский язык как иностранный». Отмечается, что в процессе обучения русскому языку необходимо уделять достаточно внимания темам, связанным с будущей профессиональной деятельностью. Изучение типологии, композиции и содержательных особенностей документов является очень важным шагом на пути к формированию профессиональных компетенций. В этом процессе большое значение имеет навык работы с клишированными конструкциями (моделями), которые могут использоваться при построении текстов служебной документации.

Abstract: The article regards the experience of foreign learners studying the topic "Official documents" in the course of the discipline "Russian as a foreign language". It is noted that in the process of teaching the Russian language, it is necessary to pay sufficient attention to themes related to future professional activities. The study of typology, composition and content peculiarities of documents is a very significant step towards the formation of professional competencies. In this process, the skill of working with clichйd patterns (models) that can be used in the construction of texts of service documentation is of great importance.

Ключевые слова: речевая модель, служебная документация, профессиональные компетенции, универсальные компетенции, ФГОС3++.

Keywords: speech model, service documentation, professional competencies, universal competencies, GEF3++.

В современном мире профессионально ориентированное обучение русскому языку приобретает особую актуальность, поскольку предусматривает формирование у иностранных учащихся коммуникативных умений, позволяющих им осуществлять профессиональную деятельность на русском языке в различных сферах и ситуациях общения[1]. Уже на первом курсе Уральского юридического института МВД России в программе по изучению русского языка иностранные курсанты знакомятся с понятием «документ», а также с видами документов по целевому назначению и функциям. Дело в том, что на первом

[1] Пугачев И.А. Профессионально ориентированное обучение русскому языку как иностранному: теория, практика, технологии : монография / И. А. Пугачев. – Москва : РУДН, 2016. – с. 38.

курсе наряду с изучением общих тем в рамках дисциплины «Русский язык как иностранный» курсанты изучают узкоспециальные темы на дисциплине «Русский язык в деловой документации», которая включена в основную профессиональную образовательную программу высшего образования федерального государственного образовательного стандарта (ФГОС) 3++. В соответствии с данной программой по окончании изучения дисциплины обучающиеся должны овладеть такой профессиональной компетенцией, как «способен разрабатывать процессуальные и служебные документы в сфере своей профессиональной деятельности»[2]. Индикаторы данной компетенции следующие:

– знать порядок составления и оформления процессуальных документов;

– уметь разрабатывать правоприменительные акты, составлять и оформлять процессуальные и служебные документы;

– владеть опытом разработки процессуальных и служебных документов в сфере своей профессионально-служебной деятельности.

Таким образом, изучая русский язык как средство общения и получения специальности, иностранные обучающиеся получают знания в области русского языка для специальных целей.

Спецификой профессионально ориентированного обучения русскому языку вслед за А.В. Кореневой мы считаем направленность педагогического процесса на будущую профессию, которая в итоге станет сферой приложения всех получаемых знаний, умений, навыков, проверкой их действенности[3]. Следует отметить, что русский язык для иностранных обучающихся является инструментом получения профессии, отсюда вытекает повышенная мотивация к изучению языка, при этом не просто русского языка как средства коммуникации, но именно русского профессионального языка, который позволит овладеть профессиональными знаниями.

Исходя из поставленных ФГОСом 3++ задач, обучающимся необходимо предложить такие задания, с помощью которых они могли бы овладеть профессиональной компетенцией и были бы готовы применять полученные знания, умения и владения в своей будущей профессиональной деятельности. Облегчить работу с профессионально ориентированными текстами способны задания с использованием речевых моделей. Вообще, в практике преподавания русского языка как иностранного большую роль играет так называемый метод моделирования, то есть речевая

[2] Рабочая программа учебной дисциплины «Русский язык в деловой документации» по специальности 40.05.01 Правовое обеспечение национальной безопасности, специализация Уголовно-правовая – профиль образовательной программы Предварительное следствие в органах внутренних дел (для иностранных обучающихся), год начала подготовки 2021, форма обучения очная. – Екатеринбург, 2021. – 40 с.

[3] Коренева А. В. Профессионально ориентированное обучение речевой деятельности студентов-нефилологов на основе междисциплинарной интеграции: автореф. дис. … канд. пед. наук: 13.00.02 / А.В. Коренева. – Орел, 2009. – С. 3.

тренировка по моделям, или речевым образцам. «Речевые модели – это клишированные и структурно-логические элементы высказывания (начало предложения), позволяющие выразить мысль определенного типа (например, оформить начало высказывания, определение понятия, привести примеры, аргументировать выводы и т.п.)»[4].

Следует отметить, что специфика официально-делового стиля заключается в стандартизированном характере изложения[5]. Другими словами, при создании текстов используются устойчивые формы расположения материала, или речевые модели, в определенной логической последовательности. Именно поэтому очень важно научить курсантов клишированным фразам, которые они использовали бы при составлении личных документов, а также важно, чтобы по стандартизированным фразам они узнавали тот или иной документ. Поэтому в практике обучения деловому русскому языку мы используем два вида заданий. Первый вид заданий – когда по клишированным фразам обучающийся должен узнать документ. Второй вид заданий – перестроить разговорную конструкцию с использованием стандартных формул для включения ее в тот или иной документ.

В качестве примера приведем задание первого вида:

Назовите, к каким видам служебных документов относятся следующие клише:

1. По существу заданных мне вопросов … 2. Я, Иванов Иван Иванович, паспорт серия 6403 номер 534 535, выдан 23.11.2001, ОВД Кировского района г. Екатеринбурга, доверяю получение со склада … 3. Прошу Вашего разрешения … 4. Довожу до Вашего сведения … 5. Свою вину признаю … 6. Я, Иванов Иван Иванович, родился 3 сентября 2000 года в г. Екатеринбурге…

Данные стандартизированные конструкции используются в личных документах, т.е. в документах, которые сотрудник полиции должен уметь сам составлять. Поэтому курсанты запоминают эти модели, чтобы использовать их в своей практической деятельности. Так, модели 1, 5 – это объяснение; модель 2 – доверенность; модель 3 – рапорт, заявление; модель 4 – служебная записка, рапорт; модель 6 – автобиография. Когда эти и другие модели будут усвоены, обучающимся предлагается задание второго вида: необходимо восстановить деловую речевую модель из разговорной конструкции.

Измените предложения, используя клише деловой речи:

[4] Лаврова О.В. Функционал и роль речевых моделей англоязычного учебно-официального юридического/полицейского дискурса в речи будущих сотрудников правоохранительных органов // Интернаука: электрон. научн. журн. 2021. № 40(216). URL: https://internauka.org/journal/science/internauka/216 (дата обращения: 07.03.2022).

[5] Букина Т.Г. Русский язык в деловой документации: учебно-методическое пособие / Т. Г. Букина, А. Х. Закирьянова, Ю. В. Казаринова. – Екатеринбург: Уральский юридический институт МВД России, 2018. – С. 13.

1. Простите меня 2. Накажите его 3. Дайте мне денег 4. Отпустите меня в отпуск 5. Если не хотите проблем

Такое задание дается уже в подготовленной аудитории, т.к. сначала надо проанализировать, в каком документе может быть реализован данный смысл, и уже после этого работать с речевыми моделями, соответствующими тому или иному документу.

Смысл первой фразы может быть реализован в объяснении и выглядеть следующим образом: *Приношу свои извинения.* Данный смысл может быть выражен и в косвенном речевом акте: *вину свою признаю, обязуюсь возместить ущерб…* или *вину свою признаю, обязуюсь больше не повторять подобное.* Смысл фразы 2 скорее всего может реализоваться в исковом заявлении. Речевая модель может быть следующая: *прошу взыскать в пользу истца компенсацию морального (материального) вреда.* Смысл 3 и 4 предложений передается, как правило, в рапорте или заявлении и может быть представлен такими речевыми моделями: *3. Прошу Вас оказать мне материальную помощь в связи с …4. Прошу Вас предоставить мне очередной оплачиваемый отпуск.* Смысл пятого предложения также может встретиться в исковом заявлении. Для его реализации существует формула *во избежание проблем.*

Правильному использованию тех или иных речевых моделей способствует знание производных отыменных предлогов, которые часто являются основой клишированных фраз, используемых в документе: *в целях* (+род. п.), *в соответствии с* (+тв. п.), *на основании* (+род. п.), *во исполнение* (+род.п.), *в связи с* (+тв.п.) и т.д. Данные предлоги являются своеобразным маркером официально-делового стиля и используются в личных и информационно-справочных документах.

Роль речевых моделей в профессионально ориентированном обучении русскому языку как иностранному трудно переоценить. В первую очередь, знание устойчивых образцов для составления документа позволяет повысить мотивацию к изучению материала по специальности на русском языке. Во-вторых, у обучающихся формируется познавательный интерес к референтно-номинативным единицам профессионального характера. Кроме того, благодаря знанию устойчивых моделей повышается общая грамотность и культура составления документа: на грамматическом уровне – это умение правильно построить высказывание согласно правилам грамматики изучаемого языка, на логико-смысловом уровне – умение логично и понятно организовать репрезентируемую информацию. Наконец, грамотная репрезентация речевых моделей в профессиональной письменной речи сотрудника правоохранительных органов способствует формированию образцовой языковой личности будущего профессионала.

Литература

1. Букина Т.Г. Русский язык в деловой документации: учебно-методическое пособие / Т. Г. Букина, А. Х. Закирьянова, Ю. В. Казаринова. – Екатеринбург: Уральский юридический институт МВД России, 2018. – 132 с.

2. Коренева А. В. Профессионально ориентированное обучение речевой деятельности студентов-нефилологов на основе междисциплинарной интеграции: автореф. дис. … канд. пед. наук: 13.00.02 / А.В. Коренева. – Орел, 2009. – 40 с.

3. Лаврова О.В. Функционал и роль речевых моделей англоязычного учебно-официального юридического/полицейского дискурса в речи будущих сотрудников правоохранительных органов // Интернаука: электрон. научн. журн. 2021. № 40(216). URL: https://internauka.org/journal/science/internauka/216 (дата обращения: 07.03.2022).

4. Пугачев И.А. Профессионально ориентированное обучение русскому языку как иностранному: теория, практика, технологии : монография / И. А. Пугачев. – Москва : РУДН, 2016. – 487 с.

5. Рабочая программа учебной дисциплины «Русский язык в деловой документации» по специальности 40.05.01 Правовое обеспечение национальной безопасности, специализация Уголовно-правовая – профиль образовательной программы Предварительное следствие в органах внутренних дел (для иностранных обучающихся), год начала подготовки 2021, форма обучения очная. – Екатеринбург, 2021. – 40 с.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛС: ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

SALARIES OF CIVIL SERVANTS, CURRENT STATUS OF LEGAL REGULATION

Э.Чимидлхам
Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн багш, докторант, цагдаагийн ахмад
E.Chimidlkham
Doctoral candidate of Law School of Law and Social Sciences, University of Internal Affairs, Lecturer of the Public Law Department, police captain
Ч.Соёлоо
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Ch.Soyoloo
Graduate student of the University of Internal Affairs

Хураангуй: Төрийн албан хаагчдын эдийн засгийн баталгаанд хамаарах цалин, хөлсний талаар 1994, 2002, 2017 оны Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмаар хэрхэн зохицуулж ирсэн хийгээд цалин хөлсний бүтцэд хамаарах ойлголтууд хэрхэн өөрчлөгдөж ирснийг харьцуулан судалж, цаашид уг бүтцэд ямар шинэчлэл хийгдэх шаардлага байгааг тодорхойлохыг зорьсон.

Abstract: Aimed to determine a comparison of the 1994, 2002, and 2017 Civil Service Laws and related regulations on economic warranty wich is salary of civil servants and necessity to determine the need for further reforms in the structure.

Түлхүүр үг: Төрийн албан хаагч, эдийн засгийн баталгаа, хууль тогтоомж, цалин хөлс

Key words: Civil servant, economic guarantees, legislation, salary

Төрийн албаны тухай хуульд[1] “төрийн алба” гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ, “төрийн албан хаагч” гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг” хэлнэ гэж заасан байдаг.

Төрийн албан хаагч нь үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулахад нь тэднийг улс төр, эдийн засаг, нийгмийн баталгаагаар хангасан байх явдал чухал[2].

- Улс төрийн баталгаа: Улс төрийн үйл явц буюу сонгуулийн дараа өөр нам засгийн эрхэнд ороход төрийн байгууллагад ажиллаж байсан мэргэшсэн боловсон хүчнүүдийг тогтвортой ажиллуулах явдал юм.
- Эдийн засгийн баталгаа: Төрийн албан хаагчдад олгож буй цалин хөлс, нөхөн олговор зэрэг дэвийн нэмэгдэл зэргийг хамааруулна.
- Нийгмийн баталгаа: Төрийн албан хаагчдад үзүүлж буй тэтгэмж, туслалцаа, орон сууц, татварт төлөх шимтгэл, эрүүл мэндийн даатгалын тодорхой хувийг төр хариуцах гэх мэт баталгаанууд хамаарна.

[1] Төрийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2018 он, № 1

[2] Х.Наранбаатар “Төрийн алба” 2010 он, 78 дах тал

Төрийн албаны тухай хууль анх 1994 оны 12 сарын 30-ны өдөр батлагдаж 1995 оны 06 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд түүний дараа 2002 оны 06 сарын 28-ны өдөр шинэчлэн батлагдсан. 2002 оны Төрийн албаны тухай хуульд 44 удаагийн нэмэлт, өөрчлөлт орж 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцогдсон. Эдгээр төрийн албаны тухай хуулиудад төрийн албан хаагчийн эдийн засгийн баталгааг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1994	2002	2017
27.1.1.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах	27.1.1.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах	61.1.1.албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж авах
27.1.3.Гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах.	27.1.3.Гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах.	61.1.3.Гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах.
-	-	61.1.8.үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх;

Дээрхээс харахад Төрийн албаны тухай хуулиудын эдийн засгийн баталгаатай холбоотой заалтуудад томоохон өөрчлөлт ороогүй байна. 1992, 2002 оны Төрийн албаны тухай хуульд “урамшил” гэсэн нэр томъёо 2017 оны Төрийн албаны тухай хуульд “Урамшуулал” болон өөрчлөлт орсон байна. “Урамшил[3]” гэж хүний ажил хөдөлмөрийг урамшуулан хөхүүлэн шагнах, амжилт бүтээлийг нь үнэлэн олгох шагнал, хөхүүлэл, “Урамшуулал[4]” гэж урам оруулах зорилгоор өгөх шан хэмээн тайлбарласнаас үзвэл ажлын бүтээмжээс хамааран олгодог тул “урамшил” хэмээх тодорхойлолт нь илүү тохирох юм.

2017 оны хуульд үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх; заалт орж ирсэн нь албан хаагчийн эдийн засгийг баталгааг хангахад чухал зохицуулалт болсон байна.

[3] Монгол хэлний эх тайлбар толь- Монгол хэлний их тайлбар толь (mongoltoli.mn)

[4] Монгол хэлний эх тайлбар толь- Монгол хэлний их тайлбар толь (mongoltoli.mn)

Төрийн албан хаагчийн эдийн засгийн баталгаанд хамаарах цалин хөлс нь 2017 оны төрийн албаны тухай хуульд[5] дараахаас бүрдэхээр зохицуулсан байна. Үүнд:

Төрийн улс төрийн албa	Төрийн захиргааны албa	Төрийн тусгай албa	Төрийн үйлчилгээний албa
Албан тушаалын цалин	Албан тушаалын цалин	Албан тушаалын цалин	Албан тушаалын цалин
Албан ажлын онцгой нөхцөлийн	-	Албан ажлын онцгой нөхцөлийн	-
Докторын	Докторын	Докторын	Докторын
-	-	-	Мэргэшлийн зэрэг
-	Төрийн албa хаасан хугацааны	Төрийн албa хаасан хугацааны	Төрийн албa хаасан хугацааны
-	Цолны	Цолны	Цолны
-	Зэрэг дэвийн	Зэрэг дэвийн	-
-	-	-	Ур чадварын
-	-	Мэргэжлийн зэргийн	-
-	Нэмэгдэл хөлс	-	Нэмэгдэл хөлс
-	-	Хуульд заасан бусад	Хуульд заасан бусад

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан Засгийн газраас доорх журмыг баталсан байна[6].

1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн албa хаасан хугацааны нэмэгдэл олгох журам

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам

3. Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам

4. Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам

5. Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам

6. Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам

7. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам

Төрийн захиргааны болон тусгай албан хаагчдын ажлыг Засгийн газраас 2020 онд баталсан журмын дагуу улирал тутам үнэлдэг. Харин төрийн үйлчилгээний албан хаагчдын хувьд тусгайлсан нийтлэг журам байхгүй. Тухайн салбарын онцлогоос хамаарч, үнэлгээний шалгуур журам харилцан адилгүй байдаг. Жишээ нь, эрүүл мэнд, боловсролын салбарынханд ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох талаар Засгийн газраас 2019 онд журам[7] баталсан. Хэдий ийм журамтай ч үнэлгээг шударга, бодитой хийж байна уу гэдэг асуулт урган гарна. Мөн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийхэд төрийн албан хаагчид урамшуулал

[5] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2018 он №1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйл

[6] Монгол Улсын засгийн газрын тогтоол 2018.12.19, №382

[7] Монгол Улсын засгийн газрын тогтоол 2019.01.09, №05

олгох нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байсан.

Засгийн газраас 2019 онд баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-д улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно гэж заасан. Үүгээр албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байхаар зааж өгчээ.

Дэлхийн банкнаас 2020 оны арванхоёрдугаар сард хийсэн “Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь: Шинэтгэлийн явц, сургамж”[8] судалгааны тайланд Төрийн албаны орон тоо, цалин хөлсний зохицуулалт, зардалтай холбоотой томоохон асуудлуудыг Засгийн газар шийдвэрлэх шаардлагатай байгааг дурдсан байна. Мөн өндөр ур чадвартай ажилтан, албан хаагчдыг ажилд авах, тогтвор суурьшилтай ажиллуулах, сэдэлжүүлэх зохистой хөшүүргийг бий болгох, ялангуяа ижил ажилд ижил цалин олгох зарчим баримтлах талаар онцолсон. Үүний тулд нэмэгдлийг үндсэн цалинд шингээн цалин хөлсний тогтолцоог хялбаршуулах, ангилал зэрэглэлийг хялбаршуулах, мөн бусад салбартай харьцуулсан жишиг цалин тогтоох шаардлагатай талаар дурджээ.

Төрийн албаны тухай хуульд[9] Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтооход дараах журмыг баримтална:

- Ажлын байрны шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн байгууллагын үйл ажиллагааны зохих хүрээ, албан тушаалын чиг үүрэг, хүлээх хариуцлагыг үндэслэн боловсруулж мөрдүүлэх;
- Цалингийн хэмжээ нь хүн амын амьжиргааны дундаж түвшин болон хувийн хэвшилд ажиллагчдын албан тушаалын цалингийн дундаж түвшинтэй уялдсан байх
- Төрийн албан хаагчийн дундаж цалингийн хэмжээ нь хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын цалингийн дунджаас 5.0 буюу түүнээс дээш хувиар бага болсон тохиолдолд албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай саналыг Засгийн газар боловсруулж, төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэхийн өмнө Улсын Их Хуралд танилцуулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ хэмээн зохицуулсан байна.

Жишээлбэл. Цагдаагийн албан хаагчийн цалин хөлс 560,000 төгрөгөөс эхэлж 625.000 төгрөгийн дундаж цалинтай байгаа бөгөөд энэ нь хүн амын амьжиргааны дундаж түвшин болон хувийн хэвшилд ажиллагчдын албан тушаалын цалингийн дундаж түвшинтэй уялдсан байж чадаж байгаа эсэх үнийн өсөлт болон инфляц нэмэгдэж байгаа энэ үед алба хаагчдын ажиллах баталгааг хангаж чадах эсэх нь эргэлзээтэй юм.

[8] https://www.worldbank.org/mn/

[9] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2018 он №1, Төрийн албаны тухай хуулийн 58 дугаар зүйл

Хэрэглээний үнийн улсын инфляц 2022 оны 1 сарын байдлаар.[10]



Төрийн алба хаагчдын цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлсний асуудлыг судлан цэгцлэх хэрэгтэй. Үнийн өсөлт, инфляц, ажлын онцлог, хүнд нөхцөл, ачаалал, зайлшгүй шаардлага зэргийг судлан ямар салбарын албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс өгөх вэ гэдгийг шинэчлэн тогтоох хэрэгтэй. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, цалингийн бүтцэд ажлын үр дүнгийн цалин, нэмэгдлийг оруулснаар ажлаа хариуцлагатай, мэргэжлийн түвшинд, чанартай, санаачилгатай хийх хөшүүрэг бий болно гэж үзэж байна

Төрийн албаны ангилал зэрэглэл, цалин хөлсийг үндэслэлтэй зөв тогтоох явдал олон талын ач холбогдолтой. Цаашид бүх шатны менежерүүдийг гүйцэтгэлийн үнэлгээг хийх арга зүйд сургах, сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн сайн үнэлгээг урамшуулах, мөнгөн урамшуулал /бонус/ олгох асуудлыг засгийн газар судлан шийдвэрлэх шаардлагатай. Төрийн албаны ангилал, цалин хөлс, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан шагнал, урамшуулал, нийгмийн баталгааг боловсронгуй болгосноор төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай, мэргэшиж ажиллах таатай нөхцөл бүрдэж, төрийн үйлчилгээний үр ашиг, бүтээмж сайжирна[11].

Дүгнэлт

Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн цалин нь ямар хэсгээс бүрдэх тухай маш тодорхой зааж өгсөн. Тодруулбал,

- Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс;
- Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс;
- Тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс;
- Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон

[10] Монголбанк - Монгол Улсын Төв Банк. (mongolbank.mn)
[11] Д.Зүмбэрэллхам “Төрийн алба: шинэтгэлд шимтэхийн учир” УБ., 2020 он, 73 тал

докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн албаа хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ хэмээн заасан байна.

Гэвч “ажлын үр дүнгийн…” цалин, нэмэгдлийн асуудал нарийн тусгагдаагүй байна. Мөн цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлсний асуудлыг ч цэгцлэх хэрэгтэй. Үнийн өсөлт, инфляц, ажлын онцлог, хүнд нөхцөл, ачаалал, зайлшгүй шаардлага зэргийг судлан ямар салбарын албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс өгөх вэ гэдгийг шинэчлэн тогтоох хэрэгтэй. Магадгүй төрийн албан хаагч хууль тогтоомжид заасан энэ нэрлэсэн, тогтмол цалин, нэмэгдлээ тасралтгүй аваад яваа нь тэдний хийсэн ажилд нь таарсан, өрсөлдөөнд суурилсан цалин хөлс биш, ажлаа хийсэн, хийгээгүй ч авдаг цалин хөлсний тогтолцоо болсон байхыг үгүйсгэхгүй.

Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, цалингийн бүтцэд ажлын үр дүнгийн цалин, нэмэгдлийг оруулснаар ажлаа хариуцлагатай, мэргэжлийн түвшинд, чанартай, санаачилгатай хийх хөшүүрэг бий болно гэж үзэж байна

Санал

- Төрийн албаны тухай хуулиар цалингийн бүтцэд ажлын үр дүнгийн цалин, нэмэгдлийг оруулах
- Төрийн албаны ангилал, цалин хөлс, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан шагнал, урамшуулал бий болгох

Эх сурвалж

1. Төрийн албаны тухай хууль 1994 он
2. Төрийн албаны тухай хууль 2002 он
3. Төрийн албаны тухай хуулт 2017 он
4. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 он
5. Монгол Улсын засгийн газрын тогтоол 2018.12.19, №382
6. Монгол Улсын засгийн газрын тогтоол 2019.01.09, №05
7. Х.Наранбаатар “Төрийн алба” 2010 он, УБ
8. Д.Зүмбэрэллхам “Төрийн алба: шинэтгэлд шимтэхийн учир” 2020 он, УБ
9. Өдрийн сонин. 2013.01.15 №011 (4775)
10. https://www.worldbank.org/mn/
11. Монголбанк - Монгол Улсын Төв Банк. (mongolbank.mn)

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХЭРЭГЖИЛТ

IMPLEMENTATION OF CONSTITUTIONAL LEGAL LIABILITY

Т.Азжаргал
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч
Azjargal.T
Senior lecturer at Common Law department of Law and Social Science School, The University of Internal Affairs, Major

Хураангуй: Судлаачийн зүгээс энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр дэвшүүлж буй санаа нь Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага: Онол туршлага, цаашдын чиг хандлага сэдэвт судалгааны ажлын нэгээхэн хэсэг бөгөөд тухайн өгүүллээр Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын хамгийн гол асуудал нь хэрэгжилт тул тухайн хэм хэмжээний хэрэгжилтийг улс орон бүрт хэрхэн тодорхойлсон манай улсын хууль тогтоомжид хэрхэн тодорхойлогдож хэрэглэгдсэн асуудлыг товч хөндөхийг зорилоо.

Abstract: From the perspective of the researcher implication of this research article is constitutional liability: on theory, practice, and future trends, and the main purpose of the research is to explain how the implementation of the norms defined in each country and how it is defined and applied in our legislation

Түлхүүр үг: Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага, Үндсэн хуулийн зөрчил, Үндсэн хуулийн хэм хэмжээ, Үндсэн хуулийн хэм хэмжээний хэрэгжилт, Үндсэн хуулийн үүрэг

Keywords: Constitutional legal responsibility, violation of the Constitution, constitutional norms, implementation of constitutional norms, constitutional obligations

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах үндэслэл, журам нь тодорхойгүй, эсвэл хэрэглэгддэггүй буюу онолын хувьд ойлголт нэг мөр тодорхойлогдоогүй байдал нь Үндсэн хуульт ёсны төлөвшилд сөрөг нөлөөтэй хэмээн үзэж байна.

Судлаачийн хувьд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах үндэслэл, хууль зүйн үр дагаварын асуудлыг Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2017 оны цуврал 62 (2) дугаарт онолын үүднээс тодорхойлсон. Үндсэн хуульт ёс төлөвшсөн улсад Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага хэмээх ойлголт нь нэг талаасаа байх ёсгүй асуудал учраас шинжлэх ухааны замаар томьёолох шаардлага тулгарна. Үүнд хууль зүйн хариуцлага оногдуулах бусад салбар эрх зүйн үндэслэлийг судалж, харьцуулан дүгнэхэд оршино. Үндсэн хуулийн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харьцааны мөн чанараас үүдэн Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын үндэслэлийг тодорхойлох хэрэгцээ шаардлага байна. Онолын хувьд Үндсэн хуулийн эрх зүйн зөрчилд Үндсэн хуулиар тодорхойлсон дэг журмаас гажсан, хэм хэмжээг зөрчсөн, хэм хэмжээнээс хэтэрсэн үйлдэл бүрийг хамааруулан ойлгоно. Иймээс Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил нь нэгэн төрлийн хууль бус үйлдэл бөгөөд дээрх эрдэм шинжилгээний өгүүллээс дэлгэрүүлэн сонирхоорой.

Мөн судлаачийн зүгээс Үндсэн хуулийн эрх зүйн зөрчилийг тодорхойлох боломж, хэрэглээний

асуудлыг Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2021 оны цуврал 84 (4) дугаарт онолын үүднээс тодорхойлж, Үндсэн хуулийн эрх зүйн зөрчлийн шинжийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үндсэн хуулийн эрх зүйн зөрчлөөс дурдвал:

- Үндсэн хуульт дэглэмд халдах
- Үндсэн хууль зөрчих (Органик хууль зөрчих, эсвэл бусад Үндсэн хуулийн эрх зүйн акт зөрчих), Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх
- Хувь хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг зөрчих
- Тангарагаас няцах, тангараг зөрчих
- Үндсэн хуульд заасан хэлбэрийн болон агуулгын шаардлагыг биелүүлэхгүй байх (хангалттай биелүүлэхгүй байх)
- Эрх мэдлээ (бүрэн эрхээ) хэтрүүлэн ашиглах
- Итгэл үл хүлээлгэх
- Нийгмийн, нийт улс орны ашиг сонирхолд харшилсан үйл хөдлөл
- Бүрэн эрхийн нийцэшгүй байдал буюу Үндсэн хуулийн субект өөр субектэд Үндсэн хуулиар олгосон эрхийг хэрэгжүүлэх
- Ёс зүйгүй үйлдэл буюу ёс зүйн зөрчил
- Улс эх орноос урвах, Үндсэн хуулийн эрх зүйн харилцааны субъект, эрх мэдэлтний хувьд Үндсэн хуульд харшилсан үйлдэл гаргах зэргийг дурдаж болно.

Иймд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг хуулиар нэг мөр тодорхойлох хэрэгцээ шаарллага байгаа бөгөөд Монгол улсын Үндсэн хуульд 2019 оны 11 сарын 14-нд орсон нэмэлт өөрчлөлтөөр Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлийн гурав дахь хэсэгт "... Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно" хэмээн нэмсэн нь Монгол улсад Үндсэн хуулийн зөрчлийн нэг шинжийг хуульчилсан бөгөөд ийнхүү хуульчлах хэрэгцээ шаардлага байна, хууль зүйн хувьд болон онолын хувьд хэрэгцээ шаардлага байна гэдэг шинжлэх ухааны ач холбогдол нь тодорхойлогдсон юм.

Монгол улсын Үндсэн хуулийн гучин тав дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт зааснаар *"....Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна",* Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т зааснаар *"...Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ"* гэжээ. Үүнээс харвал Монгол улсын ерөнхийлөгч нь Үндсэн хуулиас гадна бусад хуулийг зөрчсөн үйлдэл гаргавал Ерөнхийлөгчийн тангараг зөрчсөн гэж үзэж Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага

оногдуулж, огцруулах үндэслэлийг хуульчилжээ.[1]

Дээрх Үндсэн хуулийн зөрчлийн шинжүүд нь Үндсэн хуулийн субьектүүдийн эрх хэмжээг тодорхойлсон органик хууль тогтоомжид илүү дэлгэрэнгүй тайлбарлагдсан байдаг. Жишээ нь Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т *"...Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ",* Монгол улсын их хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д *"...Үндсэн хуулийн цэц гишүүнийг энэ хуулийн 7.2-т заасан тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно",* Мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д *"...Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гэж үзэн тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ"* хэмээн тус тус Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн Үндсэн хууль болон бусад хууль зөрчсөн бол хүлээлгэх Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг органик хуулиар ийнхүү хуульчилжээ.

Зарим тохиолдолд зөрчлийн шинжийг заах нь үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын үндэслэлийг тогтоох шалгуур болно. Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 01 сарын 12-ны өдрийн №03 дугаартай дүгнэлтээр УИХ-ын гишүүн Ц.Төрмандах Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэж, "...Улсын Их Хурлын гишүүн Цогбадрах овогтой Төрмандах нь Монгол Улсын Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлийн *"Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" тухай заалтыг зөрчжээ гэсэн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж байна"* хэмээн УИХ-ын гишүүний Үндсэн хууль зөрчсөн зөрчлийн шинжийг тодорхойлж шийдвэрлэжээ. [2] Мөн ОХУ-ын Дээд шүүхийн шийдвэрээс харвал ОХУ-ын ба түүний Үндсэн хуулийн субьектийн хууль тогтоомжийг зөрчсөн зөрчилд төлөөлөгчийг огцуулж шийдвэрлэх бөгөөд үүний үндэслэл нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг заавал харгалзаж авч үзэх шаардлагтай болохыг дурджээ.

Тухайлбал Үндсэн хуулийн Шүүхээс албан тушаалаас огцруулах, эгүүлэн татах шийдвэр нь тухайн субъектын үйлдэлд зөрчлийн хэд хэдэн шинжийг үндэслэх нь огцроох үндэслэлийг тодорхойгүй болгож байгаа буюу Үндсэн хуулийн зөрчлийн

[1] "Хууль дээдлэх ёс сэтгүүл" УБ., 2021, 84 (4) дугаар 27-43 дахь тал, Т.Азжаргал "Үндсэн хуулийн эрх зүйн зөрчлийг тодорхойлох боломж, хэрэглээ" сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл

[2] https://legalinfo.mn/mn/detail/1098 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр үзсэн.

шинжийг бүдэгрүүлэх, хаях нөхцөл болох юм. Үүнийг Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт ч мөн харгалзан үздэг байна. Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийн Дүгнэлт гаргах нь хэсгийн 1-д *“....Улсын Их Хурлын гишүүн С.Зориг нь Стратеги судалгааны төвийн захирлаар ажиллахдаа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчжээ гэсэн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж байна”,*

3-т *“Гомдол гаргагч Ш.Батдорж, Ц.Олзвой нарын гомдолд буй “Улсын Их Хурлын гишүүн С.Зориг нь албан татварын хууль зөрчсөн, Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй. Ардчилал таймс, Экспресс таймс, Нөлөөгүй толь сонинуудыг удирдан гаргадаг, сонгогчдын итгэл найдварыг алдагдуулан чуулганы хуралдаан тасалсан зэргийг магадлан шалгахыг хүссэн зэрэг” шаардлагуудыг хэрэгсэхгүй болгосугай”* гэсэн нь гомдол гаргагчаас хэд хэдн зөрчлийн шинжийг дурдсан боловч Цэцээс тухайн УИХ-ын гишүүний Үндсэн хуулийн зөрчлийн нэг шинжийг тодорхойлж, хамаарахгүй хэсгийг дурджээ.

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг Үндсэн хуулийн субъектээс хууль тогтоомжийг зөрчсөнөөс эсвэл Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүйгээс үүдэн тооцож болдог байна.[3]

Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр УИХ-ын дарга Ц.Нямдорж Монгол улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай хянан шийдвэрлэж 2007 оны 03 сарын 02-ний өдөр дүгнэлт гаргасан боловч эс биелүүлж, уг асуудлыг 2007 оны 05 сарын 23-ны өдөр дахин хэлэлцэж дүгнэлт гаргажээ. Энэ нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг эс биелүүлэх тохиолдол бөгөөд энэ асуудал Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг харахад хэд хэдэн удаагийн тохиолдол байна. [4]

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг одоогоор Монгол улсад тодорхойлох хэрэглэх журмыг нарийвчлан хуульчлан тогтоож, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох нь маш чухал юм. Учир нь үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага нь материаллаг болон процессийн хэм хэмжээний харилцан үйлчлэлийн үр дүнд бий болж байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй.

Норматив эрх зүйн актуудыг судлаж үзсэний үндсэн дээр үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг хэрэглэх нэгдсэн журам байхгүй байгаа ба хариуцлагын төрөл бүрийн субьект, үндэслэл, арга хэмжээний нэгдсэн журмыг нарийвчлан хуульчлах боломжгүй юм. Харин хариуцлагын нийтлэг журмыг шинж чанараар нь тодорхойлон гаргаж болно.

---

[3] Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг Оросын Холбооны субьектийн хууль тогтоомжийг зөрчсөнөөс (ОХУ-ын Тюмень мужийн “Хууль биелүүлээгүйн хариуцлагын тухай” хуулийн 18 зүйл) эсвэл шүүхийн шийдвэрийг биелүүлээгүйгээс (Бразилийн Холбооны улсын Үндсэн хуулийн 34 зүйл) үүдэн тооцож болдог байна. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх нь хариуцлагын үндэслэл болж болдог гэдгийг Бразилийн Холбооны улсын Үндсэн хуулийн 34 зүйлийн 6 заалтанд зааснаар шүүхийн шийдвэрийг мөн Холбооны хуулийг биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн эрх зүйн зөрчилд тооцохоор хуульчилжээ.

[4] https://legalinfo.mn/mn/detail/1101, https://legalinfo.mn/mn/detail/1100, 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр үзсэн

Нэгдүгээрт, Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагад татагдаж буй Үндсэн хуулийн эрх зүйн субьект нь өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх нь нээлттэй бөгөөд өөрийн Үндсэн хуулийн зөрлийн шинж чанар түүнд зөвтгөх үндэслэлийг тайлбарлах боломжийг олгох ёстой байдаг олон улсын туршлага байна. Жишээ нь Мексикийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн 89, 111 зүйлүүдийг харгалзан Ерөнхийлөгч төлөөлөгчийн танхимаас ажлын байрны тодорхойлолт, албаны чиг үүрэгт харшлах үйл явдал гаргасан, албаны байр сууриа зохисгүй байдлаар илэрхийлсэн гэсэн үндэслэлээр Дээд шүүхийн гишүүнийг огцруулах санал гаргаж болно. Ерөнхийлөгч огцруулах санал гаргахаасаа өмнө гомдлын дагуу тухайн шүүгчтэй нууцлалыг хадгалан ярилцаж, Үндсэн хуулийн суурь “шударга ёсны” зарчмын дагуу шийдвэр гаргана.

Энэ нь Үндсэн хууль зөрчсөн субьектэд өөртэйгээ холбоотой асуудлын зөрчлийн шинжийг авч үзэхэд оролцож, тайлбар хийж, эрхээ хамгаалах боломжийг олгодог байх ёстой байхнээ. Жишээ нь Непалын Хаант улсын Үндсэн хуулийн 87 зүйлд зааснаар Үндсэн хууль зөрчсөн үйлдэл гарган, албан үүргээ хангалттай сайн биелүүлээгүй шүүгч хууль зүйн хамгаалалт хүсэх эрхтэй. Төлөөлөгчийн танхим болон парламентийн гишүүдээс шүүгчийн өргөдлийг шалгах, нотолгоо цуглуулах, шинжилгээ хийх эрх зүйн мэргэжилтнүүдээс бүрдсэн мөрдөн шалгах хороо байгуулна. Хороо үйл ажиллагаагаа хуультай нийцүүлэн хийнэ. Зарим актуудад хариуцлагад татагдаж буй субьектийн төлөөлөгчийг уг авч үзэж буй хэрэгт оролцуулж болдог. Жишээлбэл, Израиль улсын “Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 20 зүйлд зааснаар Ерөнхийлөгч огцрох асуудалтай холбогдон Парламентийн асуудлын хорооны өмнө болон төлөөлөгчөөрөө дамжуулан Кнессетийн өмнө зогсоно. Кнессетийн гишүүн Ерөнхийлөгчийн төлөөлөгч байж болохгүй.

Хоёрдугаарт, Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага хүлээх субьектэд үндсэн хуулийн эрх зүйн санкци хэрэглэж болох хугацааг тодорхой заадаггүй тохиолдол байна. Учир нь үндсэн хуулийн зөрчил нь удаан хугацаагаар үргэлжлэх хандлагатай байдаг.

Гуравдугаарт, Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил гаргасан гэдгийг тодорхойлох, Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах процедурыг дуустал субьект үүргээ биелүүлэх асуудлыг түтгэлзүүлж болно (Непалын Хаант улсын Үндсэн хуулийн 87 зүйл, Германы Холбооны улсын Үндсэн хуулийн 61 зүйл).

Дөрөвдүгээрт, Зарим тохиолдолд субьектийн үндсэн хуулийн зөрчлийг Үндсэн хуулийн \цэц\ шүүхийн ба шүүхийн бус аргаар үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага хүлээлгэж болдог. Өөрөөр хэлбэл асуудлыг Үндсэн хуулийн зохицуулалтаар Улсын их хурлаас Үндсэн хуулийн субъектийг эгүүлэн татах, огцруулах тухай шийдвэр гаргах замаар Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг оногдуулах зохицуулалт байна. Жишээ нь Гүрж улсын Үндсэн хуулийн 54 зүйлд зааснаар, хэрэв парламентын гишүүн ээлжит хурлыг 4 сарын хугацаагаар шалтгаангүй тасалсан бол Парламент уг гишүүнийг эгүүлэн татах зохицуулалттай байна. Энэ тохиолдолд Үндсэн хууль зөрчсөн гэдгийг Үндсэн хуулийн шүүхээр шийдвэрлүүлж болно.

Тавдугаарт, Субьектийн үндсэн хуулийн эрх зүйн статус нь үндсэн хуулийн зөрчлийн нэг шинж болдог ба субьект ажил, албан тушаалаа \бүрэн эрхээ\ сайн дураар хүлээлгэн өөрийн хүсэлтээр огцорсон тохиолдолд хариуцлагын арга хэмжээг хууль зүйн хариуцлагын онолын үүднээс авах боломжгүй болж байна. Гэвч Мексикийн нэгдсэн улсын Үндсэн хуулийн 113 зүйлд зааснаар, Үндсэн хуулийн субъект нь Үндсэн албан тушаалтныг бүрэн эрхийнх нь хугацаанд болон огцорсоноос хойш 1 жилийн дотор Үндсэн хуулийн хариуцлагын арга хэмжээг авч болох зохицуулалтыг хуульчилж өгчээ.

Мөн үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах үйл аявцдаа холбогдох, хууль, журмыг зөрчин, алдаа гаргасан тохиолдолд тухайн үйлдэл нь өөрөө үндсэн хуулийн деликт болох боломжтой байдаг байна. Москвагийн “Мужийн Думын төлөөлөгчийг огцруулах тухай” хуульд тусгаснаар хэрэв тойргийн сонгуулийн хороо төлөөлөгчийг буцаан татах санал асуулгын үеэр хууль зөрчигдсөн буюу процедурт эрх зүйн зөрчил илэрвэл, санал асуулгын үр дүнг хүчингүйд тооцохоор зохицуулжээ.

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага нь бодит хууль зүйн арга текникээр дамжин хэрэгжих бөгөөд мөн Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд дан ганц хууль зүйн талаасаа ч биш улс төрийн болон Монголын ард түмний оюун санааны хувьд асар их нөлөөг үзүүлдэг байх нь их чухал.

Хэрэв Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага хууль зүйн талаасаа бодитоор хэрэгжиж буй механизм, зохицуулалт байхгүй бол үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээний шинж мөн чанар, чиг үүрэг, ач холбогдол төдий чинээгээр багасна. Жишээ нь ОХУ-ын хувьд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын арга хэмжээг харьцангуй хууль зүйн хувьд бүрэн зохицуулалтыг “Үндсэн хуулийн шүүхийн тухай” хууль болон ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтан, ард түмний төлөөлөгч, сонгуулийн албан тушаалтан, орон нутгийн засаг захиргааны удирдлагыг огцруулах, эгүүлэн татах, эсвэл бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө тараах тухай асуудлыг нарийвчлан зохицуулсан хуулиудтай байна.

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг хууль зүйн талаас нь зохицуулалтыг аль болох боловсронгуй тодорхойлохыг зорьсон улсаар Польшийг дурдаж болохоор байна. Польш улсын Үндсэн хуулийн 158, 198-201 дүгээр зүйлд болон Органик хуулиар Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагад татах дараах процедурыг тогтоожээ. Зөвхөн Ардын зөвлөл Ерөнхийлөгчийг Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Парламентад гомдол гаргах эрхтэй ба Сейм бусад албан тушаалтнуудад гомдол гаргана. Сеймийн тэргүүнд Ерөнхийлөгчийг Үндсэн хууль зөрчсөн хэмээн буруутгасан үндэслэл бүхий санал очих ба парламентиын хоёр танхимийн нийт гишүүдийн ¼-аас доошгүйн саналаар үндсэн хууль зөрчсөн зөрчлийн шинжийг харгалзан асуудлыг шийдвэрлэнэ. Бусад төрийн өндөр албан тушаалтнуудыг Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлын хувьд Ерөнхийлөгч, эсвэл Сеймийн мөрдөн шалгах хорооноос дор хаяж 115 төлөөлөгч гомдол гаргах эрхтэй байхаар зохицуулжээ. Үндсэн хууль зөрчсөн эсэх үндэслэл бүхий саналд албан тушаалтны ерөнхий мэдээл, Үндсэн хуулийн зөрчигдсөн заалт болон тухайн заалтыг хэрхэн зөрчсөн гэдгийг

санал гаргасан үндэслэлдээ бичих хэрэгтэй. Уг санал нь Сеймийн үндсэн хуулийн хариуцлагын асуудлыг шийдвэрлэх хороонд очно. Уг асуудлыг Үндсэн хуулийн хариуцлагын хороо авч үзээд Ардын зөвлөлд эсвэл Сеймд ажил албыг нь үргэлжлүүлэх эсвэл албан тушаалаас нь огцруулах эгүүлэн татах тухай тухай асуудлыг үндэслэл бүхий асуудлыг хяналт шалгалтын ажлын тайлан хэлбэрээр бичнэ. Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаарх маргаан үүсгэх эсэх шийдвэрийг Ардын зөвлөлийн нийт танхимийн нийт гишүүдийн 2/3-аас доошгүй саналаар гаргах ба Сеймийн албан тушаалтныг Үндсэн хуулийн хариуцлагад татах шийдвэрийг нийт төлөөлөгчдийн 50 хувиас доошгүй гишүүдийн ирц бүрдсэнээр хуралдаан хүчинтэй болж түүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв ирц хангалтгүй байвал Ардын зөвлөлийн тэргүүн эсвэл Сеймийн тэргүүн уг Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах эсэх асуудлыг шийдвэрлэх хуралдааныг хаах шийдвэр гаргана. Парламент одоог хүртэл цөөн тооны асуудалд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулжээ. 1984 онд Сайд нарын зөвлөлийн Тэргүүнийг бүрэн эрх нь дууссаны дараа Үндсэн хууль зөрчсөн хэмээн Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах процедурыг эхлүүлсэн авч уг асуудал нь тухайн үеийн өршөөлийн хуулиар шалгалтын ажиллагааг зогсоож байжээ. Онцгой нөхцөлд Парламентаас Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулахгүйгээр буюу санкцыг хэрэглэхгүйгээр гэм буруутайд тооцох шийдвэрийг гаргаж байжээ.

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах, түүний хэрэгжилтийг хангах тухай асуудлыг шийдвэрлэх нь төдийлөн амаргүй байдаг байна. Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хуулийн эрх зүйн нэг институт болохын хувьд тухайн салбарт хамгийн гол асуудлын нэг бол тухайн асуудлыг шийдвэрлэх холбогдох эрх бүхий байгууллага тодорхой бус байдагтай холбоотой байна.

Мөн Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах асуудлыг нэг байгууллагад харьяалуулж ч юм уу, хариуцлага оногдуулах байгууллагын статус эрх зүйн байдлын талаар судалгаа хийгдсэн байдал, судалгааны бааз материал бусад улс орныг харахад төдийлөн тийм төрлийн судалгаа хийгдээгүй байна. Тухайлбал Үндсэн хууль бол нийтлэг эрх үүргийг тодорхойлсон хууль бөгөөд энэ нь бусад салбар хуулийн эрх зүйн үндсэн суурь дүрмийг дорхойлдог онцлогтой юм.

Олон улсын туршлагыг хархад Үндсэн хуулийн зөрчил бүрд хууль тогтоомжид заасан хариуцлагын асуудал яригдахгүй өнгөрөх тохиолдол байдаг байна. Хэн нэгэн иргэний юм уу сонирхогч этгээдийн өргөдөл, мэдээллийн дагуу тухайн албан тушаалтны үйлдлийг Үндсэн хуулийн эрх зүйн зөрлийн шинжийг хангаж байна гэж үзэж тухайн зөрчлийн шинжийг тогтоох хэрэгтэй ба энэ нь цаашид хариуцлагад татах үндэслэл болдог байна. Иймд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагад татах түүний үндэслэлийг тодорхойлох, хариуцлага оногдуулах холбогдох эрх бүхий байгууллага байхгүй бол хариуцлагын тухай ойлголт яригдахад хэцүү болохнээ. Монгол улсын хувьд Үндсэн хуулийн жаран зургаадугаар зүйлд заасны дагуу “...иргэний өргөдөл мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэц өөрийн

санаачилгаар хэрэг маргааныг үүсгэхээр зохицуулсан" нь иргэний Үндсэн хуулийн цэцэд хандах өргөдөл мэдээлэл нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд чухал нөлөөтэй бөгөөд жилд дунджаар иргэдийн гаргасан өргөдөл мэдээллийн 20 хүртлэх өргөдөлд л Үндсэн хуулийн маргаан үүсгэсэн байна. Энэ нь Үндсэн хуулийн зөрчил байна гэж иргэдийн үзсэн зүйлийг Үндсэн хуулийн цэцээс 80 хувьд нь Үндсэн хуулийн маргаан үүсгэхээс татгалзсан нь Үндсэн хуульт ёсны төлөвшилд иргэний үүрэг оролцоо маш их чухал байна гэдэг нь харагдаж байна. Тэгэхээр бүхий л Үндсэн хуулийн зөрчилд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах боломжгүй болох тохиолдол байдаг байна.

Хууль зүйн шинжлэх ухаанд гэм буруугийн зарчмын дагуу шүүхээс гэм буруутай гэж үзэхээс наана тухайн хүнийг хэн ч гэм буруутайд тооцохгүй гэсэн зарчим буй юм. Философи

Дүгнэлт

Үндсэн хуулийн ариуцлага хүлээх субьект, хариуцлага оногдуулах үндэслэл, хууль зүйн арга хэрэгслэлээс гадна холбогдох эрх бүхий байгууллагыг тодорхойлж болох юм. Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах холбогдох эрх бүхий байгууллага нь зөвхөн Үндсэн хуулийн зөрчил гаргагч субьектийн Үндсэн хууль зөрчсөн үйлдэл, түүний үр дагаварыг судлах гэхээс илүү энэхүү Үндсэн хууль зөрчсөн үр дагавар нь нийгэмд Үндсэн хуульт ёсны төлөвшилд шууд болон шууд бусаар ямар сөрөг нөлөөг үзүүлэхийг сайн харгалзан үзэх, түүнийг үндэслэн зохих арга хэмжээг авдаг байх нь чухал юм. Мөн Үндсэн хуулийн зөрчлийг тогтоох, хариуцлага оногдуулах байгууллага нь заавал нэг утгаараа Үндсэн хуулийн зөрчил буйг тодорхойлж, эрх бүхий этгээдээс шийдвэр гаргах хүртэл хариуцлага нь нэгэн зэрэг оршиж ба эс оршиж байдаг гэсэн ухагдахуун бий. Учир нь Үндсэн хууль зөрчсөн гэдгийг тодорхой этгээд үндэслэл бүхий тайлбарлаж Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргасан тул Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын асуудал яригдана, нөгөө талаасаа Үндсэн хууль зөрчсөн гэдгийг Үндсэн хуулийн цэцээс тогтоогоож эцсийн шийдвэр гараагүй байгаа тохиолдолд хариуцлага оногдуулах эсэх асуудал нь яриглахгүй юм. Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага нь зөвхөн холбогдох эрх бүхий байгууллагаас субьектийн гэм буруутай тухай, үндсэн хуулийн эрх зүйн санкц хэрэглэх шийдвэр гарсаны дараа л үүсдэг. Тийм болохоор үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг хуулиар тодорхойлон хуульчлах хэрэгтэй болох нь харагдаж байна.

байгууллага байх шаардлагагүй бөгөөд тус тусын чиг үүрэгтэйгээр оршиж болно.

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын холбогдох эрх бүхий байгууллага нь үндсэн хуулийн эрх зүйн харилцааны субьект байж болох ба энэ харилцааны субьект нь үндсэн хуулийн зөрчил гаргасан субьектүүдэд хариуцлага оногдуулах, шийвэр гаргалтанд оролцох эрхтэй байж болно. Өргөн утгаараа Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах холбогдох эрх бүхий байгууллагад зөвхөн үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын асуудлыг шийддэг байгууллагаас гадна хариуцлага оногдуулах процедурт оролцдог, зөрчлийн шинжийг тодорхойлдог байгууллага ч бас орох юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол улсын Үндсэн хууль” УБ., 1992 он, ТМ №1

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль УБ., 1997 он, ТМ №6

3. “Хууль дээдлэх ёс сэтгүүл” УБ., 2021, 84 (4) дугаар 27-43 дахь тал, Т.Азжаргал “Үндсэн хуулийн эрх зүйн зөрчлийг тодорхойлох боломж, хэрэглээ” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл

4. [1] https://legalinfo.mn/mn/detail/1098 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр үзсэн.

5. Г.Совд, С.Нарангэрэл. Ред. “Хууль зүйн тайлбар толь” /хамтын бүтээл/. УБ., 2003 он,

6. Ц.Сарантуяа., “Үндсэн хуулийн процессын эрх зүй” Улаанбаатар, 2005, 128-129 дэх тал

7. Ц.Сарантуяа, Үндсэн хууль ба үндсэн хуулийн шүүх: Үндсэн хуулийг шүүхийн журмаар хамгаалах асуудалд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, 2002, №1, 21 дэх тал

8. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн үзэл баримтлал бол эрх зүйн системийн хууль зүйн үндэс мөн, (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), Уб, 2007, 168 дахь тал

9. Н.Жанцан, Үндсэн хуулийн цэц ба Үндсэн хуулийн үзэл санаа, (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), Уб. 2007, 152 дахь тал

10.Н. Жанцан, Үндсэн хуулийн цэц ба үндсэн хуульт ёсны төлөвшил, Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага. ОУЭШБХуралд тавьсан илтгэл

11.Арне Мавчич “Үндсэн хуулийн хяналт”, Улаанбаатар, 2014, /Г.Баясгалан, Д.Сугар, Д.Одбаяр нарын орчуулга, үүсмэл бүтээл/ 63 дахь тал

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ СУДЛАХ НЬ

EXPLORING POSSIBILITIES TO INCREASE EMPLOYMENT OF PEOPLE WITH DISABILITIES

Г.Наранчимэг
ДХИС-ийн магистрант
G.Naranchimeg
Master's student of UIA

Хураангуй: Хөгжлийн бэрхшээл гэдэг нь хувь хүндээ биш нийгэмд байгаа гэж үздэг “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын ойлголт Монгол Улсад хараахан нийтлэг болоогүй байгаа билээ. Тэр утгаараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сул дорой хүмүүс гэсэн ойлголт давамгайлж, тэдний нийгмийн оролцоо бодит байдал дээрээ хангагдаж чадахгүй байсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 34.0 хувь нь төрөлхийн 66.0 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлд өртөх тохиолдол өндөр байгааг харуулж байна.

Энэхүү судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зарим арга замыг тодорхойлохоор 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс чанарын судалгаа авсан. Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг илрүүлэн тэднийг хөдөлмөрийн зах зээлд татан оролцуулах боломж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Anstract: The concept of a “social model of disability” that assumes that disability exists in society, not in individuals, is not yet common in Mongolia. In that sense, people with disabilities are often perceived as vulnerable and their social participation is still not ensured in practice. 34.0 percent of persons with disabilities are congenital and 66.0 percent are persons with acquired disabilities. This indicates a high incidence of acquired disabilities in the population.

The survey included a qualitative survey of businesses and organizations with 25 or more employees and people with disabilities to identify some ways to increase the employment of people with disabilities. The aim of the study was to identify the employment problems of people with disabilities and to identify opportunities and solutions to involve them in the labor mark.

Түлхүүр үгс: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил эрхлэлт, ажлын байрны тохируулга

Keywords: Disability, employment, job placement

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний хэрэгцээ, чадавхад үндэслэн тусгай ажлын байр бий болгох, боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”, Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодит болгох” Инчеоны стратеги 2013-2022 он, “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” зэрэг урт, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд олон зүйл заалтууд тусгагдсан байдаг. Өнөөгийн нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдын нэгэн адил улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхээ бүрэн

дүүрэн эдэлж чадахгүй, мөн тэдэнд зориулсан нийгэм, хүрээлэн буй орчин хараахан бүрдээгүй байгаа бөгөөд нийгмийн орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн, тэдэнд хандах хандлагыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага байна.

Дээд боловсролтой эсвэл боловсрол эзэмшээгүй хүн амын хувьд хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс хамааран мэдэгдэхүйц ялгаа ажиглагджээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 7.7 хувь нь дээд боловсролтой байхад нийт хүн амын дундах дээд боловсролтой хүн амын эзлэх хувь түүнээс 2.4 дахин өндөр байна. Эсрэгээр, хөгжлийн бэрхшээлтэй ямар нэгэн боловсрол эзэмшээгүй хүн амын хувь нийт хүн амаас 3 дахин өндөр байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүр адилгүй. Тэдний бэрхшээл бие бялдрын, мэдрэхүйн эрхтний, оюуны болон сэтгэцийн шинжтэй байдаг. Хөгжлийн бэрхшээл төрөлхийн, хүүхэд насанд, өсвөр насанд болон амьдралын хожуу үе буюу боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх үед ч олдсон байдаг.

Хөгжлийн бэрхшээл нь тухайн хүний хөдөлмөрлөх, нийгэмшихэд бага нөлөө үзүүлдэг явдал байдаг. Эсрэгээрээ маш их нөлөө үзүүлдэг бөгөөд дэмжлэг, туслалцаа шаардах нь ч бий. Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил, хөдөлмөрийн бүхий л түвшинд ажиллаж хувь нэмрээ оруулж байна. Гэсэн хэдий ч ажил, хөдөлмөр хийхийг хүсэж байгаа боловч олон саад бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон байна. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг судлах үүднээс энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Манай улсад 103.6 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн хөдөлмөрийн насны 73.2 мянган иргэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг болоод буй юм. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудалд шинэ байр суурinaас хандаж, тэднийг өөртөө итгэлтэй, амьдралаа аваад явах чадвар бүхий нийгмийн идэвхтэй гишүүн болгож хөгжүүлэх, бусдын адил амьдрах боломж нөхцөл, нийгэмд оролцох оролцоо, хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг илрүүлж шийдвэрлэх арга замыг тодорхойлох хэрэгцээ байна.

Сэдвийн судлагдсан байдлын тойм: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж хийсэн судалгаа шинжилгээний ажил нэлээдгүй байна. Үүнээс томоохон судалгаа шинжилгээний ажлуудаас дурдахад:

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай”

2017 онд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд шалгалт хийжээ. Уг шалгалтыг Монгол Улсын 21 аймаг, Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагуудад Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн холбогдох заалтууд болон түүнтэй нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилготой хийжээ. Шалгалтанд хамрагдсан 1281 ААНБ-ын 794 буюу 62.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зохих орон тоонд авч ажиллуулсан, 131 буюу 10.2 хувь нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2-д заасны дагуу зохих төлбөрийг ХЭДС-д төлсөн, 487 буюу 38.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй, ажлын байрны төлбөрийг төлөөгүй байна. Улсын

байцаагч 149 байгууллагад акт үйлдэж 734 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьснаас 119 байгууллага 587 сая төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлсэн байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн үнэлгээ”

2016 онд IRIM судалгааны хүрээлэн судалгааг хөгжлийн бэрхшээлтэй 94 иргэн, 85 төрийн байгууллага болон ажил олгогч байгууллагуудын төлөөлөл, 6 удаагийн ганцаарчилсан ярилцлагын түүвэр дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулах зорилготой хийсэн байна.

“Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох” судалгаа

2015 онд IRIM судалгааны хүрээлэн Улаанбаатар хотын 6 дүүргийн сонсголгүй 100 иргэн, ажил олгогч 60 байгууллагын удирдлага, төрийн болон төрийн бус 35 байгууллагын удирдлагыг хамруулан зохион байгуулсан. Судалгаа нь сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, дүн шинжилгээ хийх зорилготой хийгдсэн.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг судлах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах арга замууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох юм.

Судалгааны объект: 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагууд, хөдөлмөрийн насны ажил эрхэлж буй болон ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан.

Судалгааны ач холбогдол: Энэхүү судалгааны ажлыг хийснээр хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг тооцох, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, бодлогын шийдвэр гаргахад хувь нэмрээ оруулна.

Хөгжлийн бэрхшээл, түүний хэлбэр

Албан ёсны статистикийн мэдээлэл буюу Нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж байна. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр нь бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж хэнийг хэлэх вэ гэдэг талаарх ойлголтыг эрх зүйн актуудад хэрхэн тодорхойлсон байдлыг авч үзье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгийн согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ[1].

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн

[1] “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай” НҮБ-гаас батлан гаргасан олон улсын конвенцийн 1 дүгээр зүйл

дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно[2].

Төрөлхийн болон олдмол шалтгаанаар хүний биеийн анатомийн бүтэц ба физиологи, сэтгэцийн үйл ажиллагаа алдагдсаны улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдаж, улмаар нийгмээсээ тусгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэлнэ гэж тодорхойлсон байна[3]. Олон улсын жишгийг үндэслэн Монгол улсад мэргэжлийн байгууллагуудын түвшинд Хөгжлийн бэрхшээлтэй болж буй байдлыг импэйрмэнт, чадвар алдалт, хандикап гэж 3 ангилан авч үзэж байна.

ИМПЭЙРМЭНТ гэдэг нь хүний биеийн анатомийн бүтэц ба физиологи, сэтгэл зүйн үйл ажиллааа алдагдах эсвэл хэвийн бус байхыг хэлнэ. Алдагдах, эсвэл хэвийн бус байдал нь байнгын буюу түр зуурын байна.

ЧАДВАР АЛДАЛТ гэдэг нь импэйрмэнтээс болоод хүний хэвийн гүйцэтгэх үйл ажиллагааны чадвар нь дутуу буюу хязгаарлагдмал болохыг хэлнэ. Чадвар алдалт нь байнгын буюу түр зуурын, эргэх ба эргэхгүй, сайжрах ба сайжрахгүй байж болно.

ХАНДИКАП гэдэг нь импэйрмэнт ба чадвар алдалтаас үүдээд гүйцэтгэх үүргүүд нь хязгаарлагдаж, хувь хүнд учирч буй гарз хохирлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл дээрх шалтгаанаас болж тухайн хүний нийгмийн бүхий л /соёл, нийгэм, эдийн засаг, орчин тойрны/ амьдралд оролцох үүрэг, бололцоог алдагдахад нөлөөлнө. Үүнд: 1.Харааны 2.Ярианы 3.Сонсголын 4.Хөдөлгөөний 5.Сэтгэцийн 6.Хавсарсан 7.Бусад

Ийм хүнийг нийгмээс тусгаарлагдаж байгаа хүн \хандикап\ гэж үзэж болно. Өнөөдөр олон улсын түвшинд болон манай улсад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхшээлийг дараах хэлбэрүүдээр ангилж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдал

Дэлхийн улс орнууд 1800 оноос хойш хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо мэдээллийг цуглуулж эхэлсэн бөгөөд сүүлийн 60 жилд энэ төрлийн мэдээллийг цуглуулах улс орны тоо нэмэгдэж байна. АНУ, Энэтхэг болон Португал зэрэг улсууд 19 дүгээр зууны туршид хүн амын тооллогын асуулгандаа хөгжлийн бэрхшээлийн асуултыг оруулж судалсан түүхтэй байдаг. Өнөөгийн байдлаар дэлхийн 198 улс орнууд 700 гаруй тооллого, өрхөд суурилсан түүвэр судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг гаргаж байна. Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг албан ёсны статистик болон захиргааны бүртгэл мэдээллийг авч ашиглаж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлийн асуудал нь олон салбарт хамаарагдах асуудал учраас салбар бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тоо мэдээллийг гаргахад чиглэгдэж байна.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлал, үзүүлэлтээр гаргаж байгаа, мөн статистикийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэл гэж ойлгоно. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх албан ёсны статистик мэдээллийг дараах үндсэн 3 эх үүсвэрээс гаргаж байна. (Хүснэгт 1) Үүнд:

- Зарим үзүүлэлтийн мэдээ (НЗУ-1)-гээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харуулсан мэдээллийг жил бүр гаргаж байна. Энэ мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон хүнийг хамруулж байна.

[2] Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

[3] Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан 1989 оны багц гарын авлага, хуудас 31

- ***Хүн амын орон сууцны тооллого***: Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн болон ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг цогцоор судлан тодорхойлох зорилгоор Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулж нийтэд тархаасан юм.
- ***Өрхөд суурилсан түүвэр судалгаа:*** Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөөлж болохуйц тодорхой хэсгийг сонгон авч дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх замаар бодлого хөтөлбөрийн үр дүнг дүгнэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь мэдээллийг тодорхойлж байна. Үндэсний статистикийн хороо нь тогтмол хугацааны давтамжтайгаар өрхөд суурилсан түүвэр судалгаануудыг зохион байгуулдаг бөгөөд эдгээр судалгаанууд нь өөр өөрийн гэсэн тодорхой зорилго, агуулгын хүрээнд боловсруулагдсан арга зүйг ашигладаг. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд дэлгэрэнгүй асуулгыг тэгш тоотой жилүүдэд ашиглаж байгаа бөгөөд энэ онуудад хүн амын эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийг судалж байна.

Албан ёсны статистик буюу Нийгмийн зарим үзүүлэлтийн 2021 оны мэдээллээр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 103.6 мянган иргэн (нийт хүн амын 3.3 хувь) байгаагийн 57.3 мянга нь эрэгтэйчүүд, 46.3 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлийн иргэдийн 42.8 хувь нь төрөлхийн, 57.1 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өндөр байгааг харуулж байна. Улаанбаатар хотын хувьд 2021 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 34.2 мянган иргэн байгаагийн 18.3 мянга нь эрэгтэйчүүд, 15.8 мянга нь эмэгтэйчүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо өсч байгаа нь хүн амын насжилт уртсаж байгаатай холбоотой. Учир нь өндөр настай хүмүүс хөгжлийн бэрхшээлд өртөх эрсдэл нь илүү өндөр байдаг. Мөн дэлхий даяараа өвчин архагших нөхцөл байдал хөгжлийн бэрхшээлтэй хавсрах нь, тухайлбал: чихрийн шижин, зүрх судасны өвчин, сэтгэцийн өвчин ихэсч байна. Зарим нэгэн оронд эрүүл мэндийн нөхцөл байдлын хандлага, орчны болон бусад хүчин зүйлсийн хандлага (авто замын осол, байгалийн гамшиг, зөрчилдөөн, хоолны дэглэм, бодисонд донтох) нь хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт нөлөөлдөг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, насаар авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлага байна. Энэ хандлага Улаанбаатар хотын хувьд ч адил байна.

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 34.2 мянган хүн амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 33.0 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 69.3 мянга буюу 66.9 хувь нь аймаг, орон нутагт амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзэхэд хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 19.9 хувь (20.6 мянга), ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.0 хувь (4.2 мянга) байна.

Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээнд 2021 онд давхардсан тоогоор 227.9 мянган иргэн хамрагдаж нийт 146.9 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хүрээнд 2021 онд Тэтгэврийн даатгалын сангаас 67.8

мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 183 тэрбум төгрөгийн, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 4578 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 23.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна. 2017 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ажлын байранд төлөх төлбөрт 1,0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бол 2018 оны эхний 5 сарын байдлаар нийт 497.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Монгол Улсад нийт 110.9 мянган иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, тэтгэмж авч байгаагийн 67.8 мянга буюу 61.1 хувь нь нийгмийн даатгалын сангаас, 43.1 мянга буюу 38.9 хувь нь нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авч байна. /2017 оны байдлаар/ 2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт Тогтвортой хөгжлийн зорилго 8 буюу “Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих”-д 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох зорилтыг дэвшүүлсэн.

Үндэсний статистикийн хорооны 2021 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны 19974 хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны хүн 3018 байгаа юм. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн 73285 байна.

“Ажил эрхэлдэг” хэмээн бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил эрхлэлтийн статусаар нь судлахад 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 20.1 хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч,1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад буюу албан хэвшилд гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, эсрэгээр албан бус хэвшилд ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал харьцангуй илүү байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас хэрэгжүүлдэг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 2021 оны гүйцэтгэлийг доор хүснэгтээр харуулав.

Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тогтмол буюу жил бүр тооцох боломжтой нэг эх үүсвэр нь ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа” юм. Судалгаанд хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг хувь хүний түвшинд тодорхойлдог бөгөөд үүнд: харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, хавсарсан, бусад ангилахаас гадна хөгжлийн бэрхшээл нь төрөлхийн эсвэл олдмол эсэхийг асуусан байдаг. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг хувь хүний түвшинд асуудаг учраас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлтүүдийг тодорхой алдааны түвшинд тооцох боломжтой юм. Хөдөлмөр эрхлэлтийн талаар ҮСХ-оос гадна судалгааны хувийн байгууллага, ОУ-ын байгууллагууд олон судалгаа хийдэг боловч нэгдмэл арга зүйгээр хангагдаагүй, үр дүн нь хоорондоо уялдаа муутай зэрэг хүндрэлүүд гардаг.

Тухайлбал, Азийн хөгжлийн банкны 2021 оны судалгааны үр дүнгээс харахад хөдөлмөр эрхэлдэг энгийн иргэн 63.6 хувь, хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй 16-аас тэтгэврийн насны 30.1 хувь байгаа нь эрүүл иргэдтэй харьцуулахад 2 дахин бага үзүүлэлт гэсэн бол Жайка-гийн 2014 тайлангаас үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны хүн 48489, түүнээс 26.4 хувь буюу 12802 нь ямар нэг байдлаар ажил эрхэлдэг бол 4.629 нь буюу 10 хувь нь хөдөлмөр эрхлэх хүсэлтэй байдаг харин хөдөлмөр эрхлэх боломжгүй, хүсэлгүй 29,963 нь буюу 64 хувь нь эзэлж байна гэжээ. Мөн

АХБ-ны 2016 онд РРТА төслийн хүрээнд зохион байгуулан явуулсан өрхөд суурилсан судалгаанд ХБ-тэй иргэдийн 5 хувь нь хөдөлмөр эрхэлдэг гэж тооцогджээ.

Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар орон нутагт 65.5 хувь, нийслэлд 16.7 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал орон нутагт өндөр байна. Үүнээс үзэхэд мал аж ахуй, өрхийн бизнес эрхэлдэг иргэдтэй холбоотой байна. Аймаг, сумын төвийн хөдөлмөр эрхлэлт тус бүр 18.9 болон 32.1 хувьтай байна. УБ хот, аймгийн төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин бага, сумын төв хөдөөд өндөр байгаа нь мал аж ахуй, өрхийн бизнес эрхэлдэг иргэдтэй холбоотой байна. Азийн хөгжлийн банкны 2016 оны судалгаанд хөдөө орон нутагт цалингүй мал аж ахуй эрхэлдэг, эрэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн олон байдаг тухай дурьдсан байдаг. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлыг салбараар нь үзвэл:

- Улсын байгууллага, хувийн секторт 1792 хүн буюу 14.0 хувь
- Хувиараа хөдөлмөр эрхэлдэг, албан бус 7284 хүн буюу 56.9 хувь
- Өрхийн аж ахуй, орлогогүй 2100 хүн буюу 16.4 хувь
- Тодорхоогүй, тогтмол бус хөдөлмөрийн 1626 хүн буюу 12.7 хувь гарсан байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төвийн судалгаагаар нийт төрийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэн 32 (УБ хотод 24), хувийн аж ахуйн нэгжид 128 хүн ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хийсэн судалгаагаар 84 хувь нь өөрсдөө ажлаасаа гарсан гэдэг боловч хөдөлмөрийн насны байпдыг харахад 70 хувь орчим нь хөдөлмөрийн насны иргэд байдаг. Эдгээр иргэдийн гуравны хоёр нь өмнө ажил эрхэлдэг байжээ. Хөдөлмөр зуучлалын албаар зуучилсан иргэд цөөн байдаг байна.

Хууль эрх зүйн орчин. Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулах, шинжлэн судалж, тооцон гаргахад дараах хууль эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, дэлхийн болон үндэсний хэмжээний хөгжлийн стратегийг үндэслэл болгон ажиллаж байна. Үүнд:

- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан/. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг.

Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд

чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэмсэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн хамрагдах, оролцохыг дэмжих, соёл урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулах, авъяас чадварыг нь нээн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд урлаг, соёлын бүтээл хүртээмжтэй байх асуудлыг боловсронгуй болгох зорилгоор 2016 онд Улсын Их Хурлаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна. Тус хуулийг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмнө тулгамдаж байгаа эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмж гэх мэт олон асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэс бүрдээд байна.

Дээр дурдсан конвенц, хууль, урт болон богино хугацааны хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх, бодлогыг төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг ашиглаж байна.

Баримт бичгийн шинжилгээ

Монгол Улсын хэмжээнд Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 4644 аж ахуйн нэгж, байгууллага байна /2021 оны 12 дугаар сар/. Эдгээр байгууллагууд нийт 5896 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байна. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагуудыг авч үзвэл 37.3 хувь буюу 1734 байгууллагад 4028 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Үлдсэн 62.7 хувь буюу 2910 нь 25-аас доош ажилтантай байгууллагууд байгаа ба тэдгээрт 1868 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна.

25, түүнээс дээш ажилтантай 1734 байгууллагын нийт ажилчдын тоо 220475 байгаа ба Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын дагуу 8819 орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжтой хэдий ч 4028 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Үүнээс үзэхэд хуулийн заалтыг бүх байгууллагууд хэрэгжүүлбэл 4791 орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломжтой байна[4].

Монгол Улсад нийт 110.9 мянган иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, тэтгэмж авч байгаагийн 67.8 мянга буюу 61.1 хувь нь нийгмийн даатгалын сангаас, 43.1 мянга буюу 38.9 хувь нь /2021 оны байдлаар/ нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авч байна. Үндэсний статистикийн хорооны 2021 оны мэдээгээр 103630 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа ба мэдээллийн сангуудын тоо баримт зөрүүтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй ажил олгогч

Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж буй ажил олгогчид бүгд тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан, нийгмийн даатгалд хамруулж байгаа нь сайшаалтай байлаа. Харин тэдгээр байгууллагуудын 72.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Хөдөлмөрийн тухай хуулийн 71.1 дэх заалтын дагуу богиносгосон цагаар ажиллуулдаггүй, 66.1 хувь нь тэднийг ажилдаа ирж буцахад дэмжлэг үзүүлдэггүй байна. Мөн судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй байгууллагуудын 77.4 хувь нь хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон ажлын байрны тохируулгыг хийж өгөөгүй, зарим байгууллагууд тохируулга хийх

[4] Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

шаардлагагүй гэсэн хариултыг өгчээ. Энэ нь мөн тухайн байгууллагад ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн дотор эрхтнээр, даралт ихсэх өвчнөөр, сахарын өвчнөөр групп тогтоолгосон иргэд байсантай холбоотой.

ХБИ-ийг ажиллуулах орон тоонд төлбөр төлж буй байгууллагууд Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулбал зохих орон тоонд төлбөр төлж буй 25 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан ба нийт 75 орон тоонд сар бүр төлбөр төлж байна. Төлбөр төлж буй байгууллагуудын 64 хувь нь 1 жил хүртэлх хугацаанд, 24 хувь нь 1-2 жил, үлдсэн 12 хувь нь 2-оос дээш жил төлж байна. Мөн тэдгээр байгууллагуудын 80 хувь нь цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах сонирхол байна хэмээн хариулжээ.

Дүгнэлт

Нийгэм, эдийн засгийн болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бусадтай харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх боломж харьцангуй хязгаарлагдмал байдаг. Энэхүү судалгаагаар аж ахуйн нэгж, байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хоёр талаас нь судалж үзлээ. Хөгжлийн бэрхшээл гэдэг нь хувь хүндээ биш нийгэмд байгаа гэж үздэг “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын ойлголт Монгол Улсад хараахан нийтлэг болоогүй байгаа билээ.

Тэр утгаараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сул дорой хүмүүс гэсэн ойлголт давамгайлж, тэдний нийгмийн оролцоо бодит байдал дээрээ хангагдаж чадахгүй байсаар байна. Судалгаанд Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг үндэслэн 25 ба түүнээс дээш ажилтантай 116 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсаны 53.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих тоонд ажиллуулдаг, 21.6 хувь нь ажиллуулбал зохих орон тоонд төлбөр төлдөг, 25 хувь нь хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй байгууллагууд байлаа. Хөдөлмөрийн насны нийт 144 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг судалгаанд хамруулсан ба тэдний 72 нь хөдөлмөр эрхэлж буй, 72 нь ажилгүй байгаа иргэд байлаа.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 54.7 хувь нь эмэгтэй, 45.3 хувь нь эрэгтэй байна. Анхдагч мэдээлэл цуглуулахдаа чанарын судалгааны арга болох ганцаарчилсан ярилцлагын арга, хоёрдогч тоон мэдээллийн шинжилгээнд баримт бичиг судлалын аргыг ашигласан. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүний хүний эрхлэх боломжийг зохицуулж өгсөн байдаг.

Энэхүү зүйл заалтыг төрийн болон бизнесийн байгууллагууд зарим нь хэрэгжүүлж зарим нь огт хэрэгжүүлэхгүй байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх, тэднийг ажлын байранд авч ажиллуулахдаа хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль эрх зүйн орчин болон хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээг сайн мэдэх нь чухал учраас үүнтэй холбоотой мэдээллийн хүртээмж болон хяналтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Мөн хөгжлийн бэрхшээлийн талаарх статистикий тоо мэдээ үнэн зөв байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэхэд баримтад тулгуурласан бодлого боловсруулах боломжийг бүрдүүлж өгдөг. Тиймээс хөгжлийн бэрхшээлийн

талаарх нэгдсэн мэдээллийн сан шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч ажиллуулах квотын тогтолцоо үйлчилдэг. Үүнийг хэрэгжүүлэгч нь аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс болович хууль хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцох үүрэг нь Мэргэжлийн хяналтын газарт байдаг бөгөөд эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа уялддаггүй учир хууль зөрчигч нарт хариуцлага хүлээлгэж чадахгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх нөхцөл боломж бүрэн бүрдээгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй байгууллагаас, мөн тухайн байгууллагад хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс судалгаа авах явцад анзаарагдсан нэг зүйл нь дотор эрхтнээр, даралт ихсэх өвчнөөр, сахарын өвчнөөр групп тогтоолгосон иргэд олон байлаа. Дотор эрхтний өвчнөөр групп тогтоолгосон иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэсэн ойлголтоос ангид авч үзэн ойлголт, тодорхойлолтыг дахин шинэчлэх нь зүйтэй санагдлаа. Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах нь нэмэгдэж байгаа ч нийгмийн хариуцлагаа ухамсарладаггүй байгууллагууд цөөнгүй байна. Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэд хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол дүүрэн байдаг хэдий ч нийгмийн болон бусдын хандлага сөрөг байдаг нь тэдний урам зоригийг мохоодог байна

Ном зүй

1. Ц.Оюунбаатар, Х.Оюунцэцэг, Э.Энхжаргал Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт 2017 он Улаанбаатар хот,
2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа мэдээллийн лавлах 2017 он Улаанбаатар хот,
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх нь” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй сэргээн засах тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх нь” эрдэм шинжилгээний онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл 2017 он
4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем 2021 он, Улаанбаатар хот
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Улаанбаатар хот
6. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем 2021 он. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. Улаанбаатар хот
7. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем 2021 он Нийгмийн халамжийн тухай хууль. Улаанбаатар хот
8. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем 2021 он Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль. Улаанбаатар хот
9. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn
10. ХБХүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх МУ-ын анхдугаар илтгэл 2011 он, Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

LEGAL ENVIRONMENT FOR ENVIRONMENTAL IMPACT STUDY: CURRENT IMPLEMENTATION STATUS

Ж.Бат-Эрдэнэ
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Bat-Erdene J
Master student of the University of Internal Affairs, Mongolia

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого ба байгаль орчны асуудлын уялдаа холбоо, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо, өнөөгийн байдал, ангилал, төрөл, гүйцэтгэх үүрэг, хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийн талаар товч авч үзсэн болно.

Abstract: This article provides a brief overview of the interface between Mongolia's sustainable development policy and environmental issues, the environmental impact assessment system, the current situation, classification, types, roles, legal environment and its implementation.

Түлхүүр үгс: Байгаль орчны стратегийн үнэлгээ, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ.

Key words: Strategic environmental assessment, environmental condition assessment, cumulative environmental impact assessment, environmental impact assessment.

Удиртгал:

Байгалийн баялгийн тэгш хувиарлалт, түүний ашгийг ард түмэнд хүргэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал олон жил нийгмийн томоохон сэдэв болсоор ирсэн.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн хоёр арга хэлбэр байдгийн нэг нь хууль, стандартаар хянаж шалгах, эсхүл зах зээлийн эдийн засгийн хөшүүргийг ашиглан байгалийн нөөц ашиглалтыг зохицуулан хамгаалах явдал байдаг.

Манай Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн байгаль орчныхоо бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх, эрх зүй, эдийн засаг, удирдлага зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэх талаар онцгой анхаарал хандуулж, холбогдох эрх зүйн орчныг бий болгох ажлыг 1995 оноос эхлэн эрчимтэй эхлүүлж, энэ салбарт одоогийн байдлаар байгаль орчинтой холбоотой нийт 26 хууль, 370 орчим стандарт, нэмэлт 75 эрх зүйн баримт бичиг холбогдох дүрэм журам, боловсруулан мөрдүүлж байна.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг анх 1998 онд баталж, 2012 онд шинэчлэн найруулсан бөгөөд тус хуулиар 4 төрлийн үнэлгээг зохицуулж байна. Эдгээр нь Байгаль орчны стратегийн үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ болно.

Байгаль орчинд хохирол, сөрөг нөлөөлөл тохиолдохоос урьдчилан хамгаалж болох оновчтой арга механизм нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх асуудал юм.

Үндсэн хэсэг.

Монгол улс анх 1995 онд "Байгаль орчныг хамгаалах тухай" хуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх асуудлыг анх удаа хуульчлан тусгасан.

Ардчилсан Үндсэн хууль буюу 1992 оны Үндсэн хуулийн зорилго,

зарчим, агуулгад нийцүүлж 1995 онд баталсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь байгаль орчны салбарын суурь хууль юм. Тус хууль 1998 оноос хойш 24 удаа нэмэлт, өөрчлөлт орж улам баяжуулж, хийдэл, давхардал, зөрчлийг нь арилгасаар ирсэн байна.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 1998 онд анх баталж, 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр шинэчилсэн найруулга хийж дахин баталсан. Тус хуульд 2012 оноос хойш 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх үйл ажиллагаа нь дараах эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулагдаж байна. Үүнд:

д/д	Баримт бичгийн төрөл	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Зохицуулах харилцаа
1	**Хууль**	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995-03-30 Дагаж мөрдөх огноо 1995.06.08 Төлөв 24 нэмэлт өөрчлөлт;	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулна
2		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль */Шинэчилсэн найруулга/*	2012.05.17 Дагаж мөрдөх огноо 2012.06.21 Төлөв 2 нэмэлт өөрчлөлт;	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулна.
3	**Засгийн газрын тогтоол**	“Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”	2013.11.16 №374	Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
4		Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”	2013.11.16 №374	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, түүнтэй холбогдсон шийдвэр гаргах, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна
5		Байгаль орчныг хамгаалах	2001.06.27 №136	Төрийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих болсонтой

		хөрөнгийн байршлын тухай /Засгийн газрын 2001 оны 136 дугаар тогтоол/		холбогдуулан гадаад, дотоодын төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувь хүмүүсээс байгаль орчныг хамгаалах чиглэлээр хандивласан хөрөнгийг төрийн бус байгууллагын дансанд байршуулж, уг хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж жил бүр Засгийн газарт танилцуулж ажиллахыг Байгаль орчны сайдад даалгасан.
6	**Сайдын тушаал**	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам	Байгаль орчны сайдын 2006.06.21 №195	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон тайланд үнэлгээний шинжилгээ хийх, эдгээр харилцаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулна
7		Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.10.29 А/618	Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна
8		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний комисын ажиллах журам	Байгаль орчны сайдын 2006-04-27 №119	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.4-т заасны дагуу томилогдсон комисс энэхүү журмыг мөрдөж ажиллана.
9		Уул уурхайн ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015.03.30 А-138	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 417 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ыг УИХ-аас 2012 оны 5 дугаар сард шинэчлэн батлагдсан байгаль орчны багц хуулиуд болон өнөөгийн мөрдөж буй бусад хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамтай нийцүүлэх, нөхөн сэргээлтийн талаарх орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололт, гадаадын улс орнуудын туршлагыг судлан харьцуулалт хийх, боломжтойг нь өөрийн орны нөхцөлд тохируулан аргачлалд тусгах, өмнөх аргачлалд тусгагдаагүй газрын тос, цацраг

				идэвхт ашигт малтмалын ордыг нөхөн сэргээх аргачлалыг шинэчлэн боловсруулах харилцааг зохицуулна.
10		Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019.08.28 А/181,А458 дугаар хамтарсан тушаал	Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай болон холбогдох бусад хуулийн хүрээнд уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хаалтын үйл ажиллагаанд шаардагдах бэлтгэл ажил болон тэдгээрийн хэрэгжилтийг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.
11		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.01.06 А-03	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.
12		Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2010.05.27 А-156	Эдэлбэр газарт учруулах хохирлын үнэлгээг тооцох, Хөрсний экологи-эдийн засгийн үнэлгээ, хохирол тооцох, Ургамлын нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ, хохирол тооцохдоо тус аргачлалыг баримтална.
13		Байгаль орчны аудит хийх эрх олгох	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.12.25 А/809	Байгаль орчны аудит хийх эрх олгох, сунгах, цуцлах болон байгаль орчны аудитын мэргэшсэн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
14		Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.01.06 А-04	Төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах төрийн сангийн тусгай дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавихтай холбогдсон бусад харилцааг зохицуулна.
15		Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал	Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010.05.10	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 болон 15.1.3, "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1.8 мөн 39 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтыг

			А-132/112 дугаар хамтарсан тушаал	хэрэгжүүлэхэд "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлыг тооцоход энэхүү аргачлалыг ашиглана.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийн талаарх дүн шинжилгээ:

Давхардал: Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд давхардуулан хуульчилсан эсэх:

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
1	**Байгаль орчныг хамгаалах тухай хууль** /1995.03.30/	**7 дугаар зүйл.Байгаль орчны үнэлгээ** 4.Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	**12 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгох, хүчингүй болгох** 12.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.6-д заасан тусгай зөвшөөрлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын аж ахуйн нэгжид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Дүгнэлт, санал: Агуулгын хувьд давхардуулан хуульчилсан тул Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хүчингүй болгох, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эшлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
2	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.01/	**9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах; **39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг** 39.2.Байгаль орчныг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.5, 39.1.7.3-т заасан баримт бичгийг

		хүлээн авснаасаа хойш 30 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ

Дүгнэлт, санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг болон Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага буюу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага менежментийн төлөвлөгөөг баталж зөвшөөрөл өгөхөөр агуулгын хувьд давхардуулан хуульчилсан байна. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгох.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
3	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.01/	**9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.15.Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	**39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг** 39.8.Энэ хуулийн 38.1.8, 39.1.9-д заасан тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Дүгнэлт, санал: Агуулгын хувьд давхардсан боловч нэр томьёоны хувьд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэж өөр өөрөөр хуульчилсан байна. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 15 дахь хэсгийн **“**байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
4	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.01/	**7 дугаар зүйл.Нөлөөллийн үнэлгээ** 7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. 8.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана: 8.4.1.төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал; 8.4.2.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн; 8.4.3.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж; 8.4.4.төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглах зөвлөмж;

		8.4.5.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ хийхээр заасан бол төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ; 8.4.6.газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгаллын арга хэмжээ;
	Газрын хэвлийн тухай хууль /1988.11.22/	**41[1] дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх** 1.Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор газрын хэвлийг болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. 2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг арилгах, ашигт малтмалын орд, түүний хэсэг дэр малтсан газрыг дарах буюу цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах, хөрсийг нь нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дүгнэлт, санал: Газрын хэвлийн тухай хуулийн 41[1] дүгээр зүйлд заасан үнэлгээний асуудал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуульд тусгагдсан. Харин тус хуульд заасан ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ гэдэгт юуг хамааруулах нь тодорхойгүй байна. Иймд Газрын хэвлийн тухай хуулийн 41[1].2 дэх хэсгээс “...болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ” гэснийг хасах, тус зүйлд заасан магадлан шинжилгээ гэдэгт юуг хамааруулахыг тодорхойлж бусад хуульд нийцүүлэх, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг эшлэх.

Зөрчил: Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой, хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
1	**Байгаль орчныг хамгаалах тухай хууль** /1995.03.30/	**9 дүгээр зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ** 3.Нөлөөллийн үнэлгээний зардлыг захиалагч этгээд санхүүжүүлнэ.
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/	**8 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ** 8.6.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг **төсөл хэрэгжүүлэгч** хариуцна.

Дүгнэлт, санал: Дээрх 2 хуульд үнэлгээний зардлыг нэг этгээд санхүүжүүлэхээр ижил зохицуулсан байна. Иймд нэг нэр томьёог хэрэглэх, захиалагч этгээд эсвэл төсөл санхүүжүүлэгч гэж аль нэг үгийг сонгож хэрэглэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
2	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.01/	7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. **9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.1.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна. 9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна. 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн **байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан** төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	**38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг** 38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах; 38.1.2.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах; 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах;

Дүгнэлт, санал: Ашигт малтмалын тухай хуульд байгаль хамгаалах төлөвлөгөө гэсэн ойлголт байдаггүй, ийм төлөвлөгөө батлагддаггүй байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг нэр томъёоны зөрүүтэй зохицуулсан байна. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн байгаль хамгаалах төлөвлөгөө гэсний байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болгож өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
3	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.01/	**9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.5.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	**28 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах** 28.1.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2-оос доошгүй жилийн өмнө түүнийг эзэмшигч нь төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу хугацаа сунгуулах тухай өргөдөл гаргаж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана: 28.1.3.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянасан тухай баримт.

Дүгнэлт, санал: АМТХ-ийн 28 дугаар зүйлд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах бичиг баримтыг бүрдүүлэхдээ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хавсаргахаар заасан. Гэтэл БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалтад Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ гэж заасан байна. Иймд АМТХ-ийн 28 зүйлийн 28.1.3 дах хэсэгт заасан нэр томьёо нь БОНБҮТХ-ийн нэр томьёотой уялдахгүй байгаа тул Ашигт малтмалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дах заалтад заасныг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө гэж өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
4	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.17/	**9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.1.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	**38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг** 38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;

Дүгнэлт, санал: АМТХ-ийн 38.1 дэх хэсэгт тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулахаар заасан нь БОНБҮТХ-ийн 9.1 т заасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчныг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна гэсэнтэй уялдахгүй байна. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
5	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын**	**10 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ** 10.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж нь ерөнхий үнэлгээнд заасан хугацаанд

	үнэлгээний тухай хууль /2012.05.01/	үнэлгээний ажлын тайланг холбогдох бусад бичиг баримтын хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ. **8 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ** 8.3.Энэ хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. **9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна. 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах; 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах; 38.1.4.энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

Дүгнэлт, санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд менежментийн төлөвлөгөө нь нарийвчилсан үнэлгээний салшгүй хэсэг гэж заасан бөгөөд менежментийн төлөвлөгөөг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж батлуулахаар заасан байна. Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд менежментийн төлөвлөгөөг хайгуулын талбай байрших орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлж тухайн сум дүүргийн засаг дарга батлахаар зөрүүтэй зохицуулжээ. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
6	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.17/	**9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	**38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг** 38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах;

		38.1.4.энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

Дүгнэлт, санал: Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.3 дэх заалтад энэ хуулийн 38.1.1 дэх хэсэгт заасан тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах гэсэн нь БОНБҮТХ-ийн 9.3-т заасан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлаж төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно гэсэнтэй уялдахгүй байна. АМТХ-ийн 38.1.4-т байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хүргүүлэхээр заасан бол БОНБҮТХ-ийн 9.3-т байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийсэн байгууллага нь хүргэхээр заасан. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
7	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.17/	**9 дүгээр зүйл.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** 9.14.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12, 9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ хуулийн 9.15-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ. 9.15.Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
	Ашигт малтмалын тухай хууль /2006.07.08/	**38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг** 38.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

Дүгнэлт, санал: АМТХ-ийн 38.3-т Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна гэж заасан бол БОНБҮТХ-ийн 9.14, 9.15-д заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан журмаар зохицуулжээ. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.14 дэх заалтыг “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12, 9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 9.15-д заасан журмын

дагуу шийдвэрлэнэ” гэсэн агуулгаар өөрчлөх.

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
8	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.17/	**7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ** 7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.
	Газрын тухай хууль /2002.06.07/	**34 дүгээр зүйл. Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам** 34.2.Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 90 хоногт багтаан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэсний дараа тэдгээртэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.

Дүгнэлт, санал: Газрын тухай хуулийн 34.2 дахь хэсэг нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсныхаа дараа хийлгэхээр заасан байхад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дахь хэсэгт газар эзэмших, ашиглах эрх авахаасаа өмнө үнэлгээ хийлгэх талаар заасан нь хоорондоо зөрчилджээ. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дахь хэсгийг Газрын тухай хуульд нийцүүлэх.

Хийдэл: Хуульд байх шаардлагатай зохицуулалтыг тусгах эсэх:

д/д	Эрх зүйн актын нэр	Хуулийн заалт
1	**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** /2012.05.01/	**7 дугаар зүйл.Нөлөөллийн үнэлгээ** 7.3.Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ. **8 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ** 8.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ. 8.6.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна. **10 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ** 10.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж нь ерөнхий үнэлгээнд заасан хугацаанд үнэлгээний ажлын тайланг холбогдох бусад бичиг баримтын хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.

Дүгнэлт, санал: Төсөл хэрэгжүүлэгч нь үнэлгээний компани буюу нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжээр үнэлгээ

хийлгэдэг. Үнэлгээ хийлгэхдээ зардлаа төлдөг бөгөөд тухайн төсөл батлагдсан эсэхээс үл шалтгаалан төлбөрөө төлдөг юм байна. Төсөл нь батлагдаагүй байсан ч төлбөрөө буцаан авч чаддаггүй. Иймд төсөл нь батлагдаагүй тохиолдолд төлбөрийн тодорхой хувийг буцаах талаар зохицуулалт тусгах.

Ерөнхий дүгнэлт

Манай улс нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар мэргэжлийн 131 байгууллагад олгож, тус өдрийн байдлаар нөлөөллийн ерөнхий үнэлгээний 9483 дүгнэлт, нөлөөллийн үнэлгээний 6541 тайлан, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний 2 тайланг тус тус гарган ажилласан байна.

Иргэд, олон нийтийн байгууллага, төр засгийн зүгээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж иргэдийн эрхийг улам бататгах асуудлыг олон жил ярьж хэлэлцэж ирсний үр дүнд Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан. Энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй..." гэсэн зохицуулалт орсон.

Үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Төлөвлөгөө батлах тухай" 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах замаар 2020 онд багтаан нийцүүлэх, холбогдох заалтуудыг боловсронгуй болгохоор төлөвлөгөө баталсан хэдий ч одоогоор тус хуулийн төсөл Улсын Их Хурлаар батлагдаагүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд давхардуулан хуульчилсан эсэх, нэр томъёо, зүйл, заалт зөрчилдөж байгаа эсэх асуудлыг судлахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох зүйл, заалт нь Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хуулиудын тодорхой зүйл заалтуудтай давхардсан 4 зохицуулалт, 8 зөрчил, 1 хийдэл байна гэж үзэж байгаа тул дээрх 13 давхардал, хийдэл, зөрчлийг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нийцүүлэх.

Мөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь төслийн үйл ажиллагааг төлөвлөх, сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутагтай хамтын ажиллагаа эхлүүлэхэд чухал үйл явц хэдий ч бодит байдал дээр цөөнгүй тулгамдсан асуудлууд байгаа тул Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үйл ажиллагааны ил тод байдал, тайлагналыг сайжруулах, төслүүдийн төрөл, нөлөөлөл, ангилал, хамрах хүрээнээс хамааруулан иргэдийн оролцоог хангах асуудлыг ялгаатай тусгах зэрэг асуудлыг шийдвэрлэх нь энэ салбарын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байна.

Санал

Ковид-19 цар тахлаас шалтгаалан 2020, 2021 онуудад мэргэжлийн эрх бүхий байгууллагуудын боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд олон нийтийн оролцоог хангах үйл явц зогсонги байдалд орж улмаар улс орны эдийн засагт нэмэр болохуйц төсөл, бүтээн байгуулалтуудын үйл явц зогсонги байдалд ороод байгаа тул Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 66 дугаар "Төлөвлөгөө батлах тухай" тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох хууль

тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, улс орны эдийн засагт нэмэр болохуйц төслүүдийг хөдөлгөх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

Хууль тогтоомж:
1.Монгол Улсын Үндсэн хууль
2.Байгаль орчныг хамгаалах тухай хууль
3.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
4.Ашигт малтмалын тухай хууль
5.Газрын тухай хууль
6.Газрын хэвлийн тухай хууль
Сэтгүүл, эмхэтгэл
7.Төрийн мэдээлэл. 1992. №1
8.Төрийн мэдээлэл. 1995. №5-6
9.Төрийн мэдээлэл. 2012. №22
Цахим эх сурвалж:
10.https://www.eic.mn
11.https://mn.wikipedia.org/wiki
Бусад ном, судалгаа:
12.Сэнгэдорж. Экологийн эрх зүй. УБ хот. 2001 он.
13.Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 он.
14.Т.Оюунчимэг, Ц.Мөнхсайхан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ. УБ хот. 2013 он.

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН МӨНГӨН ХӨРӨНГӨӨС СУУТГАЛ ХИЙХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ХҮНИЙ ЭРХ

Б.Замбага
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахлах дэслэгч
Zambaga.B
Lecturer, Department of Decision execution, the School of Court Decision Execution, University of internal affairs, Master in law, senior lieutenant

Хуульч хүн жинхэнэ хүн байх ёстой.
Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимид.

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын нэн тэргүүний эрхийн тухай ойлголт, хамгаалах арга замын талаар судлан үзлээ.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэх хуудас, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх, зээлийн үйл ажиллагааны зарчим, амьдралын наад захын эрх, амьжиргааны түвшин, хүний эрх.

Abstract: During the course of the executive proceedings, the court examined the concept of the parties' priority rights and ways to protect them.

Keywords: Decision Executive Notice Page, court ruling must be fulfilled, the principle of loan activity, at least the right to life, the level of living, human right.

Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхийн турш бүх л улс орны эрдэмтэд мэргэд анхаарлынхаа төвд байлгаж, зөв оновчтой онол, шийдлийн эрэлхийлэлд оюун ухааныхаа царыг сорьж ирсэн судлагдахуунуудын нэн чухалд хүний эрхийн асуудал зүй ёсоор тооцогддог[1] гэж хууль зүйн ухааны доктор, профессор Д.Зүмбэрэллхам өөрийн судалгааны ажилдаа дурджээ.

Монгол Улсын Үндсэн хууль[2] 1992 онд батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан бусад хууль тогтоомжийг уялдуулах, хэрэглэхэд хялбар, оновчтой зохицуулалтыг бий болгох, ингэхдээ хүний эрхийг бэхжүүлэх ардчилсан шинэчлэл, ололтыг бататгаж, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг хүний эрхийг хангах, иргэдэд үйлчлэх, жигд шуурхай байх боломжийг бүрдүүлэх үзэл баримтлалын хүрээнд эрх зүйн шинэчлэлийг хийж эхэлсэн байдаг.

Тэгвэл эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэгч, хүний эрх, эрх чөлөөг дээдлэгч, ардчилсан Үндсэн хуульт манай улсын хувьд шүүхээр баталгаажуулсан хүний эрхийг хангах, хамгаалах ажиллагааны явцад “Банк[3]” нь төлбөр төлөгчийн нэн тэргүүний эрх, ашиг сонирхлыг гэрээний үндсэн дээр

[1] Зүмбэрэллхам. Д, Гэм буруугүйн презумпцийн зарчмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал. Уб., 2001. 3 дахь тал.
[2] Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.
[3] Банкны тухай хууль. Уб., 2010. Төрийн мэдээлэл эмхэтгэл №10. 3 дугаар зүйлийн 3.1.1."банк" гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг.

хөндөх эрх зүйн зохицуулалттай байгааг анхаарах, засч залруулах цаг ирсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгаа, төлбөр төлөгчдөөс авсан санал асуулгаас харагдаж байна.

Хүн, хуулийн этгээдийн шүүхээр баталгаажуулсан эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааны явцад төлбөр төлөгчийн нэн тэргүүний эрх буюу хүнсний болон хүнсний бус хэрэглээний эрхийг шийдвэр гүйцэтгэгчийн баталгаажуулах арга хэмжээ авагдсан үед банк болон банк бус санхүүгийн байгууллага нь уул эрхийг дээдлэх, зөрчигдөхөөс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжоороо баталгаажуулах шаардлагатай байгааг энэхүү судалгаагаараа харуулахыг зорилоо.

Учир нь хүний эрхийн ихэнх зөрчил далд буюу бүр үл анзаарагдах байдалд[1] байдгийн илрэл нь салбар хуулиудыг хэрэглэх явцад тэдгээрийн давхцал, *“амьдралын бичигдээгүй хуулиуд”-аар*[2] хүний суурь үндсэн эрх зөрчигдөж байгааг бид өнөөг хүртэл анзааралгүй явжээ.

Монгол Улсын Үндсэн хууль[3]-ийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар *Иргэн, хуулийн этгээд нь* эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй.

Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”-хаар, хүн, хуулийн этгээдийн хөндөгдсөн эрхийг зөвхөн шүүх сэргээн эдлүүлэх эрхийг хуульчилсан бөгөөд энэ чиг үүрэг нь шүүх эрх мэдлийн нэг гол шинж[4] болон төлөвшсөн.

Шүүхээс гарсан шийдвэрүүдийг гүйцэтгэх /биелүүлэх/ явдал нь төрийн байгууллагын хүний эрхийн хангах, хамгаалах үйл ажиллагааны хамгийн чухал, хариуцлагатай ажил гэдэгтэй хэн бүхэн санал нийлэх бизээ. Учир нь шүүхээс шударга шийдвэр гарах, түүнийг хэрхэн бүрэн дүүрэн, цаг хугацаанд нь гүйцэтгэхээс эцсийн дүндээ хүний эрх, эрх чөлөө бодит зүйл болох нь хамааралтай байдаг. Үүнийг Бүгд Найрамдах Солонгос улсын дээд шүүхийн 16 дахь ерөнхий шүүгч Ким Мён Су /Kim Myeong-soo/ “Гайхалтай мэргэн шүүхийн шийдвэр гарлаа ч шийдвэр гүйцэтгэлээр дамжин түүний үр дүн баталгаажихгүй бол тэр нь ердөө хэрэгцээгүй цаас төдий” гэж тодорхойлсон байдаг.

Хүний хөндөгдсөн эрх, ашиг, сонирхлыг сэргээн эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад банк дахь төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах, төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, зарим зөрчлийн талаар дэлгэрүүлэн авч үзье.

---

[1] Чимид. Б., Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. Уб., 2004. 73 дахь тал.

[2] Лүндээжанцан. Д., Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хувиарлалт. Уб., 2001. 19 дэх тал.

[3] Монгол Улсын Үндсэн хууль., УБ., 1992., Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.,

[4] Эрх зүй-Онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл. Уб., 2017. Цуврал 37. 15 дахь тал.

Ийнхүү шүүхээр баталгаажуулсан, хамгаалуулсан эрхийн хэрэгжилтийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ганцхүү шийдвэр гүйцэтгэгч[1] гүйцэтгэх буюу бусдын нөлөөнд үл автах зарчмын үндсэн дээр албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлдэг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

Иргэний хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үйл ажиллагааг хэлбэрэлтгүй гүйцэтгэх, төрийн үндсэн үүргийн хэрэгжилтийг хангах, хамгаалалтыг бүрдүүлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай[2] хуулийн 11 дүгээр зүйлд “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай[3] хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй” хууль зүйн императив зарчмыг үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэхээр баталгаажуулсан байдаг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хатуу тогтоосон, заавал биелэгдэх шинжтэй, зөрчигдсөн нөхцөлд төрийн албадлага хэрэглэх хэм хэмжээг тогтоохдоо хүний нэн тэргүүний эрхийг хөндөхгүйгээр зөвхөн хууль, тогтоомжид зааснаар хязгаарлаж болохоор хуульчилсан нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүхий л цаг хугацаанд хангах, дээдлэх, хамгаалах үүрэгтэйгээр боловсруулагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа[4]-ны явцад төлбөр төлөгчийн хөрөнгөөс банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, эсхүл үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс төлбөрийг албадан гаргуулахаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дарааллыг тогтоож, шүүхийн шийдвэрт заасан шаардлагыг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Дээрх дарааллын дагуу баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаас, цалин хөлс, бусад орлогоос, хөдлөх эд хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө *(гуравдагч этгээдэд холбогдох бараа, ажил үйлчилгээ нийлүүлсний төлбөрийг шаардах эрх, гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн шаардах эрх, оюуны өмчийг эзэмших, ашиглах, өмчлөх болон тэдгээртэй холбоотой шаардах эрх,*

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль., УБ., 2017., Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24., 270 дугаар зүйл., “Шийдвэр гүйцэтгэгч нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ”. Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Монгол Улсын иргэн байна.

[2] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Уб., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл №8.

[3] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

[4] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24. 6 дугаар зүйлийн 6.1., “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна. Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны хэргийн талаарх шүүхийн ошийдвэр гүйцэтгэх ажиллагаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” хамаарахаар хуульчилсан.

төлбөр төлөгчийн эдийн бус бусад хөрөнгө)-өөс, дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх төлбөрийн шаардлага хангахуйц хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг зохион байгуулдаг.

Эдгээр ажиллагаанаас хамгийн түгээмэл хийгддэг ажиллагаа болох төлбөр төлөгчийн банк дахь мөнгөн хөрөнгөөс суутгал хийх *(дансны зарлагын гүйлгээг хаах, дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих)*, цалин хөлс, бусад орлогоос суутгал хийх тухай тогтоолоор төлбөр гаргуулах ажиллагааг хэрэгжүүлэх үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас биш боловч бусад хууль (Банкны тухай хууль[1], Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль[2])-ийн хэрэгжилтийг хангах явцад төлбөр төлөгчийн буюу хүний нэн тэргүүний эрх, ашиг сонирхол дараах байдлаар хөндөгдөж байна. Шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичиг[3]-т заасан мөнгөн хөрөнгийн шаардлагыг хангах зорилгоор банк дахь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгөөс төлбөрийг гаргуулах ажиллагааг түгээмэл явуулдаг[4].

Шийдвэр гүйцэтгэгчид олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь хэсэгт заасан “Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих”, мөн хуулийн 50 дугаар зүйлийг удирдлага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

[1] Банкны тухай хууль. Уб., 2010. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.

[2] Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №27.

[3] Шүүхийн гүйцэтгэх хуудас гэдэг нь шүүхийн шийдвэр, шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэрийн үндсэн дээр олгогдсон баримт бичгийг хэлэх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн баримт бичиг юм. Гүйцэтгэх баримт бичгийн талаар дараах байдлаар хуульчилсан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Гүйцэтгэх баримт бичигт иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаархи шүүхийн шийдвэр, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр, шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж, шийдвэрийг үндэслэн олгосон гүйцэтгэх хуудас, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг гаргуулах тухай шийдвэр хамаарна”-аар, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дугаар зүйлийн 136.1-д “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна” гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 183.1.-д “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна” гэж тус тус хуульчилсан.

[4] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаар дамжуулан нийт 212 шийдвэр гүйцэтгэгчээс авсан судалгааны үр дүнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны 94,2 хувьд нь төлбөр төлөгчийн банк дахь мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах зорилгоор “Төлбөр төлөгчийн банк дахь мөнгөн хөрөнгөөс суутгал хийх тухай тогтоол” хүргүүлдэг гэж хариулсан байна.

ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/167 дугаар тушаалаар батлагдсан 36 дугаар маягтын дагуу Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих тухай шийдвэрийг хүргүүлж, эрхийг хэрэгжүүлэн ажилладаг.

Энэхүү эрхийн хэрэгжилтийг хангах ажиллагааны явцад арилжааны банк нь нэг талаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын, шийдвэр гаргасан шүүхийн хараат бус, шийдвэр нь гарцаагүй хэрэгжих зарчмыг хөндөж, нөгөө талаас төлбөр авагчийн шүүхээр баталгаажуулсан эрхээ хамгаалуулах эрхийг, төлбөр төлөгчийн "*нэн тэргүүний хүнсний болон хүнсний бус хэрэгцээгээ хангах эрх*[1]"-ийг гэрээний үндсэн дээр зөрчих боломжийг бүрдүүлсэн байдаг. Тухайлбал:

Нэг. Шийдвэр гүйцэтгэгчийн "Төлбөр төлөгчийн банк дахь хадгаламжийн болон харилцах данс битүүмжлэх, хасалт хийх тухай тогтоол[2]"-ын хэрэгжилтийг хангахдаа "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.1 дэх хэсэгт заасан төлбөр төлөгчийн эзэмшилд байгаа төлбөрт гаргуулж болохгүй орлогоос бусад мөнгөн хөрөнгийг, мөн хуулийн 86.3 дахь хэсэгт зааснаар төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлого нь банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд ордог (*цалин хөлс, бусад орлогоос суутгал хийгээгүй нөхцөлд*) бол төлбөрт суутгаж болохгүй орлогыг хасаж, бусад хэсгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлэх үүргээ зарим тохиолдолд хэрэгжүүлэхгүй, шийдвэр гүйцэтгэгчийн битүүмжлэх, данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоосон байхад шинээр данс нээх, зээл олгож шилжүүлэх тохиолдолд гарч байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн хүргүүлсэн тогтоолын дагуу төлбөр төлөгчийн "Данс" *("харилцах данс" гэж гэрээний үндсэн дээр банк, цахим мөнгө гаргах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан этгээдээс иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр нээсэн дансыг)*[3] дахь мөнгөн хөрөнгөөс суутгал хийлгүйгээр өөрийн банкны олгосон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд мөнгөн хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааг явуулж байгаа нь төлбөр төлөгчийн дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналтыг хэрэгжүүлэх буюу дансны хуулгаар баталгааждаг.

[1] Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. Уб., 1998. Төрийн мэдээлэл эмхэтгэл №2. "3 дугаар зүйлийн 3.1.2.хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг" хэлнэ гэж хүний нэн тэргүүний эрх буюу хэрэглээний доод хэмжээг тодорхойлох эрх зүйн үндэслэлийг тогтоож өгсөн байдаг.

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оын 08 дугаар сарын 31-ний өдрийн А/167 дугаар тушаалаар батлагдсан 36 дугаар маягтаас үзнэ үү.

[3] Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №27. 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсэг.

Хоёр. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн хөрөнгийн байдал, төлөх төлбөрийн гүйцэтгэлийн хугацаа, давтамжаас шалтгаалан “Цалин хөлс, бусад орлогоос суутгал хийх тухай тогтоол”-ыг ажил олгогч байгууллага, төлбөрт суутгаж болох орлогыг шилжүүлэх эрх бүхий этгээдэд суутгал хийх тухай тогтоол (*Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр*[1]) хүргүүлж, цалин хөлс, бусад орлогоос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.12, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2 дахь хэсэгт заасны дагуу нэг сарын цалин хөлс, бусад орлогын 50 хүртэлх хувийг төлбөрт суутган авдаг. Энэхүү ажиллагаа нь төлбөр төлөгчийн амьдрах нэн тэргүүний эрхийг хангах буюу хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хүндэтгэн, аюулгүй орчинд амьдрах, аж төрөх хууль зүйн баталгааг[2] удиртгал болгосон энэрэнгүй ёсны зарчмыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийн хүрээнд явагддаг ажиллагааны нэг төрөл юм.

Гэтэл төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос суутгал хийгээд үлдсэн цалин, хөлс, бусад орлогыг төлбөр төлөгчид олгох явцад тэтгэврийн, цалингийн болон бусад зээлийн эргэн төлөлтөд бүхэлд нь суутган авснаас шалтгаалан төлбөр төлөгчийн зүгээс гаргасан гомдол, мэдээллийн үндсэн дээр нотлогддог.

Банк дээрх хоёр үйлдэлдээ Зөрчлийн тухай хуульд[3] заасан хариуцлага хүлээдэг ч нэг талаас шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолд заасан дансанд мөнгөн хөрөнгө шилжүүлэх[4] үйл ажиллагааг хэрэгжүүлэггүй, нөгөө талаас төлбөр төлөгчийн цалин, хөлс, бусад орлогын үлдэх хувийг олгох дансны битүүмжлэлийг чөлөөлсөн нөхцөлд ийнхүү зээлийн эргэн төлөлтөд суутгах нь хууль зөрчихгүй үйлдэл боловч өрийн дарамтад оруулах, амь зуур, амьдрах нэн тэргүүний эрхийг зөрчиж байна. Банк нь өөрийн нэрийн өмнөөс олгосон “Зээл[5]”-ийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг[6] тодорхой хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлийг

[1] Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. Уб., 1994. Төрийн мэдээлэл эмхэтгэл №8. 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх хэсэгт заасан орлого нь төлбөр гаргуулж болохгүй орлогод хамаарахгүй тул суутгал хийх эрх нь нээлттэй байдаг.

[2] Нямсүрэн. Ч. Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2021. 114 дэх тал.

[3] Зөрчлийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24. Шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлээгүй, төлбөр төлөгч болон бусад этгээд (банканд)-д холбогдуулан ахлах шийдвэр гүйцэтгэгчээс 2021 онд 157 холбогдогчид зөрчил шалган шийдвэрлэх болон хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хариуцлага хүлээлгэсэн байна.

[4] Үндэсний төлбөрийн системийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №28. 5 дугаар зүйлийн 5.1.18."шилжүүлэг" гэж аливаа этгээдээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг;

[5] Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №27. 5 дугаар зүйлийн 5.1.1."зээл" гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр хүүтэй буюу хүүгүй бусад этгээдэд аливаа хэлбэрээр олгосон мөнгөн хөрөнгийг;

[6] Иргэний хууль. Уб., 2002. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7. 451 дүгээр зүйлийн 451.1.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ гэж зохицуулсан.

хэрэгжүүлэхийг шаардах эрхийн дагуу хийгдэж байгаа ажиллагаа ч гэсэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, шуурхай, үр нөлөөтэй байх, төрөөс гарах зардлыг багасгах, хадгаламж эзэмшигч, *харилцагчийн эрх ашгийг хамгаалах* зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах үүргээ хэрэгжүүлэхгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс шүүхийн шийдвэртэй төлбөр барагдуулах ажиллагааны явцад цалин хөлс, бусад орлогоос суутгал хийгээд үлдсэн хэсгийг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд суутгахдаа төлбөр төлөгч буюу зээлдэгчид амьдарч буй бүс нутгийн амьжиргааны баталгаажих түвшинтэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг олгодог байх нь төлбөр төлөгчийн Үндсэн хуулиар баталгаажсан нэн тэргүүний эрх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн хариуцлага ухамсарласан арга хэмжээ болно гэж үзлээ[1].

Гурав. Шийдвэр гүйцэтгэгчийн “Төлбөр төлөгчийн банк дахь хадгаламжийн болон харилцах данс битүүмжлэх, хасалт хийх тухай тогтоол[2]”-ын хэрэгжилтийг хангахдаа төлбөрт гаргуулж болохгүй орлогыг төлбөр авагчид шилжүүлдэггүй. Энэ нь шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолд битүүмжлэх, хасалт хийх хөрөнгийн үндэслэлийг тогтоож тогтоож өгсөн ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.9 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэгт зааснаар төлбөрийн шаардлагыг бүрэн хангасан нөхцөлд битүүмжлэлээс чөлөөлөх үндэслэл бүхий тогтоол гаргах, тогтоолын үндсэн дээр төлбөрт гаргуулж үл болон мөнгөн хөрөнгийг чөлөөлөх ажиллагаа хийхээр шаардаж байгаа нь хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчиж байна[3].

Учир нь “Банк” нь Шийдвэр гүйцэтгэгчийн суутгал хийх, битүүмжлэх, шинээр данс нээх эрхийг хязгаарласан тогтоолын дагуу төлбөр төлөгчийн “данс” дахь мөнгөн хөрөнгөөс төлбөрт гаргуулж болохгүй хөрөнгө, орлого болох гамшиг[4], аюулт үзэгдэл[5],

---

[1] Үүнийг арай өөр утгаар нь тайлбарлавал: Кают. Ё., Шпанглер. Э., Редал. П., Хелмхаген. Р., Наранчимэг. Д., Амарсайхан. Ц., Дүгэржав. Д., Баярмаа. Н.,Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Уб., 2010. 555-556 дахь тал. Иргэний хуулийн 277 дугаар зүйлд бэлэглэгчийн эрхийг “Бэлэглэгч нь өөрийн асрамжид байгаа этгээдэд амьжиргааны нэн тэргүүний хэрэгцээт хөрөнгийг бусдад бэлэглэх эрхгүй.” Хязгаарлаж өгсөн бөгөөд асран халамжлах үүрэг хүлээсэн этгээд хөрөнгөө бусдад бэлгэлснээр түүний асрамжид байгаа этгээд хүнд байдалд орох магадлалыг энэхүү заалтаар хориглосон байна. Хуулиар гэр бүлийн гишүүдийнх нь амьжиргааны зайлшгүй шаардлагыг баталгаажуулах үүднээс өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг нь хориглодогтой уялдуулан шүүхийн шийдвэрээр баталгаажуулсан төлбөр, банкны зээлийн эргэн төлөлтөд ч энэ хуулийн заалтыг удиртгал болгох нь зүйтэй гэж үзэж байна.

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оын 08 дугаар сарын 31-ний өдрийн А/167 дугаар тушаалаар батлагдсан 36 дугаар маягтыг үзнэ үү.

[3] Нямсүрэн. Ч., Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2021. 195 дахь тал. “Эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол” гэсэн онолын томьёоллыг хэрэглэсэн байна.

[4] Гамшгийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7. 4 дүгээр зүйлийн 4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

[5] Гамшгийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7. 4 дүгээр зүйлийн 4.1.2."аюулт үзэгдэл" гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин

осол[1], онцгой нөхцөл байдлын[2] улмаас үзүүлж байгаа тусламж, тэтгэлэг, хандивын мөнгөн хөрөнгө, төлбөр төлөгчийн илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, нэг удаагийн урамшуулал, ажлаас халагдсаны тэтгэмж, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, донорт олгож байгаа нөхөх олговрын мөнгө, нэмэгдэл хоол, амралт, сувиллын эмчилгээ, хиймэл эрхтэн хийлгэхэд зориулан олгосон зардал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний, тэжээн тэтгэгчээ алдсаны тэтгэмж, тэтгэвэр, хүүхдийн болон сургалтын байгууллагын тэтгэлгийн мөнгө, эрүүл мэндэд учруулсан хохирлын нөхөн төлбөр, хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу олгож байгаа тэтгэмж, тэтгэлэг зэрэг мөнгөн хөрөнгийг барьцаалахгүй байх үүргийг хэрэгжүүлэхгүй байгаас шалтгаалан төлбөр төлөгчийн зүгээс амаар болон бичгээр гаргах өргөдөл, гомдол их байдаг. Үүнээс шалтгаалан төлбөр төлөгч наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, ажиллагааг удаашруулах нөхцөл бүхний өргөдөл, гомдол ихээр гаргах шалтгаан болдог. Үүнтэй уялдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон иргэн хуулийн этгээдийн зүгээс гаргасан өргөдөл гомдлын судалгаанаас авч үзэхэд 2015 онд 780, 2016 онд 1117, 2017 онд 742, 2018 онд 753[3], 2019 онд 607[4], 2020 онд 533[5], 2021 онд 981[6] өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэжээ.

Өнгөрсөн оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтээс 57,2 хувь нь үндэслэл бүхий, 42,8 хувь нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн байна. Үндэслэлтэй гэж үзсэн 57,2 хувийн өргөдлийн агуулгаар нь ангилан үзвэл төлбөр гаргуулах агуулга бүхий өргөдөл 43,4 хувийг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хянуулах (*цалин хөлсний суутгал, дансны битүүмжлэл шалгуулах*) хүсэлт гаргасан 5,2 хувь, хүүхдийн тэтгэлэг гаргуулах өргөдөл гаргасан 7,5 хувь, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүйд тооцуулах 11 хувь, ажилд эргүүлэн томилуулах шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай 2 хувь, бусад агуулга бүхий өргөдөл 30,9 хувийг тус тус эзэлж байна.

гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;"

[1] Гамшгийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7. 4 дүгээр зүйлийн 4.1.3."осол" гэж уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;


[2] Гамшгийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7. 4 дүгээр зүйлийн 4.1.19."гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг;


[3] Шийдвэр гүйцэтгэх алба. Иргэн, захиргааны болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт. Уб., 2018. 8 дахь тал.

[4] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. 2019 оны үйл ажиллагааны тоон мэдээ. Уб., 2020. 11 дэх тал.

[5] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. 2020 оны үйл ажиллагааны тоон мэдээ. Уб., 2021. 10 дахь тал.

[6] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх алба. Иргэний, Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт. Уб., 2022. 14 дэх тал.





Дүгнэлт:

Нийгэм, эдийн засаг хөгжихийн хэрээр эрх зүйн харилцааны агуулга, эрх зүйгээр зохицуулах хамгаалах, хууль зүйн хэрэглээг дээшлүүлэх шаардлагатай байгааг дээр дурьдсан жишээгээр батлаж болохоор байна. Үндсэн хуулиар баталгаажуулж, бусад хуулиар бэхжүүлсэн хүний эрх, эрх чөлөөг улам баталгаатай болгохын тулд шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх баталгаажуулах арга хэмжээ авагдсан нөхцөлд хүний нэн тэргүүний эрх, ашиг сонирхлыг хөндөхгүй байх, эрх зүйн актыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Үндсэн чиг үүргийнхээ хүрээнд хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хууль, тогтоомжийн хэрэглээ, зохицуулалтаас шалтгаалан зарим нөхцөлд шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцдаа хүний эрхийг зөрчил гаргаж байгааг иргэн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн биелэлт[1], уг ажиллагаанд гаргасан өргөдөл, гомдлын

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх алба. Иргэний, Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт. Уб., 2022. 9, 15 дахь тал. “Улсын хэмжээнд 2021 онд нийт 36321 гүйцэтгэх баримт бичгийн 1,8 их наяд төгрөгийг биелүүлэхээс 19693 гүйцэтгэх баримт бичгийн 339,0 тэр бум төгрөгийг биелүүлж, 16628 гүйцэтгэх баримт бичгийн 1,4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж гүйцэтгэх баримт бичгийн биелэлт 54,2 хувьтай, мөнгөн дүнгийн биелэлт, 22.2 хувьтай биелэгдсэн байна”. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтэд саад учруулж буй шалтгаан нь төлбөр төлөгчийн саад учруулж буй үйлдэл, эс үйлдэхүй, **төлбөрийн чадваргүй байдал**, төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалт хангалтгүй, албадлагын арга хэмжээ үр дүнд хүрэхгүй байгаагаас шалтгаалж байна хэмээн дүгнэсэн байна.

судалгаанаас харж болохоор байна. Тухайлбал:

Иргэн, захиргааны хэргийн шийдвэртэй биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичиг 36321, үүнээс бодит биелэлт 54,2 хувьтай, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан гаргасан өргөдөл, гомдол нь 981 буюу нийт баримт бичгийн 2,7 хувьд явуулсан ажиллагаанд гомдол гаргасан бөгөөд үүний 561 өргөдөл нь үндэслэлтэй буюу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын эрх ашгийг хөндсөн гэж шийдвэрлэгдсэн байна. Үүнээс дүгнэн үзвэл 2021 онд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан нийт 36321 баримт бичгийн 1,5 хувьд хүний эрхийн зөрчил бодитой үйлдэгдсэн байна гэж дүгнэж байна. Энэ нь бид эрх зүйн орчин, хууль зүйн хэрэглээгээ сайжруулах шалтгаан юм.

Шалтгаан бол бүх хуулийн амин сүнс[1] гэж үздэгтэй уялдуулан үзвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хамгаалагдсан хүний үндсэн эрхийг бусад үндэслэлээр зөрчихгүй байх, эрх зүйн харилцаанд оролцогч талуудын хувийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль, тогтоомж нь заавал эрх зүйт төрийнхөө утга санаатай уялдаж (хамгаалагдсан эрхийн хэрэгжилтийг хангах), тэрний дагуу хөгжих шаардлага буй болсныг харуулж байна гэж дүгнэлээ.

Дээрх дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын төрийн шагналт, соёлын гавьяат зүтгэлтэн, ардын уран зохиолч Бавуугийн Лхагвасүрэнгийн “Хууль гэдэг хүнд оногдсон том эрх, хэн нэгний эрхийг хасах тэр том эрхийг барьж байгаа хүн хүний дээд л байх учиртай, хуульч үнэн зөв, шударга, төлөв төвшин, голч, хүн чанартай байна гэдэг бол цаанаасаа шаардагддаг зүйл, хуульч хүн хэлмэгдүүлэлтээс, хилсдүүлэлтээс, хэтрүүлгээс ямагт хол байх ёстой” хэмээх сайхан үгээр төгсгөж дараах саналыг дэвшүүллээ.

Санал:

Нэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд[2]:

1.1. 44 дүгээр зүйлд 44.8 гэж нэмээд “Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн шийдвэрээр баталгаажсан мөнгөн хөрөнгийг барагдуулах зорилгоор шинээр зээлийн данс нээх бол энэ хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13-т заасан шинээр данс нээх эрхийг хзгаарлахгүй байж болно” гэж оруулах;

1.2. 50 дугаар зүйлд 50.10 гээд “Энэ хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8-т заасны дагуу нээгдсэн данснаас төлбөрийн шаардлагыг хангахуйц хэмжээний мөнгөн хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлэх, битүүмжлэх үүргийг хүлээнэ” гэж нэмэх;

1.3. 88 дугаар зүйлийн 88.1.10 гэж нэмэлт оруулан “Энэ хуулийн 89 дүгээр зүйлийн 89.12-т заасан суутгалаас үлдсэн орлого” гэж нэмэх;

1.4. 89 дүгээр зүйлийн 89.12-т Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийн дагуу гэсний урд “нэг болон” гэж нэмэх;

Хоёр. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн

[1] Хүйсийн тэгш эрхийн төлөө. Уран сайханы кино.

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд[1]:

2.1. 19 дүгээр зүйлийн 19.13. ”Зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож зээлийг буцаан төлөх чадваргүй болох нөхцөл байдал бий болохоор, эсхүл болсон бол зээлдүүлэгч зээл олгохоос татгалзах, эсхүл олгосон зээлийг буцаан төлөхийг шаардах эрхтэй” гэсний эсхүл гэсний ард “шүүхийн шийдвэрийг биелүүлэх зорилгоор битүүмжилсэн мөнгөн дүнг санхүүжүүлэх боломжгүй” гэж нэмэх;

2.2. 26 дугаар зүйлийн 26.3 гэж нэмээд “Зээлдэгчийн данс, мөнгөн хөрөнгө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13-т заасны дагуу битүүмжлэгдсэн бол шийдвэр цуцлагдах хүртэл хүсэлтийг харгалзан Хүн амьжиргааны баталгаажих доод түвшин тогтоох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасан хэмжээгээр зээлийн эргэн төлөлтийг багасгаж, хугацааг сунгаж болно гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах санал дэвшүүлж, төлбөр төлөгчийн нэн тэргүүний эрх хамгаалагдана гэж үзлээ.

Эх сурвалж

Нэг. Хууль болон эрх зүйн актын эмхэтгэл:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2002 он
3. Банкны тухай хууль. УБ., 2010 он
4. Иргэний хууль. УБ., 2002 он
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он
6. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль. УБ., 2021 он
7. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2016 он
8. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. УБ., 1998 он
9. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. УБ.,1994 он
10. Зөрчлийн тухай хууль. Уб., 2017
11. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль. Уб., 2017
12. Гамшгийн тухай хууль. Уб., 2017

Тушаал:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/167 дугаар “Маягт батлах” тухай тушаал.,

Хоёр. Онолын сурах бичиг, гарын авлага:

1. Б.Чимид. “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл”. УБ., 2004.
2. Д.Лүндээжанцан. “Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хувиарлалт”. УБ., 2001.
3. Ч.Нямсүрэн. “Эрх зүйн ерөнхий онол”. УБ., 2021.
4. Ё.Кают, Э.Шпанглер, П.Редал, Р.Хелмхаген, Д.Наранчимэг, Ц.Амарсайхан, Д.Дүгэржав, Н.Баярмаа. “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар”. УБ., 2010
5. Шийдвэр гүйцэтгэх алба. Иргэн, захиргааны болон зөрчлийн

[1] Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль. Уб., 2021. Төрийн мэдээлэл эмхэтгэл №27.

шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт. Уб., 2018

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. 2019 оны үйл ажиллагааны тоон мэдээ. Уб., 2020

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. 2020 оны үйл ажиллагааны тоон мэдээ. Уб., 2021.

8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх алба. Иргэний, Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт. Уб., 2022.

9. Эрх зүй-Онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл. Уб., 2017. Цуврал 37.

Гурав. Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл:

1. Д.Зүмбэрэллхам. “Гэм буруугүйн презумпцийн зарчмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал”. Уб., 2001.

Дөрөв. Цахим эх сурвалж:

1. https://www.legalinfo.mn/
2. https://www.zuragt.mn/channel/bolovsrol

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙН САЛБАРЫН НИЙГЭМД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

MEDIA AND PRESS SECTOR'S ROLE IN SOCIATY

М.Уянга
ДХИС-ийн магистрант
M.Uyanga
Masters student, University if Internal Affairs

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хэвлэл мэдээллийн байгууллагын нийгэмд явуулж буй үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Монгол Улсад мэдээллийн хэрэгслийн хүртээмж, иргэд, олон нийтийн мэдээлэл олж авч буй эх сурвалж, түүний харьяалал, түүнчлэн хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын нийгэмд гүйцэтгэх үүргийг хэрхэн тодорхойлж болох, нийгэмд эзлэх байр суурийн талаар товч авч үзсэн болно.

Abstract: In this article defined media and press institutes operation in the society, accessibility of media and press in Mongolia, public media and press sources and their ownership, and how to identify media and press sector's role in society and status in society.

Түлхүүр үг: олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сэтгүүл зүй, нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүл, радио, цахим мэдээллийн хэрэгсэл

Key words: public/social media, press, society, media, journals, radio, online media

Удиртгал: Хэвлэл мэдээллийн салбар бол нийгмийн эмзэг салбар юм. Учир нь энд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх гэсэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний суурь эрх хөндөгдөж байдагт оршдог.

Төр хэрхэн үндэсний аюулгүй байдлыг хангах, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, олон ургалч үзлийг дэмжих, улсын түүх, соёлын онцлогийг түгээх хүрээнд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зохицуулахын зэрэгцээ Үндсэн хуулийн хүрээнд баталгаажсан суурь эрхийг хангах тухай асуудал нь энэ судалгааны хүрээнд тодорхойлогдох юм.[1]

Тэр дундаа сэтгүүлчийн үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрэн дүүрэн зохицуулагдах нь нийгмийн салбарын үйл явцыг олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэх, түүнтэй холбоотой үүсэн гарах харилцааг зохицуулахад чухал ач холбогдолтой байх юм.

Нөгөө талаар сэтгүүл зүй гэж юу болох, түүний үр нөлөө хэрхэн нийгэмд нөлөөлж байгааг судалж, түүнийг нийгэмд бүтээмжтэй байдлаар ашиглах явдал өнөөгийн тулгамдсан асуудлын нэг юм.

Сэдвийн хамрах хүрээ: Энэхүү өгүүлэлд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, нийгэмд үзүүлэх үүрэг оролцооны талаар товч авч үзсэн болно.

Үндсэн хэсэг. Монгол Улс 1992 онд шинэ үндсэн хуулиа тунхаглаж, чөлөөт эдийн засаг бүхий ардчилсан тогтолцоонд шилжээд 30 жил гаруй

[1] https://nli.gov.mn/?p=1921

хугацаа өнгөрч, энэ хугацаанд хүний эрх, эрх чөлөө, гадаад харилцаа, чөлөөт хэвлэл, зах зээлийн чөлөөт эдийн засаг зэрэг ардчиллын олон чухал үзүүлэлтүүд Монголын хөрсөнд нутагшин хөгжсөн нь түүхэн ололт юм.

Зар сурталчилгааны тухай хуулийн 3.1.5-д "мэдээлэх хэрэгсэл" гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг"[2] ойлгоно гэж заасан. Тэгвэл хэвлэл мэдээллийн байгууллага гэдэг нь дээрх хуулиар тодорхойлсон "хэвлэл мэдээллийн хэрэгсэл"-д хамаарах үйл ажиллагааг эрхлэн явуулахын тулд холбогдох эрх бүхий байгууллагаас хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авч, эрх бүхий бүртгэх байгууллагад бүртгүүлэн албан ёсоор хэвлэл мэдээллийн хэрэгслийн чиглэлээрх үйл ажиллагааг эрхлэн явуулж буй байгууллагуудыг ойлгож байна.

Тодруулбал; хэвлэл мэдээллийн байгууллагад сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, цахим сайт зэрэг хэвлэн нийтлэх эрхийг бүхий л хэлбэрээр хэрэгжүүлж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл хамаарах юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл бол "хэвлэн нийтлэх үйл ажиллагаа" буюу Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16-д заасан "хэвлэн нийтлэх эрх чөлөө"[3]-ний тусламжтайгаар ард нийтийн дуу хоолойг төрд хүргэх, төрийн чиг үүргийг ард нийтэд таниулан сурталчлах явдал юм.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуулийн 2 дугаар зүйлд "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно"[4].

Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээлэл нь үнэн бодитой, тогтмол, шуурхай, хүртээмжтэй, багтаамж сайтай, идэвхтэй, ашигтай, чиглэсэн зорилготой байх зэрэг шинжээрээ бусад бүх төрлийн мэдээллээс ялгардаг.

Сэтгүүл зүй бол хүлээн авагчдад хандсан аливаа үйл явдлын судалгаа шинжилгээ ба үр дүнгийн тайлан юм. Сэтгүүл зүйн олон төрөл байдаг боловч туйлын зорилго нь хүлээн авагч, үзэгч, уншигчдад улс төр, бизнесийн бүтэц зохион байгуулалт, нийгмийн соёлын нүүр царай болсон урлаг соёлын тухай мэдээллүүдийг хүргэхэд оршино.

Орчин үеийн нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь мэдээллийг ханган нийлүүлэгч болон нийгмийн хэрэг явдлын бодол санаа нь болж байвч сэтгүүл зүйн үүрэг, эрх зүйн хэм хэмжээ нь өргөн олны мэдээллийн хэрэгслүүд, цахим орчны үр дүнгийн өөрчлөлт юм.[5]

Сэтгүүл зүйг баримталж буй үзэл баримтлал, хэрэглэж буй тоног төхөөрөмж, хамрах хүрээ зэргээр нь маш олон янзаар ангилж нэрлэж байгаа бөгөөд зарим нэр төрөл дээр нэлээд

[2] Төрийн мэдээлэл. 2002. №23. Зар сурталчилгааны тухай хууль
[3] Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль
[4] Төрийн мэдээлэл. 1998. №10. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль
[5] https://mn.wikipedia.org/wiki

маргаан дагуулдаг. Өдгөө шинэ шинэ үзэл баримтлал бий болж байна.

Аливаа орны чөлөөт хэвлэл төрийн мэдлийн бус, намын харьяалалгүй, статус, эдийн засгийн хувьд бүрэн бие даасан, эрх зүйн хувьд баталгаажсан, нийгэм улс төрийн нийтлэг хэвлэлийн хүрээнд үйлчилдэг, хяналтын буюу сөрөг хүчний үүргийг биелүүлж чаддаг зэрэг шалгууртай байдаг.

Дэлхийн “Фридом хаус”, “Фридом форум”, “Хил хязгааргүй сэтгүүлчдийн байгууллага” зэрэг бие даасан, нөлөө бүхий байгууллагууд тухайн орны чөлөөт хэвлэлийн зэрэглэлийг төрийн мэдлийн бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, улстөрч, эрх мэдэлтнүүдийг шүүмжилж болох эсэх, төрийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үзүүлэх улс төр, эдийн засгийн шууд ба дам дарамт, шахалт байгаа эсэхийг хамгийн түрүүнд харгалзан үздэг.[6]

Сэтгүүл зүйг юуг тусгаж, юуны тухай өгүүлж байгаа чиглэл хандлага буюу тусгаж буй сэдвээр нь ангилж үздэг. Сэтгүүл зүйн сэдвийн ангилал ч мэдээллийн эрин зуунаас шалтгаалж маш олон төрлийн болж байгаа юм.

Сэтгүүл зүйг үзэл баримтлалаар нь дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

1. Сурталчилгааны сэтгүүл зүй
2. Өргөн нэвтрүүлгийн сэтгүүл зүй, /*Радио сэтгүүл зүй, ТВ сэтгүүл зүй*/
3. Судалгааны сэтгүүл зүй
4. Гудамжны сэтгүүл зүй
5. Шар хэвлэл (Дуулиан шуугиант)
6. Социалист сэтгүүл зүй
7. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй
8. Дэлхий нийтийн сэтгүүл зүй
9. Сонин хэвлэлийн сэтгүүл зүй
10. Мэдээллийн сангийн сэтгүүл зүй, Дата сэтгүүл зүй
11. Гонзо сэтгүүл зүй
12. Гэрэл зургийн сэтгүүл зүй
13. Иргэний сэтгүүл зүй, Оролцооны сэтгүүл зүй
14. Нөлөөллийн сэтгүүл зүй, Өмгөөллийн сэтгүүл зүй
15. Интерактив сэтгүүл зүй
16. Дрон сэтгүүл зүй
17. Барууны сэтгүүл зүй гэх мэт ангилна.[7]

Дэлхий дахинд тогтмол хэвлэл 300 жилийн турш олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүргийг дангаараа гүйцэтгэж байсан бөгөөд кино, радио, телевиз бий болсноор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл цоо шинэ тогтолцоо бий болжээ.

Орчин үед цахим хэвлэл эрчимтэй хөгжиж, мэдээллийн шинэ орон зай, боломжийг нээж, хэрэглэгчдийн тоо эрс нэмэгдэж байна. Мэдээллийн хэрэгсэл болгон өөрийн гэсэн давуу ба сул талтай. Мэдээллийн хэрэгслүүдийн харилцан нөхцөлдсөн нэгдмэл үйл ажиллагаа нь тэр давуу талыг оновчтой ашиглаж, сул талыг нөхөх замаар сэтгүүл зүйн үйл ажиллагаа жам ёсоор хэвийн явагдах онцлогтой юм.

Мэдээллийн хэрэгсэл бүр өөрийн гэсэн онцлог шинж, давуу талын ачаар мэдээллийн зах зээлд орон зайгаа эзэлж, байнгын хүлээн авагчаа бий болгодог, өрсөлдөх шинэ боломжийг эрж хайдаг, нийтлэл, нэвтрүүлгийг агуулга хэлбэр, ур чадвар, арга барилын хувьд үргэлж шинэчилж, хөгжүүлэн баяжуулж байдаг. Энэ нь

[6] https://ikon.mn/n/xwl

[7] https://mn.wikipedia.org/wiki

оршин тогтнох, амьдрах чадварын эх үндэс болдог байна.

Монгол Улсад сонин сэтгүүл, радиогоос илүүтэй телевиз, интернэт хэрэглэгчийн хувь хэмжээ өндөр байдаг байна. Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2019 оны эхний 10 сарын байдлаар 84 сонин, 73 сэтгүүл, 51 радио, 140 телевиз, 154 мэдээллийн сайт тогтмол үйл ажиллагаа явуулж байна.[8]

№	Ангилал	2015	2016	2017	2018	2019
1	Сонин	101	89	88	92	84
2	Сэтгүүл	86	80	71	78	73
3	Радио	69	56	48	50	51
4	Телевиз	131	125	127	128	140
5	Мэдээллийн сайт	98	96	100	109	154
	Нийт	485	446	434	457	502

Манайд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийн мэдээллийг олж авахад хүндрэлтэй байдаг. Телевиз, радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг харилцаа холбооны зохицуулах хорооны http: //www.crc.gov.mn сайтаас үзэх боломжтой ч хувь эзэмшигчдийн хэмжээ тодорхой бус, харин сонин, сэтгүүлийн эзэмшигчдийн мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газарт хамаарагддаг бөгөөд ил тод бус байдаг байна.

Мэдээллийн сайтыг нэгдсэн журмаар, албан ёсоор бүртгэдэггүй, Харилцаа холбооны зохицуулах хороонд байх бүртгэл нь сайн дурын шинжтэй байдаг байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернэт хэрэглэгчдийн тоог албан ёсоор гаргадаг бөгөөд 2018 оны эцсийн байдлаар Монгол Улсад давхардсан тоогоор 4295400 орчим хүн интернэт хэрэглэж байна. Эдгээр интернэт хэрэглэгчдийн 72 хувь нь өдөр бүр ямар нэг хэмжээгээр интернэтэд холбогдож буй бөгөөд 34 хүртэлх насныхан байна. Газарзүйн байршлаар ангилж үзвэл Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 80 хувь, хөдөө орон нутгийн хэрэглэгчдийн 66 хувь нь интернэтэд өдөр бүр холбогддог байна.

Сонин, сэтгүүлийн уншигчид болон телевиз, радиогийн үзэгч, сонсогчдын тоог Харилцаа холбооны зохицуулах хороо болон бусад байгууллагаас тооцож гаргадаггүй. Харин хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн хүртээмж, хэрэглээний байдлыг түүвэр судалгааны дүнд үндэслэн гаргадаг.

Хэвлэлийн хүрээлэнгээс 2018 онд улсын хэмжээнд 1000 хүнийг хамруулан хийсэн судалгаагаар тус судалгаанд оролцогчдын тал нь сонин огт уншдаггүй гэжээ. Харин Улаанбаатар хотоос оролцогчдын 7 хувь нь, хөдөө орон нутгийн 3 хувь нь өдөр бүр сонин уншдаг байна. Сонины борлуулалтын хэмжээ жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна. Сонины нийт борлуулалтын 84 хувийг захиалгаар, 16 хувийг өдөр тутмын худалдаагаар борлуулдаг байна.

[8] Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль боловсруулах ажлын хэсгин тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

Телевиз, радиогийн нэвтрүүлэг хүлээн авдаг хүн амын хувь хэмжээг албан ёсоор гаргадаггүй. Гэхдээ өргөн нэвтрүүлгийн 16 телевиз радио давтамж ашиглан нэвтрүүлгээ орон даяар цацдаг. Мөн хиймэл дагуул, кабель болон IPTV-н тусламжтайгаар дээрх 16 сувгаас гадна дотоодын 52+ сувгийг орон даяар хүлээн авах боломжтой юм байна.

Телевизийн олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчийн тоо 2018 оны эхний хагас жилийн байдлаар 916.000 байна. Нийт хэрэглэгчдийн 5 хувь нь кабель, 44 хувь нь хиймэл дагуул, 30 хувь нь IPTV, 21.1 хувь нь DTV-ээр хүлээн авч байна. Түүнчлэн 14 телевизийн сувгийг өөрийнх нь веб сайтаар дамжуулан, www.looktv.mn веб сайтаар дамжуулан 27 монгол сувгийг интернэтээр, дэлхий даяар хүлээн авч байна.

Радиогийн тухайд Монголын үндэсний олон нийтийн радио, Лавайн эгшиг радио, Шинэ монгол радио үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацаж байгаагаас 11 радиог онлайнаар шууд сонсох боломжтой, 8 радио ухаалаг утасны аппликэйшн ашиглан сонсож болдог байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны веб сайтад радиогийн олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчдийн тоо тавигдаагүй байна.

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2019 оны жилийн эцсийн байдлаар манай улсад 502 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 4749 хүн ажиллаж байгаагаас 49 хувь нь бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, сурвалжлагч байна.[9]

Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын нийгэмд гүйцэтгэх үүрэг. Сэтгүүл зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудлын нэг бол үүргийн тухай асуудал юм. Сэтгүүл зүй цаг ямагт нийгмийн амьдралын төвд байсан бөгөөд нийгэм өөрөө байнга сэтгүүл зүйг өөрчилж байдаг онцлогтой.

Нийгмийн амьдралын аль ч салбар хүрээнд гарч ирсэн аливаа асуудал эцсийн үр дүнд хүмүүсийн өдөр тутмын ажил үйлстэй салшгүй холбоотой. Ямар нэгэн тулгамдсан асуудал зөвхөн хүнтэй холбогдон гарч ирдэг бөгөөд түүнийг томьёолон, шийдвэрлэх боломж гагцхүү хүнд л байдаг.

Германы судлаачдын тодорхойлсноор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хоорондоо нягт холбоотой гурван үндсэн үүрэгтэй байдаг байна. Энэ нь:

1. Иргэдийг мэдээллээр хангах;
2. Олон нийтийн үзэл бодлыг бүрдүүлэхэд нөлөө үзүүлэх;
3. Шүүмжлэл гаргах, хяналт тавих гэсэн байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүч нөлөө, ач холбогдол туйлын өндөр учраас тэр нь заримдаа “дөрөв дэх засаглал” бий болгох боломжтой, тиймээс үүнийг буруугаар ашиглах, эсвэл үүргээ биелүүлж чадахгүй байдалд оруулахгүйн тулд үйл ажиллагааг нь хуулийн хүрээнд зохицуулан, хяналт тавьж байх шаардлагатай.

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбар дараах үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

[9] Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль боловсруулах ажлын хэсгин тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

д/д	Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын нийгэмд гүйцэтгэх үүрэг	Тайлбар
1	**Мэдээлэх** */Олон түмнийг мэдээллээр хангах/*	Энэ бол чөлөөт хэвлэлийн төдийгүй, сэтгүүл зүйн гол үүрэг бөгөөд нийгмийн зорилгоос урган гарсан түүний мөн чанартай холбоотой. Сэтгүүл зүй гэдэг нь анх гарч ирэхдээ мэдээлэл түгээх, олон түмний мэдээллийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилтын үүднээс бий болсон байна. Хэзээ, хаана, юу болж байгааг хүмүүс байнга мэдэхийг хүсдэг. Тэгвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээ бол хүмүүсийн сонирхож байгаа нийгмийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн, үйл явдлын баримтыг шуурхай, үнэн зөв, ойлгомжтой, товч, хүртээмжтэй, тодорхой мэдээлэх явдал юм. Тиймээс мэдээлэх үүрэг бол хэвлэл мэдээллийн хэрэгслийн угийн шинж чанарыг тодорхойлогч үндсэн үүрэг болдог байна. Францын судлаач Б.Вуайен: “Нийгмийн доторх бүлгүүд нь материал баялгийг солилцохгүй байж яасан ч чадахгүй. Тэгвэл үзэл санаа, сэтгэл хөдлөл, мэдээг эс солилцвол нийгмийн доторх холбоо тасарч, бүлэг хэсгүүдийн хийгээд нийгмийн доторх хүмүүсийн нийтлэг ч үгүй болно.” гэж хэлсэн нь нийгэм дэх мэдээллийн үүрэг ямар чухал байхыг илэрхийлж байгаа баримт мөн.
2	**Танин мэдүүлэх** */Боловсрол олгох, соён гэгээрүүлэх/*	Танин мэдэхгүй бол хүрээлэн буй ертөнцийг тусгахад чиглэсэн ухамсрын үйл ажиллагаа мөн. Мэдээлэл, тэр тусмаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэг гол сэдвээ зөв тусгах нь ухамсрын үйл ажиллаагаа мөн тул тус асуудлаас бид танин мэдүүлэх үүргийн үндсийг тодорхойлж байдаг. Мэдээ, нийтлэл, нэвтрүүлэг болгон уншигч, сонсогч, үзэгчдийг танин мэдэхүйн зөв чиглэлд хөтлөн жолоодож, бүх юмны учрыг олох гэсэн хүн төрөлхтний хүсэл эрмэлзэлд нь тус нэмэр болж байх үүрэгтэй юм. Нийтлэл дэх танин мэдүүлэх элементийн хирээр ч уг материалын үнэ цэнэ тодорхойлогдоно.
3	**Удирдлагын хэрэгсэл болох** */Хяналт тавих/*	Сэтгүүл зүйг “дөрөв дэх засаглал” гэх буюу хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага хийгээд шүүхийн дараа дөрөв дэх засаглалд ордог. Гэхдээ дөрөв дэх засаглал гэсэн үгийг ямар утгаар нь авч үзэх талаар бодох хэрэгтэй. Логик үүднээс авч үзвэл сэтгүүл зүй шууд утгаар авч үзвэл сэтгүүл зүй хэзээ ч засаглалын үүргийг гүйцэтгэж чадахгүй, харин өөрийнхөө идэвхтэй үйл ажиллагаагаар төр засгийн ажилд нөлөөлж чаддаг байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь төр засгаас гаргаж байгаа удирдах, зохион байгуулах аливаа түгээмэл шийдвэрийг олон түмэнд дамжуулдаг. Түүнийг олон түмэн хэрхэн хүлээн авч байгааг эргээд мэдээлнэ. Эргэх мэдээллээр дээд удирдлага шийдвэр ээ хэрхэн зохион байгуулах, эсвэл засаж өөрчлөх арга аа ахин дахин

		боловсруулах, үр дүнд хүрч байгааг мэдээд дараачийн шийдвэр ээ боловсруулж эхэлдэг. Бас удирдлагын объект, субъект хоёроос хүлээн авч байгаа мэдээллээ ашиглаад оновчтой арга зарчмыг ч хэвлэл мэдээллийн байгууллага боловсруулан шинэ санаа, ажил хэрэгч шинэ эхлэл, хөдөлгөөнийг санаачилдаг. Энэ утгаараа сэтгүүл зүй нь удирдлагын үүрэгтэй байдаг байна.
4	**Зохион байгуулах** */Олон түмний үзэл бодлыг бүрүүлэхэд нөлөөлөх/*	Энэ үүрэг нь чөлөөт хэвлэлийн бусад үүрэгтэй харилцан уялдаж байж, хэвлэл мэдээллийн байгууллагын цацаж буй нийтлэл, нэвтрүүлэг нь үр нөлөөтэй байдаг. Сэтгүүл зүй өөрийнхөө зохион байгуулах үүргийг дараах гурван чиглэлээр явуулдаг байна. Үүнд: 1. Төр засаг болон удирдах дээд байгууллагуудын чухал баримт бичгүүдийг нийтлэх, сурталчлах, тайлбарлах; 2. Нийгмийн практик ажлын нэг салбар нэгжийн ажил үйлсийг сурталчлах, ололт угагдлыг илрүүлэх замаар шинэ санал зөвлөмж дэвшүүлэх, мөн зохион байгуулах ажлын нэг чухал хэлбэр болох редакцын газарт ирж буй санал, гомдол, шүүмжлэл, хүсэлт зэргийг судалж үзсэний үндсэн дээр янз бүрийн арга хэмжээ зохион байгуулж, захидлын мөрөөр томоохон нийтлэл бэлтгэн, доторхой үр дүнд хүрэх, тэдний саналыг зохих байгууллагуудад дамжуулан шийдвэрлүүлэх; 3.Шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаа зэргээр тус үүргээ хэрэгжүүлдэг байна.
5	**Харилцааны үүрэг**	Сэтгүүл зүйн хүрээн дэх мэдээллийн харилцан нөлөөллийн урьдчилсан болон зайлшгүй нөхцөл нь хэрэглэгчидтэй, өөрөөр хэлбэл олон түмэн, нийгмийн институттэй холбогдсон харилцаа байдаг. Энэ харилцааны үр дүнд сэтгүүл зүйн систем дэх сонин, хэвлэл, нэвтрүүлэг болгон хэрэглэгчдийнхээ мэдээллийн хэрэгцээг хангах замаар өөрийнхөө дүр төрх, өвөрмөц шинжийг олж, тодорхойлж байдаг байна.
6	**Зугаацуулах** */Гоо зүйн хүмүүжил олгож, алжаал тайлах/*	Сэтгүүл зүй хүмүүсийн амралт, чөлөөт цагийг зөв өнгөрөөх алжаал тайлах, гоо зүйн таашаал хүртээх, соёл боловсролын хүрээг өргөтгөхөд чухал үүрэг гүйцэтгэдгийг үгүйсгэх аргагүй юм. Радио телевизээр өгч байгаа уран сайхны нэвтрүүлгүүд, уран сайхны кино, концерт, тогтмол хэвлэлд нийтлэгдэж буй уран сайхны болон уран зохиолын, танин мэдэхүйн чиглэлийн янз бүрийн материалууд хүмүүсийн сонирхлыг хамгийн ихэд татдаг.

Тэгвэл аль нэг хэвлэл мэдээллийн байгууллага, тодорхой нэг нийтлэл туурвиж байгаа сэтгүүлч хүртэл бүгд өөр өөрийн нийтлэлийн бодлогодоо дээрх үүргийн хослол нийлэмж хэр зэрэг зөв зохицож чадаж байгаа эсэхээс тэдгээр мэдээллийн үр нөлөөтэй байх эсэх нь шалтгаална гэдгийг нийтлэлийн бодлогынхоо шалгуур болгон харгалзан үзэх нь сэтгүүл зүйн үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хэвлэл мэдээллийн салбарын эдгээр үүрэг нь нэг мэдээнээс эхлээд нийтлэл, нэвтрүүлгийн хэд хэдэн жилийн хэтийн төлөвлөгөөнд харгалзан

үзэх нэг гол чиглэл байхын дээр энэхүү чиглэл нь үүргээ хэрхэн биелүүлж байгаагийн эцсийн шалгуур нь болох юм.

Өнгөрсөн зууны эцэст дэлхийн олон оронд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь арилжааны хэрэгсэл болох хандлага улам хүчтэй өрнөх болов. Сонин, сэтгүүлийг хэвлэх, нэвтрүүлэг бэлтгэх үйл явц мэдээллийн үйлдвэрлэлийн салбар болон хувирч, хэрэглэгчдийн зах зээлийн шаардлагыг харгалзсан ажил хэрэгч шинж, үр ашигтай ажиллах менежмент, маркетингийн стандарт нэвтэрч байна. Америкийн мэдээллийн салбарынхан «Америкийн мэдээллийн үйлдвэрлэл бол бизнес мөн» гэж тунхагладаг нь үүнтэй холбоотой юм.

Арилжааны чиглэл бүхий сэтгүүл зүйд (profit seeking) сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл тодорхой зах зээлд үйлчилдэг ёстой гэсэн үзэл баримтал өргөн дэлгэрсэн бол сэтгүүл зүйн бусад чиглэлийн төлөөлөгчид юуны өмнө иргэдэд, олон нийтийн санаа бодолд, эсвэл хувь хүн болох уншигчид хандах хэрэгтэй гэж үздэг байна.

Сэтгүүл зүйн арилжааны шинж өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд зах зээлийн механизмаар дамжин хэрэгждэг хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон сэтгүүлчдийн үйл ажиллагааг эдийн засгийн хувьд зохицуулах нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Зах зээлийн дарамт нь өрсөлдөөний орчинд үйл ажиллагаа явуулж буй олон нийтийн мэдээллийн хэрэгслийн болон сэтгүүлчдийн давуу тал, «тоглоомын дүрэм»-ийг тодорхойлж өгдгөөрөө онцлогтой юм.

Арилжааны хүчин зүйл орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байгааг Америкийн сэтгүүл зүйн жишээгээр тайлбарлаж болно. 1990-ээд оны дунд тус улсын сонины төсвийн 80 хувийг сурталчилгааны орлогоос, зөвхөн 20 хувийг захиалга болон борлуулалтаас олсон мөнгөөр бүрдүүлж байв. Өөрөөр хэлбэл, сурталчилгаа олгогчид ба хүлээн авагчдын сонины санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг харьцаа нь 4:1 болж өөрчлөгдсөн юм.

Ийм сурталчилгааын нөлөө сонин хэвлэлийн агуулгад бас нөлөөлж, аль болохоор олон уншигчийн анхаарлыг татахуйц нийтлэл мэдээ нийтлэхийг чухалчилдаг болж байна. Тухайлбал, 90-ээд оны эхэнд АНУ-ын сонины сурвалжлагчдын 19 хувь нь спортын, 8 хувь нь гэмт хэрэг, шүүхийн үйл ажиллагааны асуудлаар, 7 хувь нь бизнесийн чиглэлийн сэдвээр дагнан мэргэших болжээ. Тэгвэл нийгмийн болон боловсролын асуудлаар мэргэшдэг сэтгүүлч ердөө 4 хувийг тус тус эзэлж байв.[10]

XX зууны сүүлчийн 25 жилд арилжааны телевиз нэлээд эрчимтэй хөгжихийн хамт төлбөртэй нэвтрүүлэг, хөтөлбөр явуулах явдал өргөн нэвтэрчээ. Энэ асуудал өнөөдөр Европын холбооны орнуудын олон нийтийн санааг зовоож байгаа бөгөөд төр, засгийн зүгээс олон нийтийн телевизийг хөгжүүлэх, дэмжих талаар тодорхой алхмуудыг хийж байна. Гэвч арилжааны телевизтэй хүссэн хүсээгүй өрсөлдөх шаардлагатай болсон олон нийтийн телевизийн компаниуд зар сурталчилгаа, арилжааны үйл

[10] https://mn.wikipedia.org/wiki

ажиллагааны нууц хэлбэрийг түгээмэл ашиглах болсон юм.

МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D), Соёлын гавьяат зүтгэлтэн Маулетийн Зулькафиль 2017 онд өгсөн ярилцлагадаа “Сүүлийн жилүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн түүх, онол, практикийн асуудлыг хөндсөн судалгааны цөөнгүй бүтээл гарсан нь үүний тод илрэл юм. Харин сэтгүүл зүйн шүүмж зогсонги байдалд байна гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Сэтгүүлчийн уран бүтээлийн барометр байх ёстой шүүмж үгүйлэгдэж буй нь сэтгүүл зүй судлал дахь сул тал мөн. Энэ нь хэд хэдэн шалтгаантай холбоотой.

Шүүмж бичнэ гэдэг бол асар их хүч хөдөлмөр, мэдлэг, чадвар шаардсан хүнд ажил. Маш их хөдөлмөр гаргаж, асар их юм уншиж, судалж бичсэн тэр бүтээлийг үнэлэх, дэмжих ямар ч сэтгэлгээ, механизм алга байна. Нөгөө талаар манай практик сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад шүүмж хүлээж авах сэтгэлгээ огт бүрдээгүй. Шүүмж бич-сэн хүний эсрэг бяцхан “дайн” зарлаж, ХМХ-ийг ашиглан хариу арга хэмжээ авах, харааж зүхэх нь энгийн үзэгдэл болсон.

Өнөөдөр шүүмж сонсох дургүй, өөрийнхөө алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй хүмүүс манай хэвлэл мэдээллийн хэрэгслээр дүүрэн байна. Энэ бол шүүмж зогсонги байдалд ороход нөлөөлж буй нэг гол хүчин зүйл юм. Шүүмж хөгжихгүй байгаагаас нийтлэл, нэвтрүүлгийн агуулга ч сайжрахгүй байна.

Мэдээллийн багтаамж, танин мэдэхүйн ач холбогдол сайтай, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх чадвартай, агуулга ба хэлбэрийн нэгдлийг өндөр төвшинд хангасан, гэгээлэг нийтлэл, нэвтрүүлэг үзэгдэхээ больсон гэж хэлж болно. Дээр нь зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа сайтууд олон нийтийг мэдээллээр хангах, гэгээрүүлэхийн оронд бохир аргаар буюу бусдыг шантаажилж мөнгө олох хэрэгсэл болон хувирсан нь нууц биш юм.

Шаардлагатай бол тийм сайт, сэтгүүлчдийг нэр бусаар нь баримттай хэлж болно. Энэ бол Монголын олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд дорвитой өөрчлөлт гарахгүй байгаагийн шинж юм. Судлаач хүний нүдээр харахад ийм хандлага манай сэтгүүл зүйд нэг хэсэгтээ үргэлжлэх төлөвтэй байна. Энэ бол тооны хойноос хөөцөлдөх сэтгүүл зүйн аливаа бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарах цаг болсны илрэл юм.”[11] гэсэн байдаг.

Нийгэмд сэтгүүл зүйн салбарын үүрэг оролцоог нэмэгдүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж чадвал нийгэм эрүүлжих, гэмт хэрэг, зөрчил буурах боломжтой юм гэж судлаачийн хувьд үзэж байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуулийн 3.1. “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”, 3.2. “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй”[12] гэж заасан хэвлэл

[11] https://ikon.mn/n/xwl

[12] Төрийн мэдээлэл. 1998. №10. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хууль

мэдээллийн байгууллага болон сэтгүүлчийн эрх зүйн байдлыг өнөөг хүртэл тодорхойлж өгөөгүй, мөн нийгэмд гүйцэтгэх үүрэг тодорхойгүй, зөвхөн зарчмаар нийгэмд гүйцэтгэх үүрэг нь тодорхойлогдож байгаа нь цаашид энэ талаар зайлшгүй авч үзэх шаардлага байгааг илэрхийлж байна.

Даяаршил бий болж буй өнөөгийн нийгэмд мэдээллийн шинэ технологийн хөгжлийн үр дүнд мэдээлэлд орон зай, цаг хугацаа үгүй болсон. Үүнд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гол үүрэг гүйцэтгэж байгаа нь бодит үзэгдэл юм. Хуучин цөөн хэдэн мэдээллийн хэрэгсэлд ханддаг хүлээн авагчид өнөөдөр хүссэн мэдээллийн хэрэгсэлд хандаж, хүссэн мэдээллийг чөлөөтэй хүлээн авдаг болсон нь задралын илрэл гэж үзэж болох юм.

Дүгнэлт. Өнөөдөр ардчиллын тулгуур баганын нэг бол чөлөөт хэвлэл мөн гэдгийг дэлхий даяар хүлээн зөвшөөрч байна. Чөлөөт хэвлэлийн хөгжил нь ямар хэмжээнд байгаагаар нь тухайн орны ардчиллын хөгжлийг хэмждэг нь энгийн үзэгдэл болжээ.

Сүүлийн 20 жилд нэвтрүүлгийн томоохон компаниуд олон нийтийн анхаарлыг онцгой татдаг спортын уралдаан, шоу зэрэг үйл явдлуудыг дагнан нэвтрүүлдэг эрх олж авах явдал өргөн дэлгэрч байна. Ийм эрхийг гол төлөв санхүү, эдийн засгийн нөөц боломж сайтай арилжааны телекомпаниуд авч байгаа нь олон нийтийн телевизийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг болжээ. Үүнээс үзэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн арилжааны шинж улам гүнзгийрч, компьютерийн сүлжээг өргөн ашиглах болсон нь XX зууны эцэст баян, ядуугийн хоорондох зөрчил дээр мэдээллээр хангах гэсэн өөр нэг томоохон шалгуур нэмэгдэхэд хүргэжээ. Уншигчдын нэг хэсэг нь интернетээс эхлэн мэдээллийн бүх суваг, эх сурвалжийг ашиглаж байхад нөгөө хэсэг нь хөрөнгө мөнгөний хүчин зүйлээс шалтгаалан мэдээлэл хүлээж авах боломж нь эрс хязгаарлагдмал байна.

Өнөөдөр манай улсын хууль тогтоомжид хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль өнөөг хүртэл гараагүй байгаа, гагцхүү зарчмаар нийгэмд гүйцэтгэх үүрэг тодорхойлогдож байгаа нь тулгамдсан асуудлын нэг болжээ.

Санал. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн салбарын нийгэмд үзүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуульд дараах нэмэлт өөрчлөлт оруулах;

1.1. Хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны зарчим” /*шинээр*/;

1.2. Хуулийн 3 дугаар зүйл “хуулийн нэр томъёо” /*шинээр*/;

(“хэвлэл, мэдээллийн байгууллага”, “сэтгүүлч” гэх мэт нэр томъёоны тодорхойлолт);

1.3. Хуулийн 4 дүгээр зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын эрх” /*шинээр*/;

1.4. Хуулийн 5 дугаар зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг” /*шинээр*/;

1.5. Хуулийн 6 дугаар зүйл “Сэтгүүлчийн эрх” /*шинээр*/;

1.6. Хуулийн 7 дугаар зүйл “Сэтгүүлчийн үүрэг” /*шинээр*/;

1.7. Хуулийн 8 дугаар зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагаа” /*шинээр*/;

1.8. Хуулийн 9 дүгээр зүйл “Хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүжилт” /*шинээр*/;

1.9. Хуулийн 10 дугаар зүйл “Мэдээлэлд хяналт тавихыг хориглох”;

2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай тухай хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн байгууллага гэж олон нийтийн мэдээллийн хэрэгслийг бэлтгэн гаргаж байгаа аж ахуйн нэгж байгууллагыг хэлнэ”, “Сэтгүүлч гэж олон нийтийн хэвлэл мэдээллээр дамжуулан сэдвийн мэдээлэл ба үзэл бодлыг олон нийтэд нийтлэх, түгээх ажлыг үндсэн мэргэжлээ болгон ажилладаг хүнийг хэлнэ” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг шинээр тусгаж өгөх;

3. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүжилттэй холбоотой харилцааг аливаа улс төрийн нам, хүчнээс хараат бус, зөвхөн зар сурталчилгаанаас олох зохицуулалтыг нарийвчлан тусгаж өгөх;

Ашигласан материал

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Зар сурталчилгааны тухай хууль
3. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль

Сэтгүүл, эмхэтгэл

4. Төрийн мэдээлэл. 1992. №1
5. Төрийн мэдээлэл. 1998. №10
6. Төрийн мэдээлэл. 2002. №23

Цахим эх сурвалж:

7. https://nli.gov.mn/?p=1921
8. https://mn.wikipedia.org/wiki
9. https://ikon.mn/n/xwl

Судалгааны тайлан

10.Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль боловсруулах ажлын хэсгийн 2017-2021 оны судалгааны мэдээ